ХУУЛЬ ЗҮЙН
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

СУДАЛГААНЫ ТАЙЛАНГИЙН ЭМХЭТГЭЛ

2020

VIII

Улаанбаатар хот
2021 он

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ
ХҮРЭЭЛЭН

СУДАЛГААНЫ ТАЙЛАНГИЙН ЭМХЭТГЭЛ VIII

(2020 он)

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

Улаанбаатар хот
2021

ДАА 340
ННА 67
С-701

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

Судалгааны баг:

Удирдсан:

П.Амаржаргал Эрдэмтэн нарийн бичгийн дарга

Судалгааны багийн гишүүд:

Б.Ариунжаргал
Ч.Батзориг
Д.Дэлгэрмаа
Ц.Оюунчимэг
Г.Сувд-Эрдэнэ
О.Төрболд
Э.Уянга
Г.Халиунаа
С.Цэрэндолгор
Х.Ариунсүрэн
У.Эрдэнэзаяа

© Хууль зүйн үндэсний хүрээлэн

Хянасан: Эрдэмтэн нарийн бичгийн дарга,
Хууль зүйн ухааны доктор /Ph.D/ П.Амаржаргал
Эмхэтгэсэн: Эрдэм шинжилгээний ахлах ажилтан Г.Халиунаа
Хэвлэлийн эх бэлтгэсэн: Эх бэлтгэгч, дизайнер З.Эрдэнэтөгс
Хэвлэсэн хугацаа: 2021 оны 5 дугаар сар
Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.

ISBN-978-99978-788-0-9

ГАРЧИГ

НЭГ. ЗАСГИЙН ГАЗРЫН 2016 ОНЫ 59 ДҮГЭЭР ТОГТООЛД ЗААСАН АРГАЧЛАЛЫН ДАГУУ ГҮЙЦЭТГЭСЭН СУДАЛГАА

1. Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ 11
2. Цахим гарын үсгийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ 27
3. Нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгч /илчлэгч/-ийг хамгаалах тухай хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ 50
4. Нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгч /илчлэгч/-ийг хамгаалах тухай хуулийн төслийн зардлын тооцоо 70
5. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаанд хяналт, оролцоог хэрхэн хэрэгжүүлэх талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтийн үнэлгээ 93

ХОЁР. ХАРЬЦУУЛСАН ЛАВЛАГАА

1. Гадаадын зарим орны холбоо, сангийн нийтэд тустай үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулсан хууль тогтоомж 153

ГУРАВ. БУСАД СУДАЛГАА

1. Монгол Улсын Үндсэн хууль дахь парламентын институтийн зарим нэр томьёо 171
2. Компанийн эрх зүйн зохицуулалтын өнөөгийн байдал, тулгамдсан асуудал 200

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХУРЭЭЛЭН
www.nli.gov.mn

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ААН	Аж ахуйн нэгж
ААҮАТЗтХ	Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль
АДЗ	Амьжиргаа дэмжих зөвлөл
АИХТ	Ардын Их Хурлын Тэргүүлэгчид
АНУ	Америкийн Нэгдсэн Улс
АТГ	Авлигатай тэмцэх газар
АТҮХ	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр
БЗД	Баянзүрх дүүрэг
БНМАУ	Бүгд Найрамдах Монгол Ард Улс
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ГХХтХ	Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль
ДТГ	Дипломат төлөөлөгчийн газар
КтХ	Компанийн тухай хууль
МУИС	Монгол Улсын Их Сургууль
МУҮХ	Монгол Улсын Үндсэн хууль
НАСТШҮХтХ	Нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгч /илчлэгч/-ийг хамгаалах тухай хууль
НҮБ	Нэгдсэн Үндэстний байгууллага
ОНОТХҮ	Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ
ОХУ	Оросын Холбооны Улс
ТББ	Төрийн бус байгууллага
ТМЭ	Төрийн мэдээлэл эмхэтгэл
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
УИХ	Улсын Их Хурал
УТҮГ	Улсын төсөвт үйлдвэрийн газар
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ХТтХ	Хууль тогтоомжийн тухай хууль
ХТЭТ	Хүйсийн тэгш эрхийн төв
ХК	Хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХЭҮТ	Хүчирхийллийн эсрэг үндэсний төв
ХЭХ	Хувьцаа эзэмшигчдийн хурал
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
ЭЗХАХБ	Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.mli.gov.mn

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХУРЭЭЛЭН
www.nli.gov.mn

ӨМНӨХ ҮГ

Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс жил бүр эрхлэн гаргадаг “Судалгааны тайлангийн эмхэтгэл”-ийн ээлжит цувралыг уншигч Таны мэлмий, оюунд тань хүргэхэд бэлэн болоод байна.

Энэхүү цуврал бүтээл нь хууль зүйн салбарын эрдэмтэн, судлаач, багш, оюутан залуус болон хууль сахиулах байгууллагуудын албан хаагчдад судалгааны томоохон эх сурвалж болсоор өдгөө 8 дахь дугаартайгаа золгож байна.

Энэ удаа бид 2020 онд гүйцэтгэсэн төлөвлөгөөт болон захиалгат судалгааны тайлангаа эмхэтгэн Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолд заасан аргачлалын дагуу гүйцэтгэсэн судалгаа, харьцуулсан судалгаа, бусад судалгаа гэсэн хэсэгтэйгээр бэлтгэн хүргэж байна.

Цувралын онцлогоос дурдвал, нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгч /илчлэгч/-ийг хамгаалах тухай хууль батлах шаардлагатай хэмээн яригдаж буй энэ цаг үед энэхүү харилцааг зохицуулсан хуулийн төсөлтэй холбогдох гурван төрлийн судалгааг тус хүрээлэнгээс хийж гүйцэтгэснээс өмнөх цувралд эхний тайланг, энэ дугаарт дараагийн хоёр судалгааны тайланг нь нийтэлж байна.

Уг бүтээлд нийтлэгдсэн бүтээлүүд нь хууль зүйн салбарын тулгамдсан олон асуудлыг шинжлэх ухаан болон практик судалгааны эргэлтэд оруулахад багагүй хувь нэмэр оруулна гэдэгт бид гүнээ итгэж байна.

Мэргэн уншигч Та болгооно уу.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ
ХҮРЭЭЛЭНГИЙН ЗАХИРАЛ Х.ЭРДЭМ-УНДРАХ

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.rli.gov.mn

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХУРЭЭЛЭН
www.nli.gov.mn

НЭГ. ЗАСГИЙН ГАЗРЫН 2016 ОНЫ 59 ДҮГЭЭР ТОГТООЛД ЗААСАН АРГАЧЛАЛЫН ДАГУУ ГҮЙЦЭТГЭСЭН СУДАЛГАА

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХУРЭЭЛЭН
www.nli.gov.mn

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭ[1]

УДИРТГАЛ

Улсын Их Хурлын 2020 оны 1 дүгээр сарын 9-ний өдрийн 02 дугаар тогтоолоор "Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай", Засгийн газрын 2020 оны 2 дугаар сарын 19-ний өдрийн 66 дугаар тогтоолоор "Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх ажлын төлөвлөгөө"-г баталж, уг төлөвлөгөөнд тусгагдсан хууль тогтоомжийг тогтоосон хуваарийн дагуу боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Засгийн газрын гишүүдэд даалгажээ. Ийнхүү Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх ажлын төлөвлөгөөний дагуу Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан байна.

Энэхүү хуулийн төслийг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар "Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал"-ыг баримтлан төслийн үр нөлөөг үнэлэх юм. Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд улсын төсөвт ачаалал үүсгэх эсэх, төрийн байгууллагад хуулийн төслийг хэрэгжүүлснээр үүсэх зардал байгаа эсэхийг шалгана.

Уг судалгаагаар Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн төслийн үр нөлөөг үнэлж, уг төслийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах замаар эрх зүйн орчныг сайжруулах боломжийг тодорхойлох, мөн хэрэглэхэд ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар боловсруулахад дэмжлэг үзүүлэх, хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг тооцон, төслийн чанарыг сайжруулахад чиглэсэн зөвлөмж өгөхийг зорилоо.

Төслийн үр нөлөөг үнэлэх ажиллагааг аргачлалд заасны дагуу дараах үе шаттайгаар гүйцэтгэлээ. Үүнд:

1. Шалгуур үзүүлэлтийг сонгох;
2. Хуулийн төслийн үр нөлөө тооцох хэсгээ тогтоох;
3. Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох;
4. Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх зэрэг болно.

НЭГ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОХ

Төслийн үр нөлөөний үнэлгээг тооцохдоо төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан, аргачлалд дурдсан дараах 4 шалгуур үзүүлэлтийг сонгосон.

1. Зорилгод хүрэх байдал
2. Ойлгомжтой байдал
3. Зардал
4. Харилцан уялдаа

Эдгээр шалгуур үзүүлэлтийг сонгохдоо дараах үндэслэлийг харгалзан үзэв. Үүнд:

1. Төсөл нь "Улсын Их Хурал, Засгийн газрын эрх мэдлийн харилцан хяналт, тэнцлийг хангах механизмыг бүрдүүлэн зохицуулахад оршиж байна." гэсэн

[1] Энэхүү судалгааг ЗГХЭГ, ХЗДХЯ-ны захиалгаар 2020 онд ХЗҮХ-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга П.Амаржаргал удирдан, Эрдэм шинжилгээний ажилтан Э.Уянга, У.Эрдэнэзаяа, Б.Ариунжаргал, О.Төрболд нар хамтран гүйцэтгэв.

Хуулийн тайлангийн эмхэтгэл www.nli.gov.mn

зорилгодоо хүрсэн эсэх;

2. Төсөлд тусгагдсан зохицуулалтуудыг хэрэглэх, хэрэгжүүлэх субъектүүдийн хувьд ойлгомжтой, логик дараалалтайгаар боловсруулагдсан эсэх;
3. Хуулийн төслийн зохицуулалт нь улсын төсөвт ачаалал үүсгэх эсэх, төрийн байгууллагад хуулийн төслийг хэрэгжүүлснээр үүсэх зардал байгаа эсэх;
4. Төслийн зүйл, заалт нь өөр хоорондоо болон бусад хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжтой нийцсэн эсэх, мөн төрийн байгууллагын чиг үүрэгтэй давхардсан, зөрчилдсөн эсэхийг тус тусад нь шалгана.

Хүснэгт 1. *Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалд заасан шалгуур үзүүлэлт*

Д/д	Шалгуур үзүүлэлт	Шалгуур үзүүлэлтийг сонгох
1.	Зорилгод хүрэх байдал	Улсын Их Хурал, Засгийн газрын эрх мэдлийн харилцан хяналт, тэнцлийг хангах механизмыг бүрдүүлэн зохицуулахад оршиж байна. Иймд төслийн хүрээнд эдгээр асуудлыг шийдвэрлэсэн эсэх, сонгож авсан шийдлийн зорилгод хүрэх байдлыг үнэлэх нь зүйтэй гэж үзлээ.
2.	Ойлгомжтой байдал	“Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зохицуулалт түүнийг хэрэглэх, хэрэгжүүлэх субъектүүдийн хувьд ойлгомжтой, логик дараалалтайгаар боловсруулагдсан эсэхийг шалгана.
3.	Зардал	Улсын төсөвт ачаалал үүсгэх эсхүл төрийн байгууллагад хуулийн төслийг хэрэгжүүлснээр үүсэх зардал байгаа эсэхийг шалгана.
4.	Харилцан уялдаа	“Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд давхардал, хийдэл, зөрчил байгаа эсэхийг шалгаж үзэх юм.

ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ НЬ ТООЦОХ ХЭСГЭЭ ТОГТООХ

Энэхүү хэсэгт уг төслөөс үр нөлөөг нь үнэлэх хэсгээ тогтоож, сонгосон шалгуур үзүүлэлтийн хүрээнд холбогдох зүйл, заалтыг сонгоно. Энэхүү зүйл, заалтыг сонгохдоо хууль зүйн хувьд шууд үр дагавар үүсгэж байгаа ач холбогдол бүхий заалтуудыг сонгож авсан. Өөрөөр хэлбэл, тухайн төслийн үр нөлөөг үнэлэхдээ цаг хугацаа, зардал хэмнэх үүднээс төсөлд голлох ач холбогдол бүхий заалтыг сонгож, тухайн сонгож буй зүйл, заалтын үр нөлөөг судална.

Түүнчлэн, төсөл батлагдсанаар тодорхой субъектэд үүрэг хүлээлгэсэн, тодорхой байгууллагад шинээр чиг үүрэг хүлээлгэж байгаа, мөн тухайн чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор шинээр нэгж, байгууллага бий болгох шаардлагатай эсэх зэргийг харгалзан үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон.

Ингээд сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдлыг шалгуур үзүүлэлт тус бүрийн дагуу авч үзье.

2.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд

Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах болсон “үндэслэл шаардлага, төслийн зорилго”[2] нь тодорхойгүй байна. Иймд 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд тусгасан “гүйцэтгэх эрх мэдэлтэй холбоотой Засгийн газрын бүрэлдэхүүн, гишүүдийг томилох, чөлөөлөх, огцруулах буюу Улсын Их Хурал, Засгийн газрын эрх мэдлийн харилцан хяналт, тэнцлийг хангахад чиглэсэн өөрчлөлт”-ийг уг хуулийн төсөлд оруулсныг “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтэд тооцон судалж үзлээ.

Учир нь Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлттэй холбогдох бусад хууль тогтоомжийн төслийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Засгийн газарт 2020 оны Улсын Их Хурлын 2 дугаар тогтоолоор

[2] Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтын Гурав дахь хэсгийн 3.1.1, 3.1.2-т заасан Хуулийн төслийн үзэл баримтлал батлагдаагүй байна.

даалгасан нь Монгол Улсын Засгийн газрын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн төсөл боловсруулах үндэслэл болж байна.

Иймд Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн үзэл баримтлалд дурдсан Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолоор батлагдсан "2016-2020 оны Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр"-т "...эрх мэдлийн харилцан хяналттай, тогтвортой, хариуцлагатай төрийг бий болгохын төлөө Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг өнөөгийн хэрэгцээ шаардлагыг харгалзан ард түмнээсээ асууж шийдвэрлэнэ."[3] гэсэн байх тул Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн зорилго нь Улсын Их Хурал, Засгийн газрын эрх мэдлийн харилцан хяналт, тэнцлийг хангах механизмыг бүрдүүлэн зохицуулахад оршиж байна. Дурдсан зорилгоо хэрэгжүүлэхийн тулд дараах зорилтыг дэвшүүллээ. Үүнд:

- Засгийн газар танхимын зарчмаар, тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх;
- Засгийн газрыг эмхлэн байгуулах.

Иймд хуулийн төслийн "зорилгод хүрэх байдал"-ын үр нөлөөг тооцохын тулд дээрх зорилтуудтай холбогдсон зүйл, заалтыг сонгон авч тооцох болно. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 2. *Зорилгод хүрэх байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зүйл, заалт*

Д/Д	Зорилгод хүрэх байдал	Сонгосон зүйл, заалт
1	Засгийн газар танхимын зарчмаар, тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх	Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 1/21 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 2/23 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт, 3 дугаар зүйлийн 2/23 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалт
2	Засгийн газрыг эмхлэн байгуулах, Улсын Их Хурлын гишүүн Засгийн газрын гишүүнээр хавсран ажиллахыг хязгаарлах	Хуулийн төслийн 2 дугаар зүйл

2.2. "Ойлгомжтой байдал" шалгуур үзүүлэлтийн хүрээнд

"Ойлгомжтой байдал" шалгуур үзүүлэлтийн хүрээнд уг төслийн зүйл, заалтад бүхэлд нь дүн шинжилгээ хийж, үр нөлөөг тооцно. /Хуулийн төсөл нь 5 бүлэг, 26 зүйлтэй/

2.3. "Зардал" шалгуур үзүүлэлтийн хүрээнд

"Зардал" шалгуур үзүүлэлтийн хүрээнд уг хуулийн төслийн зүйл, заалтыг бүхэлд нь шалгаж үзвэл иргэн, хуулийн этгээд, улсын төсөвт зардал, ачаалал үүсгэх зохицуулалт тусгаагүй байх тул цаашид зардлын тооцоо хийх шаардлагагүй гэж үзлээ.

2.4. "Харилцан уялдаа" шалгуур үзүүлэлтийн хүрээнд

"Харилцан уялдаа" шалгуур үзүүлэлтийн хүрээнд уг хуулийн төслийн зүйл, заалтыг бүхэлд нь шалгаж, үр нөлөөг тооцно. /Хуулийн төсөл 5 бүлэг, 26 зүйлтэй/

ГУРАВ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ҮР НӨЛӨӨГ ТООЦОХ

Өмнөх үе шатуудад хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгож, үр нөлөөг үнэлэх хэсгээ тогтоосон тул тэдгээрт тохирох шалгах хэрэгслийг дараах байдлаар харуулав.

[3] Монгол Улсын Их Хурал "Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн тайлбар" Уб., 2017 он.

Хуулийн нэгдсэн хүчинтэй www.pli.gov.mn

***Хүснэгт 3**. Шалгах хэрэгслийг сонгосон байдал*

№	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Тохирох шалгах хэрэгсэл
1.	Зорилгод хүрэх байдал	• Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 1/21 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 2/23 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт, 3 дугаар зүйлийн 2/23 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалт, • Хуулийн төслийн 2 дугаар зүйл	Зорилгод дүн шинжилгээ хийх.
2.	Ойлгомжтой байдал	Төслийг бүхэлд нь тооцно.	Хуулийн төслийн уялдаа холбоог Хууль тогтоомжийн тухай хууль болон аргачлалд заасан асуулгаар шалгах.
3.	Харилцан уялдаа	Төслийг бүхэлд нь тооцно.	Хуулийн төслийн уялдаа холбоог Хууль тогтоомжийн тухай хууль болон аргачлалд заасан асуулгаар шалгах.

Дээрх урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирсон шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг дараах байдлаар үнэллээ.

3.1. Зорилгод хүрэх байдал

<u>“Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал:</u>

Засгийн газар танхимын зарчмаар, тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх зорилгын хүрээнд хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 1/21 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 2/23 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт, 3 дугаар зүйлийн 2/23 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтад хийсэн шинжилгээ

Төслийн <u>21 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт</u> “Улсын Их Хурал Монгол Улсын Үндсэн хуулийн дөчин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу Ерөнхий сайдыг огцруулах тухай тогтоолыг баталсан тохиолдолд Ерөнхий сайд огцорно. Ерөнхий сайд огцорвол Засгийн газар бүрэлдэхүүнээрээ огцорно.”, <u>23 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт</u> “Засгийн газрын гишүүнийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн …, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн …-д тус тус заасны дагуу Улсын Их Хурал, Ерөнхийлөгчид танилцуулсны үндсэн дээр Ерөнхий сайд томилж, чөлөөлж, огцруулна;”, <u>3 дугаар зүйлийн 2/23 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалт</u> “Ерөнхий сайд Ерөнхийлөгчтэй зөвшилцсөний үндсэн дээр Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн, түүнд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ. Ерөнхийлөгчтэй зөвшилцөж чадаагүй тохиолдолд Улсын Их Хуралд өөрөө өргөн мэдүүлнэ;” гэсэн нэмэлт, өөрчлөлтийг оруулсан нь Засгийн газар танхимын зарчмаар, тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх тухай зохицуулжээ.

Ардын Их Хурлын 1990 оны 3 дугаар сарын чуулганд өргөн мэдүүлж, баталсан БНМАУ-ын төрийн байгууллагын шинэ тогтолцооны үзэл баримтлал хэмээх баримт бичигт Засгийн газрын үйл ажиллагааг танхимын зарчмаар явуулах тухай анх дурджээ. 1992 онд батлагдсан Үндсэн хуулийн 38 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын Засгийн газар бол төрийн гүйцэтгэх дээд байгууллага мөн” хэмээн заасан нь танхимын зарчмаар ажилладаг гүйцэтгэх дээд байгууллага гэдгийг тодорхойлсон. Төрийн бодлогын залгамж чанарыг хангах, хуулиар олгогдсон чиг үүргээ үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд Засгийн газар тогтвортой байж ажиллах шаардлагатай болно.[4] Гэвч шинэ Үндсэн хууль батлагдсанаас хойш Монгол Улсад 13 Засгийн газар байгуулагдаж байжээ. Эдгээр Засгийн газрын дундаж наслалт

[4] Н.Отгонбаяр, Засгийн газрыг байгуулж, огцруулах эрх зүйн зохицуулалт, төрийн бодлогын тогтвортой байдалд үзүүлэх нөлөө Монгол Улсын төрийн байгуулал дахь засаглалын институтын талаарх судалгаа, Конрад Аденаэур сан, МУИС-ийн Улс төр судлалын тэнхим, 2018 он, 113 дахь тал.

1 жил 10 сар буюу 2 жил хүрэхгүй хугацаатай байна.[5] Үндсэн хуулийн 40.1 дэх заалтад Засгийн газрын бүрэн эрхийн хугацаа 4 жил байхаар тогтоосон байдаг. Энэ Засгийн газрыг бүрдүүлэхэд парламентын оролцоо их байдаг[6], буюу Засгийн газрыг огцруулах үндэслэл "олон" янзаар огцруулж болохоор заасантай холбоотой байж болно.

2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр энэ байдлыг зохицуулахдаа Улсын Их Хурлын гишүүдийн дөрөвний нэгээс доошгүй нь Ерөнхий сайдыг огцруулах саналыг албан ёсоор тавьснаар шийдвэрлэж байгаа, мөн Засгийн газрын гишүүнийг Улсын Их Хурал, Ерөнхийлөгчид танилцуулснаар Ерөнхий сайд томилж, чөлөөлж, огцруулахаар, Монгол Улсын Ерөнхий сайд Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн, түүнд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Ерөнхийлөгчтэй зөвшилцөн Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ. Ерөнхий сайд энэ асуудлыг Ерөнхийлөгчтэй долоо хоногийн дотор зөвшилцөж чадаагүй бол Улсын Их Хуралд өөрөө өргөн мэдүүлэхээр заасан нь Засгийн газрыг тогтвортой, Засгийн газар танхимаар ажиллах зарчимд нийцүүлэн Ерөнхий сайд бие даан танхимаа бүрдүүлэх хуулийн зорилгодоо нийцэж байна.

Засгийн газрыг эмхлэн байгуулах зорилгын хүрээнд хуулийн төслийн 2 дугаар зүйлд хийсэн шинжилгээ

Хуулийн төслийн 2 дугаар зүйлд "Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Үндсэн хуулийн гучин есдүгээр зүйлд заасан ёсоор Засгийн газар Ерөнхий сайд, гишүүдээс бүрдэнэ." гэсний дараа "Ерөнхий сайд болон Засгийн газрын гишүүний дөрвөөс илүүгүй гишүүн Улсын Их Хурлын гишүүний албан тушаалыг хавсарч болно." гэсэн 2 дахь өгүүлбэрийг нэмсэн.

Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр Гучин есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Засгийн газар Ерөнхий сайд, гишүүдээс бүрдэнэ. Ерөнхий сайд болон Засгийн газрын дөрвөөс илүүгүй гишүүн Улсын Их Хурлын гишүүний албан тушаалыг хавсарч болно."[7] хэмээн Засгийн газрын бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулж байна.

1992 онд батлагдсан Үндсэн хуулийн 29 дүгээр зүйлийн 1-д "УИХ-ын гишүүн нь хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах бөгөөд бусад ажил, албан тушаал хавсарч болохгүй" гэснийг "УИХ-ын гишүүн нь Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүнээс бусад хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах ажил, албан тушаал хавсарч болохгүй"[8] гэж өөрчлөн найруулснаар "давхар албан тушаалын"-ын асуудлыг үүсгэн гол маргааны эхлэл болж Үндсэн хууль судлаач, эрдэмтэд байр суурьиа илэрхийлэх болсон. Академич Ж.Амарсанаа "...2000 онд МАХН, МҮАН, МСДН хуйвалдааны хэлбэрээр "Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг"-ийг батлав. Энэ баримт бичиг нь ядаж "хууль" гэсэн нэршилгүй. Үндсэн хуулийн бус аргаар оруулсан эл өөрчлөлт Монгол жинхэнэ Үндсэн хуулийн хямралын эхийг тавьсан"[9], Монгол Улсын гавьяат хуульч, доктор Б.Чимид "...Парламент, Засгийн газар хоёр нь нийлчихлээр хүний эрхийг зөрчих, хөрөнгө мөнгийг үрэн таран хийх суурийг тавьж өгсөн" хэмээн үзсэн байна.

---

[5] Д.Зүмбэрэллхам, "Төрийн албаны шинэтгэл ба тогтвортой нийгэм, өгүүлэл", Хууль дээдлэх ёс сэтгүүл, №76, Уб., 2020 он

[6] "Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээ", Уб., 2016 он, 108 дахь тал.

[7] *Энэ зүйлийг 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөн найруулсан бөгөөд 2020 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 12 цагаас эхлэн дагаж мөрдөнө.*

[8] *Энэ хэсгийг 1999 оны 12 дугаар сарын 24-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөн найруулсан, 2000 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн Үндсэн Хуулийн Цэцийн 02 дугаар тогтоолоор хүчингүй болгосон, 2000 оны 12 дугаар сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөн найруулсан*

[9] Үндсэн хуульт ёсны төлөвшил, цаашдын хандлага: Олон улсын эрдэм шинжилгээний бага хурал. Уб., 2012 он, 41 дэх тал.

Энэхүү Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг 2000 оны 11 дүгээр сарын 29-ны өдөр хуралдсан Үндсэн хуулийн Цэцийн их суудлын хуралдааны 02 тоот тогтоолоор 1999 оны 12-р сарын 24-ний өдрийн дүгнэлтээр хүчингүйд тооцсон байдаг.

Үндсэн хуулийн Цэцийн тогтоол одоо ч хүчинтэй хэвээр мөрдөгдөж байгаа учраас уг нэмэлт, өөрчлөлт ч хүчингүй гэж үзэх үндэслэлтэй юм.[10]

Ийнхүү Үндсэн хуульд 2000 онд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь өнөөг хүртэл маргаан дагуулсан хэвээр байсан.

Улсын Их Хурал, Засгийн газрын хяналт, тэнцэл, хариуцлагын тогтолцооны асуудал нь чухал юм. Монгол Улсын Үндсэн хуульд төрийн эрх мэдэл, засаглалыг тодорхой заасан төдийгүй Монгол Улсын Засгийн газар бол төрийн гүйцэтгэх дээд байгууллага мөн гэж заасан. Төрийн эрх мэдлийг Улсын Их Хуралд хадгалж, төрийн бодлого, хуулийг хэрэгжүүлэн гүйцэтгэх дээд байгууллага нь Засгийн газар. Тэгэхээр Засгийн газрын гишүүд нь Улсын Их хурлын гишүүдээс бүрдэхэд ирэхээр Улсын Их хурлаас төрийн бодлого хууль тогтоомжийн гүйцэтгэлд хяналт тавих, хариуцлага тооцох механизм сулрах нөхцөл бүрдэнэ. Угаасаа хяналт хариуцлага сулрах нь тодорхой төдийгүй, засаглалын хувьд байж боломгүй асуудал юм.[11]

Гадаадын орнууд Үндсэн хууль, бусад холбогдох хуульдаа Засгийн газрын гишүүн парламентын гишүүний үүргийг хавсран гүйцэтгэж болох эсэх талаар зохицуулахдаа: 1/Засгийн газрын гишүүн нь парламентын гишүүн байхыг шаарддаг; 2/Засгийн газрын гишүүн нь парламентын гишүүн байж болох зохицуулалт; 3/ Засгийн газрын гишүүн нь парламентын гишүүн байж болохгүй зохицуулалт; 4/ огт зохицуулалтгүй байхаар зохицуулдаг байна. Ингэхдээ гишүүний тоо, Засгийн газарт эзлэх хувь, тодорхой хязгаартай байдаг.[12]

Манай улсын хувьд Үндсэн хуульдаа төрийн эрх мэдэл хуваарилалт, хяналт, тэнцлийг хангах үүднээс "Ерөнхий сайд болон Засгийн газрын дөрвөөс илүүгүй гишүүн Улсын Их Хурлын гишүүний албан тушаалыг хавсарч болно" гэсэн зохицуулалтыг шинээр нэмж оруулснаар Засгийн газрын гишүүн УИХ-ын гишүүний албан үүргийг хавсран гүйцэтгэхэд хязгаарлал тавьсан байна.

Ийнхүү Улсын Их Хурлын гишүүн Засгийн газрын гишүүнээр хавсран ажиллах хязгаарыг хуульчилснаар УИХ, Засгийн газрын хүлээх үүрэг, чиг үүргийн давхардлыг арилгаж, улмаар Парламент Засгийн газрын харилцан хяналт, тэнцвэрт байдлыг, тэдгээрийн хоорондын харилцааны механизмыг хангахад чиглэсэн зохицуулалт нь хуулийн төслийн зорилгод нийцсэн байна.

3.2. Ойлгомжтой байдал

Хууль тогтоомжийн тухай хуулийн[13] /цаашид "ХТтХ" гэх/ 29 дүгээр зүйлд заасан хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлагад нийцүүлэн боловсруулсан эсэхийг дараах байдлаар шалгасан.

Хүснэгт 4. *Хууль тогтоомжийн тухай хуулийн 29, 30 дугаар зүйлд заасан шаардлагад нийцүүлэн боловсруулсан эсэх*

Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан Хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага	
Хууль тогтоомжийн тухай хуулийн зохицуулалт	Хуулийн төслийн зохицуулалтад үнэлгээ хийсэн байдал

[10] Ш.Цогтоо, Үндсэн хуулийн 7 нэмэлт, өөрчлөлт ба Үндсэн хуулийн нэмэлтэд хориглох, хязгаарлах хэм хэмжээ /онол, практик/, Хууль дээдлэх ёс сэтгүүл, Уб., 2018 он, 52 дахь тал.

[11] "Давхар дээл"-ээр судлаачид юу гэв?, https://news.mn/r/703851/

[12] Дэлгэрэнгүйг МҮҮХ-д оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөлтэй холбоотой судалгаа, мэдээлэл, лавлагаа, Уб., 2017он.

[13] Хууль тогтоомжийн тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2015 он, №25.

29.1.1. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, *бусад хууль,* үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байх;	Төслийн зарим зүйл, заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн зарим зүйл, заалттай уялдаагүй байна. Дэлгэрэнгүйг харилцан уялдаа хэсгийн "Хуулийн төслийн зүйл, заалт нь тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх" хэсгээс үзнэ үү.
29.1.2. Тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх;	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
29.1.3. Тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх;	Хуулийн төсөл зохицуулах харилцаа, хүрээнээс хальсан зүйл судалгаагаар тогтоогдоогүй.
29.1.4. Тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд үл хамаарах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болсонд тооцох тухай заалт тусгахгүй байх;	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
29.1.5. Зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх;	Төслийн зүйл, заалт нь хоорондоо зөрчилдсөн хэд хэдэн тохиолдол илэрсэн. 1. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлд "...39[2].2. Засгийн газрын гишүүнд нэр дэвшигчийг Ерөнхий сайд болон нэр дэвшигчээс *асуулт асууж, үг хэлж болно*" гэж, мөн зүйлд "...39[2].3. Байнгын хорооны болон ... нэр дэвшигчээс *асуулт асууж, үг хэлж болно*" гэж, мөн төслийн 2 дугаар зүйлд "...38.3. Байнгын хорооны ... гишүүд *асуулт асууж, үг хэлж болно*" гэж, мөн зүйлд "...39[1].3. "...Байнгын хорооны болон ... *асуулт асууж, үг хэлж болно*" гэж тус тус заасан хэрнээ тус төслийн 2 дугаар зүйлд "...39.4. Байнгын хорооны ... Ерөнхий сайдаас *асуулт асууж, хариулт авч* болох бөгөөд үүнээс өөрөөр хэлэлцүүлэг явуулахгүй." гэсэн байгаа нь өөр хоорондоо зөрчилтэй байна. 2. Монгол Улсын Их Хурлын Чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 39[1].2-т "... хуралдаанд оролцсон гишүүдийн олонхи дэмжсэн бол" гэж ойлгомжтой байдлаар бичсэн бол 37.2-т "... нэр дэвшигчийг гишүүдийн олонхи дэмжсэн бол" гэж хэт ерөнхий эргэлзээтэй байдал үүсгэхээр бичжээ. Өөрөөр хэлбэл, *нийт гишүүдийн* эсхүл *хуралдаанд оролцсон гишүүдийн* алиных нь олонхи болохыг тодорхой байдлаар хуульчлах нь зүйтэй. Иймд энэхүү хоёр зохицуулалтыг нэг мөр болгох нь зүйтэй.
29.1.6. Хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх;	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
29.1.7. Бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд ишлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх;	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
29.1.8. Тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаа, хуулийн үйлчлэх хүрээ, эрх зүйн харилцаанд оролцогч хүн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, зохицуулалтад удирдлага болгох, харгалзан үзэх нөхцөл байдал, нийтийн эрх зүйн этгээдийн чиг үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийг биелүүлэх журам;	Хуулийн төсөл бүхэлдээ

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.parliament.mn

29.1.9. Шаардлагатай тохиолдолд эрх зүйн хэм хэмжээ зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын төрөл, хэмжээ, хуулийн хүчин төгөлдөр болох хугацаа, хууль буцаан хэрэглэх тухай заалт, хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалт, бусад хуулийн зүйл, заалтыг хүчингүй болсонд тооцох, хасах заалт;	1/Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хүчин төгөлдөр болох хугацаа, хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалт тусгагдаагүй байна. 2/ Мөн хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 1/21 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 1/4 дүгээр зүйлийн 1-д хуулийн зүйл, заалтыг орхигдуулсан.
29.1.10.Шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулсан байх;	Хуулийн төслийг дагалдан “Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулжээ. Өөрөөр хэлбэл, Хууль тогтоомжийн тухай хуулийн 29.1.10-д заасан шаардлагыг зөрчсөн асуудал тогтоогдоогүй болно.
29.1.11. Хуулийн төсөл нь хуулийн зорилго гэсэн зүйлтэй байж болох бөгөөд зорилгод тус хуулиар хангахаар зорьж байгаа иргэний үндсэн эрх, бэхжүүлэх үндсэн зарчим, хүрэх үр дүнг тусгана.	Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь хуулийн зорилго гэсэн зүйлгүй байна. Энэ нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.11-д заасан заалт нь “... хуулийн зорилго гэсэн зүйлтэй байж болох бөгөөд” буюу заавал байх ёстой гэсэн зохицуулалт биш учир зөрчсөн гэж үзэхгүй юм.
Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан Хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага.	
30.1.1. Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томьёог хэрэглэх;	Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийг 3/ 36 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 3-т “Засгийн газар нь ... бэлгэдлийг *хуулийн этгээд, төрийн бус байгууллага* хэрэглэхийг хориглоно” гэж заажээ. Гэтэл “Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль”-ийн 7.1.3-т зааснаар төрийн бус байгууллага нь хуулийн этгээд гэх ойлголтод хамаардаг. Иймд хоёр тусдаа ойлголт мэт тусгасан байгааг нэгтгэн “...Засгийн газар нь ... бэлгэдлийг *хуулийн этгээд* хэрэглэхийг хориглоно” гэж зохицуулах нь зүйтэй юм.
30.1.2. Нэг нэр томьёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх;	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
30.1.3. Үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих	Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1.1-д заасан “... Үндсэн хуулийн дөчин гуравдугаар зүйлийн...” гэснийг “... Үндсэн хуулийн *Дөчин* гуравдугаар зүйлийн...” гэж засах, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2.1-д заасан “... Үндсэн хуулийн гучин есдүгээр зүйлийн...” гэснийг “... Үндсэн хуулийн *Гучин* есдүгээр зүйлийн...*”* гэж засах, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 3.1-д заасан “... Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн...” гэснийг “...Үндсэн хуулийн *Хорин* тавдугаар...” гэж засах, мөн “... гучин есдүгээр зүйл...” гэснийг “...Гучин есдүгээр зүйл..” гэж тус тус засах, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлд “...*39².2. Засгийн газрын гишүүд ... Ерөнхий сайд Төрийн байгуулалтын байнгын хорооны.... танилцуулна*...” гэж заасан хэрнээ бусад зүйл заалтуудад “... байнгын хороо...” гэж заасан байна. Иймд тус хуульд “Төрийн байгуулалтын байнгын хороо” -г /Цаашид “байнгын хороо” гэх/ гэж хуульд тусгах нь зүйтэй.

ХУУЛЬЗҮЙН ЯАМНЫ ХУРЭЭЛЭН www.mojus.mn

	Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлд *"...38.2.Нэгдсэн хуралдаан ... хэрэв Цэц дүгнэлт .... тооцно..."* гэснийг *"...хэрэв Монгол Улсын Үндсэн хуулийн цэц..."* гэж өөрчлөх. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлд *"...39.5.Улсын Их Хуралд ... Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн..."* гэж заасныг *"... Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн..."* гэж засах. Хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн "22 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн ""25.9-25,11-д" гэснийг "25.9-25,11-д" гэж, "... *заалтыг дугаарыг* 3,4,5,6,7,8,9 гэж тус тус," гэснийг "... *заалтын дугаарыг" гэж, 2 дугаар зүйлийн ", бэлгэдэл"* гэснийг *"бэлгэдэл" гэж засах*.
30.1.4. Хүч оруулсан нэр томьёо хэрэглэхгүй байх;	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
30.1.5. Жинхэнэ нэрийг ганц тоон дээр хэрэглэх.	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.

3.3. Харилцан уялдаа

Төслийн харилцан уялдаа холбоог шалгах шалгуур үзүүлэлтийн хүрээнд давхардал, хийдэл, зөрчлийг судлан, дотоод болон бусад хуультай уялдах уялдаа холбоог сайжруулах юм. Түүнчлэн хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалд заасан дараах асуудлыг тодорхойлох байдлаар төслийн харилцан уялдаатай байдлыг үнэллээ.

Хүснэгт 5. *Харилцан уялдаатай эсэхийг үнэлсэн байдал*

Аргачлалд заасан асуулт	Хуулийн төслийг үнэлсэн байдал
Хуулийн төслийн зохицуулалт нь тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх	Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн зорилт нь Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны зарчим, чиг үүрэг, бүрэн эрх, бүтэц, бүрэлдэхүүн, ажлын зохион байгуулалт, түүнчлэн Засгийн газраас бусад байгууллагатай харилцан ажиллах журмыг тогтоож, зохицуулахад оршино гэж заасан. Төслийн 1 болон 2 дугаар зүйлд тусгасан нэмэлт, 3 болон 4 дүгээр зүйлд тусгасан өөрчлөлт, 5, 6 дугаар зүйлд тусгасан хассан болон хүчингүй болгосон хэсгээс харахад төслийн зохицуулалт нь тухайн хуулийн зорилттой нийцсэн байна.
Хуулийн төслийн нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх,	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томьёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томьёотой нийцэж байгаа эсэх	Төслийн 1 дүгээр зүйлийн 36 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт Засгийн газар нь албан ёсны бэлгэдэлтэй байх бөгөөд Засгийн газар гэсэн нэршил, бэлгэдлийг *хуулийн этгээд, төрийн бус байгууллага* хэрэглэхийг хориглоно." гэж заасан. Иргэний хуульд ашгийн төлөө бус хуулийн этгээд нь холбоо, сан, хоршоо гэсэн төрөлтэй байхаар заасан бол Төрийн бус байгууллагын тухай хуульд "ТББ" гэх ангиллыг бий болгож хуульчилсан. Үүнээс үзвэл төрийн бус байгууллага нь ашгийн төлөө бус хуулийн этгээдийн нэг төрөл байх тул "хуулийн этгээд, төрийн бус байгууллага" хэмээн хуулийн этгээдийн төрөлд хамааралгүй мэтээр зэрэгцүүлэн авсан нь нэр томьёоны хувьд буруу хэрэглэсэн байна.

Хууль зүйн яамны хүрээлэн www.mjs.gov.mn

Хуулийн төслийн зүйл, заалт нь тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх	Төслийн 2 дугаар зүйлд "...24 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалтын "үүрэгтэй." гэсний дараа "Засгийн газрын гишүүн Улсын Их Хуралд тангараг өргөх бөгөөд тангараг өргөх журмыг Улсын Их Хурал тогтооно." гэсэн 2 дахь өгүүлбэр нэмэх тухай заасан тус заалтад "үүрэгтэй" гэсэн үг ороогүй байна.
	Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлд, 38 дугаар зүйлийн 1-д "Ерөнхий сайдыг огцруулах саналыг Улсын Их Хуралд <u>өргөн мэдүүлсэн бол</u> уг саналыг *Төрийн байгуулалтын байнгын хороо <u>7 хоногийн дотор</u> хуралдаанаараа хэлэлцэж санал, дүгнэлт гаргана.*", 38 дугаар зүйлийн 2-д *"Нэгдсэн хуралдаан Байнгын хорооны санал, дүгнэлт гарснаас <u>хойш 7 хоногийн дотор</u> хуралдаж* Байнгын хорооны, хэрэв Цэц дүгнэлт гаргасан бол түүний дүгнэлтийг сонсож илээр санал хураалт явуулж гишүүдийн олонхи дэмжсэн бол огцруулах тухай тогтоол батлагдсанд тооцно." гэж тус тус тусгасан байна. Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин гуравдугаар зүйлийн 1-д "Улсын Их Хурлын гишүүдийн дөрөвний нэгээс доошгүй нь Ерөнхий сайдыг огцруулах саналыг албан ёсоор тавибал Улсын Их Хурал *<u>гурав хоногийн дараа</u> хэлэлцэж эхлэн <u>арав хоногийн дотор</u> шийдвэрлэнэ.* Улсын Их Хурлын нийт гишүүний олонхи уг саналыг дэмжсэн бол Ерөнхий сайдыг огцруулах тухай Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцож, шинэ Ерөнхий сайдыг гуч хоногийн дотор томилно." гэж заасантай зөрчилдөж байна.
	Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлийн 39 дүгээр зүйлд "Ерөнхий сайд *<u>огцрох</u>* тухай саналыг хэлэлцэх журам" гэсэн гарчигтай зүйл, заалт нь Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн Дөчин гуравдугаар зүйлийн 1-д "... *<u>огцруулах</u>* саналыг албан ёсоор тавибал..." хэмээн огцруулах асуудлыг зөвхөн тусгаж өгсөн бөгөөд одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Үндсэн хуулийн Дөчин гуравдугаар зүйлийн 1-д *заасан <u>огцрох</u>* заалтыг хассанаар боломжийг хязгаарлаж өгсөн байна. Мөн хуулийн төслийн 3 дугаар зүйлийн 1/4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт "Ерөнхий сайд *<u>огцрох,</u>* чөлөөлөгдөх..." гэж оруулсан нь Үндсэн хуулийн нэмэлтийн тухай хуультай зөрчилдөж байна.
Хуулийн төслийн зүйл, заалт нь тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх	Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 4 дүгээр зүйлд "23 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн...гэж, мөн зүйлийн 2, 3, 4, 5 дахь хэсгийн дугаарыг "3, 4, 5, 6" гэж, ... 23 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2, 3, 4, 5, 6, 7, 8 дахь заалтыг дугаарыг "3, 4, 5, 6, 7, 8, 9" гэж тус тус ..." гэж заасан нь давхардуулан зохицуулсан байна.
Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
Хуулийн төсөлд байх шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх	Төсөлд энэ хуулийг хүчин төгөлдөр болох өдөр болон дагаж мөрдөх талаар тусгаж өгөөгүй байна.
Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
Төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.

хуулийн зүйн мэдээлэл www.mnlegal.mn

Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр хураамж тогтоосон эсэх	Хуулийн төсөлд татвар, төлбөр хураамж шинээр тогтоосон зүйлгүй байна.
Тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгаж байгаа эсэх	Хуулийн төсөлд тусгай зөвшөөрөлтэй холбоотой тусгай зохицуулалт тусгаагүй байна.
Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх	Хуулийн төслөөр хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгаагүй байна.
Хуулийн төслийн зүйл, заалт нь жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх	Хуулийн төслөөр хүйсийн ялгавартай байдал бий болгосон зүйл, заалт байхгүй.
Шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэгдсэн заалт тусгагдсан эсэх	Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэгдсэн заалт тусгагдаагүй байна.
Авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэгдсэн заалт тусгагдсан эсэх	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
Хуулийн төсөлд тусгасан хориглосон зохицуулалтыг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.

ДӨРӨВ. ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ

4.1. Дүгнэлт

Тус үнэлгээний хүрээнд захиалагч байгууллагаас хуулийн төсөл, холбогдох хуулиудын нэмэлт, өөрчлөлтийг ирүүлсэн бөгөөд эдгээр мэдээлэлд тулгуурлан судлаачдын зүгээс холбогдох хууль тогтоомж, судалгааны тайлан, гарын авлага зэргийг ашиглан үнэлгээг гүйцэтгэлээ.

Үнэлгээг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтын дагуу 3 шалгуур үзүүлэлтийн хүрээнд гүйцэтгэсэн болно. Эдгээрийг сонгосон шалгуур үзүүлэлт тус бүрээр дүгнэвэл:

1. *“Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд:*

Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлттэй холбогдох бусад хууль тогтоомжийн төслийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Засгийн газарт 2020 оны Улсын Их Хурлын 2 дугаар тогтоолоор даалгасан нь Монгол Улсын Засгийн газрын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн төсөл боловсруулах үндэслэл болжээ.

Иймд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслийн үзэл баримтлал мөн Монгол Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолоор батлагдсан “2016-2020 оны Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр”-т “...эрх мэдлийн харилцан хяналттай, тогтвортой, хариуцлагатай төрийг бий болгохын төлөө Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг өнөөгийн хэрэгцээ шаардлагыг харгалзан ард түмнээсээ асууж шийдвэрлэнэ.” гэж заасныг үндэслэн хуулийн төслийн зорилгыг “УИХ, Засгийн газрын эрх мэдлийн харилцан хяналт, тэнцлийг хангах механизмыг бүрдүүлэн

Хуулийн Үндэсний Хүрээлэн www.nli.gov.mn

зохицуулахад оршиж байна” гэж үзэн зорилгоо хэрэгжүүлэхийн тулд дараах зорилтыг дэвшүүлсэн. Үүнд:

- Засгийн газрыг эмхлэн байгуулах;
- Засгийн газар танхимын зарчмаар, тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх.

Уг хуулийн төслийн “зорилгод хүрэх байдал”-ын үр нөлөөг:

1/ Засгийн газар танхимын зарчмаар, тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх хүрээнд хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 1/21 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 2/23 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт, 3 дугаар зүйлийн 2/23 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтад шинжилгээ хийж үзсэнээр Засгийн газрыг тогтвортой, Засгийн газар танхимаар ажиллах зарчимд нийцүүлэн Ерөнхий сайд бие даан танхимаа бүрдүүлэх хуулийн зорилгодоо нийцэж байна гэж үзлээ.

2/ Засгийн газрыг эмхлэн байгуулах хүрээнд хуулийн төслийн 2 дугаар зүйлийг сонгон авч “Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Үндсэн хуулийн гучин есдүгээр зүйлд заасан ёсоор Засгийн газар Ерөнхий сайд, гишүүдээс бүрдэнэ.” гэсний дараа “Ерөнхий сайд болон Засгийн газрын гишүүний дөрвөөс илүүгүй гишүүн Улсын Их Хурлын гишүүний албан тушаалыг хавсарч болно.” гэсэн 2 дахь өгүүлбэрийг нэмсэн заалтад дүн шинжилгээ хийж үзвэл Үндсэн хуульдаа төрийн эрх мэдэл хуваарилалт, хяналт, тэнцлийг хангах үүднээс “Ерөнхий сайд болон Засгийн газрын дөрвөөс илүүгүй гишүүн Улсын Их Хурлын гишүүний албан тушаалыг хавсарч болно” гэсэн зохицуулалтыг шинээр нэмж оруулснаар Засгийн газрын гишүүн УИХ-ын гишүүний албан үүргийг хавсран гүйцэтгэхийг тодорхой байдлаар хязгаарлаж, энэхүү хязгаарыг хуульчилснаар УИХ, Засгийн газрын хүлээх үүрэг, чиг үүргийн давхардлыг арилгах, улмаар Парламент Засгийн газрын харилцан хяналт, тэнцвэрт байдал, тэдгээрийн хоорондын харилцааны механизмыг хангахад чиглэсэн зохицуулалт болсон нь хуулийн төслийн зорилгод нийцсэн гэж үзэж байна.

2. “*Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд:*

Төслийн ойлгомжтой байдлыг Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага, мөн Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалыг баримталсан эсэхийг харгалзан үнэлэхэд төслийн зарим зүйл, заалт шаардлагад нийцээгүй болох нь тогтоогдож байна. Үүнд[14]:

- Төсөлд хоёрдмол утга агуулсан, давхардсан, хоорондоо зөрчилдөж ойлгомжгүй байдал үүсгэсэн, зохих хэсэгт тусгаагүй зүйл, заалт байгаагаас дурдвал Монгол Улсын Их хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлд “...392.2.Засгийн газрын гишүүнд нэр дэвшигчийг Ерөнхий сайд болон нэр дэвшигчээс *асуулт асууж, үг хэлж* болно” гэж, мөн зүйлд “...392.3. Байнгын хорооны болон ... нэр дэвшигчээс *асуулт асууж, үг хэлж* болно” гэж, мөн төслийн 2 дугаар зүйлд “...38.3.Байнгын хорооны ... гишүүд *асуулт асууж, үг хэлж* болно” гэж, мөн зүйлд “...391.3. “...Байнгын хорооны болон ... *асуулт асууж, үг хэлж* болно” гэж тус тус заасан хэрнээ тус төслийн 2 дугаар зүйлд “...39.4. Байнгын хорооны ... Ерөнхий сайдаас *асуулт асууж, хариулт* авч болох бөгөөд үүнээс өөрөөр хэлэлцүүлэг явуулахгүй.” гэсэн байгаа нь өөр хоорондоо зөрчилтэй байна.
- Үндсэн хууль болон хүчин төгөлдөр үйлчилж буй бусад хууль тогтоомжтой уялдаагүй зүйл, заалтад Монгол Улсын Их хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2

[14] Дэлгэрэнгүйг үнэлгээний тайлангийн “ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийг үнэлсэн хэсгээс үзнэ үү.

дугаар зүйлд "...39.5.Улсын Их Хуралд ... Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн..." гэж заасныг "... Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн..." гэж засах.

- Хэл зүйн найруулгын хувьд Хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн "22 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн тавих нийтлэг ""25.9-25,11-д" гэснийг "25.9-25,11-д" гэж, "...заалтыг дугаарыг 3,4,5,6,7,8,9 гэж тус тус," гэснийг "...заалтын дугаарыг" гэж, 2 дугаар зүйлийн ", бэлгэдэл" гэснийг "бэлгэдэл" гэж засах.

3. *"Зардал" шалгуур үзүүлэлтийн хүрээнд:*

Төслийн үр нөлөөг тооцох аргачлалын дагуу "Зардал" шалгуур үзүүлэлтийн хүрээнд уг хуулийн төслийн зүйл, заалтыг бүхэлд нь шалгаж үзвэл иргэн, хуулийн этгээд, улсын төсөвт зардал, ачаалал үүсгэх зохицуулалт тусгаагүй байх тул зардлын тооцоо хийх шаардлагагүй гэж үзсэн болно.

4. *"Харилцан уялдаа" шалгуур үзүүлэлтийн хүрээнд:*

Төслийн үр нөлөөг тооцох аргачлалын дагуу тодруулах шаардлагатай 16 төрлийн асуулгаас 12 төрлийн асуулга шаардлага хангасан, уялдаа холбоотой болсон бөгөөд төсөлд шинээр албан татвар, төлбөр, хураамж тогтоосон зүйлгүй, жендэрийн эрх тэгш байдлыг хангасан, авлига хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгаагүй байна. Шалгуур үзүүлэлтэд заасан 4 асуулгын хүрээнд хуулийн төслийн зарим зүйл, заалт харилцан уялдаа холбоотой байх шаардлага хангаагүй гэж үзлээ. Үүнд:

- Нэр томьёоны хувьд бусад хууль болон төсөлд тусгагдсан нэр томьёотой нийцэхгүй байх тохиолдол байна. Тухайлбал, *"хуулийн этгээд, төрийн бус байгууллага* хэрэглэхийг хориглоно." гэж заасан нь "Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль"-д зааснаар төрийн бус байгууллага нь *"хуулийн этгээд"* гэх ойлголтод хамаардаг тул нэг ойлголтоор илэрхийлэх нь зүйтэй гэж үзлээ.
- Төсөлд тусгагдсан зүйл, заалт нь тухайн хуулийн төсөлд болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа байдлын хүрээнд хэд хэдэн зөрчилтэй заалтууд илэрсэн. Тухайлбал, 2 дугаар зүйлд "...24 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалтын *"үүрэгтэй"* гэсний дараа гэж заасанд *"үүрэгтэй"* гэсэн үг ороогүй, Үндсэн хуулийн Дөчин гуравдугаар зүйлийн 1-д "...*гурав хоногийн дараа хэлэлцэж эхлэн арав хоногийн дотор* шийдвэрлэнэ" гэснийг Монгол Улсын Их хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлд, 38 дугаар зүйлийн 1-д "...*7 хоногийн дотор*, 38 дугаар зүйлийн 2-т "...*7 хоног*..." гэсэн хугацааны хувьд өөр өөр тодорхойлсон, Үндсэн хуулийн Дөчин гуравдугаар зүйлийн 1-д заасан *"огцрох"* заалтыг хассан байтал холбогдох нэмэлт, өөрчлөлтөд тусгагдсан хэвээр байгаа нь өөр хоорондоо нийцэхгүй байна.
- Хуулийн төсөлд байх шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан байж болзошгүй хэсэгт хуулийн төслийг *хүчин төгөлдөр болох өдөр* болон *дагаж мөрдөх* талаар тусгаж өгөөгүй гэж үзсэн.

Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулан Засгийн газарт 2020 оны Улсын Их Хурлын 2 дугаар тогтоолоор даалгасан нь төсөл боловсруулах хуваарийн дагуу Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийг *шинэчлэн найруулах* тухай тусгасан. Ингэхдээ:

- Засгийн газрын тогтвортой ажиллах эрх зүйн үндсийг боловсронгуй болгох;
- Засгийн газар танхимаар ажиллах зарчимд нийцүүлэн Ерөнхий сайд бие даан танхимаа бүрдүүлэх зохицуулалтыг хуульчлах;
- Ерөнхий сайд өөрт нь итгэл үзүүлэх эсэх асуудлыг Улсын Их Хуралд

оруулах зохицуулалтыг хуульчлах;

- Улсын Их Хурлын гишүүн Засгийн газрын гишүүнээр хавсран ажиллах хязгаарыг хуульчлах талаар чиглэл өгсөн байна.

Эдгээр асуудлыг Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгасан хэдий ч дээр дурдсанаар Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд тусгаагүй үлдсэн, давхардсан, зөрчилдсөн асуудал байна. Тухайлбал; Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан "огцрох" гэсэн заалттай холбоотой зохицуулалт хүчингүй болж байгаа хэдий ч Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд энэ тухай 9 заалтыг хэвээр үлдээсэн байх тул Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийг *шинэчлэн найруулах* хуулийн төслийг боловсруулах шаардлагатай юм.

4.2. Зөвлөмж

Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх ажиллагааны үр дүнд гарсан дүгнэлтэд тулгуурлан дараах зөвлөмжийг гаргаж байна. Үүнд:

- Хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлагыг төслийн 2 дугаар зүйлд "...39.4. Байнгын хорооны ... Ерөнхий сайдаас асуулт асууж, хариулт авч болох бөгөөд үүнээс өөрөөр хэлэлцүүлэг явуулахгүй." гэж заасныг "асуулт асууж, үг хэлж болно" гэж зохицуулах,
- Монгол Улсын Их хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 37.2-т "...нэр дэвшигчийг гишүүдийн олонхи дэмжсэн бол" гэж заасныг "нийт гишүүдийн" эсхүл "хуралдаанд оролцсон гишүүдийн" алиных нь олонхи болохыг тодорхой болгох,
- Хуулийн төслийн хүчин төгөлдөр болох хугацаа, хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалтыг тусгах,
- Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 1/21 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 1/4 дүгээр зүйлийн 1-д хуулийн зүйл, заалтыг тодорхой болгох,
- Үндсэн хуулиас ишлэсэн заалтыг "...дөчин гуравдугаар зүйлийн..." гэснийг "...Дөчин гуравдугаар..." гэж, "...гучин есдүгээр зүйлийн..." гэснийг "...Гучин есдүгээр зүйлийн..." гэж, "...хорин тавдугаар зүйлийн..." гэснийг "...Хорин тавдугаар зүйлийн..." гэж өөрчлөх,
- Монгол Улсын Их хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлд "...38.2.Нэгдсэн хуралдаан ... хэрэв Цэц дүгнэлт .... тооцно..." гэснийг "...хэрэв Монгол Улсын Үндсэн хуулийн цэц..." гэж өөрчлөх,
- Монгол Улсын Их хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлд "...39.5.Улсын Их Хуралд ... Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн..." гэж заасныг "... Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн..." гэж өөрчлөх,
- Хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн "22 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн ""25.9-25,11-д" гэснийг "25.9-25,11-д" гэж, "...заалтыг дугаарыг 3,4,5,6,7,8,9 гэж тус тус," гэснийг "...заалтын дугаарыг" гэж, 2 дугаар зүйлийн ", бэлгэдэл" гэснийг "бэлгэдэл" гэж өөрчлөх,
- Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 36 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт "... хуулийн этгээд, төрийн бус байгууллага..." гэснийг "...хуулийн этгээд..." гэж өөрчлөх,
- Хуулийн төслийн 2 дугаар зүйлд "...24 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь

Хуулийн зүйлийн хүрээлэн www.ihl.gov.mn

заалтын “үүрэгтэй.” гэж заасныг зөв тодорхойлох,

- Монгол Улсын Их хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлд, 38 дугаар зүйлийн 1-д “...*7 хоногийн дотор*, 38 дугаар зүйлийн 2-т “...*7 хоног*...” гэсэн хугацааг Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин гуравдугаар зүйлийн 1-д заасантай нийцүүлэх,
- Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин гуравдугаар зүйлийн 1-дэх заалтыг нэмэлт, өөрчлөлтөөр хассан тул бусад хуулиас *“огцрох”*-той холбогдсон заалтыг нийцүүлэх,
- Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийг *шинэчлэн найруулах* хуулийн төслийг боловсруулах нь зүйтэй гэж үзэж байна.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

НОМ ЗҮЙ

Нэг. Монгол Улсын хууль

- Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл (1992), №1
- Монгол Улсын Засгийн газрын тухай хууль (1993), №3
- Монгол Улсын Их Хурлын тухай хууль (2006), №8
- Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль (2007), №39
- Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль (2019), №49
- Хууль тогтоомжийн тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл (2015), №25

Хоёр. Судалгааны тайлан, холбогдох эх сурвалж

- Хууль зүйн үндэсний хүрээлэн, "Төрийн албан хаагчийн хариуцлагын тухай" хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх үнэлгээний тайлан, Уб., 2018 он
- "Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээ" Уб., 2016 он
- Монгол Улсын Их Хурал "Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн тайлбар" Уб., 2017 он
- Монгол Улсын Их Хурал "Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөлтэй холбоотой" /судалгаа, мэдээлэл, лавлагаа/, Уб., 2017 он
- Ж.Амарсанаа, Эрх зүйн мэдлэгийн товч толь, Уб.,1986 он
- Б.Чимид, Үндсэн хуулийн үзэл баримтлал: Нийтлэг асуудал, Нэгдүгээр дэвтэр, Уб., 2004 он
- Д.Зүмбэрэллхам, "Төрийн албаны шинэтгэл ба тогтвортой нийгэм, өгүүлэл", Хууль дээдлэх ёс сэтгүүл, №76, Уб., 2020 он
- С.Нарангэрэл, Эрх зүйн эх толь бичиг, Уб., 2007 он
- Н.Отгонбаяр, "Засгийн газрыг байгуулж, огцруулах эрх зүйн зохицуулалт, төрийн бодлогын тогтвортой байдалд үзүүлэх нөлөө", Монгол Улсын төрийн байгуулал дахь засаглалын институтын талаарх судалгаа, Конрад Аденаэур сан, МУИС-ийн Улс төр судлалын тэнхим, Уб., 2018 он
- Тогтвортой хөгжил ба Үндсэн хууль /Эрдэм шинжилгээний бага хурлын эмхэтгэл/ Уб., 2020 он
- Үндсэн хуульт ёсны төлөвшил, цаашдын хандлага: Олон улсын эрдэм шинжилгээний бага хурал, Уб., 2012 он
- Ш.Цогтоо, Үндсэн хуулийн 7 нэмэлт, өөрчлөлт ба Үндсэн хуулийн нэмэлтэд хориглох, хязгаарлах хэм хэмжээ /онол, практик/, Хууль дээдлэх ёс сэтгүүл, Уб., 2018 он

Гурав. Цахим эх сурвалж

- Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем, http://www.legalinfo.mn/
- "Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт"-ийн тухай http://www.parliament.mn/search?query=үндсэн%20хуулийн%20нэмэлт&agg=1
- Давхар дээл"-ээр судлаачид юу гэв? https://news.mn/r/703851/
- Australian Covernmant Prime Minister and Cabinet http://www.comlaw.gov.au/series/c2004A00538

Хуулийн Үндэсний Хүрээлэн www.jhl.gov.mn

ЦАХИМ ГАРЫН ҮСГИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ[15]

УДИРТГАЛ

Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.3-т "Хууль заавал хэрэгждэг, хүн бүрт эрх тэгш, алагчлалгүй, шударга үйлчилдэг, итгэл хүлээсэн хүний эрхийн мэдрэмжтэй, шударга ёсны засаглалыг бэхжүүлэх зарчмыг баримтлана" гэж, 5.4.1-д "Хуулийн байгууллагуудын үйл ажиллагааг ил тод, нээлттэй болгож, иргэдэд чирэгдэлгүй, ялгаваргүй, тэгш, шударгаар үйлчлэх эрх зүйн орчинг цогцоор нь бүрдүүлнэ" гэж тус тус заасан байна.

ХЗДХЯ-наас ирүүлсэн 1-4/1677 тоот албан бичигт үндэслэн Хууль зүй, дотоод хэргийн сайдаас өгсөн чиглэлийн дагуу Цахим гарын үсгийн тухай хууль практикт хэрхэн хэрэгжиж байгааг тогтоох үүднээс энэхүү хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийв.

Цахим гарын үсгийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээний зорилго нь тус хуулийн хэрэгжилтийн явц дахь хүндрэл, бэрхшээл, нийгэмд үзүүлж буй эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлэн, цаашид зохистой, үр дүнтэй хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлж, үнэлэлт дүгнэлт өгөх, зөвлөмж боловсруулахад оршино.

НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ

Цахим гарын үсгийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх ажлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан "Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал"-ын дагуу төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх гэсэн гурван үе шаттайгаар хийж гүйцэтгэсэн. Төлөвлөх үе шатанд дараах ажлыг хийж гүйцэтгэв. Үүнд:

1. Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох;
2. Үнэлгээ хийх хүрээг тогтоох;
3. Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох;
4. Харьцуулах хэлбэрийг сонгох;
5. Шалгуур үзүүлэлтийг томьёолох;
6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох;

1.1. Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох

Дэлхийн улс орнуудад тоон гарын үсгийг хэрэглэх асуудлыг 1990 оноос эхлэн хуульчлан өгсөн байна. Харин манай улсын хувьд 2011 оныг хүртэл цахим гарын үсэгтэй холбоотой эрх зүйн зохицуулалт байхгүй, нийтийн түлхүүрийн дэд бүтэцгүй байсан нь цахим засаг, цахим бизнес, цахим нийгэм, мэдээллийн технологийн хөгжлөөс хоцорч, олон улсын харилцаанд ижил тэгш оролцох, бусад улстай цахим өгөгдөл солилцох боломжгүй байдлыг бий болгож байна хэмээн 2011 онд цахим гарын үсгийн тухай хуулийг баталж, өнөөдрийг хүртэл дагаж мөрдөж байна.

Байнга хэвлэх, гарын үсэг зурахын тулд гар ажиллагаа 64%, сканнер төхөөрөмж ашиглан цахим баримт болгон илгээх 60%, дамжуулах, зөөвөрлөх 33%, факс төхөөрөмж ашиглан цахим баримт болгон илгээх 30% шаардлагатай болдог байна. Харин цахим болон тоон гарын үсгийг ашигласнаар энэ бүх үргүй зардлыг цаасгүй баримт бичгийн тогтолцоонд шилжих замаар хэмнэж чадна хэмээн үздэг байна.[16]

[15] Энэхүү үнэлгээг ХЗҮХ-ийн Эрдэм шинжилгээний ахлах ажилтан Г.Халиунаа удирдан, Эрдэм шинжилгээний ажилтан Ч.Батзориг О.Төрболд, Б.Ариунжаргал, нар хамтран гүйцэтгэв.

[16] Монпасс СА тоон гарын үсгийн гэрчилгээ олгох байгууллага, https://www.monpass.mn/digital_usage, (Сүүлд үзсэн огноо: 2020.06.06).

Эрх зүйн орчны хувьд цахим гарын үсэг хэрэглэх боломж нөхцөлийг хуулиар бий болгож өгсөн хэдий ч тус хууль практикт хангалттай түвшинд хэрэгжихгүй байгаагийн шалтгаан, нөхцөлийг тодорхойлох, хуулийн ямар зохицуулалт практикт хэрэгжиж байгаа, ямар зохицуулалт огт хэрэгжихгүй байгаа талаар судлан үзэж, хуулийн зохицуулалт зорилгодоо хүрч чадсан эсэхийг тодорхойлохыг зорьлоо.

Иймд уг судалгааны ажлын хүрээнд Цахим гарын үсгийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт "...Төрийн болон албаны нууцад хамаарахаас бусад мэдээ, баримт бичгийг цахим хэлбэрээр шилжүүлэх, дамжуулахтай холбогдсон харилцааг энэ хуулиар зохицуулна" гэсэн зохицуулалт зорилгодоо хүрсэн эсэхийг судлан үзэж дүгнэх, мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэг, 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэг, 16 дугаар зүйлийн 16.3 дахь хэсэгт заасан зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байгаа болон хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудлыг судлан хэрэгжилтийг үнэлэх болно.

1.2. Үнэлгээ хийх хүрээг тогтоох

Үнэлгээний хүрээг тогтоох ажиллагаа нь хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг судлах явцад агуулгын хувьд чухал ач холбогдолтой, нөлөөлөл үзүүлэх гол зохицуулалтыг тодорхойлоход чиглэдэг.

Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт бүхэлд нь үнэлгээ хийхэд ихээхэн цаг хугацаа, хөдөлмөр, зардал шаардагдана. Харин хуулийн зорилгыг хэрэгжүүлэхэд чухал нөлөөлөл үзүүлэх зарим зохицуулалтыг тусгайлан сонгож үнэлгээ хийх нь илүү үр дүнтэй байдаг.

Иймд энэхүү судалгаагаар Цахим гарын үсгийн тухай хуулийн зарим зохицуулалтыг үнэлгээний шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгон авч эерэг, сөрөг талыг судалж, хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг хийхээр судалгааны хүрээг тогтоосон.

1.3. Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох

"Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал"-ын дагуу Цахим гарын үсгийн тухай хуулийн хэрэгжилтийг үнэлэхэд оновчтой, бодитой, хэмжиж болохуйц байдлыг баримталж, мөн үнэлгээний хүрээ, онцлогоос хамааран дараах хоёр шалгуур үзүүлэлтийг сонгосон болно.

1. Зорилгод хүрсэн түвшин;
2. Практикт нийцэж байгаа байдал;

1.3.1. "Зорилгод хүрсэн түвшин" шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл

Цахим гарын үсгийн тухай хуулийн 1.1-д энэ хуулийн зорилтыг "...Энэ хуулийн зорилт нь цахим болон тоон гарын үсгийг хэрэглэх эрх зүйн үндсийг тодорхойлж, тоон гарын үсгийн нийтийн түлхүүрийн дэд бүтцийг бий болгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино..." гэж тодорхойлжээ.

Үүнээс үзвэл, Цахим гарын үсгийн тухай хууль нь цахим болон тоон гарын үсгийг хэрэглэх нөхцөл боломжийг бүрдүүлэх, тус харилцааг зохицуулахад чиглэсэн болох нь харагдаж байна. Иймд энэхүү үнэлгээний шалгуур үзүүлэлтийг сонгохдоо дээр дурдсан хуулийн зорилгтыг тусгасан 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэг болон уг зорилгыг хангахтай холбогдуулан тусгасан 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт заасан зохицуулалтыг сонгож "Зорилгод хүрсэн түвшин"-г үнэллээ.

Сонгосон зүйл, заалтыг хүснэгтээр үзүүлбэл:

Хүснэгт 1. *Зорилгод хүрсэн түвшин шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зүйл, заалтууд*

№	Сонгосон зүйл, заалт	Зүйл, заалтын агуулга
1	1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэг	Энэ хуулийн зорилт нь цахим болон тоон гарын үсгийг хэрэглэх эрх зүйн үндсийг тодорхойлж, тоон гарын үсгийн нийтийн түлхүүрийн дэд бүтцийг бий болгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2	3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэг	Төрийн болон албаны нуущад хамаарахаас бусад мэдээ, баримт бичгийг цахим хэлбэрээр шилжүүлэх, дамжуулахтай холбогдсон харилцааг энэ хуулиар зохицуулна.

1.3.2. "Практикт нийцэж байгаа байдал" шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл

Энэхүү шалгуур үзүүлэлт нь тухайн хууль тогтоомжийн зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байгаа, түүний эерэг, сөрөг үр дагавар, хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл гарч байгаа эсэхийг тодорхойлоход чиглэгддэг.

Цахим гарын үсгийн тухай хууль төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэхэд чиглэсэн эрх зүйн үндсийг хуулиар тогтоосон бөгөөд энэ хууль батлагдаад даруй 9-н жилийн хугацаа өнгөрч байгаа хэдий ч практикт тус хуулийн хэрэгжилт хангалттай түвшинд хүрээгүй гэж үзэж болохоор байна. Өөрөөр хэлбэл цөөн тооны төрийн байгууллага цахим болон тоон гарын үсгийг ашиглаж байгаа бөгөөд иргэн бүрийг тоон гарын үсэгтэй болгох ажил өнөөдрийг хүртэл удаашралтай хийгдэж байна.

Цахим гарын үсгийн тухай хууль батлагдсантай холбогдуулан 2011 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн "Цахим гарын үсгийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын 61 дүгээр тогтоол батлагдаж уг тогтоолоор "...төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх болон Монгол улсын насанд хүрсэн иргэн бүрд тоон гарын үсгийн түлхүүрийг 2013 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болгох нөхцөлтэй шат дараалсан арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт даалгасан" байна. Гэсэн хэдий ч энэхүү ажлын практик хэрэгжилт хангалтгүй байсаар байна.

Судалгааны энэ хэсэгт "Практикт нийцэж байгаа байдал" шалгуур үзүүлэлтийн хүрээнд тоон гарын үсгийг хэрэглэх, тамга орлуулах, гэрчилгээг түдгэлзүүлэх тухай зохицуулалтыг сонгож, уг зүйл, заалт практикт хэрхэн хэрэгжиж байгаа байдал, түүний эерэг болон сөрөг үр дагавар, хэрэгжүүлэхэд тулгарч буй хүндрэл, бэрхшээл байгаа эсэхийг тодорхойлохыг зорьсон болно.

Сонгосон зүйл, заалтыг хүснэгтээр үзүүлбэл:

***Хүснэгт 2**. "Практикт нийцэж байгаа байдал" шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зүйл, заалт*

№	Сонгосон зүйл, заалт	Зүйл, заалтын агуулга
1	6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэг	**6** дугаар зүйл.Тоон гарын үсгийг хэрэглэх 6.3.Төрийн байгууллага, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой бусад хуулийн этгээд цахим баримт бичгийг бусдад шилжүүлэх, дамжуулахдаа зөвхөн тоон гарын үсэг хэрэглэнэ.
2	8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг	**8** дугаар зүйл.Тамга орлуулах 8.1.Тамга дарсан буюу дарах ёстой баримт бичгийг цахим хэлбэрээр шилжүүлэх, дамжуулах /хүлээн авах/ тохиолдолд энэ хуулийн 6.2, 6.5-д заасан тоон гарын үсгээс гадна тамга дарж баталгаажуулах эрх бүхий этгээдийн тоон гарын үсгийг давхар хэрэглэнэ.
3	13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэг	**13** дугаар зүйл.Гэрчилгээг түдгэлзүүлэх 13.1.Зөрчил илэрсэн, гэрчилгээ эзэмшигчийн хүсэлтээр маргааныг хянаж байгаа тохиолдолд тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн зөрчлийг шалгаж, арилгах хүртэл гэрчилгээг түдгэлзүүлж, зөрчил арилснаар гэрчилгээг сэргээнэ.
4	16 дугаар зүйлийн 16.3 дахь хэсэг	**16** дугаар зүйл.Гэрчилгээ эзэмшигчийн эрх, үүрэг 16.3.Гэрчилгээ эзэмшигч өөрийн буруугаас хувийн түлхүүрийг алдсан, хувийн түлхүүрийн нуущыг задалснаас үүдсэн хариуцлагыг хүлээнэ.

www.mlt.gov.mn

1.4. Харьцуулах хэлбэрийг сонгох

Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхдээ үнэлэх болсон шалтгаан, үнэлгээний хүрээ, шалгуур үзүүлэлт зэргийг харгалзан дор дурдсан харьцуулах хэлбэрүүдээс сонгоно. Үүнд:

- Байх ёстой болон одоо байгаа;
- Хууль тогтоомж батлагдахаас өмнөх болон хууль тогтоомж батлагдсанаас хойших;
- Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойших;
- Тохиолдол судлах.

1.5. Шалгуур үзүүлэлтийг томьёолох

Шалгуур үзүүлэлтийг томьёолохдоо сонгосон шалгуур үзүүлэлт тус бүрээр Цахим гарын үсгийн тухай хуулийн сонгон авсан хэсэгт тохируулан дараах таамаглал дэвшүүлж, асуулт боловсруулаа.

Зорилгод хүрсэн түвшин шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 1.

Цахим гарын үсгийн тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэгт заасан хуулийн зорилт зорилгодоо хүрсэн эсэх?

Цахим гарын үсгийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт заасан хуулийн үйлчлэх хүрээний тухай зохицуулалт зорилгодоо хүрсэн эсэх?

Практикт нийцэж буй байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 2.

Цахим гарын үсгийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 болон 6.3-т заасан тоон гарын үсгийг хэрэглэхтэй холбоотой зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байна вэ? Хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл тулгарч байгаа эсэх?

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 3.

Цахим гарын үсгийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт заасан тамга орлуулахтай холбоотой зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байна вэ? Хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл тулгарч байгаа эсэх?

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 4.

Цахим гарын үсгийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэгт заасан гэрчилгээг түдгэлзүүлэхтэй холбоотой зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байна вэ? Хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл тулгарч байгаа эсэх?

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 5.

Цахим гарын үсгийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэгт заасан гэрчилгээ эзэмшигчийн эрх, үүрэгтэй холбоотой зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байна вэ? Хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл тулгарч байгаа эсэх?

1.6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох

Энэхүү судалгааны ажлын хүрээнд үнэлгээ хийх хуулийн зүйл, заалтын зорилгод хүрсэн түвшин, практик хэрэгжилтийг илрүүлэх зорилгоор баримт бичиг, холбогдох ярилцлага, хууль тогтоомж, эрх зүйн актуудтай танилцаж, аргачлалын 3.7.3-т мэдээлэл цуглуулах дөрвөн аргыг тодорхойлсноос дараах хоёр аргыг сонгон үнэлгээ хийх мэдээллийг цуглуулсан болно.

1. Байгаа мэдээллийг цуглуулж ашиглах;
2. Холбогдох субъектээс судалгаа авах.

Байгаа мэдээллийг цуглуулах хүрээнд: Цахим гарын үсгийн тухай хууль, холбогдох эрх зүйн акт, сонин сэтгүүл, телевизд өгсөн ярилцлага, холбогдох бусад эх сурвалжаас мэдээлэл цуглуулж, үнэлгээ хийхэд ашиглав.

Хуулийн хүрээний хүрээлэн www.ulsgov.mn

Холбогдох субъектээс судалгаа авах хүрээнд: “Үндэсний дата төв” УТҮГ-аас тоон мэдээ, бусад мэдээллийг гаргуулан авч үнэлгээ хийхэд ашиглав.

ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

Цахим гарын үсгийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх мэдээллийг цуглуулахдаа баримт бичиг судлах, задлан шинжлэх ба нэгтгэн дүгнэх, ярилцлагын аргад тулгуурлаж энэхүү судалгааг гүйцэтгэв.

Баримт бичгийн судалгаа: Цахим гарын үсгийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхдээ дор дурдсан хууль тогтоомж, дүрэм, журам, эрдэмтэн, судлаач, салбарын мэргэжилтэн нарын ярилцлага, нийтлэлийг ашигласан болно. Үүнд:

Хууль, эрх зүйн акт

Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 1992, №1

Зөрчлийн тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2017 он, №24;

Иргэний хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2002 он, №7;

Цахим гарын үсгийн тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2012, №1;

Улсын Их Хурлын тогтоол, Цахим гарын үсгийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай, 2011.12.15, Дугаар 61;

Засгийн газрын тогтоол, Журам батлах тухай, Цахим хэлбэрээр албан хэрэг хөтлөх нийтлэг журам, 2017.04.12, Дугаар 111;

Засгийн Газрын тогтоол, Тамга, тэмдэг, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэглэх заавар, 2001.02.26, Дугаар 41;

Засгийн газрын тогтоол, Төрийн байгууллагуудад хэрэглэх архив, албан хэрэг хөтлөлтийн програм хангамжид тавигдах нийтлэг шаардлага, цахим хэлбэрээр албан хэрэг хөтлөх нийтлэг журам, 2017.04.12, Дугаар 111;

Засгийн газрын тогтоол, “Цахим засаг” үндэсний хөтөлбөр батлах тухай, 2012.04.04, Дугаар 101;

Засгийн газрын тогтоол, Төрийн байгууллагаас төрийн болон бусад байгууллагатай цахим хэлбэрээр мэдээлэл солилцох, мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглах журам, 2019.06.05, Дугаар 220;

Засгийн газрын тогтоол, Тоон гарын үсгийн гэрчилгээ олгох талаар авах зарим арга хэмжээний тухай, 2016.03.14, Дугаар 151;

Засгийн газрын тогтоол, Үндэсний хөтөлбөр батлах тухай (цахим засаглал), 2019.02.20, Дугаар 73;

Засгийн газрын тогтоол, Боловсролын баримт бичгийн лавлагааг цахим хэлбэрээр олгох тухай, 2016.06.28, Дугаар 347;

Архивын ерөнхий газрын тушаал, Албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар батлах тухай, 2009.07.07, Дугаар 68;

Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газрын даргын тушаал, Бодлогын чиглэл батлах тухай, 2015.03.25, Дугаар 71;

Стандарт, хэмжил зүйн газар, Баримт бичгийн бүрдэл, тэдгээрт тавих шаардлага.

Ном, гарын авлага, сэтгүүл

Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газар. “Цагаан ном 2014” (2015) ;

Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газар. “Цагаан ном 2017” (2018) ;

Ө.Одгэрэл, “Монгол Улс дахь цахим засаглалын бодлого”, (ХБНГУ, 2011),

Хуулийн мэдээлэл www.mlsi.gov.mn

Ламберт хэвлэлийн газар;

Мон Пасс СА гэрчилгээ олгох байгууллага, Байгууллагын цахим албан хэрэг хөтлөлтөд тоон гарын үсэг хэрэгжүүлэх гарын авлага, (2016) ;

А.Мөнхзул, “Цахим гарын үсэг зурах эрх зүйн зохицуулалтыг сайжруулах тухай”, Монголын төр, эрх зүй №1 (2014).

Гадаад эх сурвалж

European Union. “Regulation (EU) no 910/2014”. https://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/?uri=uriserv:OJ.L_.2014.257.01.0073.01.ENG;

John Erik Setsaas, Introduction to digital seals, 2016. https://web.archive.org/web/20180114234339/https://www.signicat.com/blog/blog-introduction-digital-seals/;

Cambridge online dictionary;

Sector, Telecommunication Standardization. “Information technology-Open Systems Interconnection-The Directory: Public-key and attribute certificate frameworks, 2016.

ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ

Үнэлэх үе шатанд Цахим гарын үсгийн тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1, 3 дугаар зүйлийн 3.1, 6 дугаар зүйлийн 6.3, 8 дугаар зүйлийн 8.1, 13 дугаар зүйлийн 13.1, 16 дугаар зүйлийн 16.3 дахь заалтуудад сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлгээ хийсэн.

3.1. “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал

Цахим гарын үсгийн тухай хуулийн зорилгыг “Энэ хуулийн зорилт нь цахим болон тоон гарын үсгийг хэрэглэх эрх зүйн үндсийг тодорхойлж, тоон гарын үсгийн нийтийн түлхүүрийн дэд бүтцийг бий болгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.” хэмээн 1.1 дүгээр зүйлд, “Төрийн болон албаны нууцад хамаарахаас бусад мэдээ, баримт бичгийг цахим хэлбэрээр шилжүүлэх, дамжуулахтай холбогдсон харилцааг энэ хуулиар зохицуулна.” хэмээн 3.1 дүгээр зүйлд тус тус заасан байна. Иймд уг хуулийн бүхий л зохицуулалт энэхүү үндсэн зорилгыг хангахад чиглэн үйлчлэх учиртай.

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 1. Цахим гарын үсгийн тухай хууль зорилгодоо хүрсэн эсэх?

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт
1.1.Энэ хуулийн зорилт нь цахим болон тоон гарын үсгийг хэрэглэх эрх зүйн үндсийг тодорхойлж, тоон гарын үсгийн нийтийн түлхүүрийн дэд бүтцийг бий болгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ
3.1.Төрийн болон албаны нууцад хамаарахаас бусад мэдээ, баримт бичгийг цахим хэлбэрээр шилжүүлэх, дамжуулахтай холбогдсон харилцааг энэ хуулиар зохицуулна.

Үнэлгээ:

2005 онд Монгол Улсын Засгийн газраас баталсан “Цахим монгол” үндэсний хөтөлбөрийн 1-р зорилтод мэдээлэл, харилцаа холбооны технологийг хөгжүүлэх хууль эрх зүйн шинэтгэл хийх тухай заасан бөгөөд тус зорилтын хүрээнд 2011 онд УИХ-аас цахим гарын үсгийн тухай хуулийг баталсан.[17] УИХ-ын 2011 оны “Цахим гарын үсгийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 61 дүгээр тогтоолоор төрийн үйлчилгээг иргэдэд цахим хэлбэрээр хүргэх төлөвлөгөөг 2013 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн боловсруулж, үе шаттайгаар хэрэгжүүлэхийг

[17] Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газар. “Цагаан ном 2014” (2011): 10 дахь тал.

Засгийн газарт даалгасан.[18] Энэ тогтоолыг үндэслэн Засгийн газрын 2016 оны 347 дугаар тогтоолоор "Боловсролын баримт бичгийн лавлагааг цахим хэлбэрээр олгох тухай"[19], Цахим гарын үсгийн тухай хуулийн 6 дугаар зүйлийг 6.4-г үндэслэн Засгийн газрын 2017 оны 111 дүгээр тогтоолоор "Төрийн байгууллагуудад хэрэглэх архив, албан хэрэг хөтлөлтийн програм хангамжид тавигдах нийтлэг шаардлага, цахим хэлбэрээр албан хэрэг хөтлөх нийтлэг журам"[20], Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 9 дүгээр зүйлийн 9.9, 12 дугаар зүйлийн 12.12-т заасныг тус тус үндэслэн Засгийн газрын 2019 оны 220 дугаар тогтоолоор "Төрийн байгууллагаас төрийн болон бусад байгууллагатай цахим хэлбэрээр мэдээлэл солилцох, мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглах журам"[21], мөн Засгийн газрын 2019 он 73 дугаар тогтоолоор "Цахим засаглал үндэсний хөтөлбөр"[22] зэрэг журам, хөтөлбөрийг баталсан байна.

Мөн Цахим гарын үсгийн тухай хууль батлагдсантай холбогдуулан "Иргэний бүртгэлийн тухай", "Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай", "Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай", "Нягтлан бодох бүртгэлийн тухай", "Патентийн тухай", "Татварын ерөнхий хууль" зэрэг хуулиудад тус тус нэмэлт, өөрчлөлт оруулж тоон гарын үсгийг цахим харилцаанд хэрэглэх, цахим баримт бичгийг баталгаажуулах эрх зүйн орчныг тодорхой хүрээнд бүрдүүлсэн.[23] Түүнчлэн "Цахим Засгийн газар мастер төлөвлөгөө (2005-2010)", "Монгол Улсад бүртгэл мэдээллийн нэгдсэн тогтолцоог бий болгох үндэсний хөтөлбөр (2008-2012)", "Цахим засаг үндэсний хөтөлбөр (2012-2016)", Монгол Улсын Засгийн Газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг хэд хэдэн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлснээр төрийн байгууллага төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр иргэд, хуулийн этгээдэд хүргэх болсон нь цахим баримт бичгийг бусдаас хүлээн авах, бусдад шилжүүлэх, дамжуулах зайлшгүй шаардлага үүссэн.[24] Дээрхээс үзвэл Монгол Улсад Цахим гарын үсгийн тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор эрх зүйн акт цөөнгүй батлагдсан хэдий ч бодит байдалд дээр тоон гарын үсгийн хэрэглээ хангалттай хэмжээнд биш байна. Тодруулбал, 2020 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн байдлаар 108-н байгууллага (эдгээр байгууллагын мэдээллийг хүснэгт 3-аас дэлгэрүүлэн үзнэ үү.) тоон гарын үсгийн гэрчилгээ аван үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Хүснэгт 3. *Тоон гарын үсгийн гэрчилгээ авсан байгууллагын мэдээлэл*

№	Байгууллагын нэр	Олголт хийгдсэн тоо
1.	Үндэсний дата төв УТҮГ	5
2.	Автотээврийн үндэсний төв	46
3.	Хууль зүй дотоод хэргийн яам	12
4.	Хавдар судлалын үндэсний төв	1
5.	Үндэсний статистикийн хороо	50
6.	Барилга хот байгуулалтын яам	64
7.	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	53
8.	Харилцаа холбоо мэдээллийн технологийн газар	15

[18] УИХ-ын тогтоол, Цахим гарын үсгийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай, https://www.legalinfo.mn/law/details/6911.

[19] Засгийн газрын тогтоол, Боловсролын баримт бичгийн лавлагааг цахим хэлбэрээр олгох тухай, https://www.legalinfo.mn/law/details/12036.

[20] Засгийн газрын 2017 оны 111 дүгээр тогтоол, Журам батлах тухай /Цахим хэлбэрээр албан хэрэг хөтлөх нийтлэг журам/, https://www.legalinfo.mn/law/details/12581.

[21] Мөн тэнд.

[22] Засгийн газрын 2019 оны 73 дугаар тогтоол, Үндэсний хөтөлбөр батлах тухай (цахим засаглал), https://www.legalinfo.mn/law/details/14177.

[23] Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар. "Тоон гарын үсгийг төрийн үйлчилгээнд нэвтрүүлсэн байгууллагад батламж гардууллаа". http://cita.gov.mn/?p=9972 (Сүүлд үзсэн огноо: 2020.05.09).

[24] Ө.Одгэрэл, "Монгол Улс дахь цахим засаглалын бодлого", (ХБНГУ, 2011), Ламберт хэвлэлийн газар, 93 дахь тал.

9.	Монгол улсын сангийн яам	142
10.	Нийслэлийн мэдээлэл, технологийн газар	28
11.	Батлан хамгаалах яам	1
12.	Улсын бүртгэлийн ерөнхий газар	149
13.	Хүүхэд залуучуудын сургалт хүмүүжлийн тусгай цогцолбор	4
14.	Нийслэлийн өмчийн ашиглалт удирдлагын газар	38
15.	Улаанбаатар хотын захирагчийн ажлын алба	13
16.	Газар зохион байгуулалт геодези зураг зүйн газар	376
17.	Нийслэлийн архивын газар	25
18.	Засгийн газрын хэрэг эрхлэх газар	74
19.	Татварын ерөнхий газар	225
20.	Нийслэлийн засаг даргын тамгын газар	39
21.	Нийслэлийн хот байгуулалт хөгжлийн газар	40
22.	Нийслэлийн нийгмийн халамжийн газар	7
23.	Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн газар	3
24.	Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар	3
25.	Сонгинохайрхан дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс	1
26.	Сүхбаатар дүүрэг нийгмийн даатгалын хэлтэс	1
27.	Баянзүрх дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс	4
28.	Хануул дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс	1
29.	Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ	17
30.	Нийслэлийн газрын алба	19
31.	Шинжлэх ухааны паркийн захиргаа	2
32.	Нийслэлийн татварын газар	78
33.	Улаанбаатар хотын замын хөдөлгөөний удирдлагын төв	13
34.	Мэдээлэл холбооны сүлжээ ххк	5
35.	Санхүүгийн зохицуулах хороо	1
36.	Ус сувгийн удирдах газар	4
37.	Цагдаагийн ерөнхий газар	527
38.	Шүүхийн ерөнхий зөвлөл	43
39.	Нийслэлийн орон сууцны корпораци хк	1
40.	Улаанбаатар дулааны сүлжээ	3
41.	Дархан уул аймгийн ЗДТГ	49
42.	Харилцаа холбооны зохицуулах хороо	3
43.	Сонгинохайрхан дүүргийн хөдөлмөр халамжийн үйлчилгээний хэлтэс	1
44.	Баянгол дүүргийн эрүүл мэндийн төв	1
45.	Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан	3
46.	Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар онөааатүг	20
47.	Зам тээврийн хөгжлийн яам	111
48.	Архивын ерөнхий газар	36
49.	Гаалийн ерөнхий газар	59
50.	Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг	1
51.	Хот тохижилтын газар	6
52.	Эрчим хүчний яам	1
53.	Гадаадын иргэн харьяатын газар	5
54.	Чингэлтэй татварын хэлтэс	88
55.	Баянгол дүүргийн татварын хэлтэс	106
56.	Худ татварын хэлтэс	70
57.	Схд татварын хэлтэс	74
58.	Сүхбаатар дүүргийн татварын хэлтэс	99
59.	Баянзүрх дүүргийн татварын хэлтэс	71

хуулийн үндэсний хүрээлэн www.nli.gov.mn

60.	Улсын нийгмийн даатгалын ерөнхий газрын дэргэдэх мэдээллийн технологийн төв	4
61.	Үндэсний хөгжлийн газар	2
62.	Төв аймгийн засаг даргын тамгын газар	23
63.	Архангай аймгийн татварын хэлтэс	1
64.	Төв аймгийн татварын хэлтэс	45
65.	Хэнтий аймгийн Татварын хэлтэс	1
66.	Сэлэнгэ аймгийн татварын хэлтэс	42
67.	Дорнод аймгийн татварын хэлтэс	1
68.	Ховд аймгийн татварын хэлтэс	1
69.	Говьсүмбэр аймгийн татварын хэлтэс	1
70.	Хөвсгөл аймгийн татварын хэлтэс	40
71.	Орхон татварын хэлтэс	1
72.	Өмнөговь татварын хэлтэс	47
73.	Сүхбаатар аймгийн татварын хэлтэс	1
74.	МУБИС	1
75.	Улаанбаатар чуулга	3
76.	Нийслэлийн орон сууцны дэд бүтцийн газар	19
77.	Төрийн албаны зөвлөл	8
78.	Нийслэлийн нийтийн тээврийн үйлчилгээний газар	1
79.	Багахангай дүүргийн дотоод аудитын алба	1
80.	Улаанбаатар хотын шуурхай удирдлага, зохицуулалтын төв онөөатүг	20
81.	Орхон аймгийн ЗДТГ	2
82.	Өмнөговь аймгийн ЗДТГ	13
83.	Ховд аймгийн засаг ЗДТГ	18
84.	Өвөрхангай аймгийн ЗДТГ	20
85.	Дундговь аймгийн ЗДТГ	16
86.	Дорноговь аймгийн ЗДТГ	16
87.	Хөвсгөл аймаг ЗДТГ	24
88.	Булган аймгийн ЗДТГ	11
89.	Хэнтий аймгийн ЗДТГ	19
90.	Сэлэнгэ аймгийн ЗДТГ	10
91.	Говь-алтай аймгийн ЗДТГ	19
92.	Баянхонгор аймгийн ЗДТГ	20
93.	Баян-Өлгий аймгийн Татварын Хэлтэс	1
94.	Дорноговь аймгийн татварын хэлтэс	39
95.	Булган аймгийн татварын хэлтэс	1
96.	Завхан аймгийн татварын хэлтэс	1
97.	Улаанбаатар лифт онөөатүг	7
98.	Увс аймгийн ЗДТГ	19
99.	Сүхбаатар аймаг ЗДТГ	14
100.	Дорнод аймгийн ЗДТГ	15
101.	Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газар	23
102.	Баян-Өлгий Аймгийн ЗДТГ	14
103.	Говьсүмбэр аймаг ЗДТГ	4
104.	Завхан аймгийн ЗДТГ	25
105.	Архангай Аймгийн ЗДТГ	20
106.	Дархан-уул аймгийн татварын хэлтэс	1
107.	Өвөрхангай аймгийн татварын хэлтэс	1
108.	Говь-алтай аймгийн татварын хэлтэс	1
	Нийт	**3574**

хуулийн үндэсний хүрээлэн www.nli.gov.mn

Дээрх тоон үзүүлэлтээс харвал Монгол Улсын хэмжээнд нийт 94,675-н аж ахуй нэгж, байгууллага үүнээс төсвийн байгууллага 4,623[25] үйл ажиллагаа явуулж байгаагаас нийт аж ахуй нэгж байгууллагын 0.11% буюу 108 байгууллага цахим гарын үсэг болон тоон гарын үсэг ашиглаж байгаа нь уг хуулийн хэрэгжилт нь зорилгодоо бүрэн хүрээгүйг харуулж байна.

3.2. "Практикт нийцэж байгаа байдал" шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 2. Цахим гарын үсгийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 болон 6.3-т заасан тоон гарын үсгийг хэрэглэхтэй холбоотой зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байна вэ? Хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл тулгарч байгаа эсэх?

6 **дугаар зүйл.Тоон гарын үсгийг хэрэглэх**
6.1.Энэ хуулийн 18 дугаар зүйлд заасан тоон гарын үсгийн гэрчилгээ олгох тусгай зөвшөөрөл эзэмшигч /цаашид "тусгай зөвшөөрөл эзэмшигч" гэх/-ээс олгосон тоон гарын үсгийн гэрчилгээгээр баталгаажсан тоон гарын үсгийг ердийн гарын үсэгтэй адил хүчинтэйд тооцно.
6.3.Төрийн байгууллага, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой бусад хуулийн этгээд цахим баримт бичгийг бусдад шилжүүлэх, дамжуулахдаа зөвхөн тоон гарын үсэг хэрэглэнэ.

Үнэлгээ:

Тоон гарын үсгийн гэрчилгээ олгох ажиллагааг Цахим гарын үсгийн тухай хуулийн 10 дугаар зүйлд заасны дагуу тоон гарын үсгийн гэрчилгээ олгох тусгай зөвшөөрөл эзэмшигч эрхэлдэг. Тус хуулийн 4.1.8-д "тоон гарын үсгийн гэрчилгээ гэж тоон гарын үсгийн гэрчилгээ олгох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн олгосон тоон гарын үсэг эзэмших эрх, тоон гарын үсгийн нийтийн түлхүүр, холбогдох бусад мэдээллийг агуулсан, баталгаажуулсан цахим баримт бичгийг"[26] ойлгоно гэж заажээ. Цахим гарын үсгийн тухай хуулийн 10.2-т заасан этгээд 10.3-т заасан мэдээллийн үнэн зөвийг шалган 10.4.1-т зааснаар "тусгай зөвшөөрөл эзэмшигч нь мэдээлэл үнэн зөв бол гэрчилгээ олгох", 10.4.2-т зааснаар "тусгай зөвшөөрөл эзэмшигчийн бүртгэлийн нэгж /цаашид "бүртгэлийн нэгж" гэх/ мэдээлэл үнэн зөв бол тухайн этгээдэд тоон гарын үсгийн гэрчилгээ олгуулахаар өргөдлийг хүсэлт гаргагчийн бөглөсөн маягтын хамт тусгай зөвшөөрөл эзэмшигчид хүргүүлэх", 10.4.3-т зааснаар "хүсэлт гаргагчийн мэдээлэл нь буруу, зөрүүтэй бол өргөдлийг хүсэлт гаргагчид буцаах" зэрэг шийдвэрүүдийн аль нэгийг гаргадаг. Ийнхүү гэрчилгээгээр баталгаажсан тоон гарын үсэгтэй болсноор цахим орчинд хүн, хуулийн этгээд нь өөрийгөө батлах, цахим өгөгдлийг аюулгүй дамжуулах, хүлээн авах, харилцагч талуудын хооронд итгэлцэл бий болгох, эх сурвалжийг баталгаатай тодорхойлох боломжтой болсон.

Монгол Улсад ердийн гарын үсэг хэрхэн хэрэглэх тухай хуулийн зохицуулалт байхгүй.[27] Кембрижийн толь бичигт гарын үсгийг "ихэвчлэн тухайн этгээд ямар нэг зүйлийг бичсэн эсвэл хүлээн зөвшөөрснийг илэрхийлж өөрийн гараар давтагдашгүй нэг хэвээр бичсэн түүний нэр"[28] гэж тодорхойлсон. Цахим гарын үсгийн тухай хуулийн 6.1-т "Энэ хуулийн 18 дугаар зүйлд заасан тоон гарын үсгийн гэрчилгээ олгох тусгай зөвшөөрөл эзэмшигч /цаашид "тусгай зөвшөөрөл эзэмшигч" гэх/-ээс олгосон тоон гарын үсгийн гэрчилгээгээр баталгаажсан тоон гарын үсгийг ердийн гарын үсэгтэй адил хүчинтэйд тооцно" гэж заасан тул тухайн этгээд тоон гарын үсэг хэрэглэснээр ердийн гарын үсгийн адил өөрийг нь таньж болох, дахин давтагдахгүй

[25] Стастикийн мэдээллийн нэгдсэн сан, http://www.1212.mn/tables.aspx?tbl_id=DT_NSO_2600_009V1&13999001_select_all=0&13999001SingleSelect=_5&01_select_all=0&01SingleSelect=_6_7&YearQ_select_all=0&YearQSingleSelect=&viewtype=table, (Сүүлд үзсэн огноо: 2020.06.06).

[26] Цахим гарын үсгийн тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2012 он, №1.

[27] А.Мөнхзул, "Цахим гарын үсэг зурах эрх зүйн зохицуулалтыг сайжруулах тухай", Монголын төр, эрх зүй №1 (2014): 25-27 дахь тал.

[28] https://dictionary.cambridge.org/dictionary/english/signature

баталгаажуулалтыг цахим орчинд хийсэнд тооцдог болсон. Энэхүү эрх зүйн үр дагавар үүсч буйг Цахим гарын үсгийн тухай хуулийн 10.5.1-д "хуульд өөрөөр заагаагүй бол тоон гарын үсгийг хэрэглэснээр ердийн гарын үсгийг хэрэглэсэнтэй адил эрх зүйн үр дагавар үүсэх ..." гэж заасны дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тоон гарын үсгийн гэрчилгээ авч буй этгээдэд таниулах үүрэгтэй.

Иргэний хуулийн 42[1].1-т "Хуульд зааснаар бүртгүүлэх, нотариатаар гэрчлүүлбэл зохих болон бичгээр хийхээр заасан хэлцлийг цахим хэлбэрээр хийж болно"[29], 42[1].2-т "Хуульд өөрөөр заагаагүй бол цахим хэлбэрээр хийх хэлцэл нь хүсэл зоригоо илэрхийлэгч этгээд цахим баримт бичиг үйлдэж, тоон гарын үсэг зурж илгээснийг гэрээний нөгөө тал нь хүлээн зөвшөөрч тоон гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно" гэж заасан нь хэлцлийг тоон гарын үсэг ашиглан баталгаажуулсны үндсэн дээр цахимаар хийж болохыг хуульчилсан. Цахимаар хэлцэл хийсэн гэж үзэхийг тус хуулийн 43.2.4-т "цахим хэлбэрээр хэлцэл хийх бол талууд хүсэл зоригоо илэрхийлсэн цахим баримт бичиг үйлдэж, Цахим гарын үсгийн тухай хуульд заасан тоон гарын үсэг зурсан" гэж заажээ. Харин цахим хэлбэрээр гэрээг байгуулсанд тооцохыг тус хуулийн 196.1.8-д "цахим хэлбэрээр гэрээ хийх бол талууд цахим баримт бичиг үйлдэж, Цахим гарын үсгийн тухай хуульд заасан тоон гарын үсэг зурснаар" гэж заасан. Эдгээр хуулийн заалтыг үндэслэн иргэн, хуулийн этгээд цахим хэлбэрээр хэлцэл, гэрээ хийж, үүнийгээ тоон гарын үсгээрээ баталгаажуулж болох ба энэхүү цахим хэлцэл, гэрээ нь цаасан суурьтай хэлцэл, гэрээг ердийн гарын үсгээр баталгаажуулсантай адил хүчинтэй байна.

Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт "Мөнгөн хадгаламжийн гэрээг цахим хэлбэрээр хийж болно", 5 дахь хэсэгт "Цахим хэлбэрээр хийх мөнгөн хадгаламжийн гэрээ хүсэл зоригоо илэрхийлэгч этгээд цахим баримт бичиг үйлдэж, тоон гарын үсэг зурж илгээснийг банк, санхүүгийн байгууллага хүлээн зөвшөөрч тоон гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно" гэж заасан. Ийнхүү цахим хэлбэрээр мөнгөн хадгаламжийн гэрээ байгуулж, үүнийгээ тоон гарын үсгээр баталгаажуулах боломжтой болсон нь цахимаар данс нээх, хаах боломжийг олгож байна. Тухайлбал, уг хуулийн 12[1] дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Иргэн, хуулийн этгээд цахим хэлбэрээр данс нээлгэх, хаалгах хүсэлтийг банк, төлбөр тооцооны үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдэд гаргаж болно", 2 дахь хэсэгт "Иргэн, хуулийн этгээдийн хүсэлтийг үндэслэн цахим хэлбэрээр данс нээж, хаана" гэж заасан.

2014 оны байдлаар Монгол Улсад цахим гарын үсгийн хэрэглээтэй холбоотой маргаан эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмаар, иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх, захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны журмаар шийдвэрлэгдээгүй байсан.[30] Өнөөгийн байдлаар мөн Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим сан /shuukh.mn/-аас цахим гарын үсэгтэй холбоотой маргаан хэлэлцэж шийдвэрлэсэн шийдвэр олдоогүй. Ерөнхийдөө тоон гарын үсгийг хуурамчаар үйлдэх боломжгүй, үнэн мөнийг шууд тогтоох боломжтой байдаг. Тэгвэл ердийн гарын үсгийг хэн ч дуурайлган зурах боломжтой ба гарын үсгийн тусгай криминалистик шинжилгээгээр дууриалгасан эсэхийг тогтоодог, ихэнх тохиолдолд энэ шинжилгээгээр ч тогтоож чаддаггүй. Дэлхий дээр өнөөдөр тоон гарын үсгийг хуурамчаар зурсан тохиолдол илрээгүй байна. Энэ тухай мөн "Тридиум э-секьюрити" компанийн ерөнхий захирал Ө.Эсболд "...хувь хүний зурсан ердийн гарын үсгийг хуулбарлан дуурайх асуудал ямагт гарч ирсэн. Харин энэхүү тоон гарын үсгийг ашигласанаар хуулбарлан дуурайх ямар ч боломжийг олгохгүй"[31]

[29] Иргэний хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2002 он, №7.

[30] А.Мөнхзул, "Цахим гарын үсэг зурах эрх зүйн зохицуулалтыг сайжруулах тухай", Монголын төр, эрх зүй №1 (2014): 26 дахь тал.

[31] Ө.Эсболд, "Иргэдэд таатай тоон гарын үсгийн технологийг нэвтрүүлэгч Тридум э-Секьюрити", 2018.11.15, https://ikon.mn/n/1fle.

гэж өгүүлсэн.

Цахим гарын үсгийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-т дахь хэсгийн "Төрийн байгууллага, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой бусад хуулийн этгээд цахим баримт бичгийг бусдад шилжүүлэх, дамжуулахдаа зөвхөн тоон гарын үсэг хэрэглэнэ" гэсэн агуулга дахь "бусдад" гэдэгт "иргэн", "хуулийн этгээд" зэргийг хамруулан ойлгож болохоор байна. Учир нь төрийн байгууллагаас зөвхөн иргэд рүү чиглэсэн бус мөн "хуулийн этгээд" рүү чиглэсэн цахим үйлчилгээг нэвтрүүлсэн билээ. Харин "цахим баримт бичиг" гэдгийг тус хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4-т тодорхойлохдоо "мэдээллийн технологийн техник хэрэгсэл, программм хангамж ашиглан үүсгэх, илгээх, хүлээн авах, хадгалах боломжтой цахим өгөгдлийг"[32] ойлгоно гэжээ. Архивын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1-ийг үндэслэн Архивын ерөнхий газрын даргын 2009 он 68 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар"[33]-ын 2.5-д заасанчлан баримт бичгийг компьютераар боловсруулдаг тул цаасан суурьтай баримт бичиг бүрийн цахим хувилбар эхлээд үүсдэг. Иймээс хуулиар хориглоогүй бүх төрлийн албан баримт бичгийг тоон гарын үсгээр баталгаажуулан цахим хэлбэрээр дамжуулах, хүлээн авах боломжтой юм.

Өмнө дурдсан зохион байгуулалтын нийтлэг журмууд батлагдсанаар төрийн байгууллагууд төрийн нууцын зэрэглэлд хамаарахаас бусад албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд албан хэрэг хөтлөлт бүртгэлийн програм хангамж ашиглаж, цахим хэлбэрээр баримт бичиг зохион бүрдүүлэх, хүлээн авах, бүртгэх, илгээх, солилцох, шийдвэрлэлтэд хяналт тавих, ангилан төрөлжүүлэх, хэрэг бүрдүүлэх, хадгалах, аюулгүй байдлыг хангах нөхцөл бүрдсэн.[34] Мөн Иргэний хуулийн 42[1].1-т "Хуульд зааснаар бүртгүүлэх, нотариатаар гэрчлүүлбэл зохих болон бичгээр хийхээр заасан хэлцлийг цахим хэлбэрээр хийж болно", 42[1].2-т "Хуульд өөрөөр заагаагүй бол цахим хэлбэрээр хийх хэлцэл нь хүсэл зоригоо илэрхийлэгч этгээд цахим баримт бичиг үйлдэж, тоон гарын үсэг зурж илгээснийг гэрээний нөгөө тал нь хүлээн зөвшөөрч тоон гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно" гэж заасан нь тоон гарын үсэг зурж цахим хэлбэрээр гэрээ хэлцэл хийж болохыг баталгаажуулсан.[35] Гэхдээ 2016 оноос өмнө цахим гарын үсгийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь заалт практикт хэрэгжих боломжгүй байв. Учир нь Монгол Улсад тоон гарын үсгийн гэрчилгээ олгох байгууллагууд 2016 оноос байгуулагдаж эхэлсэнтэй зэрэгцэн тоон гарын үсгийн нийтийн түлхүүрийн дэд бүтэц бий болсон.[36] Мөн Засгийн газрын 2016 оны 151 дүгээр тогтоолын дагуу 2016 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн төрийн албан хаагч, хуулийн этгээд, иргэдэд тоон гарын үсгийг тэдний иргэний үнэмлэхэд суурилуулан олгож эхэлсэн байдаг.[37]

Төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн зааврийн 3.6.2-т цахим баримтыг дамжуулах, хүлээн авах ажиллагааг журамлахдаа "тусгай зөөгч дээрх баримтыг өөр байгууллагад явуулахдаа албан бичгээр дагалдуулна", "гаднаас ирсэн цахим баримтыг хүлээн авч, бүртгэх, танилцуулах журам цаасан баримтынхтай ижил байна", "цахим шуудангаар хүлээн авсан баримтыг принтерээр хэвлэн, бичиг хэрэгт хүлээн авсан тухайг нотолж, бүртгэлийн тэмдэг дарна. Мөн цаасан дээрх хувь нь цахим эх баримттай адил хүчинтэй болохыг бичиг хэргийн ажилтан баталж, гарын

[32] Цахим гарын үсгийн тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2012 он, №1.

[33] Архивын ерөнхий газрын даргын 2009 оны 68 дугаар тогтоол, Албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар батлах тухай, https://www.legalinfo.mn/annex/details/6555.

[34] Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар. "Цахим хэлбэрээр албан хэрэг хөтлөх нийтлэг журам батлагдлаа". http://cita.gov.mn/?p=10198 (Сүүлд үзсэн огноо: 2020.05.10).

[35] Иргэний хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2002 он, №7.

[36] Мон Пасс СА гэрчилгээ олгох байгууллага, Байгууллагын цахим албан хэрэг хөтлөлтөд тоон гарын үсэг хэрэгжүүлэх гарын авлага, (2016), https://esign.gov.mn/tusgaj-zvshrl-bhij-gerchilgeezhleh-bajguullaga (Сүүлд үзсэн огноо: 2020.05.10).

[37] Засгийн газрын 2016 оны 151 дүгээр тогтоол, Тоон гарын үсгийн гэрчилгээ олгох талаар авах зарим арга хэмжээний тухай, https://www.legalinfo.mn/law/details/11786.

үсэг, он, сар, өдөр тавина”[38] гэж тусгасан. Энэхүү журамд цахим албан баримт илгээхдээ цахим гарын үсгээр бус албан бичиг дагалдуулан илгээж баталгаажуулж байгаа нь “Цахим гарын үсгийн тухай хууль”-ийн 6.3 заалт, “Төрийн байгууллагуудад хэрэглэх архив, албан хэрэг хөтлөлтийн программ хангамжид тавигдах нийтлэг шаардлага, цахим хэлбэрээр албан хэрэг хөтлөх нийтлэг журам”-ын 6.1.1 хэсэгтэй тус тус зөрчилдөж байна. Мөн гаднаас ирсэн цахим баримт бичгийг эх хувьтайгаа адил болохыг бичиг хэргийн ажилтан батлаж байгаа нь практикийн хувьд цаг хугацаа шаардсан ажиллагаа бөгөөд энэхүү ажилтан нь тухайн цахим баримтыг эх хувьтайгаа адил хүчинтэй гэдгийг хөдөлбөргүйгээр нотлох субъект биш юм. Жишээлбэл, татварын тайланг цахим хэлбэрээр илгээх зааварт “Тайланг тоон гарын үсэг хэрэглэж илгээсэн тохиолдолд цаасаар дахин ирүүлэх (баталгаажуулах) шаардлагагүй юм. Харин тоон гарын үсэг хэрэглээгүй тохиолдолд тайлангаа цаасан хэлбэрээр хуулийн хугацаанд ирүүлэх ёстой”[39] гэж дурдсан байна. Мөн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланг үндэсний тоон гарын үсгээр хүлээн авах тухай мэдэгдэлд “Цахимаар илгээсэн тайланг хэвлэмэл хэлбэрээр үйлдэж баталгаажуулах, эсвэл тоон гарын үсгээр баталгаажуулах сонголттой”[40] гэжээ.

Өдгөө төрийн байгууллагууд компьютер дээр бичвэрийн программ хангамж ашиглан баримт бичгийг цахим хэлбэрээр үүсгэж, боловсруулдаг ч баталгаажуулахдаа уламжлалт гарын үсэг зурах, тамга эсвэл тэмдэг дарах аргыг ихэнхдээ хэрэглэсээр байна. Ийнхүү баталгаажуулсан баримт бичгийг цаасан хэлбэрээр бусдад шуудангаар эсвэл хүргэгчээр дамжуулдаг ч яаралтай үед тухайн баталгаажуулсан цаасан баримтыг сканнер төхөөрөмжөөр цахим баримт болгон илгээх эсвэл бичвэрийн програмын файлын эцсийн хувилбарыг цахим шуудангаар илгээх нь түгээмэл байна. Ямар нэгэн материал дээр үзгээр гарын үсгээ зураад тухайн материалаа скайнэрдэж эсвэл фото зургийг нь авч цахим хэлбэрт оруулсан хуулбар, зурмал гарын үсэг бүхий факс, ямар нэг баримтын агуулга дотор скайнэрдаж оруулсан зурмал гарын үсгийн зураг, цахим шууданд хавсаргасан зурмал гарын үсгийн зураг зэргийг тоон гарын үсэгт тооцохгүй бөгөөд эдгээр нь ердөө л нэг дүрс, тэмдэгтэй файл юм.[41]

Цахим баримт бичгийг бусдад дамжуулахдаа тоон гарын үсэг ашиглахгүй байгааг зарим эрдэмтэн, мэргэжилтэн шүүмжилсэн. Тухайлбал, ШУТИС-ийн зөвлөх профессор Т.Халтар “Нийтийн түлхүүрийн дэд бүтэц, тоон гарын үсгийн ач холбогдол, мөн чанар, хэрэглээг Монголын нийгэмд мэдэхгүй, нийгмийн ойлголт төлөвшөөгүй, 30 гаруй жилээр хоцрогдсон...”[42] гэж үзсэн бол Монпасс СА ХХК-ийн “Тоон гарын үсгийн хэрэглээ” өгүүлэлд “...Монгол Улсад тоон гарын үсгийг нийгэм даяараа, үр дүнтэй ашиглахад эрх зүйн дутуу, дулимаг зохицуулалт саад болж мэдэхээр байна. Монгол Улсад тоон гарын үсгийн хэрэглээний хүрээ тодорхой бус, тоон гарын үсэг ашиглах салбаруудын эрх зүйн зохицуулалтын тухай ойлголт тусгагдаагүй, цахим нотариат хөгжих боломжийг хаасан, санхүүгийн болон бусад баримт бичгийг тоон гарын үсгээр баталгаажуулж цахим хэлбэрээр боловсруулах, хадгалах тухай заалтууд холбогдох хуулиудад ороогүй байгаа нь жинхэнэ утгаар цахим бизнес, цахим банк, цахим төр хөгжихөд саад болно”[43] гэж дурджээ. Мөн

[38] Архивын ерөнхий газрын даргын 2009 оны 68 дугаар тогтоол, Албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар батлах тухай, https://www.legalinfo.mn/annex/details/6555.

[39] Д.Баяраа, Татварын тайланг цахим хэлбэрээр хэрхэн тайлагнах вэ?, http://mta.mn/c/view/71154 (Сүүлд үзсэн огноо: 2020.05.11).

[40] Нийгмийн даатгалын ерөнхий газар, Нийгмийн даатгалын шимтгэлийн тайланг үндэсний тоон гарын үсгээр хүлээн авах тухай мэдээлэл, http://www.ndaatgal.mn/v1/view/1266 (Сүүлд үзсэн огноо: 2020.05.13)

[41] Төрийн мэдээлэл холбооны газар, Тоон гарын үсэг ба түүний баталгаажуулах хэлбэрүүд, http://ncsc.gov.mn/index.php?id=133 (Сүүлд үзсэн огноо: 2020.05.11).

[42] Т.Халтар, “Монголчууд тоон гарын үсгийг гар утасны үйлчилгээ авдагтайгаа адил ашигладаг болно”, (сурв. С.Бадрал), 2017.11.28, https://ikon.mn/n/15ts, (Сүүлд үзсэн огноо: 2020.05.11).

[43] Мон Пасс СА, Тоон гарын үсгийн хэрэглээ, https://monpass.mn/storage/uploads/download_files/ Тоон_гарын_үсэг_ашиглаж_буй_байдал.pdf (Сүүлд үзсэн огноо: 2020.05.11).

Монголбанкны Үндэсний цахим гүйлгээний төвийн ахлах мэргэжилтэн Г.Ганзориг[44] хэлэхдээ "улсын хэмжээнд уг хуулийн хэрэгжилт хангалтгүй байна. Өнөөдрийн байдлаар аж ахуйн нэгжүүд татварын байгууллагад тайлан балансаа илгээх эсвэл аливаа нэг цахим тендерт оролцохдоо баримт бичгээ хүргүүлэх төдийд л хэрэглэж байна" гэжээ.

Тоон гарын үсгийн нийтийн түлхүүрийн дэд бүтэц нь өндөр түвшний итгэлцэл болон үйл явцын аюулгүй орчныг хангаж буй хүмүүс, бодлого, журам, технологийн дэд бүтцийн нэгдэл[45] учраас тоон гарын үсэг хэрэглэх нь хүнээс тухайн технологийн мэдлэг, мэдээллийн технологийн аюулгүй байдалд итгэх итгэл, мөн тоон гарын үсэг хэрэглэх орчин зэргийг шаардаж байна. Тоон гарын үсгийг нийгэм өргөнөөр хэрэглэхгүй байгаа нь үүнийг хэрэглэх орчин хязгаарлагдмал байгаад оршино. Тухайлбал, тоон гарын үсгийн нийтийн түлхүүрийн дэд бүтэц бий болсноос хойш цөөн тооны төрийн байгууллага хэрэглээндээ нэвтрүүлсэн. Хамгийн анх Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар 2017 оны 3 сараас үйлчилгээндээ тоон гарын үсгийг нэвтрүүлсэн бол үүний дараа Нийгмийн даатгалын ерөнхий газар, Татварын ерөнхий газар, Нийслэлийн мэдээллийн технологийн газар зэрэг төрийн байгууллагууд үйл ажиллагаандаа тоон гарын үсгийг нэвтрүүлээд байна.[46]

Дээрхээс дүгнэвэл Цахим гарын үсгийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт "Төрийн байгууллага, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой бусад хуулийн этгээд цахим баримт бичгийг бусдад шилжүүлэх, дамжуулахдаа зөвхөн тоон гарын үсэг хэрэглэнэ." хэмээн зааж өгсөн хэдий ч төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар гэх мэт дүрэм журмуудад зөрчилтэй байж болох заалтууд байсаар байна. Энэ нь цахим гарын үсэг, тоон гарын үсгийн хэрэглээ удаашрах, хууль практикт нийцэж хэрэгжихгүй байх нэг нөхцөл нь болж байна.

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 3. Цахим гарын үсгийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-т заасан тамга орлуулахтай холбоотой зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байна вэ? Хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл тулгарч байгаа эсэх?

8 дугаар зүйл.Тамга орлуулах
8.1.Тамга дарсан буюу дарах ёстой баримт бичгийг цахим хэлбэрээр шилжүүлэх, дамжуулах /хүлээн авах/ тохиолдолд энэ хуулийн 6.2, 6.5-д заасан тоон гарын үсгээс гадна тамга дарж баталгаажуулах эрх бүхий этгээдийн тоон гарын үсгийг давхар хэрэглэнэ.

Үнэлгээ:

Монгол Улсын стандарт "Баримт бичгийн бүрдэл, тэдгээрт тавих шаардлага MNS5140-2:2011"[47]-ын 5.1-т "баримт бичгийг зохион бүрдүүлж, албан ёсны болгоход тамга, тэмдэг ашиглах", 6.19-т "байгууллагын удирдах албан тушаалтны гарын үсэг болон баримт бичгийн хуулийн хүчинтэй эх болохыг баталгаажуулж, тамга, тэмдэг дарна. Зохион байгуулалтын нэгжийн дарга гарын үсэг зурсан баримт бичигт тэмдэг дарна" гэж заажээ. Мөн Архивын ерөнхий газрын даргын 2009 он 68 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар"-ын 2.3.12-т "Баримт бичгийн албан ёсны хүчин төгөлдөр байдал болон албан тушаалтны гарын үсгийг тамга, тэмдэг дарж, баталгаажуулна. Байгууллагын тамгыг дарга, орлогчийн, байгууллагын тэмдгийг зохион байгуулалтын нэгжийн даргын гарын үсэг зурсан баримт бичиг дээр дарна"[48] гэж заасан. Харин тамга,

[44] Г.Ганзориг, "Цахим гарын үсгийн тухай хуулийг 2011 онд баталж, цахим орчинд баримт бичгийг баталгаажуулах эрх зүйн орчин бий болсон", https://www.mongolbank.mn/news.aspx?id=2246&tid=2, (Сүүлд үзсэн огноо: 2020.06.08).

[45] http://cita.gov.mn/wp-content/uploads/2017/01/white_paper_2017_mn.pdf

[46] http://cita.gov.mn/wp-content/uploads/2017/01/white_paper_2017_mn.pdf

[47] Стандарт, хэмжил зүйн газар, Баримт бичгийн бүрдэл, тэдгээрт тавих шаардлага, http://estandard.gov.mn/standart/reader/412 (Сүүлд үзсэн огноо: 2020.05.15).

[48] Архивын ерөнхий газрын даргын 2009 оны 68 дугаар тогтоол, Албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар батлах тухай, https://www.legalinfo.mn/annex/details/6555.

тэмдэг хэрэглэх зааврыг Засгийн газрын 2001 оны 41 дүгээр тогтоолоор баталсан бөгөөд уг тогтоолын хавсралтын 32 дугаар зүйлд "яам, засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг, түүнчлэн үйл ажиллагаа нь хуулиар буюу Засгийн газрын шийдвэрээр тодорхойлогддог төрийн байгууллага, Монгол Улсын хилийн чанадад ажиллаж байгаа дипломат төлөөлөгчийн газрын тамгыг сайд, дэд сайд, Төрийн нарийн бичгийн дарга, дарга, дэд дарга; тэмдгийг газар, хэлтэс, тасаг, албаны дарга, түүнтэй адилтгах албан тушаалтны гарын үсэг зурсан баримт бичиг дээр дарна"[49], 33 дугаар зүйлд "Бүх шатны Засаг даргын тамга, тэмдгийг Засаг дарга, тэдгээрийн орлогч, хот, тосгоны захирагчийн тамга, тэмдгийг хот, тосгоны захирагч, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тамгыг Хурлын дарга, Хурлын Тэргүүлэгчдийн дарга, Нарийн бичгийн дарга, Иргэдийн Нийтийн Хурлын тамгыг Хурлын Тэргүүлэгчдийн даргын гарын үсэг зурсан баримт бичиг дээр дарна"[50] гэж заажээ. Тэгэхээр баримт бичиг дээр дарсан тамга, тэмдэг нь баримт бичгийн бүрдэл хэсэг бөгөөд эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурсныг тамга эсвэл тэмдэг дарж баталгаажуулдаг байна.

Цаасан суурьтай баримт бичгийг баталгаажуулахад хэрэглэдэг эдгээр бүрдлийг цахим баримт бичиг баталгаажуулалтад ашиглах ёстойг цахим гарын үсгийн тухай хууль болон төрийн байгууллагуудад хэрэглэх архив, албан хэрэг хөтлөлтийн программ хангамжид тавигдах нийтлэг шаардлага, цахим хэлбэрээр албан хэрэг хөтлөх нийтлэг журамд тус тус тусгасан. Тухайлбал, Цахим гарын үсгийн тухай хуулийн 8.1-д "Тамга дарсан буюу дарах ёстой баримт бичгийг цахим хэлбэрээр шилжүүлэх, дамжуулах /хүлээн авах/ тохиолдолд энэ хуулийн 6.2, 6.5-д заасан тоон гарын үсгээс гадна тамга дарж баталгаажуулах эрх бүхий этгээдийн тоон гарын үсгийг давхар хэрэглэнэ" гэж заасан бол Төрийн байгууллагуудад хэрэглэх архив, албан хэрэг хөтлөлтийн программ хангамжид тавигдах нийтлэг шаардлага, цахим хэлбэрээр албан хэрэг хөтлөх нийтлэг журмын 4.7-д "цахим баримт бичиг нь тухайн байгууллагыг төлөөлөх эрх бүхий албан тушаалтны тоон гарын үсэг болон тамга, тэмдэг дарж баталгаажуулах эрх бүхий албан тушаалтны тоон гарын үсгээр баталгаажна"[51] гэж заасан. Тэгэхээр төрийн байгууллага албан баримт бичиг цахим хэлбэрээр шилжүүлэх, дамжуулахдаа эрх бүхий албан тушаалтны тоон гарын үсгээр болон тамга түших эрх бүхий албан тушаалтны тоон гарын үсгээр баталгаажуулах ёстой байна.

Гэхдээ Цахим гарын үсгийн тухай хуулийн 8.1-д "Тамга дарсан буюу дарах ёстой баримт бичгийг цахим хэлбэрээр шилжүүлэх, дамжуулах /хүлээн авах/ тохиолдолд энэ хуулийн 6.2, 6.5-д заасан тоон гарын үсгээс гадна тамга дарж баталгаажуулах эрх бүхий этгээдийн тоон гарын үсгийг давхар хэрэглэнэ"[52] гэж зааснаас харахад 6.2 болон 6.5-д заасан тоон гарын үсгийг эрх бүхий албан тушаалтанд олгосон тоон гарын үсэг гэж ойлгож байна. Гэтэл тус хуулийн 6.2-т "Тоон гарын үсгийг тусгай зөвшөөрөл эзэмшигчээс олгосон тоон гарын үсгийн гэрчилгээ бүхий иргэн, хуулийн этгээд хэрэглэж болно"[53] гэж заасан бол 6.5 заалтыг 2018 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн Цахим гарын үсгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар[54] хүчингүй болсонд тооцсон байна. Тусгай зөвшөөрөл эзэмшигчээс олгосон тоон гарын үсгийн гэрчилгээ бүхий иргэн гэдгийг эрх бүхий албан тушаалтан гэж ойлгохгүй ба мөн хүчингүй болсон заалтыг агуулсан тул энэ хуулийн 8.1 дэх хэсгийг

[49] Засгийн Газрын 2001 оны 41 дүгээр тогтоол, Тамга, тэмдэг, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэглэх заавар, https://www.legalinfo.mn/annex/details/1086?lawid=2822.

[50] Мөн тэнд.

[51] Засгийн газрын 2017 оны 111 дүгээр тогтоол, Төрийн байгууллагуудад хэрэглэх архив, албан хэрэг хөтлөлтийн програм хангамжид тавигдах нийтлэг шаардлага, цахим хэлбэрээр албан хэрэг хөтлөх нийтлэг журам, https://www.legalinfo.mn/annex/details/7761?lawid=12581.

[52] Цахим гарын үсгийн тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2012 он, №1.

[53] Цахим гарын үсгийн тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2012 он, №1.

[54] Цахим гарын үсгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль, https://www.legalinfo.mn/additional/details/3405?lawid=574.

нийгэм хүлээн зөвшөөрч, ойлгож хэрэгжүүлэхэд хүндрэл үүсч байна.

Мөн Цахим гарын үсгийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-т "тамга дарсан буюу дарах ёстой баримт бичгийг цахим хэлбэрээр шилжүүлэх, дамжуулах /хүлээн авах/ тохиолдолд энэ хуулийн 6.2, 6.5-д заасан тоон гарын үсгээс гадна тамга дарж баталгаажуулах эрх бүхий этгээдийн тоон гарын үсгийг давхар хэрэглэнэ"[55] гэж заасан нь тухайн цахим баримт бичгийг 2 албан тушаалтан өөрсдийн тоон гарын үсгээрээ баталгаажуулах шаардлагыг тавьсан байна. Өөрөөр хэлбэл, хоёр дахь этгээдийн тоон гарын үсгийг тухайн баримт бичигт дарсан тамга гэж ойлгох ёстой болж байна. Тамга дарсан буюу тамга дарах ёстой баримт бичигт тамгыг хэрхэн орлуулдаг тухай олон улсын зохицуулалтыг авч үзье.

Европын холбооны 2014 оны 910 дугаар тогтоолоор батлагдсан журмын 3 дугаар зүйлийн 25 дахь хэсэгт "цахим тамга гэж эцсийн байдлаар гарал үүсэл болон бүрдэлийг батлах цахим хэлбэрийн өгөгдөлд хавсаргасан эсвэл логик хамааралтай цахим өгөгдлийг хэлнэ"[56] гэж тодорхойлсон ба 5 дугаар бүлэгт цахим тамганы тухай зохицуулалтуудыг тусгасан байна. Үүнээс үзэхэд цахим тамга нь тоон гарын үсгийн адил баримт бичгийг шифрлэж хамгаалдаг боловч зарчимын хувьд ялгаатай байна. Өөрөөр хэлбэл, цахим тамгыг тоон гарын үсгээс ялгаж нэрлэж буй нь баримт бичиг баталгаажуулах процесс болон үүний эзэмшигчээс шалтгаалсан байна. Тухайлбал, нууцлалын архитектор Жон Эрик тайлбарлахдаа "тоон гарын үсгийг цахим баримт бичигт зурахдаа албан тушаалтан зөвхөн өөрийн биеэр төхөөрөмж, нууц үгээ ашигладаг бол цахим тамгыг дарахад байгууллагын төхөөрөмж, нууц үгийг ашигладаг"[57] гэжээ. Мөн цахим тамга дарах ажиллагааг хүний оролцоогүйгээр баримт бичиг боловсруулах программ хангамжид нэгтгэх байдлаар автоматуулж ашиглах боломжтой юм.[58]

Сангийн яамны тоон гарын үсгийн тухай илтгэлд цахим татварын тайланг баталгаажуулан илгээхэд хэрэглэх тоон гарын үсэг эзэмшигч нь "байгууллагын хэмжээнд тоон гарын үсэг ашиглах эрх бүхий албан тушаалтан нь тамга баригч нь тусдаа байхаас нь шалтгаалан 2-3 хүн байна"[59] буюу тамга дарах эрх бүхий албан тушаалтан, 1-р гарын үсэг /Дарга/, 2-р гарын үсэг /Ахлах нягтлан бодогч / гэсэн бол нийгмийн даатгалын шимтгэлийн цахим тайланг баталгаажуулж илгээхэд "тайланг Нягтлан бодогч, Дарга тус тусын тоон гарын үсгээр баталгаажуулсаны дараа QR кодтой тайлангийн маягтууд үүснэ[60]" гэсэн байна. Гэтэл практикт эдгээр тайланг илгээхдээ зөвхөн нягтлан бодогч дангаараа тоон гарын үсгээ зурж байна. Мөн Мон Пасс СА гэрчилгээ олгох байгууллагын Тоон гарын үсгийн технологи, түүнийг байгууллагад хэрэглэх гарын авлагад "Цахим баримт бичигт тамга дарахын тулд тамгын дардсыг сканердан зураг хэлбэрт оруулан буулгадаг"[61] гэжээ.

Дүгнэн үзвэзэс Цахим гарын үсгийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-т "тамга дарсан буюу дарах ёстой баримт бичгийг цахим хэлбэрээр шилжүүлэх, дамжуулах / хүлээн авах/ тохиолдолд энэ хуулийн 6.2, 6.5-д заасан тоон гарын үсгээс гадна тамга дарж баталгаажуулах эрх бүхий этгээдийн тоон гарын үсгийг давхар хэрэглэнэ" хэмээн заасан бөгөөд байгууллагын тамга эзэмшдэг албан тушаалтан солигдох тоолонд тамга орлуулан баталгаажуулдаг тоон гарын үсэг солигдож байгаа тул

[55] Цахим гарын үсгийн тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2012 он, №1.

[56] European Union. "Regulation (EU) no 910/2014". https://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/?uri=uriserv:OJ.L_.2014.257.01.0073.01.ENG (Сүүлд үзсэн огноо: 2020.05.12).

[57] John Erik Setsaas, Introduction to digital seals, 2016. https://web.archive.org/web/20180114234339/https://www.signicat.com/blog/blog-introduction-digital-seals/ (Сүүлд үзсэн огноо: 2020.5.12).

[58] Мөн тэнд.

[59] Сангийн яам, Тоон гарын үсэг, http://mofa.gov.mn/exp/ckfinder/userfiles/files/1101.pdf (Сүүлд үзсэн огноо: 2020.05.12).

[60] Мөн тэнд

[61] Мон Пасс СА, Байгууллагын цахим албан хэрэг хөтлөлтөд тоон гарын үсэг хэрэгжүүлэх, https://www.esign.gov.mn/storage/app/media/uploaded-files/strategy.pdf (Сүүлд үзсэн огноо: 2020.05.13).

Европын холбооны 2014 оны 910 дугаар тогтоолоор батлагдсан журмын 3 дугаар зүйлийн 25 дахь хэсэгт заасны дагуу цахим тамгыг хэрэглэх зохицуулалтыг бий болгох шаардлагатай.

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 4. Цахим гарын үсгийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэгт заасан гэрчилгээг түдгэлзүүлэхтэй холбоотой зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байна вэ? Хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл тулгарч байгаа эсэх?

13 дугаар зүйл.Гэрчилгээг түдгэлзүүлэх 13.1.Зөрчил илэрсэн, гэрчилгээ эзэмшигчийн хүсэлтээр маргааныг хянаж байгаа тохиолдолд тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн зөрчлийг шалгаж, арилгах хүртэл гэрчилгээг түдгэлзүүлж, зөрчил арилснаар гэрчилгээг сэргээнэ.

Үнэлгээ:

Цахим гарын үсгийн тухай хуулийн 18 дүгээр зүйлийн 18.1-т “гэрчилгээ олгох үйл ажиллагааг харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага /цаашид “төрийн захиргааны байгууллага” гэх/-аас олгосон тусгай зөвшөөрөлтэйгээр эрхэлнэ” гэж заасан. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Цахим гарын үсгийн тухай хуулийн 10 дугаар зүйлд заасны дагуу мөн тус хуулийн 11 дүгээр зүйлд заасан агуулга бүхий гэрчилгээг хүсэлт гаргагчид 2 хүртэл жилийн хугацаагаар[62] олгодог. Уг гэрчилгээг түдгэлзүүлэх үндэслэлийг Цахим гарын үсгийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Зөрчил илэрсэн, гэрчилгээ эзэмшигчийн хүсэлтээр маргааныг хянаж байгаа тохиолдолд тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн зөрчлийг шалгаж, арилгах хүртэл гэрчилгээг түдгэлзүүлж, зөрчил арилснаар гэрчилгээг сэргээнэ”[63] гэж заажээ. Энэ заалтад илэрсэн зөрчлийн тухай тодорхой заагаагүй тул тоон гарын үсгийн гэрчилгээ олгох тусгай зөвшөөрөлтэй Монпасс СА ХХК, Тридум Кэй ХХК зэрэг компаниуд ямар тохиолдолд олгосон гэрчилгээгээ түдгэлзүүлж байгааг авч үзье.

Монпасс СА ХХК-ийн Тоон гарын үсгийн гэрчилгээ эзэмших гэрээний 10 дугаар бүлэгт “Гэрчилгээг хүчингүй болгох, түдгэлзүүлэх, хязгаарлах” тухай заалтуудыг тусгасан байна. Тухайлбал, тус гэрээний 10.1-д “Тоон гарын үсгийн гэрчилгээ олгох байгууллагын гэрчилгээжүүлэх бодлого/гэрчилгээжүүлэх ажиллагааны журмын дагуу хэрэв үйлчлүүлэгч хүсвэл 14 хоногийн хугацаагаар гэрчилгээний үйлчлэлийг түдгэлзүүлж болно”[64] гэж заажээ. Харин Тридум Кэй ХХК-ийн үйлчилгээний нөхцөлд “гэрчилгээг эзэмшигчийн бичгээр гаргасан хүсэлтийн дагуу түдгэлзүүлж болно”[65] гэж заажээ. Тэгэхээр практикт гэрчилгээ олгогч байгууллага зөрчил илэрсэн, илрээгүйгээс үл хамааран тоон гарын үсгийн гэрчилгээг зөвхөн эзэмшигчийн хүсэлтээр тодорхой хугацаагаар түдгэлзүүлж байна гэж үзэж болохоор байна.

Тэгвэл тоон гарын үсгийн гэрчилгээтэй холбоотой ямар зөрчлүүд үүсч болохыг Зөрчлийн тухай хуулийн 10.22 дугаар зүйлд заасан байна. Тухайлбал, Зөрчлийн тухай хуулийн 10.22 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “тусгай зөвшөөрөлгүйгээр гэрчилгээ олгох үйл ажиллагаа эрхэлсэн; тусгай зөвшөөрлийн нөхцөлийг зөрчиж үйл ажиллагаа явуулсан; тусгай зөвшөөрөл эзэмшигч холбогдох иргэн, хуулийн этгээдийн мэдээлэл үнэн, зөв эсэхийг шалгах; гэрчилгээ олгохын эрх зүйн үр дагаврыг тайлбарлан таниулах үүргээ зөрчин гэрчилгээ олгосон бол хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно”[66], 4 дэх хэсэгт “тусгай зөвшөөрөл

[62] Цахим гарын үсгийн тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2012 он, №1.

[63] Мөн тэнд.

[64] Мон Пасс СА, Тоон гарын үсгийн гэрчилгээ эзэмших гэрээ, https://repository.monpass.mn/storage/uploads/documents/mn/organizational-persons-agreement-v1.0.pdf (Сүүлд үзсэн огноо: 2020.05.14).

[65] Тридум Кэй ХХК, Үйлчилгээний нөхцөл, https://tridumkey.mn/хэрэглэгчийн-булан/ (Сүүлд үзсэн огноо: 2020.05.14).

[66] Зөрчлийн тухай хууль, Төрийн мэдээлэл эмхтгэл, 2017 он, №24.

эзэмшигч гэрчилгээ олгох үйл ажиллагааны талаархи мэдээллийг бүрдүүлэх, шалгах боломжийг хангах зорилгоор гэрчилгээтэй холбогдох бүртгэл хөтлөх үүргээ биелүүлээгүй бол хүнийг арван таван нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно”[67] гэж тус тус заажээ. Эдгээр хэсгийн агуулгаас харахад тусгай зөвшөөрөл эзэмшигч гэрчилгээ олгох ажиллагаан дахь хуулиар тогтоосон үүргээ гүйцэтгээгүйг зөрчил гаргасанд тооцсон байна. Тэгэхээр цахим гарын үсгийн тухай хуулийн 13.1-т заасны дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигч зөрчил гаргасан бол гэрчилгээ эзэмшигчийн хүсэлтээр тухайн зөрчлийг шалгаж, арилгах хүртэл гэрчилгээг түдгэлзүүлж, зөрчил арилсны дараа гэрчилгээг буцааж сэргээдэг гэж ойлгож болохоор байна.

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 5. Цахим гарын үсгийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэгт заасан гэрчилгээ эзэмшигчийн эрх, үүрэгтэй холбоотой зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байна вэ? Хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл тулгарч байгаа эсэх?

16 дугаар зүйл.Гэрчилгээ эзэмшигчийн эрх, үүрэг
16.3.Гэрчилгээ эзэмшигч өөрийн буруугаас хувийн түлхүүрийг алдсан, хувийн түлхүүрийн нууцыг задалснаас үүдсэн хариуцлагыг хүлээнэ.

Үнэлгээ:

Монгол Улс нь нийтийн түлхүүрийн дэд бүтцийн тогтолцоонд Монгол Улсын болон олон улсын стандартуудыг мөрддөг. Тухайлбал, тоон гарын үсгийн гэрчилгээ нь Олон улсын цахилгаан холбооны байгууллага (ITU)-ын ITU-T X.509 стандартын хувилбар 3 хангах ёстой бол гэрчилгээжүүлэх бодлого ба гэрчилгээжүүлэх үйл ажиллагааны журам нь Интернэтийн инженерчлэлийн мэргэшсэн багийн IETF RFC 3647 стандартыг хангах ёстой.[68] Олон улсын стандарт ITU-T X.509 нь шаталсан хэлбэрийн баталгаажуулалт хийхийг шаарддаг. Ямар нэгэн хүний цахим гэрчилгээ нь эрх бүхий цахим гэрчилгээний газраар баталгаажсан байх бөгөөд уг газрын цахим гэрчилгээг нь эрх бүхий дээд шатны байгууллага нь баталгаажуулах хэлбэрээр явсаар хамгийн дээд эрх бүхий байгууллагадаа хүрнэ. Цахим гарын үсгийн тухай хууль нь баталгаажуулалтын шаталсан хэлбэр буюу X.509 стандарттай нийцсэн зохицуулалттай.[69]

Олон улсын стандарт ITU-T X.509-ийн 3.5.49-т хувийн түлхүүр гэж “гэрчилгээ эзэмшигчийн зөвхөн өөрөө мэддэг байх хос түлхүүрийн нэг”[70] гэж тодорхойлсон. “Тридиум э-секьюрити” компанийн ерөнхий захирал Ө.Эсболд хэлэхдээ “Тухайн хүнийг төлөөлөх тоон гарын үсэг нь өөрөө маш урт тусгай математикийн алгоритмын аргаар гарган авсан тоон цуваа юм. Иргэн энэхүү урт тоон цуваг гарган авахад шаардлагатай өөрийн гэсэн дахин давтагтагдашгүй урт хэмжээтэй (256 тэмдэгтээс бүрдэх) түлхүүр хэрэглэх болдог. Энэ нь цээжлэх болон аюулгүй биедээ авч явахад төвөгтэй тул тусгай олон улсын стандартын дагуу үйлдвэрлэгдсэн тээгчид хадгалах хэрэгтэй байдаг. Тээгч төхөөрөмжийг энгийнээр хэлэхэд бидний өдөр тутам хэрэглэдэг USB диск шиг гэж ойлгож болно” гэжээ. Энэхүү тээгчид хувийн түлхүүр, хэрэглэгч өөрөө хүсвэл мөн нийтийн түлхүүр, хэрэглэгчийн нийтийн түлхүүрийн сертификат, гэрчилгээ олгогч байгууллагын нийтийн түлхүүрийн хуулбар зэрэг мэдээлэл агуулагддаг. Тээгч төхөөрөмж рүү хандах хандалтыг давхар пин кодоор

[67] Мөн тэнд

[68] Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газрын даргын 2015 оны 71 дүгээр тушаал, Бодлогын чиглэл батлах тухай, https://esign.gov.mn/nijtijn-tlhrijn-ded-btcijg-ashiglah-talaar-trs-barimtlah-bodlogyn-chiglel.

[69] Төрийн мэдээлэл холбооны газар, Тоон гарын үсэг ба түүний баталгаажуулах хэлбэрүүд, http://ncsc.gov.mn/index.php?id=133.

[70] Sector, Telecommunication Standardization. “Information technology-Open Systems Interconnection-The Directory: Public-key and attribute certificate frameworks, 2016.” https://www.itu.int/rec/dologin_pub.asp?lang=e&id=T-REC-X.509-201610-S!!PDF-E&type=items.

хамгаалах ёстой.[71] Иймээс тоон гарын үсэг эзэмшигч нь энэхүү төхөөрөмжийг хэрэглэхдээ аюулгүй ажиллагааны горим мөрдөх шаардлагатай болж байгаа бөгөөд үүнийг зөрчсөнөөс үүдэх хариуцлагыг цахим гарын үсгийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 3 дахь хэсгээр зохицуулсан байна.

Цахим гарын үсгийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3-т "Гэрчилгээ эзэмшигч өөрийн буруугаас хувийн түлхүүрийг алдсан, хувийн түлхүүрийн нууцыг задалснаас үүдсэн хариуцлагыг хүлээнэ"[72] зааснаас харахад гэрчилгээ эзэмшигч өөрөө тоон гарын үсгийн төхөөрөмжөө нэвтрэх кодын хамт бусдад дамжуулах байдлаар задалснаас болж хариуцлагын алдаа үүсэхээр байна. Харин гэрчилгээ эзэмшигч уг төхөөрөмжийг алдсан бол үүнийг олж авсан этгээд ашиглах боломж хомс юм. Тухайлбал, "Тридиум э-секьюрити" компанийн ерөнхий захирал Ө.Эсболд хэлэхдээ "Энэхүү тээгч нь олон улсын аюулгүй байдлын стандартын дагуу хийгдсэн мэдээллийн аюулгүй байдлыг бүрэн хангасан ба хадгалагдсан түлхүүр нь тухайн төхөөрөмжөөс гадагш гаргаж авах ямар ч боломгүйгээр бүтээгдсэн… Тухайн төхөөрөмж нь санаатай болон санамсаргүйгээр алдагдсан тохиолдолд тухайн түлхүүрийг ашиглах ямар ч боломжгүй хийгдсэн тул итгэлтэй байж болно. Гэхдээ мэдээж тухайн төхөөрөмжид хандах нууц үгээ иргэн хэнд ч хэлж болохгүй гэдгийг анхаарах хэрэгтэй" гэжээ. Тэгэхээр цахим гарын үсгийн тухай хуулийн 16.3-т заасан "өөрийн буруугаас хувийн түлхүүрийг алдсан, хувийн түлхүүрийн нууцыг задлах" гэдгийг тухайн хувийн түлхүүр, тээгч төхөөрөмж, үүнд нэвтрэх нууц үг эсвэл пин код зэргийг алдах, задруулах гэж үзэж болохоор байна. Иймд гэрчилгээ эзэмшигч хувийн түлхүүрээ бусдад санаатай болон болгоомжгүй дамжуулснаас үл хамааран өөрт нь учирсан хохирол, бусдад учирсан хохирлыг өөрөө хариуцах болж байна.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

4.1 ДҮГНЭЛТ

Цахим баримтад зурагдсан гарын үсэг буюу тоон гарын үсэг нь хэвлэмэл материалд үзгээр зурсан гарын үсэгтэй ижил үүрэг, зорилготой баталгаажуулалтын нэг арга, хэлбэр бөгөөд цахим баримт буюу файлд гарын үсэг зурсан этгээд буюу эзэн, хариуцагч нь хэн бэ гэдгийг, тухайн файлд гарын үсэг зурагдсанаас хойш санаатай болон санамсаргүй байдлаар ямар нэгэн өөрчлөлт ороогүй эсвэл эвдрээгүй гэдгийг баталгаажуулдаг байна.

Төрийн үйлчилгээ, харилцааг цахим хэлбэрээр явуулах, цахим болон тоон гарын үсгийн хэрэглээ хангалттай биш байгаа өнөөгийн байдал нь Монгол Улсын засаглалын чадавхи болон цахим засгийн хөгжлөөр бусад орнуудаас хоцрох нөхцөлийг бүрдүүлж байна. Тодруулбал, Монгол Улсын хэмжээнд нийт 94,675-н аж ахуй нэгж, байгууллага үүнээс төсвийн байгууллага 4,623 үйл ажиллагаа явуулж байгаагаас нийт аж ахуй нэгж байгууллагын 0.11% төсвийн байгууллагын 2.3% буюу 108 байгууллага цахим гарын үсэг болон тоон гарын үсэг ашиглаж байгаа нь цахим хэрэглээ хангалттай биш байгааг харуулж байна. Энэ нь иргэн болон аж ахуй нэгж, байгууллагын цахим болон тоон гарын үсгийн талаарх мэдээлэл дутмаг байгаатай салшгүй холбоотой юм.

Энэхүү судалгааны явцад холбогдох этгээдүүдээс асууж тодруулан мөн тоон мэдээ, тайланд дүн шинжилгээ хийхэд зарим зүйлсийг нэмж хуульчлах боломжийг судлан үзэх шаардлагатай болох нь харагдаж байна. Тухайлбал, Европын холбооны 2014 оны 910 дугаар тогтоолоор батлагдсан журмын 3 дугаар зүйлийн 25 дахь хэсэгт "цахим тамга гэж эцсийн байдлаар гарал үүсэл болон бүрдэлийг батлах цахим хэлбэрийн өгөгдөлд хавсаргасан эсвэл логик хамааралтай цахим өгөгдлийг хэлнэ" хэмээн заасны дагуу цахим тамганы зохицуулалтыг хуульчлах.

[71] Мөн тэнд.

[72] Цахим гарын үсгийн тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2012 он, №1.

4.2. ЗӨВЛӨМЖ

Судалгааны үр дүнд гарсан дүгнэлтэд тулгуурлан дараах зөвлөмжийг гаргаж байна. Үүний тулд:

1. Цахим гарын үсгийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь заалтыг практикт өргөнөөр хэрэгжүүлэх үүднээс Архивын ерөнхий газрын даргын 2009 он 68-р тушаалаар батлагдсан "Төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар"-т хуулийн уг заалттай нийцүүлэн өөрчлөлт оруулах шаардлагатай. Мөн төрийн албан хаагчдад тоон гарын үсгийн технологи, аюулгүй байдал, мөн чанар, ач холбогдлыг тайлбарлан таниулах ажлыг үе шаттай хэрэгжүүлэх замаар тоон гарын үсгийн хэрэглэгчийн тоог нэмэгдүүлэх хэрэгтэй. Үүний зэрэгцээ тоон гарын үсгийн хэрэглэх орчин, хүрээг өргөжүүлж, төрийн албан хаагчид өдөр тутамдаа тоон гарын үсгээ хэрэглэх дадлыг хэвшүүлэх шаардлагатай байна.

2. Цахим гарын үсгийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-т "тамга дарсан буюу дарах ёстой баримт бичгийг цахим хэлбэрээр шилжүүлэх, дамжуулах /хүлээн авах/ тохиолдолд энэ хуулийн 6.2, 6.5-д заасан тоон гарын үсгээс гадна тамга дарж баталгаажуулах эрх бүхий этгээдийн тоон гарын үсгийг давхар хэрэглэнэ" гэх заалтын 6.5 гэсэн хэсгийг нь хасах шаардлагатай байна. Учир нь уг хэсэг нь 2018 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн "Цахим гарын үсгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар" хүчингүй болсон тооцсон байна.

3. Тоон гарын үсгийн гэрчилгээний агуулгад албан хаагчийн хувийн мэдээлэл дээр нэмээд албан тушаалын нэр ордог. Тухайн албан тушаалтны албан тушаал өөрчлөгдөхөд тоон гарын үсэг дагаад хүчингүй болдог. Ингэснээр байгууллагын тамга эзэмшдэг албан тушаалтан солигдох тоолонд тамга орлуулан баталгаажуулдаг тоон гарын үсэг солигдож байна. Иймээс олон улсын практикын дагуу тоон тамга бий болгож, тоон тамга дарах ажиллагааг автоматжуулах хэрэгтэй.

4. Дээрхээс гадна хуулийн хэл зүй, найруулгыг сайжруулах үүднээс дараах саналтай байна.

- Тус хуулийн 4.1.4, 4.1.12 дахь хэсэгт "... программм..." гэснийг "программ" гэж;
- Тус хуулийн 10.3 дахь хэсэгт "... үнэмлэхийн..." гэснийг "үнэмлэх" гэж;
- Тус хуулийн 14.1.3 дахь заалтад "...болгуулахоор..." гэснийг "болгуулахаар" гэж;
- Тус хуулийн 19 дүгээр зүйлийн гарчигт "... тавих ерөнхий шаардлага..." гэснийг "...тавигдах ерөнхий шаардлага..." гэж тус тус өөрчлөх.

Хуулийн шинжлэх ухааны үндэсний www.nli.gov.mn

НОМ ЗҮЙ

Хууль, эрх зүйн акт

1. Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 1992, №1
2. Зөрчлийн тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2017 он, №24
3. Иргэний бүртгэлийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль, 2011.12.15
4. Иргэний хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2002 он, №7
5. Иргэний хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль, 2011.12.15
6. Цахим гарын үсгийн тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2012, №1
7. Цахим гарын үсгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль, https://www.legalinfo.mn/additional/details/3405?lawid=574
8. Улсын Их Хурлын тогтоол, Цахим гарын үсгийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай, 2011.12.15, Дугаар 61, https://www.legalinfo.mn/law/details/6911
9. Засгийн газрын тогтоол, Журам батлах тухай, Цахим хэлбэрээр албан хэрэг хөтлөх нийтлэг журам, 2017.04.12, Дугаар 111, https://www.legalinfo.mn/law/details/12581
10. Засгийн Газрын тогтоол, Тамга, тэмдэг, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэглэх заавар, 2001.02.26, Дугаар 41, https://www.legalinfo.mn/annex/details/1086?lawid=2822
11. Засгийн газрын тогтоол, Төрийн байгууллагуудад хэрэглэх архив, албан хэрэг хөтлөлтийн програм хангамжид тавигдах нийтлэг шаардлага, цахим хэлбэрээр албан хэрэг хөтлөх нийтлэг журам, 2017.04.12, Дугаар 111, https://www.legalinfo.mn/annex/details/7761?lawid=12581
12. Засгийн газрын тогтоол, “Цахим засаг” үндэсний хөтөлбөр батлах тухай, 2012.04.04, Дугаар 101
13. Засгийн газрын тогтоол, Төрийн байгууллагаас төрийн болон бусад байгууллагатай цахим хэлбэрээр мэдээлэл солилцох, мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглах журам, 2019.06.05, Дугаар 220
14. Засгийн газрын тогтоол, Тоон гарын үсгийн гэрчилгээ олгох талаар авах зарим арга хэмжээний тухай, 2016.03.14, Дугаар 151, https://www.legalinfo.mn/law/details/11786
15. Засгийн газрын тогтоол, Үндэсний хөтөлбөр батлах тухай (цахим засаглал), 2019.02.20, Дугаар 73, https://www.legalinfo.mn/law/details/14177
16. Засгийн газрын тогтоол, Боловсролын баримт бичгийн лавлагааг цахим хэлбэрээр олгох тухай, 2016.06.28, Дугаар 347, https://www.legalinfo.mn/law/details/12036
17. Архивын ерөнхий газрын тушаал, Албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар батлах тухай, 2009.07.07, Дугаар 68, https://www.legalinfo.mn/law/details/10719
18. Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газрын даргын тушаал, Бодлогын чиглэл батлах тухай, 2015.03.25, Дугаар 71, https://esign.gov.mn/nijtijn-tlhrijn-ded-btcijg-ashiglah-talaar-trs-barimtlah-bodlogyn-chiglel
19. Стандарт, хэмжил зүйн газар, Баримт бичгийн бүрдэл, тэдгээрт тавих шаардлага, http://estandard.gov.mn/standart/reader/412

Хуулийн үндэсний хүрээлэн www.nlrc.gov.mn

Ном, гарын авлага, сэтгүүл

1. Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газар. “Цагаан ном 2014” (2015)
2. Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газар. “Цагаан ном 2017” (2018)
3. Ө.Одгэрэл, “Монгол Улс дахь цахим засаглалын бодлого”, (ХБНГУ, 2011), Ламберт хэвлэлийн газар
4. Мон Пасс СА гэрчилгээ олгох байгууллага, Байгууллагын цахим албан хэрэг хөтлөлтөд тоон гарын үсэг хэрэгжүүлэх гарын авлага, (2016), https://esign.gov.mn/tusgaj-zvshrl-bhij-gerchilgeezhleh-bajguullaga
5. А.Мөнхзул, “Цахим гарын үсэг зурах эрх зүйн зохицуулалтыг сайжруулах тухай”, Монголын төр, эрх зүй №1 (2014)

Нийтлэл, ярилцлага

1. Г.Ганзориг, “Цахим гарын үсгийн тухай хуулийг 2011 онд баталж, цахим орчинд баримт бичгийг баталгаажуулах эрх зүйн орчин бий болсон”, https://www.mongolbank.mn/news.aspx?id=2246&tid=2
2. Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар. “Цахим хэлбэрээр албан хэрэг хөтлөх нийтлэг журам батлагдлаа”. http://cita.gov.mn/?p=10198
3. Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар. “Тоон гарын үсгийг төрийн үйлчилгээнд нэвтрүүлсэн байгууллагад батламж гардууллаа”. http://cita.gov.mn/?p=9972
4. Д.Баяраа, Татварын тайланг цахим хэлбэрээр хэрхэн тайлагнах вэ?, http://mta.mn/c/view/71154
5. Нийгмийн даатгалын ерөнхий газар, Нийгмийн даатгалын шимтгэлийн тайланг үндэсний тоон гарын үсгээр хүлээн авах тухай мэдээлэл, http://www.ndaatgal.mn/v1/view/1266
6. Төрийн мэдээлэл холбооны газар, Тоон гарын үсэг ба түүний баталгаажуулах хэлбэрүүд, http://ncsc.gov.mn/index.php?id=133.
7. Т.Халтар, “Монголчууд тоон гарын үсгийг гар утасны үйлчилгээ авдагтайгаа адил ашигладаг болно”, (сурв. С.Бадрал), 2017.11.28, https://ikon.mn/n/15ts
8. Мон Пасс СА, Тоон гарын үсгийн хэрэглээ, https://monpass.mn/storage/uploads/download_files/ Тоон_гарын_үсэг_ашиглаж_буй_байдал.pdf
9. Сангийн яам, Тоон гарын үсэг, http://mofa.gov.mn/exp/ckfinder/userfiles/files/1101.pdf
10. Мон Пасс СА, Байгууллагын цахим албан хэрэг хөтлөлтөд тоон гарын үсэг хэрэгжүүлэх, https://www.esign.gov.mn/storage/app/media/uploaded-files/strategy.pdf
11. Мон Пасс СА, Тоон гарын үсгийн гэрчилгээ эзэмших гэрээ, https://repository.monpass.mn/storage/uploads/documents/mn/organizational-persons-agreement-v1.0.pdf
12. Тридум Кэй ХХК, Үйлчилгээний нөхцөл, https://tridumkey.mn/хэрэглэгчийн-булан/
13. Ө.Эсболд, “Иргэдэд таатай тоон гарын үсгийн технологийг нэвтрүүлэгч Тридум э-Секьюрити”, 2018.11.15, https://ikon.mn/n/1fle.

Хуулийн дэлгэрэнгүй мэдээлэл www.zli.gov.mn

Гадаад эх сурвалж

1. European Union. “Regulation (EU) no 910/2014”. https://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/?uri=uriserv:OJ.L_.2014.257.01.0073.01.ENG
2. John Erik Setsaas, Introduction to digital seals, 2016. https://web.archive.org/web/20180114234339/https://www.signicat.com/blog/blog-introduction-digital-seals/
3. Cambridge online dictionary, https://dictionary.cambridge.org/dictionary/english/signature
4. Sector, Telecommunication Standardization. “Information technology-Open Systems Interconnection-The Directory: Public-key and attribute certificate frameworks, 2016.” https://www.itu.int/rec/dologin_pub.asp?lang=e&id=T-REC-X.509-201610-S!!PDF-E&type=items

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

НИЙТИЙН АШИГ СОНИРХЛЫН ТӨЛӨӨ ШҮГЭЛ ҮЛЭЭГЧ /ИЛЧЛЭГЧ/-ИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭ[73]

УДИРТГАЛ

Энэхүү үнэлгээний зорилго нь Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын гуравдугаар хавсралтаар баталсан "Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал" /цаашид "аргачлал" гэх/-ыг баримтлан Нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгч /илчлэгч/-ийг хамгаалах тухай хуулийн төслийг боловсронгуй болгоход оршино.

Түүнчлэн, судалгаагаар төслийн үр нөлөөг үнэлж, уг төслийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах замаар эрх зүйн орчинг сайжруулах боломжийг тодорхойлох, мөн хуулийг хэрэглэхэд ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар боловсруулахад хууль санаачлагчид дэмжлэг үзүүлэхийг зорилоо.

Төслийн үр нөлөөг үнэлэх ажиллагааг аргачлалд заасны дагуу дараах үе шаттайгаар гүйцэтгэлээ. Үүнд:

1. Шалгуур үзүүлэлтийг сонгох;
2. Хуулийн төслийн үр нөлөө тооцох хэсгээ тогтоох;
3. Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох;
4. Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх зэрэг болно.

НЭГ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОХ

Хуулийн төслийн /цаашид "төсөл" гэх/ үр нөлөөг үнэлэх ажиллагааг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан "Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх тооцох аргачлал"-ын 1.4-т заасны дагуу:

- Шалгуур үзүүлэлтийг сонгох;
- Хуулийн төслөөс үр нөлөө тооцох хэсгээ тогтоох;
- Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох;
- Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх гэсэн үе шатыг баримтлан гүйцэтгэлээ.

Төслийн үр нөлөөний үнэлгээг тооцохдоо зорилго, хамрах хүрээ, зохицуулах харилцаатай уялдуулан, аргачлалд дурдсан дараах 3 шалгуур үзүүлэлтийг сонгов. Үүнд:

1. Зорилгод хүрэх байдал;
2. Ойлгомжтой байдал;
3. Харилцан уялдаа.

Эдгээр шалгуур үзүүлэлтийг сонгохдоо дараах үндэслэлийг харгалзан үзэв. Үүнд:

1. Төсөл нь "нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгч /илчлэгч/-ийг дэмжих, хамгаалах, урамшуулах эрх зүйн орчинг бий болгох" гэсэн зорилгодоо хүрсэн эсэх;

2. Төсөлд тусгагдсан зохицуулалтуудыг хэрэглэх, хэрэгжүүлэх субъектүүдийн хувьд ойлгомжтой, логик дараалалтайгаар боловсруулагдсан эсэх;

3. Төслийн зүйл, заалт нь өөр хоорондоо болон бусад хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжтой нийцсэн эсэх, мөн төрийн байгууллагын чиг үүрэгтэй давхардсан, зөрчилдсөн эсэхийг тус тусад нь шалгана.

[73] Энэхүү үнэлгээг АТГ-ын захиалгаар 2020 онд ХЗҮХ-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга, хууль зүйн ухааны доктор П.Амаржаргал удирдан, Эрдэм шинжилгээний ахлах ажилтан Г.Халиунаа, Эрдэм шинжилгээний ажилтан Б.Ариунжаргал нар хамтран гүйцэтгэв.

www.hii.gov.mn

Хүснэгт 1. *Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалд заасан шалгуур үзүүлэлт*

Д/д	Шалгуур үзүүлэлт	Шалгуур үзүүлэлтийг сонгох
5.	Зорилгод хүрэх байдал	“Зорилгод хүрэх байдал” нь тухайн хуулийн төслөөр тавьж байгаа зорилгодоо хүрч чадах эсэхийг тооцон судалдаг шалгуур үзүүлэлт юм. Хуулийн төсөлд тусгагдсан зохицуулалт, арга хэмжээнүүд нь хуулийн төслөөр тавьсан зорилгод хүрэх боломжтой эсэхийг үнэлэхэд ашиглана. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр /цаашид “АТҮХ” гэх/-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Засгийн газрын 2017 оны 114 дүгээр тогтоолоор батлагдсан. Энэхүү төлөвлөгөөнд “Шүгэл үлээгч /мэдээлэгч/-ийг хамгаалах эрх зүйн зохицуулалтыг бий болгох”-оор заасан тодийгүй манай улсын тухайд иргэд гэмт хэргийн талаар мэдээлэх, мэдээллийг төлбөртэй авах талаар Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон холбогдох бусад хууль заасан байдаг боловч мэдээлэгчийг хамгаалах, мэдээлэл өгөх боломж нөхцөлөөр хангах талаар зохицуулалт хангалтгүй тусгасан, мөн 2006 онд батлагдсан Авлигын эсрэг хуульд албан хаагч авлигын талаарх мэдээллийг Авлигатай тэмцэх газар /цаашид “АТГ” гэх/-т мэдээлэх үүрэгтэй байхаар, иргэн, хуулийн этгээд авлигын асуудлаар АТГ-т өргөдөл, гомдол гаргах, мэдээлэл өгч болохоор заасан ба мэдээлэгчийг хамгаалах, урамшуулах талаар зохицуулалт мөн л хангалттай тусгагдаагүй тул төслийн үзэл баримтлалд шүгэл үлээгчийг хамгаалах эрх зүйн орчинг бий болгох анхдагч хуулийн төслийг боловсруулах шаардлагатай гэж үзжээ. Иймд төслийн хүрээнд эдгээр асуудлыг шийдвэрлэсэн эсэх, сонгож авсан шийдлийн зорилгод хүрэх байдлыг үнэлэх нь зүйтэй гэж үзлээ.
6.	Ойлгомжтой байдал	“Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зохицуулалт түүнийг хэрэглэх, хэрэгжүүлэх субъектүүдийн хувьд ойлгомжтой, логик дараалалтайгаар боловсруулагдсан эсэхийг шалгана. Энэхүү хуулийн төсөл нь анхдагч төсөл учраас зохицуулалтын уялдаа, холбоо болон бусад хууль тогтоомжийн стандартыг хангаж буй эсэхийг хуулийн төслийг боловсруулахдаа Хууль тогтоомжийн тухай хууль, “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал”-ыг баримталсан эсэх талаас нь үнэлэх нь зүйтэй гэж үзлээ.
7.	Харилцан уялдаа	“Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн үр нөлөөг шалгах тохиолдолд хуулийн төслийн тодорхой зүйл, заалтыг бус хуулийн төслийг бүхэлд нь шалгана. Учир нь “Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд тухайн хуулийн төслийн бусад хуультай нийцэх байдлыг шалгадаг. Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалын зорилт нь хуулийн төслийн давхардал, хийдэл, зөрчлийг арилган хуулийг хэрэглэхэд ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар боловсруулах, улмаар хуулийн төслийн чанарыг сайжруулах талаар зөвлөмж өгөхөд чиглэсэн тул энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд шалгаж үзэх зайлшгүй шаардлагатай гэж үзлээ.

ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ НЬ ТООЦОХ ХЭСГЭЭ ТОГТООХ

Энэхүү хэсэгт уг төслийн үр нөлөөг нь үнэлэх хэсгээ тогтоож, сонгосон шалгуур үзүүлэлтийн хүрээнд холбогдох зүйл, заалтыг сонгоно. Энэхүү зүйл, заалтыг сонгохдоо хууль зүйн хувьд шууд үр дагавар үүсгэж байгаа голлох ач холбогдол бүхий заалтуудыг сонгож авсан. Өөрөөр хэлбэл, тухайн төслийн үр нөлөөг үнэлэхдээ цаг хугацаа, зардал хэмнэх үүднээс голлох ач холбогдол бүхий заалтыг сонгож, тухайн сонгосон зүйл, заалтын үр нөлөөг судаллаа.

2.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд

Манай орны хувьд иргэд гэмт хэргийн талаар мэдээлэх, мэдээллийг төлбөртэй авах талаар Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон холбогдох бусад хууль заасан байдаг боловч мэдээлэгчийг хамгаалах, мэдээлэл өгөх боломж нөхцөлөөр хангах талаар зохицуулалт хангалтгүй байна[74] гэж Нийтийн

[74] Нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгчийг /илчлэгчийг/ хамгаалах тухай хуулийн төслийн үзэл баримтлал, 1 дэх тал.

ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгчийг /илчлэгчийг/ хамгаалах тухай хуулийн төслийн үзэл баримтлалд дурджээ.

Дээрхээс үзвэл, төслийн үндсэн зорилго нь нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээхийг авлигын асуудалтай холбон авч үзэж, шүгэл үлээгч /илчлэгчийг/-ийг дэмжих, хамгаалах, урамшуулахтай холбогдсон харилцааг зохицуулсан бие даасан хуулийг боловсруулахад оршиж байна.

Энэхүү зорилгод хүрэхийн тулд хуулийн төсөл боловсруулагчид дараах зорилтын хүрээнд төслийг боловсруулжээ. Үүнд:

- Хуулийн төслөөр зохицуулах харилцаа нь харьцангуй шинэ тул хуулийн төсөлд хэрэглэх зарим нэр томьёог тайлбарлах;
- Нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгч /илчлэгч/-ийг дэмжих, хамгаалахтай холбоотойгоор бодлого тодорхойлох, хэрэгжүүлэх үйл ажиллагааг чиглүүлж хариуцах байгууллагыг тусгаж, чиг үүргийг тодорхойлох;
- Нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээсэн мэдээллийн мөрөөр авах арга хэмжээг нарийвчлан тусгах;
- Шүгэл үлээгч /илчлэгч/-ийг хамгаалах асуудлыг зохицуулах;
- Шүгэл үлээгч /илчлэгч/-ээс өгсөн мэдээллийн мөрөөр шагнал, урамшуулал олгохыг хэрхэн шийдвэрлэх талаар тусгах;
- Хуулийг хэрэгжүүлэх явцад хүн гүтгэх, хүний эрхийн зөрчил гаргахаас сэргийлж, шүгэл үлээсэн гэж үзэхгүй байх нөхцөлийг тодорхойлох;
- Шүгэл үлээгч /илчлэгч/-ийг хамгаалах, урамшуулах асуудлыг олон улсын хэм хэмжээнд нийцүүлж, авлигатай тэмцэх ажиллагаанд ахиц гаргах эерэг нөлөөллийг тооцох;
- Хариуцлагын асуудлыг холбогдох хуультай нийцүүлэн тогтоох гэх мэт.

Дээрх зорилтуудыг багцлан харвал ямар асуудлыг шүгэл үлээсэнд тооцох, шүгэл үлээгчийн шүгэл үлээж буй үйл ажиллагааг дэмжих, түүнийг шүгэл үлээснийх нь төлөө аливаа эрсдэлээс хамгаалах, мөн тодорхой хэмжээгээр шагнаж урамшуулах цогц арга хэмжээг зохицуулахаар байна.

Иймд хуулийн төслийн “зорилгод хүрэх байдал”-ын үр нөлөөг тооцохын тулд дээрх зорилтуудтай холбогдсон зүйл, заалтыг сонгон авч тооцох болно. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 2. *Зорилгод хүрэх байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зүйл, заалт*

№	Зорилгод хүрэх байдал	Сонгосон зүйл, заалт
1	Тухайн харилцааны эрх зүйн зохицуулалтыг нарийвчлан шинэ хуулиар зохицуулах шаардлагатай тул анхдагч хуулийн төслийг боловсруулах	Төслийн зүйл, заалтад бүхэлд нь.
2	Нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгч /илчлэгч/-ийг дэмжих чиглэлээр АТГ болон бусад байгууллагын хүлээх үүрэг, хэрэгжүүлэх ажиллагааг тодорхойлох	Төслийн 5 дугаар зүйл 5.1-5.4, 6 дугаар зүйл 6.1 дэх хэсэг.
3	Шүгэл үлээгчийн нийгэмд гүйцэтгэх үүргийг нийтэд зөв ойлгуулах, хүлээн зөвшөөрөх нөхцөл бүрдүүлэх, дэмжих, хамгаалах асуудлыг шийдвэрлэх	Төслийн 16 дугаар зүйлийн 4, 5, 6 дахь хэсэг, 19 дүгээр зүйлийн 3, 6 дахь хэсэг, 23 дугаар 2, 3 дахь хэсэг.

2.2. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд

“Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд уг төслийн зүйл, заалтад бүхэлд нь дүн шинжилгээ хийж, үр нөлөөг тооцно. /Хуулийн төсөл нь 5 бүлэг, 26 зүйлтэй/

Хуульчдын үндэсний хүрээлэн www.jil.gov.mn

2.3. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд

“Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд уг хуулийн төслийн зүйл, заалтыг бүхэлд нь шалгаж, үр нөлөөг тооцно. /Хуулийн төсөл 5 бүлэг, 26 зүйлтэй/

ГУРАВ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ҮР НӨЛӨӨГ ТООЦОХ

Өмнөх үе шатуудад хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгож, үр нөлөөг үнэлэх хэсгээ тогтоосон тул тэдгээрт тохирох шалгах хэрэгслийг дараах байдлаар харуулав.

Хүснэгт 3. *Шалгах хэрэгслийг сонгосон байдал*

№	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Тохирох шалгах хэрэгсэл
1.	Зорилгод хүрэх байдал	Төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэг.	Зорилгод дүн шинжилгээ хийх.
2.	Ойлгомжтой байдал	Төслийг бүхэлд нь тооцно.	Хуулийн төслийн уялдаа холбоог Хууль тогтоомжийн тухай хууль болон аргачлалд заасан асуулгаар шалгах.
3.	Харилцан уялдаа	Төслийг бүхэлд нь тооцно.	Хуулийн төслийн уялдаа холбоог Хууль тогтоомжийн тухай хууль болон аргачлалд заасан асуулгаар шалгах.

Дээрх урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирсон шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг дараах байдлаар үнэллээ.

3.1. Зорилгод хүрэх байдал

3.1.1. Төслөөр тавьсан зорилгын хүрээнд дэвшүүлсэн “Тухайн харилцааны эрх зүйн зохицуулалтыг нарийвчлан шинэ хуулиар зохицуулах шаардлагатай тул анхдагч хуулийн төслийг боловсруулах” эхний зорилтын хувьд:

Хууль тогтоомжийн тухай хуульд “Хууль санаачлагч нийгмийн харилцааны төлөв байдал, тулгамдсан асуудлыг судалсны үндсэн дээр шинээр үүссэн харилцааг хуулиар зохицуулах шаардлагатай, эсхүл тухайн нийгмийн харилцааны эрх зүйн зохицуулалтыг нарийвчлан шинэ хуулиар зохицуулах шаардлагатай гэж үзвэл анхдагч хуулийн төсөл боловсруулна”[75] гэж заасан.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 2003 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 58/4 тоот тогтоолоор батлагдсан Авлигын эсрэг Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенцын 33 дугаар зүйлд “Оролцогч улс бүр энэхүү конвенцийн дагуу тогтоосон гэмт хэргийн талаархи аливаа баримт нотолгоог сайн санааны үүднээс, үндэслэлтэйгээр эрх бүхий байгууллагад мэдээлж буй аливаа этгээдийг аливаа шударга бус хандлагаас хамгаалахаар заах талаарх зохих арга хэмжээг өөрийн дотоодын эрх зүйн тогтолцоонд нэвтрүүлэн оруулах асуудлыг авч үзнэ.”[76] гэж тусгасан.

Энэ хүрээнд Улсын Их Хурлын 2016 оны 51 дүгээр тогтоолоор АТҮХ-ийг, Засгийн газрын 2017 оны 114 дүгээр тогтоолоор АТҮХ-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг тус тус баталсан бөгөөд төлөвлөгөөнд “Шүгэл үлээгч /мэдээлэгч/-ийг хамгаалах эрх зүйн зохицуулалтыг бий болгох” гэж заажээ.

Мөн Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны 38 дугаар зарлигаар 2018-2019 оныг “Авлигаас татгалзах, илчлэх, авлигын гэрч, мэдээлэгчийг хамгаалах жил” болгон зарлаж, авлига, албан тушаалын гэмт хэрэг, зөрчлийг илрүүлж илчилсэн мэдээлэгчийг урамшуулах, хамгаалах, авлига, албан тушаалын гэмт хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож байгаа гэрчийг хамгаалах зэрэг асуудалд

[75] Хууль тогтоомжийн тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2015 он, №25.

[76] Авлигын эсрэг Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенцийг соёрхон батлах тухай. https://www.legalinfo.mn/annex/details/6492?lawid=10269

Хуулийн үндэсний төвөөлөн www.mn.gov.mn

тусгайлан анхаарч, хууль, эрх зүйн орчинг улам боловсронгуй болгох арга хэмжээ авч ажиллахыг зөвлөсөн.[77]

Дээрх үндэслэл шаардлагын дагуу хуулийн төсөл санаачлагчид Монгол Улсын нэгдэн орсон Авлигын эсрэг Нэгдсэн Үндэстний байгууллагын конвенц, Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулийн холбогдох заалттай уг хуулийн төслийн агуулга, нэр томьёог нийцүүлж боловсруулсан байна.

Төслийн үзэл баримтлалд дурдсан үндэслэл, шаадрлагын үүднээс тус хуулийн төслийг боловсруулах зайлшгүй шаардлага бий гэдэг нь тодорхой харагдаж байгаа төдийгүй энэ талаар Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс хийсэн "Шүгэл үлээгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах судалгаа"-ны тайланд[78] хууль зүйн болон практик шаардлагын талаар дэлгэрэнгүй тайларласан байна. Тухайлбал, тус судалгаанд "Нийтийн ашиг сонирхлыг хөндсөн аливаа мэдээллийг нийтэд ил болгосныхоо төлөө тодорхой хувь хүн, бүлэг этгээд, аж ахуйн нэгж, албан тушаалтан, засаг захиргааны зүгээс ямарваа дарамт шахалтад өртөх, эрх чөлөөгөө хязгаарлуулах, хувь хүний эрх зөрчигдөх, хүчирхийлэлд өртөх улмаар үйл ажиллагаагаа хэвийн явуулж чадахгүйд хүрэх тохиолдол дэлхий нийтийн хэмжээнд байсаар байна. Олон улсын судалгаанаас үзэхэд хувийн хэвшлийн салбарт үйлдэгдсэн луйврын хэргийн 45 орчим хувийг салбар дотроос мэдээлсэн мэдээлэлд тулгуурлан илрүүлсэн байдаг. Зохисгүй үйлдэл, гэмт үйлдлийг дотооддоо мэдээлэх буюу шүгэл үлээх боломжийг бүрдүүлж, хөхүүлэн дэмжихийн чухлыг эндээс харж болно.[79] Мөн нийтийн ашиг сонирхлын төлөө зүй бус үйлдлийг мэдээлж, шүгэл үлээхийг ардчилсан нийгэмд иргэний хүлээх ёстой үүрэг гэж үздэг. Гэтэл Монгол Улсад зүй бус үйлдлийн талаар шүгэл үлээсэн иргэнийг хамгаалах механизм бүрдээгүйн улмаас үйлдэл, эс үйлдэхүйг мэдээлсний дараа гарах эрсдэлээс болгоомжлон иргэд мэдээлэл өгдөггүй, өгөхийг хүсдэггүй байдал ажиглагдаж байна"[80] гэж тэмдэглээд эдгээр эрсдэл үүсгэж болохоор асуудлыг дараах байдлаар багцлан авч үзжээ. Үүнд[81]:

- Нийтийн ашиг сонирхлыг хөндсөн аливаа хууль бус үйлдлийг илчилж үг хэлсэн, үйл ажиллагаа явуулсан, төрийн байгууллага, этгээдэд хандсаныхаа төлөө бусдын халдлага, дарамт шахалтад өртөх, гадуурхагдах;
- Бусдын зүгээс илчлэгч, гэрч, хохирогч, мэдээлэгч (шүгэл үлээгч)-ийн нэр төр, алдар хүнд, эрх чөлөө, эрүүл мэнд, аюулгүй байдалд нь халдах, цахим хэлбэрээр доромжлох, сэтгэл санааны дарамт үзүүлэх,
- Илчлэгч, гэрч, хохирогч, мэдээлэгч (шүгэл үлээгч)-ийн гэр бүлийн гишүүдийг хөнөөлтэй нөхцөл байдал, сүрдүүлэг, сэтгэл санааны болон бие махбодийн дарамт, эрх чөлөө, амь зуулгад халдах;
- Нийгэмд шударга бус аливаа явдалтай тэмцвэл хохирдог гэсэн ойлголт нэмэгдсэнээр төрийн байгууллагын ажилтан, олон нийтийн төлөөлөл, хувь хүмүүс хууль бус үйлдлийг хараагүй мэт өнгөрүүлж, улмаар тэр үйлдэлд нь татагдан орох;
- Гадны хууль ёсны хөрөнгө оруулалт буурах, гадны хууль бус үйл ажиллагаа нэмэгдэх, улсын хөгжил, бүтээн байгуулалт нэмэгдэхгүй байх, улсын

[77] Нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгч /илчлэгч/-ийг хамгаалах тухай хуулийн төслийн үзэл баримтлал.

[78] Дэлгэрэнгүйг Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс 2019 онд гүйцэтгэсэн "Шүгэл үлээгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах судалгаа"-ны тайлангаас үзнэ үү.

[79] Дам ишлэв. Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага, Авлигатай тэмцэх гарын авлага, (Уб, 2018), 146 дахь тал

[80] Дам шилэв. "Шүгэл үлээгч, мэдээлэгчийн эрхийг хамгаалах" хуулийн төслийн талаар зөвлөлдөх уулзалт. http://parliament.mn/n/fxjo (сүүлд үзсэн 2019.10.15)

[81] Хууль зүйн үндэсний хүрээлэн, Шүгэл үлээгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн хэрэгцээ, шаардлагын урьдчилан тандан судалгааны тайлан, Уб., 2019 он, 10 дахь тал.

хөрөнгийг зүй бусаар зарцуулах нь нэмэгдэж алдагдалд орох;

- Төрийн байгууллагын хүнд суртал, авлига, хээл хахууль өндөр түвшинд шилжиж, сургуулийн багш болон бусад үйлчилгээний ажилтнуудын хууль бус жижиг үйлдэл халхавч болж буй байдал;
- Төрийн байгууллага болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, эрх бүхий албан тушаалтны зүгээс хууль бус мэдээллээ нууцлах, мэдээллээр хангах үүргээ биелүүлэхээс татгалзах, зайлсхийх, мэдээллийг нуун дарагдуулах зэрэг.

Эдгээр асуудлыг харгалзан шүгэл үлээгчийг хамгаалах нэгдсэн тогтолцоог ***хууль тогтоомжоор бий болгох*** замаар дээр дурдсан бүх асуудлыг шийдвэрлэх шаардлагатай гэж үзжээ.

Иймд судлаачдын зүгээс энэхүү анхдагч хуулийн төслийг боловсруулах нь зүйтэй гэж үзсэн бөгөөд "Тухайн харилцааны эрх зүйн зохицуулалтыг нарийвчлан шинэ хуулиар зохицуулах шаардлагатай тул анхдагч хуулийн төслийг боловсруулах" гэсэн зорилтдоо хүрсэн гэж үзэж болохоор байна.

3.1.2. Төслөөр тавьсан зорилгын хүрээнд дэвшүүлсэн "Нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгч /илчлэгч/-ийг дэмжих чиглэлээр АТГ болон бусад байгууллагын хүлээх үүрэг, хэрэгжүүлэх ажиллагааг тодорхойлох" зорилтын хувьд:

5 дугаар зүйл.Нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгч /илчлэгч/-ийг дэмжих талаар байгууллагын хүлээх үүрэг

5.1.Байгууллага нь нийтийн ашиг сонирхол хохирохоос урьдчилан сэргийлэх, энэ талаар зөрчил гарсан тохиолдолд таслан зогсоох, нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгч /илчлэгч/-ийг /цаашид "шүгэл үлээгч" гэх/ дэмжих, хамгаалах үүрэгтэй.

5.2.Захиргааны байгууллага нь хувийн хэвшил, төрийн бус байгууллагын зүгээс нийтийн ашиг сонирхлыг хохироохоос урьдчилан сэргийлэх талаар хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллаж болно.

5.3.Нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгч нь ажил мэргэжлээ солих, албан тушаалаа өөрчлөх, түр хугацаагаар өөр үүрэг гүйцэтгэх зэрэг хүний нөөц, аж ахуйн байртай холбоотой арга хэмжээ авах үндэслэл бүхий хүсэлт гаргавал тэрхүү хүсэлтийг тухайн байгууллагын удирдлага даруй шийдвэрлэнэ.

5.4.Байгууллага нь энэ хуулийн зохицуулалтад нийцүүлэн нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгчийн талаар зөв хандлага төлөвшүүлэх сургалт явуулах, шүгэл үлээсэн мэдээллийг хүлээн авах, шүгэл үлээгчийг дэмжих, урамшуулах, хамгаалах асуудлыг тусгасан журам гаргаж мөрдөнө.

6 дугаар зүйл.Авлигатай тэмцэх газраас шүгэл үлээгчийг дэмжих нэгдсэн арга хэмжээ авах

6.1.Авлигатай тэмцэх газар нь нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгчийг дэмжихтэй холбоотой дараахь асуудлаар арга хэмжээ авч, удирдамж, зөвлөмж гаргаж ажиллана:

6.1.1.нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгчийн мэдээллийг хүлээн авах, шүгэл үлээгчийн хувийн мэдээлэл үнэн эсэх, шүгэл үлээж байгаа зорилго нь нийтийн ашиг сонирхлын төлөө эсэхийг хянах;

6.1.2.мэргэжлийн хяналт шалгалт явуулах болон мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллагатай харилцан хамтран ажиллах;

6.1.3.шүгэл үлээгчийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээг зохион байгуулах;

6.1.4.шүгэл үлээгчид мөнгөн шагнал олгох, урамшуулах, нөхөн төлбөр олгох үндэслэлийг хянаж шийдвэрлэх;

6.1.5.олон нийтэд шүгэл үлээгчийг хүлээн зөвшөөрөх, дэмжихтэй холбоотой сургалт, сурталчилгаа явуулах;

6.1.6.шүгэл үлээгчид хууль зүйн болон сэтгэл зүйн үнэ төлбөргүй зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулах;

6.1.7.хуульд заасан бусад.

Хууль тогтоомжийн тухай хууль[82] /цаашид "ХТтХ" гэх/-ийн 29 дүгээр зүйлийн 29.1.11-д "хуулийн төсөл нь хуулийн зорилго гэсэн зүйлтэй байж болох бөгөөд зорилгод тус хуулиар хангахаар зорьж байгаа иргэний үндсэн эрх, бэхжүүлэх үндсэн зарчим, хүрэх үр дүнг тусгана" гэж заасан.

Энэ хүрээнд хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэгт "Энэ хуулийн зорилт нь нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгч /илчлэгч/-ийг дэмжих, хамгаалах, урамшуулахтай холбогдсон харилцааг зохицуулах, нийтийн ашиг

[82] Хууль тогтоомжийн тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2015 он, №25

сонирхлын төлөө шүгэл үлээхэд тавигдах шаардлага, шүгэл үлээх журмыг тодорхойлоход оршино" гэж хуулийн зорилтыг тодорхойлжээ. Үүнийг багцлан авч үзвэл 5 зорилтын хүрээнд шүгэл үлээгчтэй холбоотой харилцааг зохицуулахаар тусгагдсан байна. Үүнд:

1/шүгэл үлээгчийг дэмжих;

2/ шүгэл үлээгчийг хамгаалах;

3/ шүгэл үлээгчийг урамшуулах;

4/ шүгэл үлээхэд тавигдах шаардлагыг тодорхойлох;

5/ шүгэл үлээх журмыг тодорхойлох зэрэг болно.

Төсөлд "***шүгэл үлээгчийг хамгаалах, урамшуулах, шүгэл үлээхэд тавигдах шаардлага***"-ыг тус бүрд нь бүлэг болгон тусгаж өгсөн атал "***шүгэл үлээгчийг дэмжих***" зохицуулалтыг хуулийн нийтлэг үндэслэл болох нэгдүгээр бүлэгт хамааруулан тусгажээ. Энэ нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 2.5 дахь заалтад "зүйлүүдийг сэдвээр нь бүлэглэж, бүлгийг хэсэг, ангид нэгтгэж болно" гэсэн төслийн бүтцийн шаардлагыг хангаагүй, мөн тус хуулийн 28 дугаар зүйлийн 3 дахь хэсэг[83]-т заасан хуулийн төслийн бүтцийн дараалыг баримтлаагүй байна гэж үзэж болохоор байна.

Иймд хуулийн зорилго, зорилт, үзэл баримтлалаасаа ч харсан ***"шүгэл үлээгчийг дэмжих"*** зохицуулалтыг тусгай бүлэг болгон оруулах нь зүйтэй.

Төслийн 5 дугаар зүйлд шүгэл үлээгчийг дэмжихтэй холбоотой арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр байгууллага бүрд /захиргааны, хувийн хэвшлийн, төрийн бус байгууллага гэх мэт/ үүрэг болгосон зохицуулалтыг тусгажээ. Энэ нь нэг талаар шүгэл үлээгчийн сэтгэл зүйд сайнаар нөлөөлөх, айдсыг багасгах, шүгэл үлээх сэдлийг төрүүлэхэд дэмжлэг болохоос гадна, нөгөө талаар шүгэл үлээх үйл ажиллагааг дэмжих, авлигыг бууруулахад түлхэц болохуйц сайшаалтай зохицуулалт болсон гэж үзэж болохоор байна.

Мөн байгууллага бүрийг нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгчийн талаар зөв хандлага төлөвшүүлэх сургалт явуулах, шүгэл үлээсэн мэдээллийг хүлээн авах, шүгэл үлээгчийг дэмжих, урамшуулах, хамгаалах асуудлыг тусгасан журам баталж, мөрдүүлэхээр заасан нь процесс ажиллагааг улам тодорхой болгосон зохицуулалт болжээ.

Харин хуулийн төслөөс харахад байгууллага бүрд үүрэг ногдуулсан хэдий ч АТГ-т бусад байгууллагаас илүү өргөн хүрээнд харьцангуй олон арга хэмжээг хэрэгжүүлэх үүрэг ногдуулсан байна. Тухайлбал, шүгэл үлээгчийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээг зохион байгуулах, шүгэл үлээгчид мөнгөн шагнал, нөхөн төлбөр олгох, хууль зүйн болон сэтгэл зүйн үнэ төлбөргүй зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулах гэх мэт арга хэмжээг хэрэгжүүлэхийг үүрэг болгожээ.

Төслөөр АТГ болон бусад байгууллагын хэрэгжүүлэх чиг үүргийг тус тусад нь зүйл, заалт болгон тусгахыг оролдсон нь харагдаж байгаа хэдий ч зарим зүйл, заалтын хувьд давхардуулсан, ойлгомжгүй байдал үүсгэсэн зохицуулалт цөөнгүй байна. Тухайлбал, төслийн 6 дугаар зүйлд АТГ-ын хэрэгжүүлэх арга хэмжээг тусгасан бөгөөд 6 дугаар зүйлийн 1.1 дэх заалтад **"**нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгчийн мэдээллийг хүлээн авах, шүгэл үлээгчийн хувийн мэдээлэл үнэн эсэх, шүгэл үлээж байгаа зорилго нь нийтийн ашиг сонирхлын төлөө эсэхийг хянах" гэж заасан нь энэхүү арга хэмжээг зөвхөн АТГ хэрэгжүүлнэ гэж ойлгогдож байна.

Гэтэл төслийн "Мэдээллийг бүртгэх, шилжүүлэх, хянан шалгах" хэмээх 11 дүгээр зүйлийн 1.1 дэх заалтад "Авлигатай тэмцэх газар болон энэ хуулийн 9.1-

[83] Мөн тэнд, "Хуулийн төслийн бүтцийг дараах дараалаар байрлуулна:
1/хуулийн төслийн гарчиг, 2/нийтлэг хэм хэмжээ тогтоож байгаа зүйлийг нэгтгэсэн "ерөнхий анги", эсхүл "нийтлэг үндэслэл" гэсэн бүлэг, хэсэг,3/нэр томьёоны тайлбар, 4/тусгайлсан хэм хэмжээ тогтоож байгаа зүйлийг нэгтгэсэн тусгай "анги", эсхүл агуулгаар нь бүлэг, хэсэг болгосон эрх зүйн хэм хэмжээ, 5/ ...".

д заасан байгууллага, албан тушаалтан нь шүгэл үлээсэн мэдээллийг хүлээн авч ажлын таван өдөрт багтаан дараах асуудлыг тодруулж, шаардлагатай гэж үзвэл шүгэл үлээгчээс нэмэлт мэдээлэл хүсч болно" гэзд энэхүү тодруулах асуудалд нь "энэ хуулийн 8.2.3-т заасан мэдээлэл үнэн, зөв эсэх;"[84], мөн "шүгэл үлээсэн мэдээлэл нь нийтийн ашиг сонирхлын төлөө гэж үзэх үндэслэл байгаа эсэх"[85] гэж заасан нь хуулийн төслөөр зааж өгсөн холбогдох байгууллагууд бүгд хэрэгжүүлэх арга хэмжээ байхаар харагдаж байна.

Иймд төсөлд АТГ-ын онцлог хэрэгжүүлэх арга хэмжээг 6 дугаар зүйлээр, бусад байгууллагын нийтлэг хэрэгжүүлэх арга хэмжээг 11 дүгээр зүйлээр зохицуулахаар давхардуулахгүйгээр тусгаж өгөх нь зүйтэй болов уу.

Төслийн 5, 6 дугаар зүйлээс харахад шүгэл үлээгчийг дэмжих талаар холбогдох байгууллагууд сургалт, сурталчилгаа зохион байгуулах, тэдэнд урамшуулал, мөнгөн шагнал, нөхөн төлбөр олгох, аюулгүй байдлыг нь хангах арга хэмжээ зохион байгуулах, мөн хууль зүйн болон сэтгэл зүйн зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулах зэрэг олон арга хэмжээний талаар тусгасан нь сайшаалтай төдийгүй эдгээр арга хэмжээг хэрхэн хэрэгжүүлэх талаар холбогдох журмыг байгууллагууд журамлан мөрдүүлэхээр заасан нь төслөөр тавьсан "Нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгч /илчлэгч/-ийг дэмжих чиглэлээр АТГ болон бусад байгууллагын хүлээх үүрэг, хэрэгжүүлэх ажиллагааг тодорхойлох" гэсэн зорилтдоо хүрсэн гэж үзэж болохоор байна.

3.1.3. Төслөөр тавьсан зорилгын хүрээнд дэвшүүлсэн "Шүгэл үлээгчийн нийгэмд гүйцэтгэх үүргийг нийтэд зөв ойлгуулах, хүлээн зөвшөөрөх нөхцөл бүрдүүлэх, дэмжих, хамгаалах асуудлыг шийдвэрлэх" зорилтын хувьд:

ГУРАВДУГААР БҮЛЭГ
ШҮГЭЛ ҮЛЭЭГЧИЙГ ХАМГААЛАХ

16 дугаар зүйл.Шүгэл үлээгчийн хувийн аюулгүй байдлыг хамгаалах

16.4.Шүгэл үлээгчийн хүсэлтийг үндэслэн Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 5.4-т заасны дагуу тухайн хуульд заасан журмаар хамгаалалтын арга хэмжээ авч болно.

16.5.Нийтийн ашиг сонирхлыг зөрчсөн зөрчлийн талаар шүгэл үлээж, мэдээлэл өгсөн тохиолдолд шүгэл үлээгчийн хүсэлтийг үндэслэн шаардлагатай бол Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.2 дугаар зүйлийн 8-д заасны дагуу аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авч болно.

16.6.Шүгэл үлээсэн мэдээллийн дагуу эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд гэрч болж байгаа шүгэл үлээгчийг Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 13.1, 13.2-т заасны дагуу хамгаалалтын арга хэмжээнд хамруулж болно.

19 дүгээр зүйл.Шүгэл үлээгчийг дарамт, шахалтаас хамгаалах

19.3.Хяналт шалгалтаар шүгэл үлээгчид дарамт шахалт үзүүлэх үйлдэл хийх нь илэрхий болсон тохиолдолд холбогдох этгээдэд хандаж Авилгатай тэмцэх газраас тухайн үйлдлийг хийхгүй байх талаар зөвлөмж хүргүүлнэ.

19.6.Шүгэл үлээгчид дарамт, шахалт үзүүлсэн этгээд нь Авлигатай тэмцэх газрын зөвлөмжийг хүлээж авснаас хойш 30 хоногийн дотор энэ хуулийн 19.4-т заасан арга хэмжээг аваагүй тохиолдолд шүгэл үлээгч холбогдох хуулийн дагуу шүүхэд хандаж шийдвэрлүүлнэ.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ
ШҮГЭЛ ҮЛЭЭГЧИД МӨНГӨН ШАГНАЛ, УРАМШУУЛАЛ, НӨХӨН ТӨЛБӨР ОЛГОХ

23 дугаар зүйл.Мөнгөн шагналыг давхардуулан олгохыг хориглох

23.2.Энэ хуулийн дагуу олгох мөнгөн шагнал, урамшууллын хэмжээ нь бусад хууль тогтоомжийн дагуу адил үндэслэл, шалтгаанаар олгох мөнгөн шагнал, урамшууллын хэмжээтэй тэнцүү, эсхүл уг хэмжээнээс бага буюу илүү байх нөхцөлд Авлигатай тэмцэх газар болон холбогдох байгууллага уг зөрүүг хасч, нэмж тооцон олгохгүй.

23.3.Шүгэл үлээгч энэ хуульд заасантай адил үндэслэл, шалтгаанаар бусад хууль тогтоомжийн дагуу мөнгөн шагнал, урамшууллын мөнгө авсан тохиолдолд Авлигатай тэмцэх газар болон холбогдох байгууллага тэрхүү авсан хэмжээгээр мөнгөн шагнал, урамшууллын мөнгөн дүнгээс хасч тооцно.

[84] Нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгч /илчлэгч/-ийг хамгаалах тухай хуулийн төсөл, 11.1.1.

[85] Мөн тэнд, 11.1.2.

Төслийн Гуравдугаар бүлгийн 13-19 дүгээр зүйлд шүгэл үлээгч /илчлэгч/-ийг хамгаалах зохицуулалтыг, Дөрөвдүгээр бүлгийн 20-24 дүгээр зүйлд шүгэл үлээгчид шагнал, урамшуулал, нөхөн төлбөр олгох асуудлыг цогц байдлаар тусгажээ.

Энэ хэсэгт сонгон авсан зүйл заалтуудын өөр хоорондын харилцан уялдаа хийгээд бусад хууль тогтоомжтой хэрхэн нийцэж байгаа байдал талаас нь зорилтыг үнэлнэ.

Төслөөр шүгэл үлээгчийг хамгаалах асуудлыг Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль /цаашид "ГХХтХ" гэх/ болон холблгдох бусад хуультай уялдуулан зохицуулсан бөгөөд бусад хуулийн зүйл, заалтыг иш татахдаа алдаа, дутагдал нэлээд гаргасан байгаа нь ойлгомжгүй байдлыг үүсгэж байна. Тухайлбал,

Төслийн 16 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт "Шүгэл үлээгчийн хүсэлтийг үндэслэн Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 5.4-т заасны дагуу тухайн хуульд заасан журмаар хамгаалалтын арга хэмжээ авч болно" гэсэн нь уг заалтаар илэрхийлэх гэсэн буй ойлголтыг буруу илэрхийлсэн гэж үзэж болохоор байна. Өөрөөр хэлбэл, уг заалтад "... Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 5.4-т заасны дагуу ..." гэж тодотгож заасан зохицуулалтыг ГХХтХ-иас харвал "Гэмт хэрэг илрүүлэхэд ач холбогдол бүхий мэдээлэл, баримт сэлт өгөх болон бусад байдлаар туслалцаа үзүүлсэн, гэмт хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд гэрчээр оролцоогүй хүн энэ хуульд хамаарагдаж болно"[86] гэснээс харахад шүгэл үлээгч тус хуулиар хамгаалагдаж болно гэсэн утга санааг илэрхийлснээс бус ямар журмын дагуу хамгаалагдах талаар тусгаагүй заалт тул хуулийн зүйл, заалтыг буруу ишэлсэн гэж үзэж болохоор байна.

Иймд төслийн 16 дугаар зүйлийн 4 дэх хэсгийг "Шүгэл үлээгчийн хүсэлтийг Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 5.4-т заасныг үндэслэн тухайн хуульд заасан журмаар хамгаалалтын арга хэмжээ авч болно" гэж өөрчлөн, найруулж болох юм.

Мөн төслийн 16 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт ЗШШтХ-ийн зүйл, заалтыг буруу ишэлсэн байна. Өөрөөр хэлбэл, ЗШШтХ-ийн 6.2 дугаар зүйлд "8" гэсэн хэсэг байхгүй бөгөөд хуулийн төсөл санаачлагчид тус хуулийн 6.2 дугаар зүйлийн "6" дахь хэсгийг иш татаж бичих байсан болов уу.

Түүнчлэн, төслийн 16 дугаар зүйлийн 6 дахь хэсэг иш татан бичсэн "... Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль /цаашид "ЭХХШтХ" гэх/-ийн 13.1, 13.2-т заасны дагуу ..." гэснээс харахад ГХХтХ-д 13.2 гэсэн зүйл, заалт байхгүй, ЭХХШтХ-ийн 13.2[87] дугаар зүйлийг ишлэх шаардлагагүй байхаар харагдаж байна.

Иймд эдгээр зүйл, заалтыг дахин нягтлах шаардлагатай юм.

Төслийн 19 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт "Хяналт шалгалтаар шүгэл үлээгчид дарамт шахалт үзүүлэх үйлдэл хийх нь илэрхий болсон тохиолдолд холбогдох этгээдэд хандаж Авилгатай тэмцэх газраас тухайн үйлдлийг хийхгүй байх талаар

[86] Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2013 он, №30.

[87] ЭХХШтХ-ийн 13.2 дугаар зүйл. Гэрч, хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалах шийдвэр гаргах

1.Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан хамгаалалтын арга хэмжээ авах тухай шийдвэрт дараахь зүйлийг тусгана:

1.1.аюулгүй байдлын хамгаалалтын ямар арга хэмжээ авах;

1.2.аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээ авах хугацаа;

1.3.аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх байгууллага;

1.4.аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх явцад эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас хэрэглэх хуульд заасан албадлага.

2.Гэрч, хохирогчийн амь нас, эрүүл мэндэд заналхийлсэн, халдахаар завдсан, бэлтгэсэн, эсхүл халдлага бодитой эхэлсэн тохиолдолд мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллага, албан тушаалтан Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээ авч, энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан шийдвэр гаргуулахаар шүүхэд даруй хандана.

3.Шүүх нь прокурор, өмгөөлөгч, мөрдөгчийн аюулгүй байдлыг хамгаалах арга хэмжээг энэ хуулийн 13.1 дүгээр зүйлд заасны дагуу авч болно.

зөвлөмж хүргүүлнэ” гэзд энэхүү хүргүүлсэн зөвлөмжийг биелүүлээгүй тохиолдолд дараагийн авах арга хэмжээг тусгаж өгөөгүй байна. Энэ байдал нь шүгэл үлээгчид цаашдаа хохирол үүсгэж болзошгүй байх тул АТГ-ын зөвлөмжийг биелүүлээгүй бол тус газраас ямар арга хэмжээ авах талаар нарийвчлан тусгах шаардлагатай гэж үзэж байна.

Төслийн 19 дүгээр зүйлийн 6 дахь хэсэгт “Шүгэл үлээгчид ***дарамт, шахалт үзүүлсэн этгээд нь*** Авлигатай тэмцэх газрын зөвлөмжийг хүлээж авснаас хойш 30 хоногийн дотор ***энэ хуулийн 19.4-т заасан арга хэмжээг аваагүй тохиолдолд*** шүгэл үлээгч холбогдох хуулийн дагуу шүүхэд хандаж шийдвэрлүүлнэ” гэж заажээ.

Гэтэл тус хуулийн 19 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт тухайн дарамт, шахалт үзүүлсэн байгууллага, албан тушаалтан нь:

- дарамт шахалт үзүүлсэн үйлдлийг цуцлах, буюу хориглох;
- дутуу олгосон эсхүл огт олгоогүй цалин хөлс, урамшууллыг нөхөн олгох;
- сахилгын болон захиргааны, эдийн засгийн бусад сөрөг арга хэмжээг хүчингүй болгох;
- зохих ажлын байр, албан тушаалд нь томилох, бусад гэх мэт арга хэмжээг даруй авах ёстой гэж заасан.

Тэгвэл, дээрх арга хэмжээнүүд нь байгууллагын эрх бүхий албан тушаалтан, өөрөөр хэлбэл, удирдах албан тушаалтны шийдвэрээр авах арга хэмжээнүүд юм.

Эндээс үзэхэд төслийн 19 дүгээр зүйлийн 6 дахь хэсгийг “***зөвхөн дарамт, шахалт үзүүлсэн этгээд нь эдгээр арга хэмжээг аваагүй тохиолдолд шүгэл үлээгч холбогдох хуулийн дагуу шүүхэд хандаж шийдвэрлүүлэхээр заасан***” гэж ойлгож болохоор байна. Өөрөөр хэлбэл, дээрх арга хэмжээг авах эрх бүхий субъект /удирдах албан тушаалтан/ л дарамт, шахалт үзүүлсэн тохиолдлын тухай яригдаж байгаа болохоос тухайн байгууллагын гүйцэтгэх албан тушаалтан шүгэл үлээгчид дарамт, шахалт үзүүлсэн тохиолдолд хэрхэн шийдвэрлэх талаар зохицуулалт төсөлд тусгагдаагүй байна.

Иймд энэхүү зохицуулалтыг эргэн нягтлах шаардлагатай юм.

Мөн төслийн 23 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Энэ хуулийн дагуу олгох мөнгөн шагнал, урамшууллын хэмжээ нь бусад хууль тогтоомжийн дагуу адил үндэслэл, шалтгаанаар олгох ***мөнгөн шагнал, урамшууллын хэмжээтэй тэнцүү, эсхүл уг хэмжээнээс бага буюу илүү байх нөхцөлд Авлигатай тэмцэх газар болон холбогдох байгууллага уг зөрүүг хасч, нэмж тооцон олгохгүй***” гэж заасан нь ямар тохиолдолд, аль ч байгууллагаас олгож буй шагнал, урамшууллын хэмжээ зөрүүтэй байсан ч нэмж, хасч тооцохгүй гэж ойлгогдож байна. Гэтэл төслийн 23 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Шүгэл үлээгч энэ хуульд заасантай адил үндэслэл, шалтгаанаар бусад хууль тогтоомжийн дагуу мөнгөн шагнал, урамшууллын мөнгө авсан тохиолдолд ***Авлигатай тэмцэх газар болон холбогдох байгууллага тэрхүү авсан хэмжээгээр мөнгөн шагнал, урамшууллын мөнгөн дүнгээс хасч тооцно.***” гэж заасан нь хоорондоо зөрчил үүсгэж байх тул төслийн 23 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн заалтыг хасах нь зүйтэй болов уу.

Иймд төслөөр тавьсан “Шүгэл үлээгчийн нийгэмд гүйцэтгэх үүргийг нийтэд зөв ойлгуулах, хүлээн зөвшөөрөх нөхцөл бүрдүүлэх, дэмжих, хамгаалах асуудлыг шийдвэрлэх” гэсэн зорилтдоо хангалттай хүрээгүй гэж үзэж болохоор байна.

3.2. Ойлгомжтой байдал

Хууль тогтоомжийн тухай хуулийн[88] /цаашид “ХТтХ” гэх/ 29 дүгээр зүйлд заасан хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлагад нийцүүлэн боловсруулсан эсэхийг дараах байдлаар шалгасан.

[88] Хууль тогтоомжийн тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2015 он, №25.

Хүснэгт 4. *Хууль тогтоомжийн тухай хуулийн 29, 30 дугаар зүйлд заасан шаардлагад нийцүүлэн боловсруулсан эсэх*

Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан Хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага	
Хууль тогтоомжийн тухай хуулийн зохицуулалт	Хуулийн төслийн зохицуулалтад үнэлгээ хийсэн байдал
29.1.1. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, *бусад хууль,* үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байх;	Төслийн 13.3-т "...Шүгэл үлээгчийн өгсөн мэдээлэл нийтийн ашиг сонирхолд хамаарахгүй болохыг тогтоосон нь тухайн шүгэл үлээгчийг мэдээлэл өгсөнтэй нь холбогдуулан Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль болон ***бусад хуульд заасан аливаа хариуцлагад татах үндэслэл болохгүй...***" гэж заасан нь учир дутагдалтай байна. Учир нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 4-т "...Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх, хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох, шүүхийн шийдвэрийг давж заалдах, уучлал хүсэх эрхтэй..." гэж заасан. Гэтэл шүгэл үлээгчийн өгсөн мэдээлэл нь нийтийн ашиг сонирхолд хамаарахгүй тухайн иргэн, байгууллага, аж ахуйн нэгж, хуулийн этгээдийн нэр төр, алдар хүнд, сэтгэл санаанд хохирол учруулсан зөрчил, гэмт хэргийн шинжтэй үйлдэл байхад тус хуулийн төсөлд Эрүүгийн хууль, Зөрчлийн хууль болон бусад хуульд заасан хариуцлагад татахгүй гэж заасан нь шүгэл үлээгчийн шүгэл үлээсэн үйлдлийн улмаас бусад этгээд хохирсон ч өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалах боломжийг хязгаарласан зохицуулалт болсон байна.
29.1.2. Тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх;	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
29.1.3. Тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх;	Хуулийн төсөл зохицуулах харилцаа, хүрээнээс хальсан зүйл судалгаагаар тогтоогдоогүй.
29.1.4. Тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд үл хамаарах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болсонд тооцох тухай заалт тусгахгүй байх;	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
29.1.5 Зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх;	Төслийн зүйл, заалт нь хоорондоо зөрчилдсөн хэд хэдэн тохиолдол илэрсэн бөгөөд энэ талаар харилцан уялдаа хэсэгт дэлгэрэнгүй бичигдсэн болно.
29.1.6. Хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх;	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
29.1.7. Бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх;	Энэ талаар судалгааны зорилгод хүрэх байдал шалгуур үзүүлэлтийн хэсэгт дэлгэрэнгүй тусгасан.

хуульзүй.mn www.nli.gov.mn

29.1.8. Тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаа, хуулийн үйлчлэх хүрээ, эрх зүйн харилцаанд оролцогч хүн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, зохицуулалтад удирдлага болгох, харгалзан үзэх нөхцөл байдал, нийтийн эрх зүйн этгээдийн чиг үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийг биелүүлэх журам;	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
29.1.9. Шаардлагатай тохиолдолд эрх зүйн хэм хэмжээ зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын төрөл, хэмжээ, хуулийн хүчин төгөлдөр болох хугацаа, хууль буцаан хэрэглэх тухай заалт, хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалт, бусад хуулийн зүйл, заалтыг хүчингүй болсонд тооцох, хасах заалт;	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
29.1.10. Шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулсан байх;	Хуулийн төслийг дагалдан Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүгийн хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулжээ. Өөрөөр хэлбэл, Хууль тогтоомжийн тухай хуулийн 29.1.10-д заасан шаардлагыг зөрчсөн асуудал тогтоогдоогүй болно.
29.1.11. Хуулийн төсөл нь хуулийн зорилго гэсэн зүйлтэй байж болох бөгөөд зорилгод тус хуулиар хангахаар зорьж байгаа иргэний үндсэн эрх, бэхжүүлэх үндсэн зарчим, хүрэх үр дүнг тусгана.	Төслийн 1 дүгээр зүйлд тус хуулийн зорилтыг "...Энэ хуулийн зорилт нь нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгч /илчлэгч/-ийг дэмжих, хамгаалах, урамшуулахтай холбогдсон харилцааг зохицуулах, нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээхэд тавигдах шаардлага, шүгэл үлээх журмыг тодорхойлоход оршино" гэж тодорхойлсон байна.
Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан Хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага.	
30.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томьёог хэрэглэх;	Төслийн 3.1.2."хамгаалалтын арга хэмжээ" гэж Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 4.1.2-т заасныг; 3.1.3."хамаарал бүхий этгээд" гэж Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 5.3-т заасныг; 3.1.4."даруй" гэж Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.4 дүгээр зүйлийн 1.7-д заасныг тус тус ойлгохоор заасан нь бусад хуульд хэрэглэсэн нэр томьёог хэрэглэсэн гэж үзэх үндэслэлтэй байна.
30.1.2.Нэг нэр томьёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх;	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
30.1.3. Үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих;	Төслийн нэр буюу "Нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгч / илчлэгч/-ийг хамгаалахтухай" гэснийг *"...Нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгч /илчлэгч/-ийг хамгаалах тухай*" гэж; Төслийн 7.3, 7.4, 10.4, 19.3-т заасан "...Авилгатай тэмцэх..." гэснийг *"...Авлигатай тэмцэх..."* гэж; Төслийн 3.1.3-т "...Гэрч хохирогчийг хамгаалах тухай хуулийн 5.3-т заасныг..." гэснийг *"...Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 5.3-т заасныг..."* гэж; Төслийн 5.1-д "...нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгч / илчлэгч/-ийг /цаашид "шүгэл үлээгч" гэх/ гэжээ. Иймд тус төслийн 5.3, 5.4, 6.1, 6.1.1, 8.1, 10.1-д заасан "...нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгч..." гэснийг *"...шүгэл үлээгч..."* гэж;

ХУУЛЬЗҮЙН ЗӨВЛӨЛ ХУРЭЭЛЭН www.ikh.gov.mn

	Төслийн 5.3, 8.1, 10.1-д заасан "... нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгч..." гэснийг *"...шүгэл үлээгч..."* гэж; Төслийн 11.6-д "...Зохих хяналт, шалгалтаар шүгэл үлээсэн мэдээлэл нь батлагдаагүй..." гэж заасны "...мэдээлэл..." гэдгийг *"...мэдээлэл..."* гэж; Төслийн 20.2-т "...Энэ хуулийн 20.1-д зааснаар мөнгөн шагнал авах өргөдөл ирүүлснээс хойш долоо хоногийн дотор Авлигатай тэмцэх газраас Мөнгөн шагнал олгох зөвлөл байгуулах ба уг зөвлөлөөс хэлэлцэн шийдвэрлэсний дагуу дараахь хэмжээг баримтлан мөнгөн шагнал олгоно..." гэж заасны дагуу дор дурдсан хүснэгтэд нь мөнгөн шагнал олгох хувь хэмжээг зааж өгсөн. Тус хүснэгт дэх "Энэ хуулийн 20.1-д заасан орлогод хамаарах үнийн дүн /төгрөгөөр/" гэсэн багана доорх хүснэгтэн дэх үнийн дүнг ойлгомжтой байлгахын тулд дор дурдсан байдлаар өөрчилж болох юм. 1. "...50 саяас 250 сая..." гэснийг *"...50 саяас 250 сая хүртэл..."* гэж; 2. "...250 саяас 1 тэрбум..." гэснийг *"...250 саяас 1 тэрбум хүртэл..."* гэж; 3. "...1 тэрбум төгрөгөөс 2 тэрбум..." гэснийг *"...1 тэрбум төгрөгөөс 2 тэрбум хүртэл..."* гэж; Төслийн 7.5-д "...**дэлгэрэнгүй мэдээллийг Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороонд мөн хугацаанд хүргүүлж байна..." гэснийг *"...дэлгэрэнгүй мэдээллийг Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороонд мөн хугацаанд хүргүүлнэ..."* гэж тус тус өөрчлөх**; **Төслийн 9.1.2-т "...**нийтийн ашиг сонирхолтой холбоотой тухайн асуудал эрхлэх асуудлын хүрээнд нь хамаарах байгууллагын удирдах албан тушаалтанд..." гэдгийг утга зүйн хувьд найруулах; Төслийн 11.7-д заасан "... удаа дараа..." гэснийг хэдэн удаагийн үйлдэл гэж ойлгох талаар тусгаагүй байна. иймд эргэлзээтэй нөхцөл байдал үүсгэхээс сэргийлж "удаа дараа" гэж бичилгүй ".... / тоон утга/ ба түүнээс дээш удаа" гэж бичих; Төслийн 12.1.4-т "...нийтийн ашиг сонирхлыг хохироосон үйлдлийг холбогдох хуулийн дагуу хянан **шалгаж эхэлчихсэн байсан** буюу шалгаж дууссан бол..." гэснийг өөрчлөн найруулах; Төслийн 14.2-т "...Шүгэл үлээгч энэ хуулийн 14.1-д заасан зөвлөгөө авах тухай хүсэлтийг Авлигатай тэмцэх газарт гаргах ба тухайн байгууллага зөвлөгөө өгөх ажлыг хүсэлтийг хүлээн авснаас хойш даруй зохион байгуулна..." гэснийг *"...Шүгэл үлээгч нь энэ хуулийн 14.1-д заасан зөвлөгөө авах тухай хүсэлтээ Авлигатай тэмцэх газарт гаргах бөгөөд хүсэлтийг хүлээн авсан даруй зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулна..."* гэж өөрчлөн найруулах; Төслийн 16.4-т "...Шүгэл үлээгчийн хүсэлтийг үндэслэн Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 5.4-т заасны дагуу тухайн хуульд заасан журмаар хамгаалалтын арга хэмжээ авч болно..." гэснийг *"...Шүгэл үлээгчийн хүсэлтийг үндэслэн Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан журмын дагуу хамгаалалтын арга хэмжээ авч болно"* гэж өөрчлөн найруулах; Төслийн 18.1-д "...Нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээсэнтэй нь холбогдуулан шүгэл үлээгчид дараахь дарамт шахалт үзүүлэхийг хориглоно..." гэснээс харахад тодорхой хугацаа заагаагүй байна. Өөрөөр хэлбэл, шүгэл үлээгч хэдий хэр хугацаа өнгөрсний дараа ч өөрт нь нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээсэнтэй нь холбогдуулан дарамт шахалт үзүүлсэн гэж гомдол гаргах эрхтэй байна. Иймд энэхүү зохицуулалтад хугацаа зааж өгөх; Төслийн 18.2-т заасан зохицуулалтыг хууль зүйн нэр томьёо ашиглан найруулах бичих;

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ АЖИЛ www.mojha.gov.mn

	Төслийн 19.4-т "...гомдлыг Авлигатай тэмцэх газар хүлээн авснаас хойш ажлын таван өдрийн дотор энэхүү хууль бус үйлдлийн үр дагаврыг арилгах талаар зөвлөмж өгөх ба зөвлөмжийн дагуу тухайн байгууллага, албан тушаалтан дараахь арга хэмжээг даруй авна..." гэж заажээ. Тус зохицуулалтад заасан "... энэхүү хууль бус үйлдлийн үр дагаврыг арилгах" гэснийг өөрчлөн найруулах нь зүйтэй гэж үзэж байна. Учир нь шүгэл үлээгчийн гомдлыг хүлээн аваад тус гомдол гаргасан үйлдлийг шууд хууль бус гэж дүгнэх мэтээр харагдаж байна. Төслийн 19.4-т "...***зөвлөмж өгөх ба зөвлөмжийн*** *дагуу тухайн байгууллага, албан тушаалтан дараахь арга хэмжээг даруй авна"* гэж заажээ. Харин төслийн 19.6-д "...***Шүгэл үлээгчид дарамт, шахалт үзүүлсэн этгээд*** *нь Авлигатай тэмцэх газрын зөвлөмжийг хүлээж авснаас хойш 30 хоногийн дотор энэ хуулийн 19.4-т заасан арга хэмжээг аваагүй тохиолдолд шүгэл үлээгч холбогдох хуулийн дагуу шүүхэд хандаж шийдвэрлүүлнэ"* гэж заажээ. Дээрх хоёр зохицуулалт нь өөр хоорондоо уялдаа холбоо бүхий заалт байх тул 19.6-д заасан зохицуулалтыг 19.5 болгон өөрчилж, байрыг нь солих. Мөн тус зохицуулалтаас "...***Шүгэл үлээгчид дарамт, шахалт үзүүлсэн этгээд..."*** гэсэн хэсгийг хасаж, ***"...Тухайн байгууллага, албан тушаалтан нь..."*** гэж найруулан бичвэл тус зохицуулалтыг илүү ойлгомжтой болгохоор байна. Төслийн 19.7-д *"...Авлигатай тэмцэх газар хоёр жилийн турш тогтмол мониторинг хийнэ..."* гэж заасныг *"...тогтмол хяналт тавин ажиллана..."* гэж өөрчлөх. Төслийн 23 дугаар зүйлийг өөрчлөн найруулах. Учир нь тус зүйл нь " Мөнгөн шагналыг давхардуулан олгохыг хориглох" гэсэн гарчигтай боловч зохицуулалтууд нь мөнгөн шагнал, урамшууллыг давхардуулан олгохыг хориглосон байна. Мөн төслийн 23.2, 23.3-т заасан зохицуулалтууд нь өөр хоорондоо зөрчилтэй[89] төдийгүй хэт нуршуу байдлаар бичигджээ. Тухайлбал, төслийн 23.1-д *"... энэ хуулийн 20, 21 дүгээр зүйлд заасан этгээд энэ хуульд заасантай адил үндэслэлээр бусад хууль тогтоомжийн дагуу мөнгөн шагнал, урамшуулал авахыг хориглоно*" гэж бичих нь зүйтэй. Төслийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн найруулгыг засах.
30.1.4. Хүч оруулсан нэр томьёо хэрэглэхгүй байх;	Төслийн 19.4.2-т "...дутуу олгосон эсхүл огт олгоогүй цалин хөлс, урамшууллыг нөхөн олгох..." гэж заасан. Тус зохицуулалт дахь "... огт олгоогүй..." гэсэн нь "...олгоогүй.." гэдэг үгэнд хүч оруулсан буюу хүч оруулсан нэр томьёог хэрэглэсэн байна. Төслийн 19.7-д "...Авлигатай тэмцэх газар хоёр жилийн турш тогтмол мониторинг хийнэ" гэж заасан. Тус зохицуулалт дахь "... хоёр жилийн турш ..." гэсэн нь ".хоёр жилийн..." гэдэг үгэнд хүч оруулсан нэр томьёог хэрэглэсэн байна. Зүй нь "...хоёр жилийн хугацаанд тогтмол..." гэж бичих.
30.1.5. Жинхэнэ нэрийг ганц тоон дээр хэрэглэх.	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.

3.3. Харилцан уялдаа

Төслийн харилцан уялдаа холбоог шалгах шалгуур үзүүлэлтийн хүрээнд давхардал, хийдэл, зөрчлийг судлан, дотоод болон бусад хуультай уялдах уялдаа холбоог сайжруулах юм. Түүнчлэн хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалд заасан дараах асуудлыг тодорхойлох байдлаар төслийн харилцан уялдаатай байдлыг үнэллээ.

[89] Дэлгэрэнгүйг харилцан уялдаа хэсгийн "Хуулийн төслийн зүйл, заалт нь тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх" хэсгээс үзнэ үү.

Хүснэгт 5. *Харилцан уялдаатай эсэхийг үнэлсэн байдал*

Аргачлалд заасан асуулт	Хуулийн төслийг үнэлсэн байдал
Хуулийн төслийн зохицуулалт нь тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх	Хуулийн төслийн зорилт нь нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгч /илчлэгч/-ийг дэмжих, хамгаалах, урамшуулахтай холбогдсон харилцааг зохицуулах, нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээхэд тавигдах шаардлага, шүгэл үлээх журмыг тодорхойлоход оршино гэж заасан. Хуулийн төслийн нэгдүгээр бүлгийн 5, 6 дугаар зүйлд /шүгэл үлээгчийг дэмжих талаар/, хоёрдугаар бүлгийн 8 дугаар зүйлд /шүгэл үлээхэд тавигдах шаардлагыг, тус бүлгийн 9-12 дугаар зүйлд /шүгэл үлээх журмын талаар/, гуравдугаар бүлэгт /шүгэл үлээгчийг хамгаалах/, дөрөвдүгээр бүлэгт /шүгэл үлээгчид мөнгөн шагнал, урамшуулал, нөхөн төлбөр олгох асуудлыг/ тус тус тусгаснаас харахад төслийн зохицуулалт нь тухайн хуулийн зорилттой нийцсэн байна.
Хуулийн төслийн нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх,	Хуулийн төслийн үзэл баримтлалд “...Авлигын асуудлыг нийтийн ашиг сонирхлоос ангид авч үзэх боломжгүй юм. Иймд нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгч /илчлэгч/-ийн гүйцэтгэх үүрэг, ач холбогдлыг тодорхойлсон холбогдох судалгааны үр дүнг болон энэ талаарх хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгохоор тэр засгийн зүгээс шийдвэрлэж, чиглэлийг тодорхойлсны дагуу Нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгч /илчлэгч/-ийг хамгаалах тухай хуулийн төслийг боловсруулаа” гэжээ. Гэвч хуулийн төслийн нэрнээс харахад “нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгчийг хамгаалах” гэж ойлгогдож байна. Өөрөөр хэлбэл, массын сайн сайхны төлөө шүгэл үлээгчийг хамгаалах мэт ойлгогдож байна. Иймд төслийн нэрийг “Нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээсэн этгээдийг хамгаалах” эсвэл “Шүгэл үлээгч /илчлэгч/-ийг хамгаалах гэж найруулах нь зүйтэй.
Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томьёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томьёотой нийцэж байгаа эсэх	Төслийн Дөрөвдүгээр бүлэг “Шүгэл үлээгчид мөнгөн шагнал, урамшуулал, нөхөн төлбөр олгох” тухай зохицуулалтыг тусгажээ. Ийнхүү тусгахдаа тус төслийн 20 дугаар зүйлд “...Шүгэл үлээгчид мөнгөн шагнал олгох”, 21 дүгээр зүйлд “...Шүгэл үлээгчид урамшуулал олгох”, 22 дугаар зүйлд “...Шүгэл үлээгчид нөхөн төлбөр олгох” тухай тус тус зохицуулжээ. Хуулийн нэр томьёо хэсэгт мөнгөн шагнал, урамшууллыг тодорхойлох нь зүйтэй.
	Мөн төслийн 11.7-д “... олон нийтийн хэвлэл мэдээллийн байгууллагад хандаж болно...” гэж заасныг сайтар нягтлан үзэх нь зүйтэй. Учир нь Монгол Улсын бусад хууль тогтоомж, тухайлбал, Зөрчлийн тухай хууль, Компани тухай хууль, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай гэх мэт хуулиудад *“...олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл...”* гэж заасан байна.
Хуулийн төслийн зүйл, заалт нь тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх	**Төслийн зүйл, заалт нь өөр хоорондоо зөрчилтэй байгаа талаар** Төслийн 23 дугаар зүйл нь “Мөнгөн шагнал давхардуулан олгохыг хориглох” гэж заасан. Гэсэн хэдий ч 23.1, 23. 2, 23. 3 дахь хэсэгт заасан зохицуулалтуудад “... мөнгөн шагнал, урамшуулал...”-ын талаарх зохицуулалтыг агуулсан байна. Өөрөөр хэлбэл, 23 дугаар зүйлийн гарчиг нь зөвхөн мөнгөн шагнал давхардуулан олгохыг хориглоход чиглэсэн мэт харагдаж байгаа боловч тус зүйл дэх зохицуулалтуудын агуулга нь мөнгөн шагнал, урамшуулалтай холбоотой зохицуулалтууд байна. Мөн төслийн 23.1-д “... мөнгөн шагнал, урамшуулал шаардахыг хориглоно” гэж заасан нь зүйлийнхээ гарчигтай уялдахгүй байна. Учир нь “шаардах”, “олгохгүй” байх гэдэг үгнүүд нь өөр хоорондоо агуулгын зөрүүг бий болгож байна. Төслийн 23.1, 23.2, 23.3-т заасан зохицуулалт нь тодорхой хэмжээгээр зүйлийнхээ гарчигтай зөрчилдөж байна.
	Төслийн 23 дугаар зүйлийн зохицуулалтууд өөр хоорондоо зөрчилтэй байна. Энэ талаар үнэлгээний зорилгод хүрэх байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд дэлгэрэнгүй бичигдсэн болно.

Хуульзүй, шинжилгээний үндэсний хүрээлэн www.nlri.gov.mn

	Төслийн зүйл, заалт нь өөр хоорондоо зөрчилтэй байгаа талаар Төслийн 20.1-д *"...Нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээсний үр дүнд захиргааны байгууллагад учирсан хохирлыг буцаан олж авсан уг асуудлаар хууль зүйн үр дагавар бий болсон дараахь нөхцөлд шүгэл үлээгч мөнгөн шагнал авахаар Авлигатай тэмцэх газарт хандаж өргөдөл гаргаж болно"* гэж заасан. Гэтэл төслийн 20.2 дахь хэсэгт заасан зохицуулалтын доорх хүснэгтэд *"...Энэ хуулийн 20.1-д заасан **орлогод** хамаарах үнийн дүн /төгрөгөөр/..."* гэж заажээ. Өөрөөр хэлбэл, төслийн 20.1-д орлогын талаар заагаагүй төслийн 20.2-т заасан хүснэгтэд "...20.1-д заасан орлогод хамаарах..." гэж бичсэн нь учир дутагдалтай байна.
	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуультай зөрчилдөж байгаа талаар Төслийн 16.5-д "..Нийтийн ашиг сонирхлыг зөрчсөн зөрчлийн талаар шүгэл үлээж, мэдээлэл өгсөн тохиолдолд шүгэл үлээгчийн хүсэлтийг үндэслэн шаардлагатай бол Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.2 дугаар зүйлийн 8-д заасны дагуу аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авч болно..." гэж заасан бөгөөд ЗШШтХ-ийн 6.2 дугаар зүйлд "Зөрчлийн талаарх гомдол мэдээлэл хүлээн авах журам"-ыг зааж өгсөн бөгөөд тус зүйлд "***8 дахь хэсэг***" хуульчлагдаагүй буюу 6.2 дугаар зүйлийн 7 дахь хэсгээр энэхүү зохицуулалт дуусаж байна. Өөрөөр хэлбэл, төслийн 16.5-д заасан заалт нь ЗШШтХ-тай уялдаагүй байна.
Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх	Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг хуульд тодорхой тусгасан байна.
Хуулийн төсөлд байх шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх	Төслийн 3 дугаар зүйлд заасан хуулийн нэр томьёоны тайлбар хэсэгт "...Нийтийн ашиг сонирхол", "шүгэл үлээгч", "шүгэл үлээсэн мэдээлэл" гэж юуг ойлгох талаар тайлбарлах
Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх	Хуулийн төслийн 6 болон 11 дүгээр зүйлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан байна.[90]
Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр хураамж тогтоосон эсэх	Хуулийн төсөлд татвар, төлбөр хураамж шинээр тогтоосон зүйлгүй байна.
Тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгаж байгаа эсэх	Хуулийн төсөлд тусгай зөвшөөрөлтэй холбоотой тусгай зохицуулалт тусгаагүй байна.
Хуулийн төслийн зүйл, заалт нь жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх	Хуулийн төслөөр хүйсийн ялгавартай байдал бий болгосон зүйл, заалт байхгүй.
Шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэгдсэн заалт тусгагдсан эсэх	Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэдсэн заалт тусгагдаагүй байна.
Авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэгдсэн заалт тусгагдсан эсэх	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.

[90] Дэлгэрэнгүйг үнэлгээний тайлангийн "зорилгод хүрэх байдал" шалгуур үзүүлэлтийг үнэлсэн хэсгээс үзнэ үү

хуль зүйн ндэсний хүрээлэн www.nli.gov.mn

Хуулийн төсөлд тусгасан хориглосон зохицуулалтыг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх	Хуулийн төсөлд хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлагыг 25 дугаар зүйлийн 25.1-д "...Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ" гэж 25.2-т "...Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ" гэж тус тус заажээ. Өөрөөр хэлбэл, хуулийн тусгасан хориглосон зохицуулалтыг зөрчсөн этгээдэд дээр дурдсан хуулиар хариуцлага хүлээлгэхээр заажээ.

ДӨРӨВ. ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ

4.1. Дүгнэлт

Тус үнэлгээний хүрээнд захиалагч байгууллагаас хуулийн төсөл, үзэл баримтлал, танилцуулга, хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаарх мэдээллийг ирүүлсэн бөгөөд эдгээр мэдээлэлд тулгуурлан судлаачдын зүгээс холбогдох хууль тогтоомж, судалгааны тайлан, гарын авлага зэргийг ашиглан үнэлгээг гүйцэтгэлээ.

Түүнчлэн энэхүү төсөл нь шинээр үүсч байгаа харилцааг зохицуулахаар боловсруулагдсан анхдагч хуулийн төсөл учраас практикт ямар үр дагавар үүсгэх талаар мэдээлэл өгөх боломжгүй тул тухайн хуулийн төсөлд хамаарах этгээдүүдээс санал авч, хуулийн төсөл, түүний зохицуулалтыг нэг мөр ойлгож, хэрэгжүүлэх боломжтой байгаа эсэхийг тодруулах шаардлагагүй гэж үзлээ.

Үнэлгээг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтын дагуу 3 шалгуур үзүүлэлтийн хүрээнд гүйцэтгэсэн болно. Эдгээрийг сонгосон шалгуур үзүүлэлт тус бүрээр дүгнэвэл:

5. *Зорилгод хүрэх байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд:*

Төслийн үзэл баримтлалыг үзвэл гурван зорилт дэвшүүлсэн байх бөгөөд дэвшүүлсэн зорилт бүрийн хүрээнд хамаарах тодорхой зохицуулалтыг сонгон авч үр нөлөөг үнэлсэн. Тодруулбал, (1)Тухайн харилцааны эрх зүйн зохицуулалтыг нарийвчлан шинэ хуулиар зохицуулах шаардлагатай тул анхдагч хуулийн төслийг боловсруулах зорилтын хүрээнд төслийг бүхэлд нь, (2)Нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгч /илчлэгч/-ийг дэмжих чиглэлээр АТГ болон бусад байгууллагын хүлээх үүрэг, хэрэгжүүлэх ажиллагааг тодорхойлох зорилтын хүрээнд Нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгч /илчлэгч/-ийг дэмжих талаар байгууллагын хүлээх үүрэг, Авлигатай тэмцэх газраас шүгэл үлээгчийг дэмжих нэгдсэн арга хэмжээ авахтай холбогдсон зохицуулалтыг, (3) Шүгэл үлээгчийн нийгэмд гүйцэтгэх үүргийг нийтэд зөв ойлгуулах, хүлээн зөвшөөрөх нөхцөл бүрдүүлэх, дэмжих, хамгаалах асуудлыг шийдвэрлэх зорилтын хүрээнд шүгэл үлээгчийн хувийн аюулгүй байдлыг хамгаалах, түүнийг дарамт, шахалтаас хамгаалах, мөнгөн шагналыг давхардуулан олгохгүй байх талаарх зохицуулалтыг тус тус сонгон авч үнэллээ.

- Энэхүү анхдагч хуулийн төслийг боловсруулах нь зүйтэй гэж үзсэн бөгөөд "Тухайн харилцааны эрх зүйн зохицуулалтыг нарийвчлан шинэ хуулиар зохицуулах шаардлагатай тул анхдагч хуулийн төслийг боловсруулах" гэсэн зорилтдоо хүрсэн гэж үзэж болохоор байна.
- Төслийн 5, 6 дугаар зүйлээс харахад шүгэл үлээгчийг дэмжих талаар холбогдох байгууллагууд сургалт, сурталчилгаа зохион байгуулах, тэдэнд урамшуулал, мөнгөн шагнал, нөхөн төлбөр олгох, аюулгүй байдлыг нь хангах арга хэмжээ зохион байгуулах, мөн хууль зүйн болон сэтгэл зүйн зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулах зэрэг олон арга хэмжээний талаар тусгасан нь сайшаалтай төдийгүй эдгээр арга хэмжээг хэрхэн хэрэгжүүлэх талаар холбогдох журмыг байгууллагууд журамлан мөрдүүлэхээр заасан нь төслөөр тавьсан "Нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгч /илчлэгч/-ийг дэмжих чиглэлээр АТГ болон бусад байгууллагын хүлээх

үүрэг, хэрэгжүүлэх ажиллагааг тодорхойлох" гэсэн зорилтдоо хүрсэн гэж үзэж болохоор байна.

- Иймд төслөөр тавьсан "Шүгэл үлээгчийн нийгэмд гүйцэтгэх үүргийг нийтэд зөв ойлгуулах, хүлээн зөвшөөрөх нөхцөл бүрдүүлэх, дэмжих, хамгаалах асуудлыг шийдвэрлэх" гэсэн зорилтдоо хангалтай хүрээгүй гэж үзэж болохоор байна.

Ойлгомжтой байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Төслийн ойлгомжтой байдлыг Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага, мөн Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалыг баримталсан эсэхийг харгалзан үнэлэхэд төслийн зарим зүйл, заалт шаардлагад нийцээгүй болох нь тогтоогдож байна. Үүнд[91]:

- Төсөлд хоёрдмол утга агуулсан, давхардсан, хоорондоо зөрчилдөж ойлгомжгүй байдал үүсгэсэн, зохих хэсэгт тусгаагүй зүйл, заалт;
- Үндсэн хууль болон хүчин төгөлдөр үйлчилж буй бусад хууль тогтоомжтой уялдаагүй зүйл, заалт;
- Хэл зүйн найруулгад тавих нийтлэг шаардлагад нийцээгүй зүйл, заалт тус тус нэлээд байна.

Харилцан уялдаа шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Төслийн үр нөлөөг тооцох аргачлалын дагуу тодруулах шаардлагатай 14 төрлийн асуулгаас 7 төрлийн асуулга шаардлага хангасан, уялдаа холбоотой болсон бөгөөд төсөлд шинээр албан татвар, төлбөр, хураамж тогтоосон зүйлгүй, жендэрийн эрх тэгш байдлыг хангасан, авлига хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгаагүй байна.

Шалгуур үзүүлэлтэд заасан 7 асуулгын хүрээнд хуулийн төслийн зарим зүйл, заалт харилцан уялдаа холбоотой байх шаардлага хангаагүй гэж үзлээ. Үүнд:

- Төслийн зохицуулалт нь тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа хэдий ч зарим анхаарах зүйл байна гэж дүгнэхээр байна. Энэ талаар үнэлгээний тайлангийн 1 дүгээр бүлэгт дэлгэрэнгүй бичигдсэн.
- Хуулийн төслийн нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн хэдий ч найруулгын хувьд засаж, сайжруулах шаардлагатай.
- Нэр томьёоны хувьд бусад хууль болон төсөлд тусгагдсан нэр томьёотой нийцэхгүй байх тохиолдол байна. Тухайлбал, төслийн 11.7-д "... олон нийтийн хэвлэл мэдээллийн байгууллагад хандаж болно..." гэж заасныг сайтар нягтлан үзэх нь зүйтэй. Учир нь Монгол Улсын бусад хууль тогтоомж, тухайлбал, Зөрчлийн тухай хууль, Компани тухай хууль, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай гэх мэт хуулиудад "...олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл..." гэж заасан байна.
- Төсөлд тусгагдсан зүйл, заалт нь тухайн хуулийн төсөлд болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа байдлын хүрээнд хэд хэдэн зөрчилтэй заалтууд илэрсэн. Тухайлбал, төслийн 23 дугаар зүйл нь "Мөнгөн шагнал давхардуулан олгохыг хориглох" гэж заасан. Гэсэн хэдий ч 23.1, 23. 2, 23. 3 дахь хэсэгт заасан зохицуулалтуудад "... мөнгөн шагнал, урамшуулал..."-ын талаарх зохицуулалтыг агуулсан байна. Өөрөөр хэлбэл, 23 дугаар зүйлийн гарчиг нь зөвхөн мөнгөн шагнал давхардуулан олгохыг хориглоход чиглэсэн мэт харагдаж байгаа боловч тус зүйл дэх зохицуулалтуудын

[91] Дэлгэрэнгүйг үнэлгээний тайлангийн "ойлгомжтой байдал" шалгуур үзүүлэлтийг үнэлсэн хэсгээс үзнэ үү.

агуулга нь мөнгөн шагнал, урамшуулалтай холбоотой зохицуулалтууд байна. Мөн төслийн 23.1-д "... мөнгөн шагнал, урамшуулал шаардахыг хориглоно" гэж заасан нь зүйлийнхээ гарчигтай бүрэн уялдахгүй байна. Учир нь "шаардах", "олгохгүй" байх гэдэг үгнүүд нь өөр хоорондоо агуулгын зөрүүг бий болгож байна. Төслийн 23.1, 23.2, 23.3-т заасан зохицуулалт нь тодорхой хэмжээгээр зүйлийнхээ гарчигтай зөрчилдөж байна.

- Хуулийн төсөлд байх шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан байж болзошгүй хэсэгт хэд хэдэн нэр томьёог тайлбарлах шаардлагатай гэж үзсэн.
- Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан гэж үзсэн. Тухайлбал, төслийн 6 болон 11 дүгээр зүйлийн зохицуулалт давхардсан гэж дүгнэлээ.

4.2. Зөвлөмж

Нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгч /илчлэгч/-ийг хамгаалах тухай хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх ажиллагааны үр дүнд гарсан дүгнэлтэд тулгуурлан дараах зөвлөмжийг гаргаж байна. Үүнд:

- Хуулийн нэрийг "Нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээсэн этгээдийг хамгаалах тухай" гэж өөрчлөх;
- Хуулийн нэр томьёоны тайлбар хэсэгт "нийтийн ашиг сонирхол", "шүгэл үлээгч", "шүгэл үлээсэн мэдээлэл", "мөнгөн шагнал", "урамшуулал", "хохироох бодит нөхцөл бүрдсэн" гэж юуг ойлгох талаар тайлбарлах;
- "Шүгэл үлээгчийг дэмжих" зохицуулалтыг тусад нь бүлэг болгон тусгах;
- Төслөөр давхардуулан тусгасан зохицуулалтыг нэг мөр болгох. Тухайлбал, АТГ-ын онцлог хэрэгжүүлэх арга хэмжээг 6 дугаар зүйлээр, бусад байгууллагын нийтлэг хэрэгжүүлэх арга хэмжээг 11 дүгээр зүйлээр зохицуулах;
- Бусад хуулиас иш татсан зохицуулалтыг дахин нягтлах;
- Төслийн 19 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан АТГ-ын зөвлөмжийг биелүүлээгүй бол тус газраас ямар арга хэмжээ авах талаар нарийвчлан тусгах;
- төслийн 19 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг, 23 дугаар зүйлийг бүхэлд нь дахин нягтлах ;
- Төслийн 6.1.7, 17.1.5, 19.4.5-д "... хуульд заасан бусад" гэж зааныг илүү тодорхой болгон аль болох "... хуульд заасан бусад" гэж бичихээс татгалзах;
- Хууль тогтоомжийн тухай хуулийн 29, 30 дугаар зүйл болон Монгол хэлний зөв бичих дүрмийг баримтлан үг үсэг, найруулгын алдааг засах зэрэг болно.

Хуульзүйн нарийн хүрээлэн www.nlrc.gov.mn

НОМ ЗҮЙ

Нэг. Монгол Улсын хууль, олон улсын гэрээ

- Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл (1992), №1
- Авлигын эсрэг хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл (2006), №35
- Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль (2013), №30
- Компанийн тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл (2011), №42
- Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл (2015), №28
- Захиргааны ерөнхий хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл (2015), №28
- Зөрчлийн тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл (2017), №24
- Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл (2017), №23
- Харилцаа холбооны тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл (2001), №43
- Хууль тогтоомжийн тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл (2015), №25
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (2017), №23
- Авлигын эсрэг Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенц, 2003

Хоёр. Судалгааны тайлан, холбогдох эх сурвалж

- Хууль зүйн үндэсний хүрээлэн, Шүгэл үлээгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах судалгаа, 2019
- Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага, Авлигатай тэмцэх гарын авлага, 2018
- *Нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгчийг /илчлэгчийг/ хамгаалах тухай хуулийн төслийн үзэл баримтлал, 2020*
- Нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгч /илчлэгч/-ийг хамгаалах тухай хуулийн төсөл, 2020

Гурав. Цахим эх сурвалж

- Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем, http://www.legalinfo.mn/
- “Шүгэл үлээгч, мэдээлэгчийн эрхийг хамгаалах” хуулийн төслийн талаар зөвлөлдөх уулзалт. http://parliament.mn/n/fxjo

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.ri.gov.mn

“НИЙТИЙН АШИГ СОНИРХЛЫН ТӨЛӨӨ ШҮГЭЛ ҮЛЭЭГЧ /ИЛЧЛЭГЧ/-ИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ” ХУУЛИЙН ТӨСЛИЙН ЗАРДЛЫН ТООЦОО[92]

УДИРТГАЛ

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг Улсын Их Хурлын 2016 оны 51 дүгээр тогтоолоор, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Засгийн газрын 2017 оны 114 дүгээр тогтоолоор тус тус баталсан. Энэхүү төлөвлөгөөнд “Шүгэл үлээгч /мэдээлэгч/-ийг хамгаалах эрх зүйн зохицуулалт бий болгох”-оор тусгасан.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1-д “Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг санаачлах, боловсруулах ажиллагааны үндэслэл, чанарыг сайжруулах, түүнд олон нийтийн оролцоог хангах, хууль тогтоомжийн төсөлд тавих шаардлагыг тодорхойлох, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр нөлөөг үнэлэх замаар хууль дээдлэх ёсыг бэхжүүлнэ” гэж заасан юм.

Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ыг баримтлан Нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгчийг /илчлэгчийг/ хамгаалах тухай хуулийн төсөл дэх зардал, ачааллыг тооцох, зардлыг багасгах санал боловсруулахад энэхүү судалгааны зорилго чиглэнэ.

Энэхүү судалгаагаар хууль тогтоомжийг хэрэгжүүлэх явцад хэдий хэмжээний зардал, ачаалал үүсгэхийг урьдчилан гаргах юм. Уг төсөлд шүгэл үлээснээр иргэнд, хуулийн этгээдэд зардал, ачаалал үүсгэх, үүрэг болгосон заалт тусгаагүй, харин төрийн байгууллагад зардал, ачаалал үүсгэх зохицуулалт туссан байна. Иймд тухайн үүргийг хэрэгжүүлэх төрийн байгууллагад үүсэх зардал, ачааллыг аргачлалын дагуу дараах алхмаар тооцож үзлээ. Үүнд,

1. Төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг,
2. Ажил, үйлчилгээг гүйцэтгэх хүний нөөцийн зардлыг тооцох,
3. Гарах зардлыг урьдчилан тооцоолох,
4. Нийт дүнг тооцон тэдгээрийг бууруулах боломжтой эсэхийг судлан боломжит хувилбарыг дэвшүүлэхийг зорьсон болно.

НЭГ. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ

1.1. Төрийн байгууллагын гүйцэтгэх үүргийг тодорхойлох

Энэ бүлэгт Нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгч /илчлэгч/-ийг хамгаалах тухай хуулийн төслийн /цаашид “төслийн” гэх/ төрийн байгууллагад үүрэг оногдуулсан зарим зохицуулалтууд нь төрд хэдий хэр ачаалал, зардал үүсгэх магадлалтайг баримжаалан тооцоолох юм. Төрийн байгууллагад үүсэх ачаалал, зардлын хэмжээг урьдчилан тооцох нь тухайн зохицуулалтыг хэрэгжүүлэх төсөв, санхүүжилтийн хэмжээ, хэрэгцээ, шаардлагыг тогтоох, мөн хуулийн зохицуулалтын хэрэгжих боломжийг тодорхойлоход нөлөөлөх хүчин зүйлийн нэг юм.

Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь заалт, 6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Гуравдугаар бүлэг, 16 дугаар зүйл, Дөрөвдүгээр бүлэгт заасан хэсгүүдэд төрийн байгууллагад үүсэх зардалтай шууд ба шууд бус хамаарал бүхий зохицуулалт орсон боловч төрд зайлшгүй зардал ачаалал үүсэх үүргийг бий болгосон зохицуулалтыг тодорхойлон, тэдгээрийн хоорондын уялдаа холбоог анхааран үзэж, голлон үүрэг гүйцэтгэх байгууллага, түүнд хамааралтай заалтыг авч үзлээ.

[92] Энэхүү судалгааг АТГ-ын захиалгаар 2020 онд ХЗҮХ-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга П.Амаржаргал удирдан, Эрдэм шинжилгээний ажилтан Э.Уянга, О.Төрболд нар хамтран гүйцэтгэв.

Хүснэгт 1. *Төрийн байгууллагад үүрэг хүлээлгэсэн заалт*

Хуулийн төслийн зүйл, заалт	Зохицуулалт	Хэрэгжүүлэх байгууллага
3 дугаар зүйлийн 3.1.1 дэх заалт, 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.3, 1.6 дахь заалт, Гуравдугаар бүлгийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсэг, 16 дугаар зүйлийн 16.4, 16.5 дахь хэсэг	Шүгэл үлээгчийг хамгаалах	Авлигатай тэмцэх газар
6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.4 дэх заалт, Дөрөвдүгээр бүлгийн 20 дугаар зүйлийн 20.1, 20.2, 20.4, 20.10 дахь хэсэг, 21 дүгээр зүйлийн 21.1, 21.3 дахь хэсэг, 22 дугаар зүйл	Шүгэл үлээгчид мөнгөн шагнал олгох, урамшуулах, нөхөн төлбөр олгох	Авлигатай тэмцэх газар

Дээрх хүснэгтэд дурдсан “шүгэл үлээгчийг хамгаалах” болон “мөнгөн шагнал олгох, урамшуулах, нөхөн төлбөр олгох”-д шаардлагатай зардалд хамаарагдах хүчин зүйлсийг тодорхойлохын зэрэгцээ улсын төсөвт үүсэх зардлыг урьдчилан тооцох болно.

Түүнчлэн хуулийн төсөлд дурдсан бүх байгууллагын зардлыг биш гүйцэтгэх үүрэгт гол ачаалал үүрэх байгууллагыг сонгон[93] авч зардлыг тооцох юм. Гол ачаалал үүрэх байгууллага нь төслийн 6 дугаар зүйлийн 1-д “Авлигатай тэмцэх газар нь нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгчийг дэмжихтэй холбоотой дараах асуудлаар арга хэмжээ авч, удирдамж, зөвлөмж гаргаж ажиллана” гэж заасан байх тул Авлигатай тэмцэх газар нь (*цаашид “АТГ” гэх*) гол үүргийг гүйцэтгэхээр байна.

“Шүгэл үлээгчийг хамгаалах”-д үүсэх зардлыг АТГ-тай холбогдуулан авч үзэх хэдий ч аргачлалын дагуу тус байгууллагын стандарт үйл ажиллагааг нарийвчлан тооцох боломжгүй. Учир нь Хууль зүйн сайдын 2014 оны А/114 дүгээр тушаалд “...хамгаалах байрны байршил, гэрч, хохирогчийн талаарх мэдээллийн нууцлалыг задруулахгүй байх”, “журмыг зөрчсөн албан тушаалтанд хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ” гэж заасан. Иймд, Нийслэлийн Цагдаагийн газар /цаашид “НЦГ” гэх/-ын дэргэдэх “Түр хамгаалах байр” болон ХЭҮТ, ХТЭТ-ийн хамгаалах байранд байрлуулж, хэлтсийн зүгээс шаардлагатай үйлчилгээг үзүүлдэг[94] тул эдгээрээс төслийн 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх хэсэгт заасныг жишиг болгон “хамгаалалтын арга хэмжээ”-ний зардлыг тооцов. Хүний нөөцийн зардал, материаллаг зардлыг авч үзэхдээ холбогдох дүрэм, журамд заасан жишгийг баримталсан болно.

Нөгөө талаас нь авч үзвэл Гуравдугаар бүлгийн 16 дугаар зүйлд “Шүгэл үлээгчийн хувийн аюулгүй байдлыг хамгаалах” тухай заасан хэдий ч 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэгт зааснаас бусад 16.2-16.6 дахь заалтад “болно” гэсэн нь болохгүй ч байж болох хоёрдмол утгыг агуулж буй нь 16 дугаар зүйлийн 16.4, 16.5 дахь хэсэгт заасан аюулгүй байдлыг хамгаалахгүй, зардал үүсгэхгүй ч байж болох юм. Иймд, төслийн 16 дугаар зүйлийн “болно” гэдгийг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт, Засгийн газрын 2010 оны 68 дугаар тогтоолд заасан аргачлалын дагуу ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар томьёолох нь зүйтэй байна.

Хуулийн төслийн Дөрөвдүгээр бүлэгт “Шүгэл үлээгчид мөнгөн шагнал олгох, урамшуулах, нөхөн төлбөр олгох” хэмээн заасан нь төрийн байгууллага, улсын төсөвт шууд утгаар зардал, ачаалал үүсгэсэн гэж үзсэний үндсэн дээр судлан үзвэл, аргачлалын 4.1.1 дэх хэсэгт зааснаар АТГ-т Мөнгөн шагнал олгох зөвлөл байгуулан мөнгөн шагнал олгох тухай хуулийн төслийн Дөрөвдүгээр бүлгийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь заалтад үүрэг хүлээлгэсэн байна. /хавсралт 2/ Мөн “мөнгөн шагнал” олгох тухай заасан нь төрийн байгууллагад зардал, ачааллыг бий

[93] Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлалын гарын авлага. Хууль тогтоомжийн тухай хууль /аргачлал, гарын авлага/, Хууль зүй, дотоод хэргийн яам, GIZ, Уб., 2016 он, 279 дэх тал.

[94] Түр хамгаалах байр http://www.mnb.mn/i/170106 /сүүлд үзсэн 2020.02.04/

болгосон байх боловч хуулийн төслийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэгт заасан орлогод хамаарах үнийн дүнгээс 50 хүртэл хувийг тооцон “мөнгөн шагнал” олгох талаар зохицуулсан нь төрийн байгууллагын орлогод хамаарах үнийн дүнгээс бага хувийг эргүүлэн шагнал болгон олгох тул төсөвт орлого бүрдэх боломжтой гэж үзэж байна.

Гэхдээ төрийн байгууллагад орох орлогыг уг хуулийн төслийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэгт заасан “... захиргааны байгууллагад учирсан хохирлыг буцаан олж авсан...” гэж зааснаар хэрэгжүүлэх боломжгүй юм. Учир нь 1/ нийтийн ашиг сонирхлыг “захиргааны байгууллагад” гэж хязгаарласан, 2/ “учирсан хохирлыг” гэж өнгөрсөн цагт авч үзсэн нь хуулийн зорилгод тодорхойлсон үндсэн үзэл санааг хэрэгжүүлэхэд саад болох төдийгүй Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх хэсэгт заасан “олон нийтийн итгэл” гэснийг, хуулийн төслийн 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх хэсэгт заасан “...хохироох бодит нөхцөл бүрдүүлсэн” гэсэн заалттай зөрчилдөж байх тул хууль хоорондын болон хуулийн төслийн зүйл заалт хоорондын уялдаа холбоог ханган, шүгэл үлээгчийг дэмжсэн хууль бус үйлдэлтэй тэмцсэнээр уг хуулийн төслийн үзэл санаа бүрэн утгаар хэрэгжих төдийгүй төрийн байгууллагад орлого бүрдэх боломжтой болох юм.

Хуулийн төслийн 21 дүгээр зүйлийн 21.3-т заасан урамшууллыг шүгэл үлээгчийн ажиллаж байгаа байгууллагаас гаргах тухай заасан нь үүссэн нөхцөл байдлаас шалгаалан тодорхой тохиолдолд төрийн байгууллагаас зардал гарахгүй байх боломжтой юм.

Хуулийн төслийн 22 дугаар зүйлд заасан нөхөн төлбөрийг авах тухай хүсэлт гаргаж болох тухай заасан хэдий ч хэн, хэзээ, хэрхэн олгох талаар уг хуулийн төсөлд тусгаагүй байх хуулийн хийдэл үүсэж болзошгүй бөгөөд зардал тооцох боломжгүй байна.

1.2. Стандарт үйл ажиллагааг тодорхойлох

Хуулийн төсөлд туссан “шүгэл үлээгчийг хамгаалах” арга хэмжээг хэрэгжүүлэхэд гол үүрэг гүйцэтгэх байгууллага болох Авлигатай тэмцэх газрын гүйцэтгэх үүрэг, стандарт үйл ажиллагааг дараах байдлаар авч үзлээ.

Хүснэгт 2. *Төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг, стандарт үйл ажиллагаа*

Үүргийг хэрэгжүүлэх байгууллага	**Төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил үйлчилгээ**			**Стандарт үйл ажиллагаа**
Авлигатай тэмцэх газар	Шүгэл үлээгчийг хамгаалах /НАСТШҮХтХ 3.1.2 буюу хамгаалалтын арга хэмжээ/	Аюулгүй байдлын хамгаалалт	урьдчилан сануулах	гэмт хэрэг үйлдэхээр заналхийлсэн эсэхийг тогтоох
				тухайн этгээдэд хүлээлгэх ял шийтгэлийн талаар олж мэдэх
				мөрдөгч бичгээр урьдчилан сануулж, гарын үсэг зуруулна
			тодорхой үйлдлийг хязгаарлах	тодорхой үйлдлийг хязгаарлах арга хэмжээ авсан тухай мэдэгдэж гарын үсэг зуруулна
				хяналт тавина
			биечилсэн хамгаалалт	харуул хамгаалалтын бүсэд хэрэгжүүлэхэд томилогдох хүний тоо, хугацааг тогтоох
				хамгаалалтад гарах
			мэдээллийн нууцлалыг хангах	мэдээллийн нууцлалыг хангахтай холбоотой байгууллага, албан тушаалтантай холбогдох бичиг явуулах

Хуулийн зөвлөлдөх нэгж www.jl.gov.mn

			нэг бүрийн тусгай хэрэгсэл болон тусгай техник хэрэгсэл, харилцаа холбооны хэрэгслээр хангах	нэг бүрийн тусгай хэрэгсэл, харилцаа холбооны хэрэгслээр хангах
				биед болон орон байранд тусгай техник хэрэгсэл суурилуулах
			аюулгүй газарт түр байрлуулах	аюулгүй байдал хангагдсан газарт бодит аюул, заналхийлэл арилах хүртэл хугацаанд түр байрлуулах
			нүүлгэн шилжүүлэх	нүүлгэн шилжүүлэхэд түүний болон хамт амьдардаг гэр бүлийн гишүүдийн ажил, сургууль, амьдрах орон байр болон шаардлагатай бусад асуудлыг хамтад нь шийдвэрлэх
			баримт бичгийг солих	иргэний бүртгэл, болон бусад холбогдох баримт бичгийг солиход албан тушаалтанд албан бичиг явуулах
			гадаад төрхийг өөрчлөх	гадаад төрхийг мэс заслын аргаар өөрчлөх
				үс засалт, үс, нүдний өнгийг өөрчлөх
				гэмт хэрэгт холбогдож байсан эсэх талаарх лавлагааг авах
		Сэтгэл зүйн хамгаалалт	шүгэл үлээгчийг хамгаалалтад авсан үеэс эхлэн шаардлагатай тохиолдолд сэтгэл зүйчийг байлцуулах	шүгэл үлээгчийг хамгаалалтад авах
				сэтгэл зүйчийг томилох
				сэтгэл зүйч нь шүгэл үлээгчтэй уулзах
			шүгэл үлээгчийн оролцоотой явагдах мөрдөн шалгах ажиллагааны явцад үүсэх сэтгэл зүйн таагүй нөхцөл байдлын талаар урьдчилан мэдээлэх	мөрдөн шалгах ажиллагаа явуулах
				сэтгэл зүйн таагүй нөхцөл үүсэж буйг тогтоох
				үүссэн нөхцөл байдлыг мэдээлэх
			шүүх хуралдааны хугацаа, дараалал, явц болон нөхцөл байдлын талаар урьдчилан мэдээлэх	олж мэдэх
				мэдээллэх
			шаардлагатай бусад арга хэмжээ	сэтгэл зүйн зөвлөгөө өгөх
		Хамгаалалтын арга хэмжээ	шүгэл үлээгчийг хүлээн авах үйл ажиллагаа	шүгэл үлээгчийг хүлээн авсан тэмдэглэл үйлдэх
				эрсдэлийн түвшинг тодорхойлох
				шүгэл үлээгчийг эрсдэлийн түвшнээс шалтгаалан хамгаалах байр, бусад газарт хүргэж өгөх
				шүгэл үлээгчийг хүлээлгэн өгсөн тэмдэглэл үйлдэх
			хамгаалах байрны үйлчилгээ[95]	ариун цэврийн болон цагаан хэрэглэл олгох
				үйлчилгээний төлөвлөгөөг хамтран боловсруулах
				анхан шатны эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх, (эм бэлдмэлээр хангах)
				хоол, хүнсээр хангах
				номын сангийн үйлчилгээ үзүүлэх
				дэмжих бүлгийн ярилцлагад оруулах
				хууль зүйн анхан шатны зөвлөгөө өгөх
				нотлох бичиг баримт бүрдүүлэх

[95] ХЗДХ сайдын 2017.2.14-ний өдрийн А/39 дүгээр тушаалаар батлагдсан “Хүчирхийлэлд өртсөн хүүхдийг түр хамгаалах журам”-ыг баримжаалав.

Хууль зүйн хүрээлэн www.jus.gov.mn

				бичиг баримттай холбоотой үйлчилгээ[96]
				сэтгэл зүйн анхан шатны зөвлөгөө өгөх
				мэдээ, мэдээллээр хангах
				сургалтад хамруулах

Дээрх АТГ-аас “хамгаалалтын арга хэмжээ” авахад гүйцэтгэх үүрэг, стандарт үйл ажиллагааг хууль, дүрэм журамд зааснаар тодорхойлбол, тус газрын аюулгүй байдлын хамгаалалт, сэтгэл зүйн хамгаалалтыг нэгтгэн анхан шатны туслалцаа үзүүлэх “хамгаалалтын арга хэмжээ”-г явуулахтай холбоотой зардлыг тооцох нь зүйтэй юм.

ХОЁР. АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭГ ГҮЙЦЭТГЭХ ХҮНИЙ НӨӨЦИЙГ ТОДОРХОЙЛОХ

Төсөл дэх төрийн байгууллагад хүлээлгэсэн үүргийг гүйцэтгэхэд шаардагдах ажил, үйлчилгээ тус бүрийг стандарт үйл ажиллагааны загварын дагуу тооцож, хэдий хэмжээний цаг хугацаа зарцуулахыг тогтоох юм. Хугацааг тодорхойлсноор тухайн зохицуулалтыг хэрэгжүүлэх хүний нөөцийн хэрэгцээг тогтоох бөгөөд улмаар улсын төсөвт хүний нөөцтэй холбоотой ямар хэмжээний зардал нэмэгдэхийг урьдчилан тооцох боломжтой.

Хүний нөөцийн хэрэгцээг тооцохдоо тухайн ажил, үйлчилгээг хэрэгжүүлэхэд зарцуулах хугацаа болон 1 жилд гүйцэтгэх тохиолдлын тоогоор баримжаалдаг.

Төрийн байгууллагын үйл ажиллагаа, ачааллын онцлогт тохирсон стандарт үйл ажиллагаа болон түүнд шаардагдах хугацааг нэгдсэн байдлаар тогтоосон зүйлгүй байна. Иймд стандартад тооцох тохиолдлын тоог адил төстэй үйлчилгээ үзүүлдэг ЦЕГ-ын дэргэдэх Гэрч, хохирогчийг хамгаалах төвийн хамгаалалтад авсан иргэдийн сүүлийн 4 жилийн дундаж тоо, АТГ-ын Мөрдөн шалгах хэлтэст иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн гомдол мэдээллийн сүүлийн 4 жилийн дундаж үзүүлэлтээр авч үзсэн.

2015-2018 оны байдлаар АТГ-ын Мөрдөн шалгах хэлтэст иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас **2,370,** үүнээс харьяаллын дагуу шилжүүлсэн **288**, хэрэг бүртгэлийн хэрэг нээсэн **796**, хэрэг бүртгэлийн хэрэг нээхээс татгалзсан **1241** гомдол, мэдээлэл байна.[97]

Хүснэгт 3. *Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтэст иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн гомдол мэдээллийн тоо*

Тохиолдол	2015 он	2016 он	2017 он	2018 он	Жилийн дундаж
Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтэст иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн гомдол мэдээлэл	440	414	658	858	**593**

АТГ-ын Мөрдөн шалгах хэлтэст иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн гомдол мэдээллийн дөрвөн жилийн дундаж үзүүлэлт нь 593 байна. Нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээх /илчлэх/ нь зөвхөн авлигатай холбоотой асуудлаар хязгаарлагдахгүй хэдий ч нийтийн ашиг сонирхолтой холбоотой мэдээлсэн иргэдийн нэгдсэн мэдээлэл, тоо бүртгэл байхгүйгээс шүгэл үлээгчийн тоог бодитой гаргах боломжгүй, мөн байгууллага доторх шүгэл үлээгчийн мэдээлэл тодорхойгүй байна. Иймд АТГ-ын Мөрдөн шалгах хэлтэст иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн гомдол мэдээллийн тоог баримжаалан хамгаалалтад авах боломжтой иргэдийн тоог гаргавал илүү ойролцоо утгаар гарч болох юм.

[96] Бүртгэлийн гэрчилгээ олгохоос эхлээд улсын бүртгэлийн дэлгэрэнгүй лавлагаа авах хүртэлх үйлчилгээ багтах юм.

[97] Авлигатай тэмцэх газар, Авлигтай тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилт, авлигын ерөнхий нөхцөл байдал-2018, авлигтай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт (2016-2018), 72 дахь тал.

хуулийн мэдээллийн хүрээлэн www.mli.gov.mn

Учир нь ажил үйлчилгээг гүйцэтгэхэд зарцуулах хугацааг тодорхойлохдоо бусад төрийн байгууллагад адил төстэй үйлчилгээ байгаа эсэх талаар судалж байгаа тохиолдолд тухайн байгууллагын үйл ажиллагааг нарийвчлан авч үзэж зарцуулах хугацааг тодорхойлох шаардлагатай. Төслийн Гуравдугаар бүлгийн "Шүгэл үлээгчийг хамгаалах" хэмээх үүрэгтэй төстэй үүрэг хэрэгжүүлдэг ЦЕГ-ын дэргэдэх Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтсийн өдөр тутам хийгддэг ажиллагаа, хамгаалалтад авсан иргэдийн тоог авч үзье:

Хүснэгт 4. *Хамгаалалтад авсан иргэдийн тохиолдлын тоо*[98]

Тохиолдол	2015 он	2016 он	2017 он	2018 он	Жилийн дундаж
Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасны дагуу хамгаалалтад авсан иргэдийн тоо	85	42	36	65	**57**

ЦЕГ-ын дэргэдэх Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтэст хамгаалалтад авсан иргэдийн жилийн дундаж нь 57 иргэн байх ажээ.

2.1. Зарцуулах хугацааг тодорхойлох

Тагнуулын ерөнхий газар гэрч, хохирогчийг хамгаалах үйл ажиллагаа явагддаг эсэх нь тодорхойгүй, нууц байх тул 57 гэсэн тоогоор тохиолдлын тоог тооцох нь хангалтгүй төдийгүй нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгчийг хамгаалах тухай хуулийн зорилгод заасныг хэрэгжүүлбэл ирээдүйд хамгаалалтад авах иргэдийн тоо, зардал ачаалал нэмэгдэх нь зайлшгүй тул хамгаалалтад авагдсан иргэдээс гадна АТГ-ын мөрдөн шалгах хэлтэст иргэн, аж ахуй нэгж байгууллагаас ирүүлсэн гомдол мэдээллийн тоог тохиолдлын тоо болгон авч үзэн хоёр янзаар хүний нөөцийн хэрэгцээг тодорхойллоо.

2.1.1. Хамгаалалтад авсан иргэдийн тохиолдлын тоотой холбогдон гарах анхан шатны үйлчилгээ үзүүлэх хүний нөөцийн хэрэгцээ

Хүснэгт 5. *"Хамгаалалтын арга хэмжээ" авахад шаардлагатай стандарт үйл ажиллагаа, зарцуулах хугацаа*[99]

Төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа /мин/	Тохиолдлын тоо	Хүний нөөцийн хэрэгцээ /мин/
"Хамгаалалтын арга хэмжээ"	Шүгэл үлээгчийг хүлээн авах, тэмдэглэл үйлдэх	10	57	570
	Эрсдэлийн түвшинг тодорхойлох	15	57	855
	Хамгаалах байранд хүргэж өгөх	45[99]	57	2736
	Хүлээлгэн өгсөн тухай тэмдэглэл үйлдэх	10	57	570
	Ариун цэврийн болон цагаан хэрэглэл олгох	10	57	570
	Үйлчилгээний төлөвлөгөөг хамтран боловсруулах	15	57	855
	Анхан шатны эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх, эм бэлдмэлээр хангах	20	57	1140
	Хоол, хүнсээр хангах	20	57	1140
	Номын сангийн үйлчилгээ үзүүлэх	30	57	1710
	Дэмжих бүлгийн ярилцлагад оруулах	30	57	1710
	Хууль зүйн анхан шатны зөвлөгөө өгөх	45	57	2565
	Нотлох бичиг баримт бүрдүүлэх	25	57	1425

[98] Хамгаалалтад авсан иргэдийн тохиолдлын тоог ЦЕГ-ын дэргэдэх Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтсийн буюу нэг байгууллагын хэмжээнд авсан.

[99] Нэг байршлаас нөгөө байршил руу ирэх, очих хугацаа, замын хөдөлгөөний нягтаршил зэргийг харгалзан дээд хугацаагаар тооцов.

Хууль зүйн үндэсний хүрээлэн www.nli.gov.mn

	Сэтгэл зүйн анхан шатны зөвлөгөө өгөх	45[100]	57	2565
	Мэдээ, мэдээллээр хангах	15	57	855
	Сургалтад хамруулах	120	57	6840
	Нийт	**455**	57	**26,106**

Дээрх хүснэгтээс үзвэл анхан шатны туслалцаа “хамгаалалтын арга хэмжээ” үзүүлэхэд жилд дунджаар 26,106 минут буюу 435 ажлын цаг шаардагдахаар байна. Нэг албан хаагч 200 ажлын өдөр буюу 1600 цаг ажилладаг гэвэл 435 ажлыг цаг: 1600 цаг[101] = 0.27 хүний нөөцийн хэрэгцээ шаардлагатай байна.

Иймд АТГ-ын Мөрдөн шалгах хэлтэст иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн гомдол мэдээллийн тоог тохиолдлын тоо болгон авч хүний нөөцийн хэрэгцээг дараах байдлаар тодорхойлж үзлээ.

2.1.2. Хохирогч иргэдийн тоотой холбогдон гарах анхан шатны үйлчилгээ үзүүлэх хүний нөөцийн хэрэгцээ

Хүснэгт 6. *“Хамгаалалтын арга хэмжээ” авахад шаардлагатай стандарт үйл ажиллагаа, зарцуулах хугацаа*

Гүйцэтгэх үүрэг	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа /мин/	Тохиолдлын тоо	Хүний нөөцийн хэрэгцээ /мин/
“Хамгаалалтын арга хэмжээ”	Шүгэл үлээгчийг хүлээн авах, тэмдэглэл үйлдэх	10	593	5930
	Эрсдэлийн түвшинг тодорхойлох	15	593	8895
	Хамгаалах байранд хүргэж өгөх	45	593	26685
	Хүлээлгэн өгсөн тухай тэмдэглэл үйлдэх	10	593	5930
	Ариун цэврийн болон цагаан хэрэглэл олгох	10	593	5930
	Үйлчилгээний төлөвлөгөөг хамтран боловсруулах	15	593	8895
	Анхан шатны эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх, эм бэлдмэлээр хангах	20	593	11860
	Хоол, хүнсээр хангах	20	593	11860
	Номын сангийн үйлчилгээ үзүүлэх	30	593	17790
	Дэмжих бүлгийн ярилцлагад оруулах	30	593	17790
	Хууль зүйн анхан шатны зөвлөгөө өгөх	45	593	26685
	Нотлох бичиг баримт бүрдүүлэх	25	593	14825
	Сэтгэл зүйн анхан шатны зөвлөгөө өгөх	45	593	26685
	Мэдээ, мэдээллээр хангах	15	593	8895
	Сургалтад хамруулах	120	593	71160
	Нийт	**455**	593	**269,815**

АТГ-ын Мөрдөн шалгах хэлтэст иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн гомдол мэдээллийн тоогоор “хамгаалалтын арга хэмжээ” авахад шаардлагатай анхан шатны туслалцаа үзүүлэх хүний нөөцийн хэрэгцээг тооцож үзвэл жилд дунджаар 269,815 минут буюу 4,497 ажлын цаг шаардагдахаар байна. Нэг албан хаагч 200 ажлын өдөр буюу 1600 цаг ажилладаг гэвэл 4,497 ажлын цаг: 1600 цаг = 2.8 хүний нөөцийн хэрэгцээ шаардлагатай болно.

[100] Энэ нь анхан шатны зөвлөгөө өгөх хугацаа бөгөөд сэтгэл заслын эмчилгээ 2 жил хүртэл хугацаагаар үргэлжилдэг байна.

[101] Нийт зарцуулах хугацаагаар хүний нөөцийн хэрэгцээ тодорхойлогдох ба тэрхүү хугацааг жилд ажиллах ажлын цагт хуваасаар шаардлагатай хүний нөөцийн хэрэгцээ буюу нэмэгдэх ажлын байрны тоо гарна.

Хууль зүйн дотоодын хүрээлэн www.mli.gov.mn

ГУРАВ. ГАРАХ ЗАРДЛЫГ УРЬДЧИЛАН ТООЦООЛОХ

Төрийн байгууллагад буюу төрөөс гарах зардлыг урьдчилан тооцох үе шатанд:

- Хүний нөөцийн зардал *(*төрийн албан хаагчтай холбоотой шууд болон шууд бусаар үүсэх зардал*)*
- Материаллаг зардал *(*төрийн албан хаагчийн ажлын байртай холбогдон гарах нийтлэг зардал*)*
- Бусад зардал *(*тухайн ажил үйлчилгээг гүйцэтгэхэд дагалдан гарах зардал*)*-ыг тус тус тооцож гаргана.

3.1. Хүний нөөцийн зардал

Хүний нөөцийн зардлыг тооцохдоо тухайн ажил, үйлчилгээ буюу үүргийг гүйцэтгэх төрийн байгууллагын албан хаагчид зарцуулах цалин хөлс, нэмэгдэл, урамшуулал зэрэг төрөөс даадаг бүх зардлыг нэгтгэн авч үзэх ба эдгээрийн дундаж хэмжээгээр тооцож тогтоодог.

ЦЕГ-ын дэргэдэх Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтэс нь нийт 30 албан хаагчтай чиг үүргээ хэрэгжүүлдэг бөгөөд Төрийн тусгай албан хаагчийн ТТ-7 – ТТ-15 болон Төрийн үйлчилгээний албан хаагчийн ТҮ-1 зэрэглэлээр цалинждаг[102] байна.

Хүснэгт 7. *Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтсийн албан тушаал, цол, цалингийн зэрэглэл, орон тоо*

Д/д	Албан тушаал	Цолны зэрэглэл	Цалингийн зэрэглэл	Орон тоо
1	Хэлтсийн дарга	Цагдаагийн хурандаа	ТТ – 15	1
2	Тасгийн дарга	Цагдаагийн дэд хурандаа	ТТ – 13	2
3	Ахлах мэргэжилтэн	Цагдаагийн хошууч	ТТ – 12	1
4	Эрүүгийн ахлах мөрдөгч	Цагдаагийн хошууч	ТТ – 12	4
5	Эрүүгийн мөрдөгч	Цагдаагийн ахмад	ТТ – 11	12
6	Мэргэжилтэн	Цагдаагийн ахмад	ТТ – 10	1
7	Мэдээлэл, холбоо, сүлжээний инженер	Цагдаагийн ахмад	ТТ – 10	1
8	Сэтгэл зүйч	Цагдаагийн ахмад	ТТ – 10	2
9	Бичиг хэргийн эрхлэгч, архивч	Цагдаагийн ахлах ахлагч	ТТ – 7	1
10	Цагдаа – жолооч	Цагдаагийн ахлах ахлагч	ТТ – 7	3
11	Үйлчлэгч	Энгийн	ТҮ – 1	1

Дээр дурдсан албан хаагчдын цалингийн хэмжээг тооцохдоо Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”[103] 472 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтыг үндэслэн 1 хүний дундаж цалингийн үнэлгээг гаргав. Ингэхдээ тухайн ажил, үүргийг гүйцэтгэдэг буюу “хамгаалалтын арга хэмжээ” авахад хэрэгжүүлэх тус хэлтсийн Аюулгүй байдал, хамгаалалтын тасгийн албан хаагчдын цалингийн хэмжээг авч үзлээ.

Хүснэгт 8. *Албан тушаалын зэрэглэл, цалингийн хэмжээ*

Албан тушаалын зэрэглэл	1	2	3	4	5	Дундаж цалин
ТТ – 12	719990	770718	819842	865643	912829	**817,804₮**
ТТ - 11	692493	740806	787589	831210	876151	**785,649₮**

[102] Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн А/136 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт “Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтсийн албан тушаал, орон тоо, цол, цалингийн зэрэглэл”.

[103] Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 472 дугаар тогтоол “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай” https://www.legalinfo.mn/law/details/14892, (сүүлд үзсэн 2020.02.01).

хүний эрхийн үндэсний хороо www.nhrc.gov.mn

ТТ - 10	666304	712316	756873	798418	841216	**755,025₮**
ТТ - 7	594989	634796	673225	709113	776260	**677,676₮**

Аюулгүй байдал, хамгаалалтын тасгийн нэг албан хаагчид зарцуулах, төрөөс даах зардлыг тооцохдоо түүнд олгох үндсэн цалингаас гадна (1) бүх төрлийн даатгал, (2) хоол, унааны нэмэгдэл, (3) ажилласан жилийн нэмэгдэл, (4) зэрэг дэвийн нэмэгдэл, (5) буцалтгүй тусламж, (6) шагнал, урамшуулал зэрэг нэмэлт зардлыг нэмж тооцох шаардлагатай байдаг.

Эдгээрийн хэмжээг тодорхой тогтоох боломжгүй тохиолдолд нэг албан хаагчийн цалингийн дундаж хэмжээний 30%-иар[104] нэмэгдэл, урамшууллын зардлыг тооцож, нийтлэг болон дагалдах зардал болоод хүний нөөцийн нийт дундаж зардлыг дараагийн хүснэгтүүдээр тооцох болно. Ингэхдээ Хүснэгт 8-ын хүрээнд авсан цалингийн зэрэглэл тус бүрээр нэг албан хаагчид ногдох нэмэгдлийн мөнгөн дүнг тооцоолъё.

Хүснэгт 9. *Нэг албан хаагчид ногдох цалингийн зардал*
/ТТ – 12 зэрэглэлийн дагуу/

Зардлын нэр	Цалингийн дундаж хэмжээ	Хувь	Хэмжээ /төгрөг/
Үндсэн цалингийн дундаж хэмжээ	817,804₮		817,804₮
Нэмэгдэл, урамшууллын зардал	817,804₮	30%	245,341₮
Нийт			**1,063,145₮**

Хүснэгт 10. *Нэг албан хаагчид ногдох цалингийн зардал*
/ТТ – 11 зэрэглэлийн дагуу/

Зардлын нэр	Цалингийн дундаж хэмжээ	Хувь	Хэмжээ /төгрөг/
Үндсэн цалингийн дундаж хэмжээ	785,649₮		785,649₮
Нэмэгдэл, урамшууллын зардал	785,649₮	30%	235,694₮
Нийт			**1,021,343₮**

Хүснэгт 11. *Нэг албан хаагчид ногдох цалингийн зардал*
/ТТ – 10 зэрэглэлийн дагуу/

Зардлын нэр	Цалингийн дундаж хэмжээ	Хувь	Хэмжээ /төгрөг/
Үндсэн цалингийн дундаж хэмжээ	755,025₮		755,025₮
Нэмэгдэл, урамшууллын зардал	755,025₮	30%	226,507₮
Нийт			**981,532₮**

Хүснэгт 12. *Нэг албан хаагчид ногдох цалингийн зардал*
/ТТ – 7 зэрэглэлийн дагуу/

Зардлын нэр	Цалингийн дундаж хэмжээ	Хувь	Хэмжээ /төгрөг/
Үндсэн цалингийн дундаж хэмжээ	677,676₮		677,676₮
Нэмэгдэл, урамшууллын зардал	677,676₮	30%	203,302₮
Нийт			**880,978₮**

Хуулийн үнэсний хүрээлэн www.rli.gov.mn

[104] Хууль тогтоомжийн тухай хууль /аргачлал, гарын авлага/, Хууль зүй, дотоод хэргийн яам, GIZ, Уб., 2016 он, 286 дахь тал.

Хүснэгт 13. *Хүний нөөцийн дундаж зардал /1 жилээр[105]/*

Цалингийн зэрэглэл	Үндсэн цалин	Нэмэгдэл /30%/	Хоол, унаа/өдөр	Хоол ,унааны мөнгөн дүн	1 сарын цалин	12 сарын цалин	НДШ	Нийт /төгрөгөөр/
ТТ – 12	817,804	245,341	5000	110,000	1,063,145	12,757,740	1,403,351	14,161,091
ТТ – 11	785,649	235,694	5000	110,000	1,021,343	12,256,116	1,348,173	13,604,289
ТТ – 10	755,025	226,507	5000	110,000	981,532	11,778,384	1,295,622	13,074,006
ТТ – 7	677,676	203,302	5000	110,000	880,978	10,571,736	1,162,890	11,734,626
Нийт дундаж зардал								**13,143,503₮**

Ийнхүү дээрх хүснэгтүүдээс үзвэл нэг албан хаагчид зэрэглэлээсээ хамаарч тодорхой хэмжээний ялгаатай зардал үүсэж буй бөгөөд хүний нөөцийн зардлын дундаж нь 1 албан хаагч 1 жилд 13,143,503 /арван гурван сая нэг зуун дөчин гурван мянга таван зуун гурав/ төгрөг авах юм.

3.2. Материаллаг зардал

Материаллаг зардал гэдэгт тухайн ажлын байртай холбоотой нийтлэг зардал буюу тухайн үүргийг гүйцэтгэж буй албан хаагчийг ажиллах нөхцөлөөр хангахад зарцуулж буй зардлыг хамааруулдаг. Тухайлбал, ажлын байр, эд хөрөнгө, техник хэрэгсэл, тэдгээрийн элэгдэл хорогдол, бусад ахуйн зардлыг тооцох шаардлагатай.

Тус зардлыг тооцохдоо “Хууль, хуулийн төслийн үр нөлөөг тооцох аргачлал”[106]-д үзүүлсэн Хууль зүй, дотоод хэргийн яамны нэг ажилтанд зарцуулагдах материаллаг зардлыг[107] ашиглалаа.

[105] Хууль тогтоомжийн тухай хууль /аргачлал, гарын авлага/, Хууль зүй, дотоод хэргийн яам, GIZ, Уб., 2016 он, 286 дахь тал.

[106] Хууль, хуулийн төслийн үр нөлөөг тооцох аргачлал, Хууль зүй, дотоод хэргийн яам, GIZ, Уб., 2012 он, 97 дахь тал.

[107] Гэвч тэрхүү материаллаг зардлын мөнгөн дүн нь 2012 оны тоон мэдээлэл болох тул агуулгыг удирдлага болгон “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлалын гарын авлага”-ын дагуу үнийн дүнг авч тооцов. Тус хавсралтын зарим агуулгыг мөн хүснэгтэд нэмсэн болно. (Хууль тогтоомжийн тухай хууль /аргачлал, гарын авлага/, Хууль зүй, дотоод хэргийн яам, GIZ, Уб., 2016 он, 287 дахь талаас үзнэ үү.)

Хуулийн нэгдсэн хөтөлбөр www.jli.gov.mn

Хүснэгт 14. *Нэг албан хаагчид гарах материаллаг зардал /1 жилээр/*

Зардлын нэр		Зардлын төрөл	Хэмжээ /төгрөг/
Урсгал зардал	Хангамж, бараа материалын зардал	Бичиг хэрэг	640,000₮
		Ном, хэвлэл	1,625,000₮
		Шуудан холбоо	306,812₮
		Гэрэл, цахилгаан, сантехник, бусад эд хогшлын холбогдолтой сэлбэг хэрэгсэл, гэрлийн шил, залгуур зэрэг[108]	1,800,000₮
		Цэвэрлэгээний материал[109]	960,000₮
		Нийт	**7,331,812₮**
	Байр, өрөө тасалгааны ашиглалттай холбоотой зардал	Түлш, халаалт	263,408₮
		Гэрэл, цахилгаан	128,239₮
		Цэвэр, бохир ус	599,438₮
		Урсгал засвар	127,752₮
		Нийт	**1,118,837₮**
	Урсгал засвар	Компьютер, тоног төхөөрөмжийн засвар	456,000₮
		Автомашины засвар үйлчилгээ, тос масло[110]	2,000,000₮
		Нийт	**2,456,000₮**
	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	Автотээврийн хэрэгслийн татвар	185,000₮
		Автотээврийн утааны татвар	3500₮
		Газрын төлбөр	22,253₮
		Нийт	**210,753₮**
	Элэгдэл, хорогдлын зардал[111]	Техник, тоног төхөөрөмж[112]	160,000₮
		Тавилга, эд хогшил[113]	100,000₮
		Барилга, байгууламж[114]	65,670₮
		Нийт	**325,670₮**

Эдгээр зардлууд нийлээд “ажлын байрны ердийн дундаж материаллаг зардал”-ыг бүрдүүлнэ.

Хүснэгт 15. *Ажлын байрны нийт дундаж материаллаг зардал /1 жилээр/*

Ажлын байрны дундаж материаллаг зардал = 11,443,072₮
Хангамж, бараа материалын зардал /7,331,812₮/ + Байр, өрөө тасалгааны ашиглалттай холбоотой зардал /1,118,837₮/ + Урсгал засвар /2,456,000₮/ + Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж /210,753₮/ + Элэгдэл хорогдлын зардал /325,670₮/

Дээрхээс үзвэл нэг албан хаагчид гарах материаллаг зардал нь жилд 11,443,072 /арван нэгэн сая дөрвөн зуун дөчин гурван мянга далан хоёр/ төгрөг байна.

[108] Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс.

[109] Хог хаягдал зайлуулах, устгал, ариутгалд хамаарах бөгөөд хангамж, бараа материалын зардлын нэг хэсэг болдог байна.

[110] Нэг ширхэг автомашинд ногдох зардал.

[111] МУЗГ-ын 2005 оны 233 дугаар тогтоол “Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох журам, Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцоход баримтлах хугацаа, жилд байгуулах элэгдлийн хэмжээ”.

[112] Мөн тэнд – Хоёрдугаар хавсралт, Үнийг дунджаар 800,000₮ гэж тооцоход 20% нь элэгдэл, хорогдол буюу 160,000₮ болно.

[113] Мөн тэнд – Хоёрдугаар хавсралт, Эд хогшил болох ширээ, сандал, шүүгээ, утасны аппаратын үнийг дунджаар 1,000,000₮ гэж тооцоход 10% нь элэгдэл хорогдол буюу 100,000₮ болно.

[114] ЗГ-ын 2002 оны 120 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Төрийн албан хаагчийн албан ажлын унаа, өрөөний талбайн хэмжээ, тавилга, хэрэгслийн нийтлэг жишиг”–т заасны дагуу нэг дэс түшмэлд ногдох ажлын өрөөний талбай 8м2 талбай байна. Үүнээс 2,300,000,000₮ 4483м2 = 513,049.29₮ нь 1м2 талбайн өртөг бөгөөд 8м2 талбайн өртөг нь 4,104,394.37₮ болно. Нэг албан хаагчид оногдох талбайн өртөг 4,104,394.37₮ гэж тооцоход 1,6% нь элэгдэл хорогдол буюу 65,670₮ болно.

Хүний эрхийн үндэсний комисс www.nhrc.mn

3.3. Бусад зардал

Бусад зардалд тухайн ажил, үүргийг гүйцэтгэхэд дагалдан гарах зардлыг авч үздэг. Төсөлтэй холбогдуулан дараах төрлийн бусад зардал гарахаар байна. Үүнд,

1. "Хамгаалалтын арга хэмжээ" авахад шаардагдах бусад зардлын хүрээнд нэг үйлчлүүлэгчид ногдох нэг удаагийн нийт зардлыг тооцох шаардлагатай бөгөөд Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын 2018 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн А/80 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх үйлчилгээнд хамрагдах иргэний тоо, шаардагдах хөрөнгийн хэмжээг тодорхойлох аргачлал"[115]-ыг баримжаалан шаардлагатай дүнг авч үзлээ.

Хүснэгт 16. *Түр хамгаалах байранд байрлах нэг үйлчлүүлэгчид ногдох нэг хоногийн зардал*

№	Зардлын төрөл	Хэмжээ /төгрөг/
1	Байр	2000₮
2	Хоол, цай	4000₮
3	Ариун цэвэр	600₮
4	Эрүүл мэндийн үйлчилгээ	2000₮
5	Нийгмийн ажлын үйлчилгээ	1000₮
6	Сэтгэл зүйн үйлчилгээ	2000₮
7	Аюулгүй байдлын үйлчилгээ	2000₮
10	Хууль зүйн зөвлөгөө	3000₮
11	Цэвэрлэгээ, үйлчилгээ[116]	2,550
Нийт		**19,150₮**

Хүснэгт 17. *Сургалтад хамрагдах нэг суралцагч (үйлчлүүлэгч)-д ногдох зардлын дээд хэмжээ*

№	Зардлын төрөл	Ажлын 5 өдөр	Ажлын 10 өдөр
1	Бичиг хэрэг	2000₮	2000₮
2	Тараах материал, гарын авлага	2000₮	4000₮
3	Цайны зардал	3000₮	6000₮
4	Хоол, унааны мөнгө	8500₮	17,000₮
5	Дадлагын материал	3000₮	6000₮
Нийт		**18,500₮**	**35,000₮**

Хүснэгт 18. *Бусад зардлын нийт хэмжээ*

Зардлын төрөл	Зардлын хэмжээ
Түр хамгаалах байр /90 хоног/[117]	1,723,500₮
Бичиг баримттай холбоотой үйлчилгээ /1 хүн/[118]	79,600₮

[115] Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын 2018 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн А/80 дугаар тушаалын хавсралт, http://hudulmur-halamj.gov.mn/uploads/document/5f826e04bbd963714254f01897cd357f2e6cb642.pdf (сүүлд үзсэн 2020.02.01).

[116] Мөн тэнд. Түр хамгаалах байрны 1 хоногийн зардалд "Цалин, шимтгэл" гэдгийг нэгтгэн "цэвэрлэгээ, үйлчилгээний хөлс" гэж өөрчлөсөн ба нийт үнийн дүнд өөрчлөлт ороогүй болно. /ажилтны цалин хөлсийг хүний нөөцийн зардалд тооцсон тул энд давхардуулан тооцох шаардлагагүй гэж үзлээ./

[117] "Хохирогчийг хамгаалах байрны үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага" MNS 6040:2009 Монгол Улсын стандартад зааснаар "Түр хамгаалах байр" гэж хохирогчийг хүлээн авснаас эхлэн 1 долоо хоногоос 3 сар хүртэлх хугацаанд тусламж, үйлчилгээ үзүүлэх газрыг хэлэх бөгөөд нийт зардлыг тооцохдоо дээд хугацаа болох 3 сар буюу 90 хоногийн хугацаагаар тооцов. Ингэхдээ Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын 2018 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн А/80 дугаар тушаалын хавсралтаар баталсан нэг хоногийн зардлыг 90 хоногоор үржүүлэн нийт дүнг гаргасан.

[118] А/80 дугаар тушаалын хавсралтад бичиг баримттай холбоотой үйлчилгээний зардлыг тусгаснаас нийт дүнг авав.

Хуулийн үнэсний хүрээлэн www.nli.gov.mn

Сургалтад хамруулах /Ажлын 10 өдөр/	35,000₮
Эмчийн үзлэг, бариа засал, эм тариа[119]	42,000₮
Нийт	**1,880,100₮**

Дээрхээс үзвэл "хамгаалалтын арга хэмжээ" авахад шаардагдах бусад зардал буюу нэг үйлчлүүлэгчид ногдох нэг удаагийн нийт зардлын дээд хэмжээ 1,880,100₮ /нэг сая найман зуун наян мянга нэг зуу/ гэж тооцлоо.

ДӨРӨВ. ЗАРДЛЫГ НЭГТГЭН ТООЦОХ ҮЕ ШАТ

Энэ үе шатанд улсын төсвөөс гарах нийт зардлыг тооцож гаргах бөгөөд өмнөх үе шатанд тооцсон хүний нөөц, материаллаг зардал болон бусад зардлын нийлбэрийг хүний нөөцийн хэрэгцээнд үржүүлснээр нийт зардал гарна.

Хүний нөөцийн хэрэгцээг тооцож гаргахдаа тохиолдлын тоог хоёр төрлөөр тооцсон тул зардлыг нэгтгэн тооцохдоо мөн хоёр төрлөөр гаргах шаардлагатай юм.

а/ Хамгаалалтад авсан иргэдийн тоотой холбогдон гарах нийт зардал

Хүснэгт 17. *Нийт зардал*

(**13,143,503₮** /хүний нөөцийн зардал/ + **11,443,072₮** /материаллаг зардал/ + **1,880,100₮** /бусад зардал/) x 0.27 /хүний нөөцийн хэрэгцээ/ = **7,146,002.25₮**

ЦЕГ-ын дэргэдэх Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтсийн хамгаалах арга хэмжээ авсан иргэдийн тоогоор гарах зардлыг тооцоолоход **7,146,002.25₮** /долоон сая нэг зуун дөчин зургаан мянга хоёр төгрөг хорин таван мөнгө/-ийн зардал гарахаар байна.

Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын зохицуулалтын дагуу төр, хувийн салбарт ажиллагч, олон нийтийн төлөөлөл, гэрч, хохирогч, шинжээч нь шүгэлдэгч байж болох тухай заасан хэдий ч эдгээртэй холбоотой ирүүлсэн мэдээллийн нэгдсэн тоо бүртгэл Монгол Улсын хэмжээнд хийгдэггүй байна байна.

Гэрч, хохирогч нь шүгэл үлээгчийн зөвхөн нэг хэсэг байх тул дээрх тоог нэмэгдүүлэн тооцох үүднээс АТГ-ын Мөрдөн шалгах хэлтэст иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлж байгаа гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээллийн тоогоор /Хүснэгт 18/ гарах зардлыг тооцож үзлээ.

б/ АТГ-ын Мөрдөн шалгах хэлтэст иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлж байгаа гэмт хэргийн шинжтэй гомдол тоогоор тооцоолсон нийт зардал

Хүснэгт 18. *Нийт зардал*

(13,143,503₮ /хүний нөөцийн зардал/ + **11,443,072₮** /материаллаг зардал/ + **1,880,100₮** /бусад зардал/**)** x **2.8** /хүний нөөцийн хэрэгцээ/ **= 74,106,690₮**

Хүснэгтээс үзвэл АТГ-ын Мөрдөн шалгах хэлтэст иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлж байгаа гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээллийн тоогоор гарах зардлын хэмжээг тооцоолоход 74,106,690₮ /далан дөрвөн сая нэг зуун зургаан мянга зургаан зуун ерэн төгрөг/-ийн зардал гарах юм.

4.1. Хувилбарыг нягталж, үр дүнг танилцуулах

Энэ үе шатанд хуулийн төсөлд шинээр нэмэгдэж байгаа буюу өөрчлөгдөж буй зохицуулалттай холбоотой төрд үүсэх зардлыг багасгах, эдийн засагт дарамт багатай өөр хувилбар, боломж байгаа эсэхийг шалгадаг. Ингэхдээ дараах хувилбар, боломжуудыг дэвшүүлэн шалгаж үзье. Үүнд:

- Төсвийн зардлыг багасгах боломж байгаа эсэх, зохицуулалтын өөр хувилбар байгаа эсэх;

[119] Мөн тэнд. Нэг үйлчлүүлэгчид шаардлагатай уламжлалт болон орчин үеийн аргаар сэргээн засах үйлчилгээний дүнг нэгтгэн гаргасан.

- Хамгаалалтад авах шаардлагатай шүгэл үлээгчийн тоог багасгах, хүний нөөцийн хэрэгцээ, ачааллыг бууруулах боломж бий эсэх зэрэг болно.

Төсвийн зардлыг багасгах боломж, зохицуулалтын өөр хувилбар бий эсэх:

Дээрхээс үзвэл хамгаалалтад авах шаардлагатай иргэдийн тооноос хамааруулан төсөвт үүсэх зардлыг тодорхой хэмжээгээр багасгаж болох хэдий ч төсвийн зардлыг бууруулах шалтгаан, зохицуулалтын өөр хувилбар эрэлхийлэх нь төдийлөн оновчтой биш байна.

Хамгаалалтад авах шаардлагатай шүгэл үлээгчийн тоог багасгах, хүний нөөцийн хэрэгцээ, ачааллыг бууруулах боломж бий эсэх:

Хамгаалалтад авах шаардлагатай шүгэл үлээгчийн тоо уг судалгаанд туссан мэдээлсэн иргэдийн тоотой харьцуулан үзвэл бага байх тул шүгэл үлээгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндөхгүйгээр эдийн засгийн хувьд үр ашигтай байх зарчмыг баримтлах, боломжтой арга замыг эрэлхийлэх нь чухал юм. Өөрөөр хэлбэл, эрүүл мэндийн туслалцаа үзүүлэх, сэтгэл зүйн туслалцаа үзүүлэх, хууль зүйн туслалцаа үзүүлэх мэргэжлийн багт даатгах, аюулгүй байдлын хамгаалалтыг мөн адил, нэг цэгийн үйлчилгээ, бусад хамгаалах байруудын үйлчилгээтэй нэгтгэн зохицуулах, анхан шатны тусламж үйлчилгээг Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Нийгмийн халамжийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулж болох юм.

4.2. Үр дүн

Төсөлд шинээр тусгагдсан “шүгэл үлээгчийг хамгаалах” болон “мөнгөн шагнал, урамшуулал, нөхөн төлбөр олгох”-д төрийн байгууллагад буюу улсын төсөвт үүсэх зардлыг урьдчилсан байдлаар тооцоолов. Ингэхдээ тохиолдлын тоо болон мөнгөн шагнал, урамшууллын мөнгөн дүнг дараах янзаар авч үзэн тусад нь тооцсон болно.

Тийнхүү тусад нь авч үзсэний үндсэн дээр гарсан тооцоог нэгдсэн байдлаар дурдвал:

а/ Хамгаалалтад авсан иргэдийн тоогоор гарах зардлыг тооцоолоход 7,146,002.25₮ /долоон сая нэг зуун дөчин зургаан мянга хоёр төгрөг хорин таван мөнгө/-ийн зардал, 0.27 хүний нөөцийн хэрэгцээ;

б/ АТГ-ын Мөрдөн шалгах хэлтэст иргэн аж ахуй нэгж, байгууллагаас ирүүлсэн гомдол, мэдээллийн тоогоор гарах зардлын хэмжээг тооцоолоход 74,106,690₮ / далан дөрвөн сая нэг зуун зургаан мянга зургаан зуун ер/ төгрөгийн зардал, 2.8 хүний нөөцийн хэрэгцээ тус тус үүсэж байна.

Дээрхээс үзэхэд ЦЕГ-ын дэргэдэх Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтсийн хамгаалалтын арга хэмжээ авсан иргэдийн тоогоор зардлыг тооцоолох нь улсын төсөвт үүсэх зардал, ачаалал харьцангуй бага байна. Харин АТГ-ын Мөрдөн шалгах хэлтэст ирүүлсэн гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээллийн тоог тохиолдлын тоо болгон зардлыг тооцож тэдгээрийн дунджийг тооцоолсноор “хамгаалалтын арга хэмжээ”-г авах төрийн байгууллагад буюу улсын төсөвт жилд дунджаар 74,106,690₮ / далан дөрвөн сая нэг зуун зургаан мянга зургаан зуун ер / төгрөгийн зардал, 2.8 хүний нөөцийн хэрэгцээ үүсэх магадлалтай байна.

ТАВ. ДҮГНЭЛТ

Төслийн зардлын тооцоог хийх нь хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх явцад иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад хэдий хэмжээний зардал, ачаалал үүсгэхийг урьдчилан гаргах зорилготой байдаг.

Шүгэл үлээснээр иргэн, хуулийн этгээдэд үүрэг хүлээлгэсэн, зардал ачаалал үүсэх зохицуулалтгүй байна. Нийтийн ашиг сонирхол хохирохоос урьдчилан сэргийлэх, энэ талаар зөрчил гарсан тохиолдолд таслан зогсоох үүргийг байгууллагад хүлээлгэсэн байгааг хуулийн этгээдэд хүлээлгэсэн үүрэг хэмээн үзэж

болохгүй юм. Учир нь “зөрчил гарсан тохиолдолд” хийгдэх үйл ажиллагааг тооцон гаргах нь огт хийгдэхгүй ч байж болох юм. Иймд, төрийн байгууллагад хүлээлгэсэн үүргийн дагуу үүсэх зардал, ачааллыг урьдчилсан байдлаар тооцов. Ингэхдээ зардал үүсгэх боломжтой зүйл, заалт буюу төслийн Гуравдугаар бүлгийн “Шүгэл үлээгчийг хамгаалах”-тай холбогдуулан гарах зардлын тооцоог хийлээ.

Хуулийн төсөлд тусгагдсан үйл ажиллагааг төрөөс авч хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд хэрэгжүүлэх стандарт үйл ажиллагааг нэг бүрчлэн тооцоход шаардлагатай төрийн байгууллагаас авч болох тоон мэдээлэл хомс байх тул төслийн 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь заалтын дагуу “хамгаалалтын арга хэмжээ” авч хэрэгжүүлэх заалт, холбогдох хуулиар заасантай уялдуулан ЦЕГ-ын дэргэдэх Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтсийн хамгаалалтад авсан иргэдийн тоог үндэслэсэн. Мөн нэг байгууллагын зардлаар улсын төсөвт үүсэх зардал, ачааллыг гаргах боломжгүй гэж үзэн АТГ-ын Мөрдөн шалгах хэлтэст иргэн аж ахуй нэгж байгууллагаас ирүүлсэн гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээллийн тоог авч тэдгээрийн дунджийг тооцоолсноор шүгэл үлээгчид туслалцаа үзүүлэхэд шаардлагатай нийт мөнгөн дүнг тооцоолон гаргасан.

АТГ-т “мөнгөн шагнал олгох, урамшуулах, нөхөн төлбөр олгох” талаар шууд үүрэг болгон, төсөвт төвлөрөх орлого, түүнээс олгох мөнгөн шагналын хэмжээг заасан хэдий ч хуулийн төслийн зүйл, заалт өөр хоорондоо болон бусад хуулийн зүйл, заалттай уялдаа холбоогүй, ойлгомжгүй, хийдэлтэй байгаа нь зардлыг бодитоор урьдчилан тооцоход хүндрэлтэй нөхцөлийг үүсгэж байх тул аргачлалын дагуу стандарт үйл ажиллагаа хийгдэх боломжгүй юм.

Төслийг хэрэгжүүлснээр улсын төсөвт тодорхой хэмжээний ачаалал үүсгэх хэдий ч гэрч, хохирогч болон шүгэл үлээгчийг хамгаалах үйл ажиллагаа нь багагүй зардлыг шаарддаг. Шаардлагатай туслалцааг зүй ёсоор үзүүлэх нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан иргэний эрхийг баталгаатай эдлүүлэх, НАСТШҮХтХ-н зорилтыг хангахад чиглэсэн чухал алхам юм. Энэхүү зардлын мөнгөн дүнг эргээд ямар замаар эргэн төвлөрүүлэх, төсөвт ашигтай байдлаар зохицуулах тухай асуудал бодитоор урган гарна.

Ийнхүү судалгааны үр дүнгээс дараах саналыг гаргаж байна. Үүнд:

- Төслийн “Шүгэл үлээгчийг хамгаалах” хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх зүйл заалтын тухайд 16 дугаар зүйлийн 16.2, 16.4, 16.5 дахь заалтын “...арга хэмжээ авч болно.” гэснийг “...арга хэмжээ авна.” гэж, 16.6 дахь заалтын “...хамгаалалтын арга хэмжээнд хамруулж болно.” гэснийг “... хамгаалах шийдвэр гаргуулж болно.” гэж тодорхой заан өөрчлөн найруулах,
- НАСТШҮХтХ, Засгийн газрын тусгай сангийн тухай хууль болон бусад хуулийн уялдаа холбоог нягтлах, нарийвчилсан зохицуулалт бий болгох буюу “хамгаалалтын арга хэмжээ” авахад зарцуулагдсан зардлыг эргээд хэрхэн төвлөрүүлэх талаар арга зам, боломжит хувилбарыг эрэлхийлэх;
- Төрийн байгууллагад орох орлогыг уг хуулийн төслийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэгт заасан “... захиргааны байгуулагад учирсан хохирлыг буцаан олж авсан...” гэж зааснаар хэрэгжүүлэх боломжгүй болсон байна. Учир нь 1/ нийтийн ашиг сонирхлыг “захиргааны байгууллагад” гэж хязгаарласан, 2/ “учирсан хохирлыг” гэж өнгөрсөн цагт авч үзсэн нь хуулийн зорилтод тодорхойлсон үндсэн үзэл санааг хэрэгжүүлэхэд саад болох төдийгүй Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх хэсэгт заасан “олон нийтийн итгэл” гэснийг авч үзэх, хуулийн төслийн 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх хэсэгт заасан “...хохироох бодит нөхцөл бүрдүүлсэн” гэсэн заалттай зөрчилдөж байх тул нийтийн ашиг сонирхлыг хохироосон, хохироох бодит нөхцөл үүссэн гэсэн 2 үндэслэлийг авч үзэж

орлогыг тооцох нь зүйтэй байна. Энэ мэт хууль хоорондын болон хуулийн төслийн зүйл заалт хоорондын уялдаа холбоог хангах нь шүгэл үлээгчийг дэмжсэн хууль бус үйлдэлтэй тэмцсэнээр уг хуулийн төслийн үзэл санаа бүрэн утгаар хэрэгжих төдийгүй төрийн байгууллагад орлого бүрдэх боломжтой болох юм.

- Хуулийн төслийн 22 дугаар зүйлд заасан нөхөн төлбөрийг авах тухай хүсэлт гаргаж болох тухай заасан хэдий ч хэн, хэзээ, хэрхэн олгох талаар уг хуулийн төсөлд тусгаагүй байгаа нь хуулийн хийдэл үүсгэж зардал тооцох боломжгүй байна.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

НОМ ЗҮЙ

МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ, МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- Авлигын эсрэг нэгдсэн үндэстний байгууллагын конвенц, 2003 он.
- Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 1992 он, №1
- Авлигын эсрэг хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2006 он, №35
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 1998 он, №1
- Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2013 он, №30

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- Улсын Их Хурлын 2016 оны 51 дүгээр тогтоолоор баталсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”
- Улсын Их Хурлын 2016 оны 11 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”
- Үндсэн хуулийн цэцийн 2014 оны 1 дүгээр дүгнэлтийн тухай /дугаар 21/
- Хуулийн төслийг буцаах тухай /дугаар 20/
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар авах зарим арга хэмжээний тухай 2013 оны /дугаар 20/

ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал” Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралт
- “Хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2010 оны 68 дугаар тогтоол
- “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө” Засгийн газрын 2017 оны 114 дүгээр тогтоол
- Гэрч, хохирогчийг хамгаалах, туслалцаа үзүүлэх үндэсний хөтөлбөр, Засгийн газрын 2015 оны 346 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт
- Хохирогчид нөхөх олговор олгох журам батлах тухай, Засгийн газрын 2009 оны 9 дүгээр сарын 23-ны өдрийн дугаар 294 тогтоол
- Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай, 2017 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн дугаар 115 /Засгийн газрын 2015 оны 346 дугаар тогтоолд өөрчлөлт оруулах тухай/
- Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 472 дугаар тогтоол

САЙДЫН ТУШААЛ

- Гадаад харилцааны сайдын 2013 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн дугаар А/91 тушаал, Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид үйлчилгээ үзүүлэх журам
- Хөдөлмөрийн сайдын 2015 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн дугаар А/135 дугаар тушаал, Хохирогчийг ажлын байраар хангах, мэргэжлийн сургалтад

Хуулийн үндэсний хүрээлэн www.mlgov.mn

хамруулах үйлчилгээ үзүүлэх журам

- Хууль зүй, дотоод хэргийн сайдын үүрэг гүйцэтгэгчийн 2014 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн А/112 дугаар тушаал, Биечилсэн хамгаалалтын журам /Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 7.1.3/
- Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2014 оны 7 дугаар сарын 02-ны өдрийн А/112 дугаар тушаал, Гэрч, хохирогчийг мэдээллийн нууцлалыг хангах аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрэглэх журам /Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 7.1.4/
- Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2014 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн А/113 дугаар тушаал, Гэрч, хохирогчийг тусгай техник хэрэгслийн жагсаалт, хэрэгслээр хангах, хэрэглэх журам /Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 7.1.5/
- Хууль зүй, дотоод хэргийн сайд сайдын 2014 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн А/114 дүгээр тушаал, Гэрч, хохирогчийг аюулгүй газарт түр байрлуулах аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрэглэх журам /Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 7.1.6/
- Хууль зүй, дотоод хэргийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, эрүүл мэндийн сайдын хамтарсан 2017 оны 4 дүгээр сарын 6-ны өдрийн дугаар А/84, /А/59/, А/130 дугаар тушаал, Хохирогчид үйлчилгээ үзүүлэх төрийн бус байгууллагыг магадлан итгэмжлэх журам
- Эрүүл мэндийн сайд, Хууль зүйн сайдын хамтарсан 2014 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн А/250, А-171 дугаар тушаал, Гэрч, хохирогчид эрүүл мэндийн туслалцаа үзүүлэх журам /Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 18.1.3/
- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн А/74 дүгээр тушаал, Сэтгэл зүйн зөвлөгөө үзүүлэх журам
- Эрүүл мэндийн сайдын 2017 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн А/394 дүгээр тушаал, Хохирогчид сэтгэл заслын үйлчилгээ үзүүлэх журам
- Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны 4 дүгээр сарын 6-ны өдрийн А/80, А/132, А/60, Нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх санхүүжүүлэх журам

НОМ, ГАРЫН АВЛАГА

- Шүгэл үлээгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах судалгааны тайлан. 2019 он.
- Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн зардлын тооцоо. 2018 он.
- Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан. 2018 он.
- Авлигатай тэмцэх газар, Авлигатай тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилт, авлигын ерөнхий нөхцөл байдал-2018, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт (2016-2018)
- Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлалын гарын авлага. Хууль тогтоомжийн тухай хууль /аргачлал, гарын авлага/, Хууль зүй, дотоод хэргийн яам, GIZ, Уб., 2016

Хуулийн зөвлөлийн хэрэгсэл www.lrc.gov.mn

Хавсралт 1

Нийтийн ашиг сонирхолын төлөө шүгэл үлээгч /илчлэгч/-ийг хамгаалах тухай хуулийн төслийн хүрээнд хүлээлгэсэн үүрэг

№	Хуулийн зүйл, заалт	Хуулийн зохицуулалт
1.	5 дугаар зүйл. Нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгч / илчлэгч/-ийг дэмжих талаар байгууллагын хүлээх үүрэг	5.1.Байгууллага нь нийтийн ашиг сонирхол хохирохоос урьдчилан сэргийлэх, энэ талаар зөрчил гарсан тохиолдолд таслан зогсоох, нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгч /илчлэгч/-ийг /цаашид "шүгэл үлээгч" гэх/ дэмжих, хамгаалах үүрэгтэй. 5.2.Захиргааны байгууллага нь хувийн хэвшил, төрийн бус байгууллагын зүгээс нийтийн ашиг сонирхлыг хохироохоос урьдчилан сэргийлэх талаар хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллаж болно. 5.3.Нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгч нь ажил мэргэжлээ солих, албан тушаалаа өөрчлөх, түр хугацаагаар өөр үүрэг гүйцэтгэх зэрэг хүний нөөц, ажлын байртай холбоотой арга хэмжээ авах үндэслэл бүхий хүсэлт гаргавал тэрхүү хүсэлтийг тухайн байгууллагын удирдлага даруй шийдвэрлэнэ. 5.4.Байгууллага нь энэ хуулийн зохицуулалтад нийцүүлэн нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгчийн талаар зөв хандлага төлөвшүүлэх сургалт явуулах, шүгэл үлээсэн мэдээллийг хүлээн авах, шүгэл үлээгчийг дэмжих, урамшуулах, хамгаалах асуудлыг тусгасан журам гаргаж мөрдөнө.
2.	6 дугаар зүйл.Авлигатай тэмцэх газраас шүгэл үлээгчийг дэмжих нэгдсэн арга хэмжээ	6.1.Авлигатай тэмцэх газар нь нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгчийг дэмжихтэй холбоотой дараахь асуудлаар арга хэмжээ авч, удирдамж, зөвлөмж гаргаж ажиллана: 6.1.1.нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгчийн мэдээллийг хүлээн авах, шүгэл үлээгчийн хувийн мэдээлэл үнэн эсэх, шүгэл үлээж байгаа зорилго нь нийтийн ашиг сонирхлын төлөө эсэхийг хянах; 6.1.2.мэргэжлийн хяналт шалгалт явуулах болон мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллагатай харилцан хамтран ажиллах; 6.1.3.шүгэл үлээгчийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээг зохион байгуулах; 6.1.4.шүгэл үлээгчид мөнгөн шагнал олгох, урамшуулах, нөхөн төлбөр олгох үндэслэлийг хянаж шийдвэрлэх; 6.1.5.олон нийтэд шүгэл үлээгчийг хүлээн зөвшөөрөх, дэмжихтэй холбоотой сургалт, сурталчилгаа явуулах; 6.1.6.шүгэл үлээгчид хууль зүйн болон сэтгэл зүйн үнэ төлбөргүй зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулах; 6.1.7.хуульд заасан бусад.
3.	7 дугаар зүйл. Мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх	7.1.Авлигатай тэмцэх газар нь нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээж илчилсэн мэдээллийг хүлээн авсан болон түүний мөрөөр хянан шалгасан, шүгэл үлээгчид хамгаалалтын арга хэмжээ авсан, цуцалсан, хохирол арилгасан, шагнал, урамшуулал олгосон зэрэг шүгэл үлээсэнтэй холбогдуулан авсан арга хэмжээний талаар тусгасан мэдээллийн нэгдсэн сан бий болгож ажиллана. 7.2.Мэдээллийн нэгдсэн санд тусгах шаардлагатай мэдээллийг холбогдох байгууллага Авлигатай тэмцэх газраас албан бичгээр тавьсан хүсэлтийг хүлээж авснаас хойш долоо хоногийн дотор гаргаж өгөх үүрэгтэй. 7.3.Авилгатай тэмцэх газар нь мэдээллийн нэгдсэн санд тусгасан мэдээллийг энэ хуулийн зорилгод нийцүүлэн хадгалах ашиглах, хамгаалах арга хэмжээ авна. 7.4.Мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, ашиглах тухай журмыг Авилгатай тэмцэх газрын дарга батална. 7.5.Авлигатай тэмцэх газар нь нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээсэн талаар статистик мэдээллийг улсын хэмжээнд нэгтгэн гаргаж, дараа оны нэгдүгээр улиралд багтаан нийтэд мэдээлж байх ба дэлгэрэнгүй мэдээллийг Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороонд мөн хугацаанд хүргүүлж байна.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.unesco.mn

4.	14 дүгээр зүйл.Шүгэл үлээгчид зөвлөгөө өгөх	14.2.Шүгэл үлээгч энэ хуулийн 14.1-д заасан зөвлөгөө авах тухай хүсэлтийг Авлигатай тэмцэх газарт гаргах ба тухайн байгууллага зөвлөгөө өгөх ажлыг хүсэлтийг хүлээн авснаас хойш даруй зохион байгуулна.
5.	16 дугаар зүйл.Шүгэл үлээгчийн хувийн аюулгүй байдлыг хамгаалах	16.4.Шүгэл үлээгчийн хүсэлтийг үндэслэн Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 5.4-т заасны дагуу тухайн хуульд заасан журмаар хамгаалалтын арга хэмжээ авч болно. 16.5.Нийтийн ашиг сонирхлыг зөрчсөн зөрчлийн талаар шүгэл үлээж, мэдээлэл өгсөн тохиолдолд шүгэл үлээгчийн хүсэлтийг үндэслэн шаардлагатай бол Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.2 дугаар зүйлийн 8-д заасны дагуу аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авч болно
6.	19 дүгээр зүйл.Шүгэл үлээгчийг дарамт, шахалтаас хамгаалах	19.7.Энэ хуулийн 18.1-д заасан дарамт шахалт шүгэл үлээгчид үзүүлснээс хойш тухайн этгээд дахин ийм арга хэмжээ авсан эсэх дээр Авлигатай тэмцэх газар хоёр жилийн турш тогтмол мониторинг хийнэ.
7.	20 дугаар зүйл.Шүгэл үлээгчид мөнгөн шагнал олгох	20.2.Энэ хуулийн 20.1-д зааснаар мөнгөн шагнал авах өргөдөл ирүүлснээс хойш долоо хоногийн дотор Авлигатай тэмцэх газраас Мөнгөн шагнал олгох зөвлөл байгуулах ба уг зөвлөлөөс хэлэлцэн шийдвэрлэсний дагуу дараахь хэмжээг баримтлан мөнгөн шагнал олгоно: Энэ хуулийн 20.1-д заасан орлогод хамаарах үнийн дүн /төгрөгөөр/ — Мөнгөн шагналын хувь, хэмжээ /төгрөгөөр/ 50 сая хүртэл — 20 хувь 50 саяас 250 сая — 10 сая төгрөг дээр 50 сая төгрөгөөс давсан дүнгийн 14 хувийг нэмнэ 250 саяас 1 тэрбум — 36 сая төгрөг дээр 250 сая төгрөгөөс давсан дүнгийн 10 хувийг нэмнэ 1 тэрбум төгрөгөөс 2 тэрбум — 113 сая төгрөг дээр 1 тэрбум төгрөгөөс давсан дүнгийн 6 хувийг нэмнэ 2 тэрбумаас дээш — 173 сая төгрөг дээр 2 тэрбум төгрөгөөс давсан дүнгийн 4 хувийг нэмнэ 20.3.Мөнгөн шагнал нь 100 мянган төгрөгөөс 1 тэрбум 500 сая төгрөг хүртэл байна. 20.4.Авлигын эсрэг хуулийн 4.1-д заасан этгээд албан үүрэгтэй холбоотойгоор мэдээлэл өгч шүгэл үлээсэн тохиолдолд энэ хуулийн 20.2-т заасан мөнгөн шагналын 50 хувийг олгоно. 20.6.Авлигатай тэмцэх газар мөнгөн шагнал олгох эсэх асуудлыг шүгэл үлээгчийн өргөдлийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор шийдвэрлэж, шүгэл үлээгчид албан бичгээр мэдэгдэнэ. 20.7.Авлигатай тэмцэх газар мөнгөн шагнал олгох эсэхтэй холбоотой хяналт шалгалт явуулах бол энэ хуулийн 20.6-д заасан хугацааг 30 хүртэл хоногоор сунгаж болно. 20.8.Энэ хуулийн 20.7-д заасан хяналт шалгалт явуулах нөхцөлд шаардлагатай материал, тайлбар ирүүлэхийг мөнгөн шагнал хүссэн өргөдөл гаргагч, лавлагаа, тодорхойлолт гаргах этгээд, холбогдох байгууллагаас хүсч болно. Мөнгөн шагнал хүссэн өргөдөл гаргагч, лавлагаа, тодорхойлолт гаргах этгээд, холбогдох байгууллага энэхүү хүсэлтийг хангах үүрэгтэй.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.mli.gov.mn

8.	21 дүгээр зүйл.Шүгэл үлээгчид урамшуулал олгох	21.1.Авлигатай тэмцэх газар нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээснээр захиргааны байгууллагад учрах байсан бодит хохирлоос сэргийлсэн болон доор дурдсан үндэслэлээр нийтийн ашиг сонирхлыг дэмжсэн бол урамшуулал олгох талаар Мөнгөн шагнал олгох зөвлөлөөр хэлэлцүүлж энэ тухай зөвлөмж гаргана: 21.1.1.нийтийн ашиг сонирхлыг хохироосон этгээдэд шийтгэл, ял, албадлагын арга хэмжээ оногдуулсан; 21.1.2.залруулах арга хэмжээ авах, хориглох зэрэг тусгай үйлдэл шаардлагатай захиргааны арга хэмжээ авсан; 21.1.3.нийтийн ашиг сонирхлыг хохироох үйлдлээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн журам, дүрэм, хууль тогтоомж батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах зэрэг тогтолцоог сайжруулахад чиглэсэн үйл ажиллагаанд хувь нэмэр оруулсан. 21.2.Урамшуулал олгох тухай зөвлөмжийг гарснаас хойш ажлын гурван өдрийн дотор энэ хуулийн 21.4-т заасан байгууллагад хүргүүлэх ба шүгэл үлээгчид мэдэгдэнэ. 21.3.Энэ хуулийн 21.1-д заасан урамшууллын хэмжээ 500 000 төгрөг байх ба мөнгөн шагналтай давхардуулан олгохгүй. 21.4.Урамшууллыг энэ хуулийн 5.1-д заасан үүргийн дагуу шүгэл үлээгчийн ажиллаж байгаа байгууллагаас олгоно. 21.5.Энэ хуулийн 21.1-д заасан үндэслэл бий болсон байхад урамшуулал олгоогүй бол шүгэл үлээгч Авлигатай тэмцэх газарт болон шүүхэд гомдол гаргаж болно.
9.	22 дугаар зүйл.Шүгэл үлээгчид нөхөн төлбөр олгох	22.1.Шүгэл үлээгч, түүний хамаарал бүхий этгээдэд энэ хуулийн 16 дугаар зүйлд заасны дагуу хамгаалалтын арга хэмжээ авахад гарах зардал нь тухайн хуульд заасны дагуу зохицуулагдана. 22.2.Шүгэл үлээгч болон түүний хамаарал бүхий этгээдэд хамгаалалтын арга хэмжээ авснаас гадна болон хамгаалалтын арга хэмжээ аваагүй байхад учирсан хохиролтой холбогдуулан нөхөн төлбөр авах тухай хүсэлт гаргаж болно.
10.	23 дугаар зүйл.Мөнгөн шагналыг давхардуулан олгохыг хориглох	23.1.Энэ хуулийн 20 дугаар зүйлд заасан мөнгөн шагнал, 21 дүгээр зүйлд заасан урамшуулал авах этгээд адил үндэслэлээр бусад хууль тогтоомжийн дагуу мөнгөн шагнал, урамшуулал шаардахыг хориглоно. 23.2.Энэ хуулийн дагуу олгох мөнгөн шагнал, урамшууллын хэмжээ нь бусад хууль тогтоомжийн дагуу адил үндэслэл, шалтгаанаар олгох мөнгөн шагнал, урамшууллын хэмжээтэй тэнцүү, эсхүл уг хэмжээнээс бага буюу илүү байх нөхцөлд Авлигатай тэмцэх газар болон холбогдох байгууллага уг зөрүүг хасч, нэмж тооцон олгохгүй 23.3.Шүгэл үлээгч энэ хуульд заасантай адил үндэслэл, шалтгаанаар бусад хууль тогтоомжийн дагуу мөнгөн шагнал, урамшууллын мөнгө авсан тохиолдолд Авлигатай тэмцэх газар болон холбогдох байгууллага тэрхүү авсан хэмжээгээр мөнгөн шагнал, урамшууллын мөнгөн дүнгээс хасч тооцно.
11.	24 дүгээр зүйл.Мөнгөн шагнал, урамшууллын мөнгийг буцаан авах	24.1.Авлигатай тэмцэх газар болон холбогдох байгууллага дараахь тохиолдолд мөнгөн шагнал, урамшуулал авсан шүгэл үлээгчид мэдэгдэх бөгөөд ийнхүү мэдэгдсэнээс хойш гурван сарын дотор шүгэл үлээгч нь урьд авсан хэмжээгээр мөнгөн шагнал, урамшууллын мөнгийг буцааж өгнө: 24.1.1.мөнгөн шагнал, урамшууллын мөнгийг хуурамч баримт бичиг бүрдүүлж, эсхүл үндэслэлгүйгээр олж авсан тохиолдол; 24.1.2.энэ хуулийн 20, 21 дүгээр зүйлд заасныг зөрчиж мөнгөн шагнал, урамшуулал олгосон; 24.1.3.мөнгөн шагналын мөнгийг буруу тооцож олгосон. 24.2.Шүгэл үлээгч энэ зүйлийн 24.1-д заасны дагуу мөнгөн шагнал, урамшууллын мөнгийг заасан хугацаанд буцааж өгөөгүй тохиолдолд Авлигатай тэмцэх газар болон холбогдох байгууллагаас шүүхэд хандаж шийдвэрлүүлнэ.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.official.mn

Хавсралт 2

Шүгэл үлээгчид мөнгөн шагнал олгох, урамшуулах, нөхөн төлбөр олгох үндэслэлийг хянаж шийдвэрлэх замаар төсөвт төвлөрүүлэх орлого

Төслийн 6 дугаар зүйлийн 1.4-д “Шүгэл үлээгчид мөнгөн шагнал олгох, урамшуулах, нөхөн төлбөр олгох үндэслэлийг хянаж шийдвэрлэх” хэмээн АТГ-т үүрэг болгосон хэдий ч шаардлагатай төрийн байгууллагаас авч болох тоо мэдээлэл хомс, энэ талаарх мэдээллийг тусгайлан бүртгэдэггүй, мэдээлэл төвлөрсөн газар байхгүй зэрэг шалтгаанаас үүдэн нарийвчилсан тоо гаргахад хүндрэлтэй хэдий ч 2015-2018 оны Авлигын гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг баримжаалан авч үзлээ. Нийтийн ашиг сонирхыг төлөө шүгэл үлээснээр төсвийн орлогыг нэг бүрчлэн тооцох нь төрд илүү ашигтай. Учир нь энэ төрлийн гэмт хэргийн хохирогч нь дийлэнх тохиолдолд төр байдаг бөгөөд учирсан хохирлыг нь төрийн олох ёстой байсан орлого хэмээн үзэх боломжтой юм.

	2015	2016	2017	2018	дундаж
Гэмт хэргийн улмаас учирсан хохирол	50,300,000,000	37,727,800,000	69,546,211,566	663,213,994,905	205,197,001,617
Мөрдөн байцаалтын шатанд нөхөн төлүүлсэн	2,900,000,000	2,808,900,000	3,412,008,000	17,470,753,530	6,647,915,382

Дээрх хүснэгтээс үзвэл Авлигын гэмт хэргээс жилд дунджаар 205,197,001,617 төгрөгийн хохирол учирдаг бөгөөд үүнээс жилд дунджаар 3.2% буюу 6,647,915,382 төгрөгийг мөрдөн байцаалтын шатанд нөхөн төлүүлдэг байна.

Төслийн 20.2 дахь хэсэг. Мөнгөн шагналын хувь хэмжээ

Энэ хуулийн 20.1-д **заасан орлогод хамаарах үнийн дүн /төгрөгөөр/**	**Мөнгөн шагналын хувь, хэмжээ /төгрөгөөр/**
50 сая хүртэл	20 хувь
50 саяас 250 сая	10 төгрөг дээр 50 сая төгрөгөөс давсан дүнгийн 14 хувийг нэмнэ
250 саяас 1 тэрбум	36 сая төгрөг дээр 250 сая төгрөгөөс давсан дүнгийн 10 хувийг нэмнэ.
1 тэрбум төгрөгөөс 2 тэрбум	113 сая төгрөг дээр 1 тэрбум төгрөгөөс давсан дүнгийн 6 хувийг нэмнэ
2 тэрбумаас дээш	173 сая төгрөг дээр 2 тэрбум төгрөгөөс давсан дүнгийн 4 хувийг нэмнэ

Хуулийн төсөлд тусгагдсаны дагуу авлигын гэмт хэргийн улмаас учирсан хохирол буюу төсөвт төвлөрүүлэх орлогын сүүлийн 4-н жилийн дундаж үзүүлэлтээр тооцсон мөнгөн шагналын хэмжээ нь 173,000,000 + (203,197,001,617 ч 100 Ч 4) = 8,300,880,064.68 төгрөг байна. Гэсэн хэдий ч энэхүү хэмжээ нь төрд 205,197,001,617 төгрөгийн хохирлыг буруутай этгээдээдээс нөхөн төлсний дараа үүсэх зардал юм. Иймд төслийн 20 дугаар зүйлийн 20.1.1 дэх заалтаас 20.1.4-д заасны дагуу мөнгөн шагналыг Мөрдөн байцаалтын шатанд нөхөн төлүүлсэн төгрөгөөс тооцон үзвэл 173,000,000 + (4,647,915,382 ч 100 Ч 4) = 358,916,615.28 төгрөгний мөнгөн шагнал олгохоор байна.

Шүгэл үлээгчид мөнгөн шагнал олгох, урамшуулах, нөхөн төлбөр олгох нь тодорхой үр дагавар үүсэх буюу төсөвд орлого оруулсны үндсэн дээр гарах зардал байх тул мөнгөн шагналыг Мөрдөн байцаалтын шатанд нөхөн төлүүлсэн зардлыг

хуулийн дэлгэцийн хуулийн www.mnsay.mn

баримжаалан тооцоход 358,916,615.28 төгрөгний зардал урамшууллыг Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтэст иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлж байгаа гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээллийн тооны дунджаар баримжаалан авч үзэхэд 296,500,000 төгрөг буюу нийт 655,416,615 төгрөгний зардал гарахаар байна.

Харин төслийн 21 дүгээр зүйлийн 1-д зааснаар урамшуулал олгох үндэслэлийг нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээснээр захиргааны байгууллагад учрах байсан бодит хохирлоос сэргийлсэн болон доор дурдсан үндэслэлээр нийтийн ашиг сонирхлыг дэмжсэн бол хэмээн тодорхойлон урамшууллын хэмжээг 500,000 төгрөг байхаар тогтоосон байна. Дээрх зардлыг тооцоход дээр дурдсанчлан нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээсэн этгээдийн нэгдсэн тоо бүртгэл байхгүйгээс бодит тоог гаргахад хүндрэлтэй байгаа тул Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтэст ирүүлсэн гомдол мэдээллийн тоог баримжаалан зардлыг тооцлоо. Хүснэгт 3-аас харахад жилд дунджаар 593-н мэдээлэл ирдэг бөгөөд үүнд урамшуулал олгосон тохиолдолд 296,500,000 (593 Ч 500,000) төгрөгний урамшуулал олгогдохоор байна.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЛЦЭХ
www.nli.gov.mn

ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦООНД ТҮШИГЛЭСЭН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ, ОРОЛЦООГ ХЭРХЭН ХЭРЭГЖҮҮЛСЭН ТАЛААРХ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТ[120]

УДИРТГАЛ

Авлигатай тэмцэх газар нь Улсын Их Хурлын 2016 оны 51 дүгээр тогтоолоор батлсан "Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр"-ийн 2.1.7-д "авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн хяналт, иргэний нийгмийн байгууллагын үүрэг, оролцоог нэмэгдүүлэн, идэвх санаачилгыг дэмжих" зорилт, АТҮХ-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 4.1.7.1-д "Төрийн бодлого боловсруулах, хэлэлцэх, батлах зэрэг шийдвэр гаргах бүх шатанд тухайн асуудлаар үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгмийн байгууллагыг татан оролцуулах замаар авлигатай тэмцэх, авлигаас урьдчилан сэргийлэхэд иргэний нийгмийн байгууллагын оролцоог дэмжих" үйл ажиллагааны хүрээнд олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааны хяналт, оролцоог хэрхэн хэрэгжүүлсэн талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтэд үнэлгээ хийхээр зорьсон.

Энэхүү ажлын хүрээнд Хууль зүйн үндэсний хүрээлэн нь иргэн, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагын оролцоотойгоор өрх, иргэнд дэмжлэг туслалцаа, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааны талаар зохицуулсан эрх зүйн зохицуулалтыг түүвэрлэн хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд тулгамдсан асуудлыг тодорхойлон, төрийн болон төрийн бус байгууллагын оролцоог хэрэгжүүлсэн ажлын талаарх тайлан мэдээ, нотлох баримтад тулгуурлан үнэлгээг Хууль тогтоомжийн тухай хуулийн 50 дугаар зүйл, 51 дүгээр зүйл болон Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 5 дугаар хавсралтаар батлагдсан "Хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт, шинжилгээ хийх аргачлал", 6 дугаар хавсралтаар батлагдсан "Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал"-ын дагуу гүйцэтгэнэ.

Судалгааг баримт бичиг судлах, задлан шинжлэх ба нэгтгэн дүгнэх, статистик судалгаа авах, ганцаарчилсан болон фокус бүлгийн ярилцлага авах зэрэг аргыг хэрэглэж, хараат бус бие даасан байдлаар, шинжлэх ухааны арга зүйг баримтлан, үнэлгээг бодит мэдээлэлд тулгуурлан, дүгнэлтийг зөвхөн үнэлгээгээр тогтоогдсон үр дүнд үндэслэн гаргах зарчмыг баримтална.

Ийнхүү олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаанд иргэн, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагын оролцоог тодорхойлох, оролцоог хэрэгжүүлсэн ажлын талаарх тайлан мэдээ, нотлох баримтыг шинжлэх, эрх зүйн зохицуулалтын үр дагавар, хэрэгжилтийг үнэлэн, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаанд хяналт, оролцоог хэрхэн хэрэгжүүлсэн тухай дүгнэлт гаргахад чиглэх бөгөөд авлигатай тэмцэх, авлигаас урьдчилан сэргийлэхэд иргэний нийгмийн байгууллагын оролцоог дэмжих үйл ажиллагааны хүрээнд олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаанд хяналт, оролцоог хэрхэн хэрэгжүүлсэн талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэн, боломжит хувилбарыг дэвшүүлэх юм.

НЭГ. ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ЗОРИЛГЫГ ТОДОРХОЙЛОХ

Авлигатай тэмцэх газраас Улсын Их Хурлын 2016 оны 51 дүгээр тогтоолоор батлсан "Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр"-ийн 2.1.7-д "авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн хяналт, иргэний нийгмийн байгууллагын үүрэг, оролцоог нэмэгдүүлэн, идэвх санаачилгыг дэмжих" заалтыг

[120] Энэхүү хяналт шинжилгээ, үнэлгээг АТГ-ын захиалгаар 2020 онд ХЗҮХ-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга, хууль зүйн доктор П.Амаржаргал удирдан, Эрдэм шинжилгээний ажилтан Э.Уянга, Б.Ариунжаргал, О.Төрболд, Ерөнхий нягтлан бодогч Д.Дэлгэрмаа нар хамтран гүйцэтгэв.

энэхүү судалгааны үндэслэл болгосон тул Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 5 дугаар хавсралтаар батлагдсан "Хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт, шинжилгээ хийх аргачлал"-ын дагуу үндсэн зорилгыг тодорхойлон авч үзлээ.

Харин энэхүү зорилгод хүрэх дэд зорилгыг олон нийтийн хяналт, оролцоог нэмэгдүүлэх ажлын хүрээнд АТҮХ-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 4.1.7.1-д "Төрийн бодлого боловсруулах, хэлэлцэх, батлах зэрэг шийдвэр гаргах бүх шатанд тухайн асуудлаар үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгмийн байгууллагыг татан оролцуулах замаар авлигатай тэмцэх, авлигаас урьдчилан сэргийлэхэд иргэний нийгмийн байгууллагын оролцоог дэмжих" гэж тодорхойлсон зарим хэсгийн хүрэх үр дүн "олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааны хяналт, оролцоог хэрхэн хэрэгжүүлсэн талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтэд үнэлгээ хийснээр гарч байгаа хүндрэл, бэрхшээлтэй асуудал, нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлэхэд чиглэж байна.

ХОЁР. ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ЗОРИЛГОД ХҮРЧ БАЙГАА БАЙДАЛ

Авлигатай тэмцэх, хүний эрхийг хамгаалах нь хоорондоо салшгүй холбоотой бөгөөд ерөнхий утгаараа "авлигатай тэмцэнэ гэдэг нь хүний эрх зөрчигдөхөөс хамгаалж буй хэрэг мөн"[121] бөгөөд үүнд иргэд, олон нийтийн хяналт, иргэний нийгмийн байгууллагын үүрэг, оролцоог хуулийн дагуу нэмэгдүүлэн, идэвх санаачилгыг дэмжих нь ардчилсан нийгмийн үндсэн шаардлагыг хангасан зүй зохистой үйл ажиллагаа, Үндсэн хуулиараа тунхагласан хүний эрхийг төрөөс баталгаатай хангуулах суурь болох юм.

Ийнхүү Улсын Их Хурлаас батлагдсан үндсэн зорилгыг хэрэгжүүлэх дэд зорилгод хүрэх үр дүнг олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааны хяналт, оролцоог хэрхэн хэрэгжүүлсэн талаарх холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтэд Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар батлагдсан "Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал"-ыг баримтлан үнэлэх бөгөөд өнөөгийн нөхцөл байдалд шууд бусаар нөлөөлж буй хүчин зүйлийг тодорхойлох юм.

2.1. Үнэлгээ хийх шалтгаан

Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалын 3 дугаар зүйлийн 3.2.4 дэх заалт "нийгмийн бүлэг, төрийн бус байгууллага хуулийн хэрэгжилттэй холбоотой тодорхой асуудлаар түүнийг өөрчлөх, шинэчлэх, эсхүл хүчингүй болгох талаар үндэслэл бүхий санал гаргасан", 3.2.5 дахь заалт "төрөөс хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, хангах талаарх үүргээ биелүүлэхгүй байгаа буюу Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээгээр тодорхойлсон хүний эрх, эрх чөлөө зөрчигдөж байгаа бол" гэсэн нөхцөлийг хангаж байгаа тул үнэлгээг гүйцэтгэх боломжтой байна.

2.2. Үнэлгээ хийх хүрээ

Судалгааны хүрээг захиалагчаас ирүүлсэн саналын дагуу Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаанд төрийн болон төрийн бус байгууллагын хяналт, оролцоог хэрхэн хэрэгжүүлж буй байдлыг сонгож дараах байдлаар үнэлгээний хүрээг тогтоов.

Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжид хамрагдах өрх иргэнд үзүүлж буй үйлчилгээний төрөл, хэлбэр: Нийгмийн халамжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 18 дугаар зүйлийн 2 дахь хэсэг

Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний хяналт,

[121] Авлигатай тэмцэх /хууль тогтоомжийн хэрэгжилт, авлигын ерөнхий нөхцөл байдал-2018, авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт/ (2016-2018) Авлигатай тэмцэх газрын дарга, тэргүүн комиссар Х.Энхжаргалын илтгэлийн хэсгээс. Уб., 2019 он /8 дахь тал/

оролцоо: Нийгмийн халамжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 8, 24 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг

2.3. Үнэлгээний шалгуур үзүүлэлт

Үнэлгээний ажлын хэрэгжилтийн үр дагаврыг тодорхойлоход дараах шалгуур үзүүлэлтээс тохиромжтойг тогтооно.

- Хүлээн зөвшөөрөгдсөн байдал;
- Практикт нийцэж байгаа байдал;

Нийгмийн халамжийн тухай хуулийн заалтад тохируулан оновчтой, бодитой, хэмжиж болохуйц тодорхой шалгуур үзүүлэлтийг сонгон авч үнэлэх юм.

2.4. Үнэлгээний харьцуулах хэлбэр

Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхдээ үнэлэх болсон шалтгаан, үнэлгээний хүрээ, шалгуур үзүүлэлт зэргийг харгалзан дор дурдсан харьцуулах хэлбэрээс сонгоно.

Хүснэгт 1

№	Харьцуулах хэлбэр	Ойлголт, онцлог
1.	Байх ёстой болон одоо байгаа	Хуулиар тогтоосон “байх ёстой” үзүүлэлт практикт хэр байгааг илрүүлэх зорилготой. Үнэлгээ хийх хуульд байвал зохих тодорхой абсолют үзүүлэлтийг зааж өгсөн тохиолдолд одоо бодит байгаа үзүүлэлттэй харьцуулна.
2.	Хууль тогтоомж батлагдахаас өмнөх болон хууль тогтоомж батлагдсанаас хойш	Хууль хүчин төгөлдөр үйлчлэхээс өмнөх нөхцөл байдлыг хууль хүчин төгөлдөр хэрэгжсэний дараах буюу хуулийн хэрэгжилтийн явцад гарч буй үр дагавартай харьцуулна.
3.	Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш	Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш нөхцөл байдал хэрхэн өөрчлөгдсөнийг он дараалаар тогтоон харьцуулна.
4.	Тохиолдол судлах	Хууль, эсхүл үнэлгээний хүрээгээр тогтоогдсон зүйл, заалт өөр орчин нөхцөлд (бусад улсад, өөр орон нутагт гэх зэрэг) хэрхэн хэрэгжиж буй байдлыг харьцуулна.

Судалгааны явцад хууль тогтоомжоос сонгон авсан зохицуулалтын өнөөгийн хэрэгжилтийг байх ёстой буюу бүрэн хэрэгжсэн тохиолдолд хэрхэн авч үзэх тухай харьцуулалтын хэлбэрийг ашиглав.

2.5. Үнэлгээний шалгуур үзүүлэлтийг томьёолох

“Шалгуур үзүүлэлтийг томьёолох” гэдэг нь сонгосон шалгуур үзүүлэлт тус бүрээр тодорхой таамаглал дэвшүүлэх буюу асуулт тавихыг хэлэх бөгөөд үнэлгээний хүрээнд хамаарах зохицуулалт тус бүр дээр “практикт хэрхэн нийцэж байна вэ?” гэсэн асуулт тавьж үнэлгээг хийсэн.

2.6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох

Аргачлалын 3.7.3-т мэдээлэл цуглуулах дөрвөн аргыг тодорхойлсон ба үүнээс дараахь хоёр аргыг сонгон, үнэлгээ хийх мэдээллийг цуглуулав. Үүнд:

1/байгаа мэдээллийг цуглуулж ашиглах;

2/холбогдох субьектээс судалгаа авах.

Байгаа мэдээллийг цуглуулах хүрээнд: Нийгмийн халамжийн багц хууль, холбогдох эрх зүйн актууд, судалгааны тайлан, ажлын тайлан, мэдээг цуглуулж, судалгаа хийхэд ашиглав.

Холбогдох субъектээс судалгаа авах хүрээнд: Олон нийтийн оролцоонд түшиглэсэн нийгмийн халамжийн үйлчилгээг авч хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудал, хууль эрх зүйн орчныг судлах зорилгоор практикт ажиллаж буй энэ чиглэлийн мэргэжилтэн, төрийн бус байгууллага, үйлчилгээ авч буй иргэн, бусад холбогдох хүмүүстэй уулзаж ярилцлага хийсэн. Мөн холбогдох байгууллагаас үйл

Хуулийн үнэлгээний хүрээлэн www.ri.gov.mn

ажиллагааны тайлан, судалгаа, бусад мэдээллийг гаргуулан авч судалгаа хийхэд ашиглав.

ГУРАВ. ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦООНД ТҮШИГЛЭСЭН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ

Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалын 4.1-д мэдээлэл цуглуулах аргын дагуу холбогдох мэдээллийг цуглуулах, судалгаа хийх ажлыг хэрэгжүүлэх үе шатанд гүйцэтгэнэ. Иймд цуглуулсан мэдээллийг Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний талаарх ойлголт, эрх зүйн зохицуулалт, төсөв санхүүжилт гэж ангилан дараах байдлаар авч үзлээ.

3.1. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ

Нийгмийн халамж (social welfare) нь хүн амын сайн сайхан байдлыг бий болгох, тэдний суурь хэрэгцээг хангахад чиглэсэн Засгийн газар, холбогдох бусад институтийн үйл ажиллагааг илэрхийлж, юуны урьд хүн амын эдийн засаг, санхүүгийн сайн сайхан байдлыг хангах бодлого үйл ажиллагаатай холбогддог"[122] хэмээн олон улсад авч үздэг байна. Харин манай улсын Нийгмийн халамжийн тухай хуульд "нийгмийн халамж" гэж эрүүл мэндийн доройтолтой, гэр бүлийн халамж, асрамж дутагдалтай, бие даан, эсхүл бусдын тусламжгүйгээр хэвийн амьдрах боломжгүй, өвөрмөц хэрэгцээ бүхий иргэн, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэнд наад захын хэрэгцээг нь хангах зорилгоор улсаас тэтгэвэр, тэтгэмж олгох, тусгайлсан үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг ойлгох тухай заажээ.

Энэ үүднээс нийгмийн халамжийн тогтолцоог үр дүнтэй хөгжүүлэхэд халамжийн үйлчилгээний асуудал юунаас ч илүү чухал гэж үзэж байна. Халамжийн үйлчилгээнд хамрагдах өрх, иргэнээ зөв тодорхойлж чадаагүйгээс "хавтгайрсан халамж", "халамж эзэндээ хүрдэггүй", "ядуу иргэн, гэр бүлийн тоо ихсэж байна" гэсэн шүүмжлэлд байнга өртөж ирсэн бөгөөд 2019 онд дэлхийн 189 орноос хүний хөгжлийн индексээр 92, аз жаргалын индексээрээ 156 орноос 83 дугаар байранд жагсав. Тэгвэл хүний хөгжлийн индексээр хүний эрүүл саруул амьдрах, суурь хэрэгцээ хангагдах эрх хамаардаг бол аз жаргалын индексээр улс үндэстнүүд өөрийн орны ард иргэдийг сайн сайхан амьдрахад хэрхэн тусалж сайн зүйл хийж байгааг харуулдаг байна. Ийнхүү иргэдийн сайн сайхан амьдрал, эрүүл саруул байх, хүний наад захын суурь хэрэгцээг хангах боломж бүрдүүлсэн улс орны иргэд аз жаргалтай, хүний хөгжлөөр тэргүүлэх нь ойлгомжтой билээ.

Улс орны халамж, хамгааллын бодлого нийгмийн эмзэг хэсгийн суурь хэрэгцээг хангах, тохиолдсон хүндрэлтэй асуудлыг шийдвэрлэхэд чиглэдэг[123] бол үүнийг төр дангаар хэрэгжүүлэхээс илүүтэй олон нийтийн оролцоог хангах байдлаар хэрэгжүүлэх нь хавтгайрсан төсвийн зарцуулалтыг багасгах ач холбогдолтой төдийгүй иргэдийн идэвх оролцоог нэмэгдүүлэн төрийн зарим чиг үүргийг гэрээлэн гүйцэтгэх, үйл ажиллагаанд нь чиглүүлэх төдийгүй сайн үйлсэд хандуулах ач холбогдолтой.

Нийгмийн халамжийн тухай хуульд төрөлжсөн асрамжийн үйлчилгээ болон ОНОТХҮ гэх 2 төрлийн халамжийн үйлчилгээг тусгасан байна. Тодруулбал, төрөлжсөн асрамжийн үйлчилгээ гэдэгт асран хамгаалах, харгалзан дэмжих төрөл, садангүй бөгөөд бие даан амьдрах чадваргүй, ганц бие, байнгын эмчилгээ, асаргаа шаардагдах ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэн, түүнчлэн хүнд нөхцөлд байгаа хүүхдийг байрлуулан хоол, хувцас, эмнэлэг, соёл, ахуй, сэтгэл зүй, асаргаа сувилахуйн үйлчилгээ үзүүлэн, тэдний амьдралын хэвийн нөхцөлийг

[122] Удирдахуйн онол практикийн асуудлууд. Эрдэм шинжилгээний бичиг №9, Доктор (Ph.D) Л.Отгонтуяа "Нийгмийн халамжийн бодлогын үр нөлөө" сэдэвт судалгааны зарим үр дүн. Уб.,2009 он. /15 дахь тал/

[123] Удирдахуйн онол практикийн асуудлууд. Эрдэм шинжилгээний бичиг №9, Доктор (Ph.D) Л.Отгонтуяа "Нийгмийн халамжийн бодлогын үр нөлөө" сэдэвт судалгааны зарим үр дүн. Уб.,2009 он. /15 дахь тал/

бүрдүүлэх, хууль ёсны эрх ашгийг нь хууль тогтоомжид заасны дагуу хамгаалах үйл ажиллагааг[124] ойлгодог байна.

Харин ОНОТХҮ нь иргэн, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагын оролцоотойгоор өрх, иргэнд дэмжлэг туслалцаа, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг ойлгох бөгөөд эмзэг бүлгийн зорилтот хүн амд шууд хүрдэг нийгмийн халамжийн тогтолцооны цогц үйлчилгээ юм.[125]

Төрөлжсөн асрамжийн үйлчилгээ нь байнгын удаан хугацаагаар байж болдог бол ОНОТХҮ нь түр зуурын хугацаанд туслалцаа үзүүлэх үйлчилгээ явуулдаг байдлаар өөр хоорондоо ялгаатай байна. Тухайлбал: “Зөв амьдрах ухаан” ТББ нь “түр байрлуулан асрамжлах” үйлчилгээ эрхлэх эрх авсан бөгөөд төрөлжсөн асрамжийн үйлчилгээ эрхлэх эрхгүйгээр удаан хугацаагаар байрлуулж байгаа нь зөвшөөрөлгүй үйлчилгээ явуулсан гэж үзжээ.

Н.Мандуул: “Зөв амьдрах ухаан” ТББ-д хүүхдийг 24 цагаар асарч, хамгаалах зөвшөөрөл байхгүй.[126] Нийслэлийн ЗДТГ: “Зөв амьдрах ухаан” ТББ нь орон гэргүй, орц, траншейнд амьдардаг, архи мансуруулах бодист донтсон, засан хүмүүжүүлэх ангиас суллагдсан, өнчин ядуу бүх насны иргэдийг дахин нийгэмшүүлэх, ажил хөдөлмөр эхлүүлэх, сэтгэлзүйн сургалт олгож, нийгэмд эзлэх байр сууриа дахин олоход нь тусалж, бүтээлч иргэн болгон ажлын байраар хангаж, хамтдаа ажиллаж хөдөлмөрлөх боломжийг олгодог байгууллага аж[127]

Төрөөс нийгмийн халамжийн үйлчилгээг нийгмийн эмзэг хэсгийн суурь хэрэгцээг хангах, тохиолдсон хүндрэлтэй асуудлыг шийдвэрлэхэд чиглүүлдэг бол энэ үйлчилгээг үзүүлж байгаа байгууллагын санхүүгийн асуудлыг шийдвэрлэх, үйлчилгээ авч буй иргэдийн санхүү, хүнсний талон, эм тарианы мөнгө, түлээ нүүрсний мөнгө, түр байрлуулах, сургалт явуулах зэрэг 70 гаруй чиглэлийн халамжийг төрөөс үзүүлдэг байна. Үүнээс ОНОТХҮ-нд 9 чиглэлээр үйлчилгээ үзүүлдэг байна.

3.1.1. Улсын хэмжээнд олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тоо

Хүснэгт 2. *2018, 2019 онд ОНОТХҮ-нд хамрагдсан иргэдийн тоо / үйлчилгээний төрлөөр/*

№	Үйлчилгээний төрөл	2018 он	2019 он
		Хамрагдсан хүний тоо	Хамрагдсан хүний тоо
1	Сургалт зохион байгуулах	4487	3923
2	Зөвлөгөө өгөх	561	889
3	Сэргээн засах үйлчилгээнд хамруулах	5921	3249
4	Түр байршуулан асрамжлах	250	95
5	Өдрийн үйлчилгээнд хамруулах	5494	4520
6	Гэрийн асрамж, халамжийн үйлчилгээнд хамруулах	308	252
7	Иргэн, түүний гэр бүлийн хэрэгцээнд тулгуурласан нийгмийн халамжийн бусад үйлчилгээ	1000	172
8	Гэр оронгүй иргэн, түүний гэр бүлийн гишүүдийн амьдрах итгэлийг нэмэгдүүлэх, нийгэмшүүлэх, бичиг баримтжуулах, түр хоноглох байранд байрлуулах	960	955
9	Төсөл хэрэгжүүлэх үйлчилгээ	2239	1239
	НИЙТ ДҮН	**21220**	**15294**

[124] Нийгмийн халамжийн тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, № 8, 2012.

[125] Олон_нийтийн_оролцоонд_түшиглэсэн_халамжийн_үйлчилгээ_2017.pdf судалгаа /нөлөөллийн шинжилгээ/ http://rilsp.gov.mn/tasudalgaa.php?count=50 сүүлд үзсэн 2020.5.25

[126] https://medee.mn/single/147218 сүүлд үзсэн 2020.5.25

[127] Улаанбаатар хотын Захирагч С.Амарсайхан https://updown.mn/104555.html Сүүлд үзсэн 2020.5.25

Дээрх хүснэгтэд Нийгмийн халамжийн тухай хуульд заасан 10 төрлийн үйлчилгээнээс 9 төрлийн үйлчилгээг тусгасан байгаа нь хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.10-т заасан "*гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг түр хамгаалан байрлуулах үйлчилгээ*"-г дээрх хүснэгтэд дурдаагүй нь хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.4-т заасан "түр байрлуулан асрамжлах, хүчирхийлэлд өртсөн хүнийг түр хамгаалан байрлуулах" гэсэн өргөн утгаар зохицуулсан ойлголттой давхардсантай холбоотой юм.

2018 онд Монгол Улсын хэмжээнд олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд хамрагдсан 21220 хүн дээрх хүснэгтэд харагдаж буй 9 төрлийн үйлчилгээнд хамрагдсан байна. Тус үйлчилгээний төрөлд хамрагдсан иргэдийн тоог хувьчилж үзүүлбэл:

График. *2018 онд улсын хэмжээнд ОНОТХУ-нд хамрагдсан иргэдийн тоо /хувь, үйлчилгээний төрлөөр/*

2018 оны хувьд хуульд заасан олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнээс сэргээн засах үйлчилгээнд хамгийн олон хүн хамрагдсан нь нийт иргэдийн 27.9 хувийг эзэлж байна. Дээрх графикаас харвал иргэд сэргээн засах, өдрийн үйлчилгээ, сургалт зохион байгуулах, төсөл хэрэгжүүлэх үйлчилгээнд түгээмэл байдлаар хамрагддаг байна. Харин түр байршуулан асрамжлах, гэрийн асрамж халамжийн үйлчилгээ, зөвлөгөө өгөх үйлчилгээнд хамрагддаг иргэдийн тоо бага байдаг байна.

График. *2019 онд улсын хэмжээнд ОНОТХУ-нд хамрагдсан иргэдийн тоо /хувь, үйлчилгээний төрлөөр/*



Хүний эрхийн үндэсний комисс www.nhrc.gov.mn

2019 оны хувьд хуульд заасан ОНОТХУ-нээс сургалт зохион байгуулах үйлчилгээнд хамгийн олон хүн хамрагдсан байна. Энэ нь ОНОТХУ-нд хамрагдсан нийт иргэдийн 25.7 хувийг эзэлж байна. Дээрх графикаас харвал 2019 онд иргэд сургалт зохион байгуулах, сэргээн засах, өдрийн үйлчилгээ, төсөл хэрэгжүүлэх үйлчилгээнд түгээмэл байдлаар хамрагдсан байна.

Дээрх хоёр графикаас үзвэл, иргэд сэргээн засах, сургалтад хамрагдах, өдрийн үйлчилгээ, төсөл хэрэгжүүлэх үйлчилгээнд ихэвчлэн хамрагддаг байна. Харин түр байршуулан асрамжлах, гэрийн асрамж халамжийн үйлчилгээ, зөвлөгөө өгөх үйлчилгээнд хамрагддаг иргэдийн тоо бага байна.

Монгол Улсын хэмжээнд ОНОТХУ-нд хамрагдсан иргэдийн тоог авч үзвэл дараах байдлаар үйлчилгээнд хамрагдсан байна.

Хүснэгт 3. *2018, 2019 онд ОНОТХУ-нд хамрагдсан иргэдийн тоо*

№	Аймгийн нэр	2018 онд хамрагдсан хүний тоо	2019 онд хамрагдсан хүний тоо
1.	Архангай	264	266
2.	Баян-Өлгий	226	138
3.	Баянхонгор	927	769
4.	Булган	48	106
5.	Говь-Алтай	319	204
6.	Говьсүмбэр	109	121
7.	Дархан-Уул	208	179
8.	Дорноговь	368	49
9.	Дорнод	1262	394
10.	Дундговь	242	235
11.	Завхан	822	362
12.	Орхон	378	451
13.	Өвөрхангай	2926	917
14.	Өмнөговь	68	204
15.	Сүхбаатар	282	393
16.	Сэлэнгэ	230	1904
17.	Төв	130	127
18.	Увс	3422	543
19.	Ховд	89	172
20.	Хөвсгөл	3169	1363
21.	Хэнтий	141	120
22.	Улаанбаатар	5590	6277
	Улсын дүн	**21220**	**15294**

ОНОТХУ-нд 2018 онд нийт 21220 хүн хамрагдсан байна. Нийт энэхүү үйлчилгээнд хамрагдсан иргэдийн 26.3 хувийг Улаанбаатар хотод амьдардаг иргэд эзэлж байна.

Хөдөө орон нутгийн хувьд хамгийн их нь Увс аймагт 3422 иргэн энэ төрлийн үйлчилгээнд хамрагдсан бөгөөд ОНОТХУ-нд хамрагдсан иргэдийн 16.1 хувийг эзэлж байна. Мөн Хөвсгөл аймагт 3169 буюу 14.9 хувь, Өвөрхангай аймагт 2926 ОНОТХУ-нд хамрагдсан нийт тус үйлчилгээнд хамрагдсан иргэдийн 13.8 хувийг тус тус эзэлж байна. Хөдөө орон нутгаас энэ төрлийн үйлчилгээнд хамгийн бага хүн хамрагдсан аймаг нь 2018 оны хувьд Булган аймаг 48 буюу 0.2 хувьтай байна.

ОНОТХУ-нд 2019 оны хувьд нийт 15294 хүн хамрагдсан нь өмнөх оныхтой харьцуулахад 5926-аар буурсан байна.

2019 онд нийт энэхүү үйлчилгээнд хамрагдсан иргэдийн 41 хувийг Улаанбаатар хотод амьдардаг иргэд эзэлж байна. Хөдөө орон нутгийн хувьд хамгийн их нь Сэлэнгэ аймагт 1904 иргэн энэ төрлийн үйлчилгээнд хамрагдсан нь нийт ОНОТХУ-

Хүний эрхийн үндэсний комисс www.nhrc.gov.mn

нд хамрагдсан иргэдийн 12.4 хувийг эзэлж байна. Мөн Хөвсгөл аймаг 1363 буюу 8.9 хувь, Өвөрхангай аймагт 917 хүн ОНОТХУ-нд хамрагдсан нийт иргэдийн 6 хувийг тус тус эзэлж байна.

Хөдөө орон нутгаас энэ төрлийн үйлчилгээнд хамгийн бага хүн хамрагдсан аймаг нь 2019 оны хувьд Дорноговь аймаг 49 буюу 0.2 хувийг эзэлж байна.

Дээрхээс дүгнэвэл, 2018 онд ОНОТХУ-нд хамрагдсан иргэдийн тоо 2019 оныхтой харьцуулахад 5926-аар их байна. Түүнчлэн, нийт энэ төрлийн үйлчилгээнд хамрагдсан иргэдийн олонх нь Улаанбаатар хотод оршин суудаг байна.

2018, 2019 онд тус үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тоог аймаг тус бүрээс авч үзэхэд 2018 оны хувьд Увс, Хөвсгөл, Өвөрхангай аймгуудад ОНОТХУ-нд хамрагдсан иргэдийн тоо их байсан бол 2019 онд Увс, Хөвсгөл аймагт энэ төрлийн үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тоо өмнөх оныхтой харьцуулахад огцом буурсан үзүүлэлттэй байна. Тухайлбал, 2018 онд Увс аймаг энэ төрлийн үйлчилгээнд нийт 3422 хүн хамрагдаж байсан бол 2019 онд 543 болж 2879 хүнээр буурсан үзүүлэлттэй байна.

Тус үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тоо 2019 онд өмнөх оныхтой харьцуулахад буурсан. Харин Архангай, Орхон, Өмнөговь, Сүхбаатар, Сэлэнгэ, Ховд, Улаанбаатар хотод тус үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тоо өмнөх оныхтой харьцуулахад тодорхой хувиар өссөн үзүүлэлттэй байна.

3.1.2. Нийслэлийн хэмжээнд олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тоо

Хүснэгт 4. *Нийслэлийн хэмжээнд ОНОТХУ-нд хамрагдсан иргэдийн тоо*

№	Үйлчилгээний төрөл	2018 он	2019 он
		Хамрагдсан хүний тоо	Хамрагдсан хүний тоо
1	Амьдралын итгэл үнэмшил, бие даан амьдрах чадвар, хөдөлмөрийн дадал олгох, авьяасыг нь дэмжих зорилгоор сургалт зохион байгуулах	1151	1725
2	Зөвлөгөө өгөх	172	572
3	Сэргээн засах үйлчилгээнд хамруулах	2018	1555
4	Түр байршуулан асрамжлах	28	34
5	Өдрийн үйлчилгээнд хамруулах	797	803
6	Гэрийн асрамж, халамжийн үйлчилгээнд хамруулах	194	121
7	Гэр оронгүй иргэн, түүний гэр бүлийн гишүүдийн амьдрах итгэлийг нэмэгдүүлэх, нийгэмшүүлэх, бичиг баримтжуулах, түр хоноглох байранд байрлуулах	758	842
8	Төсөл хэрэгжүүлэх үйлчилгээ	670	625
Нийт дүн		**5788**	**6277**

Судалгааны ажлын хүрээнд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас 2018, 2019 онд олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тоо, санхүүжилтийн талаарх тайлан мэдээг авсан. Гэсэн хэдий ч тус байгууллагаас ирүүлсэн тоон мэдээ нь өөр хоорондоо зөрүүтэй байна. Дээрх хүснэгтэд 2018 онд нийслэлийн хэмжээнд нийт 5788 хүн олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд хамрагдсан гэсэн тоон мэдээ байна.

Гэтэл "***Хүснэгт 2.*** 2018, 2019 онд ОНОТХУ-нд хамрагдсан иргэдийн тоо", "***Хүснэгт 3.*** 2018, 2019 онд ОНОТХУ-нд хамрагдсан иргэдийн тоо /үйлчилгээний төрлөөр/" мэдээг тус байгууллагаас ирүүлсэн тоон мэдээнд үндэслэн хүснэгтэлсэн боловч 2018 онд нийслэлийн хэмжээнд олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тоо 5590 гэж тус байгууллагаас ирүүлсэн тайланд тусгасан байна.

Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн яам www.nll.gov.mn

Өөрөөр хэлбэл, тус байгууллагаас 2018 онд нийслэлийн хэмжээнд ОНОТХУ-нд хамрагдсан иргэдийн тоог 5788, 5590 гэж 198 хүний зөрүүтэй байдлаар гарган ирүүлсэн байна. Харин тус байгууллагаас ирүүлсэн 2019 оны тоон мэдээ өөр хоорондоо зөрүүгүй байна.

ОНОТХУ-нд 2019 онд нийслэлийн хэмжээнд 6277 иргэн хамрагдсан бөгөөд үйлчилгээний төрөл тус бүрээр нь задлан үзвэл:

График. *2019 онд нийслэлийн хэмжээнд ОНОТХУ-нд хамрагдсан иргэдийн тоо /хувь, үйлчилгээний төрлөөр/*

3.1.3. БЗД-ийн хэмжээнд олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тоо

Хүснэгт 5. *2019 онд БЗД-ийн хэмжээнд ОНОТХУ-нд хамрагдсан иргэдийн тоо*

№	Үйлчилгээний төрөл	2019 он
		Хамрагдсан хүний тоо
1.	Зөвлөгөө өгөх	142
2.	Сэргээн засах үйлчилгээнд хамруулах	316
3.	Түр байршуулан асрамжлах	4
4.	Өдрийн үйлчилгээнд хамруулах	190
5.	Гэрийн асрамж, халамжийн үйлчилгээнд хамруулах	11
6.	Гэр оронгүй иргэн, түүний гэр бүлийн гишүүдийн амьдрах итгэлийг нэмэгдүүлэх, нийгэмшүүлэх, бичиг баримтжуулах, түр хоноглох байранд байрлуулах	323
7.	Сургалт зохион байгуулах үйлчилгээ	625
Нийт дүн		**6277**

Судалгааны ажлын хүрээнд БЗД-ийн 2019 онд олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тоо, санхүүжилтийн талаарх тайлан мэдээг авсан. Гэсэн хэдий ч тус байгууллагаас ирүүлсэн тоон мэдээ нь өөр хоорондоо зөрүүтэй байна. Дээрх хүснэгтэд 2019 онд 7 төрлийн үйлчилгээ үзүүлсэн байгаа бол Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас ирүүлсэн нийслэлийн 9 дүүргийн ОНОТХУ-ний санхүүжилтийн хуваарьт 10 төрлийн үйлчилгээ бичигдсэн байна. Төрөөс тавигдаж буй санхүүжилтэд тааруулан ОНОТХУ-г үзүүлдэг болсон төдийгүй нийтэд туслалцаа үзүүлэхээс илүүтэй ашиг орлого, нэр хүнд олох гэсэн сонирхолтой ТББ байдаг байна.

Хүүхэд зүйн мэдээний хүрээлэн www.nli.gov.mn

"Зөв амьдрах ухаан" ТББ нь 0-70 насны 120 гаруй иргэний сар бүр олгогдох бүтэн өнчин хүүхдийг асарч буй иргэний тэтгэмж, тэжээгчээ алдсаны тэтгэвэр, байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг асарч буй иргэний тэтгэмж зэрэг Г.Загдаагийн эхнэр Г.Амарсайханы дансаар нийт 554.000 төгрөг оржээ. Мөн түр хоноглуулах үйлчилгээнд хамрагдсан нийт 33 иргэдийн халамжийн тэтгэвэр, хүүхдийн мөнгө, цалинтай ээжийн мөнгө, насны хишиг, түр хоноглохын үнэ гэх мэт 2019 оны сүүлийн 11,12 дугаар сард 19 сая 820 мянган төгрөгийг авсан бол 2018 онд 400 сая, 2019 онд 240 сая төгрөгийг тус тус улсын төсвөөс шилжүүлснийг зорилтод бүлгийн иргэдэд хүргэдэггүй дэргэдээ авч хооллож, орон гэртэй байлгадаг гэх нэрийн дор өөртөө үлдээдэг болох нь тогтоогдсон байна.[128]

Мөн ямар нэгэн өвчин зовлонгүй, гэр бүлийн хувьд асуудалгүй, ажил хөдөлмөр хийгээд явах боломжтой иргэд халамжийн үйлчилгээнд хамрагдах сонирхол ихсэж худал бичиг баримт бүрдүүлдэг байна.

Олон хүүхэдтэй нөхрөөсөө салсан гэж бичиг баримт бүрдүүлэн халамжид хамрагдсан байдаг, залуучууд халамжийн үйлчилгээнд хамрагдах сонирхолтой болсон.[129]

Энэ мэтчилэн үйлчилгээ үзүүлж байгаа байгууллага, үйлчилгээ авах сонирхолтой иргэдэд төрийн бодлого, хяналтыг нэмэгдүүлэх, иргэд олон нийтийн тусламж үзүүлэх оролцоог дэмжих эрх зүйн орчныг бүрдүүлэх, түр байрлуулан асрамжлах үйлчилгээг цэгцлэх хууль хоорондын уялдаа холбоог хангах шаардлага үүсээд байна.

Халамж, хамгааллын бодлого нийгмийн эмзэг хэсгийн суурь хэрэгцээг хангах, тохиолдсон хүндрэлтэй асуудлыг шийдвэрлэхэд төр дангаар оролцохоос илүүтэй олон нийтийн оролцоог хангасан бодлого шийдвэрийг гарган түүндээ сөрөг хандлага буюу эмзэг байдлыг далимдуулан туслах нэртэй хүний эрхэнд халдах байдлаас хамгаалах шийдвэрийг гарган хэрэгжүүлэх нь төсөв болон үйл ажиллагааг хөнгөлөх, хөгжлийг хурдасгах ач холбогдолтой хэмээн бусад улс орон хэрэгжүүлдэг байна.

Тухайлбал, Англи улсад 2011 оноос олон нийтийн оролцоотой халамжийн үйл ажиллагаанд хувийн болон төрийн зүгээс тэнцвэртэй байдлыг хадгалж буй нь хөгжлийг хурдасгах явдал хэмээн үзсэн байна.[130] АНУ-д олон нийтийн халамжийн түүх нь улс орны байнгын өсөлт, хөгжлийн нэг мөн бөгөөд 1900 оноос орон нутгийн Засгийн газар хувийн буяны байгууллагатай хамт олон нийтийн туслалцаа "нийтийн тусламж" үзүүлэх томоохон үүрэг хүлээдэг[131] байсан. Харин сүүлийн үед олон нийтийн тусламж үйлчилгээг гутаан доромжлол гэж үздэг болсон бөгөөд хамрагдахаас аль болох зайлсхийдэг байна.[132] Австралийн Засгийн газраас албан бус үйлчилгээ нь албан ёсны халамжийн үйлчилгээ үзүүлэх бөгөөд албан бус үйлчилгээ нь бусад албан ёсны дэмжлэг үзүүлэх үйлчилгээний эрэлтийг бууруулдаг[133] гэж үзжээ.

3.2. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний талаарх эрх зүйн зохицуулалт

Манай улсад Нийгмийн халамжийн багц хууль анх 1995 онд батлагдсанаар нийгмийн зүгээс зайлшгүй дэмжлэг туслалцаа үзүүлбэл зохих бие даан амьдрах, өөртөө үйлчлэх чадваргүй эмзэг бүлгийн иргэдийг төр ивээлдээ авч, тэдний амьдралын баталгааг алдагдуулахгүй байх зорилготой нийгмийн халамжийн тогтолцоо бий болсон. Үүнээс хойш Нийгмийн халамжийн хуулийг 1998, 2005, 2012

[128] Г.Загдаа эмзэг бүлгийн иргэдийн 600 гаруй саяыг завшжээ. https://www.urug.mn/news/1048

[129] БЗД-ийн хяналтын албаны мэргэжилтэн Ч.Гүндсамбуу /ярилцлагын хэсгээс/

[130] Public and Private Welfare Activity in England http://sticerd.lse.ac.uk/dps/case/cp/casepaper193.pdf June 2016

[131] Origins of the State and Federal Public Welfare Programs By John E. Hansan, Ph.D. https://socialwelfare.library.vcu.edu/public-welfare/origins-of-the-state-federal-public-welfare-programs/

[132] How to improve participation in social assistance programs https://wol.iza.org/uploads/articles/104/pdfs/how-to-improve-participation-in-social-assistance-programs.pdf

[133] Understanding welfare and wellbeing https://www.aihw.gov.au/reports/australias-welfare/understanding-welfare-and-wellbeing Release Date: 11 Sep 2019

онд шинэчлэн найруулж, 2000, 2008 онд нэмэлт, өөрчлөлт оруулж байжээ.[134]

2005 онд батлагдсан Нийгмийн халамжийн тухай хуульд анх удаа олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг хуульчлан өгснөөр нийгмийн дэмжлэг туслалцаа шаардлагатай иргэдийн нэн тэргүүний хэрэгцээнд үндэслэсэн нийгмийн халамжийн шинэ үйлчилгээ болон хэрэгжиж эхэлсэн.

Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2012 оны 1 сарын 19-ний өдөр батлагдан, 2012 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс дагаж мөрдөх болсон бөгөөд энэхүү хуулиар олон нийтийн оролцоонд түшиглэсэн нийгмийн халамжийн үйлчилгээ нь иргэн, аж ахуйн нэгж (ААН), төрийн бус байгууллага (ТББ)-ын оролцоотойгоор 12 бүлгийн өрх, иргэнд арван төрлийн дэмжлэг туслалцаа, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг тусгаж өгсөн байна.

Монгол Улсын хэмжээнд хүчин төгөлдөр нийт 10180[135] эрх зүйн акт байгаагаас олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд чиглэсэн харилцааг зохицуулан үйлчилж буй дараах хууль тогтоомж байна.

- Хууль 32
- Улсын Их Хурлын тогтоол 5
- Засгийн газрын тогтоол 9
- Сайдын тушаал 7
- Бусад эрх зүйн акт үйлчилж байна. (хавсралт 1)

Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ гэж иргэн, аж ахуйн нэгж төрийн болон төрийн бус байгууллагын оролцоотойгоор өрх, иргэнд дэмжлэг туслалцаа, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг[136] хэлэх бөгөөд Монгол Улсын нийгмийн халамжийн хуулиудад үйлчилгээний төрөл, хяналт, оролцоог дараах байдлаар тусгаж хэрэгжүүлж ирсэн байна. Тодруулбал:

Анх 2005 оны Нийгмийн халамжийн тухай хуулийн 26 дугаар зүйлд[137] Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд:

- Амьдралын итгэл үнэмшил, хөдөлмөрийн дадал олгох, авьяасыг нь дэмжих зорилгоор зөвлөгөө өгөх, сургалт зохион байгуулах;
- Зохион байгуулалттайгаар хөдөлмөр эрхлүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох зэргээр ядуурлаас гарахад нь туслах, энэ чиглэлээр хэрэгжих төсөл, хөтөлбөрүүдэд зуучлан хамруулах;
- Сэргээн засах үйлчилгээнд хамруулах;
- Түр байрлуулан асрамжлах;
- Гэрийн асрамж, халамжийн үйлчилгээнд хамруулах зэрэг 5-н төрлийн үйлчилгээг тусгасан байна.

Тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.9 дэх хэсэгт “Нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь нийгмийн халамж үйлчилгээний анхан, дунд шатны байгууллагын үйл ажиллагааны талаар мэргэжлийн зөвлөгөө өгөх, нөхцөлт мөнгөн тэтгэмж, мөнгөн тусламж болон нийгмийн халамжийн зориулалттай хөрөнгийн, зээлийн, хандивын зарцуулалтад хяналт тавих, хууль тогтоомж зөрчсөн этгээдэд хариуцлага ногдуулах саналаа энэ хуулийн 6.8-д заасан байгууллагад тавих чиг үүрэг бүхий хяналт, шинжилгээ, үнэлгээний нэгжтэй байж болно”, 6.10 дахь хэсэгт “Аймаг, дүүргийн нийгмийн халамж үйлчилгээний байгууллага хяналт,

[134] Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл http://mlsp.gov.mn/nnews/431 сүүлд үзсэн 2020.5.25

[135] Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем дэх эрх зүйн акт. http://legalinfo.mn/ сүүлд үзсэн 2020.5.25.

[136] Нийгмийн халамжийн тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл №, (2012)

[137] Нийгмийн халамжийн тухай хууль /2012 оны 1 дүгээр сарын 19-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/, (2005)

шинжилгээ, үнэлгээний асуудал хариуцсан ажилтантай байж болно”, 10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсэгт Нийгмийн ажилтан дор дурдсан эрх эдэлнэ хэмээн 10.4.1 дэх заалтад “олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэх байгууллага, иргэнийг сонгоход оролцох, үйл ажиллагаа, үйлчилгээнийх нь чанарт хяналт, үнэлгээ хийх;” гэх зэргээр хяналтын тогтолцоог хэн хэрхэн хэрэгжүүлэх талаар заасан байна.

Үүнээс үзвэл 2005 оны хуульд Нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон аймаг, дүүргийн нийгмийн халамжийн байгууллагад хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх нэгжтэй байж болно хэмээн эрх олгосон зохицуулалт оруулан анхан шатны хяналтыг нийгмийн ажилтан хэрэгжүүлэхээр заасан нь харагдаж байна.

Харин одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Нийгмийн халамжийн тухай хуульд Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг 10 төрөл болгон өргөжүүлэн хуульчилсан байна. Үүнд:

1. Амьдралын итгэл үнэмшил, бие даан амьдрах чадвар, хөдөлмөрийн дадал олгох, авьяасыг нь дэмжих зорилгоор сургалт зохион байгуулах;
2. Зөвлөгөө өгөх;
3. Сэргээн засах үйлчилгээнд хамруулах;
4. Түр байрлуулан асрамжлах, хүчирхийлэлд өртсөн хүнийг түр хамгаалан байрлуулах;
5. Өдрийн үйлчилгээнд хамруулах;
6. Гэрийн асрамж, халамжийн үйлчилгээнд хамруулах;
7. Иргэн, түүний гэр бүлийн хэрэгцээнд тулгуурласан нийгмийн халамжийн бусад үйлчилгээ үзүүлэх;
8. Гэр оронгүй иргэн, түүний гэр бүлийн гишүүдийн амьдрах итгэлийг нэмэгдүүлэх, нийгэмшүүлэх, бичиг баримтжуулах, түр хоноглох байранд байрлуулах;
9. Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай нийгмийн халамжийн тухай хуулийн 3.1.2, 18.2-т заасан өрх, иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухаанд сургах;
10. Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг түр хамгаалан байрлуулах үйлчилгээнд хамруулах зэрэг үйлчилгээг тухайн аймаг, дүүргийн орон нутгийн төсвөөс санхүүжүүлэн ААН, ТББ-аар гүйцэтгүүлдэг бөгөөд нийгмийн халамжийн хяналтын мэргэжилтнүүдээс үйлчилгээ үзүүлж буй ААН, ТББ-д хяналт тавьж ажилладаг байна.

3.3. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний төсөв, санхүүжилт

3.3.1.Улсын хэмжээнд олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд зарцуулсан зардал

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны өгсөн мэдээллээс үзэхэд улсын хэмжээнд олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд 2011 онд 3340.6 сая, 2012 онд 3450.6 сая, 2013 онд 5087.7 сая, 2014 онд 7184.6 сая, 2015 онд 1684.1 сая, 2016 онд 1266.5 сая, 2017 онд 651.2 сая, 2018 онд 3617.7 сая, 2019 онд 1696.6 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Доорх зурагт улсын хэмжээнд 2011-2019 онд ОНОТХҮ-нд зарцуулсан зардлыг харьцуулан харуулав.

Хуулийн үндэсний хүрээлэн www.nli.gov.mn

График. *Улсын хэмжээнд 2011-2019 онд ОНОТХУ-нд зарцуулсан зардлын харьцуулалт (сая.төг)*



Улсын дүнгээс үзэхэд 2014, 2013, 2018 онуудад ОНОТХУ-ний зардал хамгийн өндөр байсан бол 2015-2017 онд энэ төрлийн задал хамгийн бага байсан нь харагдаж байна.

Харин улсын хэмжээнд 2019 онд ОНОТХУ-ний зардалд 1,913,407,300 төгрөг төсөвлөснөөс 1,696,600,000 орчим төгрөг зарцуулсан бөгөөд төсвийн бодит зарцуулалт төсвөөс 216.8 сая орчим төгрөгөөр дутуу байв. Улсын хэмжээнд 2019 оны ОНОТХУ-ний төсөв болон төсвийн зарцуулалтыг доорх зурагт харьцуулан харуулав.

График. *ОНОТХУ-ний 2019 оны төсөв болон төсвийн зарцуулалтын харьцуулалт (сая.төг)*



Энэхүү мэдээллийг нарийвчлан дүгнэж үзвэл улсын хэмжээнд ОНОТХУ-ний төсвийг 2019 онд Өвөрхангай аймаг 2.1 дахин бага зарцуулсан, Хөвсгөл аймаг 1.9 дахин бага зарцуулсан нь нь хамгийн бага хувиар зарцуулсан аймгууд байсан бол Улаанбаатар хотын хэмжээнд 1.2 дахин бага зарцуулсан боловч дутуу зарцуулсан дүнгээрээ хамгийн их буюу 147.4 сая төгрөг байжээ. Харин Сүхбаатар аймаг тус онд ОНОТХУ-ний төсвөө 2.9 дахин илүү зарцуулсан, Сэлэнгэ аймаг 2.4 дахин их зарцуулсан нь хамгийн их дүнгээр давуулан зарцуулсан аймгууд байжээ.

Харин 2018 онд улсын хэмжээнд нэг үйлчлүүлэгчид оногдох ОНОТХУ-ний дундаж зардал 170,485 төгрөг байсан бол 2019 онд дундаж зардал 110,932 төгрөг болж буурсан байна.

3.3.2.Нийслэлийн олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний зардал

Нийслэлийн хэмжээнд ОНОТХУ-ний зардалд 2018 болон 2019 онд ижилхэн 1,081,883 төгрөгийн зардлыг төсөвлөсөн бөгөөд эдгээрийг дүүргээр ангилж үзвэл

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХУРЭЭЛЭН www.ali.gov.mn

2018 онд Баянгол дүүрэгт 110,664, Баянзүрх дүүрэгт 256,424, Чингэлтэй дүүрэгт 140,688, Сүхбаатар дүүрэгт 101,802, Сонгинохайрхан дүүрэгт 209,824, Хан-Уул дүүрэгт 90,957, Багануур дүүрэгт 66,477, Багахангай дүүрэгт 45,490, Налайх дүүрэгт 59,557 төгрөгийг тус тус төсөвлөсөн бол, 2019 онд Баянгол дүүрэгт 103,498, Баянзүрх дүүрэгт 265,291, Чингэлтэй дүүрэгт 136,543, Сүхбаатар дүүрэгт 98,522, Сонгинохайрхан дүүрэгт 204,825, Хан-Уул дүүрэгт 116,903, Багануур дүүрэгт 60,590, Багахангай дүүрэгт 41,462, Налайх дүүрэгт 54,249 төгрөгийг тус тус төсөвлөсөн байна. Үүнийг харьцуулан доорх зурагт харуулав. Үүнд:

График. *Нийслэлийн ОНОТХУ-ний зардал дүүргээр (сая.төг)*



Харин нийслэлийн хэмжээнд 2018 онд ОНОТХУ-ний бүлгийн төслөөс бусад зардалд 626,413,350 төгрөгийг зарцуулсан бол 2019 онд энэ төрлийн зардалд 618,088,700 төгрөгийг зарцуулсан нь 1.33 хувь буюу 8,324,650 төгрөгөөр багассан байна. Ийнхүү багассан нь сэргээн засах үйлчилгээ болон өдрийн үйлчилгээний зардал тус тус багассанаас шалтгаалсан бөгөөд бусад бүх үйлчилгээний зардал дунджаар 33 орчим хувиар өссөн боловч нийт зардалд эзлэх хувь бага байсан тул нөлөөлөл нь бага байжээ (дэлгэрэнгүйг доорх хүснэгтээс үзнэ үү).

Хүснэгт 6*. Нийслэлийн ОНОТХУ-ний зарцуулалт болон үйлчлүүлсэн иргэдийн харьцуулалт (2018, 2019 он)*

№	Үйлчилгээний төрөл	2018	2019
		Зарцуулалт	Зарцуулалт
1.	Амьдралын итгэл үнэмшил, бие даан амьдрах чадвар, хөдөлмөрийн дадал олгох, авьяасыг нь дэмжих зорилгоор сургалт зохион байгуулах	25,421,300	39,132,600
2.	Зөвлөгөө өгөх	7,293,000	24,342,000
3.	Сэргээн засах үйлчилгээнд хамруулах	345,239,500	274,141,000
4.	Түр байрлуулан асрамжлах	14,318,100	21,939,100
5.	Өдрийн үйлчилгээнд хамруулах	44,425,250	47,919,500
6.	Гэрийн асрамж, халамжийн үйлчилгээнд хамруулах	31,786,300	18,725,900
7.	Гэр оронгүй иргэн, түүний гэр бүлийн гишүүдийн амьдрах итгэлийг нэмэгдүүлэх, нийгэмшүүлэх, бичиг баримтжуулах, түр хоноглох байранд байрлуулах	157,929,900	191,888,600
	НИЙТ	626,413,350	618,088,700

Дээрх хүснэгтээс үзэхэд 2018 онд нийслэлийн хэмжээнд 5,118 иргэд, 2019 онд 5,652 иргэд үйлчлүүлсэн бөгөөд үйлчлүүлсэн иргэдийн тоо 10 орчим хувиар өссөн үзүүлэлттэй байх боловч нэг үйлчлүүлэгчид оногдох дундаж зардал 2018 онд 122,394 орчим төгрөг байсан нь 2019 онд 109,358 орчим төгрөг болж буурсан нь нийслэлийн хэмжээнд ОНОТХУ-ний зардлын зарцуулалт багасахад илүү хүчтэй нөлөөлсөн гэж үзэж болохоор байна.

ХУУЛЬ ЗҮЙН ЯАМНЫ ХУРЭЭЛЭН www.ardsem.mn

Нийслэлийн ОНОТХУ-ний 2018 оны зардлыг дүүргүүдээр ангилж доорх хүснэгтэд дэлгэрэнгүй харуулав. Үүнд:

Хүснэгт 7. *Нийслэлийн ОНОТХУ-ний 2018 оны зардлын төсөв, дүүргээр (мян.төг)*

Дүүргийн нэр	Баянгол	Баянзүрх	Чингэлтэй	Сүхбаатар	Сонгино хайрхан	Хан-Уул	Багануур	Багахангай	Налайх	Дүн
Сургалт зохион байгуулах	6,397	9,825	7,034	5,885	10,491	4,548	3,843	2,629	3,443	**54,094**
Зөвлөгөө өгөх	6,397	9,825	7,034	5,885	10,491	4,548	3,843	2,629	3,443	**54,094**
Сэргээн засах үйлчилгээнд хамруулах	38,381	58,948	42,206	35,307	62,947	27,287	23,056	15,777	20,656	**324,565**
Түр байрлуулан асрамжлах	6,397	9,825	7,034	5,885	10,491	4,548	3,843	2,629	3,443	**54,094**
Өдрийн үйлчилгээнд хамруулах	6,397	9,825	7,034	5,885	10,491	4,548	3,843	2,629	3,443	**54,094**
Гэрийн асрамж, халамжийн үйлчилгээнд хамруулах	6,397	9,825	7,034	5,885	10,491	4,548	3,843	2,629	3,443	**54,094**
Гэр оронгүй иргэдийн амьдрах итгэлийг нэмэгдүүлэх, нийгэмшүүлэх, бичиг баримтжуулах, түр хоноглох байранд байрлуулах;	1,919	89,403	21,103	1,765	31,474	13,644	1,153	789	1,033	**162,282**
Бүлгийн төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухаанд сургах	38,381	58,948	42,206	35,307	62,947	27,287	23,056	15,777	20,656	**324,565**
НИЙТ ДҮН	110,666	256,424	140,685	101,804	209,823	90,958	66,480	45,488	59,560	**1,081,882**

Нийслэлийн 2019 оны ОНОТХУ-ний зардлыг дүүргүүдээр ангилж доорх хүснэгтэд дэлгэрэнгүй харуулав. Үүнд:

Хүснэгт 8. *Нийслэлийн ОНОТХУ-ний 2019 оны зардлын төсөв, дүүргээр (мян.төг)*

Дүүргийн нэр	Баянгол	Баянзүрх	Чингэлтэй	Сүхбаатар	Сонгино хайрхан	Хан-Уул	Багануур	Багахангай	Налайх	Дүн
Сургалт зохион байгуулах	5,500	12,820	7,035	5,500	10,491	5,500	3,320	2,275	2,980	**55,421**
Зөвлөгөө өгөх	4,400	10,256	5,627	4,400	8,392	4,400	2,660	1,820	2,382	**44,337**
Сэргээн засах үйлчилгээнд хамруулах	41,076	56,949	42,206	40,307	59,947	32,000	23,055	15,776	20,655	**331,971**
Түр байрлуулан асрамжлах	3,320	7,692	4,220	3,055	6,295	2,728	1,995	1,365	1,786	**32,456**

ХУУЛЬЗҮЙН ҮНДЭСНИЙ ХУРААНГУЙ www.nli.gov.mn

Өдрийн үйлчилгээнд хамруулах	6,396	9,824	7,035	5,885	9,900	4,547	3,845	2,630	3,445	**53,507**
Гэрийн асрамж, халамжийн үйлчилгээнд хамруулах	3,320	9,800	4,220	3,055	9,800	2,728	1,995	1,365	1,786	**38,069**
Гэр оронгүй иргэдийн нийгэмшүүлэх, бичиг баримтжуулах, түр хоноглох байранд байрлуулах;	1,106	99,000	24,000	1,020	35,000	35,000	665	455	560	**196,806**
Бүлгийн төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухаанд сургах	38,380	58,950	42,200	35,300	65,000	30,000	23,055	15,776	20,655	**329,316**
Нийт	**103,498**	**265,291**	**136,543**	**98,522**	**204,825**	**116,903**	**60,590**	**41,462**	**54,249**	**1,081,883**

Нийслэлийн ОНОТХУ-ний 2018 болон 2019 оны зардлын төсвийг харьцуулж үзвэл сэргээн засах үйлчилгээнд хамруулах үйлчилгээ, гэр оронгүй иргэн, түүний гэр бүлийн гишүүдийн амьдрах итгэлийг нэмэгдүүлэх, нийгэмшүүлэх, бичиг баримтжуулах, түр хоноглох байранд байрлуулах үйлчилгээний болон бүлгийн төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухаанд сургах үйлчилгээний төсөв аль аль онд илүү өндөр байна.

Түүнчлэн хүн ам ихтэй Баянзүрх, Сонгинохайрхан дүүргүүдэд ОНОТХУ-ний зардал ерөнхийдөө харьцангуй өндөр, бусад дүүргүүдийн дундаас Чингэлтэй болон Баянгол дүүргийн зардал харьцангуй өндөр байх бөгөөд нийт дүүргүүдийн хувьд амьдралын итгэл үнэмшил, бие даан амьдрах чадвар, хөдөлмөрийн дадал олгох, авьяасыг нь дэмжих зорилгоор сургалт зохион байгуулах, зөвлөгөө өгөх, түр байрлуулан асрамжлах, өдрийн үйлчилгээнд хамруулах, гэрийн асрамж, халамжийн үйлчилгээнд хамруулах үйлчилгээнүүдийн зардал жигд хэмжээнд харьцангуй бага байгаа нь ажиглагдаж байна.

Нийслэлийн дүүргүүдийн ОНОТХУ-ний зардлын төрөл бүрээр ангилж үзвэл мөн л бүх төрөлд Баянзүрх, Сонгинохайрхан дүүргүүд илүү өндөр, үүний дотор Баянзүрх дүүргийн гэр оронгүй иргэн, түүний гэр бүлийн гишүүдийн амьдрах итгэлийг нэмэгдүүлэх, нийгэмшүүлэх, бичиг баримтжуулах, түр хоноглох байранд байрлуулах үйлчилгээний хувьд Баянзүрх дүүрэг 2 дугаарт бичигдсэн өндөр (2018 онд 31.5 сая, 2019 онд 35.3 сая төгрөгийн) зардалтай Сонгинохайрхан дүүргийнхээс аль аль онд ойролцоогоор 2.8 дахин өндөр (2018 онд 89.4 сая, 2019 онд 99 сая төгрөгийн) төсөвтэй байгаа нь анхаарал татаж байв.

Харин Сонгинохайрхан, Баянзүрх дүүргүүдээс бусад дүүргүүдийн хувьд Чингэлтэй дүүрэг харьцангуй өндөр зардалтай байсан бол үүний дараа Баянгол, Хан-Уул дүүргүүд ОНОТХУ-ний зардлаараа 2018 болон 2019 онуудад 4 болон 5-т жагсахаар өндөр зардалтай байсан байна. Хан-Уул дүүргийн хувьд 2018 онд Баянгол дүүргээс бага төсөвтэй, 2019 онд илүү төсөвтэй байсан боловч хоёр оны зардлын нийт дүнгээрээ Баянгол дүүрэг 4, Хан-Уул дүүрэг 5- жагссан байна.

Нийслэлийн ОНОТХУ-ний 2018 болон 2019 оны зардлын төсвийг харьцуулсан үр дүнг доорх зурагт харуулав.

Хүний нөөцийн хөгжлийн яам www.hrd.gov.mn

График. *Нийслэлийн ОНОТХУ-ний 2018 болон 2019 оны зардлын төсвийн харьцуулалт, дүүргээр (сая.төг)*





ХУУЛЬ ЗҮЙН ЯАМЫН ХУРААЛЭН
www.mli.gov.mn

3.3.3.Баянзүрх дүүргийн олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний зардлын зарцуулалт

Баянзүрх дүүрэг нь ОНОТХУ-ний хувьд 2018 болон 2019 онуудад нийслэлийн бусад дүүргүүдээс хамгийн өндөр төсөвтэй дүүрэг байсан бөгөөд байна. Тус дүүргийн хувьд 2019 онд ОНОТХУ-нд нийт 180,557,400 төгрөг зарцуулснаас сургалт зохион байгуулахад 4.73 хувийг, зөвлөгөө өгөхөд 2.52 хувийг, сэргээн засах үйлчилгээнд хамруулахад 30.97 хувийг, түр байршуулан асрамжлахад 3.05

хувийг, өдрийн үйлчилгээнд хамруулахад 6.27 хувийг, гэрийн асрамж, халамжийн үйлчилгээнд хамруулахад 1.22 хувийг, гэр оронгүй иргэн, түүний гэр бүлийн гишүүдийн амьдрах итгэлийг нэмэгдүүлэх, нийгэмшүүлэх, бичиг баримтжуулах, түр хоноглох байранд байрлуулахад хамгийн их буюу 51.25 хувийг тус тус зарцуулсан байна. Үүнийг доорх хүснэгтэд дэлгэрэнгүй харууллаа. Үүнд:

Хүснэгт. *БЗД-ийн 2019 оны ОНОТХҮ-ний зардлын зарцуулалт*

Д/д	Үйлчилгээний төрөл	ТББ	ХХК	Нийт байгууллага	Гүйцэтгэсэн үйлчилгээний тоо	Үйлчилгээний дүн
1	Сургалт зохион байгуулах	2	-	2	415	8,542,100
2	Зөвлөгөө өгөх	2	-	2	142	4,542,000
3	Сэргээн засах үйлчилгээнд хамруулах	1	4	5	316	55,914,500
4	Түр байршуулан асрамжлах	1	-	1	4	5,506,800
5	Өдрийн үйлчилгээнд хамруулах	1	2	3	190	11,322,000
6	Гэрийн асрамж, халамжийн үйлчилгээнд хамруулах	1	-	1	11	2,200,000
7	Гэр оронгүй иргэн, түүний гэр бүлийн гишүүдийн амьдрах итгэлийг нэмэгдүүлэх, нийгэмшүүлэх, бичиг баримтжуулах, түр хоноглох байранд байрлуулах	4	-	4	323	92,530,000
	Нийт	**12**	**6**	**18**	**1,401**	**180,557,400**

Дээрх хүснэгтээс үзэхэд БЗД нь 2019 онд нийт 1,401 хүнд 180,557,400 төгрөгийн ОНОТХҮ-г 18 байгууллагаар дамжуулан үзүүлсэн бөгөөд нэг үйлчлүүлэгчид дунджаар 128,877.52 төгрөгийн үйлчилгээ үзүүлсэн нь мөн онд нийслэлийн хэмжээнд нэг үйлчлүүлэгчид үзүүлсэн үйлчилгээний дундаж зардлаас 20 орчим мянган төгрөгөөр, улсын хэмжээнд нэг үйлчлүүлэгчид үзүүлсэн үйлчилгээний дундаж зардлаас 28 орчим мянган төгрөгөөр өндөр байна.

Улсын хэмжээнд 2019 онд ОНОТХҮ-ний зардалд 1,913,407,300 төгрөг төсөвлөснөөс 1,696,600,000 орчим төгрөг зарцуулсан бол БЗД-ийн ОНОТХҮ-ний зардал нь улсын хэмжээний зардлын 10 орчим хувийг, нийслэлийн ОНОТХҮ-ний зардлын 19 орчим хувийг эзэлж байна. Улсын хэмжээний ОНОТХҮ-ний зардлаас БЗД-ийн ОНОТХҮ-ний зардлын эзлэх хувь хэмжээг доор зурагт дэлгэрэнгүй харуулав. Үүнд:

хүний эрхийн үндэсний хүрээлэн www.nhrc.gov.mn

График. *Улсын хэмжээний ОНОТХУ-ний зардлаас БЗД-ийн ОНОТХУ-ний зардлын эзлэх хувь хэмжээ*



Дээрх зургаас үзэхэд БЗД нь 2019 онд гэр орогнүй иргэн, түүний гэр бүлийн гишүүдийн амьдрах итгэлийг нэмэгдүүлэх, нийгэмшүүлэх, бичиг баримтжуулах, түр хоноглох байранд байрлуулахад ОНОТХУ-ний зардлаас хамгийн их буюу 51.25 хувийг зарцуулсан нь улсын хэмжээнд зарцуулсан ОНОТХУ-ний зардлын 5 орчим хувийг, сэргээн засах үйлчилгээнд хамруулахад ОНОТХУ-ний зардлын 30.97 хувийг зарцуулсан нь улсын хэмжээнд зарцуулсан ОНОТХУ-ний зардлын 3 орчим хувийг эзэлж байжээ.

ДӨРӨВ. ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦООНД ТҮШИГЛЭСЭН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ ХИЙХ ҮНЭЛГЭЭ

Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг судлах явц нь агуулгын хувьд чухал ач холбогдолтой нөлөөлөл үзүүлэх хамгийн гол зохицуулалтыг тодорхойлоход чиглэнэ. Үнэлгээний өмнөх хэсэгт авч үзсэнчлэн олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжид хамрагдах өрх иргэнд үйлчилгээг үзүүлэхэд тулгамдаж буй асуудлыг тодруулан, хууль тогтоомжийн холбогдох зүйл, заалтын хэрэгжилтийг үнэлэв.

4.1. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжид хамрагдах өрх иргэнд үзүүлж буй үйлчилгээний төрөл, хэлбэр

ХУУЛЬЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

Нийгмийн халамжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 18 дугаар зүйлийн 2 дахь хэсэг

Үнэлгээний зүйл 1.

18 дугаар зүйл.Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ
18.1.Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ нь дараах төрөлтэй байна:
18.1.1.амьдралын итгэл үнэмшил, бие даан амьдрах чадвар, хөдөлмөрийн дадал олгох, авьяасыг нь дэмжих зорилгоор сургалт зохион байгуулах;
18.1.2.зөвлөгөө өгөх;
18.1.3.сэргээн засах үйлчилгээнд хамруулах;
18.1.4.түр байрлуулан асрамжлах, хүчирхийлэлд өртсөн хүнийг түр хамгаалан байрлуулах;
/Энэ заалтад 2016 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/
18.1.5.өдрийн үйлчилгээнд хамруулах;
18.1.6.гэрийн асрамж, халамжийн үйлчилгээнд хамруулах;
18.1.7.иргэн, түүний гэр бүлийн хэрэгцээнд тулгуурласан нийгмийн халамжийн бусад үйлчилгээ үзүүлэх;
18.1.8.гэр оронгүй иргэн, түүний гэр бүлийн гишүүдийн амьдрах итгэлийг нэмэгдүүлэх, нийгэмшүүлэх, бичиг баримтжуулах, түр хоноглох байранд байрлуулах;
18.1.9.нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай энэ хуулийн 3.1.2, 18.2-т заасан өрх, иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухаанд сургах.
18.1.10.гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг түр хамгаалан байрлуулах үйлчилгээнд хамруулах.
/Энэ заалтыг 2016 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар нэмсэн/
18.2.Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд дараах өрх, иргэн хамрагдана:
18.2.1.ахмад настан;
18.2.2.хөгжлийн бэрхшээлтэй иргэн;
18.2.3.эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд
/Энэ заалтыг 2016 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/
18.2.4.хүчирхийлэлд өртсөн иргэн;
18.2.5.хорих ангиас суллагдсан иргэн;
18.2.6.согтуурах, мансуурах донтох өвчтэй иргэн;
18.2.7.эдгэшгүй хүнд өвчтэй хүн;
18.2.8.гэр оронгүй тэнэмэл амьдралтай өрх, иргэн;
18.2.9.шилжин суурьшсан энэ хуулийн 3.1.2-т заасан өрхийн гишүүн-иргэн, иргэн;
18.2.10.өрх толгойлсон эх /эцэг/.
18.2.11.хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй өрх.
/Энэ заалтыг 2013 оны 2 дугаар сарын 07-ны өдрийн хуулиар нэмсэн/
18.2.12.гурав болон түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн хүүхэд.
/Энэ заалтыг 2017 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн хуулиар нэмсэн/

<u>Шалгуур үзүүлэлт.</u> Хүлээн зөвшөөрөгдсөн байдал

Уг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1 дэх заалтад заасан “Амьдралын итгэл үнэмшил, бие даан амьдрах чадвар, хөдөлмөрийн дадал олгох, авьяасыг нь дэмжих” зорилгоор 1/ Амьдрах ухааны болон бие даан амьдрах ур чадвар эзэмшүүлэх, 2/ Хөдөлмөрийн дадал олгох, авьяасыг нь дэмжих зорилгоор сургалт зохион байгуулах, 3/ Амьдралын итгэл үнэмшил бий болгох сургалт зохион байгуулах гэсэн үйлчилгээний чиглэлтэй байх бол үйлчилгээний хэлбэрийг дараах байдлаар зохион байгуулдаг байна. Үүнд:

1. Өөртөө итгэх итгэл, өөрийгөө үнэлэх үнэлэмж бий болгох;

2. Зорилтот бүлгийн гэр бүлийн гишүүдэд зориулсан сургалт зохион байгуулах;

3. Өдөр тутмын амьдралын дарамт, стрессийг даван туулах чадварыг бий болгох;

4. Эрүүл амьдралын хэв маягт хэвшүүлэх;

хуулийн мэдээллийн үндэсний сан www.mli.gov.mn

5. Тодорхой бэрхшээл, эрсдэлээс зайлсхийх, даван туулах, урьдчилан сэргийлэх чадварыг бий болгох;

6. Мэргэжлийн чиг баримжаа олгох зэрэг сургалт хамаарах юм.

Эдгээр үйлчилгээнд дараах өрх, иргэн хамруулдаг.

1. Ахмад настан;

2.Хөгжлийн бэрхшээлтэй иргэн

3. Хүчирхийлэлд өртсөн иргэн;

4. Хорих ангиас суллагдсан иргэн;

5. Согтуурах, мансуурах донтох өвчтэй иргэн;

6. Гэр оронгүй тэнэмэл амьдралтай өрх, иргэн;

7. Шилжин суурьшсан нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэн;

8. Өрх толгойлсон эх /эцэг/;

Нийгмийн халамжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 дахь заалтад заасан “Зөвлөгөө өгөх” үйлчилгээг хууль зүйн зөвлөгөө, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх чиглэлээр үзүүлдэг бөгөөд 1/ амьдралын асуудлаа өөрсдөө шийдвэрлэхэд туслах, 2/ тулгарч буй сэтгэл зүйн асуудал, бэрхшээлтэй нөхцөл байдлыг оношлон тогтоох, шийдвэрлэхэд нь мэргэжлийн тусламж, дэмжлэг үзүүлэх хэлбэрээр дараах өрх, иргэдийг хамруулдаг байна. Үүнд:

1. Ахмад настан;

2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн;

3. Хүчирхийлэлд өртсөн иргэн;

4. Хорих ангиас суллагдсан иргэн;

5.Согтуурах, мансуурах донтох өвчтэй иргэн;

6. Гэр оронгүй тэнэмэл амьдралтай өрх, иргэн;

7. Шилжин суурьшсан нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэн;

8. Өрх толгойлсон эх /эцэг/;

9. Эдгэшгүй хүнд өвчтэй иргэн

Уг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3 дахь заалтад заасан “Сэргээн засах” үйлчилгээг 1/эрүүл мэнд, 2/Боловсрол, 3/ Хөдөлмөр, 4/Нийгэм-сэтгэл зүйн чиглэлээр а/ Хэл, хөдөлгөөн, ахуйн, сэтгэл заслын үйлчилгээ үзүүлэх, б/ эзэмшсэн мэргэжлийг нь сэргээх, ур чадварыг нь сайжруулах, в/ алдагдсан чадварыг сэргээхэд чиглэсэн орчныг бүрдүүлэх, сэтгэл зүйн нөлөөллийг үзүүлэх, г/ нийгмийн зан үйл, нөлөөллийн аргуудыг ашиглах замаар хүмүүсийн харилцааны боломжит нөхцөлийг бүрдүүлэх, д/ Боловсрол эзэмших, хөдөлмөр эрхлэх боломжийг бүрдүүлэх, ахуйн үйлчилгээ үзүүлэх, шаардлагатай байгууллагын үйл ажиллагаанд хамруулах, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, сэтгэл засал хийх, сэтгэл санааны дэмжлэг үзүүлэх хэлбэрээр дээрх 9 чиглэлийн өрх, иргэдийг мөн адил хамруулдаг байна.

Нийгмийн халамжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.4 дэх заалтад заасан “Түр байрлуулан асрамжлах” үйлчилгээг 1/ хүчирхийлэлд өртөх магадлалтай иргэдийг урьдчилан сэргийлэх, 2/хүчирхийлэлд өртсөн иргэдэд стандартын дагуу үйлчилгээ үзүүлэх чиглэлээр а/ бичиг баримтжуулах, б/эрүүл мэндийн болон хууль зүйн үйлчилгээ үзүүлэх, в/ хөгжлийн дэмжлэг, туслалцаа үзүүлэх, г/ холбон зуучлах, д/ хүүхдэд бүх төрлийн үйлчилгээ үзүүлэх, е/халуун хоол цайгаар үйлчлэх хэлбэрээр дараах өрх, иргэдийг хамруулдаг байна. Үүнд:

1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн;

2. Хүчирхийлэлд өртсөн иргэн;

хүний эрхийн үндэсний комисс www.nhrcgov.mn

3. Хорих ангиас суллагдсан иргэн;

4.Согтуурах, мансуурах донтох өвчтэй иргэн;

5. Шилжин суурьшсан Нийгмийн халамжийн тухай хуулийн 3.1.2-т заасан өрхийн гишүүн -иргэн;

6. Хүнд нөхцөлд байгаа хүүхэд;

Уг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.5 дахь заалтад заасан "Өдрийн үйлчилгээ" нь ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэний чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, амьдралын чанарыг дээшлүүлэх, хүнд нөхцөлд байгаа хүүхдүүдийн эрхийг хамгаалах, нийгэмшүүлэх, амьдрах ухаанд сургах юм. Өөрөөр хэлбэл, 1/ахмад настны өдрийн үйлчилгээ, 2/ хүнд нөхцөлд байгаа хүүхдийн өдрийн үйлчилгээ, 3/ хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн өдрийн үйлчилгээ үзүүлэх, 4/ хөгжлийн бэрхшээлтэй иргэний өдрийн үйлчилгээг соёл, урлаг биеийн тамир спортын арга хэмжээнд оролцуулах, сэргээн засах, амьдрах ухаанд сургах, зөвлөгөө өгөх хэлбэрээр ахмад настан, хүнд нөхцөлд байгаа хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэн ба хүүхэд хамруулдаг байна.

Нийгмийн халамжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.6 дахь заалтад заасан "гэрийн асрамж, халамжийн үйлчилгээнд хамруулах" үйлчилгээг а/гэр ахуйн үйлчилгээ үзүүлэх, б/өдөр тутмын асаргааны үйлчилгээ үзүүлэх, в/гадуур ажилд туслах үйлчилгээ үзүүлэх, г/эрүүл мэнд, эмчилгээний дэглэм сахиулах, д/хоол хүнс бэлтгэх, хоолны дэглэм сахиулах, хооллож ундлах хэлбэрээр байнгын асаргаатай ахмад настан, байнгын асаргаатай хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүнд нөхцөлд байгаа хүүхэд гурвыг хамруулдаг.

Уг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.7 дахь заалтад заасан "иргэн, түүний гэр бүлийн хэрэгцээнд тулгуурласан нийгмийн халамжийн бусад үйлчилгээ үзүүлэх"-д өрх, иргэний амьдралын нөхцөл байдлыг өөрсдийнх нь оролцоотойгоор үнэлэх, өрх, иргэний нөөц боломж чадавхи хэрэгцээнд тохирох үйлчилгээг туршин хэрэгжүүлэх чиглэлээр өөрсдөө бие даан хөгжих боломжийг нь судалж, өрхийн нөхцөл байдлыг судлан үнэлэх, нөөц боломж, чадавхийг тодорхойлж, сэтгэл зүйн нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх, нийгмийн халамжийн болон хөгжүүлэх үйлчилгээ үзүүлэх хэлбэрээр дараах өрх, иргэдийг хамруулдаг байна. Үүнд:

1. Ахмад настан;

2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн;

3. Хүчирхийлэлд өртсөн иргэн;

4. Хорих ангиас суллагдсан иргэн;

5.Согтуурах, мансуурах донтох өвчтэй иргэн;

6. Гэр оронгүй тэнэмэл амьдралтай өрх, иргэн

7. Шилжин суурьшсан нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн -иргэн;

8. Эдгэшгүй хүнд өвчтэй иргэн;

9. Өрх толгойлсон эх /эцэг/;

Нийгмийн халамжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.9 дэх заалтад заасан "нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрх, иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухаанд сургах"-даа а/төсөл бичих, түүнийг хэрэгжүүлэх амьдрах ухааны сургалтад хамруулах, зөвлөгөө өгөх, б/хамт олны бүлэг бүрдүүлж орлого нэмэгдүүлэх, үйлдвэрлэл үйлчилгээний төсөл хэрэгжүүлэх, нийгэмшүүлэх чиглэлээр 1/төсөл бичих чадвартай болгох, 2/багаар ажиллах чадвартай болгох. 3/ тухайн төслөө хэрэгжүүлэхэд шаардлагатай ур чадвартай болгох, 4/тухайн төслийг цааш нь өргөжүүлэх санхүүгийн эх үүсвэртэй болох хэлбэрээр дараах өрх, иргэдийг хамруулдаг байна. Үүнд:

1. Ахмад настан;
2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн;
3. Хүчирхийлэлд өртсөн иргэн;
4. Хорих ангиас суллагдсан иргэн;
5.Согтуурах, мансуурах донтох өвчтэй иргэн;
6. Гэр оронгүй тэнэмэл амьдралтай өрх, иргэн;
7. Шилжин суурьшсан нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэн;
8. Өрх толгойлсон эх /эцэг/;
9. Эдгэшгүй хүнд өвчтэй иргэн

2016 онд "Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль" батлагдан дагаж мөрдөгдөх болсонтой холбогдуулан Нийгмийн халамжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.4 дэх заалт өмнө нь "...түр байрлуулах асрамжлах..." гэж байсныг 18 дугаар зүйлийн 18.1.4 дэх заалтын "асрамжлах" гэсний дараа ", хүчирхийлэлд өртсөн хүнийг түр хамгаалан байрлуулах" гэж нэмэн "...түр байрлуулан асрамжлах, хүчирхийлэлд өртсөн хүнийг түр хамгаалан байрлуулах..." болгосон юм.

Ийнхүү нэмэлт, өөрчлөлт оруулсан нь Нийгмийн халамжийн тухай хуулийг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуультай уялдуулах, хууль хоорондын уялдааг хангах алхам болсон хэдий ч давхардлыг бий болгосон гэж үзэж болохоор байгаа юм. Учир нь Нийгмийн халамжийн тухай хуулийн 18.1.4-т заасан "...түр байрлуулан асрамжлах, хүчирхийлэлд өртсөн хүнийг түр хамгаалан байрлуулах..." гэдэгт тус хуулийн 18.1.10-т заасан "... гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг түр хамгаалан байрлуулах үйлчилгээнд хамруулах..." ойлголт мөн адил хамаарч байгаа юм. Үүнийг Нийгмийн халамжийн тухай хуульд давхардуулан тусгажээ.

Мөн 18 дугаар зүйлийн 18.1.4-т заасан "...түр байрлуулан асрамжлах, хүчирхийлэлд өртсөн хүнийг түр хамгаалан байрлуулах..." зохицуулалтад 18 дугаар зүйлийн 18.1.8.гэр оронгүй иргэн, түүний гэр бүлийн гишүүдийн амьдрах итгэлийг нэмэгдүүлэх, нийгэмшүүлэх, бичиг баримтжуулах, түр хоноглох байранд байрлуулах үйлчилгээ давхардуулан зохицуулагдсан байна. Түр байрлуулан асрамжлах болон түр хоноглох байранд байлгах үйлчилгээ нь утгын хувьд адил зохицуулалт төдийгүй гэр оронгүй иргэн, түүний гэр бүлийн гишүүдийн амьдрах итгэлийг нэмэгдүүлэх, нийгэмшүүлэх, бичиг баримтжуулах үйлчилгээг үзүүлдэг байна.

Ахмад настан нь нийгмийн халамжийн тухай хуульд зааснаар олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд хамрагдахаас гадна төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамрагддаг байна. Гэсэн хэдий ч Ахмад настны тухай хуулийн 7 дугаар зүйлд "Ахмад настанд үзүүлэх үйлчилгээ нь дараах төрөлтэй байна" хэмээн лавлагаа мэдээллийн үйлчилгээ, зөвлөгөө өгөх үйлчилгээ, явуулын үйлчилгээ, өдрийн үйлчилгээ, сайн дурын үйлчилгээ, өдрөөр эмчлэх, асран сувилах үйлчилгээ, асрамжийн үйлчилгээ, хүнсний дэмжлэг үзүүлэх үйлчилгээ, гэр бүлийн хүчирхийллээс хамгаалагдах үйлчилгээ гэх 9-н төрлийн үйлчилгээг тусгаж өгсөн гэтэл эдгээр үйлчилгээнээс хүнсний дэмжлэг үзүүлэх үйлчилгээ, явуулын үйлчилгээнээс бусад үйлчилгээг нийгмийн халамжийн тухай хуультай давхардуулан хуульчилсан байна.

Ийнхүү дүгнэн үзвэл: Нийгмийн халамжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.4 дэх заалттай агуулгын хувьд давхардсан 18 дугаар зүйлийн 18.1.8 дахь заалтад гэр оронгүй иргэн, түүний гэр бүлийн гишүүдийн амьдрах итгэлийг нэмэгдүүлэх, нийгэмшүүлэх, бичиг баримтжуулах, түр хоноглох байранд байрлуулах үйлчилгээ болон 18 дугаар зүйлийн 18.1.10 дахь заалтад заасан "Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг түр хамгаалан байрлуулах үйлчилгээнд хамруулах" гэсэн давхардсан зохицуулалтыг хасах, мөн Ахмад настны тухай хуулийн 7 дугаар зүйлийг хуулийн

заалттай нийцүүлэх нь зүйтэй юм.

4.2. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний хяналт, оролцоо

Нийгмийн халамжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.8, 24 дүгээр зүйлийн 24.9 дэх хэсэг

Үнэлгээний зүйл 2

Нийгмийн халамжийн тухай хууль (шинэчилсэн найруулга)
24.8.Нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь нийгмийн халамжийн үйлчилгээний анхан, дунд шатны байгууллагад мэргэжлийн зөвлөгөө өгөх, тэтгэвэр, тэтгэмжийн олголт, үйлчилгээний чанар хүртээмж болон халамжийн сангийн хөрөнгийн зарцуулалтад хяналт тавих, шаардлагатай тохиолдолд энэ хуулийн 24.7-д заасан мэргэжлийн хяналтын байгууллагад хүсэлт гаргах чиг үүрэг бүхий хяналт, шинжилгээ, үнэлгээний нэгжтэй байна.
24.9.Аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага нь энэ хуулийн 24.8-д заасан чиг үүрэг бүхий ажилтантай байна.

Шалгуур үзүүлэлт. Практикт нийцсэн байдал

Хэрэгжиж байгаа эрэг үр дагавар: 2005 оны Нийгмийн халамжийн тухай хуульд эрх олгосон зохицуулалтыг уг хуулийн 24 дүгээр зүйлийн 8 дахь хэсэгт “Нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь нийгмийн халамжийн үйлчилгээний анхан, дунд шатны байгууллагад мэргэжлийн зөвлөгөө өгөх, тэтгэвэр, тэтгэмжийн олголт, үйлчилгээний чанар хүртээмж болон халамжийн сангийн хөрөнгийн зарцуулалтад хяналт тавих, шаардлагатай тохиолдолд энэ хуулийн 24.7-д заасан мэргэжлийн хяналтын байгууллагад хүсэлт гаргах чиг үүрэг бүхий хяналт, шинжилгээ, үнэлгээний нэгжтэй байна”, 9 дэх хэсэгт “Аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага нь энэ хуулийн 24.8-д заасан чиг үүрэг бүхий ажилтантай байна.” хэмээн заавал нэгж ажилтантай байхаар тусгаж өгсөн бөгөөд уг заалтаас үндэслэн хяналтыг хэрэгжүүлдэг байна.

Тодруулбал, Олон нийтийн оролцоот халамжийн үйлчилгээний хяналтыг нийгмийн халамжийн мэргэжилтнүүд ажиллаж буй шат шатандаа олон нийтийн, мэргэжлийн байгууллагын, гүйцэтгэлийн хяналтыг тавьдаг байна. Хорооны нийгмийн халамжийн мэргэжилтнүүд өдөр тутам үйл явцын хяналтыг үйлчилгээнд хамрагдсан иргэн, үйлчилгээг хэрэгжүүлэх байгууллага бүрээр тогтмол хийдэг бол дүүргийн нийгмийн халамжийн мэргэжилтэн стандартын биелэлт, хөрөнгийн зарцуулалт, гэрээний биелэлтийг хянадаг. Мөн нийгмийн халамжийн байгууллагын дотоод хяналтын албаныхан аймаг дүүргийн үйлчилгээнд хамрагдсан иргэдийг түүвэрлэн давхар хянадаг байна.[138]

Уг хяналтын тогтолцоог хэрхэн хэрэгждэг, үр дүнтэй байдал зэргийг тодруулах үүднээс холбогдох мэргэжилтнүүдээс ярилцлагын аргаар судалгаа авахад дараах хариултыг өгсөн байна.

Дүүргийн хэмжээнд хяналт үнэлгээ, шинжилгээ хариуцдаг 2 албан хаагч ажилладаг эдгээр нь бүх байгууллага бүх иргэнийг хамруулан хяналт хийх боломжгүй байдаг учраас түүврийн аргаар хяналтыг хэрэгжүүлдэг. Хяналтын зардал байхгүй, хяналт хийх талаар хуульд тусгаж өгсөн ч гэсэн хэт ерөнхий учир ойлгомжгүй байдаг талаар дурдсан байна.[139]

Монгол Улсын нийгмийн халамжийн үйлчилгээний хамрах хүрээ хэт өргөн буюу жилд 730.0 орчим мянган хүнийг хамарч, 4 хүн тутмын нэгд төрөөс халамж үзүүлж байгаа нь халамжийн үйлчилгээ зорилтот бүлэгт чиглээгүй хэмээх үндэслэлээр “Нийгмийн халамжийн тухай хууль /шинэчилсэн найруулга/”-ийн төслийг боловсруулан хуулийн төсөлд санал авах ажиллагаа явагдаж байна.[140] Уг

[138] Нийгмийн халамжийн зарим хөтөлбөрийн нөлөөллийн шинжилгээ ”Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ”, 2017 он, 29 дэх тал.

[139] Баянзүрх дүүргийн халамжийн албаны дарга Ш.Ганцэцэг /ярилцлагаас/

[140] “Нийгмийн халамжийн тухай хууль /шинэчилсэн найруулга/”-ийн төсөл http://www.mlsp.gov.mn/nnews/431 сүүлд үзсэн 2020.05.26

төсөлд дээр дурдсан эрх зүйн асуудлыг хэрхэн зохицуулсан талаар авч үзвэл:

Төслийн 22 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний төрлийг:

- Хувь хүнийг хөгжүүлэх, нийгмийн амьдралд орох оролцоог дэмжих үйлчилгээ;
- Өдрийн үйлчилгээ;
- Гэрийн асрамж, халамжийн үйлчилгээ;
- Орон гэргүй, тэнэмэл амьдралтай иргэдийг түр байрлуулах үйлчилгээ;
- Орлогын эх үүсвэртэй болгоход чиглэсэн төслийг дэмжих үйлчилгээ;
- Орон нутгийн онцлогт тохирсон бусад үйлчилгээ гэх зургаан төрлийн үйлчилгээг оруулж өгсөн байна.

Төслийн 33 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Нийгмийн халамжийн сангийн хөрөнгийг дараахь үйл ажиллагааг санхүүжүүлэхэд зарцуулна:" хэмээн 33.1.8 дахь заалтад "нийгмийн халамжийн үйл ажиллагааны үр дүнгийн талаарх, судалгаа, хяналт-шинжилгээ, үнэлгээний зардал" гэж хяналтын тухай тусгасан байна. Уг заалтыг төсөлд тусгаж өгснөөр одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулийн хяналт хэрэгжихгүй байх нэг үндэслэл болсон зардлын асуудлыг шийдэж өгөх зохицуулалтыг тусгасан байна.

Хэрэгжиж байгаа сөрөг үр дагавар: Аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага нь иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагаар гэрээний үндсэн дээр олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг гүйцэтгүүлдэг. Ийнхүү гэрээ байгуулан тухайн халамжийн үйлчилгээг авч хэрэгжүүлэхэд хэд хэдэн асуудал тулгамдаж буйг онцгойлон дурдвал:

- Төрийн бус байгууллагын үйл ажиллагаа тогтвортой бус, зарим байгууллагын хувьд тухайн халамжийн үйл ажиллагаа явуулахын тулд байр түрээслэх, хэсэг хугацааны дараа үйл ажиллагаагаа зогсоох гэх мэт асуудал тулгардаг.
- Түүнчлэн, харьцангуй тогтвортой ажиллаж, сургалт, зөвлөгөө өгөх мэргэжлийн баг хамт олон, орчин нөхцөл бүрдүүлсэн байгууллагын тухайд зарласан тендерт тавигдаж буй мөнгөн дүн, нэг удаагийн сургалтын зардал, түүнд олгогдож буй санхүүжилт бага байдгаас олон нийтийн оролцоонд түшиглэсэн нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлэх сонирхол бага байдаг.
- Зөвлөгөө үзүүлэх үйлчилгээнд мэргэжлийн хуульч, сэтгэл зүйч байх шаардлагатай байдаг, сургалт явуулах тохиолдолд мэргэжлийн арга зүйч багш байх, түр байрлуулах үйлчилгээнд байр суутцай байх, тоног төхөөрөмжтэй байх зэрэг шаардлагыг хангах нь байнгын орлогогүй хуулийн этгээдэд хүндрэл үүсгэж байдаг.

Нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын /Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар/ дэргэдэх магадлан итгэмжлэх Орон тооны бус зөвлөл магадлан итгэмжлэх үйл ажиллагааг хариуцдаг. /Олон нийтийн оролцоонд түшиглэсэн нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлэхээр 2019 онд гэрээ байгуулсан аж ахуйн нэгж байгууллагын нэрсийн жагсаалтыг хавсралт №.... үзнэ үү./

Магадлан итгэмжлүүлэх хүсэлт гаргаж буй байгууллагуудын хувьд хэд хэдэн асуудал гардаг байна. Тухайлбал, бичиг баримтын бүрдүүлбэр дутуу, албан бичиг хөтлөлтийн стандарт болон бусад шаардлага хангахгүй материалууд ирүүлдэг байна. Гэтэл хөдөө орон нутаг, зарим дүүргүүдийн хувьд тухайн олон нийтийн оролцоонд түшиглэсэн үйл ажиллагаа явуулах магадлан итгэмжлэл авсан байгууллага тухайн орон нутагт нь байдаггүйгээс энэхүү үйлчилгээнд

Хуулийн үндэсний хүрээлэн www.pilsoyan.mn

хамрагдаж чадахгүй байх тохиолдол үүсдэг учир магадлан итгэмжлэх ажиллагаанд өндөр шалгуур тавих боломж байдаггүй талаар ярилцлагын судалгааны явцад хэлж байсан болно. Мөн магадлан итгэмжлэл авсан хэдий ч үйл ажиллагаа огт явуулдаггүй байгууллагууд ч байдаг байна.

Хөдөө орон нутаг, зарим дүүргүүдийн хувьд Нийгмийн халамжийн тухай хуульд заасан олон нийтийн оролцоонд түшиглэсэн нийгмийн халамжийн 10 төрлийн үйлчилгээнээс зарим төрлийн үйлчилгээ огт хийгдэхгүй байх тохиолдлууд цөөнгүй гардаг байна. Энэ тухайн орон нутаг, сум, дүүрэгт олон нийтийн оролцоонд түшиглэсэн нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлэх сонирхолтой аж ахуйн нэгж байгууллага байдаггүй байна. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн нийгмийн халамжийн үйлчилгээнд тавигдах санхүүжилт нь тухайн орон нутгийн сангаас төсөвлөгдөн тавигддаг. Тиймээс тухайн санхүүжилтэд Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газраас ямар нэгэн хяналт тавьдаггүй бөгөөд үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудад тавьж буй хяналтын хувьд сум, дүүргийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн хяналт шинжилгээ үнэлгээний албаны мэргэжилтэн олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг хэрэгжүүлэгч байгууллагуудын нөхцөл байдалтай танилцах, санамсаргүй түүврийн аргаар тухайн үйлчилгээнд хамрагдсан иргэдтэй холбогдон мэдээлэл авч хяналт тавин ажилладаг байна.

Ийнхүү үнэлгээний зүйл 2-ийг дүгнэж үзвэл: ТББ-ын нийгмийн оролцоо, санхүүгийн чадавх сул /үйл ажиллагаа явуулах байр, тоног төхөөрөмж гэх мэт зүйл байдаггүй/, хүний нөөц, ажиллах хүч байдаггүй зэрэгтэй холбоотой орон нутаг, дүүргийн хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтсийн хяналт шинжилгээ үнэлгээний алба хяналт тавин ажилладаг хэдий ч тус алба нь орон тооны хувьд дутмаг, мөн хяналт тавихад шаардагдах төсөв санхүүжилт гэж байдаггүй байна. Тиймээс ажлын ачаалал, хөрөнгө санхүүтэй холбоотойгоор хяналтыг бүрэн хэрэгжүүлэхэд боломж хязгаарлагддаг.

Түүнчлэн, хуульд заасан 10 төрлийн үйлчилгээнээс иргэд сэргээн засах, бүлгийн төслийн үйлчилгээ хүртэх сонирхолтой байдаг ч бусад үйлчилгээнд хамрагдах сонирхолтой иргэдийн тоо бага байдаг байна. Тухайн аймаг, сум, дүүргийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн ОНОТХҮ хариуцсан мэргэжилтэн иргэдийг хамруулах үйл ажиллагаа зохион байгуулдаг бөгөөд энэ нь хуульд заасан шат дараалын дагуу бус харин ч эсрэг урсгалаар хийгддэг байна. Өөрөөр хэлбэл, энэ төрлийн үйлчилгээнүүдэд хамрагдах иргэдийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэгдсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай байгаа юм.

Нийгмийн халамжийн тухай хуулийн 2008 оны нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд ОНОТХҮ үзүүлэх журмыг баталж, 2011 оноос ОНОТХҮ-г хэрэгжүүлэх иргэн, ААН, ТББ-аар гүйцэтгүүлэх эрх зүйн орчин бүрдсэн.[141]

ДҮГНЭЛТ

Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний хяналт шинжилгээ, үнэлгээний тогтолцоо сайн байх нь ирээдүйд илүү үр дүнтэй нийгмийн халамжийн үйлчилгээ хэрэгжүүлэх боломжийг Засгийн газарт олгоно. Дээрх үйлчилгээний төрлөөс хийгдсэн ажлын үр дүнгийн үнэлгээ өнөөдрийг хүртэл хийгдээгүй тул Засгийн газар эцсийн үр дүн ямар байгааг, хэрхэн сайжруулж болох тал дээр ойлголт багатай байна.

ОНОТХҮ нь нийгмийн зорилтот бүлгийг бүхэлд нь хамрах боломжтой төдийгүй иргэдийн санаачилга оролцоог дэмжих өргөн талбар хэдий ч салбарын мэргэжилтнүүдийн ажлын ачаалал их, орон тоо дутмаг байдгаас тухайн төсөл

[141] Нийгмийн халамжийн зарим хөтөлбөрийн нөлөөллийн шинжилгээ ”Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ”, 2017 он, 6 дахь тал.

хөтөлбөр, тогтоол, шийдвэрийг бүрэн хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байдаг талаар мэргэжилтнүүдийн ажилтай танилцах явцад, мөн ярилцлага хийх явцад ажиглагдсан. Төрөөс тавигдах санхүүжилт нь тухайн орон нутгийн сангаас төсөвлөгдөж буй хэдий ч зарцуулалтад төдийлөн хяналт тавьдаггүй байгаа нь зарим нэг тоо баримтын зөрүү үүсч байгаагаас харж болох юм.

Энэхүү үйлчилгээнд төрийн дэмжлэг туслалцаа, үйлчилгээ нь бодлого, шийдвэрээр дамжин хууль тогтоомжийн уялдаа холбоог ханган нийгмийн зорилтот бүлэгт чиглэсэн үйлчилгээ гэдэг утгаар хэрэгжүүлэх нь чухал бөгөөд санхүүжилт гол үүрэг гүйцэтгэхгүй болох нь судалгаанаас харагдаж байна. Тухайлбал, 2011 оны санхүүжилт 3,340,6 сая байхад 42,845 мянган иргэн хамрагдаж байсан бол 2018 онд 3,617,7 сая төгрөгийн төсөвт 21,220 иргэнийг хамруулсан байгаа нь хамрагдсан иргэдийн тоо 50 хувиас илүү буурсан үзүүлэлттэй байгаа юм.

Тиймээс тухайн санхүүжилтэд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газраас хяналт тавьдаггүй бөгөөд үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудад тавьж буй хяналтын хувьд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсээс хяналт, шинжилгээ, үнэлгээ хийж, холбогдох мэргэжилтэн олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг хэрэгжүүлэгч байгууллагуудын нөхцөл байдалтай танилцах, санамсаргүй түүврийн аргаар тухайн үйлчилгээнд хамрагдсан иргэдтэй холбогдон мэдээлэл авч хяналт тавин ажиллаж байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт хамаарах 6 гол хуулиас гадна бусад холбогдох хууль тогтоомж хоорондын уялдаа холбоог хангах шаардлагатай төдийгүй “түр байрлуулан асрамжлах” болон бусад төрлийн үйлчилгээ үзүүлэх харилцаа хоорондоо давхардсан, зөрчилдсөн, зохицуулагдаагүй орхигдсон асуудал нэлээд байна.

Хөдөө орон нутаг, зарим дүүргүүдийн хувьд олон нийтийн оролцоонд түшиглэсэн үйл ажиллагаа явуулах магадлан итгэмжлэл авсан байгууллага тухайн орон нутагт нь байдаггүйгээс энэхүү үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байх тохиолдол үүсдэг магадлан итгэмжлэх ажиллагаанд өндөр шалгуур тавих боломжгүй байгаа нь үйлчилгээ эрхлэх хүсэлтэй байгууллагын оролцоог дэмжсэн бодлого хэрэгтэй байна. Үйлчилгээ эрхлэх хүсэлтэй байгууллагууд магадлан итгэмжлүүлэх хүсэлтээ Хөдөлмөр халамж үйлчилгээний ерөнхий газарт гаргадаг хэдий ч бичиг баримтын бүрдүүлбэр дутуу, албан бичиг хөтлөлтийн стандарт болон бусад шаардлага хангахгүй материалууд ирүүлснээс үүдэн буцах, тэнцэхгүй байх тохиолдол элбэг байна.

Мөн магадлан итгэмжлэл авсан хэдий ч үйл ажиллагаа огт явуулдаггүй байгууллагууд байдаг нь ОНОТХҮ-г хэрэгжүүлэх арга туршлага, зардлын зарцуулалт тодорхой биш, нөгөө талаас энэ үйлчилгээний үүрэг, ач холбогдлын ойлголт хангалтгүй байдагтай холбоотой байна.

ОНОТХҮ чиглэлээр төсөв төдийлэн хангалттай байдаггүй ч хяналт шалгалт тавигдах, аливаа байдлаар үйл явцад саад учруулах, хүнд нөхцөлд байгаа иргэдэд туслалцаа үзүүлэхэд дотоод, гадаад хүчин зүйлээс шалтгаалах хүндрэлтэй нөхцөл үүсдэг, мэргэжлийн боловсон хүчний дарамт илүүтэй учирдаг нь энэ төрлийн үйл ажиллагаа явуулах иргэдийн сонирхол төрөхгүй нь лавтай.

САНАЛ

- Хэрэгжүүлж байгаа үйлчилгээний талаарх захиргааны мэдээлэлд тогтмол давтамжтай дүн шинжилгээ хийж шийдвэр гаргахад ашиглах.
- Асуудлуудыг шийдвэрлэхийн тулд олон нийтийн оролцоонд түшиглэсэн нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлж буй байгууллага, иргэдийг дэмжих, чадавхжуулахад анхаарах;
- Албан ёсны сургалт, эрүүл мэндийн болон сэтгэл зүйн, хууль зүйн зөвлөгөө зэрэг мэргэжлийн байгууллага гүйцэтгэх үйлчилгээг үзүүлэхэд төрөөс дэмжлэг болох эрх зүйн зохицуулалтыг бий болгож өгөх, /мэргэжлийн чиглэлийн үйлчилгээ үзүүлэх төлбөрийн зарим хэсгийг төр хариуцах буюу эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр, хууль зүйн салбар дахь төр, хувийн хэвшлийг ОНОТХҮ эрхлэх боломжоор хангах, татан оролцуулахад төрөөс анхаарал хандуулах шаардлагатай байна/
- Төрөлжсөн асрамж буюу удаан хугацаагаар байрлуулан асрамжлах үйлчилгээнээс ОНОТХҮ буюу түр хугацаагаар үйлчилгээ үзүүлэх ойлголтыг нийтэд түгээх;
- Хяналт, шинжилгээний ажилтны хийгдэх ажиллагааг нарийн тодорхой тусгах;
- Түр байрлуулан асрамжлах үйлчилгээ болон бусад үйлчилгээг сайжруулахад хууль тогтоомж хоорондын уялдаа холбоог хангах, (Нийгмийн халамжийн тухай хуулийн ОНОТХҮ-тэй холбоотой заалтыг бусад хуультай уялдуулах, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн зохицуулалт нь Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн зохицуулалт гэх мэт)
- Хүний эрхийг хангах хамгаалах бүхий л тогтолцоог өөр хооронд нь уялдуулан холбох нийгмийн сайн сайхны төлөө чиглүүлэх,
- Нийгмийн халамжийн тогтолцоо нь нийгмийн хамгааллын тогтолцоотой харилцан хамааралтай байх,
- Цахим орчинг нийгмийн халамжийн тогтолцоотой уялдуулах, ингэхдээ хувь хүний нууцыг хамгаалах,

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nhgov.mn

НОМ ЗҮЙ

Эрх зүйн актууд

- Ахмад настны тухай, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2017, №13
- Алдар цолтой ахмад настанд нэмэгдэл, хөнгөлөлт олгох тухай, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2017, №13
- Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2017, №29
- Нийгмийн халамжийн тухай, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2012, №8
- Нийгмийн халамжийн тухай хууль /2012 оны 1 дүгээр сарын 19-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/, 2005.
- Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай, 2010, №31
- Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2003, №44
- Согтуурах, мансуурах донтой хүнийг захиргааны журмаар албадан эмчлэх тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2018, №46
- Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2016, №9
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2011, №40
- Хүүхдийн эрхийн тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2016, №9
- Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2017, №27
- Монгол Улсын Засгийн газрын тогтоол, Үндэсний хөтөлбөр батлах тухай /Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр/, 2017.11.29, Дугаар 321
- Монгол Улсын Засгийн газрын тогтоол, Үндэсний хөтөлбөр батлах тухай / Ажилгүйдэл, ядуурлыг бууруулах/, 2019.04.23, Дугаар 159,
- Монгол Улсын Засгийн газрын тогтоол, “Ахмад насны төрөлжсөн асрамжийн шинэчлэлийн хөтөлбөр” батлах тухай, 2020.03.04, Дугаар 84
- Монгол Улсын Засгийн газрын тогтоол, Зорилтот өрхийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр батлах тухай, 2016.02.04, Дугаар 16
- Монгол Улсын Засгийн газрын тогтоол, Үндэсний хөтөлбөр батлах тухай / Ахмад настны хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр”, 2019.10.30, Дугаар 389
- Монгол Улсын Засгийн Газрын тогтоол, Аргачлал шинэчлэн батлах тухай / Орон нутгийн төсвийн суурь зарлага тооцох аргачлал/, 2019.12.18, Дугаар 445
- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаал, Журам, загвар шинэчлэн батлах тухай /Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ, ахмад настанд үйлчилгээ үзүүлэх иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагыг магадлан итгэмжлэх/, 2019.02.14, Дугаар А/65
- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаал, Сургалт зохион байгуулах үйлчилгээний чанарт тавигдах шалгуур батлах тухай, 2019.12.26, Дугаар А/374
- Хууль зүй, дотоод хэргийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд,

Хуулийн Шинжлэх Ухаан www.ilt.gov.mn

Эрүү мэндийн сайдын хамтарсан тушаал, Журам батлах тухай /Хохирогчид үйлчилгээ үзүүлэх Төрийн бус байгууллагыг магадлан итгэмжлэх/, 2017.04.06, Дугаар А/84/А/59/А/130

Ном, сурах бичиг, судалгааны тайлан, эмхэтгэл

- Нийгмийн халамжийн зарим хөтөлбөрийн нөлөөллийн шинжилгээ, Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам, 2017.
- Нийгмийн халамжийн салбар дахь төрийн үйлчилгээ-Хүний эрх ба хүнд суртал, 2012.
- Нийгмийн халамжийн хөтөлбөрүүдийн дизайн, үр шим хүртэгчдийн байдалд хийсэн дүн шинжилгээ, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам, Дэлхийн банк, 2015.
- Удирдахуйн онол, практикийн асуудлууд /эрдэм шинжилгээний бичиг/, Удирдлагын академи, 2011.

Цахим эх сурвалж

- mlsp.gov.mn, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
- ub.hudulmur-halamj.gov.mn, Нийслэлийн нийгмийн халамжийн газар
- https://wol.iza.org/uploads/articles/104/pdfs/how-to-improve-participation-in-social-assistance-programs.pdf
- https://socialwelfare.library.vcu.edu/public-welfare/origins-of-the-state-federal-public-welfare-programs/
- https://childwelfaresparc.files.wordpress.com/2013/02/child-welfare-financing-in-the-united-states-final.pdf
- https://www.aihw.gov.au/reports-data/health-welfare-overview/australias-welfare/overview

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

Хавсралт 1

№	Хуулийн нэр	Батлагдсан он, сар, өдөр	Холбогдох зүйл, заалт
1.			6.2.Ахмад настан хүнс тэжээл, орон байраар хангагдах, ахуйн болон эрүүл мэнд, тэтгэвэр, тэтгэмж, нийгмийн хамгааллын үйлчилгээ авах эрхтэй бөгөөд ахмад настанд олгох тэтгэвэр, тэтгэмжийг холбогдох хуулиар зохицуулна. 6.8.Ахмад настан өөрийгөө хөгжүүлэх эрхтэй бөгөөд өөрийн чадавхийг хөгжүүлэх бололцоогоор хангагдах, сургалтад хамрагдах хэлбэрээр энэ эрхээ эдэлнэ. 7.1.Ахмад настанд үзүүлэх үйлчилгээ дараахь төрөлтэй байна: 7.1.2.зөвлөгөө өгөх үйлчилгээ; 7.1.4.өдрийн үйлчилгээ; 7.1.5.сайн дурын үйлчилгээ; 7.1.6.өдрөөр эмчлэх, асран сувилах үйлчилгээ; 7.1.7.асрамжийн үйлчилгээ; 7.1.8.хүнсний дэмжлэг үзүүлэх үйлчилгээ; 7.1.9.гэр бүлийн хүчирхийллээс хамгаалагдах үйлчилгээ. 7.2.Энэ хуулийн 7.1-д заасан үйлчилгээг дараахь хэлбэрээр зохион байгуулна: 7.2.1.аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага, сум, хорооны нийгмийн ажилтан, ахмадын байгууллага нь ахмад настан, түүний гэр бүлийн гишүүн, асран хамгаалагчид дэмжлэг, туслалцаа, үйлчилгээ үзүүлэх, ахмад настны эрхийг хамгаалах асуудлаарх мэдээллийг амаар, бичгээр, цахим хэлбэрээр хүргэх, сургалт зохион байгуулах; 7.2.2.ахмад настанд нийгэм, эдийн засаг, сэтгэл зүй, хууль зүйн зөвлөгөө өгөх болон өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх; 7.2.3.ахмад настанд ус, түлш, хүнс бэлтгэх, угаалга цэвэрлэгээ хийх зэрэгт туслах, зайлшгүй шаардлагатай асаргаа, сувилгааг явуулын үйлчилгээний хэлбэрээр зохион байгуулах; 7.2.4.ахмад настныг хооллох, сургах, хөгжүүлэх үйлчилгээг өдрийн, эсхүл түр байрлуулах хэлбэрээр зохион байгуулах; 7.2.5.ахмад настанд туслах хүсэл, сонирхолтой сайн дурын байгууллага, ажилтны үйл ажиллагааг зохион байгуулах; 7.2.6.хүнд өвчтэй, байнгын асаргаа сувилгаа шаардлагатай ахмад настныг сум, тосгон, өрхийн эрүүл мэндийн төвөөс өдрийн эмчилгээ, сувилахуйн болон сэргээн засахын тусламж, үйлчилгээнд хамруулах бөгөөд шаардлагатай тохиолдолд гэрээр тусламж, үйлчилгээ үзүүлэх; 7.2.7.бие даан амьдрах чадваргүй ахмад настныг Нийгмийн халамжийн тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасан асрамжийн үйлчилгээнд хамруулах; 7.2.8.Нийгмийн халамжийн тухай хуулийн 22.1.1-д заасан өрхийн ахмад настанд хүнсний бүтээгдэхүүн авах эрхийн бичиг олгох; 7.2.9.шаардлагатай тохиолдолд ахмад настныг холбогдох хуульд заасны дагуу хүчирхийллээс хамгаалах үйлчилгээнд хамруулах; 7.2.10.аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага, сум, хорооны нийгмийн ажилтан нь ахмад настны нөхцөл байдлыг судлан, хэрэгцээт дэмжлэг, туслалцаа, үйлчилгээг тодорхойлж, тэдгээрээс сонголт хийхэд туслах, зөвлөгөө өгөх. 7.3.Энэ хуулийн 7.1-д заасан үйлчилгээг аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага Нийгмийн халамжийн тухай хуулийн 18.8-д заасан шалгуур, журмыг хангасан иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагаас сонгон шалгаруулж, гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх бөгөөд үйлчилгээ нь өрх, иргэний хүсэлтийн дагуу төлбөртэй байж болно. 7.4.Энэ хуулийн 7.3-т заасан иргэн, хуулийн этгээдийн бүртгэл, мэдээллийн санг нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага бүрдүүлнэ.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХЭЛТЭЭЛЭН
www.legal.mn

2.	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль	2016.12.22.	**13 дугаар зүйл. Нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэг** 13.1.Нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ: 13.1.1.түр хамгаалан байрлуулах үйлчилгээ, нийгмийн халамжийн үйлчилгээ, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, холбон зуучлах ажлыг зохион байгуулах; 13.1.2.энэ хуулийн 13.1.1-д заасан үйлчилгээ үзүүлэх үүрэг бүхий ажилтныг давтан сургах хөтөлбөр болон сургалт зохион байгуулах журам баталж, хэрэгжилтэд хяналт тавих; **22 дугаар зүйл. Төрийн бус байгууллагын чиг үүрэг** 22.1.3.хохирогчийг түр хамгаалах байраар хангах болон энэ хуульд заасан бусад үйлчилгээ үзүүлэх. **35 дугаар зүйл. Түр хамгаалан байрлуулах үйлчилгээ** 35.1.Хохирогчийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах зорилгоор түүнд түр хамгаалан байрлуулах үйлчилгээг үзүүлнэ.
3.	Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль	2013-07-05	**7 дугаар зүйл.Аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээ** 7.1.Аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээ нь дараах хэлбэртэй байна: 7.1.6.аюулгүй газарт түр байрлуулах; **13 дугаар зүйл.Аюулгүй газарт түр байрлуулах** 13.1.Шаардлагатай тохиолдолд энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан насанд хүрсэн гэрч, хохирогчийг өөрийнх нь зөвшөөрснөөр, насанд хүрээгүй гэрч, хохирогчийг түүний эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигч, эсхүл хүүхдийн эрхийг хамгаалах байгууллагын зөвшөөрснөөр аюулгүй байдал хангагдсан газарт бодит аюул, заналхийлэл арилах хүртэл хугацаанд түр байрлуулна.
4.	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай /Шинэчилсэн найруулга/	2019-06-06	**1 дүгээр зүйл.Хуулийн зорилт** 1.1.Энэ хуулийн зорилт нь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын зарчим, үндсэн чиглэл, зохион байгуулалт, төрийн болон төрийн бус байгууллага, олон нийтийн оролцоог тодорхойлох замаар гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын эрх зүйн үндсийг тогтоох оршино. **5 дугаар зүйл.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын үндсэн зарчим** 5.1.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд дараах зарчмыг баримтална: 5.1.6. олон нийтийн оролцоонд түшиглэсэн, хэрэгцээ, шаардлагад нь нийцсэн байх; 5.1.7.төрийн байгууллага, албан тушаалтан гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд хуульд заасны дагуу оролцох үүрэгтэй бөгөөд төрийн захиргааны болон хууль сахиулах байгууллага үйл ажиллагаандаа гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг тэргүүлэх чиглэл болгох.
5.	Дээд боловсролын тухай хууль		12 дугаар зүйл.Дээд боловсролын сургалтын байгууллагын эрх, үүрэг 12.1.Дээд боловсролын сургалтын байгууллага дараахь эрх, үүргийг хэрэгжүүлнэ: 12.1.13.иргэдийн боловсрол, соёлын түвшинг дээшлүүлэх болон нийгмийн халамж, хүмүүнлэгийн чиглэлийн үйлчилгээ үзүүлэх.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХУРЛЫН ЭРГЭН www.parliament.mn

6.	Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль	2017.05.18	4.1.8.“амьдрах ухааны чадвар” гэж гэр бүл төлөвлөлт, санхүүгийн мэдлэг болон эрүүл, аюулгүй ажиллах, амьдрах зан үйл, дадал төлөвшил, нийгэм сэтгэл зүйн чадварыг; **7 дугаар зүйл.Төрөөс залуучуудын хөгжлийг дэмжих чиглэл** 7.1.Төрөөс залуучуудын хөгжлийг дэмжих үйл ажиллагааг дараахь чиглэлээр зохион байгуулна: 7.1.1.хувь хүний хөгжил; 7.1.2.боловсрол, соёл, урлаг, спорт, шинжлэх ухаан; 7.1.3.эрүүл мэнд; 7.1.4.хөдөлмөр эрхлэлт; 7.1.5.аюулгүй амьдрах, хөгжих орчин. **8 дугаар зүйл.Залуучуудын хувь хүний хөгжлийг дэмжих** 8.1.Залуучуудын хувь хүний хөгжлийг дараахь чиглэлээр дэмжинэ: 8.1.2.залуучуудад зориулан хувь хүний хөгжлийг дэмжих, амьдрах ухааны чадварыг эзэмшүүлэх сургалт зохион байгуулахыг дэмжих; 8.1.3.түүх, соёлоо мэддэг, эх оронч үзэлтэй, бие дааж амьдрах чадвартай, хариуцлагатай иргэн болж төлөвшихөд чиглэсэн амьдрах ухааны чадварыг эзэмшүүлэх хөтөлбөрийн дагуу цэргийн мэргэжил олгох сургалтад 18-27 насны залуучуудыг хамруулах; **9 дүгээр зүйл.Залуучуудын боловсрол, соёл, урлаг, спорт, шинжлэх ухааны хөгжлийг дэмжих** 9.1.Залуучуудын хэрэгцээнд нийцсэн, хүртээмжтэй, чанартай боловсрол эзэмшүүлэхийг дараахь чиглэлээр дэмжинэ: **10 дугаар зүйл.Залуучуудын эрүүл мэндийг хамгаалах** 10.1.Хорт зуршил, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрүүл дадал, хэвшилтэй иргэн болж төлөвшүүлэх зорилгоор залуучуудын эрүүл мэндийг дараахь чиглэлээр дэмжинэ: **11 дүгээр зүйл.Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих** 11.1.Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дараахь чиглэлээр дэмжинэ: 1.1.6.мэргэжлийн ур чадвараа сайжруулах, шинэ мэргэжил эзэмших сургалтад ажилгүй залуучуудыг хамруулах; **12 дугаар зүйл.Аюулгүй амьдрах, хөгжих орчныг бүрдүүлэх** 12.1.Залуучуудын аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх үйл ажиллагааг дараахь чиглэлээр дэмжинэ: 12.1.2.залуучуудыг гэмт хэрэгт татагдан орохоос урьдчилан сэргийлэх ажлыг хэвлэл мэдээллийн байгууллага, иргэний нийгмийн оролцоотой зохион байгуулах; 12.1.3.хорих болон засан хүмүүжүүлэх байгууллагад хоригдож байгаа залуучуудад зориулсан сэтгэл заслын үйлчилгээ, соёл, спорт, хүмүүжлийн арга хэмжээг холбогдох мэргэжлийн байгууллагын оролцоотой зохион байгуулах; 12.1.4.гэмт хэрэг үйлдэж, хорих ял эдэлсэн залуучуудад боловсрол, мэргэжил олгох, хорих ангиас суллагдах үед ажлын байраар хангах талаар төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн гаргасан санаачилгыг дэмжих; 12.2.Энэ хуулийн 12.1.2, 12.1.3, 12.1.4, 12.1.5-д заасан үйл ажиллагааг залуучуудын болон хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар, иргэний нийгмийн байгууллагын хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжүүлнэ.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ www.ogc.gov.mn

7.	Засгийн газрын тусгай сангийн тухай	2019-11-13	3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ 3.2.Нийгмийн даатгалын сан, Эрүүл мэндийн даатгалын сан, Нийгмийн халамжийн сан, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, Төсвийн тогтворжуулалтын сан, Ирээдүйн өв сан, Улсын авто замын сан, Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн бүрдүүлэлт, зарцуулалтын онцлогтой холбогдсон харилцааг тусгай хуулиар, нийтлэг харилцааг энэ хуулиар зохицуулна. 5 дугаар зүйл.Тусгай сан, түүний төрөл, тусгай санг шинээр байгуулах, татан буулгах 5.3.Тусгай сан дараах төрөлтэй байна: 5.3.12.Нийгмийн халамжийн сан;
8.	Зөрчлийн тухай хууль		**5.4 дүгээр зүйл.Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих** 2.Түр хамгаалах байрны журам зөрчиж нэвтэрсэн бол хүнийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно. 3.Түр хамгаалах байрны зориулалтыг өөрчилсөн, эсхүл хуульд зааснаас өөр зориулалтаар ашигласан бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно. **6.20 дугаар зүйл.Хүүхдийн эрхийг зөрчих** 5.Сургууль, сургуулийн дотуур байр, өдөр өнжүүлэх төв, асрамж, халамжийн төв, хүүхэд хамгааллын төв болон хүүхдэд үйлчилгээ үзүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа бусад байгууллага нь хүүхдэд аюулгүй, ээлтэй орчин бүрдүүлэх үүргээ биелүүлээгүйгээс хүүхдийн эрх зөрчигдсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
9.	Коронавируст халдвар / ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай	2020.4.29	**7 дугаар зүйл.Засгийн газраас авч хэрэгжүүлэх арга хэмжээ** 7.1.Цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах талаар Засгийн газар энэ хуулийн 11.1-д заасан шаардлагад нийцүүлэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ: 7.1.12.цар тахлын үед орон гэргүй, нэн ядуу иргэдийг орон байр, хоол хүнс, ундны цэвэр усаар хангах, халдвараас сэргийлэх ажлыг зохион байгуулах;
10.	Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний Мэдэгдэл, 2021-2022 оны төсвийн төсөөллийн тухай	2019-05-30	1 дүгээр зүйл.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2021-2022 оны төсвийн төсөөллийн үзүүлэлтийг доор дурдсанаар баталсугай: 9 Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс санхүүжүүлэх зардлын нийт хэмжээ /тэрбум төгрөг/ 756.6 817.1 882.5 -Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь 1.9 1.8 1.7 2020 2021 2022

ХУУЛЬЗҮЙН ҮНДЭСНИЙ ГАЗАР www.legal.mn

11.	Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай	2006.12.15	**28 дугаар зүйл. Баг, хорооны Засаг даргын бүрэн эрх** 28.1.Баг, хорооны Засаг дарга харьяалах нутаг дэвсгэртээ дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 28.1.6.шаардлагатай иргэдийг асрамжийн болон халамжийн үйлчилгээнд хамруулах саналыг хууль тогтоомжийн дагуу сум, дүүргийн Засаг даргад тавьж шийдвэрлүүлэх; 28.1.7.нутаг дэвсгэрийн хүн амын амьжиргааны түвшинг судлах; **29 дүгээр зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын нийтлэг бүрэн эрх** 29.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга харьяалах нутаг дэвсгэртээ дараахь нийтлэг бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 29.1.5.хүн амын нийгэм-соёлын үйлчилгээ, нийгмийн хамгааллын талаар: д/нутаг дэвсгэрийнхээ хүн амын нийгмийн хамгааллын хөтөлбөрийг боловсруулж Хурлаар шийдвэрлүүлэх, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, нийгмийн халамжийн зэрэг хууль тогтоомжид заасан санг бүрдүүлэх, захиран зарцуулах ажлыг ерөнхий удирдлагаар хангах;
12.	Монгол Улсын Засгийн газрын тухай	1993-05-06	**9 дүгээр зүйл.Нийгмийн хөгжлийн бодлого боловсруулж хэрэгжүүлэх, хүн амын нийгмийн хамгаалалтын талаархи Засгийн газрын бүрэн эрх** 4.Хүн амын эрүүл мэндийг хамгаалах, биеийн тамир, спортыг хөгжүүлэх бодлого боловсруулан хэрэгжүүлнэ. Хууль тогтоомжид заасны дагуу хүн амын эрүүл мэндийг хамгаалах ажилд улс, олон нийтийн байгууллага, иргэдийн хүчийг нэгтгэн зохион байгуулна. 5.Хүн амын бодлого, түүний дотор хүүхэд, залуучууд, эмэгтэйчүүд, ахмадуудын талаар төрөөс явуулах бодлого боловсруулж хэрэгжүүлнэ. 6.Ажил эрхлэлт, мэргэжлийн сургалт, хөдөлмөрийн асуудлаар оновчтой бодлого боловсруулж хэрэгжүүлэх, иргэдийн хөдөлмөр, ахуй, орон сууцны нөхцөлийг сайжруулах, хэрэглэгчийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах арга хэмжээ авна. 7.Гэр бүлийг бэхжүүлэх, нийгмийн халамж, нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалын тогтолцоог боловсронгуй болгох, эх нялхас, тахир дутуу хүмүүс зэрэг нийгмийн эмзэг хэсгийн эрх ашгийг хамгаалах арга хэмжээ авна. **20 дугаар зүйл.Засгийн газрын бүрэлдэхүүн** 8/Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд: -хүн амын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал; -нийгмийн халамжийн бодлого;
13.	Монгол Улсын Их хурлын тухай		20 дугаар зүйл. Байнгын хороодын эрхлэх асуудлын хүрээ 20.3. Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо: 20.3.1. хүн ам, хөгжлийн бодлого; 20.3.3. нийгмийн халамж, хамгааллын бодлого;
14.	Монгол Улсын 2020 оны төсвийн тухай	2019.11.13	**3 дугаар зүйл.Монгол Улсын төсөвт 2020 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч, түүний харьяа болон бусад байгууллагын төвлөрүүлэх орлогын хэмжээг доор дурдсанаар баталсугай:** 17 — Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд — 53,133.2 Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар — 950.0 Эрүүл мэндийн даатгалын сангаас улсын эмнэлэгт олгох санхүүжилтийн орлого Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого — 798.4 51,384.8

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ГАЗАР www.mn.gov.mn

15.	Монголын улаан загалмай нийгэмлэгийн эрх зүйн байдлын тухай	2016.1.7	**6 дугаар зүйл. Монголын улаан загалмай нийгэмлэгийн зорилго, чиг үүрэг** 6.2.Энэ хуулийн 6.1-д заасан зорилгыг биелүүлэхийн тулд Монголын улаан загалмай нийгэмлэгийн дүрэм, Монгол Улсын олон улсын гэрээ болон олон улсын Улаан загалмай, Улаан хавирган сар хөдөлгөөний олон улсын чуулганы тогтоолд тодорхойлогдсон дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ: 6.2.4.сайн дурын үйл ажиллагааг дэмжих, зэвсэгт мөргөлдөөн, гамшиг болон бусад хүчирхийлэлд өртсөн нэн эмзэг бүлгийн хүмүүст халамж үйлчилгээ үзүүлэх, амьжиргаа, амьдралын чанарыг дээшлүүлэхэд төрд нэмэлт хүч болон ажиллах; 6.3.Монголын улаан загалмай нийгэмлэг нь зорилго, чиг үүрэгтээ хамаарах дараах үйл ажиллагааг эрхэлнэ: 6.3.4.олон нийтийн оролцоонд түшиглэж нийгмийн эмзэг бүлэгт халамжийн үйлчилгээ үзүүлэх;
16.	Монгол Улсын Үндсэн хууль	1992.1.13	**Тавдугаар зүйл.** 4.Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна**.** **Арван зургадугаар зүйл.** Монгол Улсын иргэн дараахь үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ: **Арван есдүгээр зүйл.** 1.Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.
17.	Нийгмийн халамжийн тухай хууль	2012.1.19	20.2.Боловсролыг дэмжих үйлчилгээнд дараах иргэнийг хамруулна: 20.2.4.гэр оронгүй тэнэмэл амьдралтай иргэний хүүхэд; 22.1.Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд дараах өрхийн гишүүн-иргэн, иргэнийг хамруулна: 22.1.2.гэр оронгүй, тэнэмэл амьдралтай иргэн.
18.	Сэтгэцийн эрүүл мэндийн тухай	2013.1.3	ХОЁРДУГААР БҮЛЭГ СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙГ ХАМГААЛАХ, ДЭМЖИХ ТАЛААРХ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ҮҮРЭГ 5 дугаар зүйл.Сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах, дэмжих талаарх төрийн байгууллагын үүрэг 5.1.Хүн амын сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах, дэмжих талаар төрийн бүх шатны байгууллага тус тусын эрх хэмжээний хүрээнд дараах үүрэг хүлээнэ: 5.1.4.сэтгэцийн эмгэгтэй хүний хэрэгцээ, чадамжийг харгалзан мэргэжлийн сургалтад хамруулах, хөдөлмөр эрхлэх боломжоор хангах, гэр бүл, орон нутагт нь ойр байлгаж, амьдрах ур чадварыг нь дээшлүүлэхэд чиглэсэн сэтгэц-нийгмийн сэргээн засах тусламж, үйлчилгээнд шаардлагатай төхөөрөмж, хэрэгслээр хангах, нийгмийн халамжийн болон боловсролын тусгайлсан үйлчилгээг бий болгох зэргээр тэдний бие даан амьдрах чадвар, нийгмийн амьдралд оролцох оролцоог нь дэмжлүүлэх арга хэмжээ авах; 5.1.5.хууль ёсны төлөөлөгч /эцэг, эх, асран хамгаалагч/ нь тогтоогдоогүй, иргэний эрх зүйн бүрэн бус чадамжтай сэтгэцийн эмгэгтэй хүнийг асран халамжлах асуудлыг Гэр бүлийн тухай хуулийн 63, 64 дүгээр зүйлд заасны дагуу шийдвэрлэх; **6 дугаар зүйл.Сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах, дэмжих талаарх иргэн, хуулийн этгээдийн үүрэг** 6.1.Хүн амын сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах, дэмжих талаар хуулийн этгээд дараах үүрэг хүлээнэ: 6.1.2.иргэний эрх зүйн бүрэн бус чадамжтай сэтгэцийн эмгэгтэй хүний хууль ёсны төлөөлөгчид дэмжлэг, туслалцаа үзүүлэх ажлыг зохион байгуулах. 6.2.Сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих талаар Монгол Улсын иргэн дараах үүрэг хүлээнэ: 6.2.3.сэтгэцийн эмгэгтэй хүний бие даан амьдрах, нийгмийн амьдралд оролцоход нь дэмжлэг, туслалцаа үзүүлэх.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ www.legal.mn

			14 дүгээр зүйл.Сэтгэцийн эмгэгтэй хүнд үзүүлэх нийгмийн халамжийн туслалцаа 14.1.Мэргэжлийн байгууллагын тодорхойлолтыг үндэслэн сэтгэцийн эмгэгтэй хүнд нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж олгох, асрамж, үйлчилгээнд хамруулах асуудлыг эрх бүхий байгууллага холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.
19.	Согтуурах, мансуурах донтой хүнийг захиргааны журмаар албадан эмчлэх тухай хууль	2018.11.15	**3 дугаар зүйл.Албадан эмчлэх үндэслэл** 3.1.Согтуурсан, мансуурсны улмаас өөртөө болон бусдад аюул учруулах эрсдэлтэй байдалд орсон хүн согтуурах, мансуурах донтой болох нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон боловч сайн дурааараа эмчлүүлэхээс татгалзсан тохиолдолд шүүхийн шийдвэрээр албадан эмчилгээнд хамруулна. **6 дугаар зүйл.Сайн дурааараа эмчлүүлэх хүсэлт гаргах** 6.1.Согтуурах, мансуурах донтой нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагын дүгнэлтээр тогтоогдсоны дараа тухайн хүн өөрөө сайн дурын үндсэн дээр энэ төрлийн эмчилгээнд хамрагдах хүсэлтээ цагдаагийн байгууллагад бичгээр гаргасан тохиолдолд хувийн байдлыг нь харгалзан албадан эмчилгээнд явуулахгүй байж болно. **9 дүгээр зүйл.Шүүх шийдвэр гаргах** 9.7.Цагдаагийн алба хаагч албадан эмчлэх тухай шүүхийн шийдвэр гарсан талаар тухайн хүний гэр бүлийн гишүүн, төрөл садангийн хүнд, хэрэв ганц бие хүн бол түүний оршин суугаа газрын нийгмийн халамж, үйлчилгээний байгууллагад ажлын таван өдрийн дотор мэдэгдэнэ. **19 дүгээр зүйл.Сургалтад хамруулах** 19.1.Албадан эмчлэх эмнэлэг эзэмшсэн мэргэжилгүй, ажил эрхэлдэггүй эмчлүүлэгчдэд зориулж мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт зохион байгуулж болно. 19.2.Энэ хуулийн 19.1-д заасан сургалтыг дараах шаардлагын дагуу явуулна: 19.2.1.эмчлүүлэгчийн эмчилгээний горим, үр дүн, биеийн эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх; 19.2.2.сургалтын үргэлжлэх хугацаа эмчлүүлэгчийн эмчилгээний хугацаанд багтсан байх; 19.2.3.сургалтын үр дүнд мэргэжлийн үнэмлэх олгох; 19.2.4.сургалт явуулах байгууллага Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд заасан шаардлагыг хангасан байх; 19.2.5.сургалт явуулах байгууллага Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд нийцсэн үйлчилгээ, арга хэмжээг санал болгох. 19.3.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 11.2, 11.4-т заасны дагуу сургалтын төлбөрийг хөдөлмөр эрхлэлтийн сангаас санхүүжүүлнэ. 19.4.Албадан эмчлэх эмнэлэг эмчилгээний хугацаа дууссаны дараа сургалтад хамрагдсан хүнийг эзэмшсэн мэргэжлийнх нь дагуу ажлын байранд зуучлах ажлыг хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамж, үйлчилгээний асуудал хариуцсан байгууллагатай хамтран зохион байгуулж болно.
20.	Сургуулийн өмнөх боловсролын тухай	2008-05-23	8 дугаар зүйл. Цэцэрлэг 8.1.Цэцэрлэг нь ердийн, тусгай, сувиллын, асрамжийн, халамжийн гэсэн хэв шинжтэй байна. 8.6.Тусгай, гэр цэцэрлэг болон сувиллын цэцэрлэгийн үлгэрчилсэн дүрэм, эрүүл ахуй, ариун цэврийн дүрмийг эрүүл мэнд, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, асрамжийн болон халамжийн цэцэрлэгийн үлгэрчилсэн дүрмийг боловсролын болон нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран батална
21.	Татварын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/	2019.3.22	**61 дүгээр зүйл.Битүүмжлэхийг хориглох хөрөнгө, орлого** 61.1.Дараах хөрөнгийг битүүмжлэхийг хориглоно: 61.1.7.нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж болон нийгмийн халамжийн үйлчилгээ, нийгмийн хөгжлийн үйлчилгээний хүрээнд олгосон тусламж, дэмжлэг.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХЭЛЛЭГ www.legal.mn

22.	Төсвийн тухай /Шинэчилсэн найруулга/	2011.12.23	**41 дүгээр зүйл.Төсвийн хэрэгжилтийг зохион байгуулах** 41.2.6.төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэлийн санхүүжилтийг бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гэрээ, төлбөрийн хуваарийг үндэслэн санхүүжүүлэх; 41.4.2.нийгмийн халамжийн болон нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмжийг доод хэмжээгээр нь; 58 дугаар зүйл.Орон нутгийн төсвөөр хэрэгжүүлэх чиг үүрэг 58.2.Аймаг өөрийн төсвөөр тухайн шатанд хамаарах дараах чиг үүргийг бие даан хэрэгжүүлнэ: 58.2.4.нийгмийн асрамж, халамжийн үйлчилгээг үзүүлэх, зохион байгуулах; 58.3.Дүүрэг өөрийн төсвөөр дараах чиг үүргийг бие даан хэрэгжүүлнэ: 58.3.2.дүүргийн Засаг даргын шийдвэрээр олгодог нийгмийн халамж, асрамжийн үйлчилгээг үзүүлэх, зохион байгуулах; 58.4.Сум өөрийн төсвөөр дараах чиг үүргийг бие даан хэрэгжүүлнэ: 58.4.2.сумын Засаг даргын шийдвэрээр олгодог нийгмийн халамж, асрамжийн үйлчилгээг үзүүлэх, зохион байгуулах;
23.	Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай	2013.7.5	7.1.Төлбөрийн чадваргүй яллагдагчид гэмт хэрэгт холбогдсон дараах хүн хамаарна: 7.1.1.Үндэсний статистикийн хороо, нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран баталсан аргачлалын дагуу өрхийн мэдээллийн нэгдсэн санд орсон, амьжиргааны түвшин нь тухайн үеийн ядуурлын шугамаас доогуур өрхийн гишүүн; 7.1.2.энэ хуулийн 7.1.1-д заасан нэгдсэн санд бүртгэлгүй боловч ядуурлын шугамаас доогуур орлоготой болохоо тодорхойлсон хүн;
24.	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль	2016.02.05.	**5 дугаар зүйл. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, хамгаалахад баримтлах зарчим** 5.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, хамгаалахад дараах зарчмыг баримтална: 5.1.1.хөгжлийн бэрхшээлтэй хүнийг нийгмийн амьдралд эрх тэгш оролцоход аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхахыг үл тэвчих; 5.1.2.хөгжлийн бэрхшээлтэй хүний сонголт хийх эрх, хараат бус байдлыг хүндэтгэх; 5.1.3.сурч боловсрох, хөдөлмөрлөх, нийгэмших зэрэг бүхий л харилцаанд оролцох хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг саадгүй, хүртээмжтэй хангах орчин, нөхцөлийг бүрдүүлэх; 5.1.4.хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжих эрхийг хангах, тэдний онцлог байдлыг хүндэтгэх; 5.1.5.хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй хүнд тэгш, хүртээмжтэй хүргэх явдал нь бүх нийтийн үүрэг байх; 5.1.6.хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй холбоотой төрийн бодлого, шийдвэрийг боловсруулах, хэрэгжүүлэх, хэрэгжилтэд нь хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үйл ажиллагаанд хөгжлийн бэрхшээлтэй хүн, тэдгээрийн эрх ашгийг хамгаалах чиг үүрэг бүхий төрийн бус байгууллагын төлөөллийн оролцоог хангах. **26 дугаар зүйл. Нийгмийн халамжийн сангаас хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх тусламж, хөнгөлөлт** 26.2.Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төрөлжсөн асрамжийн болон олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд хамруулж болно. **Бусад холбогдох заалт**

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.mongolnotary.mn

25.	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай / Шинэчилсэн найруулга/	2011-06-17	**4 дүгээр зүйл.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны зарчим, төрийн бодлогын чиглэл** 4.1.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд дараах зарчим баримтална: 4.1.4.ажил олоход хүндрэлтэй иргэдийн хөдөлмөрлөх тэгш эрх, адил боломжийг хангах; 4.1.5.нийгмийн түншлэлийг дэмжих; 4.1.6.олон нийтийн оролцоонд тулгуурлах.
26.	Цагдаагийн албаны тухай /Шинэчилсэн найруулга/	2017.2.9	46 дугаар зүйл. Гэр бүлийн хүчирхийллийг таслан зогсоох 46.6.1.хамгаалах боломжтой хүн, гэр бүлд хүлээлгэн өгөх; 46.6.2.нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байр, эсхүл асрамж, халамжийн үйлчилгээний байгууллагад хүргэх. 65 дугаар зүйл. Иргэн, хуулийн этгээд, албан тушаалтны үүрэг, туслалцаа 65.2.Иргэн, хуулийн этгээд, албан тушаалтан дараахь чиглэлээр цагдаагийн байгууллагад туслалцаа үзүүлнэ: 65.2.6.төрийн болон төрийн бус байгууллага цагдаагийн байгууллагаас шаардсан мэдээллийг саадгүй гаргаж өгөх;
27.	Хүүхдийн эрхийн тухай хууль	2016.02.05.	**13 дугаар зүйл. Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын үүрэг, оролцоо** 13.1.Хүүхдийн эрхийг хангах, хамгаалахад хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь тэргүүлэх чиг үүргийг гүйцэтгэнэ: 13.1.5.хүүхдийн эрхийг хангах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг хуулийн этгээдийг дэмжих; **16 дугаар зүйл. Хүүхдийн төлөө үндэсний болон орон нутгийн зөвлөл** 16.4.Хүүхдийн төлөө үндэсний болон орон нутгийн зөвлөл нь дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ: 16.4.1.хүүхдийн эрхийг хангах, эрх нь зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, хүүхэд хамгаалал, хөгжлийн талаархи төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд нийгмийн нөөц баялгийг дайчлах, салбар дундын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах шаардлагатай арга хэмжээ авах; 16.4.2.хүүхдийн эрхийг хангах, эрх нь зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, хүүхэд хамгаалал, хөгжлийн үйл ажиллагааны талаар холбогдох төрийн байгууллагад чиглэл, хуулийн этгээдэд зөвлөмж өгөх.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.legal.mn

28.	Хүүхэд хамгааллын тухай хууль	2016.02.05.	**5 дугаар зүйл. Гэр бүл дэх хүүхэд хамгаалал** 5.3.Гэр бүлийн орчинд хүчирхийлэлд өртсөн хүүхдэд үзүүлэх яаралтай тусламж, үйлчилгээг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд заасны дагуу үзүүлнэ. **6 дугаар зүйл. Боловсролын салбар дахь хүүхэд хамгаалал** 6.1.Сургалтын байгууллага хүүхэд хамгааллын бодлогыг тухайн байгууллагад хэрэгжүүлэхдээ хөтөлбөр, төлөвлөгөө гарган, мөрдөж ажиллана. 6.2.Сургалтын байгууллага, албан тушаалтан, багш, ажилтан эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн талаар таамагласан, мэдсэн, илрүүлсэн тохиолдолд Хүүхдийн эрхийн тухай хуулиар үүрэг хүлээсэн оролцогч талуудад заавал мэдээлнэ. 6.3.Сургалтын байгууллагад суралцаж байгаа хүүхэд бүрийг тухайн орчинд бие махбодийн шийтгэл, сэтгэл зүйн болон үе тэнгийнхний дарамт, үл хайхрах байдал, гэмт хэрэг, зөрчил, хорт зуршилд өртөхгүй байх нөхцөлийг бүрдүүлэхийн тулд дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлнэ: 6.3.1.сургалтын байгууллагын багш, ажилтан хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга эзэмших; 6.3.2.сургалтын байгууллагын багш, ажилтан суралцагчдын эрсдэлт нөхцөлд байгаа эсэхийг үнэлэх, судлах, зөвлөгөө өгөх; 6.3.3.сургалтын байгууллагын багш, ажилтан суралцагчдын хоорондын нөхөрсөг бус харилцаа, маргаан, зөрчлийг эвлэрүүлэх, зохицуулах, гэр бүлд нь мэдэгдэх зэргээр урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах; 6.3.4.хүүхдийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдалд хохирол учруулж болохуйц үйл ажиллагаа, арга хэмжээнд хүүхдийг оролцуулахгүй байх; 6.3.5.хүүхдийг соглуурах, мансуурах, донтох байдалд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээг авах. **7 дугаар зүйл. Эрүүл мэндийн үйлчилгээн дэх хүүхэд хамгаалал** 7.1.Эрүүл мэндийн ажилтан ажил, үүргээ гүйцэтгэх явцдаа эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн талаар таамагласан, мэдсэн тохиолдолд хүүхдийн асуудал эрхэлсэн орон нутгийн ажилтан, албан тушаалтан, эсхүл цагдаагийн байгууллагын алба хаагчид заавал мэдээлнэ. 7.2.Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэхдээ хүүхдийн, түүний гэр бүл, хувийн нууцад хамаарах мэдээллийг хуулиар зөвшөөрснөөс бусад тохиолдолд байгууллага, албан тушаалтан, хувь хүнд мэдээлэхийг хориглох бөгөөд задруулснаас үүдэн гарах үр дагаврыг өөрөө хариуцна. 7.3.Эрүүл мэндийн байгууллага эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хуульд заасны дагуу үзүүлнэ. **9 дүгээр зүйл. Олон нийтийн арга хэмжээ, үйлчилгээн дэх хүүхэд хамгаалал** 9.1.Худалдаа үйлчилгээ, олон нийтийг хамарсан арга хэмжээ, жагсаал цуглаан, замын хөдөлгөөн, хүүхэд оролцсон шалгалт, уралдаан тэмцээний үед хүүхдийг эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх үүргийг зохион байгуулагч болон оролцогч талууд ханган ажиллана. **10 дугаар зүйл. Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ** 10.1.Эрсдэлт нөхцөлд байгаа, гэмт хэргийн хохирогч болсон, гэмт хэрэг, зөрчилд холбогдсон, ял шийтгүүлж, албадлагын арга хэмжээ авагдсан, сургалт, хүмүүжлийн тусгай байгууллагаас суллагдсан хүүхдийг нийгэмд хэвийн амьдрахад нь тусалж, дэмжих чиглэлээр дараахь хариу үйлчилгээ үзүүлнэ: 10.1.1.мэдээлэл хүлээн авах, илрүүлэх, шалгах; 10.1.2.нөхцөл байдлын үнэлгээ хийх; 10.1.3.аюулгүй байдлыг хангах; 10.1.4.дэмжих, холбон зуучлах; 10.1.5.хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйлчилгээ үзүүлэх; 10.1.6.гэр бүлд нь эргэн нэгтгэх.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ҮЙЛЧЛЭЛ
www.legalinfo.mn

			10.2.Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг төрийн байгууллага эсхүл тухайн чиглэлээр мэргэшсэн иргэн, магадлан итгэмжлэгдсэн хуулийн этгээд төрийн зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгүүлэх замаар үзүүлнэ. 10.3.Хүүхэд хамгааллын чиглэлээр үйлчилгээ үзүүлж байгаа төрийн байгууллага болон хуулийн этгээд тусгайлан бэлтгэгдэж, мэргэшсэн хүний нөөцтэй байна. 10.4.Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээд нь хүүхэд, гэр бүлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас магадлан итгэмжлэгдсэний үндсэн дээр үйл ажиллагаа явуулах бөгөөд уг журмыг хүүхэд, гэр бүлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. **13 дугаар зүйл. Хүүхдийн аюулгүй байдлыг хангах** 13.1.Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн нөхцөл байдлын үнэлгээг харгалзан Гэр бүлийн тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд зааснаас гадна хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд хамруулах арга хэмжээг авна. **19 дүгээр зүйл. Хүүхдийн эрхийн ажилтан, нийгмийн ажилтны хүүхэд хамгааллын чиглэлээр явуулах үйл ажиллагаа** 19.1.Орон нутгийн хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан байгууллагын нийгмийн ажилтан, хүүхдийн эрхийн ажилтан дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ: 19.1.1.эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг судлан тогтоох, бүртгэх, тэдний эрх ашгийг хамгаалах, хариу үйлчилгээнд хамруулах;
29.	Хүн амын амьжиргааны доод түвшинг тодорхойлох тухай	1998-01-08	**3 дугаар зүйл.Хуулийн нэр томьёо** 3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно: 3.1.1.хүн амын амьжиргааны доод түвшин гэж хэрэглээний доод хэмжээг мөнгөн хэлбэрээр илэрхийлснийг; 3.1.2.хэрэглээний доод хэмжээ гэж хүний нэн тэргүүний зайлшгүй хэрэгцээг хангах хүнсний болон хүнсний бус хэрэглээний сагсаар тодорхойлсон бараа, үйлчилгээний шинжлэх ухааны үндэслэлтэй тогтоосон тоо, хэмжээг.
30.	Хүн худалдаалахтай тэмцэх тухай	2012-01-19	5.3.Хүн худалдаалахтай тэмцэх талаар гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 5.4.Хүн худалдаалахтай тэмцэх талаар нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 5.4.2.хохирогчийг хамгаалах, халамж, үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий төрийн бус байгууллагын үйл ажиллагааг дэмжих, туслалцаа үзүүлэх. 5.12.Бүх шатны нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 5.12.2.хохирогчид үзүүлэх халамж, үйлчилгээг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх; 12 дугаар зүйл.Хохирогчид үзүүлэх халамж, үйлчилгээ 12.1.Хохирогчид дараах халамж, үйлчилгээг үзүүлнэ: 12.1.1.эрүүл мэндийн нөхөн сэргээх эмчилгээ; 12.1.2.сэтгэцийн нөхөн сэргээх эмчилгээ; 12.1.3.ажлын байраар хангах, мэргэжлийн сургалтад хамруулах; 12.1.4.хууль зүйн туслалцаа; 12.3.Энэ хуулийн 12.1-д заасан хохирогчид үзүүлэх халамж, үйлчилгээ үнэ төлбөргүй байна.
31.	Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай	2017.6.30	1.1.Энэ хуулийн зорилт нь жирэмсэн эх, 0-3 хүртэлх насны хүүхдээ асарч байгаа эх, дөрөв хүртэлх насны ихэр хүүхэдтэй эх, эцэг, гурав болон түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСЛЭЛТ www.

32.	Эрүүгийн хууль	2015.12.03	7.4 дүгээр зүйл.Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ 3.Гэмт хэрэг үйлдэх үедээ хэрэг хариуцах чадваргүй байсан хүний сэтгэцийн байдал нь өөртөө, бусдад аюул учруулахааргүй бол шүүх эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэхгүйгээр сэтгэцийн эрүүл мэндийн холбогдох байгууллагад эмчлүүлэх, асран хамгаалагчид халамжлуулахаар шилжүүлж болно. 18.12 дугаар зүйл.Хууль бусаар нийгмийн халамж, үйлчилгээ авах 1.Хуурамч баримт бичиг, эд зүйл ашиглаж, зохиомол байдлыг зориудаар бий болгож, бодит байдлыг нууж нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, үйлчилгээ, нийгмийн хөгжлийн үйлчилгээг авсан бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг зуун дөчин цагаас дөрвөн зуун наян цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 2.Энэ гэмт хэргийг: 2.1.албан тушаалын байдлаа ашиглаж; 2.2.их хэмжээний нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, үйлчилгээ, нийгмийн хөгжлийн үйлчилгээг авч үйлдсэн бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар эрх хасаж арван мянган нэгжээс дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
Улсын Их Хурлын тогтоол			
1.	Коронавируст халдвар / COVID-19/-ын цар тахлын үед иргэдийн эрүүл мэнд, орлогыг хамгаалах, ажлын байрыг хадгалах, эдийн засгийг идэвхжүүлэх багц арга хэмжээний тухай	2020-04-09 **Дугаар 21**	Дөрөв.Эдийн засгийг идэвхжүүлэх чиглэлээр: 2/эдийн засгийг төрөлжүүлэх, дэмжих, ажлын байр бий болгох, нийгмийн халамжийн үйлчилгээг сайжруулах зорилгоор гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл арга хэмжээг идэвхжүүлэх, үр ашгийг нэмэгдүүлэх арга хэмжээг авах, эх үүсвэр бүрдүүлэх гэрээ, хэлэлцээрийг байгуулах, түүнийг Монгол Улсын Их Хурлын чуулганаар нэн яаралтай хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлэх;
2.	Нийгмийн халамжийг сайжруулах талаар авах арга хэмжээний тухай	2009-11-25 Дугаар 81	Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь: 1.Төрөөс нийгмийн халамжийн талаар нэгдсэн бодлого баримтлах, халамжийн үйлчилгээг цэгцлэх, нэгтгэх арга хэмжээг дараахь чиглэлээр авч хэрэгжүүлэхийг Засгийн газар /С.Батболд/-т үүрэг болгосугай: 3/нийгмийн халамжийг зорилтот бүлэгт чиглүүлэх, давхардлыг арилгах, өрхийн амьжиргааны түвшинг дээшлүүлэхэд бодитой нөлөө бүхий хөтөлбөр, төслийг хэрэгжүүлэх, олон нийтэд түшиглэсэн халамжийн үйлчилгээг дэмжих, салбарын хууль тогтоомжоор зохицуулагдаж байгаа нийгмийн халамжийн шинж чанартай олон төрлийн арга хэмжээ, хөтөлбөрийг нийгмийн халамжийн бодлогын эрх зүйн нэгдсэн зохицуулалтын хүрээнд шийдвэрлэх арга хэмжээ авах.

Хуулийн үнэтэй эшлэл www.nlt.gov.mn

3.	Нийгмийн халамжийн тухай хуулиуд, Ахмад настан, түүнд үзүүлэх хөнгөлөлт, үйлчилгээний тухай болон Тахир дутуу хүний нийгмийн хамгаалалт, түүнд үзүүлэх хөнгөлөлт, үйлчилгээний тухай хуулиудыг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай	1995-12-19 Дугаар 89	Нийгмийн халамжийн тухай хуулиуд, Ахмад настан,түүнд үзүүлэх хөнгөлөлт, үйлчилгээний тухай болон Тахир дутуу хүний нийгмийн хамгаалалт, түүнд үзүүлэх хөнгөлөлт, үйлчилгээний тухай хуулиуд батлагдсантай холбогдуулан Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь: 1/Нийгмийн халамжийн тухай хуулиуд, Ахмад настан, түүнд үзүүлэх хөнгөлөлт, үйлчилгээний тухай болон Тахир дутуу хүний нийгмийн хамгаалалт, түүнд үзүүлэх хөнгөлөлт, үйлчилгээний тухай хуулиудад Засгийн газраас батлан мөрдүүлэхээр тогтоосон дүрэм, журам, тэтгэмж, зардлын хэмжээг 1996 оны 4 дүгээр сарын 1-ний дотор батлан гаргах;
4.	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай	2017-06-09 Дугаар 46	Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь: 1.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай болон Нийгмийн халамжийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Ж.Эрдэнэбат/-т даалгасугай.
5.	Хүн амын нийгмийн хамгааллын талаар авах зарим арга хэмжээний тухай	1997-01-16 Дугаар 5	1.Хүн амын нийгмийн хамгааллыг сайжруулах зорилгоор дор дурдсан арга хэмжээ авахыг Засгийн газар /М.Энхсайхан/-т даалгасугай: 5/Нийгмийн халамжийн талаар төрөөс явуулж буй бодлого, үйл ажиллагаа, нийгмийн халамжийн санг эрхлэн зохион байгуулахдаа ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажилтай нягт уялдуулан зохицуулах.
		Засгийн газрын тогтоол	
1.	Аймгийн засаг даргын тамгын газрын бүтцийг шинэчлэн тогтоох тухай	2016-08-03 **Дугаар 9**	Үндсэн хуулийн Жаран нэгдүгээр зүйлийн 4 дэх хэсэг, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33.2-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь: 4. Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд дор дурдсан хэрэгжүүлэгч агентлаг ажиллуулахаар тогтоосугай: -Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар;
2.	“Ахмад насны төрөлжсөн асрамжийн шинэчлэлийн хөтөлбөр” батлах тухай,	2020.03.04 Дугаар 84	Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.3.26-д “Ахмад настны асаргаа үйлчилгээ, сэргээн засах болон сувилахуйн үйлчилгээг өргөжүүлж, хувийн хэвшлийн асрамжийн газар байгуулахыг дэмжинэ” гэсэн бодлогын зорилтыг хангахад “Ахмад настны төрөлжсөн асрамжийн шинэчлэлийн хөтөлбөр” чиглэгдэх болно. **Хоёр. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх зарчим** 2.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараахь зарчмыг баримтална: 2.1.1. шинэчлэлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ Төрөөс хүн амын талаар баримтлах бодлого болон нийгмийн халамжийн шинэчлэлийн бодлоготой нийцүүлж нийгмийн хамгааллын талаар авч хэрэгжүүлж байгаа салбарын стратегитэй уялдуулсан байх; 2.1.2. ахмад настны төрөлжсөн асрамжийн шинэчлэл хийхэд салбар дундын үйл ажиллагаа, харьяа байгууллагуудын ажлын уялдаа холбоо, оролцогч талууд, гадаад, дотоодын донор байгууллагуудын оролцоог бүрэн дүүрэн хангах; 2.1.3. төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаанд тулгуурлах, иргэд олон нийтийн оролцоог дэмжих, салбар дундын болон төв, орон нутгийн байгууллагын уялдааг хангах, хөрөнгө оруулалтын болон санхүүгийн таатай нөхцөлийг бий болгосон байх;

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХУРААЛЭН www.legal.mn

3.	Үндэсний хөтөлбөр батлах тухай /Ахмад настны хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр”	2019.10.30, Дугаар 389	ХАВСРАЛТ **Тав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа** 5.1. Ахмад настны аж байдлыг дээшлүүлж, ядуурлаас хамгаалах зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ: 5.1.12. ахмад настны амьжиргааг дэмжих, ядуурлаас хамгаалах үйл ажиллагаанд хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх. 5.2. Ахмад настны эрүүл мэнд, эрүүл насжилтыг дэмжих, урт хугацааны тусламж үйлчилгээний стратеги төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ: 5.2.8. Гэрээр болон олон нийтийн оролцоонд түшиглэсэн урт хугацааны тусламж үйлчилгээ үзүүлэгчдийн хөдөлмөрийн үнэлэмж, нийгмийн хамгааллын асуудлыг судалж шийдвэрлэх; 5.2.9. ахмад настанд тусламж, үйлчилгээ үзүүлэгчдийн чадавхыг нэмэгдүүлэх, асаргаа, сувилгааны чиглэлээр сургалтад хамруулах, мэргэшүүлэх, тэдэнд зориулсан зөвлөгөө, дэмжлэг туслалцааг өргөжүүлэх; 5.2.11. түншлэл, хамтын ажиллагаа, олон нийтийн оролцоонд түшиглэн өнөөгийн тогтолцоог боловсронгуй болгох замаар ахмад настанд үзүүлэх тусламж үйлчилгээний сүлжээ бий болгох;
4.	Зорилтот өрхийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр батлах тухай		Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь: 1. “Зорилтот өрхийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр”-ийг хавсралт ёсоор баталсугай. Хавсралт **Арван нэг. Хөтөлбөрийн үр дүн, шалгуур үзүүлэлт** 11.1.2. нийгмийн хамгааллын үйлчилгээ, дэмжлэг туслалцаа зорилтот бүлгийн иргэдэд хүрсэн байна. 11.1.2-д заасан үр дүнгийн хүрээнд. а) в) Нийгмийн халамжийн болон хөгжлийн үйлчилгээнд хамрагдах нөхцөл, болзлыг хангасан иргэд шаардлагатай үйлчилгээндээ бүрэн хамрагдсан байна.
5.	“Гэр оронгүй тэнэмэл амьдралтай иргэдийг нийгэмшүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай”	2014.4.26 дугаар 137	1. Гэр оронгүй тэнэмэл амьдралтай иргэдийг бүртгэлжүүлэн мэдээллийн сан бүрдүүлэх, нийгмийн халамж болон сэтгэл засал, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээнд хамруулах, мэргэжлийн чиг баримжаа олгох, ажлын байранд зуучлах зэрэг тэднийг нийгэмшүүлэх арга хэмжээнд шаардагдах хөрөнгийг орон нутгийн төсөвтөө тусган хэрэгжүүлэхийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

ХУУЛЬЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.gov.mn

6.	Аргачлал шинэчлэн батлах тухай /Орон нутгийн төсвийн суурь зарлага тооцох аргачлал/,	2019.12.18 Дугаар 445	Орон нутгийн төсвийн суурь зарлагад тооцох нийгмийн халамж, асрамжийн үйлчилгээний жагсаалт
			2. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ
			2.1. Амьдралын итгэл үнэмшил, бие даан амьдрах чадвар, хөдөлмөрийн дадал олгох, авьяасыг нь дэмжих зорилгоор сургалт зохион байгуулах
			2.2. Зөвлөгөө өгөх
			2.3. Сэргээн засах үйлчилгээнд хамруулах
			2.4. Түр байрлуулан асрамжлах, хүчирхийлэлд өртсөн хүнийг түр хамгаалан байрлуулах
			2.5. Өдрийн үйлчилгээнд хамруулах
			2.6. Гэрийн асрамж, халамжийн үйлчилгээнд хамруулах
			2.7. Иргэн, түүний гэр бүлийн хэрэгцээнд тулгуурласан нийгмийн халамжийн бусад үйлчилгээ үзүүлэх
			2.8. Гэр оронгүй иргэн, түүний гэр бүлийн гишүүдийн амьдрах итгэлийг нэмэгдүүлэх, нийгэмшүүлэх, бичиг баримтжуулах, түр хоноглох байранд байрлуулах
			2.9. Нийгмийн халамжийн тухай хуулийн 3.1.2, 18.2-т заасан өрх, иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухаанд сургах
			2.10. Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг түр хамгаалан байрлуулах үйлчилгээнд хамруулах
7.	Өнчин, эцэг эхийн хараа хяналтаас гарсан хүүхдийн талаар авах зарим арга хэмжээний тухай	1997-09-22	Улсын Их Хурлын 1997 оны 52 дугаар тогтоолын 6 ду-гаар заалтыг хэрэгжүүлэх зорилгоор **Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь** : 4.Өнчин, эцэг эхийн хараа хяналтаас гарсан болон нэн ядуу айл өрхийн хүүхдүүдийн амьдрал байдлыг сайжруулах зориулалтаар 1997 оны 2 дугаар хагаст 100 сая төгрөг, хэрвээ харж хандах хүнгүй хүүхдэд зориулсан халамж, үйлчилгээний төв байгуулан ажиллуулахад олон улсын халамжийн байгууллагуудаас хөрөнгө гаргахаар бол энэ арга хэмжээнд 50 сая төгрөг тус тус улсын төвлөрсөн төсвөөс гаргахыг Сангийн сайд П.Цагаан, уг хөрөнгийг үр ашигтай зарцуулж, хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайд Л.Зориг нарт тус тус даалгасугай.
8.	"Үндэсний хөтөлбөр батлах тухай"	2019.4.23 дугаар 159	1. "Ажилгүйдэл, ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөр"-ийг 1 дүгээр хавсралт, "Ажилгүйдэл, ядуурлыг бууруулах үндэсний зөвлөл"-ийн бүрэлдэхүүнийг Засгийн газрын 2017 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 27 дугаар тогтоолын 26 дугаар хавсралт болгон 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай. Хавсралт 1. 5.5.10. ядуурлын түвшингийн хамгийн доогуур хэрэглээтэй нэн ядуу иргэдэд нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, үйлчилгээг хүртээмжтэй хүргэж, туйлын ядуурлыг бууруулах;

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХЭЛТЭН www.legalinfo.mn

9.	ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ (Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай)	2017.12.13 дугаар 340	Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох хуулийн 5.1, 7.1, 7.3-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь: 1.“Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох журам”-ыг хавсралт ёсоор баталсугай. (Энэ тогтоолын хавсралтад Засгийн газрын 2018 оны 96 дугаар тогтоолоор нэмэлт, өөрчлөлт орсон) 2.Жирэмсэн эхийн тэтгэмжийн хэмжээг сард 40.000 (дөчин мянган) төгрөг, 0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмжийн хэмжээг сард 50.000 (тавин мянган) төгрөг, ихэр хүүхдийн тэтгэмжийн хэмжээг нэг удаа хүүхэд тус бүрт 1.000.000 (нэг сая) төгрөг, 3 болон түүнээс дээш ихэр хүүхдэд олгох тэтгэмжийн хэмжээг нэг удаа хүүхэд тус бүрт 3.000.000 (гурван сая) төгрөг байхаар тус тус тогтоосугай. 3.Энэ тогтоол гарсантай холбогдуулан Засгийн газрын 2012 оны 185 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж олгох журам”-ын 3.5, 4.7 дахь заалт, Засгийн газрын 2012 оны 136 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Нийгмийн халамжийн сангаас олгох зарим тэтгэмж, ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлэх тусламж, хөнгөлөлтийн хэмжээ”-ний 4, 5 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай. 4.Энэ тогтоолыг 2018 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.
		Сайдын тушаал	
1.	Хууль зүй, дотоод хэргийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаал, Хохирогчид үйлчилгээ үзүүлэх төрийн бус байгууллагыг магадлан итгэмжлэх журам	2017-04-06 Дугаар А/84/ А/59/ А/130	1.6.Хохирогчид хуульд заасан үйлчилгээ үзүүлэх төрийн бус байгууллагыг магадлан итгэмжлэхэд Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын 2014 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн А/52 дугаар тушаалаар баталсан “Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг үзүүлэх байгууллагыг магадлан итгэмжлэх журам”, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2016 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн А/330 дугаар тушаалаар баталсан “Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг үзүүлэх хуулийн этгээдийг магадлан итгэмжлэх журам”-ын холбогдох заалтыг нийцүүлэн хэрэглэж болно.
2.	Эрүүл мэндийн сайд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын хамтарсан тушаал Жагсаалт, шалгуур үзүүлэлт, заавар, маягт батлах тухай	2018-02-23 Дугаар А/69, 48	Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Нийгмийн халамжийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.11 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь: 1.“Байнгын асаргаа шаардлагатай ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэний өвчин, гэмтлийн жагсаалт”-ыг нэгдүгээр,”Байнгын асаргаа шаардлагатай 0-16 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн өвчин, гэмтлийн жагсаалт”-ыг хоёрдугаар,”Байнгын асаргаа шаардлагатай ахмад настан,хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдийг үнэлэх шалгуур үзүүлэлтийг гуравдугаар,“Байнгын асаргаа шаардлагатай иргэн хүүхдийг тодорхойлох заавар”-ыг дөрөвдүгээр, “Байнгын асаргаа шаардлагатай иргэн, хүүхдийн тодорхойлолт маягт”-ыг тавдугаар хавсралтаар тус тус баталсугай.

Хуулийн үнэт зүйлийн лавлах www.nlt.gov.mn

3.	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаал, Журам, загвар шинэчлэн батлах тухай / Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ, ахмад настанд үйлчилгээ үзүүлэх иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагыг магадлан итгэмжлэх/	2019-02-14 **Дугаар А/65**	Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24.2 дахь хэсэг, Нийгмийн халамжийн тухай хуулийн 18.9 дэх хэсэг, Ахмад настны тухай хуулийн 7.3 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь: 1.“Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ, ахмад настанд үйлчилгээ үзүүлэх иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагыг магадлан итгэмжлэх журам”-ыг 1 дүгээр хавсралтаар, “Магадлан итгэмжлэгдсэн иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагад олгох гэрчилгээний загвар”-ыг 2 дугаар хавсралтаар тус тус батлсугай. Хавсралт бүхэлдээ хамаарна.
4.	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаал, Сургалт зохион байгуулах үйлчилгээний чанарт тавигдах шалгуур батлах тухай	2019.12.26 Дугаар 374	Монгол Улсын Нийгмийн халамжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1 дэх заалт, 18.8 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь: 1.Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний “Амьдралын итгэл үнэмшил, бие даан амьдрах чадвар, хөдөлмөрийн дадал олгох, авъяасыг нь дэмжих зорилгоор сургалт зохион байгуулах үйлчилгээний чанарт тавигдах шалгуур”-ыг хавсралтаар батлсугай.
5.	Сангийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын хамтарсан тушаал Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалттай асрамжийн газарт санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам батлах тухай	2018-01-08 Дугаар 03/03	Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Ахмад настны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь: 1.“Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалттай асрамжийн газарт санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам”-ыг хавсралтаар батлсугай.
6.	Эрүүл мэндийн сайдын тушаал, Сувилал, сэргээн засах болон сувилахуйн төвийг магадлан шинжлэх шалгуур батлах тухай,	2020.03.16 Дугаар А/180	Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.18, 22 дугаар зүйлийн 22.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь: 1.“Сувиллыг магадлан шинжлэх шалгуур”-ыг нэгдүгээр, “Сэргээн засах төвийг магадлан шинжлэх шалгуур”-ыг хоёрдугаар, “Сувилахуйн төвийг магадлан шинжлэх шалгуур”-ыг гуравдугаар, Сувилал, сэргээн засах болон сувилахуйн төвд магадлан шинжлэх шалгуураар үнэлгээ хийх аргачлалыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус батлсугай.

ХУУЛЬЗҮЙН ҮНДЭСНИЙ ХЭРЭЭЛЭН
www.mn.gov.mn

7.	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын тушаал, Журам батлах тухай / Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийг суурь боловсролын үйлчилгээнд тасралтгүй хамруулах/,	2018.10.01, Дугаар А/612	Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24.2 дахь хэсэг, “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай” хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.5 дахь заалтыг тус тусүндэслэн ТУШААХ нь: 1.“Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийг суурь боловсролын үйлчилгээнд тасралтгүй хамруулах журам”-ыг хавсралт ёсоор баталсугай. **Хоёр. Ерөнхий зохион байгуулалт** 2.1. “Хамтарсан баг” нь нийгмийн ажилтны хийсэн нөхцөл байдлын үнэлгээг үндэслэн хүчирхийлэлд өртсөн болон болзошгүй эрсдэлд байгаа насанд хүрээгүй хүүхдийг урьдчилан сэргийлж, түр хамгаалах байранд шилжүүлэн суурь боловсролын үйлчилгээнд тасралтгүй хамруулах, тэдний суралцах хэвийн нөхцөлийг хангах ажлыг аймаг, нийслэл, сум, дүүргийн Боловсрол, соёл, урлагийн газар, хэлтэс, Насан туршийн боловсролын төв, ерөнхий боловсролын сургуулийг түшиглэн дараах хэлбэрээр хамтран зохион байгуулна:
Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчдийн тогтоолоор			
1.	“Гэртээ харих зам” хөтөлбөр[142]	2015.10.23 Дугаар 187	Төсөл, хөтөлбөрийн зорилго: Иргэдийг тэнэмэл амьдралд шилжихээс урьдчилан сэргийлэх, гэр оронгүй тэнэмэл амьдралтай иргэдийн нийгмийн амьдралд оролцох оролцоог нэмэгдүүлэх замаар амьдралын чанарыг сайжруулах тухай
Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын тушаал,			
1.	Аргачлал батлах тухай,	2018.04.19, Дугаар А/80	

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХЭЛЭЛЦ
www.nli.gov.mn

[142] http://development.ub.gov.mn/uploads/Gertee-xarix-zam.pdf

Хавсралт 2

2019 оны 11-р сарын 1

№	Дүүрэг	Гэрээ байгуулсан огноо	д/д	Үйлчилгээний төрөл	Байгууллагын нэр	Удирдлагын нэр	Харилцах утас	Тайлбар
1	ХУД	06.06	1	Сургалт зохион байгуулах	“Бат-Өөдөө” ХХК	Б.Хишигжаргал	99023516	2019 онд магадлан авсан.
2		06.06	2	Зөвлөгөө өгөх	“Тэнүүн итгэлт үйлс”	М.Мөнхтогтох	99049779	2019 онд магадлан авсан.
3		06.06	3	Сэргээн засах	“Сайжив Оюу” ХХК	Я.Оюунцэцэг	96635778, 88830799	2019 онд магадлан авсан.
4		06.06	4	Сэргээн засах	Озон сервис” ХХК	Д.Нэмэхбат	91929285, 91909075	2019 онд магадлан авсан.
5		06.06	5	Сэргээн засах	“Батануган СТ” ХХК	П.Тогоо	96620371	2019 онд магадлан авсан.
6		06.06	6	Өдрийн үйлчилгээ	“Ачлалт Орчлон” ХХК	Ө.Сэргэлэн	95143005, 99824847	2018 онд магадлан авсан.
7		06.06	7	Өдрийн үйлчилгээ	“Монголын үндэсний хараагүйчүүдийн холбоо” ТББ	Б.Болдбаатар	88111379	2018 онд магадлан авсан.
8		06.06	8	Гэрийн асрамж халамж	“Монголын мэдрэлийн сэргээн засахын үндэсний нийгэмлэг” НҮТББ	М.Бүрэнтөгс	99559257	2019 онд магадлан авсан.
9		06.06	9	Түр байрлуулан асрамжлах	“Өлзийт Асар” ТББ	Л.Баянмөнх	95244085	2018 онд магадлан авсан.
10		06.06	10	Түр хоноглох	“Хаган богда” ТББ	Б.Алтанбаяр	99088653, 99990796 88014104	2018 онд магадлан авсан.
11	СХД	06.18	1	Сургалт зохион байгуулах, зөвлөгөө өгөх	“Амар тал” ХХК	Д.Алтанцэцэг	99063019	2019 онд магадлан авсан.
12		06.18	2	Сэргээн засах	“Ачит арвис” ХХК	Я.Саранчимэг	98100009	2019 онд магадлан авсан.
13		10.01	3	Сэргээн засах	“Озон сервис” ХХК	Д.Нэмэхбат	91929285, 91909075	2019 онд магадлан авсан.
14		10.01	4	Сэргээн засах	“Хас цэгц” ХХК	Д.Цэцэгсүрэн	99004881	2019 онд магадлан авсан.
15		10.01	5	Сэргээн засах үйлчилгээ	“Ариун лотус” ХХК	Л.Хандсүрэн	88828287	Тодорхой биш
16		06.18	6	Өдрийн үйлчилгээ	“Наянзургаа дөрвөн зуу” ХХК	П.Чинбат	95731260	2019 онд магадлан авсан.
17		06.18	7	Гэрийн асрамж халамж	“Ачлалт хүүхдүүд” ТББ	Я.Болор	94049098	2018 онд магадлан авсан.
18		06.18	8	Түр байрлуулан асрамжлах	“Хүчирхийллийн эсрэг үндэсний төв” ТББ	Н.Арвинтариа	99204558	2019 онд магадлан авсан.
19		06.18	9	Түр хоноглох	“Титэм констракшн” ХХК			2018 онд магадлан авсан.

ХУУЛЬ ЗҮЙН ЯАМНЫ ХУУЛЬ ЗҮЙ www.mojhr.gov.mn

20	БХД	06.19	1	Сэргээн засах, өдрийн үйлчилгээ, түр байрлуулан халамжийн үйлчилгээ	“Хангайн хаш чулуу” ТББ	Д.Боломж	99979406	2019 онд магадлан авсан.
21		06.19	2	Гэрийн асрамж халамж	Багахангай дүүргийн “Улаанзагалмайн хороо” ТББ	Н.Зина	99047472	2018 онд магадлан авсан.
22		07.02	3	Сургалт зохион байгуулах, зөвлөгөө өгөх	“Монголын эрэгтэйчүүдийн хөгжлийн нийгэмлэг” ТББ	Ж.Сугар	98989993	2018 оны 10 сард магадлан авсан
23		07.02	4	Сургалт зохион байгуулах	“Насжилт судлал, настны эмгэг судлалын нийгэмлэг” ТББ	Т.Дулмаа	99756838	2019 онд магадлан авсан.
24	БЗД	07.01	1	Сэргээн засах, өдрийн үйлчилгээ,	“Тулгат МТМ” ХХК	Д.Тунгалаг	99182367	2017 онд магадлан авсан.
25		07.01	2	Өдрийн үйлчилгээ	“Сэтгэл зүйн эрүүл оршихуй” ТББ	Р.Уянга	99250118	2019 онд магадлан авсан.
26		07.01	3	Түр байрлуулан асрамжлах	“Хүчирхийллийн эсрэг үндэсний төв” ТББ	Н.Арвинтариа	99204558	2019 онд магадлан авсан.
27		07.01	4	Түр хоноглох	“Дөлгөөн минж” ТББ	Т.Хатанбаатар	94117546	2018 онд магадлан авсан.
28		07.01	5	Түр хоноглох	“Шинэ амьдрал ялагч” ТББ	А.Батцэнгэл	96328858	2018 онд магадлан авсан.
29		07.25	6	Сургалт зохион байгуудах, зөвлөгөө өгөх	“Сэтгэл зүйн сургалт, хөдөлгөөнт дасгалын төв” ТББ	Д.Оюунчимэг	91914375	2019 онд магадлан авсан.
30		07.25	7	Сургалт зохион байгуулах	“Шинэ хөгжлийн түлхүүр” ТББ	Б. Анхбаяр	99176180	2018 онд магадлан авсан.
31		07.25	8	Зөвлөгөө өгөх	“Хойморын эзэд” ТББ	Б.Мэндбаяр	90242744	2018 онд магадлан авсан.
32		09.05	9	Сэргээн засах, өдрийн үйлчилгээ	“Амьдрах увидас” ХХК	Б.Энхсайхан	88050358	2019 онд магадлан авсан.
33		09.05	10	Түр хоноглох	“Зөв амьдрах ухаан” ТББ	Г.Загдаа	99938959	2018 онд магадлан авсан.
34		09.05	11	Сэргээн засах	“Озон сервис” ХХК	Д.Нэмэхбат	91929285, 91909075	2019 онд магадлан авсан.
35		09.05	12	Сэргээн засах	“Есүн-Удам” ХХК	Б.Идэрмөнх	99026628	2018 онд магадлан авсан.
36		09.05	13	Сэргээн засах	“Дуут баян богд” ХХК	Ц.Пэлжидмаа	99215097	2018 онд магадлан авсан.

ХҮЧИРХИЙЛЛИЙН ЭСРЭГ ҮНДЭСНИЙ ТӨВ
www.nchr.gov.mn

37	ЧД	08.19	1	Сургалт зохион байгуулах	“Насжилт судлал, настны эмгэг судлалын нийгэмлэг” ТББ	Т.Дулмаа	99756838	2019 онд магадлан авсан.
38		08.19	2	Сэргээн засах	“Озон сервис” ХХК	Д.Нэмэхбат	91929285, 91909075	2019 онд магадлан авсан.
39		08.19	3	Сургалт, зөвлөгөө өгөх	“Хойморын эзэд” ТББ	Б.Мэндбаяр	90242744	ЧД авах
39		08.19	4	Өдрийн үйлчилгээ	“МББ жаргалан” ХХК	Д.Оюунчулуун	96001672	2018 онд магадлан авсан.
40		08.19	5	Сэргээн засах үйлчилгээ	“Батануган” ХХК	П.Тогоо	96620371	2019 онд магадлан авсан.
41		08.19	6	Сэргээн засах, өдрийн үйлчилгээ	“Ахмадын мишээл” ТББ	Д.Оюунсүрэн	99132907	2019 онд магадлан авсан.
42		08.19	7	Түр байршуулан асрамжлах	“Хүчирхийллийн эсрэг үндэсний төв” ТББ	Б.Сувд	70119949, 88441944	2019 онд магадлан авсан.
43		08.19	8	Түр хоноглох	“Тэрэм Уул” ХХК	Г.Эрдэнэбат	96601757,	2018 онд магадлан авсан.
44		10.01	9	Сэргээн засах	“Нөйрохелт” ХХК	Б.Рэгзэдмаа	91013052	2018 онд магадлан авсан.
45	БГД	09.04	1	Сургалт зохион байгуулах	“Хайрхан бүрд” ТББ	Р.Нямжав	99059257	2017 онд магадлан авсан.
46		09.04	2	Зөвлөгөө өгөх	“Тэнүүн итгэлт үйлс” НҮТББ	М.Мөнхтогтох	99076577	2018 онд магадлан авсан.
47		09.04	3	Сэргээн засах, өдрийн үйлчилгээ	“Очир дэлэг” ХХК	Г.Ганзориг	88313533, 99030545	2018 онд магадлан авсан.
48		09.04	4	Сэргээн засах үйчлилгээ	“Эй ви жи” ХХК	О.Бат-Эрдэнэ	99177347	2019 онд магадлан авсан.
49		09.04	5	Сэргээн засах үйчлилгээ	“Пиксел” ХХК	Б.Содбилэг	88011045	2018 онд магадлан авсан.
50		09.04	6	Сэргээн засах, өдрийн үйлчилгээ	“Гурван цохиот” ХХК	А.Дариймаа	99050649	2018 онд магадлан авсан.
51		09.04	7	Өдрийн үйлчилгээ	“Монголын үндэсний хараагүйчүүдийн холбоо” ТББ	Б.Болдбаатар	88111379	2018 онд магадлан авсан.
52		09.04	8	Гэрийн асрамж халамжийн үйлчилгээ	“Түгээмэл хөгжил” ТББ	Ч.Ундрахбаяр	99267408, 99856665	2018 онд магадлан авсан.
53		09.04	9	Түр байршуулан асрамжлах	“Хүчирхийллийн эсрэг үндэсний төв” ТББ	Б.Сувд	70119949, 88441944	2019 онд магадлан авсан.

ХЭРЭГЛЭГЧИЙН ХЭСЭГ www.mlsp.gov.mn

54	СБД	09.09	1	Зөвлөгөө өгөх	“Нийгмийн даатгалын мэдээллийн холбоо” ТББ	Р.Наранцэцэг	88002766, 99118085	2019 онд магадлан авсан.
55		09.09	2	Сэргээн засах	“Озон сервис” ХХК	Д.Нэмэхбат	91929285, 91909075	2019 онд магадлан авсан.
56		09.09	3	Сэргээн засах	“Ачит арвис” ХХК	Я.Саранчимэг	98100009	2019 онд магадлан авсан.
57		09.09	4	Сэргээн засах	“Хаш чулуун энхийн цэцэг” ХХК	Ж.Энхцэцэг	99008471, 99682040	2019 онд магадлан авсан.
58		09.09	5	Сэргээн засах, өдрийн үйлчилгээ,	“Тулгат МТМ” ХХК	Д.Тунгалаг	99182367	2017 онд магадлан авсан.
59		09.09	6	Түр байршуулан асрамжлах	“Хүчирхийллийн эсрэг үндэсний төв” ТББ	Б.Сувд	70119949, 88441944	2019 онд магадлан авсан.
60	НД	08,20	1	Сургалт зохион байгуулах, зөвлөгөө өгөх	“Цэлмэг ухаан нандин хүсэл” ТББ	А.Хүслэн	91860120	2018 онд магадлан авсан.
61		08,20	2	Сургалт зохион байгуулах, зөвлөгөө өгөх	“Өүлэн эхийн ачлал” ХХК	П.Эрдэнэтогтох		2019 онд магадлан авсан.
62		08.20	3	Сэргээн засах, өдрийн үйлчилгээ	“Си си мэд” ХХК	Г.Сувдаа	80478074	2019 онд магадлан авсан.
63	БНД	10.23	1	Сургалт зохион байгуулах	“Азийн нөхөрлөл” ТББ	Д.Номуунзаяа	99152277	2018 онд магадлан авсан.
64		10.23	2	Сэргээн засах үйлчилгээ үзүүлэх	“Замбага трейд” ХХК	М.Шүрэнцэцэг	99286194	2019 онд магадлан авсан.
65		10.23	3	Гэрийн асрамж халамж , өдрийн үйлчилгээ	Багануур дүүргийн “Улаан загалмай хороо” ТББ	Л.Хонгорзул	94079798	2018 онд магадлан авсан.
66		10.23	4	Өдрийн үйлчилгээ	“Ахмадын хороо ТББ”	Ж.Мядаг	99127031	2018 онд магадлан авсан.

ХУУЛЬЗҮЙН ЯАМНЫ ЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.mlsjpv.mn

Хавсралт 3

д/д	Хууль, журмын заалт	Үйлчилгээний төрөл	Нэмэлт мэдээлэл, хэрэгжүүлэх аргачлал
1	НХТ Хууль 18.1.1	Амьдралын итгэл үнэмшил, бие даан амьдрах чадвар, хөдөлмөрийн дадал олгох, авьяасыг нь дэмжих зорилгоор сургалт зохион байгуулах;	**Үйлчилгээний чиглэл:** 1. Амьдрах ухааны болон бие даан амьдрах ур чадвар эзэмшүүлэх; 2. Хөдөлмөрийн дадал олгох, авьяасыг нь дэмжих зорилгоор сургалт зохион байгуулах; 3. Амьдралын итгэл үнэмшил бий болгох сургалт зохион байгуулах; **Үйлчилгээний хэлбэр:** 1. Өөртөө итгэх итгэл, өөрийгөө үнэлэх үнэлэмж бий болгох; 2. Зорилтот бүлгийн гэр бүлийн гишүүдэд зориулсан сургалт зохион байгуулах; 3. Өдөр тутмын амьдралын дарамт, стрессийг даван туулах чадварыг бий болгох; 4. Эрүүл амьдралын хэв маягт хэвшүүлэх; 5. Тодорхой бэрхшээл, эрсдлээс зайлсхийх, даван туулах, урьдчилан сэргийлэх чадварыг бий болгох; 6. Мэргэжлийн чиг баримжаа олгох **Хамрагдах өрх, иргэн:** 1. Ахмад настан; 2.Хөгжлийн бэрхшээлтэй иргэн 3. Хүчирхийлэлд өртсөн иргэн; 4 Хорих ангиас суллагдсан иргэн; 5.Согтуурах, мансуурах донтох өвчтэй иргэн; 6. Гэр оронгүй тэнэмэл амьдралтай өрх, иргэн; 7. Шилжин суурьшсан нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэн; 8. Өрх толгойлсон эх /эцэг/;
2	НХТ Хууль 18.1.2	Зөвлөгөө өгөх;	**Үйлчилгээний чиглэл:** 1. Хууль зүйн зөвлөгөө өгөх; 2. Сэтгэл зүйн зөвлөгөө өгөх; **Үйлчилгээний хэлбэр** 1. Амьдралын асуудлаа өөрсдөө шийдвэрлэхэд туслах; 2. Тулгарч буй сэтгэл зүйн асуудал, бэрхшээлтэй нөхцөл байдлыг оношлон тогтоох, шийдвэрлэхэд нь мэргэжлийн тусламж, дэмжлэг үзүүлэх; **Хамрагдах өрх, иргэн:** 1. Ахмад настан; 2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн; 3. Хүчирхийлэлд өртсөн иргэн; 4. Хорих ангиас суллагдсан иргэн; 5.Согтуурах, мансуурах донтох өвчтэй иргэн; 6. Гэр оронгүй тэнэмэл амьдралтай өрх, иргэн; 7. Шилжин суурьшсан нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэн; 8. Өрх толгойлсон эх /эцэг/; 9. Эдгэшгүй хүнд өвчтэй иргэн
3	НХТ Хууль 18.1.3	Сэргээн засах үйлчилгээнд хамруулах	**Үйлчилгээний чиглэл:** 1. Эрүүл мэндийн сэргээн засах; 2.Боловсролын сэргээн засах; 3. Хөдөлмөрийн сэргээн засах; 4.Нийгэм-сэтгэл зүйн сэргээн засах; **Үйлчилгээний хэлбэр:** 1. Хэл, хөдөлгөөн, ахуйн, сэтгэл заслын үйлчилгээ үзүүлэх; 2.Эзэмшсэн мэргэжлийн нь сэргээх, ур чадварыг нь сайжруулах; 3. Алдагдсан чадварыг сэргээхэд чиглэсэн орчныг бүрдүүлэх, сэтгэл зүйн нөлөөллийг үзүүлэх;

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ҮЙЛЧЛЭЛ www.legal.mn

			4. Нийгмийн зан үйл, нөлөөллийн аргуудыг ашиглах замаар хүмүүсийн харилцааны боломжит нөхцөлийг бүрдүүлэх; 5.Боловсрол эзэмших, хөдөлмөр эрхлэх боломжийг бүрдүүлэх, ахуйн үйлчилгээ үзүүлэх, шаардлагатай байгууллагын үйл ажиллагаанд хамруулах, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, сэтгэл засал хийх, сэтгэл санааны дэмжлэг үзүүлэх; **Хамрагдах өрх, иргэн:** 1. Ахмад настан; 2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн; 3. Хүчирхийлэлд өртсөн иргэн; 4. Хорих ангиас суллагдсан иргэн; 5.Согтуурах, мансуурах донтох өвчтэй иргэн; 6. Гэр оронгүй тэнэмэл амьдралтай өрх, иргэн; 7. Шилжин суурьшсан нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэн; 8.Өрх толгойлсон эх /эцэг/; 9. Эдгэшгүй хүнд өвчтэй иргэн Тайлбар: Сэргээн засах үйлчилгээ нь хүний алдагдсан эрүүл мэнд, хөдөлмөрлөж аж төрөх чадварыг сэргээж, нийгмийн болон хувийн амьдралд нь идэвхитэй оролцох боломж нөхцлийг нь бүрдүүлэхэд нийгэм анагаах ухаан, хөдөлмөр сургалт сэтгэл зүйн цогц үйлчилгээ.
4	НХТ Хууль 18.1.4	Түр байрлуулан асрамжлах	**Үйлчилгээний чиглэл:** 1. Хүчирхийлэлд өртөх магадлалтай иргэдийг урьдчилан сэргийлэх; 2. Хүчирхийлэлд өртсөн иргэдэд стандартын дагуу үйлчилгээ үзүүлэх; **Үйлчилгээний төрөл:** 1. Бичиг баримтжуулах, 2. Эрүүл мэндийн болон хууль зүйн үйлчилгээ үзүүлэх; 3. Хөгжлийн дэмжлэг, туслалцаа үзүүлэх, 4. Холбон зуучлах; 5. Хүүхдэд бүх төрлийн үйлчилгээ үзүүлэх; 6. Халуун хоол цайгаар үйлчлэх; **Хамрагдах өрх, иргэн:** 1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн; 2. Хүчирхийлэлд өртсөн иргэн; 3. Хорих ангиас суллагдсан иргэн; 4.Согтуурах, мансуурах донтох өвчтэй иргэн; 5. Шилжин суурьшсан Нийгмийн халамжийн тухай хуулийн 3.1.2-т заасан өрхийн гишүүн -иргэн; 6. Хүнд нөхцөлд байгаа хүүхэд; **Түр байрлуулан асрамжлах үйлчилгээ:** Хохирогчийг хүлээн авснаас эхлэн 1 долоо хоногоос 3 сар хүртэлх хугацаанд тусламж үйлчилгээ үзүүлнэ. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн эсхүл хүчирхийлэлд өртөх магадлалтай хохирогч, түүний бага насны хүүхдийг тодорхой хугацаагаар байрлуулж хохирогчид хэрэгцээтэй мэдээлэл, эрх зүйн болон бусад зөвлөгөө өгөх, сэтгэхүй нь түр хямарсан үед эмчилгээ хийх сэргээн засах зэрэг үйлчилгээ үзүүлнэ.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ҮЙЛЧИЛГЭЭНД www.legal.mn

5	НХТ Хууль 18.1.5	Өдрийн үйлчилгээ	**Үйлчилгээний чиглэл:** 1. Ахмад настны өдрийн үйлчилгээ үзүүлэх; 2. Хүнд нөхцөлд байгаа хүүхдийн өдрийн үйлчилгээ үзүүлэх; 3. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн өдрийн үйлчилгээ үзүүлэх; 4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний өдрийн үйлчилгээ үзүүлэх; **Үйлчилгээний хэлбэр:** 1. Соёл, урлаг биеийн тамир спортын арга хэмжээнд оролцуулах; 2. Сэргээн засах; 3. Амьдрах ухаанд сургах; 4. Зөвлөгөө өгөх; **Хамрагдах өрх, иргэн:** 1. Ахмад настан; 2. Хүнд нөхцөлд байгаа хүүхэд; 3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн ба хүүхэд Өдрийн үйлчилгээ: Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэний чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, амьдралын чанарыг дээшлүүлэх, хүнд нөхцөлд байгаа хүүхдүүдийн эрхийг хамгаалах, нийгэмшүүлэх, амьдрах ухаанд сургах үйлчилгээ
6	НХТ Хууль 18.1.6	Гэрийн асрамж, халамжийн үйлчилгээ	**Үйлчилгээний хэлбэр:** 1. Гэр ахуйн үйлчилгээ үзүүлэх; 2.Өдөр тутмын асаргааны үйлчилгээ үзүүлэх; 3.Гадуур ажилд туслах үйлчилгээ үзүүлэх; 4.Эрүүл мэнд, эмчилгээний дэглэм сахиулах; 5. Хоол хүнс бэлтгэх, хоолны дэглэм сахиулах, хооллож ундлах; **Хамрагдах өрх, иргэн:** 1. Байнгын асаргаатай ахмад настан; 2. Байнгын асаргаатай хөгжлийн бэрхшээлтэй иргэн; 3. Хүнд нөхцөлд байгаа хүүхэд;
7	НХТ Хууль 18.1.7	Иргэн, түүний гэр бүлийн хэрэгцээнд тулгуурласан нийгмийн халамжийн бусад үйлчилгээ үзүүлэх;	**Үйлчилгээний чиглэл:** 1. Өрх, иргэний амьдралын нөхцөл байдлыг өөрсдийнх нь оролцоотойгоор үнэлэх; 2. Өрх, иргэний нөөц боломж чадавхи хэрэгцээнд тохирох үйлчилгээг туршин хэрэгжүүлэх; **Үйлчилгээний хэлбэр:** 1. Өөрсдөө бие даан хөгжих боломжийг нь судалж, 2. Өрхийн нөхцөл байдлыг судлан үнэлэх, нөөц боломж, чадавхийг тодорхойлж, сэтгэл зүйн нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх, нийгмийн халамжийн болон хөгжүүлэх үйлчилгээ үзүүлэх. **Хамрагдах өрх, иргэн:** 1. Ахмад настан; 2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн; 3. Хүчирхийлэлд өртсөн иргэн; 4. Хорих ангиас суллагдсан иргэн; 5.Согтуурах, мансуурах донтох өвчтэй иргэн; 6. Гэр оронгүй тэнэмэл амьдралтай өрх, иргэн 7. Шилжин суурьшсан нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн -иргэн; 8. Эдгэшгүй хүнд өвчтэй иргэн; 9. Өрх толгойлсон эх /эцэг/; Аргачлал: Өөрсдөө бие даан хөгжих боломж нөхцөл хязгаарлагдмал, нийгмийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн нөхцөл байдлыг судлан үнэлэх, нөөц боломж, чадавхи, хэрэгцээг өрхийн гишүүдийн оролцоотой тодорхойлж, өрхийн гишүүдийг сэтгэл зүйн хувьд сэргээн засах, нийгмийн халамжийн болон хөгжлийн үйлчилгээг үзүүлнэ.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЛЦЭН www.legal.mn

8	НХТ Хууль 18.1.9	Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрх, иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухаанд сургах.	**Үйлчилгээний чиглэл:** 1. Төсөл бичих, түүнийг хэрэгжүүлэх амьдрах ухааны сургалтанд хамруулах, зөвлөгөө өгөх 2. Хамт олны бүлэг бүрдүүлж орлого нэмэгдүүлэх, үйлдвэрлэл үйлчилгээний төсөл хэрэгжүүлэх, нийгэмшүүлэх **Үйлчилгээний хэлбэр:** 1. Төсөл бичих чадвартай болгох; 2. Багаар ажиллах чадвартай болгох. 3. Тухайн төслөө хэрэгжүүлэхэд шаардлагатай ур чадвартай болгох; 4. Тухайн төслийг цааш нь өргөжүүлэх санхүүгийн эх үүсвэртэй болох; **Хамрагдах өрх, иргэн:** 1. Ахмад настан; 2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн; 3. Хүчирхийлэлд өртсөн иргэн; 4. Хорих ангиас суллагдсан иргэн; 5.Согтуурах, мансуурах донтох өвчтэй иргэн; 6. Гэр оронгүй тэнэмэл амьдралтай өрх, иргэн; 7. Шилжин суурьшсан нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэн; 8. Өрх толгойлсон эх /эцэг/; 9. Эдгэшгүй хүнд өвчтэй иргэн Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай 2 ба түүнээс дээш өрх, иргэд өөрсдийн санаачлагаар нэгдэн бүлэг болж орлогоо нэмэгдүүлэх зорилгоор төсөл боловсруулан хэрэгжүүлэх нь олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний нэг төрөлд хамрагдана. Иргэдийн ирүүлсэн төслийг амьжиргааг дэмжих зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлнэ. АДЗ-өөр дэмжигдсэн төслийг НХҮХ хянаж үзээд хэрэгжих магадлалтай бол 1,0 сая хүртэлх төгрөгөөр санхүүжүүлнэ.

(Footnotes)

1 Дэлгэрэнгүйг харилцан уялдаа хэсгийн “Хуулийн төслийн зүйл, заалт нь тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх” хэсгээс үзнэ үү.

2 Дэлгэрэнгүйг үнэлгээний тайлангийн “зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийг үнэлсэн хэсгээс үзнэ үү.

3 ХЗДХ сайдын 2017.2.14-ний өдрийн А/39 дүгээр тушаалаар батлагдсан “Хүчирхийлэлд өртсөн хүүхдийг түр хамгаалах журам”-ыг баримжаалав.

4 Бүртгэлийн гэрчилгээ олгохоос эхлээд улсын бүртгэлийн дэлгэрэнгүй лавлагаа авах хүртэлх үйлчилгээ баггах юм.

5 Нэг байршлаас нөгөө байршил руу ирэх, очих хугацаа, замын хөдөлгөөний нягтаршил зэргийг харгалзан дээд хугацаагаар тооцов.

6 Энэ нь анхан шатны зөвлөгөө өгөх хугацаа бөгөөд сэтгэл заслын эмчилгээ 2 жил хүртэл хугацаагаар үргэлжилдэг байна.

7 Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс.

8 Хог хаягдал зайлуулах, устгал, ариутгалд хамаарах бөгөөд хангамж, бараа материалын зардлын нэг хэсэг болдог байна.

9 Нэг ширхэг автомашинд ногдох зардал.

10 МУЗГ-ын 2005 оны 233 дугаар тогтоол “Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох журам, Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцоход баримтлах хугацаа, жилд байгуулах элэгдлийн хэмжээ”.

11 Мөн тэнд – Хоёрдугаар хавсралт, Үнийг дунджаар 800,000₮ гэж тооцоход 20% нь элэгдэл, хорогдол буюу 160,000₮ болно.

12 Мөн тэнд – Хоёрдугаар хавсралт, Эд хогшил болох ширээ, сандал, шүүгээ, утасны аппаратын үнийг *дунджаар 1,000,000₮ гэж тооцоход* 10% нь элэгдэл хорогдол буюу 100,000₮ болно.

13 ЗГ-ын 2002 оны 120 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Төрийн албан хаагчийн албан ажлын унаа, өрөөний талбайн хэмжээ, тавилга, хэрэгслийн нийтлэг

жишиг”–т заасны дагуу нэг дэс түшмэлд ногдох ажлын өрөөний талбай 8м2 талбай байна. Үүнээс 2,300,000,000₮ 4483м2 = 513,049.29₮ нь 1м2 талбайн өртөг бөгөөд 8м2 талбайн өртөг нь 4,104,394.37₮ болно. Нэг албан хаагчид оногдох талбайн өртөг 4,104,394.37₮ гэж тооцоход 1,6% нь элэгдэл хорогдол буюу 65,670₮ болно.

14 Мөн тэнд. Түр хамгаалах байрны 1 хоногийн зардалд “Цалин, шимтгэл” гэдгийг нэгтгэн “цэвэрлэгээ, үйлчилгээний хөлс” гэж өөрчилсөн ба нийт үнийн дүнд өөрчлөлт ороогүй болно. /ажилтны цалин хөлсийг хүний нөөцийн зардалд тооцсон тул энд давхардуулан тооцох шаардлагагүй гэж үзлээ./

15 “Хохирогчийг хамгаалах байрны үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага” MNS 6040:2009 Монгол Улсын стандартад зааснаар “Түр хамгаалах байр” гэж хохирогчийг хүлээн авснаас эхлэн 1 долоо хоногоос 3 сар хүртэлх хугацаанд тусламж, үйлчилгээ үзүүлэх газрыг хэлэх бөгөөд нийт зардлыг тооцохдоо дээд хугацаа болох 3 сар буюу 90 хоногийн хугацаагаар тооцов. Ингэхдээ Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын 2018 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн А/80 дугаар тушаалын хавсралтаар баталсан нэг хоногийн зардлыг 90 хоногоор үржүүлэн нийт дүнг гаргасан.

16 А/80 дугаар тушаалын хавсралтад бичиг баримттай холбоотой үйлчилгээний зардлыг тусгаснаас нийт дүнг авав.

17 Мөн тэнд. Нэг үйлчлүүлэгчид шаардлагатай уламжлалт болон орчин үеийн аргаар сэргээн засах үйлчилгээний дүнг нэгтгэн гаргасан.

18 https://medee.mn/single/147218 сүүлд үзсэн 2020.5.25

19 Улаанбаатар хотын Захирагч С.Амарсайхан https://updown.mn/104555.html Сүүлд үзсэн 2020.5.25

20 Г.Загдаа эмзэг бүлгийн иргэдийн 600 гаруй саяыг завшжээ. https://www.urug.mn/news/1048

21 БЗД-ийн хяналтын албаны мэргэжилтэн Ч.Гүндсамбуу /ярилцлагын хэсгээс/

22 Баянзүрх дүүргийн халамжийн албаны дарга Ш.Ганцэцэг /ярилцлагаас/

23 http://development.ub.gov.mn/uploads/Gertee-xarix-zam.pdf

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭЛ
www.nli.gov.mn

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХУРЭЭЛЭН
www.nli.gov.mn

ХОЁР. ХАРЬЦУУЛСАН ЛАВЛАГАА

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХУРЭЭЛЭН
www.nli.gov.mn

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХУРЭЭЛЭН
www.nli.gov.mn

ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ХОЛБОО, САНГИЙН НИЙТЭД ТУСТАЙ ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ХОЛБООТОЙ ХАРИЛЦААГ ЗОХИЦУУЛСАН ХУУЛЬ ТОГТООМЖ[1]

УДИРТГАЛ

Хууль зүй, дотоод хэргийн яам /цаашид "ХЗДХЯ" гэх/-наас Холбооны эрх зүйн байдлын тухай хууль, Сангийн эрх зүйн байдлын тухай хууль, Нийтэд тустай үйл ажиллагааны тухай хуулийн төслийг тус тус боловсруулахтай холбогдуулан "Гадаадын зарим орны холбоо, сангийн нийтэд тустай үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулсан хууль тогтоомж" сэдэвт харьцуулсан судалгаа хийлгэхээр тус хүрээлэнд захиалга ирүүлсэн.

Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс хуулийн этгээд, төрийн бус байгууллагатай холбоотойгоор хэд хэдэн судалгаа, лавлагааг гүйцэтгэн ХЗДХЯ-нд хүргүүлж байсан. Тухайлбал, "Нийтэд тустай, сайн дурын үйл ажиллагааны үр нөлөөтэй эрх зүйн зохицуулалт" сэдэвт бодлогын судалгаа (2013 он), "Төрийн бус байгууллагын санхүүжилт, татварын эрх зүйн зохицуулалт" бодлогын судалгаа (2015 он), "Гадаадын зарим орнуудын хуулийн этгээдийн төрөл" сэдэвт лавлагаа (2017 он), "Төрийн бус байгууллагын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ" болон Төрийн бус байгууллагын тухай хуультай холбоотой харьцуулсан судалгаа (2018 он). Эдгээр судалгаанд хуулийн этгээд, тэр дундаа төрийн бус байгууллагын төрөл, үйл ажиллагаа, гадаадын болон Монгол Улсын эрх зүйн зохицуулалт, тулгамдсан асуудлыг нэлээд дэлгэрэнгүй судалж, дүгнэлт, санал дэвшүүлж байжээ.

Иймд энэ удаад ХЗДХЯ-наас ирүүлсэн захиалгын дагуу гадаадын зарим орны ашгийн төлөө бус хуулийн этгээдийн төрөл болох холбоо, сангийн эрх зүйн зохицуулалт, эдгээр байгууллагын нийтэд тустай үйл ажиллагааны талаарх харилцааг зохицуулсан хуулийн зохицуулалтын хүрээнд тус ажлыг гүйцэтгэнэ.

Уг судалгааг гүйцэтгэх хугацааны хувьд маш богино байсан төдийгүй улс орныг хамарсан бүх нийтийн бэлэн байдал зарласантай холбогдуулан хөл хорионы хатуу дэглэм үйлчилж байгаа цаг үед хийж байгаа тул судалгааны багийн зүгээс голчлон цахим эх сурвалжид тулгуурлан Холбооны Бүгд Найрамдах Герман Улс, Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Солонгос Улсын эрх зүйн зохицуулалтыг тусгайлан авч харьцуулсан лавлагаа хэлбэрээр гүйцэтгэлээ.

Энэхүү лавлагааг гүйцэтгэхдээ тухайн сонгон авсан улс орны хууль тогтоомжид холбоо, сангийн харилцааг хэрхэн зохицуулсан байдаг, эдгээр байгууллагаас хэрэгжүүлдэг нийтэд тустай үйл ажиллагаанд ямар үйл ажиллагаа хамаардаг болоод эрх зүйн зохицуулалтыг хэрхэн хийсэн талаар судалсан бөгөөд холбоо, сангийн эрх зүйн зохицуулалтын үр нөлөөний талаар үнэлэлт, дүгнэлт хийгээгүй болно.

НЭГ. ХОЛБООНЫ БҮГД НАЙРАМДАХ ГЕРМАН УЛС (ХБНГУ)

ХБНГУ нь Монгол Улстай нэг эрх зүйн бүлд харьяалагддаг төдийгүй эх газрын эрх зүйн тогтолцооны гол төлөөлөгч улс болохын хувьд тус улсыг сонгон авч холбогдох зохицуулалтыг судаллаа.

Холбоо, сангийн харилцааг зохицуулж буй хууль тогтоомж болон нийтэд тустай үйл ажиллагааны талаарх зохицуулалт

[1] Энэхүү лавлагааг ХЗҮХ-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга, хууль зүйн доктор П.Амаржаргал удирдан, Эрдэм шинжилгээний ахлах ажилтан Г.Халиунаа, Эрдэм шинжилгээний ажилтан Ч.Батзориг, Г.Сувд-Эрдэнэ, С.Цэрэндолгор нар хамтран гүйцэтгэв.

ХБНГУ-ын Үндсэн хуулийн[2] “Холбооны эрх чөлөө” хэмээх 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Герман хүн корпораци, холбоонд эвлэлдэн нэгдэх эрхтэй” гэж заасан. Мөн зүйлийн 2 дахь хэсэгт “Холбооны зорилго, үйл ажиллагаа нь Үндсэн хуулийн дэг журам, Эрүүгийн хууль болон олон улсын үзэл баримтлалын эсрэг байхыг хориглоно”; 3 дахь хэсэгт “Хүн бүр ажил мэргэжил, эдийн засгийн болон хөдөлмөрлөх нөхцөлөө сайжруулах, хамгаалах зорилгоор холбоод байгуулах эрхтэй. Энэхүү эрхийг хориглох эсхүл хязгаарлахаар тохиролцсон гэрээ нь хүчин төгөлдөр бус байна ...” гэж тус тус зааснаар холбоо байгуулах үндэслэл, эрхийг баталгаажуулжээ.

Ийнхүү ХБНГУ-ын Үндсэн хуулиар холбоо (герм. Verein) байгуулах эрхийг баталгаажуулсан бол ХБНГУ-ын Иргэний хууль (BGB)[3] /цаашид “ИХ” гэх/-аар холбоог хуулийн этгээд болохын хувьд эрх зүйн байдлыг нь тодорхойлсон байна.

ХБНГУ-ын хувьд холбооны үйл ажиллагааг дээрх хоёр хуулиар ерөнхийд нь зохицуулахаас гадна “Холбооны тухай хууль”; “Холбооны тухай хуулийг дагаж мөрдөх журам”; “Холбоог бүртгэх журам” гэсэн хууль тогтоомжоор тухайлан зохицуулдаг. Энэ хуулиудад дээр дурдсан Үндсэн хууль, ИХ-ийн зохицуулалтыг нарийвчлан хуульчилсан байна. Тус бүрд нь товч авч үзье.

ХБНГУ-ын Холбооны тухай хууль (герм. *Vereinsgesetz*)[4]

Тус хууль нь нийт 33 зүйлтэй бөгөөд Үндсэн хуулийн 9 дүгээр зүйл, ИХ-д заасан ерөнхий зохицуулалтыг нарийвчлан хуульчилсан. Тус хуулийн 2 дугаар зүйлд холбооны тодорхойлолт болон холбоонд үл хамаарах хуулийн этгээдийг хуульчилжээ.

Холбоо гэж үзэх хамгийн чухал шалгуур нь “сайн дураар, нийтийн зорилгын дор, удаан хугацаагаар эвлэлдэн нэгдсэн” хуулийн этгээдийг хэлэхээр байна. Ингэхдээ дараах хоёр байгууллагыг холбоонд хамааруулахгүй гэжээ:

- Үндсэн хуулийн 21 дүгээр зүйлд заасан улс төрийн намууд;
- Холбооны Муж улсын Парламент, Бундестагийн фракцууд.

Тус хуульд мөн “Гадаад иргэдийн байгуулсан холбоо” (гишүүд болон удирдах зөвлөл нь гадаадын харьяат иргэдээс бүрдсэн холбоо); “олон улсын холбоо” (бүтэц, үйл ажиллагаа нь олон улсын хүрээг хамарсан, хилийн чанадад суурилсан холбоо); “Ажилтан, ажил олгогчийн холбоо”; “Бизнесийн холбоо” зэрэг холбооны тусгай төрлүүдийг зохицуулснаараа онцлогтой.

ХБНГУ-ын Холбооны тухай хуулийг дагаж мөрдөх журам (герм. *Verordnung zur Durchfьhrung des Gesetzes zur Regelung des цffentlichen Vereinsrechts*)[5]

Тус журам нь нийт 25 зүйлтэй, Холбооны тухай хуулийн 19 дүгээр зүйлд үндэслэсэн бөгөөд холбоог бүртгэх эрх бүхий байгууллагын эрх; үүрэг; маргаан; гомдол шийдвэрлэх журам; олон улсын холбоог бүртгэх; мэдээлэл өгөх үүрэг зэргийг зохицуулжээ.

ХБНГУ-ын Холбоог бүртгэх журам (герм. *Vereinsregisterverordnung* (VRV))[6]

---

[2] Хууль зүйн үндэсний хүрээлэн, *ХБНГУ-ын Үндсэн хууль*, орч. П.Амаржаргал нар (Уб, ХЗҮХ, 2020).

[3] *ХБНГУ-ын Иргэний хууль (Кодификацийн бүрэн эх)*, орч. Б.Буянхишиг (Уб, “Соёмбо принтинг” ХХК, 2017).

[4] Vereinsgesetz vom 5. August 1964 (BGBl. I S. 593), das zuletzt durch Artikel 149 der Verordnung vom 19. Juni 2020 (BGBl. I S. 1328) geändert worden ist. – Холбооны хуулийн эмхэтгэлийн 1964 оны I дугаарт нийтлэгдэж, хамгийн сүүлд 2020 оны 6 дугаар сарын 19-нд нэмэлт оруулсан.

[5] Verordnung zur Durchführung des Gesetzes zur Regelung des öffentlichen Vereinsrechts (Vereinsgesetz) vom 28. Juli 1966 (BGBl. I S. 457), die zuletzt durch Artikel 6 Absatz 1 des Gesetzes vom 22. August 2002 (BGBl. I S. 3390) geändert worden ist. – Холбооны хуулийн эмхэтгэлийн 1966 оны I дугаарт нийтлэгдэж, хамгийн сүүлд 2002 оны 8 дугаар сарын 22-нд өөрчлөлт оруулсан.

[6] Vereinsregisterverordnung vom 10. Februar 1999 (BGBl. I S. 147), die zuletzt durch Artikel 6 des Gesetzes

Тус журам нь нийт 31 зүйл, хоёр хавсралттай ба холбоог бүртгэх журам (холбоог байгуулах, бүртгэх, татан буулгах)-ыг нэг бүрчлэн, нарийвчлан зохицуулсан байна.

Харин ХБНГУ-ын Үндсэн хуульд сан (герм. Stiftungen)-гийн талаар тухайлан зохицуулаагүй боловч холбоо байгуулах эрхийн талаар зохицуулсан 9 дүгээр зүйлийг агуулгаар нь хамааруулах боломжтой юм.

Түүнчлэн, тус улсын сангийн тухай эрх зүйн зохицуулалтын хамгийн чухал онцлог нь 16 Муж улс тус бүр өөрсдийн Сангийн тухай хуультай. Холбооны тухай хууль нь улсын хэмжээнд үйлчилдэг бол Сангийн тухай хууль нь тухайн Муж улсын харилцааг дангаар нь зохицуулдаг. Иймд ИХ-аар сан байгуулахад шаардагдах хөрөнгийн хэмжээг тогтоогоогүй боловч сангийн зорилгыг тогтмол, тогтвортой хэрэгжүүлэх хэмжээний хөрөнгөтэй байхыг шаарддаг. Үүний дагуу Муж улс тус бүрийн Сангийн тухай хуульд санг бүртгэхэд шаарддаг мөнгөн дүнг тогтоодог бөгөөд ихэвчлэн доод хэмжээг €50,000 (тавин мянган евро)-гоор тогтоосон байна.

Мөн тус улсын “сан”-гийн эрх зүйн зохицуулалт нь нэр томьёоны хувьд гагцхүү “Stiftung”-аар хязгаарлагддаггүйгээр онцлогтой. Тодруулбал, сангийн бусад хэлбэр гэдэгт холбоо, хувьцаат компани, хязгаарлагдмал хариуцлагатай компани зэрэг хамаардаг ба эдгээр нь нэрийн хувьд “сан” гэсэн нэр томьёог хэрэглэж болдог. Тухайлбал, ХБНГУ-ын томоохон сангуудын нэг болох Роберт Бошийн Сан (герм. *Robert Bosch Stiftung*) нь хязгаарлагдмал хариуцлагатай компани (*GmbH*)-ийн хэлбэрээр үйл ажиллагаа явуулдаг.

Ийнхүү сангийн үйл ажиллагааг дээр дурдсан ИХ-аар ерөнхийлөн зохицуулж, муж улс тус бүрийн хуулиар нарийвчлан зохицуулахаас гадна “Сангийн тухай хууль”; “Германы амлалт, сайн дурын үйл ажиллагаа явуулах сан байгуулах тухай хууль”-аар зохицуулдаг. Эдгээр хуулийг тус бүрд нь товч авч үзье.

ХБНГУ-ын Сангийн тухай хууль (герм. *Stiftungsgesetz*)[7]

Тус хууль нь Бүгд Найрамдах Ардчилсан Герман Улсын үед батлагдсан бөгөөд хүчин төгөлдөр үйлчилж байна. Гэсэн хэдий ч Муж улсууд тус бүрдээ Сангийн тухай хуультай учир уг хуулийн хамрах хүрээ, хэрэгжилтийн хязгаар өргөн биш ажээ. Хууль нь нийт 32 зүйлтэй, санг бүртгэх, бүртгэхээс татгалзах үндэслэлийг тодорхой зохицуулсан. Харин ИХ-аас ялгаатай нь нийтийн эрх зүйн хэм хэмжээний дагуу байгуулагддаг сан болон хуулийн этгээдийн эрхгүй санг хуульчилснаараа онцлогтой байна.

Германы амлалт, сайн дурын үйл ажиллагаа явуулах сан байгуулах тухай хууль (герм. *Gesetz zur Errichtung der Deutschen Stiftung fьr Engagement und Ehrenamt*)[8]

Тус хууль нь “Германы амлалт, сайн дурын үйл ажиллагаа явуулах сан” хэмээх нийтийн эрх зүйн хэм хэмжээний үндсэн дээр байгуулагдсан, хуулийн этгээдийн эрхтэй сангийн үйл ажиллагааг зохицуулсан, 14 зүйлтэй хууль юм.

Ийнхүү ХБНГУ-ын сангийн зохицуулалт нь төрөлжсөн, тусдаа зохицуулалттай боловч Холбооны Засгийн газар ИХ-ийн сантай холбоотой зохицуулалтыг шинэчлэх талаар хэлэлцэж байгаа[9] ажээ. Энэхүү шинэчлэл нь сангийн зорилгыг

vom 24. September 2009 (BGBl. I S. 3145) geändert worden ist. – Холбооны хуулийн эмхэтгэлийн 1999 оны I дугаарт нийтлэгдэж, хамгийн сүүлд 2009 оны 9 дүгээр сарын 24-нд нэмэлт оруулсан.

[7] Stiftungsgesetz vom 13. September 1990 (GBl. DDR 1990 I S. 1483) – 1990 оны 9 дүгээр сарын 13-ны өдрийн Сангийн тухай хууль (Бүгд Найрамдах Ардчилсан Герман Улсын 1990 оны Хуулийн эмхэтгэлийн I дугаарт нийтлэгдсэн)

[8] Gesetz zur Errichtung der Deutschen Stiftung für Engagement und Ehrenamt vom 25. März 2020 (BGBl. I S. 712) – Тус хууль нь 2020 оны 3 дугаар сарын 25-ны өдөр батлагдсан бөгөөд Холбооны хуулийн эмхэтгэлийн 2020 оны I дугаарт нийтлэгдсэн.

[9] https://www.cof.org/country-notes/nonprofit-law-germany#:~:text=Under%20German%20law%2C%20almost%20any,used%20to%20form%20an%20NPO.&text=German%20NPOs%20are%20generally%20governed,the%20German%20states%20(L%C3%A4nder). [Сүүлд үзсэн: 2020.11.12]

өөрчлөх тохиолдолд шаардах үндэслэлүүдийг илүү тодорхой болгож, нарийвчлан хуульчлахад чиглэж байна.

Нэмж дурдахад, тус улсын хувьд нийтэд тустай үйл ажиллагаа явуулдаг тусгайлсан эрх зүйн байдал бүхий байгууллага байхгүй бөгөөд хамгийн сүүлд 2020 онд дээрх санг байгуулсан.

Сангийн үйл ажиллагааны чиглэл

Дээрх хуулиар сангийн зорилгыг дараах байдлаар томьёолсон:

1. Иргэдийн оролцоо, сайн дурын үйл ажиллагааны хүрээнд зорилтот бүлэгт чиглэсэн цогц үйлчилгээ санал болгох, тухайлбал, зөвлөгөө, арга зүйгээр хангах;
2. Иргэдийн оролцоо, сайн дурын үйл ажиллагааг хөгжүүлэх чиг үүрэг бүхий байгууллагууд, ялангуяа дижиталчлалаар дагнасан байгууллагуудыг мэдээллээр хангах;
3. Холбоо, муж улс, хот, хувийн хэвийн хэвшил, иргэний нийгмийг хооронд нь зуучлан холбох;
4. Иргэдийн оролцоо, сайн дурын үйл ажиллагаа, ялангуяа дижитал инновацийн чиглэлийн сайн дурын үйл ажиллагааны салбарыг хөхүүлэн дэмжих;
5. Бүтцийн хувьд сул бүтэцтэй болон хөдөө, орон нутаг дахь иргэдийн оролцоо, сайн дурын үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудыг чадавхжуулах;
6. 1 болон 5-д заасан чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай судалгаа, шинжилгээ хийх.

Тус сан нь ХБНГУ-ын Гэр бүл, ахмад, эмэгтэйчүүд, хүүхэд, залуучуудын яамны харьяа байгууллага байж, холбооны төсвөөс санхүүжиж, сайн дурын үйл ажиллагаа буюу нийтэд тустай үйл ажиллагаа явуулах дагнасан чиг үүрэг бүхий сан болж байгаагаар онцлогтой болно.

ХБНГУ-д “нийтэд тустай үйл ажиллагаа” (герм. Frei-gemeinnьtzige Arbeit) гэдгийг иргэн, хуулийн этгээдээс ямар нэг нөхцөл, болзолгүй сайн дурын хүсэл зоригоор, тодорхой хугацаатай, хариу төлбөргүй, зохион байгуулалтай, олон нийт, нийгмийн төлөө хийх ажлыг[10] ойлгодог.

Дээрх хууль тогтоомжуудад ийнхүү холбооны талаар нэг бүрчлэн, нарийвчлан хуульчилсан боловч нийтэд тустай үйл ажиллагаа явуулахтай холбоотой харилцааг зохицуулаагүй байна. Харин сангийн харилцааг зохицуулсан хууль тогтоомжид нийтэд тустай үйл ажиллагаа явуулахтай холбоотой зохицуулалтыг тусгаж өгсөн гэж үзэж болохоор байна.

Холбоо, сангийн төрөл

ХБНГУ-ын ИХ-ийн 21-79 дүгээр зүйлд “холбоо”-ны талаар тухайлан зохицуулж 1/ашгийн бус холбоо (герм. *Nicht wirtschaftlicher Verein*); 2/ашгийн төлөө холбоо (герм. *Wirtschaftlicher Verein*) гэж хоёр ангилсан. Мөн “эрх зүйн чадамжгүй холбоо” (герм. *Nicht rechtsfдhige Vereine*) гэж байна.

Харин тус улсад санг ямар хэм хэмжээний үндсэн дээр байгуулагдаж байгаагаас хамааран 1/нийтийн эрх зүйн сан (герм. *Stiftung des цffentlichen Rechts*); 2/хувийн эрх зүйн сан (герм. *Stiftungen des Privatrechts*) гэж хоёр ангилна.

[10] Harald A. Mieg, Theo Wehner: *Frei-gemeinnützige Arbeit: Eine Analyse aus Sicht der Arbeits und Organisationspsychologie* (Harburger Beiträge zur Psychologie und Soziologie der Arbeit Nr. 33). Technische Universität HamburgHarburg, Arbeitswissenschaft, 2002. *Төрийн бус байгууллагын тухай хуулийг шинэчлэн найруулах хэрэгцээ, шаардлагын тандан судалгаа,* Баасанжав Консалтинг” ХХК (Уб, 2017), 17 дахь талаас дам эшлэв.

www.mn.gov.mn

Нийтийн эрх зүйн сан гэдэгт нийтийн эрх зүйн хэм хэмжээний үндсэн дээр байгуулагддаг, нийтийн зорилгын төлөө үйл ажиллагаа явуулдаг этгээдийг хэлнэ. Ийм сангуудад тухайлбал, орон нутгийн сангууд, сүм хийдийн сангууд хамаардаг. Харин ХБНГУ-ын ИХ-ийн 80-88 дугаар зүйлд хуулийн этгээдийн эрхтэй, хувийн эрх зүйн сангийн эрх зүйн байдлыг зохицуулсан.

Хуулийн этгээдийн эрхтэй сан (герм. *Entstehung einer rechtsfðhigen Stiftung*):

ИХ-ийн 80 дугаар зүйлд зааснаар "нийтийн эрх ашигт хохиролтой бус зорилго бүхий, тэрхүү зорилгоо урт хугацаанд тогтвортой хэрэгжүүлэх боломжтой санг хуулийн этгээдийн эрхтэй гэж хүлээн зөвшөөрнө". Энд заасан тогтвортой урт хугацаа гэдгийг мөн зүйлд "10 жил" гэж тодорхойлсон.

Холбоо, санг бүртгэх ба татан буулгах

Холбооны дээрх хоёр төрлөөс "ашгийн бус холбоо" нь түгээмэл бөгөөд ИХ-ийн 22 дугаар зүйлд зааснаар ашгийн төлөө холбоо нь хууль тогтоомжид тусгалаа олоогүй тул төрийн зүгээс тусгайлан эрх олгох замаар эрх зүйн чадамжтай болдог байна. Харин ашгийн бус холбоог Анхан шатны шүүхийн дэргэдэх холбооны бүртгэлд бүртгэснээр эрх зүйн чадамжтай болдог.

Холбооны эрх зүйн чадварыг хасах үндэслэлийг ИХ-ийн 43 дугаар зүйлд заасан ба "дүрэмд зааснаас өөр үйл ажиллагаа явуулсан" бол тухайн холбоог анх бүртгэсэн байгууллага эрх зүйн чадварыг нь хасаж болно.

Тус улсын ИХ-ийн холбоотой хамаарах онцлог бүхий зохицуулалт нь "Холбооны электрон бүртгэл" (55а дугаар зүйл) юм. Муж Улсын Засгийн газраас холбооны бүртгэлийг автоматжуулсан сан хэлбэрээр бүртгэх тухай тогтоол гаргаж, хэрэгжүүлдэг байна.

Харин сан нь удирдлагын төв байр байрлах газрын харьяалах Муж улсын эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл олгосны үндсэн дээр хуулийн этгээдийн эрхтэй болдог байна. Эрх бүхий байгууллага нь санг бүртгэхдээ хуульд заасан тодорхой шалгуур хангасан эсэхийг эн тэргүүнд шалгах бөгөөд иргэн, хуулийн этгээдийн аль аль нь сангийн үүсгэн байгуулагч байж болохоор зохицуулалтыг хуульчилжээ. Ингэхдээ сан, тэр дундаа гэр бүлийн санг хуульд нийцсэн аливаа зорилгоор байгуулж болохыг зохицуулсан нь ерөнхий бөгөөд уян хатан зохицуулалт байна.

Холбоо, сангийн татвар, хөнгөлөлт, чөлөөлөлт

Хэдийгээр дээр хууль тогтоомждоо нийтэд тустай үйл ажиллагаа явуулдаг байгууллагын эрх зүйн байдал, хэлбэрийг тодорхой, хатуу тогтоогоогүй боловч холбоо болон санг нийтийн болон хувийн зорилгоор байгуулж болох тул нийтийн зорилгоор байгуулж, холбогдох хуулийн шаардлагыг хангасан тохиолдолд татварын тусгай хөнгөлөлт эдлэх эрхтэй байдаг байна. Тодруулбал, Төсвийн тухай хууль (герм. *Abgabenordnung*)-аар дараах гурван зорилго бүхий байгууллага (холбоо, сан)-ыг татвараас чөлөөлдөг. Үүнд:

- Нийтэд тустай үйл ажиллагаа явуулах зорилго бүхий (§52);
- Буяны үйл ажиллагаа явуулах зорилго бүхий (§53);
- Сүм хийдийн зорилгоор үйл ажиллагаа явуулах (§54) гэжээ.

Ингэхдээ хуулийн §52 дугаар зүйлд нийтэд тустай үйл ажиллагаа гэдэгт дараах бүлэгт чиглэсэн болон дараах тодорхой үйл ажиллагааг хамааруулахаар заажээ: (1) шинжлэх ухаан; (2) шашин; (3) нийтийн эрүүл мэнд; (4) хүүхэд, хөгшид; (5) урлаг, соёл; (6) түүхэн нөөц; (7) боловсрол; (8) байгаль хамгаалал; (9) нийтийн халамж; (10) хохирогч, хөгжлийн бэрхшээлтэй, улс төрийн зорилгоор хэлмэгдсэн хүмүүс; (11) амьдрал хамгаалагчид (англ. *lifeguards*); (12) осол гэмтлээс урьдчилан сэргийлэх; (13) олон улсын ойлголцол, хүндлэл; (14) амьтан хамгаалал; (15) хөгжлийн тусламж; (16) хэрэглэгчийг хамгаалах; (17) ял эдлэгсдийг нийгэмшүүлэх; (18)

хүйсийн ялгаварлалгүй байдал; (19) гэрлэлт, гэр бүл; (20) гэмт хэргээс урьдчилан сэргийлэх; (21) спорт (шатар хамаарна); (22) дотоодын түүх, газарзүй; (23) мал аж ахуй, тариалан, уламжлалт зан заншлууд (Багт наадам хамаарна), сонирхогчдын радио, нисэх онгоцны загвар, нохойн спорт; (24) Герман дахь ардчилсан улс төрийн тогтолцоо; (25) нийтийн ашиг тусын төлөөх иргэдийн оролцоо зэрэг болно.

ХОЁР. ОРОСЫН ХОЛБООНЫ УЛС (ОХУ)

Холбоо, сангийн харилцааг зохицуулж буй хууль тогтоомж болон нийтэд тустай үйл ажиллагааны талаарх зохицуулалт

Оросын Холбооны Улсын Үндсэн хуулийн "Хүний болон иргэний эрх, эрх чөлөө" бүлгийн 39 дүгээр зүйлд "Нийгмийн сайн дурын даатгал, нийгмийн хамгааллын нэмэлт хэлбэрийг бий болгох болон буяны үйл ажиллагааг дэмжих", 30 дугаар зүйлд "Хүн бүр хуулийн этгээд байгуулах, түүний дотор тэдний ашиг сонирхлыг хамгаалах үүднээс үйлдвэрчний эвлэл байгуулах эрхтэй" болохыг тодорхойлсон.[11] Иргэдийн энэхүү үндсэн эрхийг хэрэгжүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх үүднээс нийтэд тустай үйл ажиллагааны харилцааг 1996 онд батлагдсан "Буяны болон сайн дурын үйл ажиллагааны тухай"[12] тусгайлан зохицуулсан холбооны хууль болон тус үйл ажиллагааг хэрэгжүүлэх 1996 онд батлагдсан "Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн тухай"[13] холбооны хуулиар зохицуулдаг.

"Буяны болон сайн дурын үйл ажиллагааны тухай" холбооны хуульд нийтэд тустай үйл ажиллагаа буюу буяны үйл ажиллагаа гэх ойлголтыг иргэн болон хуулийн этгээдийн сайн дурын, ашиг олох зорилгогүйгээр (үнэ төлбөргүй эсхүл хөнгөлөлттэй нөхцөлөөр) иргэн, хуулийн этгээдэд эд хөрөнгө тэр дундаа мөнгөн хөрөнгө шилжүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх эсхүл бусад дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа гэж тайлбарласан бол "Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн тухай" холбооны хуульд хуулийн этгээдийг байгуулж буй зорилго нь иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, биеийн тамир, спортыг хөгжүүлэх, иргэдийн оюун санааны болон бусад биет бус хэрэгцээг хангах, иргэд, байгууллагын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахад чиглэгдсэн.[14]

Холбоо, сангийн тухай эрх зүйн зохицуулалтыг ОХУ-ын "Иргэний хууль"-ийн 50 дугаар зүйлд ерөнхий байдлаар зохицуулсан бол "Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн тухай" холбооны хуульд нарийвчлан зохицуулсан байна.

Холбоо, сангийн төрөл

Сан нь нийгэм, буяны үйл ажиллагаа, соёл, боловсрол болон бусад нийгэмд тустай үйл ажиллагааг эрхлэх зорилгоор иргэн, хуулийн этгээдийн гишүүнчлэлгүй, сайн дурын өмчийн хандивын үндсэн дээр байгуулсан ашгийн төлөө бус хуулийн этгээд юм. Үүсгэн байгуулагчдын сан руу шилжүүлсэн эд хөрөнгө нь сангийн өмч бөгөөд үүсгэн байгуулагчид болон сан нь харилцан бусад этгээдүүдийн өмнө хүлээсэн үүрэгтэй холбоотойгоор хариуцлагыг хүлээхгүй.[15]

[11] ОХУ-ын Үндсэн хуулийн 39 дүгээр зүйл, http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_28399/fe434e420c3130424bbee0b97bc794f0e96c3081/ (Сүүлд үзсэн: 2020.11.10)

[12] ОХУ-ын "Буяны болон сайн дурын үйл ажиллагааны тухай" холбооны хууль, http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_7495/ (Сүүлд үзсэн: 2020.11.10)

[13] ОХУ-ын "Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн тухай" холбооны хууль, http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_8824/ (Сүүлд үзсэн: 2020.11.10)

[14] ОХУ-ын "Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн тухай" холбооны хуулийн 2 дугаар зүйл, http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_8824/87a16eb8a9431fff64d0d78eb84f86accc003448/ (Сүүлд үзсэн: 2020.11.10)

[15] ОХУ-ын "Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн тухай" холбооны хуулийн 7 дугаар зүйл, http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_8824/a60bdb6ce5f9c05a91d70ec8204b1a753cebaee1/ (Сүүлд үзсэн: 2020.11.12)

Сангийн явуулах үйл ажиллагаа, цар хүрээнээс хамааран дараах төрлөөр байгуулагдаж болно:

- сан ("Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн тухай" холбооны хуулийн дагуу үйл ажиллагаагаа явуулдаг);
- нийтийн сан («Олон нийтийн холбоодын тухай» холбооны хуулийн дагуу үйл ажиллагаагаа явуулдаг);
- буяны сан («Буяны болон сайн дурын үйл ажиллагааны тухай» холбооны хууль, "Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн тухай" холбооны хуулийн дагуу үйл ажиллагаа явуулдаг);
- олон нийтийн буяны сан («Буяны болон сайн дурын үйл ажиллагааны тухай» холбооны хууль, "Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн тухай" холбооны хууль, «Олон нийтийн холбоодын тухай» холбооны хууль тогтоомжийн дагуу ажилладаг).

Холбоо нь нийгэмд ашиг тустай тэр дундаа мэргэжлийн эрх, ашиг сонирхлыг төлөөлж хамгаалах мөн холбооны хуультай зөрчилдөхгүй бусад үйл ажиллагаа эрхлэх зорилгоор байгуулагдсан гишүүнчлэл бүхий иргэн, хуулийн этгээдийн ашгийн төлөө бус хуулийн этгээд юм.[16]

"Буяны болон сайн дурын үйл ажиллагааны тухай" холбооны хуульд буяны байгууллагын үйл ажиллагаа явуулах хэлбэрээс хамааран хувь хүн болон ашгийн төлөө бус хуулийн этгээд байж[17] болох бөгөөд тус этгээдүүд нь өөрийн үйл ажиллагааны зорилгод нийцүүлэн үйл ажиллагаагаа дэлгэрүүлэх зорилгоор холбоо, сан хэлбэрээр харилцан тохиролцон, гэрээний үндсэн дээр нэгдэж ашгийн төлөө бус хуулийн этгээд байгуулж болохоор зохицуулсан байна.

Холбоо, сан нь нэгдэж байгаа тохиолдолд өөрсдийн хараат бус байдал болон хуулийн этгээдийн эрхийг хэвээр хадгалан авч үлдэхээс гадна түүнд нэгдсэн гишүүдийнхээ үүргээс үүссэн хариуцлагыг хүлээдэггүй, нэгдэх гэрээнд заасан хэм хэмжээ, дарааллын дагуу хариуцлагыг хүлээх зохицуулалтыг хуулиар тодорхойлсон.[18]

Сайн дурын болон буяны үйл ажиллагаа эрхэлдэг этгээдүүд ОХУ-ын хууль тогтоомж, нэгдэн орсон олон улсын гэрээнд заасан журмын дагуу олон улсын буяны үйл ажиллагааг эрхлэх эрхтэй. Олон улсын буяны үйл ажиллагааны төсөлд, олон улсын буяны байгууллагуудын ажилд, гадаадын байгууллагуудтай буяны үйл ажиллагаатай холбоотойгоор харилцах түүнчлэн ОХУ-ыг хуульд харшлахгүйгээр олон улсын зарчим, эрх зүйд үндэслэн бусад хэлбэрээр олон улсын буяны үйл ажиллагаанд оролцож болно. Тус үйл ажиллагаатай холбоотойгоор хуульд харшлахгүйгээр бусад улс оронд банкны харилцах данстай байж болно. Буяны байгууллага нь гадаад улсын иргэн, харьяалалгүй хүн, гадаадын болон олон улсын байгууллагаас хандив тусламж авах мөн тэдгээр этгээдүүд ОХУ-ын нутаг дэвсгэр дээрх буяны үйл ажиллагаанд оролцох эрхтэй[19] байдаг байна.

---

[16] ОХУ-ын "Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн тухай" холбооны хуулийн 11 дүгээр зүйл, http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_8824/e46eaf5d69e335ddbd0839f17ebcba4c581690c2/ (Сүүлд үзсэн: 2020.11.12)

[17] ОХУ-ын "Буяны болон сайн дурын үйл ажиллагааны тухай" холбооны хуулийн 6 дугаар зүйл, http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_7495/2ed3d0b5267bd2036f397b45b099a596dd16dd94/ (Сүүлд үзсэн: 2020.11.10)

[18] ОХУ-ын "Буяны болон сайн дурын үйл ажиллагааны тухай" холбооны хуулийн 14 дүгээр зүйл, http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_7495/e32fec43350b4eeb0b56acd682ed8b8afd2fbc39/ (Сүүлд үзсэн: 2020.11.10)

[19] ОХУ-ын "Буяны болон сайн дурын үйл ажиллагааны тухай" холбооны хуулийн 21 дүгээр зүйл, http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_7495/edaffcedf573489bfece73f9719a5ab6c014f83a/ (Сүүлд үзсэн: 2020.11.11)

Буяны болон сайн дурын байгууллагын үйл ажиллагааны чиглэл

Дараах зорилгоор буяны болон сайн дурын үйл ажиллагаа явуулна. Үүнд:[20]

- ажилгүй болон амьжиргааны түвшнээс доогуур байгаа иргэн, өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг бие даан хамгаалж чадахгүй хөгжлийн бэрхшээлтэй болон оюуны хомстолтой иргэнд үзүүлэх нийгмийн халамжийн үйлчилгээ;
- хар салхи, байгалийн гамшиг, зэвсэгт мөргөлдөөн, дайны улмаас хохирсон хохирогчдод туслах үйл ажиллагаа;
- үндэстэн хоорондын энх тайван, эв найрамдлыг бэхжүүлэх, нийгэм, үндэсний, шашны мөргөлдөөнөөс урьдчилан сэргийлэхэд дэмжлэг үзүүлэх;
- нийгэм дэх гэр бүлийн оролцоо болон нэр хүндийг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;
- эцэг, эх, хүүхдийг хамгаалахад дэмжлэг үзүүлэх;
- шинжлэх ухаан, хүмүүнлэг, боловсрол, соёл, хүмүүжлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;
- иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, сурталчлах үйл ажиллагаа, эрүүл амьдралын хэв маягийг сурталчлах, иргэдийн ёс суртахуун, сэтгэлзүйн байдлыг сайжруулахад дэмжлэг үзүүлэх;
- биеийн тамир, спортын салбар дахь үйл ажиллагааг сурталчлах (мэргэжлийн спортоос бусад), бие бялдрын спорт, спортын арга хэмжээг зохион байгуулах, зохион байгуулахад ажлыг үнэ төлбөргүй гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх хэлбэрээр оролцох;
- хүрээлэн буй орчин, ан амьтан, байгалийн өв соёлыг хамгаалах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;
- онцгой байдлын үед ард иргэд болон газар нутгаа хамгаалах, тухайн нөхцөлд болон галын аюулгүй байдлыг хэрхэх талаар мэдлэгийг сурталчлах;
- ард иргэдэд үнэ төлбөргүй хууль зүйн зөвлөгөө, тусламж үзүүлэх;
- сайн дурын үйл ажиллагаа явуулах, түүнийг сурталчлах;
- насанд хүрээгүй этгээдүүдийн эрхийг хамгаалах үйл ажиллагаа;
- хүүхэд, залуучуудад шинжлэх ухаан, техник, урлагийн бүтээлч байдлыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, тэдгээрт эх оронч, оюунлаг, ёс суртахууны боловсролыг сурталчлах.

Дээрх хэлбэрээс бусдаар мөнгөн болон бусад материаллаг эд хөрөнгөөр арилжааны байгууллага, улс төрийн нам бусад хөдөлгөөн эвслүүдийг дэмжих нь буяны болон сайн дурын үйл ажиллагаанд хамаарахгүй. Түүнчлэн сонгуулийн өмнөх сурталчилгаа, ард нийтийн санал асуулгатай холбоотой сурталчилгааны ажлыг буяны үйл ажиллагаатай зэрэг явуулахыг хориглодог[21] байна.

Сайн дурын болон буяны байгууллагын санхүүжилт

Дараах үйл ажиллагаанаас олох орлогоор сайн дурын болон буяны байгууллагын өмч хөрөнгийг бүрдүүлнэ:[22]

---

[20] ОХУ-ын "Буяны болон сайн дурын үйл ажиллагааны тухай" холбооны хуулийн 2 дугаар зүйл, http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_7495/64f28a13d583f3ad112dbfef99c8eb61c548bf8e// (Сүүлд үзсэн: 2020.11.10)

[21] ОХУ-ын "Буяны болон сайн дурын үйл ажиллагааны тухай" холбооны хуулийн 2 дугаар зүйл, http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_7495/64f28a13d583f3ad112dbfef99c8eb61c548bf8e// (Сүүлд үзсэн: 2020.11.11)

[22] ОХУ-ын "Буяны болон сайн дурын үйл ажиллагааны тухай" холбооны хуулийн 15 дугаар зүйл, http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_7495/ff1611d3e290c8a8b567906ab2e1e5394813ccfd/ (Сүүлд

- буяны байгууллага үүсгэн байгуулагчдын оруулсан хувь;
- гишүүнчлэлийн хураамж;
- иргэн, хуулийн этгээдээс өгсөн бэлэн болон бэлэн бус хандив (буяны буцалтгүй тусламж);
- борлуулалтаас бусад гүйлгээний орлого (үнэт цаасны орлого багтана);
- олон нийтийг татах үйл ажиллагаанаас олох орлого (хүмүүнлэгийн үйлс, сайн дурын ажилтнуудыг татах кампанит ажил, үүнд зугаа цэнгэл, соёл урлаг, спорт болон бусад олон нийтийн арга хэмжээ зохион байгуулах, ОХУ-ын хууль тогтоомжийн дагуу хандив цуглуулах, хонжворт сугалаа, дуудлага худалдаа зохион байгуулах, буяны үйл ажиллагаанд зориулж бусад этгээдүүдээс өгсөн эд хөрөнгө, хандивыг тэдний хүслийн дагуу зарах);
- хууль ёсны дагуу арилжааны үйл ажиллагаанаас олсон орлого;
- буяны байгууллагаас байгуулсан аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны орлого;
- сайн дурын ажилчдын бий болгосон орлого;
- хуулиар хориглоогүй бусад эх үүсвэр.

Сайн дурын болон буяны байгууллагыг бүртгэх ба татан буулгах

Сайн дурын болон буяны байгууллагыг улсын бүртгэлд бүртгүүлэхдээ "Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн тухай" холбооны хуулийн 13.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу бүртгүүлдэг бөгөөд оршин суугаа газартайн холбоотойгоор улсын бүртгэлд бүртгэхээс татгалзахыг хориглодог, хэрэв бүртгэхээс татгалзсан тохиолдолд шүүхийн журмаар маргаанаа хянан шийдвэрлүүлэх эрхтэй.[23]

Буяны байгууллага нь өөрийн зорилгод харшлах үйл ажиллагаа, түүнчлэн холбооны хуулийг зөрчсөн үйл ажиллагаа явуулсан тохиолдолд тухайн байгууллагыг бүртгэсэн байгууллага анхааруулгыг бичгэн хэлбэрээр мэдэгдэнэ, хэрэв хэд хэдэн удаа анхааруулах бичиг илгээсэн тохиолдолд тус буяны байгууллагыг татан буулгаж болох бөгөөд тус анхааруулгыг шүүхийн журмаар маргаж болно. Татан буулгасан буяны байгууллагын эд хөрөнгийг улсын өмч болгон хурааж, буяны зорилгоор хэрэглэнэ.[24]

Сайн дурын болон буяны байгууллагын татвар, хөнгөлөлт, чөлөөлөлт

"Буяны болон сайн дурын үйл ажиллагааны тухай" холбооны хуульд заасан буяны үйл ажиллагааны хүрээнд бараа шилжүүлэх (ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх), өмчийн эрхийг үнэ төлбөргүй шилжүүлэх тохиолдолд онцгой албан татвар ногдохоос бусад эд хөрөнгийг ОХУ-ын 2000 оны "Татварын тухай" холбооны хуульд заасны дагуу татвараас чөлөөлнө.

ГУРАВ. БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛС (БНСУ)

БНСУ нь гүйцэтгэх, шүүх, хууль тогтоох гэсэн 3 засаглал бүхий иргэний эрх зүйд суурилсан үндсэн хуулийн ардчилалтай улс юм. Ерөнхийлөгч нь гүйцэтгэх засаглалын тэргүүнээс гадна төрийн тэргүүн, зэвсэгт хүчний ерөнхий командлагч юм. Хууль тогтоох засаглалыг 300 гишүүн бүхий үндэсний ассамблей хэрэгжүүлдэг ба мөн орон нутгийн ассамблей аймаг, хотын түвшинд үйл ажиллагаа явуулдаг.

үзсэн: 2020.11.11)

[23] ОХУ-ын "Буяны болон сайн дурын үйл ажиллагааны тухай" холбооны хуулийн 9 дүгээр зүйл, http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_7495/f7c4946a05b01957c44d050ad6cf11d1e70d4e87/ (Сүүлд үзсэн: 2020.11.11)

[24] ОХУ-ын "Буяны болон сайн дурын үйл ажиллагааны тухай" холбооны хуулийн 9 дүгээр зүйл, http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_7495/f7c4946a05b01957c44d050ad6cf11d1e70d4e87/ (Сүүлд үзсэн: 2020.11.11)

Шүүх засаглалыг хэрэгжүүлэх бүрэлдэхүүнд Улсын дээд шүүх, улсын томоохон хотууд дахь давж заалдах шатны шүүх, дүүргийн давж заалдах шатны шүүх болон орон нутгийн шүүхүүд багтдаг.[25]

Холбоо, сангийн харилцааг зохицуулж буй хууль тогтоомж болон нийтэд тустай үйл ажиллагааны талаарх зохицуулалт

БНСУ-д иргэд эвлэлдэн нэгдэж холбоо байгуулах эрх чөлөөг тус улсын Үндсэн хуулийн 21-р зүйлээр хуульчилсан байдаг. Тухайлбал, 21-р зүйлийн (1) дэх хэсэгт "Иргэд үг хэлэх, хэвлэн нийтлэх, цугларах, эвлэлдэн нэгдэх эрх чөлөөтэй" гэж заасан байна.[26] Холбооны үйл ажиллагааг Иргэний хууль болон Нийтийн ашиг сонирхлын төлөөх байгууллагын байгуулал ба үйл ажиллагааны тухай хууль болон бусад дэмжих чиглэлийн хуулиар зохицуулдаг.

Холбоо, сан үйл ажиллагаа эрхлэхэд Иргэний хуулиас гадна Ашгийн төлөө бус байгууллага болон төрийн бус байгууллагыг дэмжих тухай хууль,[27] Олон нийтийн салбарыг дэмжих тухай хууль,[28] Гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих тухай хууль,[29] Хандив цуглуулах, зарцуулах тухай хууль,[30] Байгууллагын татварын тухай хуулийн[31] холбогдох зүйл, заалтыг баримталдаг.

Холбоо, сангаас зохион байгуулж болох нийтэд тустай үйл ажиллагааны тодорхойлолт, эдгээр байгууллага нийтэд тустай үйл ажиллагааг хэрхэн зохион байгуулах талаар хуулийн нэгдсэн зохицуулалт байхгүй байна. БНСУ-ын Нийтийн ашиг сонирхлын төлөөх байгууллагын байгуулал ба үйл ажиллагааны тухай хуулиар ийм төрлийн байгууллагын удирдлага, зохион байгуулалтыг Иргэний хуулийн нэмэлт байдлаар зохицуулдаг. Уг хуулиар сургуулийн эсвэл судалгааны тэтгэлэг, нийгмийн сайн сайханд хувь нэмэр оруулах зорилготой буяны тусламж, дэмжлэг үзүүлэхтэй холбоотой үйл ажиллагааг зохион байгуулах зорилго бүхий холбоо, сангийн зохион байгуулалт, удирдлага, хөрөнгө, санхүүгийн харилцааг зохицуулдаг.[32]

Нийтэд тустай үйл ажиллагаанд хандив өргөх, хандивын зарцуулалттай холбоотой харилцааг Хандив цуглуулах, зарцуулах тухай хуулиар зохицуулдаг. Тус хуулиар ашиг олох, улс төрийн болон шашны дэмжлэг үзүүлэхээс бусад зорилгоор хандив цуглуулах, зарцуулах үйл ажиллагааг авч үздэг. Тухайлбал, хуулийн 4-р зүйлийн (2) дахь хэсэгт зааснаар олон улсын тусламжийн үйл ажиллагаа, байгалийн гамшигт өртөгсдөд туслах үйл ажиллагаа, ядуурлыг бууруулах чиглэлийн буяны үйл ажиллагаа, боловсрол, соёл, урлаг, шинжлэх ухааныг дэмжих, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалсан эдийн засгийн дэмжлэг, байгаль орчин хамгаалах, нийгмийн эмзэг бүлгийн эрх ашгийг хамгаалах, нийгмийн эрүүл мэнд, халамжийг дэмжих, Өмнөд болон Хойд Солонгосын нэгдлийн төлөөх энхийг сахиулах олон улсын үйл ажиллагаа, нийгмийн эрүүл мэнд, иргэдийн оролцоог бий болгох, БНСУ-ын Ерөнхийлөгчийн зарлигаар тогтоосон нийтийн ашиг сонирхлын төлөөх үйл

[25] Park, Sauk-Hee, and Mark Wilding. "The politics of government reform in Korea: From tripartite to bipartite politicization." *Administration & Society* 48, no. 9 (2016): 1059-1084.

[26] Article 21(1) of the South Korean Constitution, 1948, https://www.icrc.org/applic/ihl/ihlnat.nsf/162d151af444ded44125673e00508141/aba339f342ad7493c1256bc8004c2772/$file/constitution %20-%20korea%20-%20en.pdf

[27] Assistance for non-profit, non-governmental organizations act, https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=47145&lang=ENG

[28] Social enterprise promotion act, http://ethmar.social/wp-content/uploads/2017/08/43-South-Korea-SOCIALENTERPRISEPROMOTIONACT.pdf

[29] Foreign investment promotion act, https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=49546&lang=ENG

[30] Act on collection and use of donations, https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=47137&lang=ENG

[31] Corporate tax act, https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=49689&lang=ENG

[32] Act on the establishment and operation of public interest corporations, https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=46307&lang=ENG

ажиллагаа зэрэг зориулсан хандивын ажиллагааг бүртгэдэг байна.[33]

Холбоо, сангийн төрөл

Ашгийн бус байгууллага нь олон нийтэд тустай эсвэл гишүүдэд ашиг тустай байх үйл ажиллагаа эрхэлдэг. Олон нийтэд ашигтай үйл ажиллагааг хамгаалал болон үйлчилгээ үзүүлэх гэсэн хоёр төрөлд хуваж болно. Хамгаалал гэдэгт ардчилал, хүний эрх, шударга ёс, амьдрах орчныг сайжруулах чиглэлээр байгаль орчныг хамгаалах, эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах зэрэг үйл ажиллагааг хамруулдаг бол үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаанд боловсрол, эмнэлгийн үйлчилгээ, нийгмийн халамж, соёлын өв зэргийг хамруулдаг байна.[34]

Холбоо, санг үүсгэн байгуулах ба татан буулгах

БНСУ-д ашгийн төлөө бус байгууллага нь бүртгэлгүй эсвэл бүртгэлтэй байгууллага хэлбэрээр оршиж болдог бөгөөд бүртгүүлснээр татварын хөнгөлөлт болон бусад санхүүгийн үр ашгийг хүртэх боломжтой.

Урлаг, хандив, шинжлэх ухаан, шашин, нийгмийн харилцаа, эсвэл бусад ашгийн төлөө бус үйл ажиллагаа зэрэг олон нийтийн ашиг сонирхлын төлөөх холбоо, санг хуулийн этгээд гэж үзэх бөгөөд үйл ажиллагаа, харилцааг БНСУ-ын Иргэний хуулиар зохицуулдаг.[35] Хуульд зааснаар холбоо, санг эрх бүхий байгууллагын зөвшөөрлийг үндэслэн байгуулах ба уг нэгдэх зөвшөөрлийг холбооны зорилго, нэр, байршил, хөрөнгийн талаарх зохицуулалт, захирал томилох, чөлөөлөх зохицуулалт, гишүүнээр элсүүлэх, чөлөөлөх зохицуулалт, татан буулгах үндэслэл зэргийг тусгасан дүрмийг боловсруулж, хянуулсны үндсэн дээр авдаг байна.[36] Санг үүсгэн байгуулахдаа нийлүүлж буй хөрөнгөөс гадна холбоо байгуулахад шаардсантай адил дүрмийг мөн боловсруулж өгдөг.[37] Холбоо эсвэл сан байгуулахыг холбогдох захиргааны байгууллагаас зөвшөөрсөн бол зөвшөөрлийг авсан өдрөөс хойш гурван долоо хоногийн дотор үндсэн хаяг дээрээ бүртгүүлэх ёстой. Зөвшөөрөл олгогдсоны дараа зорилго, нэр, оффисын хаяг, зөвшөөрлийн огноо, татан буугдах шалтгаан; хөрөнгийн нийт үнэлгээ, хөрөнгө оруулах арга, захирлын нэр, оршин суух хаяг гэсэн мэдээллийг бүртгүүлдэг[38] бол холбоо болон санг дараах шалтгааны улмаас татан буулгаж болно. Үүнд, дампуурлаа зарласан, зорилгоо биелүүлж дуусан, зорилгоосоо өөр үйл ажиллагаа эрхлэх, холбоо эсвэл сан байх нөхцөлийг зөрчсөн, нийтийн ашиг сонирхлыг хохироосон, гишүүнчлэлгүй болсон, удирдах зөвлөлийн хуралдаанаараа татан буулгах тогтоол гаргасан зэрэг болно.[39]

Ашгийн төлөө бус байгууллагын татвар, хөнгөлөлт, чөлөөлөлт

Бүртгэлтэй болон бүртгэлгүй ашгийн төлөө бус байгууллагын татварын асуудлыг БНСУ-ын Байгууллагын татварын тухай хуулиар зохицуулдаг. Ийм ашгийн төлөө бус байгууллагыг “ашгийн төлөө бус дотоодын байгууллага” гэж үзэх бөгөөд бизнесийн жил бүрт гарч ирсэн ашгийн төлөө бус байгууллагын “ашгаас бий болсон орлого”-д ашгийн төлөө байгууллагад ногдуулдагтай адил татварыг ногдуулдаг

[33] Act on collection and use of donations, https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=47137&lang=ENG

[34] Kim, Inchoon, and Changsoon Hwang. *Defining the nonprofit sector: South Korea*. Johns Hopkins University Center for Civil Society, 2002.

[35] Article 31, 32, Civil Act of South Korea, https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=45912&lang=ENG [Civil Act].

[36] Article 40, Civil Act of South Korea, https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=45912&lang=ENG [Civil Act].

[37] Article 43, Civil Act of South Korea, https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=45912&lang=ENG [Civil Act].

[38] Article 49, Civil Act of South Korea, https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=45912&lang=ENG [Civil Act].

[39] Article 77, Civil Act of South Korea, https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=45912&lang=ENG [Civil Act].

байна.[40]

Түүнчлэн БНСУ-ын Засгийн газар ашгийн бус салбарт татвар, санхүүгийн олон хөшүүргийг бий болгосон байдаг. Тухайлбал, Ашгийн төлөө бус байгууллага болон төрийн бус байгууллагыг дэмжих тухай хууль, Олон нийтийн салбарыг дэмжих тухай хуулиар бүртгэлтэй төрийн бус байгууллагуудад татварын урамшуулал олгох боломжийг олгодог.

Ашгийн төлөө бус байгууллагын санхүүжилт

Ашгийн төлөө бус байгууллага нь олсон ашгаа өөрсдийн ашгийн төлөө бус зорилгыг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлаа санхүүжүүлэх, мөн энэ зорилгоо санхүүжүүлэхээр бизнесийн үйл ажиллагаа эрхлэн ашиг олж болохыг зөвшөөрдөг.[41] Харин БНСУ-ын Байгаль хамгаалах тухай хуулийн дагуу Засгийн газар нь байгаль орчныг хамгаалах үйл ажиллагаа эрхэлж буй байгууллагыг санхүүжилт олгох эсвэл бусад чиглэлээр дэмжих ёстой байдаг байна. Ашгийн төлөө бус байгууллагад оруулж буй гадаадын хөрөнгө оруулалтыг Гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих тухай хуулиар зохицуулдаг.

Аудит хийх, тайлан гаргах

БНСУ-ын Иргэний хуулийн дагуу холбоо болон сан нь жил бүр хөрөнгийн бүртгэл, тооллого хийж эрх бүхий байгууллагад хүргүүлэх ба тайлангаа архивлах үүрэгтэй. Мөн холбоо нь гишүүдийнхээ бүртгэлийг хөтөлж, жагсаалтыг тогтмол хөтлөх ёстой байна.[42] Олон нийтийн аж ахуйн нэгжүүд бизнесийн үйл ажиллагаа болон оролцогч талуудын шийдвэр гаргахад оролцсон оролцоог хамруулсан бизнесийн тайлан гаргаж, санхүүгийн жилийн 2-р сарын сүүлчээр Хөдөлмөрийн сайдад хүргүүлэх[43], ашгийн төлөө бус байгууллага болон төрийн бус байгууллагыг дэмжих тухай хуулийн дагуу тэдгээр байгууллагад үзүүлсэн дэмжлэг болон төслийн тайланг төсвийн дараагийн жилийн нэгдүгээр сарын сүүлч гэхэд илгээхээс гадна татварын албаны шаардлагаар ашгийн төлөө бус байгууллага нь дансны бүртгэл хөтлөх бөгөөд ашиг олсон үйл ажиллагааныхаа тайланг архивлах ёстой[44] байдаг байна.

Хүлээлгэх хариуцлага

БНСУ-ын Иргэний хуулиар холбоо болон сангийн захирал, аудитор, татан буулгагч нь дараах зөрчлийг гаргасан бол таван сая воноос (ойролцоогоор 4500 ам.доллар) хэтрэхгүй торгууль ногдуулна. Үүнд, иргэний хуульд заасан аливаа зохицуулалтыг үл тоомсорлосон, тайлагнах шаардлагыг зөрчсөн, холбоо болон сангийн хяналт, шалгалтад саад учруулсан, эрх бүхий байгууллага эсвэл удирдах зөвлөлийн хуралд хуурамч мэдээлэл өгсөн эсвэл баримтыг тэднээс нуун дарагдуулсан зэрэг болно.[45] Иргэний хуульд эдгээр зөрчлийг хэрхэн тогтоох талаар заагаагүй боловч Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар[46] үүнийг зохицуулж, өргөдөл гаргах боломжийг олгоно гэж үздэг.[47] Ашгийн төлөө бус байгууллага болон төрийн бус байгууллагыг дэмжих тухай хуулийн дагуу төслийн

[40] Articles 3(1), (2), Corporate Tax Act, https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=49689&lang=ENG.

[41] Articles 29, Corporate Tax Act, https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=49689&lang=ENG

[42] Article 55, Civil Act of Korea, https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=45912&lang=ENG [Civil Act].

[43] Article 17(1), Social Enterprise Promotion Act, http://ethmar.social/wp-content/uploads/2017/08/43-South-Korea-SOCIALENTERPRISEPROMOTIONACT.pdf

[44] Assistance for non-profit, non-governmental organizations act, https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=47145&lang=ENG

[45] Article 97, Civil Act of Korea, https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=45912&lang=ENG [Civil Act].

[46] Civil Act of Korea, https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=45912&lang=ENG [Civil Act].

[47] Civil Procedure Act, https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=45913&lang=ENG

хуурамч санал боловсруулсан бол 3 жил хүртэл хорих ял шийтгэх эсвэл 10 сая хүртэл вонийн торгууль ногдуулах шийтгэлтэй. Дэмжлэгээр олгосон олговрыг зүй бусаар зарцуулсан нь тогтоогдвол 1 жил хүртэл хугацаагаар хорих эсвэл 5 сая хүртэл воноор торгох шийтгэл оногдуулдаг. Шийтгэл хүлээсэн этгээд шүүхийн шийдвэр гарснаас хойш 7 хоногийн дотор давж заалдах эрхтэй.[48]

ДҮГНЭЛТ

Ийнхүү улс орнуудын хууль тогтоомж болон эрдэмтэн судлаачдын үзэл бодол, судалгааны үр дүнгээс нийтэд тустай үйл ажиллагааг тодорхойлох шалгуур, хамрах чиглэл, хориглох хүрээ зэргийг олон янзаар иш татаж болох боловч нийтэд тустай үйл ажиллагаанд хамаарах төрлүүдийг нэг бүрчлэн тодорхойлж цэг тавих боломжгүй юм. Учир нь олон талт, баялаг харилцаа бүхий нийгэмтэй эл ойлголт салшгүй холбоотой.

ХБНГУ-ын хувьд "нийтэд тустай үйл ажиллагаа"-г иргэн, хуулийн этгээдээс ямар нэг нөхцөл, болзолгүй сайн дурын хүсэл зоригоор, тодорхой хугацаатай, хариу төлбөргүй, зохион байгуулалтай, олон нийт, нийгмийн төлөө хийх ажлыг ойлгодог бөгөөд холбооны харилцааг зохицуулсан хууль тогтоомжид нь холбооны талаар нэг бүрчлэн, нарийвчлан хуульчилсан боловч нийтэд тустай үйл ажиллагаа явуулахтай холбоотой харилцааг зохицуулаагүй байна. Харин сангийн харилцааг зохицуулсан хууль тогтоомжид нийтэд тустай үйл ажиллагаа явуулахтай холбоотой зохицуулалтыг тусгаж өгсөн гэж үзэж болохоор байна.

ОХУ-ын тухайд холбоо, сангийн тухай харилцааг "Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн тухай" холбооны хуулиар тусгайлан зохицуулдаг бөгөөд холбоо, сангийн нийтэд тустай үйл ажиллагаа эрхлэх харилцааг "Буяны болон сайн дурын үйл ажиллагааны тухай" холбооны хуулиар зохицуулж ирсэн. Тус хуульд "нийтэд тустай үйл ажиллагаа", "сайн дурын үйл ажиллагаа" гэх ойлголтыг агуулгын хувьд ижил утгатай хэрэглэдэг бөгөөд буяны үйл ажиллагааг ашгийн төлөө бус хуулийн этгээд болон хувь хүн эрхлэн явуулахаар зохицуулсан байна.

Хэдийгээр тус улсад холбоо, сангийн харилцааг зохицуулсан бие даасан хууль байгаа ч гэсэн тус хуульд нийтэд тустай үйл ажиллагаа эрхлэх харилцааг тодорхойлон зохицуулаагүй, гэхдээ ашгийн төлөө бус хуулийн этгээдийг байгуулж байгаа зорилго, агуулгын хүрээнд тайлбарласан байна гэж үзэж болохоор юм.

ОХУ дахь холбоо, санг нийтэд тустай үйл ажиллагаа эрхлэх харилцааг "Буяны болон сайн дурын үйл ажиллагааны тухай" холбооны хуулиар ерөнхийлөн зохицуулж байна. Ашгийн төлөө бус хуулийн этгээдүүд нь буяны үйл ажиллагаа эрхлэх гэж байгаа тохиолдолд хуульд заасан үндэслэл журмын дагуу буяны байгууллагыг бүртгүүлж, түүнд нийцсэн зорилгын хүрээнд үйл ажиллагааг эрхлэх, эд хөрөнгийг бий болгох, захиран зарцуулах эрх, үүргийг тус хуульд зохицуулсан байна.

Харин БНСУ-ын тухайд холбоо, сан байгуулах эрх чөлөөг Үндсэн хуулиараа олгосон байдаг бөгөөд эдгээр байгууллагын харилцааг Иргэний хууль болон бусад холбогдох хуулийн зүйл заалтаар зохицуулдаг байна. Холбоо болон санг Иргэний хуулийн дагуу бүртгүүлснээр эдгээр байгууллагууд татварын хөнгөлөлт эдлэх, төрөөс үзүүлэх зохих дэмжлэг авах эрх үүснэ. Дотоод хэрэг, аюулгүй байдлын сайд болон шат шатны засаг дарга нар ардчилсан нийгмийн хөгжилд хувь нэмрээ оруулж буй ашгийн төлөө бус байгууллагын нийтэд тустай үйл ажиллагааг хүлээн зөвшөөрч, тэдний үйл ажиллагааг санхүүжилт болон бусад чиглэлээр дэмжих, баталгаажуулах үүргийг хуулиар тогтоож өгсөн байна. Ингэснээр ашгийн төлөө бус

[48] Article 12, Assistance for Nonprofit, Nongovernmental Organizations Act, https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=47145&lang=ENG.

байгууллагуудын нийтэд тустай үйл ажиллагааг хянах, тайлан гаргуулах, зорилгоос гадуур үйл ажиллагаа явуулах эрсдэлийг хязгаарлах боломжийг бий болгосон гэж үзэж болохоор байна.

Цаашид Холбооны эрх зүйн байдлын тухай хууль, Сангийн эрх зүйн байдлын тухай хууль, Нийтэд тустай үйл ажиллагааны тухай хуулийн төсөл боловсруулахдаа дараах хэдэн зүйлд анхаарлаа хандуулах нь зүйтэй болов уу. Үүнд:

1. Ашгийн төлөө бус хуулийн этгээд, төрийн бус байгууллагын төрөл, үйл ажиллагааг нарийвчлан тодорхойлох;
2. Нийтэд тустай ажил, үйл ажиллагааг ТББ-ын үйл ажиллагаанаас ялгах;
3. Нийтэд тустай ажил, үйл ажиллагаа эрхэлж байгаа байгууллагыг татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хэрхэн хамруулах талаар хуулийн төсөлдөө нарийвчлан тусгах;
4. Нийтэд тустай ажил, үйл ажиллагааг албадан хөдөлмөр хийлгэхээс ялган зааглах зэрэг болно.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

НОМ ЗҮЙ

Хууль тогтоомж

1. БНСУ-ын Үндсэн хууль (1948);
2. БНСУ-ын Ашгийн төлөө бус байгууллага болон төрийн бус байгууллагыг дэмжих тухай хууль
3. БНСУ-ын Байгууллагын татварын тухай хууль
4. БНСУ-ын Иргэний хууль
5. БНСУ-ын Нийтийн ашиг сонирхлын төлөөх байгууллагын байгуулал ба үйл ажиллагааны тухай хууль
6. БНСУ-ын Олон нийтийн салбарыг дэмжих тухай хууль
7. БНСУ-ын Хандив цуглуулах, зарцуулах тухай хууль
8. Германы амлалт, сайн дурын үйл ажиллагаа явуулах сан байгуулах тухай хууль
9. Иргэний хууль болон Нийтийн ашиг сонирхлын төлөөх байгууллагын байгуулал ба үйл ажиллагааны тухай хууль
10. ОХУ-ын Үндсэн хууль (1993);
11. ОХУ-ын Иргэний холбооны хууль (1994);
12. ОХУ-ын Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн тухай холбооны хууль (1996);
13. ОХУ-ын Буяны болон сайн дурын үйл ажиллагааны тухай холбооны хууль (1996);
14. ОХУ-ын “Татварын тухай” холбооны хууль (2000).
15. ХБНГУ-ын Үндсэн хууль
16. ХБНГУ-ын Иргэний хууль
17. ХБНГУ-ын Холбооны тухай хууль
18. ХБНГУ-ын Сангийн тухай хууль
19. ХБНГУ-ын Холбооны тухай хуулийг дагаж мөрдөх журам
20. ХБНГУ-ын Холбоог бүртгэх журам

Ном, гарын авлага, өгүүлэл, судалгааны тайлан:

1. Хууль зүйн үндэсний хүрээлэн, ХБНГУ-ын Үндсэн хууль, орч. П.Амаржаргал нар (Уб, ХЗҮХ, 2020).
2. ХБНГУ-ын Иргэний хууль (Кодификацийн бүрэн эх), орч. Б.Буянхишиг (Уб, “Соёмбо принтинг” ХХК, 2017).
3. Хуулийн этгээдийн төрөл:харьцуулсан лавлагаа, ХЗҮХ, УБ, 2017 он.

Цахим эх сурвалж:

1. ОХУ-ын хуулийн цахим сайт, www.consulitant.ru
2. Park, Sauk-Hee, and Mark Wilding. “The politics of government reform in Korea: From tripartite to bipartite politicization.” Administration & Society 48, no. 9 (2016): 1059-1084.
3. South Korean Constitution, 1948, https://www.icrc.org/applic/hl/ihlnat.nsf/162d151af444ded44125673e00508141/aba339f342ad7493c1256bc8004c2772/$file/constitution %20-%20korea%20

Хуулийн үндэсний хүрээлэн www.hli.gov.mn

-%20en.pdf

4. Kim, Inchoon, and Changsoon Hwang. Defining the nonprofit sector: South Korea. Johns Hopkins University Center for Civil Society, 2002.
5. Assistance for non-profit, non-governmental organizations act, https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=47145&lang=ENG
6. Social enterprise promotion act, http://ethmar.social/wp-content/uploads/2017/08/43-South-Korea-SOCIALENTERPRISEPROMOTIONACT.pdf
7. Foreign investment promotion act, https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=49546&lang=ENG
8. Act on collection and use of donations, https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=47137&lang=ENG
9. Corporate tax act, https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=49689&lang=ENG
10. Civil Act of South Korea, https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=45912&lang=ENG [Civil Act].

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

ГУРАВ. БУСАД СУДАЛГАА

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХУРЭЭЛЭН
www.nli.gov.mn

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХУРЭЭЛЭН
www.nli.gov.mn

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ ДАХЬ ПАРЛАМЕНТЫН ИНСТИТУТИЙН ЗАРИМ НЭР ТОМЬЁО[49]

УДИРТГАЛ

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Хууль зүйн судалгааны төвөөс 2019 оноос эхлэн хууль тогтоомжийн нэр томьёог жигдлэх, нэгдмэл сан бүрдүүлэх зорилгоор өөрсдийн санаачлагаар хууль зүйн нэр томьёоны талаарх судалгааг гүйцэтгэж байгаа билээ.

Тус ажлын хүрээнд бид 2019 онд Монгол Улсын Үндсэн хуулийн Ерөнхийлөгчийн институт дахь тодорхой нэр томьёог эрдэмтэн, судлаачид болон уг зүйн толь бичигт хэрхэн тодорхойлж, тайлбарласан, тухайн нэр томьёог агуулгын хувьд хэрхэн ойлгож, хэрэглэж байгаа болон уг нэр томьёоны талаар гадаад улсын зарим жишээг авч үзсэн бол 2020 онд Монгол Улсын Үндсэн хуулийн парламентын институт дахь зарим нэр томьёог сонгон авч өмнөх онд гүйцэтгэсэн судалгааны арга зүйг баримтлан судаллаа.

Судалгааны объект

1992 оны Үндсэн хуулийн Хорьдугаар зүйлээс Хорин есдүгээр зүйлд Улсын Их Хуралтай холбоотой зохицуулалтыг тусгасан бөгөөд тус судалгааны хүрээнд Монгол Улсын Үндсэн хуулийн дээрх хэсгээс дараах нэр томьёог сонгон судлав. Үүнд:

1. Төрийн эрх барих дээд байгууллага;
2. Ард түмний элч;
3. Хууль;
4. Соёрхон батлах;
5. Өршөөл;
6. Үндсэн хуулийн дэг журам;
7. Хүрээ, хязгаар;
8. Нийтийн ашиг сонирхол;
9. Гишүүний халдашгүй байдал.

Судалгааны арга зүй

Дээрх судалгааны ажлаар түүхэн талаас нь түүхчлэх арга, тухайн үгийн агуулгыг илүү тодорхой болгохоор харьцуулалтын арга, мөн Үндсэн хуулийн холбогдох зүйл заалт, үгийн утга агуулгыг ойлгох үүднээс Үндсэн хууль тайлбарлах үгчлэх, системчлэх, утга зүйн аргуудыг тус тус хэрэглэсэн болно.

ТӨРИЙН ЭРХ БАРИХ ДЭЭД БАЙГУУЛЛАГА

"Төрийн эрх барих дээд байгууллага" Монгол Улсын Үндсэн хуулийн Хорьдугаар зүйлд "Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална." хэмээн зохицуулсан.

"Төрийн эрх барих дээд байгууллага" гэдгийг академич С.Нарангэрэл "Эрх зүйн эх толь бичиг" номондоо "*Төрийн дээд байгууллага"* (англи. Highest organ of state; ор. Весший орган государственной власти) МУ-д Монгол Улсын Үндсэн хуульд Улсын Их Хурлыг ийнхүү нэрлэжээ. *Төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллага*

[49] Энэхүү судалгааг ХЗҮХ-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга, хууль зүйн доктор П.Амаржаргал удирдан, Эрдэм шинжилгээний ахлах ажилтан Г.Халиунаа, Эрдэм шинжилгээний ажилтан Ч.Батзориг, Ц.Оюунчимэг, О.Төрболд, Г.Сувд-Эрдэнэ, Э.Уянга, С.Цэрэндолгор нар хамтран гүйцэтгэв.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНГ www.nli.gov.mn

-МУ-д Улсын Их Хурал[50] гэх мэтээр тайлбарлажээ.

Харин Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбарт, 1/ Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар Улсын Их Хурал нь нийт ард түмний чөлөөт сонгуулиар мандатаа авч тэдгээрийг төлөөлөн үйл ажиллагаагаа явуулж төрийн бүрэн эрхийг хэрэгжүүлдэг учраас төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд түүний төрийн эрх барих дээд байгууллага болох шинж нь Улсын Их Хуралд Үндсэн хуулиар олгогдсон бүрэн эрхээр тодорхойлогдож байна хэмээн ойлгож болно. 2/ Улсын Их Хуралд хадгалагдах онцгой бүрэн эрхийн нэг нь түүний хууль тогтоох эрх мэдэл бөгөөд энэ эрхийг өөр бусад ямар ч байгууллага, албан тушаалтан төлөөлөхгүй. Хууль гэдэг бол төр засгийн байгууллагын гаргаж байгаа эрх зүйн хэм хэмжээнүүдийн дотроос хууль зүйн хувьд хамгийн дээд хүчин чадалтай, бүхнийг хамаарч үйлчилдэг, нийтээр заавал дагаж мөрдөх үүргийг буй болгож хэрэв зөрчигдвөл төрийн албадлагаар хэрэгждэг санкцтай учраас төрийн бүрэн эрхийн илэрхийлэл юм. Хууль тогтоох, хууль хүчингүй болгох, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хурал хэрэгжүүлэх бөгөөд түүний гаргасан бүх хууль нь Үндсэн хуульд бүрнээ нийцэж байх ёстой. Төр, засгийн бусад байгууллага, албан тушаалтнаас гаргаж байгаа актууд Улсын Их Хурлаас гаргасан хуульд нийцэж байх учиртай”[51] хэмээжээ.

Түүнчлэн төрийн эрх барих дээд байгууллагыг олон улсад хэрэглэгдэх нийтлэг нэр томьёогоор тайлбарлахдаа “Парламент” /Parlamentum/ гэсэн латин үгнээс гаралтай бөгөөд үг хэлэх, ярих, гэсэн утга бүхий боловч, парламент нь хурал доторх ярилцлага, нийтэд хамаатай асуудал гэсэн давхар утгыг илэрхийлдэг төдийгүй дундад зууны үед Европын улсад нэвтэрч эхэлжээ.[52] Харин Монгол Улсад эрт дээр үеэс “Хорин дөрвийн зөвлөл” мянганы ноёдын хуралдай, аймгийн ноёдын хуралдай, аймгийн ноёдын чуулган, хожмоо Богд хаант Монгол Улсын Олноо өргөгдсөний 3 дугаар онд байгуулагдсан Улсын Дээд, Доод Хурал хэмээн олон байгууллага байсан боловч бүгд зөвлөх эрхтэй байжээ. Хаан өргөмжлөх, дотоод гадаад бодлогын гол гол асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх, хаанд зөвлөх зэрэг бүрэн эрхийг хэрэгжүүлдэг[53] байсан тухай тэмдэглэсэн байна.

Парламент нь Үндсэн хуулийн эрх зүйн нэг гол институц бөгөөд ард түмний төлөөлөгчдийн дээд байгууллагын хувьд мөн л олон нийтийн анхаарал, хэлэлцүүлгийн төвд оршиж байдаг, зуун зууныг дамжсан ч шавхагдашгүй бөгөөд хөгжил нь асуудлыг төрүүлдэг[54] байх тул тал бүрээс нь судлан үзэх боломжтой сэдэв юм.

Монгол Улсын эрдэмтэн, судлаачид хийгээд нэр томьёоны тайлбар тольд дээрх байдлаар тодорхойлон бичсэн бол бусад орны хувьд төрийн эрх барих дээд байгууллага гэсэн нэршлээр ямар байгууллагыг төлөөлүүлснийг 3 улсын жишээнээс авч үзье.

Америкийн Нэгдсэн Улс (АНУ): АНУ-ын Үндсэн хуулийн 1-р зүйлийн 1 дэх хэсэгт “Үүгээр олгож буй бүх хууль тогтоох эрх мэдэл АНУ-ын Конгресст хадгалагдах бөгөөд Конгресс нь Сенат болон төлөөлөгчдийн танхимаас бүрдэнэ” гэж заасан байна. Монгол Улсын хувьд хууль тогтоох байгууллагаа төрийн эрх барих дээд байгууллага мөн гэж тодорхойлсонтой жишвэл, АНУ-ын хувьд Конгресс нь төрийн эрх барих дээд байгууллага гэж харж болохоор байна. Гэхдээ АНУ-ын Үндсэн хууль нь нэг хүн эсвэл байгууллагад хэт их эрх мэдэл төвлөрүүлэхээс зайлсхийж

[50] С.Нарангэрэл, Эрх зүйн эх толь бичиг /Dictionary of law/ (Уб, 2007), 431 дэх тал.

[51] Г.Совд нар, Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар (Уб, 2000), 136 дахь тал.

[52] Ч.Энхбаатар, Үндсэн хуулийн эрх зүй (Уб, 2007), 206 дахь тал.

[53] Мөн тэнд, 214 дэх тал.

[54] П.Амаржаргал, “Үндсэн хуулийн эрх зүй:Парламентын онол, үзэл баримтлалын асуудал” эрдэм шинжилгээний илтгэл, өгүүлэл, (Уб, 2015), 5 дахь тал.

холбооны засаглалын эрхийг тусдаа 3 салбарт хуваарилдаг.[55] Үүнд:

- Хууль тогтоох – Хууль боловсруулах, батлах (Конгресс);
- Гүйцэтгэх – Хуулийн хэрэгжилтийг хангах (Ерөнхийлөгч, дэд ерөнхийлөгч, кабинет, холбооны агентлаг);
- Шүүх – Хууль тогтоомжийн үнэлгээ (Дээд шүүх ба бусад шүүх).[56]

Ерөнхийдөө АНУ-ын Ерөнхийлөгч нь улс орныг удирдан чиглүүлэх бөгөөд Ерөнхийлөгч нь төрийн тэргүүн, холбооны засгийн газрын тэргүүн, зэвсэгт хүчний командлагч юм.[57]

Холбооны Бүгд Найрамдах Герман Улс (ХБНГУ): ХБНГУ-ын Үндсэн хуулийн 20-р зүйлийн 2 дахь хэсэгт "Улсын бүх эрх мэдэл ард түмнээс эх үндэстэй байна. Энэ эрх мэдэл нь ард түмний санал хураалт, сонгуулийн үндсэн дээр байгуулагдсан хууль тогтоох эрх мэдэл, гүйцэтгэх засаглал, шүүх эрх мэдлээр дамжин хэрэгжинэ"[58] гэж заасан. ХБНГУ-ын Бундестаг нь хууль тогтоох эрх мэдлийг хадгалдаг гол байгууллага юм.[59]

Бүгд Найрамдах Хятад Ард Улс (БНХАУ): БНХАУ-ын Үндсэн хуулиар төрийн эрх нь ард түмний мэдэлд байна гэж заасан байдаг.[60] БНХАУ-ын ардын их хурал төрийн эрхийг хэрэгжүүлэгч бөгөөд төрийн эрх барих дээд байгууллага юм. Тус улсын Ардын их хурал нь хууль тогтоох эрх мэдлийг хэрэгжүүлэхээс гадна төрийн дээд байгууллагын удирдагчид, гишүүдийг сонгох, огцруулах, Үндсэн хууль болон бусад хуулийн хүрээнд улсын чухал том асуудлыг шалгах, шийдвэрлэх эрхийг хэрэгжүүлдэг.[61]

Эрх, төрийн эрх гэж юу болох талаар, эдгээрийг толь бичигт хэрхэн тодорхойлсныг авч үзье.

Power (Эрх мэдэл) - АНУ-ын Black's law dictionary толь бичигт "үйлдэх, эс үйлдэх хуулиар олгосон эрх эсвэл бүрэн эрх, мөн хүсэл эрмэлзэл, эрх, үүрэг, хариуцлага, хүн эсвэл байгууллагын аль алиных нь эрх зүйн харилцааг өөрчлөх хүн эсвэл байгууллагын боломж, чадал юм" [62] гэж тодорхойлсон. Харин Merriam Webster тольд энэ үгийг "хүч, эрх мэдэл, нөлөөллийг өөртөө хадгалах боломжийг эзэмших" [63] гэж тодорхойлсон.

Sovereignty (Бүрэн эрх, улс орон дахь дээд эрх мэдэл) – Farlex-ийн эрх зүйн толь бичигт "Тусгаар тогтносон улсын хамгийн дээд, бүрэн эрхт, юунд ч үл захирагдах эрх нь улс орныг засаглах ба улс төрийн бүхий л тодорхой эрх мэдлээс урган гардаг; аливаа улсын гадны оролцоогүйгээр дотоод асуудлаа зохицуулах эрх, засаглах эрх мэдлийг хослуулсан улс орны тунхагласан тусгаар тогтнол", "хууль тогтоох, гүйцэтгэх, хэрэглэх, татвар ногдуулах, цуглуулах, дайн хийх, энх тайван тогтоох, гадаад үндэстэнтэй худалдааны гэрээ хэлэлцээр байгуулах гэх мэт өөртөө засаглан шаардлагатай бүхнийг хийх улсын эрх"[64] гэж тус тус тодорхойлсон.

---

55 "Branches of the U.S. Government," USAGov, 2020-09-15, https://www.usa.gov/branches-of-government.

56 Мөн тэнд.

57 Мөн тэнд.

58 Хууль зүйн үндэсний хүрээлэн, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Үндсэн хууль, Орч. П.Амаржаргал нар (Уб, 2020), 27 дахь тал.

59 "National Parliaments: Germany," Library of Congress, 2020-09-18, https://www.loc.gov/law/help/national-parliaments/

60 "State Organs," 2020-09-19, http://za.china-embassy.org/eng/zgjj/ssysz/spp/t244841.htm.

61 "State Organs," 2020-09-19, http://za.china-embassy.org/eng/zgjj/ssysz/spp/t244841.htm.

62 Gamer, Bryan A., Jeff Newman, and Tiger Jackson. "Black's Law Dictionary (Standard Ninth Edition)." (2009).

63 Merriam Webster, s.v. "Power", 2020-09-11, https://www.merriam-webster.com/dictionary/power.

64 Farlex Dictionary, s.v. "Sovereign power", 2020-09-12, https://legal-dictionary.thefreedictionary.com/

Тэгвэл, хууль тогтоох эрх мэдлийг хадгалж буй байгууллагуудыг хэрхэн тодорхойлсныг дор авч үзье.

- Parliament (Парламент) – Merriam Webster толь бичигт "ээлжит чуулганаар хуралддаг байнгын институт болох улс төрийн үндсэн нэгжийн хууль тогтоох дээд байгууллага"[65] гэж тодорхойлсон бол АНУ-ын Black's law dictionary толь бичигт "зарим үндэстний хууль тогтоох дээд байгууллага"[66] гэж тодорхойлжээ.
- Congress (Конгресс) – Merriam Webster толь бичигт "Үндэстэн тухайлбал Бүгд Найрамдах Улсын хууль тогтоох дээд байгууллага"[67] гэж тодорхойлсон бол АНУ-ын Black's law dictionary толь бичигт "Холбооны Засгийн газрын хууль тогтоох дээд байгууллага"[68] гэж тодорхойлжээ.
- Diet (Чуулган) – Merriam Webster толь бичигт "ван эсвэл хөрөнгөтнүүдийн албан ёсны зөвлөлдөх чуулган"[69] гэж тодорхойлсон бол АНУ-ын Black's law dictionary толь бичигт "Израиль, Япон, зарим зүүн Европын орны үндэсний парламентын чуулган"[70] хэмээн тодорхойлсон байна.

Дээрхээс дүгнэвэл, *төрийн эрх барих дээд байгууллага* нь Монгол Улсын Үндсэн хуульд нийт ард түмний чөлөөт сонгуулиар мандатаа авч тэдгээрийг төлөөлөн үйл ажиллагаагаа явуулж төрийн бүрэн эрхийг хэрэгжүүлдэг байгууллага болох Улсын Их Хуралд хадгалагдах тухай зохицуулсан бол АНУ-ын Үндсэн хуульд зааснаар АНУ-ын хувьд Конгресс хэрэгжүүлдэг. Харин ХБНГУ-ын Үндсэн хуулиар Бундестаг нь хууль тогтоох эрх мэдлийг хадгалдаг гол байгууллага бөгөөд БНХАУ-ын Үндсэн хуулиар Ардын Их Хурал нь хууль тогтоох эрх мэдлийг хэрэгжүүлдэг байна. Хэдийгээр улс орон бүр төрийн эрх барих дээд байгууллагыг өөр өөрсдийн онцлогт нийцүүлэн нэрлэдэг ч нийтлэг утгаараа хууль тогтоох эрх мэдлийг хэрэгжүүлэх чиг үүргийг бүгд өөртөө агуулдаг байх юм.

АРД ТҮМНИЙ ЭЛЧ

"Ард түмний элч" (англи. Envoy of the people) Монгол Улсын Их Хурлын гишүүний үндсэн шинжийн нэг. Академич С.Нарангэрэл "Эрх зүйн эх толь бичиг" номондоо тайлбарлахдаа "Үндсэн хуулийн эрх зүйн онолд аль нэгэн үндэстний нийтлэгт хуваагдахаас үл хамааран нийгэм-эдийн засаг, улс төрийн нэгдмэл нийтлэгийг бүрдүүлдэг улсын нийт хүн амыг хамаардаг ухагдахуун. Энэ утгаар орчин цагийн үндсэн хуульд ард түмнийг улсын бүрэн эрхт байдлыг агуулагч ба эрх мэдлийн цорын ганц эх сурвалж гэж заасан байдаг. Ард түмэн хэмээх ухагдахуун нь түүнчлэн аль нэгэн улсын нутаг дэвсгэртэй холбоо байхгүй ба бусад үндэстэн-соёлын нийтлэгээс ялгагдахын тулд хэрэглэгдэнэ. Энэ тохиолдолд "Ард түмэн гэсэн нэр томьёо нь заримдаа "үндэстэн" "угсаатны нийтлэг" хэмээх нэр томьёотой ойролцоо утгатай байдаг."[71] хэмээжээ.

Sovereign+power#:~:text=power%3A%20Sovereign%20right-,Sovereignty,internal%20affairs%20without%20foreign%20interference.

[65] Merriam Webster, s.v. "Power", 2020-09-11, https://www.merriam-webster.com/dictionary/parliament.

[66] Gamer, Bryan A., Jeff Newman, and Tiger Jackson. "Black's Law Dictionary (Standard Ninth Edition)." (2009).

[67] Merriam Webster, s.v. "Power", 2020-09-11, https://www.merriam-webster.com/dictionary/congress.

[68] Gamer, Bryan A., Jeff Newman, and Tiger Jackson. "Black's Law Dictionary (Standard Ninth Edition)." (2009).

[69] Merriam Webster, s.v. "Power", 2020-09-11, https://www.merriam-webster.com/dictionary/diet.

[70] Gamer, Bryan A., Jeff Newman, and Tiger Jackson. "Black's Law Dictionary (Standard Ninth Edition)." (2009).

[71] С.Нарангэрэл, Эрх зүйн эх толь бичиг /Dictionary of law/ (Уб, 2007), 42 дахь тал.

Монгол хэлний их тайлбар тольд тусгахдаа *“ард түмэн”* гэдгийг хоршоо үг хэмээгээд (ард олон, улсын иргэд) гэж тодорхойлсон бол “Элч” хэмээх ойлголтыг “байгууллагаас албан ёсоор томилогдсон эрх бүхий хүн”[72] хэмээн тусгасан байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Улсын Их Хурлын гишүүн бол ард түмний элч мөн бөгөөд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримтална.” хэмээн заажээ. Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар номонд ард түмний элч нь нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримтлахдаа “сонгогдсон тойргийнхоо сонгогчдын төлөөлөгч мэтээр ойлгож, тойргийнхоо эрх ашгийг улсын эрх ашгаас дээгүүр тавих эрхгүй”[73], “Үндсэн хууль түүнтэй нийцэн гарсан бусад хуулиа дээдлэх ёстой. Гэхдээ нийт иргэн улсын ашиг сонирхол бүхнийг хуульчлагдсан байна гэж үзэж болохгүй. Монголын ард түмний ёс заншил, өв уламжлал, эх орноо гэх сэтгэл, шударга үнэнийг эрхэмлэх ёсон зэрэг олон зүйлийг...”[74] баримтлах учиртайг тайлбарласан.

Ард түмэн элчээ сонгохдоо түмний итгэлийг олсон, төв шударгуу, эрдэм илүү, сахилга ариун, ажил хэрэгт хичээнгүй, нас залуу буюу ахимаг боловч тэнхлүүн нэгнийг олж албанаа тохоох, ховдог шунахай, харгис, чадалгүй, үхээнц, долгин хатан, эрдэм дорой, хичээнгүй бусыг цээрлэх нь төрийн түшээг сонгоход баримталж байсан түүхэн уламжлал ч бий.[75]

Шинжлэх ухааны доктор Ч.Энхбаатар “Үндсэн хуулийн эрх зүй” бүтээлдээ ард түмний элч гэдэг утгаар Улсын Их Хурлын гишүүнийг “ардчилсан дэглэмтэй улс орнуудад өөрийг нь сонгосон тодорхой тойргийн сонгогчдоо бус, харин нийт ард түмнээ парламентад төлөөлдөг. Тийм ч учраас сонгогчид итгэл хөсөрдүүлсэн гэсэн үндэслэлээр түүний бүрэн эрхийн хугацаа дуусахаас өмнө эгүүлэн татах журам байдаггүй”[76] тухай дурджээ.

Түүнчлэн ард түмний элч болох Улсын Их Хурлын гишүүнээр дамжуулан ард түмэн эрх мэдлээ хэрэгжүүлэхэд зөвхөн сонгуулийн өдөр л боломж олгогддог хэмээх ташаа ойлголтын талаар Хөдөлмөрийн баатар, гавьяат хуульч Б.Чимид “Өнөөгийн улс төр хуульчийн нүдээр” бүтээлд тайлбарласан байна. Тэрээр “Эрх мэдэл сонгож илгээсэн элчээр дамжиж хэрэгждэг нь үнэн боловч зөвхөн үүгээр дуусахгүй. Хэрэв тэд сонгогдсоны эцэст сонгогчдын эсрэг эргэж хандваас дарангуйлал нүүрлэх аюултай”[77] гэжээ. Иймд сонгогчдын зүгээс хяналт тавих, механизм, хариуцлагын тогтолцоог хэрэгжүүлэхэд анхаарч байх хэрэгтэй.

Монгол Улсын эрдэмтэн, судлаачид хийгээд нэр томьёоны тайлбар тольд дээрх байдлаар тодорхойлон бичсэн бол бусад орны Үндсэн хуульд (ард түмний элч) хууль тогтоох байгууллагын гишүүнийг хэрхэн тодорхойлсныг 3 улсын жишээнээс авч үзье.

АНУ: АНУ-ын хууль тогтоох дээд байгууллагыг Конгресс хэмээн нэрлэдэг бөгөөд гишүүнийг Member of Congress буюу Конгрессын гишүүн гэж нэрлэдэг.[78] Конгрессын гишүүд нь төлөөлөгчдийн танхимын гишүүд (member of the house representative) болон сенатчид (senator)-аас бүрддэг байна.[79] Төлөөлөгчдийн танхимын гишүүн нь хууль тогтоомж боловсруулах, батлалцах, сонсгол хийх зэрэгт АНУ-ын Конгресст өөрсдийн сонгогдсон дүүргийн ард иргэдийг төлөөлдөг.[80] Харин

[72] https://mongoltoli.mn/dictionary/detail/136065 (сүүлд үзсэн 2020.10.13).

[73] Г.Совд нар, Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар (Уб, 2000), 140 дэх тал.

[74] Мөн тэнд.

[75] Ч.Энхбаатар, Үндсэн хуулийн эрх зүй, (Уб, 2007), 206 дахь тал.

[76] Мөн тэнд, 226 дахь тал.

[77] Б.Чимид, Өнөөгийн улс төр хуульчийн нүдээр, (УБ, 2006), 34 дэх тал.

[78] “The Constitution of the United States,” 2020-09-19, https://constitutionus.com/.

[79] Мөн тэнд.

[80] “How Congress works,” 2020-09-19, https://walberg.house.gov/about/how-congress-works.

сенатч сонгогдсон муж улсаа бүхэлд нь төлөөлдөг байна. Тэгэхээр АНУ-ын хувьд хууль тогтоох байгууллагад сонгогдсон төлөөлөгч нь зөвхөн сонгогдсон дүүрэг болон муж улсаа төлөөлдөг гэж ойлгож болохоор байна.

ХБНГУ: Тус улсын Үндсэн хуулийн 38 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Германы Бундестагийн гишүүд нь ард түмний төлөөлөгч (representatives of the whole people) бөгөөд тушаал, зааварт бус зөвхөн өөрийн итгэл үнэмшилдээ захирагдана"[81] гэж заасан байна. Үүнээс харахад Бундестагийн гишүүд нь бүгд нийлээд ХБНГУ-ын ард түмний төлөөлөл болдог гэж ойлгож болохоор байна.

БНХАУ: "Ардын Их Хурал нь Төв засгийн газрын шууд удирдлага дор аймаг, өөртөө засах бүс, хотоос сонгогдсон төлөөлөгч (deputy), тусгай захиргааны бүсээс сонгогдсон төлөөлөгч, зэвсэгт хүчнээс сонгогдсон төлөөлөгч зэргээс бүрддэг. Бүх үндэсний цөөнх тохирох төлөөлөлтэй байх эрхтэй."[82] гэж БНХАУ-ын Үндсэн хуулийн 59 дүгээр зүйлд заажээ. Энэ заалтаас харахад Ардын их хурлын төлөөлөгч нь тодорхой бүс нутгийн иргэдийг төлөөлөхөөс гадна мөн зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүнийг төлөөлдөг байна.

Монгол Улсын Үндсэн хуулийг Англи хэлнээ хөрвүүлэхдээ "элч" гэдэг үгийг "envoy" гэсэн үгээр орлуулсан байна.

- Envoy (Элч, төлөөлөгч) – Black's Law Dictionary толь бичигт (1) "байнгын дипломат төлөөлөгчийн үүрэг гүйцэтгэх эсвэл тусгай үүрэг гүйцэтгэхээр гадаад оронд илгээгдсэн дээд төвшний дипломат"[83]; (2) "мэдээлэл хүргэгч эсвэл төлөөлөгч"[84] гэж тодорхойлсон байна. Харин Merriam Webster толь бичигт (1) "элчин сайд ба оршин суугч сайдын хэмжээнд эрэмбэлэгдэх гадаадын Засгийн газарт илгээгдсэн бүрэн эрхт, итгэмжлэгдсэн сайд"[85]; (2) "нэг Засгийн газраас нөгөө Засгийн газарт харилцах харилцаанд төлөөлөх итгэмжлэгдсэн хүн"[86] гэж тодорхойлжээ.
- Senator (Сенатын гишүүн) – Black's Law Dictionary толь бичигт "хоёр танхим бүхий хууль тогтоох байгууллагын дээд танхимын гишүүн"[87] гэж тодорхойлсон бол Merriam Webster толь бичигт "хууль тогтоох үүрэг бүхий дээд байгууллагын чуулганы гишүүн"[88] гэж тодорхойлжээ.
- Representative (Төлөөлөгч) - Black's Law Dictionary толь бичигт "бусдын өмнөөс үйлдэх эсвэл зогсох"[89] гэсэн утгаар тайлбарласан бол Merriam Webster толь бичигт "хууль тогтоох байгууллагын гишүүн гэгдэж сонгогчдыг төлөөлсөн этгээд", "хэн нэгэн эсвэл бусдыг төлөөлж буй этгээд"[90] гэж тайлбарласан байна.

Deputy (Төлөөлөгч) - Black's Law Dictionary толь бичигт "хэн нэгнийг орлох

[81] "Germany's Constitution of 1949 with Amendments through 2012," ConstituteProject, 2020-09-16, https://www.constituteproject.org/constitution/German_Federal_Republic_2012.pdf.

[82] "China (People's Republic of) 1982 (rev. 2018)," ConstituteProject, 2020-09-16, https://www.constituteproject.org/constitution/China_2018?lang=en

[83] Gamer, Bryan A., Jeff Newman, and Tiger Jackson. "Black's Law Dictionary (Standard Ninth Edition)." (2009).

[84] Мөн тэнд.

[85] Merriam Webster, s.v. "Power", 2020-09-11, https://www.merriam-webster.com/dictionary/envoy.

[86] Merriam Webster, s.v. "Power", 2020-09-11, https://www.merriam-webster.com/dictionary/envoy.

[87] Gamer, Bryan A., Jeff Newman, and Tiger Jackson. "Black's Law Dictionary (Standard Ninth Edition)." (2009).

[88] Merriam Webster, s.v. "Power", 2020-09-11, https://www.merriam-webster.com/dictionary/senator.

[89] Gamer, Bryan A., Jeff Newman, and Tiger Jackson. "Black's Law Dictionary (Standard Ninth Edition)." (2009).

[90] Merriam Webster, s.v. "Power", 2020-09-11, https://www.merriam-webster.com/dictionary/representative.

эсвэл түүний өмнөөс үйлдэхээр илгээгдсэн эсвэл томилогдсон этгээд”[91] гэж тодорхойлсон бол Merriam Webster толь бичигт (1) “эрхийг хэрэгжүүлэхээр орлож буй томилогдсон этгээд”; (2) “зарим хууль тогтоох чуулганы доод танхимын гишүүн”[92] гэж тодорхойлжээ.

Дээрхээс дүгнэвэл, *ард түмний элч* гэснийг Монгол Улсын Үндсэн хуулиар “Улсын Их Хурлын гишүүн бол ард түмний элч мөн” гэж **элч (төлөөлөгч)** гэсэн үгээр шууд заасан бол АНУ нь Конгрессын гишүүдээ хоёр янзаар хуваан 1/өөрсдийн сонгогдсон дүүргийн ард иргэдийг төлөөлдөг, 2/сонгогдсон муж улсаа бүхэлд нь төлөөлдөг сенатч гэж **төлөөлөгч** гэсэн утгаар тусгасан байна. Харин ХБНГУ-ын Үндсэн хуульд Бундестагийн гишүүд нь ард түмний төлөөлөгч байх тухай, БНХАУ-ын Үндсэн хуульд Ардын их хурлын төлөөлөгч нь тодорхой бүс нутгийн иргэдийг төлөөлөхөөс гадна мөн зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүнийг төлөөлөхөөр мөн л **төлөөлөгч** гэсэн утгаар тусгагджээ. Өөрөөр хэлбэл, манай улсын хувьд ард түний илч гэх нэр томьёог Үндсэн хуульдаа шууд утгаар нь авч тусгасан бол бусад орны хуьд ард түмний төлөөлөгч гэсэн нэр томьёонд дүйцүүлэн тус тусын хуульдаа тусгасан байна.

ХУУЛЬ

Хууль гэх нэр томьёог Монгол хэлэнд англи хэл болон латин хэлнээс өөр өөр үгтэй утга дүйцүүлэн хэрэглэж байна. Тодруулбал, англи хэлнээс “law”[93] болон “act”[94], латин хэлнээс “ius”[95], “lex”[96] гэх үгтэй утга дүйцүүлэн хэрэглэдэг бөгөөд “хууль” гэх үг хятадын “Fa-Lu” буюу эмхлэх цэгцлэх үгнээс үүдэлтэй[97] хэмээн үздэг байна.

Хууль нь хэлбэрийн болоод агуулгын талаасаа тодорхойлогддог хэлбэрийн хувьд ард түмнээс төлөөллийн дагуу сонгогдсон бүрэн эрх бүхий субъект хуулийг албан ёсоор батлах ёстой бол агуулга буюу мөн чанарын хувьд эртний Ромын хуульчид, сэтгэгчид эрх /jus/, хууль /lex/ гэсэн хоёр өөр нэршлээр ялган, тэдгээрийн хоорондын уялдаа холбооны хүрээнд хуулийн мөн чанарыг авч үзэж байсан[98] бөгөөд хууль нь нийтлэг ашиг сонирхлыг тусгаж, цөөнхийг хамгаалах механизмыг орхигдуулаагүй, эрх зүйн мөн чанар илэрхийлсэн оршихуй буюу байх ёстой зүйлийг[99] агуулах ёстой. Тэрхүү байх ёстой зүйл нь хуулийн амин сүнс буюу Ш.Л.Монтескьюгийн хэлснээр хамгийн өргөн утга санаагаар тодорхойлогдох, юмны цаад мөн чанараасаа урган гардаг шаардлага бүхий харилцаа, ард олны мөн чанарт уялдах зүйл юм. Тиймээс хуулийг хүлээн зөвшөөрөхүйцээр зохиох[100] буюу хүмүүсийн хүсэл зоригийг тусгах буюу өөрөөр хэлбэл, хууль буюу тухайн нийгэмд заавал мөрдөгдөх хэм хэмжээнүүд нь эрх буюу шудрага ёсны хэм хэмжээгээр нөхцөлдсөн байх ёстой[101] гэж үздэг байна.

---

91 Gamer, Bryan A., Jeff Newman, and Tiger Jackson. “Black’s Law Dictionary (Standard Ninth Edition).” (2009).

92 Merriam Webster, s.v. “Power”, 2020-09-11, https://www.merriam-webster.com/dictionary/deputy.

93 Ж.Амарсанаа, Англи-орос-герман- монгол Олон улсын эрх зүйн толь (Уб, 2004), 424 дэх тал, мөн С.Нарангэрэл, Эрх зүйн эх толь бичиг (Уб, 2007), 550 дахь тал.

94 Ж.Амарсанаа, Англи-орос-герман- монгол Олон улсын эрх зүйн толь (Уб, 2004), 17 дахь тал.

95 Латин-Англи толь бичиг, http://latin-dictionary.net/search/english/law (Сүүлд үзсэн: 2020.09.11).

96 С.Нарангэрэл, Эрх зүйн эх толь бичиг (Уб, 2007), 550 дахь тал.

97 Б.Батсайхан, Хууль зүйн тайлбар толь (Уб, 2003), 199 дэх тал.

98 П.Амаржаргал, Үндсэн хуулийн эрх зүй Парламентын онол үзэл баримтлалын асуудал (эрдэм шинжилгээний илтгэл, өгүүлэл), (Уб, 2015), 92 дахь тал.

99 Д.Лүндээжанцан, Л.Өлзийсайхан, Парламент ёс (Уб, 2002), 181 дэх тал.

100 Ф.Бастиа, орч:Н.Баярбаатар, Хууль (Уб, 2001), 11 дэх тал.

101 П.Амаржаргал, Үндсэн хуулийн эрх зүй Парламентын онол үзэл баримтлалын асуудал (эрдэм шинжилгээний илтгэл, өгүүлэл), (Уб, 2015), 92 дахь тал.

Дээрхээс үзвэл, нэг хэсэг судлаачид ард түмний нэрийн өмнөөс хууль тогтоох онцгой бүрэн эрхтэй нийгмийн институтээс батлан гаргасан аливаа шийдвэр акт нь хууль болно гэж формаль талаас нь тайлбарладаг бол, нөгөө хэсэг судлаачид нь мөн чанараараа хууль болж байгаа аливаа акт төрийн байгууллага гаргаснаас хамааралгүйгээр хууль болно гэж материал талаас нь тайлбарлаж байна.[102] Тухайлбал, ХБНГУ-д Gesetz буюу хууль нь хоёр утгыг илэрхийлдэг байна. Явцуу утгаараа үүнийг парламентын процессын үр дүнд бий болсон буюу баталсан эрх зүйг илэрхийлсэн хэлбэр байдаг бол өргөн утгаараа эрх зүйн хэм хэмжээний эх сурвалж болохын хувьд эрх бүхий байгууллагаас баталсан эрх зүйн аливаа хэлбэр хэмээн ойлгодог. Ийнхүү өргөн утгаараа Gesetz Үндсэн хууль, хууль болон төрөлжсөн хууль, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээний актыг өөртөө агуулсан ойлголт юм.[103]

Монгол Улсад зарим тохиолдолд “act” гэх нэр томьёог монгол хэлний “акт” хэмээх үгтэй утга дуйцүүлэн хэрэглэдэг байна. Уг нэр томьёог академич Ж.Амарсанаа “Монгол Улсын Үндсэн хуульд орсон харь үг” хэмээх бүтээлдээ тус үгийг үйлдэл, түүний бичгээр баримтжуулан илэрхийлэх үйл ажиллагааны төрөл бүрийн салбарт хэрэглэдэг хэллэг, баримт хэмээн тайлбарласан[104] бол академич С.Нарангэрэл “Эрх зүйн толь бичиг” бүтээлдээ “Үндсэн хуулийн эрх зүйд эрх хэмжээнийхээ хүрээнд хуулиар тогтоосон хэлбэрээр төрийн дээд байгууллагаас батлан гаргасан хууль зүйн баримт бичиг гэж”[105], Д.Баярсайхан “Эрх зүйн онол” бүтээлдээ “Эрх зүйн хэм хэмжээний акт гэдэг нь төрийн эрх бүхий байгууллагаас тогтоосон хууль зүйн хүчин чадалтай хэм хэмжээний албан ёсны шинжтэй заавал биелэгдэх баримт бичгийн цогц мөн”[106] хэмээн тус тус тодорхойлсон байна.

Харин “хууль” гэх үгийг Монголын эрдэмтэн, судлаачид дараах байдлаар тайлбарласан байна. Үүнд, Б.Чимид “Үндсэн хуулийн мэдлэг” бүтээлдээ “Улсын хууль гэдэг бол хууль тогтоогчийн баталсан нийтээр дагаж биелүүлэх дээд хүчин чадалтай эрх зүйн хэм хэмжээ мөн. Тэр нь зайлшгүй нөхцөлд албадан биелүүлэх арга хэрэглүүрээр хангагдсан байна.”[107] хэмээн тодорхойлсон бол академич С.Нарангэрэл “Эрх зүйн эх толь бичиг” бүтээлдээ “1. Нарийвчилсан утгаараа нийгмийн амин чухал харилцааг зохицуулж, засаг төрийн төлөөлөгчдийн дээд байгууллага, эсхүл хүн амын хүсэл зоригийг шууд илэрхийлж батлан гаргасан хууль зүйн акт. Хууль нь тухайн улсын эрх зүйн тогтолцооны үндсийг бүрдүүлнэ. Хууль нь төрийн байгууллагын хэм хэмжээ тогтоосон бусад эрх зүйн акттай харьцуулахад хууль зүйн дээд хүчин чадлыг агуулна... 2. Өргөн утгаараа бүх нийтээр заавал биелүүлэх журам болгон төрөөс хэм хэмжээ тогтоосон эрх зүйн бүх актыг хамарна.”[108] , Я.Цэвэлийн “Монгол хэлний товч тайлбар толь”-д “1.Тогтмол зүйн дотор илэрч гарах жинхэнэ үнэн байдлын аливаа үзэгдлүүдийн хоорондын холбоо ба харьцах зүй тогтоол; байгалийн хууль; нийгмийн хөгжлийн хууль; сэтгэхүйн хууль; 2. Засгийн дээд эрхийг барих газраас заавал дагаж шийтгүүлэхээр баталсан тогтоол”[109] , Д.Баярсайхан “Эрх зүйн онол” бүтээлдээ “хуулийг парламентаас гишүүдийнхээ санал хураалтын үндсэн дээр тогтоосон, улс, нийгмийн хэмжээнд үйлчлэх хүчин чадал бүхий эрх зүйн хэм хэмжээний акт”,[110] Г.Совд “Үндсэн хуулийн тайлбар” бүтээлдээ “Хууль гэдэг бол төр, засгийн байгууллагуудын гаргаж байгаа

[102] Д.Лүндээжанцан, Монгол улс дахь Төрийн эрх мэдлийн хуваарилалт (Уб, 2014), 155 дахь тал.

[103] Б.Амарсанаа, Харьцуулсан эрх зүй судлал (Уб, 2014), 140 дэх тал.

[104] Ж.Амарсанаа, Монгол Улсын Үндсэн хуульд орсон харь үг (Уб, 2014), 7 дахь тал.

[105] С.Нарангэрэл, Эрх зүйн толь бичиг (Уб, 2015), 18 дахь тал.

[106] Д.Баярсайхан, Эрх зүйн онол (Уб, 1996), 44 дэх тал.

[107] Б.Чимид, Үндсэн хуулийн мэдлэг (Уб, 2008), 184 дэх тал.

[108] С.Нарангэрэл, Эрх зүйн эх толь бичиг (Уб, 2007), 550 дахь тал.

[109] Я.Цэвэл, Монгол хэлний товч тайлбар толь (Уб, 1966), 737 дахь тал.

[110] Д.Баярсайхан, Эрх зүйн онол (Уб, 2010), 235 дахь.

эрх зүйн хэм хэмжээнүүдийн дотроос хууль зүйн хувьд хамгийн дээд хүчин чадалтай, бүхнийг хамаарч үйлчилдэг, нийтээс заавал дагаж мөрдөх үүргийг буй болгож хэрэв зөрчигдвөл төрийн албадлагаар хэрэгждэг санкцтай учраас төрийн бүрэн эрхийн илэрхийлэл юм."[111] зэргээр тодорхойлсон байна.

Монгол Улсын эрх зүйн түүхэнд хууль гэх нэр томьёог XVII зууны үеэс хэрэглэж эхлэн уламжлалт цааз гэдэг үгтэй хамтатган хууль цааз гэдэг хоршоо үг бий болсон бөгөөд хууль, цааз гэдгийг төрөөс тогтоосон зохицуулагч хэм хэмжээ гэдэг утгаар, хуулийн байгууллагын үйл ажиллагаа, байгууллага гэдэг утгаар хэрэглэж ирсэн байна.[112] Дээрх нэр томьёо нь 1924 оноос хойш батлагдсан Үндсэн хуулиудад нийтдээ 592 удаа хэрэглэгдсэн байна.[113]

Харинг өмнө дурдсанчлан Америкийн нэгдсэн улс, Их Британи Умард Ирландын нэгдсэн вант улс болон Африкийн зарим улсад "act" гэх нэр томьёог "law" гэх нэр томьёотой адилтган хэрэглэдэг бөгөөп акт нь Actus гэсэн (үйлдэхүүн, баримт бичиг гэсэн утгыг илэрхийлдэг) грек үгнээс гаралтай.[114] АНУ-ын "*Black's law dictionary"* толь бичигт "law" гэх үгийг "Нийгэмд улс төрийн зохион байгуулалттайгаар нийгмийн хүчийг системтэйгээр ашиглах замаар хүний үйл ажиллагаа, харилцааг нийгмийн шахалтаар дамжуулан хүчээр баталгаажуулдаг дэглэм." гэж тайлбарлажээ.*[115]*

Үүнээс үзвэл зарим улс оронд акт гэх нэр томьёо нь хууль гэх ойлголттой адил мэт боловч Монгол Улсын эрх зүйн харилцаанд акт нь хуулийг бодвол илүү тодорхой нөхцөл байдал болон тодорхой хүмүүст зориулагдсан эрх зүйн зохицуулалт[116] хэмээн ойлгож болохоор байна.

Дээрхээс дүгнэвэл, *Хууль* хэмээх үг нь монгол хэлний үгийн санд орж ирсэн харь үг хэдий ч салаа утгагүй, нэг мөр тогтсон ойлголтоор хэрэгдэгдэж байна. Харин уг нэр томьёог бусад улсад өөр нэр томьёогоор хэрэглэгддэг болох нь харагдаж байна.

СОЁРХОН БАТЛАХ

Монгол Улсын Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 3 дахь хэсэгт "Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ" гэж заасан. Үүнээс олон улсын гэрээг дотоодын хуулийн нэгэн адил хэрэглэхэд "соёрхон батлах" гэсэн ойлголт чухал болох нь харагдаж байна. Гэрээг соёрхон батлах (бичгээр[117]) гэсэн нэр томьёо нь олон улсын эрх зүйн үзэл баримтлал юм.[118] Соёрхон батлах нь акт гэсэн утгаар олон улсын гэрээг төрийн дээд байгууллага эцэслэн батлахыг[119] хэлнэ.

Академич С.Нарангэрэл "олон улсын гэрээг соёрхон батлах нь тухайн улсын засаг төрийн дээд байгууллага, түүнээс олгосон бүрэн эрхийн дагуу байгуулсан олон улсын гэрээг батламжлах үйл ажиллагаа"[120] гэж тодорхойлсон бол Стивен Х.Гифис

---

111 Г.Совд, Үндсэн хуулийн тайлбар (Уб, 2000), 136 дахь тал.

112 Д.Лүндээжанцан, Хууль бүтээх ажиллагаа ба Хууль зүйн техник (Уб, 2016), 12 дахь тал.

113 Ж.Амарсанаа, Монгол Улсын хуульд орсон харь үг (Уб, 2013), 24-25 дахь тал.

114 Ё.Бямбатогтох, Төр эрх зүйн онол (Уб, 2010), 123 дахь тал.

115 Henry Campbell Black, *Black's law dictionary*, 9th edition (St.Paul, Minn:West publishing Co, 2009), p.962.

116 Эрх зүйн толь бичиг, https://legal-dictionary.thefreedictionary.com/act (Сүүлд үзсэн: 2020.09.15).

117 Олон улсын нийтийн эрх зүй (Уб, 2008), 89 дэх тал.

118 https://www.abacademies.org/articles/The-legal-status-of-treaty-international-agreement-and-ratification-in-the-indonesian-practice-within-the-framework-of-the-development-of-the-national-legal-system-1544-0044-21-2-180.pdf

119 М.Мөнхбат, *Олон Улсын гэрээний эрх зүй* (Уб, 2017), 63-71 дэх тал.

120 С.Нарангэрэл, *Эрх зүйн эх толь бичиг, анхны хэвлэл* (Уб, 2007), 390 дэх тал

“албан ёсны зөвшөөрөл эсхүл бусдын үйлдлийг хууль ёсны эрх мэдэлтэй эсэхийг үл харгалзан хүлээн зөвшөөрч байгааг бататгах”[121] гэж тайлбарласан байна. АНУ-ын “Black’s law dictionary” тольд “зөвшөөрөх эсхүл хамгийн сүүлчийн шаардлага, зайлшгүй авах ёстой шат болсон батлах буюу батламжлах, мөн өмнө батлагдсан актыг батлан, хүлээн зөвшөөрсөн цаг үеэс хүчин төгөлдөр болох гэсэн утгатай хэмээн тэмдэглэжээ. Харин “олон улсын эрх зүйд гэрээг дагаж мөрдөхөө эцэслэн илэрхийлж байна гэдгээ гэрээний талууд хүлээн зөвшөөрөх утгатай”[122] гэжээ.

Энэ нэр томьёог үгзүйн хувьд англи хэлний “ratification” гэсэн үгээр манай толь бичгүүдэд орчуулжээ. Тухайлбал:

1/ соёрхон батлах - (герман. *Ratifizierung*), *ratification*[123];

2/ соёрхон батлах – *Ратификация международного договора- ratifizieren*[124];

3/ соёрхон батлах ёсчлох гарын үсэг зурах – *ratification*[125];

4/ ratification- ратификация – ratifizierung ratification – соёрхон батлах[126]

5/ олон улсын гэрээ соёрхон батлах – *ратификация*[127];

6/ батламжлахуй – *ratification* – (ор. утверждение)[128]

7/ соёрхон зөвшөөрөхүй – *approval of a treaty- визирование*[129]

Дээрх нэр томьёо нь латин хэлний албан ёсны зөвшөөрөл, баталгаажуулсан гэсэн утгатай ratificātiō хэмээх үгээс гаралтай[130] бөгөөд үгийн үндэс (ratify) нь XIV-XV зуунд англи хэлэнд анх хэрэглэгдэж[131] байжээ. Нэр томьёоны үгзүйн утга нь *sanction* (зөвшөөрөл) эсхүл хүлээн зөвшөөрч байгааг баталгаажуулах гэсэн утгыг агуулдаг байна.

Дээр дурдсанчлан, уг нэр томьёо нь олон улсын эрх зүйн ойлголт болохын хувьд олон улсын эрх зүйн хэм хэмжээнд түгээмэл тусгагдсан байдаг. Тухайлбал, 1969 оны Венийн конвенцод ““соёрхон батлах”, “хүлээн зөвшөөрөх”, “батлах”, “нэгдэн орох” гэж улс гүрэн гэрээг заавал биелүүлэхээ олон улсын хэмжээнд зөвшөөрч байгааг илэрхийлсэн бөгөөд тухайн тохиолдол бүрт өөр өөрөөр нэрлэгдэх олон улсын үйлдлийг хэлнэ”[132] гэж тодорхойлсон. Харин “*хүлээн зөвшөөрөх*” (acceptance), “*батлах”* (approval) зэрэг нь соёрхон батлахын хялбаршуулсан хэлбэр[133] юм. Монгол Улсын хувьд соёрхон батлах[134] олон улсын гэрээг заавал УИХ-аас хууль батлах замаар байгуулдаг.

Монгол Улсын олон улсын гэрээг соёрхон батална гэдэг бол Монгол Улсын эрх бүхий субъект гадаад улстай буюу ОУ-ын байгууллагатай тохиролцож гарын үсэг зурсан гэрээний үүргийг хүлээн зөвшөөрч УИХ-аас хууль баталж хүчин төгөлдөр[135]

[121] Steven H.Gifis, *Dictionary of Legal terms*, III ed., (Barron’s Educational Series, Inc. 1998), P.398.

[122] Bryan A. Garner, *Black’s law dictionary*, 9th edition (West publishing Co.), P.1376

[123] English-Korean-Mongolian-Russian-German Legal dictionary (2011), Yг № 4522, 572 дахь тал.

[124] English-Korean-Mongolian-Russian-German Legal dictionary (2011), Yг №1298 74 дэх тал.

[125] Korean legislation research institute, *English-Korean-Mongolian legal dictionary*, P.438

[126] Ж.Амарсанаа, Англи-орос-герман-монгол Олон улсын эрх зүйн толь (Уб, 2004), 604 дэх тал.

[127] З. Жаргалмаа, *Монгол -Орос, Орос-Монгол толь* (Уб, 2007), 74, 87 дахь тал.

[128] Luuzangiin Dambadorj, The most up-to-date English –Russian –Mongolian dictionary, P.876

[129] Мөн тэнд.

[130] https://www.dictionary.com/browse/ratification

[131] https://www.merriam-webster.com/dictionary/ratification

[132] Монгол Улсын олон улсын гэрээ - Олон улсын гэрээний эрх зүйн тухай Венийн конвенц, https://www.legalinfo.mn/law/details/1214

[133] Burns H.Weston, International law IV ed., Thomson west (2006), P.94

[134] Jugnee Amarsanaa, *The Constitution of Mongolia by trans,* Legal Academy (Ulaanbaatar: Soyombo printing, 2020), P.133

[135] Б.Ганболд, *Эрх зүй судлал* (Уб, 2011), 267 дахь тал.

болох тухай ойлголт юм. Дэлхийн улсуудын тогтсон практикт олон улсын гэрээг батлах ба цуцлах нь төрийн тэргүүний бүрэн эрхийн хүрээнд багтдаг байсан. Гэвч цагийн явцад олон улсын гэрээ дотоод хууль тогтоомжтой зөрчилдөх тохиолдол ихсэх хандлагатай болсон төдийгүй дэлхий дахинд үндэсний хууль тогтоомжоос олон улсын гэрээ давуу эрхтэй байх гэсэн зарчим ноёлж ирсэн. Иймд олон улсын гэрээ болон дотоодын хууль тогтоомжийг хооронд нь нийцүүлэх, Үндсэн хуулийг хатуу чанд сахих зорилгоор, олон улсын гэрээг соёрхон батлах ба цуцлах асуудлыг парламентын бүрэн эрхэд илүү хамааруулах болсон.[136]

Дүгнэвэл, "соёрхон батлах" хэмээх нэр томьёо нь олон улсын нийтийн эрх зүйн ухагдахуун бөгөөд дэлхийн улс орнуудын хувьд тогтсон (хэвшсэн) ойлголт төдийгүй өргөн хэмжээний утга агуулгатай нэр томьёо юм. Түүнчлэн, олон улсын гэрээ нь үндэсний хууль тогтоомжоос давуу эрхтэй болохын хувьд Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 15 дахь хэсэгт зааснаар олон улсын гэрээг соёрхон батлах нь УИХ-ын онцгой бүрэн эрх байх нь оновчтой юм.

ӨРШӨӨЛ ҮЗҮҮЛЭХ

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 14 дэх хэсэгт заасан УИХ-ын онцгой бүрэн эрхийн нэг болох "өршөөл үзүүлэх" хууль зүйн нэр томьёо буюу монгол хэлний ял хэлтрэх[137], ял хэлтрүүлэх ойлголтыг авч үзье.

Монгол хэлний журамласан толь бичигт "өршөө" гэх үйл үгийг нигүүлсэн тэтгэх, уучлан хэлтрүүлэх гэж; "өршөөл" хэмээх нэр үгийг өршөөх үйлийн нэр, энэрэл[138] гэж тайлбарласан байна. Хууль зүйн утгын хувьд, академич Ж.Амарсанаа "нийгэмд аюултай гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийг ял шийтгэлээс бүрмөсөн чөлөөлөх, хагасыг чөлөөлөх, эсвэл ялыг хөнгөрүүлэх, цагаатгах, мөрдөн байцаалтын ажиллагааг (тодорхой хэргүүдэд хамаарах) зогсоох талаар төрийн эрх барих дээд байгууллагаас гаргаж байгаа онцгой шийдвэр" гээд "өршөөл үзүүлэх талаар гаргасан зарлиг нь эрүүгийн эрх зүйн хэм хэмжээ тогтоосон шинжтэй байдаг бөгөөд зарлигт заасан гэмт хэргүүдийг үйлдсэн хэнд ч хамаарч үйлчлэх хүчин чадалтай байдгаараа онцлогтой. Өршөөлийн тухай зарлиг нь гол төлөв түүнийг гарахаас өмнө үйлдсэн гэмт хэргүүдэд хамаарч үйлчилдэг"[139] хэмээн тайлбарласан бөгөөд уучлалаас ялгагдах ялгааг нь "уучлал– нийгэмд онц аюултай гэмт хэрэг үйлдсэн тодорхой этгээдэд оноосон хүнд ялыг хөнгөн ялаар солих, ялыг хөнгөрүүлэх, эсвэл цагаатгах талаар төрийн эрх барих дээд байгууллагаас (АИХТ) гаргаж байгаа онцгой шийдвэр"[140] гэжээ.

Харин хууль зүйн ухааны доктор Д.Солонго өршөөлийг "гэмт хэрэг үйлдсэн этгээдэд эрүүгийн хариуцлага, шүүхээс ногдуулсан ялыг хөнгөрүүлэх, эсвэл хугацаанаас өмнө суллах үндэслэл"[141] гэж өөрийн бүтээлдээ дурдсан байна.

Хууль зүйн толь бичиг, тайлбарт англи хэлнээ "*pardon* - гэмт хэргийн улмаас үүссэн гэм буруутай этгээдэд ногдуулсан ял, хууль зүйн үр дагавраас чөлөөлөх тусгаар тогтносон бүрэн эрх мэдэлтний хэрэгжүүлэх давуу эрх"[142] хэмээн тодорхойлсон. АНУ-ын "Black's law dictionary" тольд "pardon - үгийн үүсэл гарлыг эртний Францын хуульд анхлан хэрэглэгдэж, латин хэлний (*perdonare*) буюу төрийн

[136] Д.Лүндээжанцан нар, *Парламентат ёс* (Уб, 2005), 90 дэх тал.

[137] Б.Амарбаясгалан, Цаазаар авах ял: Эрүүгийн эрх зүйн үндсэн асуудал (Уб, 2015).

[138] Төрийн хэлний зөвлөл, *Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь* (Уб, 2018), 235 дахь тал.

[139] Ж.Амарсанаа, *Эрх зүйн мэдлэгийн товч толь* (Уб, 1986), 112 дахь тал.

[140] Мөн тэнд.

[141] Д.Солонго, *Төрийн эрх зүйн тайлбар толь* (Уб, 2003), 93 дахь тал.

[142] Steven H.Gifis, *Dictionary of Legal terms*, III ed., (Barron's Educational Series, Inc. 1998), P.344.

дээд бүрэн эрхт эрх мэдэлтний бэлэг (чөлөөтэй байх баталгаа өгөх)”[143] гэсэн утгатай үгнээс үүсэлтэй болохыг тайлбарласан байна. Мөн тус тайлбарт эртний хэллэг болох “mercy - цаазаар авах ял ногдуулах эрүүгийн гэмт хэрэгтэнд хорих ял ногдуулан, өршөөн хэлтрүүлэхийг хэлнэ”[144] гэжээ.

Богд хааны үед Засгийн газрын тогтоол, шийдвэрт мутрын тэмдэг дарж батламжлах, Засгийн газраар уламжлан ялтныг уучилж, өршөөн ялыг нь хөнгөрүүлж байсан түүх байна. 1921 оноос хойш “өршөөл” хэмээх нэр томьёоны хуульчлагдсан байдлыг хүснэгтээр үзүүлбэл:

1926 оны Шүүх цаазын бичиг	40 дүгээр зүйлд: “... өршөөн хэлтрүүлэх буюу хөнгөтгөх эрхийг Улсын бага хурлын тэргүүлэгчид эдэлнэ...”
1929 оны Шүүх цаазын бичиг	41 дүгээр зүйлд: “... Улсын бага хурлын тэргүүлэгчид болбоос нийт буюу зарим ялтны хэргийг хөнгөтгөх ба бүрмөсөн өршөөн хэлтрүүлэх эрхийг хадгалмой ...”
1934 оны Шүүх цаазын бичиг	37 дугаар зүйлд “... Аливаа хүнийг шүүн таслах газар шийтгэхэд тогтоосон ялыг бүрмөсөн буюу заримыг хэлтрүүлэх эрхийг гагцхүү Улсын Бага Хурлын Тэргүүлэгчид эдэлнэ ...”
1942 оны Эрүүгийн хууль	49 дүгээр зүйлд “... Шүүн таслах газраас тогтоосон ялыг бүрмөсөн буюу заримыг өршөөн хэлтрүүлэх эрхийг Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдийн газар хадгална ...”

“Өршөөл үзүүлэх” нэр томьёог НҮБ ба бусад орны жишээнээс авч үзье.

Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ): Ерөнхий Ассамблей, Аюулгүйн Зөвлөлийн тогтоолоор дайны гэмт хэрэг болон хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэгтнээс бусад гэмт хэрэгт өршөөл үзүүлэхийг[145] улсуудад уриалж байжээ.

Иргэний дайнд асуудлыг шийдвэрлэх, зөрчилдөөнд хариу үзүүлэх, энхийн хэлэлцээрт өршөөл /amnesties/-ийг маш өргөн[146] хүрээнд хэрэглэдэг. Олон улсын бус шинж чанартай зэвсэгт мөргөлдөөнд хэлмэгдэгсдийг хамгаалах тухай 1949 оны Женевийн конвенцийн нэмэлт II протоколын 6.5-д “Дайтах ажиллагаа зогсмогц эрх баригч байгууллага зэвсэгт мөргөлдөөнд оролцсон, эсхүл тэднийг албадан саатуулсан буюу эрх чөлөө нь хязгаарлагдсаныг харгалзахгүйгээр зэвсэгт мөргөлдөөний улмаас эрх чөлөөгөө хасуулсан этгээдэд аль болох өргөн хүрээнд өршөөл үзүүлнэ” гэж заасан. Уг зохицуулалтын “аль болох өргөн хүрээнд” хэмээх хэсэг нь маргаан бүхий судлагдахуун болдог байна.

Америкийн Нэгдсэн Улс (АНУ): Анх 1795 онд Ерөнхийлөгч Жорж Вашингтон Вискиний татварыг эсэргүүцэгчдэд[147] өршөөл үзүүлсэн байдаг. Мөн Вьетнамын иргэний дайнд оролцогсдод өршөөл үзүүлж байсан түүхтэй.

Европ болон Азийн зарим улс: Швейцарийн Холбооны Хурал болон Испанийн Парламент (конгресс) буюу Сенат нь бүх нийтийн өршөөл үзүүлэх хууль гаргах бүрэн эрхтэй байдаг бол Япон Улсын Эзэн хаан бүх нийтийн болон хэсэгчилсэн өршөөл үзүүлэх, БНЧех улсын Ерөнхийлөгч шүүх эрх мэдлийн хүрээнд өршөөл үзүүлэх, Индонезийн Ерөнхийлөгч өршөөл үзүүлэх эрх эдэлдэг байна.

Дээрхээс дүгнэвэл, хууль зүйн шинжлэх ухаанд “өршөөл үзүүлэх”, “уучлал үзүүлэх” хэмээх хоёр ялгаатай ойлголт байх бөгөөд “өршөөл үзүүлэх” нь дийлэнх улсын хувьд парламентын эдлэх бүрэн эрх байдаг. Монгол Улсын хувьд ч мөн адил өршөөл үзүүлэх нь УИХ-ын бүрэн эрхэд хамаардаг байна. Өршөөл үзүүлэх бүрэн эрхийг хэрэгжүүлэхэд өршөөл үзүүлэх гэмт хэргийг зөв тодорхойлох шаардлагатай

[143] Bryan A. Garner, 9th edition Black’s law dictionary, (West publishing Co.), P.1221 (executive pardon-absolute pardon, conditional pardon- faultless pardon- general pardon-faultless pardon-partial pardon-unconditional pardon)

[144] Bryan A. Garner, 9th edition Black’s law dictionary, (West publishing Co.), P.1077

[145] Jean-Marie Henckaerts and Louise Doswald-Beck, *Customary International Humanitarian Law Volume I: RULES* P. 612

[146] Louise Mallinder, *Amnesties and Inclusive Political Settlements* (2018)

[147] https://www.americanheritage.com/amnesty

бөгөөд НҮБ-аас гишүүн улсууддаа дайны болон хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэгтнээс бусад гэмт хэрэгт өршөөл үзүүлэхийг уриалсан байгааг онцгойлон дурдах нь зүйтэй.

ҮНДСЭН ХУУЛИЙН ДЭГ ЖУРАМ

Энэ үгийг англи хэлний “constitutional order” орос хэлний “конституционный порядок”[148] гэсэн нэр томьёотой утга дүйцүүлэн хэрэглэдэг. Нийтлэг утгаараа Үндсэн хуулийн дэг журам гэдэг нь Үндсэн хууль болон Үндсэн хуульд нийцэн гарсан хэм хэмжээгээр тогтоогдсон, баталгаажсан нийгэм, эдийн засаг, улс төр-эрх зүйн харилцааны нэгдэл юм.

Монгол хэлний хувьд “Үндсэн хуулийн дэг журам” гэсэн үгийн утга болоод, чухам хэзээнээс хэрэглээнд орсон талаарх мэдээлэл хомс байна. Харин эрх зүйн зохицуулалтын хүрээнд 1992 оны Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Дараахь онцгой нөхцөл бий болсон үед үр дагаврыг нь арилгах, хүн ам, нийгмийн амьдралыг хэвийн болгохын тулд онц байдал зарлаж болно:” хэмээн 2-д “Үндсэн хуулийн дэг журам, нийгмийн хууль ёсны тогтолцоо оршин тогтноход заналхийлсэн аливаа байгууллага, бүлэг хүний зохион байгуулалт бүхий хүч хэрэглэсэн хууль бус үйл ажиллагааны улмаас үүссэн нийтийн эмх замбараагүй байдлыг төрийн байгууллага эрх хэмжээнийхээ дотор ердийн арга хэрэгслээр тохинуулах боломжгүй болсон.” гэж тусгасан бөгөөд Үндсэн хуулийн уг заалтаас үүдэн 1995 оны Онц байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт[149] Үндсэн хуулийн дэг журам, нийгмийн хууль ёсны тогтолцоо оршин тогтноход заналхийлсэн аливаа байгууллага, бүлэг хүний зохион байгуулалт бүхий хүч хэрэглэсэн хууль бус үйл ажиллагааны улмаас үүссэн нийтийн эмх замбараагүй байдлыг төрийн байгууллага эрх хэмжээнийхээ дотор ердийн арга хэрэгслээр тохинуулах боломжгүй болсон тохиолдолд онц байдал зарлаж болохоор зохицуулсан байна. Дээрх зохицуулалтаас өөрөөр хууль, хэм хэмжээний актад “Үндсэн хуулийн дэг журам” гэх нэр томьёог хэрэглээгүй байна.

Харин эрдэмтдээс академич С.Нарангэрэл “Монголын эрх зүйн англи, орос, латин хадмал эх толь бичиг” бүтээлдээ “Үндсэн хууль, түүнд үндэслэгдсэн хуулийн хэм хэмжээний дагуу тогтоосон ба үйл ажиллагааны дэг журам; засаг төрийн байгууллагын бүхий л тогтолцооны зохион байгуулалт ба үйл ажиллагааны байгуулал мөн эрх мэдэл ба хүн амын хоорондын харилцаа хуульд үндэслэнэ; үндсэн хуулиар тодорхойлсон тогтоомж ба холбогдох журмыг чанд сахин хангуулах.”[150] гэж тайлбарласан бөгөөд өөр эрдэмтэд дээрх нэр томьёог тайлбарласан эх сурвалж одоогоор байхгүй байна.

Үндсэн хуулийн дэг журам хэмээх нэр томьёог Ази тивд 10 улс, Хойд болон Латин Америкд 13 улс, Европ тивд 18 улс, Африк тивд 15 улс Үндсэн хуульдаа хэрэглэсэн байдаг.[151] Иймд Англи-Америкийн болон Эх газрын эрх зүйн бүлд хамаарагдах зарим оронд Үндсэн хуулийн дэг журам хэмээх нэр томьёог хэрхэн зохицуулсан талаар авч үзье.

ОХУ-ын 1993 оны Үндсэн хуульд Үндсэн хуулийн дэг журам хэмээх нэр томьёог Үндсэн хуулийн тогтолцоотой адилтган зохицуулсан байдаг.[152] ОХУ-ын

[148] Орос хэлний цахим толь бичиг, https://kartaslov.ru/синонимы-к-слову/конституционный+строй

[149] Онц байдлын тухай хууль, Төрийн мэдээлэл эмхтгэл №2 (Уб, 1996).

[150] С. Нарангэрэл, “Монголын эрх зүйн эх толь бичиг” (англи, орос, латин хадмал) 4 дэх хэвлэл, (УБ, 2015), 466 дахь тал.

[151] https://www.constituteproject.org/search?lang=en&q=constitutional%20order&status=in_force&status=is_draft (Сүүлд үзсэн: 2020.10.08).

[152] ОХУ-ын Үндсэн хууль, https://www.constituteproject.org/constitution/Russia_2014?lang=en (Сүүлд үзсэн: 2020.09.10).

Үндсэн хуулийн 13 дугаар зүйлийн 13.5 дахь хэсэгт "Үндсэн хуулийн дэг журмыг хүчээр өөрчлөх, ОХУ-ын бүрэн бүтэн байдлыг зөрчих, төрийн аюулгүй байдлыг алдагдуулахад ... чиглэсэн олон нийтийн холбоо байгуулах, ажиллуулахыг хориглоно."гэж заасан байна. Уг заалттай холбоотойгоор Үндсэн хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэгт Үндсэн хуулийн дэг журамд халдсан гэж тооцож болох үйлдлүүдийг зохицуулсан байна. Тодруулбал, нийгэмд арьс өнгө, үндэсний болон шашны үзэн ядалт, дайсагналыг өдөөх суртал ухуулга, сурталчилгаа явуулах нь Үндсэн хуулийн дэг журамд харшилсан үйлдэл гэж үзэхээр тусгажээ.

Дээрхээс гадна тус хуулийн 55 дугаар зүйлийн 55.3 дахь хэсэгт "Хүний болон иргэний эрх, эрх чөлөөг Үндсэн хуулийн дэг журам, ёс суртахуун, эрүүл мэнд, бусдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, улс орны батлан хамгаалах, төрийн аюулгүй байдлыг хангах зорилгоор зөвхөн Холбооны хууль тогтоомжийн дагуу хязгаарлаж болно*.",* 56 дугаар зүйлийн 56.1 дэх хэсэгт "Онцгой байдлын үед иргэдийн аюулгүй байдлыг хангах, Үндсэн хуулийн дэг журмыг хамгаалах зорилгоор Холбооны Үндсэн хуульд заасны дагуу эрх, эрх чөлөөнд тодорхой хязгаарлалт тогтоож, тэдгээрийн үйлчлэх хугацааг зааж өгч болно". Дээрх хуулийн зохицуулалт нь ганц улсынхаа иргэдийг бус тухайн улсад амьдарч буй бүх хүний эрх, эрх чөлөөг Холбооны Үндсэн хуулийн дэг журмыг хамгаалахын тулд хязгаарлах нөхцөлийг хуулиараа бий болгосон байна. Мөн түүнчлэн тус хуулийн 79 дүгээр зүйлд "Хүний болон иргэний эрх, эрх чөлөөг хязгаарлахгүй, ОХУ-ын Үндсэн хуулийн дэг журамтай харшлахгүй бол ОХУ олон улсын гэрээнд заасны дагуу улс хоорондын холбоонд нэгдэж бүрэн эрхийнхээ зарим хэсгийг тэдэнд шилжүүлж болно." хэмээн тус тус зохицуулсан байна.

Холбооны Бүгд Найрамдах Герман Улс: 1949 оны Үндсэн хуулийн 2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Хүн бүр өөрийгөө хөгжүүлэх эрхээ эдлэхдээ бусдын эрхэнд халдах, Үндсэн хуулийн дэг журам болон ёс суртахууны хуулийг зөрчиж үл болно."[153], 9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт "Холбооны зорилго, үйл ажиллагаа нь Үндсэн хуулийн дэг журам, Эрүүгийн хууль болон олон улсын үзэл баримтлалын эсрэг байхыг хориглоно.", 20 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт "Хууль тогтоох эрх мэдэл нь үндсэн хуулийн дэг журам, гүйцэтгэх болон шүүх эрх мэдэл нь хууль, шударга ёсонд захирагдана.", 20а дугаар зүйлд "Үндсэн хуулийн дэг журмын бүхий л хүрээнд төр нь ирээдүй үеийн өмнө хүлээсэн хариуцлагаа ухамсарлан амьдралын баталгааг хууль тогтоох замаар ханган, хуульд нийцсэн гүйцэтгэх болон шүүхийн үйл ажиллагаагаар хамгаална", 28 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Мужийн Үндсэн хуулийн дэг журам нь энэхүү Үндсэн хуулийн үзэл санааны дагуу Бүгд Найрамдах Улсын байгуулалтай, ардчилсан бөгөөд нийгмийн баримжаатай улс, эрх зүйт ёсны зарчмын агуулгад нийцсэн байна ....", тус зүйлийн 3 дахь хэсэгт "Мужийн Үндсэн хуулийн дэг журам нь үндсэн эрх[154] болон энэ зүйлийн 1, 2 дахь хэсэгт нийцсэн бол Холбоо баталгаажуулна.", 98 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт "Хэрэв Холбооны шүүгч нь албан, эсхүл албан бус байдлаар энэхүү Үндсэн хуулийн зарчим, эсхүл Мужийн Үндсэн хуулийн дэг журмыг зөрчсөнийг Бундестагаас Холбооны Үндсэн Хуулийн шүүхэд гомдол гаргасан бол гуравны хоёрын олонхийн саналаар тухайн шүүгчийг шилжүүлж, эсхүл ажлаас нь чөлөөлнө. Санаатайгаар зөрчил гаргасан тохиолдолд ажлаас нь огцруулж болно" хэмээн тус тус зохицуулсан байна.

Бүгд Найрамдах Косово Улс Үндсэн хуулийнхаа 7 дугаар зүйлийн 1-д "Косово улсын Үндсэн хуулийн дэг журам нь энх тайван, ардчилал, тэгш байдал, хүний эрх, эрх чөлөө, хууль дээдлэх ёсыг хүндэтгэх, ялгаварлан гадуурхахгүй байх, өмчлөх эрх, байгаль орчныг хамгаалах, нийгмийн шударга ёс, олон ургальч үзэл, төрийн

[153] Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Үндсэн хууль, Орч: П.Амаржаргал нар (Уб, 2020), 16 дахь тал.

[154] Мөн тэнд.

эрх мэдлийг хуваарилах, зах зээлийн эдийн засагт суурилна."[155] хэмээн Үндсэн хуулийн дэг журмын талаар зохицуулсан байна.

Холбооны Бүгд Найрамдах Бразил Улсын 1988 оны Үндсэн хуулийн 2 дугаар бүлгийн 1 дүгээр хэсгийн 5 дахь зүйлд "Хуулийн өмнө хүн бүр тэгш эрхтэй бөгөөд тус улсад оршин суугаа Бразилчууд болон гадаадын иргэд иргэний болон цэргийн зэвсэгт бүлэг байгуулан үндсэн хуулийн дэг журам болон ардчилсан төрийн эсрэг үйл ажиллагаа явуулах гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа тооцохгүй."гэж зохицуулжээ.[156]

Дээрхээс дүгнэвэл, манай улсын хувьд "Үндсэн хуулийн дэг журам" хэмээх нэр томьёо нь харьцангуй бага судлагдсан бөгөөд энэ үгтэй холбоотойгоор эрх зүйн эх сурвалжуудад тусгаж өгөөгүйгээс нэгдсэн ойлголт байхгүй байгаа нь харагдаж байна.

ХҮРЭЭ, ХЯЗГААР

"Хүрээ" гэх үгийг Монгол хэлний тайлбар тольд нэлээд олон утгыг илэрхийлснээр бичсэн бөгөөд бидний энд дурдаж байгаа үгийн тухайд Б.Чойндон. Галбын говьд., ажлын хүрээ (тухайн ажил хэргийг гүйцэтгэх, эрх үүрэг, хариуцлага)[157]гэж, "эрх зүйн хүрээ" гэдгийг академич С.Нарангэрэл "Англи-Монгол эрх зүйн толь бичиг" бүтээлдээ "legal framework" гэдэг үгтэй дүйцүүлэн тайлбарласан[158] бол "хязгаар" гэх үгийг юмны туйлын хэмжээ, төгсгөл: хязгаар тогтоох (юмны эцсийн хэмжээ, зааг тогтоох)[159] гэж тайлбарласан байна. Дээрх нэр томьёоны агуулга нь ямарваа нэг юмс, үзэгдлийн туйлийн хэмжээг[160] тодотгоход хэрэглэдэг үгс юм. Хүрээ гэх үгийг англи хэлний "framework"[161] гэх үгтэй утгай дүйцүүлэн хэрэглэдэг бөгөөд дараах байдлаар тайлбарласан байна. Үүнд, Камбриджийн цахим толь бичигт ямар нэг зүйлийг төлөвлөх, шийдэхэд ашигладаг дүрэм, санаа, мэдээлэл, зарчим[162] гэх утгыг илэрхийлдэг гэсэн бол, Хуулийн тайлбар цахим толь бичигт шийдвэр гаргах, гэрээ хэлэлцээр, хууль тогтоомжийг зохицуулж, зохицуулдаг дүрэм журмын өргөн тогтолцоо,[163] үзэл баримтлалын үндсэн бүтэц[164] гэж тус тус тайлбарласан байна.

Харин "хязгаар" гэх үгийг англи хэлний "limitations"[165] гэх үгтэй утга дүйцүүлэн хэрэглэдэг бөгөөд утгын хувьд *Камбриджийн цахим толь бичигт "limit"* зөвшөөрөгдсөн эсвэл боломжтой хамгийн их хэмжээ, тоо, эсвэл төвшин,[166] *Хуулийн тайлбар цахим толь бичигт* ямарваа нэг зүйлийн хүрэх тодорхой тоо, хэмжээ, төвшин,[167] ямарваа нэг зүйлийг хүрээлэх, тогтоон барих дээд хэмжээ[168] гэж тус тус тайлбарласан байна.

---

155 Бүгд Найрхамдах Косово Улсын Үндсэн хууль, https://www.constituteproject.org/constitution/Kosovo_2016?lang=en (Сүүлд үзсэн:2020.10.12).

156 ХБНБУ-ын Үндсэн хууль, https://www.constituteproject.org/constitution/Brazil_2017?lang=en (Сүүлд үзсэн: 2020.09.30) .

157 Монгол хэлний тайлбар толь, https://mongoltoli.mn/dictionary/detail/118324 (Сүүлд үзсэн: 2020.09.15).

158 С.Нарангэрэл, "Англи-Монгол эрх зүйн толь бичиг" (Уб, 2005), 426 дахь тал.

159 Монгол хэлний тайлбар толь, https://mongoltoli.mn/dictionary/detail/121218 (Сүүлд үзсэн: 2020.09.15).

160 Я.Цэвэл, Монгол хэлний товч тайлбар толь (Уб, 1966), 770 дахь тал.

161 http://www.bolortoli.com/dictionary/(Сүүлд үзсэн: 2020.09.15).

162 Камбриджийн цахим толь бичиг, https://dictionary.cambridge.org/dictionary/english/framework

163 Хуулийн цахим толь бичиг, https://www.translegal.com/dictionary/en/legal-framework/noun

164 Merriam-webster цахим толь бичиг, https://www.merriam-webster.com/dictionary/framework

165 Ж.Амарсанаа, Англи-орос-герман- монгол Олон улсын эрх зүйн толь (Уб, 2004), 478 дахь тал.

166 Камбриджийн цахим толь бичиг, https://dictionary.cambridge.org/dictionary/english/limit

167 Хуулийн цахим толь бичиг, https://www.translegal.com/dictionary/en/limit/verb/?to=en

168 Merriam-webster цахим толь бичиг, https://www.merriam-webster.com/dictionary/limit

Дээрх нэр томьёог төсвийн, татварын гэх зэрэг мэргэжлийн яамны боловсруулвал зохих хууль, тогтоомжийг УИХ-ын гишүүн, мөн түүнчлэн Ерөнхийлөгч санаачилдаг байдлыг болиулах, Үндсэн хуулийн дараа эрэмбэлэгдэх ач холбогдол бүхий хуулиудыг мэргэжлийн өндөр түвшинд хийдэл, зөрчилгүйгээр боловсруулан баталж, сайжруулдаг байх, хууль санаачлах эрхийн хүрээ, хязгаарыг дэлхийн улс орнуудын жишиг, өөрийн орны онцлог нөхцөлд нийцүүлэн хуулиар зөв тогтоох зэрэг[169] үндэслэлээр 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт хэсэгт "Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газар хууль санаачлах эрх эдлэх бөгөөд энэхүү эрхийн хүрээ, хязгаарыг хуулиар тогтооно." хэмээн хуульчилсан.

Харин Монгол Улсын Үндсэн хуульд хууль санаачлах эрхтэй холбоотойгоор дараах хязгаарлалт байж болохоор байна. Тодруулбал, Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт "Онц болон дайны байдал зарласан тохиолдолд Үндсэн хууль, бусад хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг гагцхүү хуулиар хязгаарлаж болно. Тийнхүү хязгаарласан хууль нь хүний амьд явах эрх, иргэл үнэмшилтэй байх, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө, түүнчлэн хэнд боловч эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахыг хориглосон хуулийн заалтыг үл хөндөнө" хэмээн зааснаас үзвэл хууль санаачлагч ямар ч тохиолдолд хүний амьд явах эрх, иргэл үнэмшилтэй байх, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө, хэнд боловч эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахыг хориглосон заалтыг хөндөхөөр хуулийг ямар ч тохиолдолд санаачлахгүй байхаар хязгаарласан байж болохоор байна.

Мөн Монгол Улсын Их Хурлын тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн 38 дугаар зүйлд хууль санаачлах эрхийн хүрээ, хязгаарын талаар дараах байдлаар зохицуулсан байна. Үүнд, Тус хуулийн 38 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Улсын Их Хурлын үйл ажиллагаа, хуралдааны дэгтэй холбоотой хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг зөвхөн Улсын Их Хурлын гишүүн санаачилна.", 38 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт "Ерөнхийлөгч Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлд заасан үндсэн бүрэн эрхийнхээ хүрээнд хууль санаачилна.", 38 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт "Төсвийн хүрээний мэдэгдэл, улсын төсөв, түүний гүйцэтгэл, эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэл, түүнчлэн өмч, татвар, эрүү, иргэн, захиргааны ерөнхий болон зөрчлийн тухай анхдагч хууль, шинэчилсэн найруулга болон Засгийн газар санаачлахаар Үндсэн хууль, бусад хуульд тусгайлан заасан асуудлаар хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг зөвхөн Засгийн газар санаачилна." хэмээн тус тус зааж хүрээ, хязгаарыг тодорхойлж өгсөн байна.

Дийлэнх улсын Үндсэн хуульд хууль санаачлах эрхтэй холбоотойгоор хүрээ, хязгаарын асуудлыг тусгаагүй бөгөөд цөөн хэдэн улс Үндсэн хуульдаа энэ асуудлыг зохицуулсан байна. Тодруулбал, ОХУ-ын 1993 оны Үндсэн хуулийн 104 дүгээр зүйлийн 104.1 дэх хэсэгт "ОХУ-ын Ерөнхийлөгч, Холбооны Зөвлөл, ОХУ-ын сенаторууд, Төрийн Думын депутат, ОХУ-ын Засгийн газар, ОХУ-ын бүрэлдэхүүн хэсгүүдийн хууль тогтоох (төлөөлөх) байгууллагууд хууль санаачлах эрхтэй. ОХУ-ын Үндсэн хуулийн шүүх, ОХУ-ын Дээд шүүх өөрийн харьяаллын асуудлаар хууль санаачлах эрхтэй." гэж зохицуулсан байна.[170] Дээрх зохицуулалтаар Үндсэн хуулийн шүүхэд болон Дээд шүүхэд хамааралтай асуудлаар хууль санаачлах эрхийг Үндсэн хуулиараа олгосон. Тус хууль санаачлах эрхийг дээрх шүүхүүдийн харилцааг нарийвчилан зохицуулсан хуулиар зохицуулсан байдаг байна. Тухайлбал, ОХУ-ын 1994 оны "Үндсэн хуулийн шүүхийн тухай хууль"-ийн 3 дугаар зүйлд ОХУ-ын

[169] Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн үзэл баримтлал, https://president.mn/10139/ (Сүүлд үзсэн: 2020.09.15).

[170] ОХУ-ын Үндсэн хууль, https://www.constituteproject.org/constitution/Russia_2014?lang=en (Сүүлд үзсэн: 2020.09.10).

Үндсэн хуулийн шүүхэд харьяалах харилцааг[171], 2014 оны "ОХУ-ын Дээд шүүхийн тухай хууль"-ийн 2 дугаар зүйлд Дээд шүүхийн харьяалах харилцааг зохицуулсан байна.[172]

Харин Франц улсын Үндсэн хуулийн Гучин Есдүгээр зүйлд "Улсын Их Хурлын гишүүн, Ерөнхий сайд хууль санаачлах эрхтэй.", Дөчдүгээр зүйлд "Улсын Их Хурлын гишүүний оруулсан санал, нэмэлт, өөрчлөлт нь улсын нөөц баялгийг хорогдуулах, эсхүл зардлыг нэмэгдүүлэхэд хүргэх бол батлахгүй." хэмээн хууль санаачлах субъектыг болон хүрээ, хязгаарын талаар тусгасан гэж үзэж болохоор байна.[173]

Түүнчлэн Бүгд Найрамдах Польш Улсын Үндсэн хуулийн 118 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Сеймийн гишүүд, Сенатын гишүүд, Бүгд найрамдах Улсын Ерөнхийлөгч болон Сайд нарын зөвлөлд хууль санаачлах эрх үйлчилнэ.", 2 дахь хэсэгт "Хууль санаачлах эрх мөн Сеймд сонгогдох эрхтэй доод тал нь 100,000-аас дээш иргэдийн нэгдэлд үйлчилж болно. Энэ аргыг хэрэглэх журмыг хуулиар тогтооно."[174] хэмээн заасан нь ч мөн хүрээ, хязгаарын талаар тусгасан гэж ойлгогдож байна.

Мөн дээрх улсуудаас гадна эрх зүйн бүл, төрийн удирдлагын хэлбэр, парламентын танхимын тоо болон сонгуулийн тогтолцоо зэргийг шалгуур болгон Монгол Улстай төсөөтэй улсуудын хууль санаачлах эрх бүхий субъект[175], хууль санаачлах эрхийн хүрээ, хязгаарын талаар харьцуулан авч үзвэл:

ПАРЛАМЕНТЫН ХААНТ ЗАСАГЛАЛТАЙ УЛС

Улс	Хууль санаачлах эрх	Хүрээ, хязгаар тусгасан эсэх
Испани	- танхимууд; - өөртөө засах эрх бүхий мужийн парламент; - Засгийн газар; - 500 мянгаас доошгүй иргэд нэгдэж хууль санаачлах эрх эдэлнэ; - доод танхимаас Сенатын хоригийг энгийн олонхын саналаар хэрэгсэхгүй болгож болно.	Иргэдийн хууль санаачлах эрхэд Органик хуулиар зохицуулагддаг асуудлууд (үндсэн эрх, эрх чөлөө, автономит нийгэмлэгийн дүрмийг нэвтрүүлэх, сонгуулийн тогтолцооны үндэс суурийг бий болгох гэх мэт), татвар, олон улсын харилцаа, өршөөлийн асуудлаар хууль санаачлах эрх хамаарахгүй.[176]
Их Британи	- Танхимын гишүүд хууль санаачлах эрхтэй ба 7 хоногт 1 өдөр хуулийн төсөл өргөн барих эрхтэй; - Засгийн газрын гишүүд төлөөлөгч хэдийд ч хуулийн төсөл өргөн барих давуу эрхтэй.	тусгагдаагүй
Япон	- Ерөнхий сайд Засгийн газрыг төлөөлөн хуулийн төсөл өргөн барина[177];	Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслийг парламент санаачилна.[178]

[171] ОХУ-ын "Үндсэн хуулийн шүүхийн тухай хууль", http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_4172/97abe6fd8de21b3e15e5f784b30144f6e2a068b7/ (Сүүлд үзсэн: 2020.09.15).

[172] ОХУ-ын "ОХУ-ын Дээд шүүхийн тухай хууль", http://www.consultant.ru/document/

[173] Франц Улсын Үндсэн хууль, (1958) https://constituteproject.org/constitution/France_2008?lang=en

[174] Польш Улсын Үндсэн хууль, https://constituteproject.org/constitution/Poland_2009?lang=en

[175] УИХ-н Тамгын газрын Судалгаа, шинжилгээ, хяналт үнэлгээний хэлтсийн Судалгаа, мэдээлэл, лавлагааны алба, "Монгол Улсын Үндсэн хуульд оруулах, нэмэлт, өөрчлөлтийн төсөлтэй холбоотой судалгаа, мэдээлэл, лавлагаа" (УБ, 2017), 176-177 дахь тал.

[176] Б.А Страшун, Хууль санаачлах эрх, https://w.histrf.ru/articles/article/show/zakonodatielnaia_initsiativa (Сүүлд үзсэн: 2020.10.12).

[177] Япон Улсын Үндсэн хуулийн 72 дугаар зүйл, https://www.constituteproject.org/constitution/Japan_1946?lang=en (Сүүлд үзсэн 2020.10.13).

[178] Япон Улсын Үндсэн хууль 96 дугаар зүйл, https://www.constituteproject.org/constitution/Japan_1946?lang=en (Сүүлд үзсэн 2020.10.13).

Хуулийн Үндэсний Хүрээлэн www.rli.gov.mn

ПАРЛАМЕНТЫН БҮГД НАЙРАМДАХ УЛС

Улс	Хууль санаачлах эрх	Хүрээ, хязгаар байгаа эсэх
Улс	- Бүх Хятад Ардын Төлөөлөгчдийн Их Хурал (Парламент)-ын бүх төлөөлөгч; - Байнгын хороо (Standing committee)-ны бүх төлөөлөгчид хууль санаачлах эрхтэй; - Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг БХАИТХ-ын төлөөлөгчдийн 1/5-ээс дээших нь санаачлах эрхтэй.	тусгагдаагүй
Болгар	- Парламентын гишүүн; - Сайд нарын Зөвлөл; - Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг Үндэсний Ассамблей ½ гишүүд, эсхүл Ерөнхийлөгч санал оруулна.	тусгагдаагүй
Исланд	- Ерөнхийлөгч нь хуулийн төсөл болон бусад шийдвэрийн төслийг Парламентад өргөн барих эрхтэй байна; - Парламентын гишүүн; - Сайд нар хууль болон бусад шийдвэрийн төсөл санаачлах эрхтэй.	тусгагдаагүй
Италиа	- Засгийн газар; - Парламентын гишүүд; - 50000-аас багагүй сонгогчид гарын үсгээ цуглуулан хуулийн төсөл боловсруулах замаар хууль санаачлах эрхтэй; - Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөлд эрх бүхий хуулийн этгээд болон сонирхогч талууд оролцох эрхтэй.	Ард иргэдийн хууль санаачлах эрх бол хуулийн эсрэг санал өгөх эрх юм. Хэрэв ард нийтийн санал асуулгад оролцсон сонгогчдын талаас илүү хувь нь хуулийн эсрэг санал өгсөн бол хуулийг хүчингүй болсонд тооцдог. Хууль санаачлах эрх мэдлээ парламентын бүрэн эрхийн хугацаа дуусахаас нэг жилийн өмнө, эсхүл сонгогдсоноос хойш нэг жилийн дараа, жил бүрийн сүүлийн гурван сарын дотор хэрэгжүүлэх эрхгүй байдаг. Мөн татвар, төсвийн тухай хууль, өршөөл, уучлал үзүүлэх, Олон улсын гэрээг соёрхон батлах тухай хуулиудад ийм санал асуулга явуулахыг хориглодог.[179]
Киргиз	- Засгийн газар; - Парламентын гишүүн; - 10000 сонгох, сонгогдох эрхтэй иргэд хууль санаачлах эрхтэй.	Улсын хилийг өөрчлөх, төсөв бүрдүүлэх, өршөөл, уучлал үзүүлэх, олон улсын харилцааны асуудал, цэргийн болон онц байдал зарлах тухай асуудлын талаар хууль санаачлах эрхгүй.[180]
Серби	- Парламентын гишүүн; - Автономит мужуудын Ассамблей; - 30000 сонгох, сонгогдох эрхтэй иргэд; - Иргэний хамгаалагч болон Сербийн Үнэсний Банк нь өөрийн эрх мэдэлд хамаарх асуудлаар хууль мэдүүлэх эрхтэй.	тусгагдаагүй
Латви	- Ерөнхийлөгч; - Засгийн газар; - Меймийн хороод; - Сеймийн 5-аас доошгүй гишүүд; - 50000 сонгох, сонгогдох эрхтэй иргэд хууль санаачлах эрхтэй.	тусгагдаагүй

Дээрхээс дүгнэвэл, хууль санаачлах эрхийн хүрээ, хязгаар гэх ойлголт нь Монгол Улсын эрх зүйн хөгжилд шинэлэг ойлголт бөгөөд энэ ч утгаараа нэгдсэн ойлголтонд хүрээгүй байгаа нь харагдаж байна.

[179] Е. Бусол, Народная законодательная инициатива «народное вето» –разновидность отклоняющего референдума.

[180] "Бүгд Найрамдах Киргиз улсад ард түмний хууль тогтоох санаачилгын талаарх" хууль, http://cbd.minjust.gov.kg/act/view/ru-ru/203452, (Сүүлд үзсэн: 2020.10.13).

Хуулийн хэрэгжилтийн хүрээлэн www.nli.gov.mn

НИЙТИЙН АШИГ СОНИРХОЛ

XIII зуунд Италийн философич Аквины Фома (Thomas Aquinas) “хууль тогтоомж болон Засгийн газрын зорилго нь “нийтийн сайн сайхан”-ы төлөө үйлчлэх юм” [181] хэмээн тодорхойлж байжээ. Нийтийн сайн сайхан гэсэн үг нь явсаар “нийтийн ашиг сонирхол” болсон бөгөөд латин хэлний “bonum commune” гэсэнтэй дүйж байгаа юм.

АНУ-ын Black’s law dictionary тольд “нийтийн ашиг сонирхол” гэдгийг (1)Хүлээн зөвшөөрөх, хамгаалах шаардлагатай нийтийн сайн сайхан байдал; (2)Нийтийн оролцоог шаарддаг, ялангуяа, Засгийн газрын зохицуулалтыг зөвтгөдөг зүйл[182] гэж тайлбарлажээ.

Нийтийн ашиг сонирхол гэдэг үг анх англи хэлнээ 1670-1680 онд тэмдэглэгдсэн болох тухай мөн холбогдох эх сурвалжид дурдсан[183] байна. Академич С.Нарангэрэл нийтийн ашиг сонирхол гэдгийг “нийтийн эрх зүйд төрөөс хүлээн зөвшөөрсөн ба эрх зүйгээр зохицуулагдсан нийгэмшлийн нийтлэгийн ашиг сонирхол, тэдгээрийг оршин тогтнох болон хөгжихийг хангах нөхцөл ба баталгаа”[184] гэж тодорхойлжээ.

Монгол Улсад “нийтийн ашиг сонирхол” хэмээх үг хэдий үеэс хэрэглээнд нэвтэрсэн талаар тодорхой баримт байхгүй, монгол хэлний товч тайлбар толиудад гагцхүү үг бүрчлэн тайлбарласан байна. Гэсэн хэдий ч “Амин хувийн ашиг өвсний шүүдэртэй адил, ард олны ашиг өндөр тэнгэртэй адил” хэмээх ардын зүйр үгийг монголчууд хэрэглэж ирсэн нь агуулгын хувьд эл ойлголттой дүйх бөгөөд ард олны ашгийг эрхэмд тавьж ирснийг илэрхийлж байна. Түүнчлэн, 1924 оны Монгол Улсын Үндсэн хуульд “эрх ашиг” хэмээх үг орсон нь агуулгын хувьд “нийтийн ашиг сонирхол”-той нийцэхээр байна. Мөн 1960 оны Үндсэн хуульд “хувийн ба нийгмийн эрх ашгийг зөв зохицуулах” гэсэн хэллэг оруулсан нь нийтийн ашиг сонирхлыг хувийн ашиг сонирхлоос ялгаж, салгах тухай зохицуулалт болсон гэж үзэж болохоор байна. Иймд “нийтийн ашиг сонирхол” гэсэн ойлголт Монгол Улсад хагас зууны өмнөөс байсан гэж үзэх үндэслэлтэй юм.

Хүснэгтээр үе үеийн Монгол Улсын Үндсэн хуулиудын холбогдох зохицуулалтыг дэлгэрэнгүй харуулбал:

1924 оны Үндсэн хууль[185]	1960 оны Үндсэн хууль[186]	1992 оны Үндсэн хууль
Тус улсын *олон ардын эрх ашгийг хүндэтгэн хамгаалахын* тул хэрэв аль нэгэн хүн буюу хэсэг этгээд нар өөрийн эрхийг улсын явдалд хортойгоор хэрэглэх аваас тэд нарын эрхийг хязгаарлах буюу устгаваас зохино	Наймдугаар бүлгийн Наян есдүгээр зүйлийн в-д “Хувийн ба нийгмийн эрх ашгийг зөв зохицуулах, улс нийгмийн эрх ашгийг хувийнхаас илүүд үзэж байх”; мөн зүйлийн е-д “Өсвөрийн залуу үеийг хөдөлмөрт дуртай, ... хамт олонч, нийгмийн эрх ашгийг хүндэтгэгч ... хүмүүс болон хүмүүжүүлэх”	Арван зургадугаар зүйлийн 10 дахь хэсэгт “<u>нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол</u>, үзэл бодлын үүднээс ... сайн дурааараа эвлэлдэн нэгдэх эрхтэй”; Хорин наймдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Хуулийн биелэлтийг хангахтай холбоотой <u>нийтийн ашиг сонирхлыг</u> хөндсөн тодорхой асуудлаар ... хороог байгуулна”; Дөчин зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Монгол Улсын төрийн жинхэнэ албан хаагч ... иргэний ёсоор <u>төрийн ашиг сонирхолд</u> захирагдан ажиллана”

[181] “Public Interest, Political Philosophy and the Study of Public Administration” Public Interest in UK Courts.

[182] Bryan A.Garner, *Black’s Law Dictionary*, 9th edition (St. Paul: Thomson Reuters, 2009), p.1350.

[183] Цахим толь бичиг, https://www.dictionary.com/browse/public-interest (Сүүлд үзсэн: 2020.09.29).

[184] С.Нарангэрэл, *Монголын эрх зүйн эх толь бичиг* (Уб, 2015), 278 дахь тал.

[185] Ж.Амарсанаа, О.Батсайхан, Монгол Улсын Үндсэн хууль /баримт бичиг/ (Уб, 2004), 75 дахь тал.

[186] Мөн тэнд, 304 дэх тал.

Тайлбар:	Тайлбар:	Тайлбар:
Бидний Монголын олон түмэн ардууд хэдэн зуун онд эзэрхэг харгисын гарт бүдүүлэг харанхуйгаар боолчлогдон дарлагдсаар эрдэм соёлоос ихэд хоцрогдсон бөгөөд эдүгээ бүгдээр нэгэн адил эрх чөлөө олсонд зарим нэгэн ухвар мөчид нь ташааран ухаж, захирах захирагдахын ёсыг үл хэрэгсэх буюу хууль цаазаас ангид явах аваас даруй олон ардын эрх ашиг ба улсын явдалд хорлолтой болохын тул тийнхүү тэд нарын эрхийг хязгаарлах буюу устгаваас зохино хэмээн тодорхойлон тогтоосон нь болой.[187]	Социализмын үед хувийн болон нийгмийн эрх ашиг салшгүй холбоотой байдаг бөгөөд хувийн эрх ашгийг бүрэн дүүрэн хангах явдал нь уул ашиг сонирхол, нийгмийн ашиг сонирхолд бүрэн захирагдаж байж биеллээ олох болно. Энэхүү үндэслэлийн дагуу манай иргэдийн үүрэг бол "хувийн ба нийгмийн эрх ашгийг зөв зохицуулах, улс нийгмийн эрх ашгийг хувийнхаасаа илүүд үзэж байх"-д оршино.[188]	"нийгмийн ашиг сонирхол"; "өөрийн ашиг сонирхол"; "нийтийн ашиг сонирхол"; "төрийн ашиг сонирхол" гэх ялгаатай үгсээр хуульчилсан ч эдгээр нь "нийтийн болон хувийн ашиг сонирхол"-ыг шууд буюу дам утгаар илэрхийлнэ.

Хүснэгтээс үзвэл, Монгол Улсын үе үеийн Үндсэн хуулиудад ийнхүү "нийтийн ашиг сонирхол" хэмээх нэр томьёог хуульчилсан бөгөөд хуулийн зохицуулах харилцаанаас хамаарч тодорхой хэмжээний ялгаатай байгаа хэдий ч алинд нь ч шууд байдлаар агуулгыг тайлбарлаагүй нь "... хуулиар шууд тодорхойлон заах боломжгүй ойлголт учраас хууль тогтоогч шууд болон тодорхой тайлбар хийхээс татгалзаж, нээлттэй орхисон"[189] гэж үзэж болох юм.

Судалгааны агуулга нь Үндсэн хуулийн нэр томьёоны хүрээнд тул бусад улсын Үндсэн хуульд "нийтийн ашиг сонирхол" хэмээх ойлголтыг хуульчилсан эсэхийг авч үзье.

ХБНГУ: Тус улсын Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт "Зөвхөн нийтийн сайн сайхны төлөө өмчийг албадан хурааж болно. Нөхөн төлбөрийн хамрах хүрээ, шинж чанарыг зөвхөн хуулиар тогтооно. Нөхөн төлбөрийг нийтийн ашиг сонирхол болон ашиг сонирхол хөндөгдсөн этгээдийн эрх ашгийг тэнцүүлсний үндсэн дээр тогтооно. Нөхөн төлбөрийн хэмжээтэй холбогдох маргаан нь ердийн шүүхэд харьяалагдана"[190] гэж заажээ.

Дээрх хуульд ганцхан удаа "нийтийн ашиг сонирхол" гэх нэр томьёо дурдагдсан нь мөнхүү заалт бөгөөд нийтийн ашиг сонирхол болон холбогдох этгээдийн эрх ашгийг жинлэн үзсэний дүнд нийтийн сайн сайхны төлөө өмчийг албадан хурааж болох тухай зохицуулсан байна.

БНХАУ: Тус улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлд "Төр нь нийтийн ашиг сонирхол болон хуульд заасныг үндэслэн газрыг түүний хэрэгцээний дагуу дайчлан авах бөгөөд дайчлан авсан газарт нөхөх олговор төлнө"[191] гэжээ.

БНХАУ-ын Үндсэн хуулийн дээрх зохицуулалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 3 дахь хэсэгт зохицуулсантай төстэй бөгөөд "нийтийн ашиг сонирхлыг үндэслэн" дайчлан авахаар хуульчилжээ.

[187] Мөн тэнд, 75 дахь тал.

[188] Мөн тэнд.

[189] Т.Мөнх-Эрдэнэ, "Нийтийн ашиг сонирхлыг тодорхойлох нь", https://legaldata.mn/buteel/pdf?id=143 холбоосоор дэлгэрүүлж үзнэ үү. (Сүүлд үзсэн: 2020.09.28).

[190] Хууль зүйн үндэсний хүрээлэн, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Үндсэн хууль, Орч. П.Амаржаргал нар (Уб, 2020), 23 дахь тал.

[191] БНХАУ-ын Үндсэн хууль (1982), https://www.constituteproject.org/constitution/China_2018?lang=en

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.ulti.gov.mn

Нидерлантын Вант Улс (Нидерланд): Тус улсын Үндсэн хуульд[192] "нийтийн ашиг сонирхол" гэсэн нэр томьёо 6 удаа, зохицуулалтын зүйлээсээ хамаарч ялгаатай байдлаар дурдагдсан байгаагаар манай улсын Үндсэн хуультай төстэй юм.

Нидерландын Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Парламентын тухай хууль эсхүл тогтоосон журмын дагуу гагцхүү нийтийн ашиг сонирхлын тулд нөхөх олговрыг бүрэн олгох баталгааны үндсэн дээр өмчийг хураан авч болно"; 41 дүгээр зүйлд "Хаантан нийтийн ашиг сонирхлыг харгалзан Ордны хэргийг эрхлэн зохион байгуулна"; 132 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт "Захиргааны байгууллагаас гаргасан шийдвэрийг гагцхүү Хааны Зарлиг, хууль, эсхүл нийтийн ашиг сонирхолтой зөрчилдөж байгаа тохиолдолд цуцална" гэж тус тус заажээ.

Норвегийн Вант Улс (Норвеги): Тус улсын Үндсэн хуулийн[193] 95 дугаар зүйлд "Хүн бүр шударга, хараат бус шүүхээр боломжит хугацаанд хэргээ шүүлгэх эрхтэй. Шүүх хуралдаан шударга, нээлттэй явагдана. Талуудын ашиг сонирхол, халдашгүй байдал, эсхүл нийтийн ашиг сониирхолд ач холбогдолтой бол шүүх хуралдааныг хаалттай явуулж болно" гэж заасан байна.

Дээрхээс дүгнэвэл, ХБНГУ, БНХАУ, Нидерланд улсуудын Үндсэн хуульд "нийтийн ашиг сонирхол"-ыг хувийн өмчийг хураан авахтай холбогдсон зохицуулалтад оруулсан байх бөгөөд Норвегийн Үндсэн хуульд шүүх хуралдаан хаалттай явагдах үндэслэлд "нийтийн ашиг сонирхол"-той холбоотой байх үндэслэл хамаарч байна. Харин хувийн өмчийг дайчлан авахтай холбоотой асуудлыг манай Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 3 дахь хэсэгт заахдаа "... нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн ..." гэж хуульчилсан байна. "Нийтийн ашиг сонирхол" хэмээх ойлголтын тухайд Монгол Улсын Үндсэн хуульд эвлэлдэн нэгдэх эрх, нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар УИХ хороо байгуулах зэрэг асуудалд тусгаснаараа ялгаатай юм.

ГИШҮҮНИЙ ХАЛДАШГҮЙ БАЙДАЛ

"Гишүүний халдашгүй байдал" Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 2-т "Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлыг хуулиар хамгаална." гэж зохицуулсан.

Академич С.Нарангэрэл "Эрх зүйн эх толь бичиг" бүтээлдээ "Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдал (англи. Involiolability member of the state great hural) УИХ-ын гишүүний албан үүргээ зохих ёсоор гүйцэтгэхэд зориулагдсан эрх дарх. УИХ-ын гишүүнийг албадан саатуулах, цагдан хорих, түүнд шүүхийн журмаар захиргааны шийтгэл ногдуулах, гэр, албан өрөө, тээврийн хэрэгсэл, биед нь үзлэг нэгжлэг хийхийг хуулиар хориглосон. Тэгэхдээ гэмт үйлдлийнх нь явцад, эсхүл гэмт хэргийн газарт эд мөрийн баримттай нь баривчилж, улмаар бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх тухай саналыг Улсын ерөнхий прокурор УИХ-д оруулсан бол УИХ-ын гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлнэ." гэжээ.[194]

Харин Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбарт, Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдал нь өргөн хүрээтэй ойлголт. Үүнээс Улсын Их Хурал шаардлагатай гэж үзсэн зарим эрх хэмжээг хуулиар тогтоож ердийн иргэн хүнээс давуу байдал тогтоож болно. Хуулиар тусгайлан тогтоогоогүй тохиолдолд иргэн хүний нэг адил эрх хэмжээ эдэлнэ. Жишээ нь: Улсын Их Хурлын гишүүний харилцуур утас

[192] Нидерландын Вант Улсын Үндсэн хууль (1814), https://www.constituteproject.org/constitution/Netherlands_2008?lang=en

[193] Норвегийн Вант Улсын Үндсэн хууль (1814), https://www.constituteproject.org/constitution/Norway_2016?lang=en

[194] С.Нарангэрэл, Эрх зүйн эх толь бичиг /Dictionary of law/ (Уб, 2007), 462 дахь тал.

болон бусад холбооны хэрэгсэл төрийн хамгаалалтад байх бөгөөд бүрэн эрхээ хэрэгжүүлэх, үйл ажиллагаагаа явуулахтай холбогдсон захидал харилцааны нууцыг задруулахыг хориглоно. Улсын Их Хурлын гишүүнийг албадан саатуулах, цагдан хорих, түүнд шүүхийн журмаар захиргааны шийтгэл оногдуулах, гэр, албан өрөө, биед нь нэгжлэг хийхийг хориглоно гэх мэтээр хуульчилсан байдаг.[195]

Мөн гишүүний үндсэн ба тодорхой бүрэн эрхтэй түүний халдашгүй байдал буюу дархлааг хутган ойлгож болохгүй. Халдашгүй байдал нь /дархлаа/ нь гишүүний бүрэн эрхийг хангах хууль зүйн баталгааны нэг, хамгаалах онцгой хэрэглүүр юм. “Immunitas” (иммунитет) гэсэн латин гаралтай халдашгүй, халдварлашгүй гэсэн утгатай шинжлэх ухааны нэр томьёог дотоодын эрх зүйд “дархан эрх” буюу “дархлаа” гэдэг. Түүнийг Үндсэн хуульд “халдашгүй байдал” гэсэн утгаар хэрэглэжээ.[196] Энэ талаар Удирдлагын академаас хийсэн “Парламентын засаглалын үндсэн шинж” нийтлэг жишиг, Монголын онцлог судалгааны тайланд мөн дурдсан байна.[197]

Уг ойлголтын талаар Хөдөлмөрийн баатар, гавьяат хуульч Б.Чимид “Үндсэн хуулийн мэдлэг” бүтээлдээ “Чуулган хуралдаан таслах, парламентын үүрэг даалгавар тасалдуулж хариуцлага алдах, гишүүнд хориглосон ажил эрхлэх (Засгийн газрын гишүүн, ТББ-ын сонгуультаас бусад ажил хавсрах, бизнес эрхлэх, бусдаас шан харамж авах, эрх мэдлээ хувьд ашиглах гэх мэт) өндөр албаны нэр хүндэд харш ёс суртахууны гажуудал гаргах, дураар аашилж эрх, тушаалаа хэтрүүлэх гээд гэмт хэрэг үйлдэх хүртэл хууль, ёс зүй зөрчих аваас гэм буруудаа тохирсон зэм хохирол хүртэнэ. Үйлдсэн хэргээсээ хамааран дархлаагаа хасуулж ял хүлээх хүртэл хууль зүйн хариуцлага цаана нь байхыг дээр цухас дурдсан. Түүнээс гадна нэгэн өдрийн хуралдаанаас хөөгдөхөөс гишүүнийхээ мандатыг хасуулах (эргүүлэн татах) хүртэл улс төр-ёс зүйн шинж агуулсан сахилгын хариуцлага хүлээх үндэслэл журмыг тогтоосон орнууд байдаг. Орчин цагийн парламентат ёсыг нэвтрүүлэхийг зорьж гишүүд эрх дархыг бусдын нэгэн адил эдэлж байгаа болохоор хариуцлагыг нийтийн жишгээр ард түмнийхээ өмнө хүлээх нь бүрэн зүй ёсны шаардлага. Энэ нь “тэдний нэр хүнд, асар их үлгэр дууриалаас баг хорооны ИНХ-ын Тэргүүлэгчдээс эхлээд бүх сонгуультан, төрийн албан хаагчдын төрх төлөв шууд хамаардаг. Дууриамал хэвшил ноёрхсон манай оронд “УИХ-ын гишүүд төлөв хичээнгүй, төв шударга байвал төр түвшин байна.” [198] гэж дэлгэрэнгүй тэмдгэлжээ.

Ийнхүү тэдний нэр хүнд, үлгэр дууриалал олонд ил тод байхад халдашгүй байдал нь хувь хууль тогтоогчийг хууль тогтоох ажиллагаанд оролцохдоо бусдын нөлөөнд автахаас сэргийлж хамгаалахаар тогтоосон зүйл[199] байх бөгөөд хууль тогтоох байгууллагын гишүүнийг гаднын эрхшээлээс хамгаалснаар хууль тогтоох үйл ажиллагаанд хүний эрхийг бие даасан байдлаар хэрэгжүүлэх боломжтой болгож байдаг.[200]

Монгол Улсын эрдэмтэн, судлаачид хийгээд нэр томьёоны тайлбар тольд дээрх байдлаар тодорхойлон бичсэн бол бусад орны хувьд төрийн эрх барих дээд байгууллага гэсэн нэршлээр ямар байгууллагыг төлөөлүүлснийг 3 улсын жишээнээс авч үзье.

АНУ: Тус улсын Үндсэн хуулийн 6 дугаар хэсэгт “Сенатч болон төлөөлөгч нарт албан ажилд олгох нөхөн олговрыг хуулиар тогтоож Нэгдсэн Улсын сангаас гаргана.

[195] Г.Совд нар, Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар (Уб, 2000), 155 дахь тал.

[196] Б.Чимид, Үндсэн хуулийн мэдлэг (Уб, 2008), 214 дахь тал.

[197] Ч.Энхбаатар нар, “Парламентын засаглалын үндсэн шинж” нийтлэг жишиг, Монголын онцлог судалгааны тайлан, (Уб, 2018), 80 дахь тал.

[198] Мөн тэнд.

[199] Yankwich, Leon. “The Immunity of Congressional Speech--Its Origin, Meaning and Scope’,(1951).” University of Pennsylvania Law Review 99: 960.

[200] Мөн тэнд.

Үндэснийхээ эрх ашгаас урвах, хүнд гэмт хэрэг үйлдэх болон нийтийн дэг журам зөрчсөнөөс бусад тохиолдолд танхимынхаа чуулганд хуралдаж байх хугацаанд, эсвэл тэндээс буцах, очих үед тэднийг баривчилж үл болно. Тэд танхимууд дээр үг хэлэх, мөн санал шүүмжлэл гаргасныхаа төлөө хаана ч асуугдах ёсгүй."[201] гэж заасан нь сенатор болон төлөөлөгчдийн халдашгүй байдлыг баталгаажуулдаг байна.

ХБНГУ: Бундестагийн гишүүн хурал дээр хэлсэн үгийнхээ төлөө хариуцлага хүлээхгүй байх эрх, түүний халдашгүй байдлын талаар тус улсын Үндсэн хуулийн 46 дугаар зүйл (immunities of members)-д зохицуулсан байдаг. Тухайлбал, 1 дүгээр хэсэгт "Бундестагийн гишүүн саналаа өгсөн байдал, Бундестагийн чуулган болон аль нэг хорооны хуралдаан дээр хэлсэн үгийнхээ төлөө хуулийн болон захиргааны журмаар хариуцлага хүлээхгүй ба ямар ч тохиолдолд Бундестагаас гадна хариуцлагад татагдах ёсгүй. Энэ нь бусдыг гутгэсэн хэрэгт үйлчлэхгүй."[202], 2 дугаар хэсэгт "Бундестагийн гишүүнийг эрүүгийн хариуцлага хүлээх үйлдэл хийж байхад нь буюу үйлдсэнийх нь дараа хоногийн дотор баривчлахаас бусад тохиолдолд Бундестагийн гишүүнийг эрүүгийн хариуцлага хүлээх үйлдэл хийснийх нь төлөө гагцхүү Бундестагийн зөвшөөрснөөр хариуцлагад татах буюу баривчилж болно."[203], 3 дугаар зүйлд "Түүнчлэн Бундестагийн гишүүний хувийн эрх чөлөөг хөндсөн аливаа хязгаарлалт хийх буюу 18-р зүйлд заасны дагуу гишүүнтэй холбоотой ажиллагаанд Бундестагийн зөвшөөрөл авах шаардлагатай."[204], 4 дүгээр зүйлд "Бундестагийн гишүүнтэй холбоотой эрүүгийн байцаан шийтгэх аливаа ажиллагаа болон 18-р зүйлийн дагуу түр саатуулах, баривчлах ба хувийн эрх чөлөөг нь хязгаарлах аливаа арга хэмжээг Бундестагийн шаардлагаар зогсооно."[205] гэж тус тус заажээ.

БНХАУ: Тус улсын Үндсэн хуулийн 74 дүгээр зүйл (immunity)-д "Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Их Хурлын нэг ч төлөөлөгчийг Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Их Хурлын одоогийн хуралдааны Тэргүүлэгчдийн зөвшөөрөлгүйгээр, эсвэл Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Их Хурал хуралдаагүй байхад Байнгын хорооны зөвшөөрөлгүйгээр баривчлах, эрүүгийн шүүх хуралдаанд оруулахыг хориглоно"[206], 75 дугаар зүйл (indemnity)-д "Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Их Хурлын төлөөлөгчдийг хуралдаан дээр хэлсэн үг, өгсөн саналынх нь төлөө хуулийн хариуцлагад татахыг хориглоно"[207] гэж тус тус заасан нь төлөөлөгчийн халдашгүй байдлыг Үндсэн хуулиараа хамгаалсан гэж үзэж болохоор байна.

Монгол Улсын Үндсэн хуулийг Англи хэлнээ хөрвүүлэхдээ "халдашгүй байдал" гэдэг үгийг "immunity" гэсэн үгээр орлуулсан байна.

- Immunity (Халдашгүй байдал) - Black's Law Dictionary толь бичигт "хариуцлага, үүргийн ямарваа чөлөөлөлт"[208] гэж тодорхойлсон бол Merriam Webster толь бичигт (1) "бусадтай адилгүй шийтгэл эсвэл үүргээс чөлөөлөгдөх байдал"; (2) "хуулиар хүлээлгэсэн хариуцлага эсвэл үүргээс чөлөөлөгдөх байдал" [209]гэж тодорхойлжээ.

[201] "United States of America 1789 (rev. 1992)," ConstituteProject, 2020-09-16, https://www.constituteproject.org/constitution/United_States_of_America_1992?lang=en.

[202] "Germany's Constitution of 1949 with Amendments through 2012," ConstituteProject, 2020-09-16, https://www.constituteproject.org/constitution/German_Federal_Republic_2012.pdf.

[203] Мөн тэнд.

[204] Мөн тэнд.

[205] Мөн тэнд.

[206] "China (People's Republic of) 1982 (rev. 2018)," ConstituteProject, 2020-09-25, https://www.constituteproject.org/constitution/China_2018?lang=en

[207] Мөн тэнд.

[208] Gamer, Bryan A., Jeff Newman, and Tiger Jackson. "Black's Law Dictionary (Standard Ninth Edition)." (2009).

[209] Merriam Webster, s.v. "Power", 2020-09-11, https://www.merriam-webster.com/dictionary/immunity.

Дээрхээс дүгнэвэл, *гишүүний халдашгүй байдлыг* улс орнууд ихэвчлэн ойролцоо байлаар хууль тогтоомждоо тусгасан бөгөөд манай улсын хувьд гишүүний халдашгүй байдлыг хуулиар хамгаалахаар заасан бол АНУ-ын Үндсэн хуульд сенатор болон төлөөлөгчдийн халдашгүй байдлыг баталгаажуулсан шууд зохицуулалт байхгүй ч чуулганд хуралдаж байх хугацаанд, эсвэл тэндээс буцах, очих үед тэднийг баривчилж үл болох зэрэг зохицуулалтаар баталгаажуулсан байна. Харин ХБНГУ, БНХАУ Үндсэн хуулиар "гишүүн халдашгүй байна" хэмээн шууд зохицуулаагүй ч халдашгүй байдлыг баталгаажуулсан зохицуулалт тусгагдсан байна.

ДҮГНЭЛТ

Сүүлийн жилүүдэд хууль зүйн нэр томьёог судлах, цэгцлэх, жигдрүүлэх талаар эрдэмтэн, судлаачид нэлээд ажлыг хийж, судалгааны цөөнгүй бүтээл хэвлэгдэн гарчээ. Хууль зүйн үндэсний хүрээлэн ч мөн энэхүү ажилд хувь нэмрээ оруулах үүднээс хууль хууль зүйн нэр томьёоны судалгаа хийхээс гадна зарим байгууллагуудтай хамтран эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулж ирсэн.

Тус судалгааг шинжлэх ухааны хэд хэдэн арга зүйд тулгуурлан хийхийг оролдсон бөгөөд хууль зүйн болон хэл шинжлэлийн эрдэмтэн, судлаачдын бүтээлээс аль болох иш татахыг хичээлээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорьдугаар зүйлээс Хорин есдүгээр зүйлийн хүрээнд нийт 9 нэр томьёог сонгон авч судалгаа хийхээр хамрах хүрээгээ тогтоож, эдгээр нэр томьёог Монгол Улсын эрдэмтэн судлаачид, болон бусад улсын эрх зүйн толь бичиг хууль тогтоомжид ямар агуулгаар хэрхэн хэрэгжиж байгаа талаар судаллаа.

Судалгаанаас үзэхэд манай Үндсэн хуульд тусгасан нэр томьёог гадны зарим оронд ч ойролцоо утгаар тайлбарлан хэрлэж байгаа нь ажиглагдаж байна. Тухайлбал, "төрийн эрх барих дээд байгууллага" гэсэн нэр томьёог Монгол Улсын хувьд нийт ард түмний чөлөөт сонгуулиар мандатаа авч тэдгээрийг төлөөлөн үйл ажиллагаагаа явуулж төрийн бүрэн эрхийг хэрэгжүүлдэг байгууллага болох Улсын Их Хуралд хадгалагдах тухай зохицуулсан бол АНУ-ын Үндсэн хуульд зааснаар АНУ-ын хувьд Конгресс хэрэгжүүлдэг. Харин ХБНГУ-ын Үндсэн хуулиар Бундестаг нь хууль тогтоох эрх мэдлийг хадгалдаг гол байгууллага бөгөөд БНХАУ-ын Үндсэн хуулиар Ардын Их Хурал нь хууль тогтоох эрх мэдлийг хэрэгжүүлдэг байна. Хэдийгээр улс орон бүр төрийн эрх барих дээд байгууллагыг өөр өөрсдийн онцлогт нийцүүлэн нэрлэдэг ч нийтлэг утгаараа хууль тогтоох эрх мэдлийг хэрэгжүүлэх чиг үүргийг бүгд өөртөө агуулдаг байх юм.

Мөн "соёрхон батлах" хэмээх нэр томьёо нь олон улсын нийтийн эрх зүйн ухагдахуун бөгөөд дэлхийн улс орнуудын хувьд тогтсон (хэвшсэн) ойлголт төдийгүй өргөн хэмжээний утга агуулгатай нэр томьёо болох нь харагдаж байна.

Түүнчлэн дэлхийн улс орнуудын хувьд хэвшин тогтсон нэр томьёо Монгол Улсын хувьд харьцангуй бага судлагдаж нэгдсэн ойлголтод хүрээгүй, мөн ойлголтын зөрүүтэй зарим нэр томьёо байна гэж үзэж болохоор байна. Тухайлбал, "Үндсэн хуулийн дэг журам" хэмээх нэр томьёо нь манай улсын хувьд харьцангуй бага судлагдсан бөгөөд энэ үгтэй холбоотойгоор эрх зүйн эх сурвалжуудад тусгаж өгөөгүйгээс нэгдсэн ойлголт байхгүй байгаа нь харагдаж байна. Мөн "Хууль" хэмээх үг нь монгол хэлний үгийн санд орж ирсэн харь үг хэдий ч салаа утгагүй, нэг мөр тогтсон ойлголтоор хэрэгдэгдэж байна. Харин уг нэр томьёог бусад улсад өөр нэр томьёогоор хэрэглэгддэг болохыг судалгааны үндсэн хэсэгт дэлгэрүүлэн авч үзсэнээс гадна "нийтийн ашиг сонирхол" гэх нэр томьёог ХБНГУ, БНХАУ, Нидерланд улсуудын Үндсэн хуульд хувийн өмчийг хураан авахтай холбогдсон зохицуулалтад

Хууль зүйн Үндэсний хүрээлэн
www.legalinstitute.mn

оруулсан бол Норвегийн Үндсэн хуульд шүүх хуралдаан хаалттай явагдах үндэслэлд “нийтийн ашиг сонирхол”-той холбоотой байх үндэслэлд хамаарч байх жишээтэй. Харин хувийн өмчийг дайчлан авахтай холбоотой асуудлыг манай Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 3 дахь хэсэгт заахдаа “... нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн ...” гэж хуульчилсан байна. Иймд “Нийтийн ашиг сонирхол” хэмээх ойлголтын тухайд Монгол Улсын Үндсэн хуульд эвлэлдэн нэгдэх эрх, нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар УИХ хороо байгуулах зэрэг асуудалд тусгаснаараа ялгаатай юм.

Эцэст нь тэмдэглэхэд, Хөдөлмөрийн баатар, гавьяат хуульч Б.Чимид агсан “Үндсэн хуулийн үзэл баримтлал: нийтлэг асуудал” бүтээлдээ “...нэр томьёог зөв оноох, хэрэглэх нь чухал, нэр томьёог жигдрүүлэх ажлыг байнга хийх ёстой...” хэмээн тэмдгэлсэн байдаг, иймд аливаа нэр томьёо нь нийгмийн хөгжлөө дагаад хувьсан өөрчлөгдөх, шинээр бий болохыг үгүйсгэхгүй ч цаашид хууль зүйн нэр томьёог жигдлэх үүднээс нэр томьёоны хэрэглээ, орчуулгад баримтлах журам боловсруулах, хууль зүйн нэр томьёоны судалгаан дахь эрдэмтэн, судлаачдын оролцоог сайжруулах, эрдэмтэн, судлаачид тус тусдаа биш, нэгдэн нийлж хууль зүйн тайлбар толь бичиг гаргах, үүнийгээ тогтмол баяжуулж, сайжруулан ажиллах шаардлагатай.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

НОМ ЗҮЙ

Монгол Улсын хууль тогтоомж:

- Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн мэдээлэл эмхтгэл, №1, (1992)
- Монгол Улсын Их Хурлын тухай хууль, (2020)
- Онц байдлын тухай хууль, (1995)

Гадаад улсын хууль, тогтоомж

- Бразил Улсын Үндсэн хууль, (1988)
- Бүгд найрамдах Косова Улсын Үндсэн хууль, (2008)
- Болгар Улсын Үндсэн хууль, (1991)
- Исланд Улсын Үндсэн хууль, (2011)
- Испани Улсын Үндсэн хууль, (1978)
- Итали Улсын Үндсэн хууль, (1947)
- Польш Улсын Үндсэн хууль, (1997)
- Киргиз Улсын Үндсэн хууль, (2010)
- Литва Улсын Үндсэн хууль, (1992)
- ОХУ-ын Үндсэн хууль, (1993)
- ОХУ-ын Дээд шүүхийн тухай хууль, (2014)
- ХБНГУ-ын Үндсэн хууль, (2020)
- Франц Улсын Үндсэн хууль, (1958)
- Япон Улсын Үндсэн хууль, (2011)

Ном, өгүүлэл, нийтлэл:

- Б.Амарсанаа, Харьцуулсан эрх зүй судлал, (Уб, Хууль зүйн Үндэсний хүрээлэнгийн хэвлэх үйлдвэр, 2014)
- Ж.Амарсанаа, Англи-Орос-Герман-Монгол Олон улсын эрх зүйн толь, (Уб, 2004)
- Ж.Амарсанаа, Монгол Улсын Үндсэн хуульд орсон харь үг, (Уб, 2014)
- Ж.Амарсанаа нар, Хууль зүйн тайлбар толь (Уб, 2003)
- Ж.Амарсанаа, Монгол Улсын Үндсэн хууль 13 хэлээр (Уб, 2019)
- Ж.Амарсанаа нар, Англи-Солонгос-Монгол-Орос-Герман Хууль зүйн толь, (Уб, 2011)
- Б.Батсайхан, Хууль зүйн тайлбар толь (Уб, 2003)
- Д.Баярсайхан, Эрх зүйн онол, (Уб, 1996)
- Д.Баярсайхан, Эрх зүйн онол, (Уб, 2010)
- Ф.Бастиа, орч: Н.Баярбаатар, Хууль, (Уб, 2001)
- Ё.Бямбатогтох, Төр эрх зүйн онол, (Уб, 2010)
- Г.Гантөмөр, Г.Лхагвамаа, Уучлалын эрх зүйн зохицуулалтын асуудал, (Уб, 2009)
- Б.Ганболд, Эрх зүй судлал, (Уб, 2011)
- М.Дүгэрсүрэн, О.Хосбаяр, Дипломат ажиллагаа, дипломат албаны үндэс, (Уб, 1998)

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

- З. Жаргалмаа, Монгол-Орос, Орос-Монгол толь, (УБ, Адмон принт, 2007)
- Д.Лүндээжанцан, Монгол улс дахь Төрийн эрх мэдлийн хуваарилалт, (Уб, Адмон принт, 2014)
- Д.Лүндээжанцан, Л.Өлзийсайхан, Парламент ёс, (Уб, Адмон принт, 2002)
- Д.Лүндээжанцан, Хууль бүтээх ажиллагаа ба Хууль зүйн техник, (Уб, 2016)
- Д.Лүндээжанцан нар. Парламентат ёс, (Уб, 2005)
- Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь, (Уб, 2018)
- Монгол Улсын төрийн байгуулал дахь засаглалын институтын талаарх судалгаа, (Уб, 2018)
- М.Мөнхбат, Олон Улсын гэрээний эрх зүй, (Уб, 2017)
- С.Нарангэрэл, Эрх зүйн эх толь бичиг, анхны хэвлэл, (Уб, 2007)
- С.Нарангэрэл, Монголын эрх зүйн эх толь бичиг (англи, орос, латин хадмал) 4 дэх хэвлэл, (Уб, 2015)
- Нэгдсэн Үндэстний Байгууллага ба Монгол Улс, (Уб, 2008)
- Ч.Өнөрбаяр, Монгол Улсад үндсэн хуульт ёсны үзэл санаа нэвтэрсэн нь (1911-1924), (Уб, 2005)
- О.Өнөрцэцэг, Олон улсын эрх зүй, (Уб, 2003)
- Г.Совд, Үндсэн хуулийн тайлбар, (Уб, 2000)
- Д.Солонго, Төрийн эрх зүйн тайлбар толь, (Уб, 2003)
- Г.Төмөрчулуун. Даяар ертөнц: Монголын геополитик, дипломат ажиллагаа, (Уб, 2019)
- УИХ-н Тамгын газрын Судалгаа, шинжилгээ, хяналт үнэлгээний хэлтсийн Судалгаа, мэдээлэл, лавлагааны алба, “Монгол Улсын Үндсэн хуульд оруулах, нэмэлт, өөрчлөлтийн төсөлтэй холбоотой судалгаа, мэдээлэл, лавлагаа”, (Уб, GT Printing, 2017)
- Д.Ундралсайхан, Орчин үеийн олон улсын эрх зүй, (Уб, 2016)
- Я.Цэвэл, Монгол хэлний товч тайлбар толь (Уб, 1966)
- Б.Чимид, Үндсэн хуулийн үзэл баримтлал: нийтлэг асуудал, (Уб, 2004)
- Б.Чимид, Үндсэн хуулийн мэдлэг, (Уб, 2008)
- Ш.Чоймаа нар, Монгол хэлний хадмал толь (кирил- монгол- тайлбар), (Уб, 2011)
- Ш.Чоймаа нар. Монгол хэлний хэлзүйн толь бичиг, Тэргүүн боть, (Уб, 2006)
- А.Энхтуяа, С.Мөнхжаргал, Ц.Сарантуяа, Монгол-Орос- Герман Хууль зүйн товч толь, (Уб, 2013)
- English-Korean-Mongolian-Russian-German Legal dictionary, Англи-Солонгос-Монгол хууль зүйн толь, KLRI, (2011)
- Ч.Энхбаатар нар, “Парламентын засаглалын үндсэн шинж” нийтлэг жишиг, Монголын онцлог судалгааны тайлан, (Уб, 2018)

Гадаад хэл дээрх ном, өгүүлэл, нийтлэл.

- 42 Aaron Twerski, The Independent Doctrine of Ratification v. the Restatement and Mr. Seavey. Temple law quarterly (1968)
- Andreas Dьr, Nikitas Konstantinidis. International Treaty Ratification and Party Competition: Theory and Evidence from the EU’s Constitutional Treaty (2013)

Хуулбарыг үндэсний хурээлэн www.nlmgov.mn

- Burns H.Weston, International law, Thomson west (4th ed. 2006)
- Е. Бусол, Народная законодательная инициатива «народное вето» – разновидность отклоняющего референдума.
- Gamer, Bryan A., Jeff Newman, and Tiger Jackson, Black's Law Dictionary (9th ed. 2009)
- Henry Campbell Black, Black's law dictionary (5th ed. 2009)
- 1 Jean-Marie Henckaerts and Louise Doswald-Beck, Customary International Humanitarian Law (2009)
- Louise Mallinder Amnesties and Inclusive Political Settlements (2018)
- Michael A. Foster, Presidential Pardons: Overview and Selected Legal Issues Legislative Attorney January 14 (2020)
- Richard A. Nielsen and Beth A. Simmons. Rewards for Ratification: Payoffs for Participating in the International Human Rights Regime? International Studies Quarterly, (2015)
- Steven H.Gifis, Dictionary of Legal terms (3th ed. 1998)
- Б.А Страшун, Законодательная инициатива.
- Uta Oberdorster. Why Ratify? Lessons from Treaty Ratification Campaigns, Vanderbilt Law Review (2008)
- Yankwich, Leon, The Immunity of Congressional Speech-Its Origin, Meaning and Scope (1951) (University of Pennsylvania Law Review 99: 960)

Орчуулгын ном

- J.Amarsanaa, The Constitution of Mongolia by trans. Legal Academy, (Уб, Соёмбо принт 2020)
- The Constitution of Mongolia, National Human Rights Action Programme of Mongolia, (Уб, 2004)
- L.Dambadorj, The most up to date English–Russian–Mongolian dictionary, (Уб, 2016)

Цахим эх сурвалж:

- Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем, https://www.legalinfo.mn/
- Орос хэлний цахим толь бичиг, https://kartaslov.ru/
- Дэлхийн Үндсэн хуулиуд, https://www.constituteproject.org/
- Монгол хэлний тайлбар толь, https://mongoltoli.mn/dictionary/detail/121218
- Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн үзэл баримтлал, https://president.mn/10139/
- Мэргэжлийн түүхчдийн эмхэтгэсэн Оросын анхны интернет цахим хуудас, https://w.histrf.ru/articles/article/show/zakonodatielnaia_initsiativa
- Бүгд Найрамдах Киргиз улсад ард түмний хууль тогтоох санаачилгын талаарх хууль, http://cbd.minjust.gov.kg/act/view/ru-ru/203452,
- Латин-Англи толь бичиг, http://latin-dictionary.net/search/english/law
- Эрх зүйн толь бичиг, https://legal-dictionary.thefreedictionary.com/act
- Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь, http://toli.gov.mn/
- Allied Business Academies, https://www.abacademies.org/articles/The-legal-

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХУРЭЭЛЭН www.nli.gov.mn

status-of-treaty-international-agreement-and-ratification-in-the-indonesian-practice-within-the-framework-of-the-development-of-the-national-legal-system-1544-0044-21-2-180.pdf

- The Organization of American States, https://www.oas.org/legal/english/docs/Vienna%20Convention%20Treaties.html
- United Nations treaty collections, https://treaties.un.org/pages/viewdetails.aspx?src=treaty&mtdsg_no=iii3&chapter=3&lang= n
- Толь бичиг, https://www.dictionary.com/browse/ratification
- Толь бичиг, https://www.merriam-webster.com/dictionary/ratification
- Euoropean Parliament, https://www.europarl.europa.eu/RegData/etudes/BRIE/2016/593513/EPRS_BRI(2016)593513_EN.pdf
- Government of Netherlands, https://www.government.nl/topics/treaties/the-difference-between-signing-and-ratification
- Rastification Rules, https://scholar.harvard.edu/files/bsimmons/files/APP_3.2_Ratification_rules.pdf
- https://www.legal-tools.org/doc/233183/pdf/
- "Branches of the U.S. Government," USA Gov https://www.usa.gov/branches-of-government.
- "National Parliaments: Germany," Library of Congress, 2020-09-18, https://www.loc.gov/law/help/nationalparliaments/germany.php#:~:text=Germany%20is%20a%20federal%20republic,its%20inaugural%20meeting%20in%201949.
- "State Organs," http://za.chinaembassy.org/eng/zgjj/ssysz/spp/t244841.htm.
- "The Constitution of the United States," https://constitutionus.com/.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

КОМПАНИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ТУЛГАМДСАН АСУУДАЛ[210]

УДИРТГАЛ

Компани үүсгэн байгуулах, бүртгүүлэх, өөрчлөн байгуулах, компанийн удирдлага, зохион байгуулалт, хяналтын бүтэц, хувьцаа эзэмшигчийн эрх, үүргийг тогтоох, компани татан буулгахтай холбогдсон харилцааг зохицуулахаар 2011 онд Компанийн тухай хуулийг шинэчлэн баталсан. Ийнхүү 9 жилийн хугацаанд нийт 7 удаагийн нэмэлт, өөрчлөлтөөр 48 зүйл, заалтыг өөрчлөн найруулсан байна.

Мөн Компанийн хувьцааны хяналтын багцыг эзэмшигчид өөрсдийн болон нэгдмэл сонирхолтой этгээдүүдийн эрх ашигт нийцүүлэн шийдвэр гаргах, эрх хэмжээгээ хэтрүүлэн ашиглах үйлдлийг хязгаарлах, компанийн хэлбэр, нэгдлийн тухай ойлголтыг тодорхой болгох, толгой болон охин, хараат компанийн хоорондын харилцааг нарийвчлан зохицуулах, хуульд байгаа зөрчил, давхардлыг арилгах зорилгоор Монгол Улсын Их Хурлын 2017 оны 11 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн дагуу Компанийн тухай хуулийг шинэчлэн найруулахаар заажээ.

Энэхүү судалгааг ХЗДХЯ-ны захиалгаар “Компанийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах ажил эхэлсэнтэй холбогдуулан судалгааны ажлыг 2011 оны Компанийн тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойш өнөөг хүртэл хугацаанд эдийн засаг, эрх зүйн орчинд хэрхэн нөлөөлж, ямар эрх зүйн өөрчлөлт, шинэчлэлийг хийх шаардлагыг бий болгосон, цаашид буюу Ковид-19-тэй холбоотойгоор эдийн засгийн эрх зүйн орчинд ямар өөрчлөлт хийх бодит шаардлага бий болж буйг дүгнэн, санал боловсруулах юм.

Компанийн тухай хуулийн хөгжил, дэвшил, 2011 оноос хойш өнөөг хүртэл хугацаанд Монгол Улсын эдийн засаг, эрх зүйн орчин хэрхэн өөрчлөгдсөн тухай, гадаадын зарим орны Компанийн тухай хуулийн хэрэгжилтэд тулгамдсан зарим асуудлыг харьцуулан Компанийн тухай эрх зүйн зохицуулалтын хэрэгжилтэд тулгамдсан зарим асуудлыг тодорхойлон цаашид ямар өөрчлөлт хийх бодит шаардлага бий болж буйг дүгнэн, санал боловсруулсан байна.

Судалгааны хүрээг тогтоохдоо Компанийн тухай хуулийн хэрэгжилтэд тулгамдсан зарим асуудлыг тодорхойлон, цаашид хэрхэн өөрчлөн шинэчлэх тухай санал дэвшүүлнэ. Энэхүү судалгааны явцад гарч болох хүндрэл, бэрхшээл түүнийг шийдвэрлэх арга замын талаарх эрдэмтэн, судлаачдын санал, шүүмжлэл, зөвлөмж, эрдэм шинжилгээний хурлын илтгэл, энэ чиглэлээр хийгдсэн судалгааны бүтээл, мэргэжилтнүүдийн ярилцлага зэргийг харгалзан үзсэн болно.

НЭГ. МОНГОЛ УЛСЫН КОМПАНИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ТУЛГАМДСАН АСУУДАЛ

1.1 Компанийн тухай хуулийн өнөөгийн байдал

Нэг улс төрийн дэглэмээс нөгөө улс төрийн дэглэмд шилжсэний дараа буюу 1990 оноос хойш Монгол Улсын эрх зүйн харилцаанд “компани” хэмээх нэр томьёог бүрэн утгаар нь анх хэрэглэжээ.

Энэхүү судалгааны хүрээнд өнөөгийн Компанийн тухай хуулийг гол объект болгохын зэрэгцээ тус хуулиас өмнө үйлчилж байсан хуулиудыг цухас авч үзэх нь зүйтэй. 1990 оноос хойш Компанийн эрх зүйн харилцааг зохицуулж байсан хуулиудыг он дараалаар авч үзвэл:

[210] Энэхүү үнэлгээг ХЗҮХ-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга, хууль зүйн доктор П.Амаржаргал удирдан, Эрдэм шинжилгээний ажилтан Э.Уянга, Г.Сувд-Эрдэнэ, С.Цэрэндолгор нар хамтран гүйцэтгэв.

- 1990 оны “Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль”[211]
- 1991 оны “Аж, ахуйн нэгжийн тухай хууль”[212]
- 1995 оны “Нөхөрлөл, компанийн тухай хууль”[213]
- 1999 оны “Компанийн тухай хууль”[214] юм. Дурдсан хуулиудыг баталснаар компанийн эрх зүйн харилцааг боловсронгуй болгох оролдлогыг тухай бүрд нь үе шаттай хийсээр өнөөдрийн үйлчилж буй “Компанийн тухай хууль”[215]-ийг 2011 онд баталжээ.

КтХ-ийн тулгамдсан асуудлыг тодорхойлохоос өмнө одоогийн хууль болон 1999 оны КтХ-ийг харьцуулан үзсэн бөгөөд агуулгын хувьд нүсэр өөрчлөлт ороогүй байх боловч хэлбэрийн хувьд, түүнчлэн тодруулах шаардлагатай асуудлыг тодруулж, засах шаардлагатай нэр томьёог зөвтгөснөөр орчин үеийн компанийн засаглалд нийцэхүйц зохицуулалт бүхий хууль болсон гэж үзэж болох юм. Тэдгээр сайн зохицуулалтаас жишээ болгож, бүгдийг нь нуршихгүйн үүднээс цөөхнийг дурдъя.

1999 оны КтХ	2011 оны КтХ
“Хувь нийлүүлэгчдийн хурал” гэсэн нэршил байсан.	“Хувьцаа эзэмшигчдийн хурал” гэж хуульчилсан нь хэлбэр болоод агуулгын хувьд оновчтой болсон.
“Нэгдмэл сонирхолтой этгээд”-д гэр бүлийн гишүүн, эхнэр, нөхөр, эцэг эх, хамт амьдардаг 18-аас доош насны хүүхэд зэрэг хамаарч, бусад хамаатан, садан ордоггүй байсан буюу арай явцуу зохицуулалттай байсан.	Тус хуульд өмнөх зохицуулалтыг өргөжүүлэн “ач, зээ нар ах дүү, бусад төрөл, садангийн хүн”-ийг “нэгдмэл сонирхолтой этгээд”-д хамааруулахаар тодорхой заажээ.
Тус хуульд “хараат бус гишүүн” гэсэн ойлголт байх боловч тоог нь тодорхой заагаагүй, хэт ерөнхий зохицуулалттай байжээ.	Одоогийн хуульд ТУЗ-ийн гишүүдийн гуравны нэгээс доошгүй хувь нь хараат бус гишүүн байхаар тодотгож өгсөн нь компанийн засаглалд нийцэх оновчтой зохицуулалт болсон байна.
Мөн 2011 оны КтХ-ийн 83 дугаар зүйлийн 83.4 дэх хэсэгт “Компанийн гүйцэтгэх удирдлагыг хэрэгжүүлэгч этгээд нь төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн байж болох бөгөөд төлөөлөн удирдах зөвлөлийн дарга байхыг хориглоно” гэж заасан нь “... компанийн сайн засаглалын чиглэлээр манай орны хийсэн томоохон алхмын нэг юм. Өнөөдөр дэлхийд сайн засаглалын хувьд энэ албан тушаалыг салгахыг зөвлөдөг.”[216]	
2011 оны КтХ—ийн 6 дугаар зүйлийн 6.14-т “Толгой компани, түүнтэй энэ хуулийн 6.1, 6.3, 6.8-д заасан хамаарал бүхий компаниуд, нэг этгээд дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран хувьцааных нь хяналтын багцыг эзэмшдэг, эсхүл компанийн удирдлагын шийдвэрийг нь тодорхойлох боломжтой компаниудыг компанийн нэгдэл гэнэ”, мөн зүйлийн 6.15-т “Нэг толгой компанийн хараат болон охин компаниуд, эсхүл нэг этгээд дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран хувьцааных нь хяналтын багцыг эзэмшдэг компаниудыг зэргэлдээ компани гэнэ” гэж тус тус заасан. Эдгээр нь шинээр хуульчлагдсан бөгөөд хэдийгээр нарийвчлах шаардлагатай ч орчин үеийн компанийн засаглалд нийцэхүйц шинэлэг зохицуулалт болсон.	

[211] “Тус хуульд анх удаа хувийн өмчийг хүлээн зөвшөөрч, иргэд хувьдаа өмчтэй байх эрхтэйг хуульчлан баталгаажуулсан” - М.Төрбаяр “Үнэт цаасны зах зээлийн эрх зүйн зохицуулалтын өнөөгийн байдал”, *Үнэт цаас, хөрөнгийн зах зээл бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ, эдийн засгийн өсөлт илтгэлийн эмхэтгэл* (УБ: ХЗҮТ, 2006): 38 дахь тал.

[212] “Тус хуульд анх удаа “компани” гэх нэршлийг тусгаж, түүний тодорхойлолтыг хуульчилсан” – Хууль зүйн үндэсний төв, Германы хамтын ажиллагааны нийгэмлэг, *Компанийн эрх зүйн асуудал* (УБ. ХЗҮТ, 2003), 10 дахь тал /дам эшлэв/

[213] Тус хуульд дүрмийн сангийн доод хэмжээний хувийг өмнөх хуулиас өсгөсөн бөгөөд бусад зохицуулалтын хувьд өмнөх хуультай ерөнхийдөө адил.

[214] Тус хуулийг 1997 онд УИХ Соросын сангийн шугамаар хамтарсан төсөл хэрэгжүүлж, Колумбын их сургууль-ийн ... профессор Блэк болон Краакман-ийн компанийн жишиг загварт (A Self Enforcing Model of Corporate Law) үндэслэн боловсруулахыг зорьжээ. – Г.Даваанням, *Морал хазардын асуудлаас үүдэх толгой компанийн хариуцлага* (УБ: Адмон принт, 2020), 29 дэх тал.

[215] *Төрийн мэдээлэл* эмхэтгэл (2011), №42

[216] Д.Байлыхүү, Компанийн төлөөлөн удирдах зөвлөл (Адмон принт, Уб., 2016 он.), 31 дэх тал

1.2. Компанийн эрх зүйн зохицуулалт

КтХ нь 2011 онд батлагдан хэрэгжсэнээс хойш даруй 9 жилийн турш тус салбарын харилцааг зохицуулах эрх зүйн гол эх сурвалж байж иржээ. Компанийн эрх зүйн харилцааг тус хуулиас гадна хууль зүйн салбар бүрийг зохицуулсан нийт 9572 эрх зүйн акт эрх зүйн мэдээллийн нэгдсэн системийн хүрээнд үйлчилж[217] байгаагаас шууд холбогдох дараах эрх зүйн актууд хүчин төгөлдөр үйлчилж байна:

Монгол Улсын хууль 72 *(хавсралт 1)*

Улсын Их Хурлын тогтоол 34

Монгол Улсын олон улсын гэрээ 12

Ерөнхийлөгчийн зарлиг 1

Үндсэн хуулийн цэцийн шийдвэр 36

Улсын дээд шүүхийн тогтоол 11

Засгийн газрын тогтоол 270

Сайдын тушаал 27

Засгийн газрын агентлагийн даргын тушаал 2

УИХ-аас томилогддог байгууллагын дарга, түүнтэй адилтгах албан тушаалтны шийдвэр 3

Аймаг, нийслэлийн Засаг даргын захирамж 1

Зөвлөл, хороо, бусад байгууллага 14

Эдгээр эрх зүйн актаас "Иргэний хууль"[218], "Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль"[219], "Үнэт цаасны зах зээлийн тухай хууль"[220], "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль"[221] зэрэг холбогдох хууль, тэдгээрт хамаарах эрх зүйн актуудаар голчлон зохицуулдаг хэдий ч өөр хоорондоо уялдаагүй, алдаатай зохицуулалт нэлээдгүй байна. Тухайлбал: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 5 дугаар зүйл, 14 дүгээр зүйл, 21 дүгээр зүйлд Нөхөрлөл, компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 35 дугаар зүйл, 91 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу хэмээн хүчингүй хуулийн заалт эшлэсэн.

Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2-т заасан "Даатгалын компанид Компанийн тухай хуулийн 45 дугаар зүйл хамаарахгүй" гэж 1999 оны Компанийн тухай хуулийг эшлэсэн, Банкны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.10.банкны хянан шалгагч /хянан шалгах зөвлөл/-ийн асуудлыг Компанийн тухай хуулийн 92 дугаар зүйлийн дагуу зохицуулах талаар заасан нь одоо хүчин төгөлдөр үйлчилж буй хуультай нийцэхгүй байна.

Судалгааны гол объект нь КтХ болохын хувьд шаардлагатайгаас бусад тохиолдолд дээр дурдсан хуулиудын агуулга руу хэт орохоос зайлсхийсэн бөгөөд КтХ-ийн тодорхой зохицуулалт болон практик хоорондын уялдааг тодруулах замаар тулгамдсан асуудлыг гаргаж, шийдэл эрэлхийлэхийг зорив. Ингэхдээ хуулийг бүхэлд нь тайлбарлах илүүц бөгөөд энэ талаарх танилцуулга, ном, гарын авлага хангалттай байх тул онцлог цөөн зохицуулалтыг сонгон авлаа.

- *Хувьцаатай холбоотой зохицуулалт*

Хувьцаатай холбоотой эрх зүйн харилцааг "Үнэт цаасны зах зээлийн тухай

[217] Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ. /ХЗҮХ-ийн судалгааны тайлан. 2018 он./ http://nli.gov.mn/?p=4961 (сүүлд үзсэн 2019.10.25)

[218] *Төрийн мэдээлэл* эмхэтгэл (2002), №7

[219] *Төрийн мэдээлэл* эмхэтгэл (2018), №30

[220] *Төрийн мэдээлэл* эмхэтгэл (2013), №24

[221] *Төрийн мэдээлэл* эмхэтгэл (2010), №20

Хуулийн электронний хүрээлэн www.nli.gov.mn

хууль”-иар нарийвчлан хуульчилсан. Иймд КтХ-ийн бусад эрх зүйн зохицуулалтыг бодвол харьцангуй тодорхой зохицуулалттай. Гэвч КтХ-ийн 33 дугаар зүйлийн 33.1-д “Компанийн энгийн болон давуу эрхийн хувьцааны тоог компанийн дүрмээр тогтоох бөгөөд үүнийг зарласан хувьцаа гэнэ” гэж зааснаас үзвэл манай хуульд давуу эрхийн хувьцааны тоог тогтоосон, хязгаарласан зүйлгүй байна.

“... Зарим улсад гаргасан нийт хувьцаанд ноогдох давуу эрхийн хувьцааны тоог түүний дээд хэмжээг тогтоон өгөх замаар хязгаарлаж өгсөн байдаг ба үүний шалтгаан нь энгийн хувьцаагаар оруулсан хөрөнгө оруулалтыг их байлгах бодлогыг дэлхий нийтээрээ баримталдагтай холбоотой.”[222]

Мөн 2017 оны байдлаар давуу эрхийн хувьцаа гаргасан компани бараг байхгүй байна[223]. Харин 2012 онд “Эрдэнэс Монгол” ХХК давуу эрхийн хувьцааг Монгол Улсын нийт иргэнд эзэмшүүлэхээр гаргаж байжээ.

Иймд энгийн хувьцаанд ноогдох давуу эрхийн хувьцааны тооны дээд хэмжээг тогтоох, давуу эрхийн хувьцаатай холбоотой зохицуулалтын хэрэгжилтийг эрчимжүүлэх нь зүйтэй.

- *Хувьцаа эзэмшигчийн эрхтэй холбоотой зохицуулалтууд*

КтХ-ийг үзвэл, төр нь компанийн эрх зүйн харилцаанд төрийн захиргааны байгууллагын хувиар болон хувьцаа эзэмшигчийн хувиар гэх хоёр төрлөөр оролцох боломжтой байна.

Гэтэл манай өнөөгийн практикт төрийн байгууллагаас төрийн эзэмшилд байгаа хувьцааг төлөөлж эзэмшигчийн хувьд гаргаж байгаа шийдвэр нь тухайн төрийн байгууллагын шууд нэрээр гарч байгаа нь уг шийдвэр хууль зүйн хувьд хүчин төгөлдөр бус болоход хүргэж байна.[224]

ЭЗХАХБ-аас гаргасан “Төрийн өмчит компанийн засаглалын гарын авлага”[225]-д “Төр нь бусад хувьцаа эзэмшигчтэй адил эрх эдлэх бөгөөд хувьцаа эзэмшигчийн эрхээ төрийн захиргааны эрхээс тусдаа хэрэгжүүлэх нь зүйтэй” гэжээ. Иймд хувьцаа эзэмшигчийн хувьд эдлэх эрхийн хүрээнд “Төрийн эзэмшилд байгаа хувьцааг төлөөлөн эзэмшигч” гэсэн тодотголыг тухайн төрийн байгууллагын өмнө оруулж байх нь хэлбэрийн хувьд зохимжтой.

Санхүүгийн хэрэгслийг амьдралд ашиглахад эзэмшигч этгээдүүдийн эдлэх эрхийг хамгаалах асуудал хамгийн чухал. Энэхүү эрхийн хамгаалалт хангалтгүй бол хувьцаа болон бусад үнэт цаас ямар ч үнэ цэнэгүй хий хоосон цаас болно. Иймээс хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалах асуудлыг компанийн засаглалын нэг чухал бүрэлдэхүүн хэсэг болгон тусгайлан авч үздэг.[226]

Компанийн багц хувьцаа эзэмшигчдийн эдлэх эрхийн хувьд: энгийн хувьцааны 10-аас дээш хувийг эзэмшигч нь компанийн аж ахуй, санхүүгийн үйл ажиллагаанд аудитын шалгалт хийлгэх эрхтэй[227] бол жижиг буюу энгийн хувьцаа эзэмшигчид тийм эрх байхгүй байна.

---

222 Д.Байлыхүү. *Хувьцаа болон хувьцаа эзэмшигчийн эрх, түүний хэрэгжүүлэлт* (Адмон принт, Уб., 2017 он.),19 дэх тал.

223 Мөн тэнд.

224 Д.Байлыхүү. *Хувьцаа болон хувьцаа эзэмшигчийн эрх, түүний хэрэгжүүлэлт* (Адмон принт, Уб., 2017 он.), 52 дахь тал.

225 The OECD, *Guidelines on Corporate Governance of State-Owned Enterprises* (Paris: OECD Publishing, 2015), http://dx.doi.org/10.1787/9789264244160-en

226 Д.Байлыхүү. *Хувьцаа болон хувьцаа эзэмшигчийн эрх, түүний хэрэгжүүлэлт* (Адмон принт, Уб., 2017 он.),3 дахь тал

227 Мөн тэнд, 30 дахь тал.

ЭЗХАХБ-аас гаргасан “Компанийн засаглалын зарчим”[228]-д “Жижиг хувьцаа эзэмшигчид нь хувьцааны хяналтын багцыг эзэмшиж байгаа этгээдээс шууд буюу шууд бусаар үзүүлж болох аливаа дарамт, эсхүл ашиг сонирхлоо хамгаалсан үйлдлээс хамгаалагдсан байх ба эрх нь зөрчигдсөн тохиолдолд зөрчигдсөн эрхийг нь сэргээх үр дүнтэй арга замаар хангагдсан байна” гэжээ. Мөн, КтХ-д ХХК-г ХК болгон өөрчлөхөд хувьцааны талаар зохицуулсан боловч ХК-г ХХК болгоход хувьцааг хэрхэх, ялангуяа жижиг хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрхэн хамгаалах талаар хуульчлаагүй байна. Иймд жижиг хувьцаа эзэмшигчийн эрхийг хамгаалсан зохицуулалтыг нарийвчлах нь зүйтэй.

- *Хувьцаа эзэмшигчдийн хуралтай холбоотой зохицуулалтууд*

КтХ-ийн 10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсэгт “Компанийн оршин байгаа газар, шуудангийн хаягийг түүний ерөнхий захиргаа байршин байгаа газраар тодорхойлно”, 65 дугаар зүйлийн 65.4 дэх хэсэгт “Хувьцаа эзэмшигчдийн хурлын зард компанийн оноосон нэр, байршил, хурал хийх өдөр, цаг, газар, ... бусад мэдээллийг тусгасан байна” гэж тус тус заажээ.

Дээрх заалтуудаас үзвэл, Хувьцаа эзэмшигчдийн хурал хийх байршлыг хатуу тогтоогоогүй боловч компанийн ерөнхий захиргаа байгаа газрыг компанийн оршин байгаа газраар тодорхойлох тул хурал компанийн ерөнхий захиргаа буюу төв байр байгаа газар болохоор ойлгогдож байна. Үүний дагуу практикт ихэвчлэн “... компанийн төв байранд хийхээр зарласан байдаг боловч байрны зай, байршил болон хувьцаа эзэмшигчдийн тооноос хамаарч өөр газар хийх тохиолдол ч гардаг. Ямар ч тохиолдолд хурал болох газрыг сонгохдоо хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн зүгээс аль болох бага зардал гаргах, олон хувьцаа эзэмшигч оролцох бололцоог хангах, мөн хурал болох газрын байршил, хаяг нь хүмүүст ойлгомжтой, олж очиход хялбар байх, нийтийн тээврийн хэрэгсэл үйлчилдэг байх зэрэг асуудлыг анхаарах ёстой.”[229]

Хувьцаа эзэмшигчдийн хурлын байртай холбоотойгоор КтХ-ийн 65 дугаар зүйлийн 65.8 дахь хэсэгт “Компани нь хувьцаа эзэмшигчдийг хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдах байранд орох бололцоог хангах үүрэгтэй” гэж заасан. Сүүлийн үед Монгол Улсад олон давхар, дундын оффис бүхий барилга байгууламжийн тоо нэмэгдэж буй бөгөөд зарим тохиолдолд нэвтрэхэд шаардлага тавигдах болсонтой холбогдуулан ийм барилгад хурал зарлах бол хувьцаа эзэмшигчдийг хурал болох өрөө, танхимд саадгүй нэвтрэн орох бололцоог хангах нь компанийн үүрэг юм.

КтХ-ийн 65 дугаар зүйлийн 65.3 дахь хэсэгт “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журмыг Санхүүгийн зохицуулах хороо тогтооно” гэсэн байх бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 377 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”[230]-д хурлын зар хүргэх ажиллагааг дэлгэрэнгүй журамласан байх бөгөөд өдөр тутмын сонин, орон даяар нэвтрүүлгээ түгээдэг телевиз, радио, компани өөрийн болон арилжаа эрхлэх байгууллагын цахим хуудас, утас, факс, электрон шуудан зэрэг бүхий л төрлийн аргыг хэрэглэж болохоор зохицуулсан байгаа нь сайн хэрэг. Гэвч эдгээрээс цахим хуудсаар түгээх нь хамгийн зардал багатай, цаг үеийн аливаа нөхцөл байдалд хэрэглэж болохуйц арга байх тул цахимаар хурлын зарыг хүргэх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагатай юм.

---

[228] G20/OECD, *Principles of Corporate Governance* (Paris: OECD Publishing, 2015), p.26. http://dx.doi.org/10.1787/9789264236882-en (Тус баримт бичгийг ЭЗХАХБ болон “Их Хорь” хамтран 2015 онд шинэчлэн баталсан бөгөөд 2019 онд нэмэлт, өөрчлөлт оруулсан байна)

[229] Д.Байлыхүү, *Хувьцаа эзэмшигчдийн хурал* (Адмон принт, Уб., 2016 он.),35 дахь тал

[230] СЗХ-ны 2018 оны 12 сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолын хавсралт “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”, https://www.legalinfo.mn/annex/details/8870?lawid=13845

КтХ-ийн 83 дугаар зүйлийн 83.8 дахь хэсэгт “Гүйцэтгэх удирдлага нь төлөөлөн удирдах зөвлөлөөс олгосон эрх хэмжээний хүрээнд хэлцэл хийх, гэрээ байгуулах, компанийг төлөөлөх зэргээр компанийн нэрийн өмнөөс итгэмжлэлгүйгээр үйл ажиллагаа явуулна” гэж зааснаас үзвэл итгэмжлэлгүйгээр төлөөлөх этгээд нь гүйцэтгэх удирдлага байх боловч мөн хуулийн 90 дүгээр зүйлийн 90.2-т “компанийг төлөөлөх эрх бүий албан тушаалтан” гэсэн нэр томьёо бий.

Харин КтХ-ийн 84 дүгээр зүйлийн 84.1-д “Компанийн төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын багийн гишүүн, гүйцэтгэх захирал, санхүүгийн албаны дарга, ерөнхий нягтлан бодогч, ерөнхий мэргэжилтэн, төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга зэрэг компанийн албан ёсны шийдвэрийг гаргахад болон гэрээ, хэлцэл хийхэд шууд болон шууд бусаар оролцдог этгээдийг компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцно” гэжээ.

Эндээс, компанийг төлөөлөх эрх бүхий албан тушаалтан гэдэгт гагцхүү гүйцэтгэх удирдлага орох уу, эсвэл компанийн эрх бүхий албан тушаалтнууд давхар хамаарах уу гэдэг асуудал урган гарна. Хэрэв компанийн эрх бүхий албан тушаалтнууд хамаарах бол тэдний итгэмжлэлийн асуудал хэрхэх талаар тодорхойгүй байна.

Дээрх асуудалтай холбогдон гарсан шүүхийн маргааныг[231] товч дурдвал: “Т” банк бэлэн мөнгөний машин (АТМ)-аа “ТНИ” ХХК-ийн байранд байрлуулдаг бөгөөд Олон Улсын хурал зохиохтой холбоотойгоор ХХК-ийн зүгээс “Т” банкинд машиныг шилжүүлэн байршуулах хүсэлтийг хүргүүлсэн. Гэтэл “Т” банкны төв салбараас хариу өгөөгүй бөгөөд тухайн компанийн байранд байрладаг “Т” банкны салбарын захирал банкныхаа өмнөөс хэлцэл хийж, шилжүүлэн байршуулахад холбогдох төлбөрийг “ТНИ” ХХК-аас гаргуулж, машиныг шилжүүлэн байршуулжээ. Ажил дуусаны дараа “ТНИ” ХХК ажлын хөлсийг “Т” банкнаас нэхэмжилсэн боловч удирдлага солигдсон шалтгаанаар өгөхгүй байсан тул шүүхэд ханджээ. Харин хариуцагч “Т” банкны зүгээс салбарын захирлыг банкийг төлөөлөх эрх бүхий этгээд биш гэж маргасан байна.

Шүүх шийдвэртээ “... хэдийгээр “Т банк” ХХК-ийн ... салбарын захирал нь гэрээ байгуулах эрхгүй талаар ... журамд заасан ч Иргэний хуулийн 53 дугаар зүйлийн 53.1.-д “Эрх олгогдоогүй этгээдийн хийсэн үйлдлийг эрх бүхий этгээд хожим дэмжин зөвшөөрсөн бол уг үйлдлийг хүчин төгөлдөр гэж үзнэ” гэж заасны дагуу ... салбарын захирлын байгуулсан ажил гүйцэтгэх гэрээг хожим дэмжин зөвшөөрсөн, хүчин төгөлдөр хэлцэл гэж үзнэ” гэжээ. Өөрөөр хэлбэл, “Т” банкны төв салбар нь салбарын захирлынхаа үйлдлийг хожим дэмжин зөвшөөрсөн буюу бэлэн мөнгөний машиныг шилжүүлэн байршуулсан болон ажлын хөлсний тухайд маргаан гаргаагүй тул салбарын захирлын банкаа төлөөлөн хийсэн хэлцэл нь хүчин төгөлдөр гэж шийдвэрлэжээ.

“Банкны тухай хууль”[232]-ийн 3 дугаар зүйлийн 3.1.13-т “банкны нэгж” гэж банкны салбар, төлөөлөгчийн газар, тооцооны төв, тооцооны касс зэрэг хуулийн этгээдийн эрхгүй байгууллагыг” ойлгохоор заасан байх тул салбарын захирал нь аливаа харилцаанд банкийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх этгээд биш байх боловч дээрх тохиолдолд үйлдэл нь хүчин төгөлдөр байна.

Энэ талаар холбогдох судалгаанд “Манай улсын хувьд ихэнх тохиолдолд зөвхөн гүйцэтгэх захирлыг л итгэмжлэлгүйгээр төлөөлөх бүрэн эрхтэй этгээд гэж тайлбарлах байдлаар бусад этгээдийн бүрэн эрхийг ерөнхий байдлаар бус тусгайлсан байдлаар зохицуулах нь түгээмэл байна. Гэтэл эдгээр захирал,

[231] Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2018.04.04-ний өдрийн 649 дугаар шүүхийн шийдвэрээс маргааны талаар дэлгэрэнгүй үзнэ үү. http://new.shuukh.mn/irgenanhan/74995/view (Сүүлд үзсэн: 2020.08.05)

[232] *Төрийн мэдээлэл* эмхэтгэл (2010), №7

менежер, дарга гэх мэт албан тушаалтай этгээд нь бусадтай гэрээ байгуулах, хэлцэл хийх тохиолдолд тэдгээрийн төлөөлөх бүрэн эрхийг тодорхойлоогүйгээс гуравдагч этгээд төдийгүй, үүнээс үүдэн арилжаа, бизнесийн үйл ажиллагааны тогтвортой, түргэн шуурхай явагдах, найдвартай байдал хангагдах явдалд тодорхой хүндрэл учирч байна[233]" гэснийг анзаарч, компанийг төлөөлөх этгээдийн эрх зүйн зохицуулалтыг илүү тодорхой, боловсронгуй болгох нь зүйтэй.

КтХ-ийн 78 дугаар зүйлийн 78.1 дэх хэсэгт "Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол төлөөлөн удирдах зөвлөлийн даргыг төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн дотроос нийт гишүүний олонхийн саналаар сонгоно" гэж заасан боловч "... манай зарим компани ялангуяа нэг хувьцаа эзэмшигчтэй компанид ТУЗ-ийн даргыг ХЭХ-ын бүрэн эрхийг хэрэгжүүлэгч этгээд нь ТУЗ-ийн гишүүдээс гадна шууд томилсон тохиолдол гарч"[234] байжээ. Иймд ХЭХ нь хуулиар олгогдсон чиг үүргийн хүрээнд шийдвэр гаргах, хүрээнээс халихгүй байхад хуулийн хэрэгжилтийг сайжруулах шаардлагатай байна.

КтХ-ийн 65 дугаар зүйлийн 65.6-д "Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдах үед хувьцаа эзэмшигчид дараах баримт бичигтэй танилцах бололцоог олгоно: 65.6.6.компанийн төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын зардал, цалин, урамшуулал" гэж заасан. Энэ заалттай холбоотой нэг зүйлийг дурдах нь зүйтэй.

ТУЗ нь ажлын тайлангаа жилд нэгээс доошгүй удаа ХЭХ-д тайлагнах үүрэгтэй. Ялангуяа хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд ТУЗ тухайн жилд өөрийн хийсэн ажлын тайлангаа заавал танилцуулж дүгнэлт гаргуулах нь компанийн үйл ажиллагаанд тустай. "Манай ихэнх компанид компанийн жилийн тайланг танилцуулсныгаа ТУЗ тайлангаа тавьсан мэт ойлгодог. Компанийн үйл ажиллагааны тайлан бол ТУЗ-ийн өөрийнх нь хийсэн ажлын тайлан биш юм. ... Энэхүү тайланд ТУЗ-ийн хурал, түүгээр хэлэлцэн шийдвэрлэсэн асуудал, хороодын ажиллагаа, гишүүдийн оролцоо, ТУЗ өөрийн ажлыг үнэлж дүгнэсэн дүгнэлт зэргийг тусгасан байвал зохино."[235] Иймд ТУЗ нь дээр дурдсан зардал, цалин, урамшууллаас гадна үйл ажиллагааны дэлгэрэнгүй тайлангаа ХЭХ-д танилцуулж байхыг тодорхой хуульчлах буюу компанийн дүрэмд зохицуулах нь ТУЗ-ийн үйл ажиллагааг сайжруулах алхам болох юм.

- *Төлөөлөн удирдах зөвлөлтэй холбоотой зохицуулалтууд*

КтХ-ийн 75 дугаар зүйлийн 75.4 дэх хэсэгт "Хувьцаат компани болон төрийн өмчийн компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь ес буюу түүнээс дээш гишүүнтэй байх ба тэдгээрийн гуравны нэгээс доошгүй хувь нь хараат бус гишүүн байна", мөн хуулийн 81 дүгээр зүйлийн 81.5-д "Энэ хуулийн 81.2-т заасан нэр дэвшүүлэх хороо нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 81.5.7.энэ хуулийн 59.5-д заасан үндэслэлээр төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрх нь дуусгавар болсноос хойш гурван жилийн хугацаанд тухайн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн байсан этгээдийн нэрийг аливаа хувьцаат компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд дэвшүүлэхээс татгалзах" гэж тус тус заажээ.

Дээрх зохицуулалтууд нь компанийн сайн засаглалд нийцэхүйц зохицуулалт мөн бөгөөд гагцхүү практикт хэрэгжүүлэх тал дээр компанийн ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх хороо өндөр ач холбогдол өгөх шаардлагатай юм. Учир нь "Гүйцэтгэх удирдлага нь ТУЗ-д ажлаа тайлагнадагтай холбогдуулан компанийн Гүйцэтгэх удирдлага, ТУЗ хоёрын дунд сонирхлын зөрчил үүсгэхгүй байх үүднээс ТУЗ-д

[233] Ханнс Зайделийн сан, Эрх зүйн боловсрол академи, *Арилжаа (худалдаа)-ны хуулийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах /судалгааны тайлан/*, (УБ: 2019), 15 дахь тал https://mongolia.hss.de/fileadmin/user_upload/Projects_HSS/Mongolia/Dokumente/2019/HGB_Studie.pdf

[234] Д.Байлыхүү, *Компанийн төлөөлөн удирдах зөвлөл* (Адмон принт, Уб., 2016 он.), 30 дахь тал.

[235] Мөн тэнд, 57 дахь тал.

компанид ажилладаг өндөр албан тушаалтныг аль болох бага хэмжээнд сонгож, болж өгвөл ийм хүнийг томилохгүй байх нь зүйтэй”[236].

КтХ-ийн ТУЗ-ийн гишүүнтэй холбогдох зохицуулалтыг үзвэл, ажилтанд хувьцаа эзэмшүүлэх, тэдгээрийн төлөөллийг ТУЗ-д байлгах талаар зохицуулалт байхгүй байх бөгөөд компанийн ажилтан хувьцаа эзэмших эрхтэй байж, ТУЗ-д төлөөлөлтэй байснаар компанийн засаглалыг хараат бус, амжилттай ажиллахад нөлөөтэй байж болох юм. Иймд “Ажилтанд хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөр”[237]-ийг хуульчлах эсэхийг цаашид дэлгэрүүлэн судлах хэрэгцээ байна.

Түүнчлэн, ТУЗ-ийн гишүүд гаргасан шийдвэрийнхээ төлөө өөрийн хувийн эд хөрөнгөөр хариуцлага хүлээх учраас “... ихэнх тохиолдолд эрсдэлтэй шийдвэр гаргахаас зайлсхийж чухал асуудал хэлэлцэх хуралд оролцохгүй байх, эсвэл шийдвэр гаргахгүй хойшлуулах зэргээр асуудалд идэвхгүй хандах явдал гаргадаг. Энэ байдал нь компанийг эрсдэлээс сэргийлэх сайн талтай боловч зарим тохиолдолд асуудлыг шийдэхгүй хойшлуулснаар компанид илүү хохирол учруулах эсвэл эрсдэл хийснээр нааштай үр дүн гарах байсныг болиулах зэрэг сөрөг үр дагаварт хүргэдэг.”[238] Энэ асуулдыг шийдвэрлэх зорилгоор “барууны ихэнх компани ТУЗ-ийн гишүүдэд тодорхой хэмжээнд эрсдэлтэй шийдвэр гаргах бололцоог бий болгох үүднээс тэдгээрт албан тушаалын даатгалыг тодорхой хэмжээний хүрээнд компанийн зүгээс хийдэг”[239] байна. Одоогоор манай КтХ-д ийм зохицуулалт байхгүй.

“Даатгалын тухай хууль”[240]-д зааснаар Монгол Улсад сайн дурын даатгалын хэлбэрийг Санхүүгийн зохицуулах хороо тогтоодог ба Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 207 дугаар тогтоолын хавсралт[241]-д заасан “Сайн дурын даатгалын хэлбэр”-ээс үзвэл Монгол Улсад “албан тушаалын” гэх даатгал байхгүй байна. Тиймд “хөрөнгийн даатгал”, “хариуцлагын даатгал”-ын аль тохиромжтойг сонгон ТУЗ-ийн гишүүнд санал болгож болох юм.

1.3. Компанийн эрх зүйн тулгамдсан асуудал

2020 оны эхээр дэлхий дахинаа илэрсэн COVID-19 вирусийн тархалттай холбоотойгоор улсуудын нийгэм, улс төр, эдийн засгийн байдал, тэдгээртэй холбоотой явуулах үйл ажиллагааны арга, хэлбэрт багагүй өөрчлөлт орж байна. Тэр дундаа худалдааны эрх зүй, компанийн эрх зүйн харилцаа, түүнтэй холбогдох үндсэн асуудлуудыг нухацтай хэлэлцэж, үр дүнд нь хуульдаа нэмэлт, өөрчлөлт оруулж байгаа юм.

Монгол Улсын хувьд цар тахалтай холбогдуулан дараах хуулиудыг баталсан байна. Үүнд:

- Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль[242]
- Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хууль[243]

[236] Мөн тэнд, 32 дахь тал.

[237] ESOP – Employee Stock Ownership Plan

[238] Д.Байлыхүү, *Компанийн төлөөлөн удирдах зөвлөл* (Адмон принт, Уб., 2016 он.), 40 дэх тал.

[239] Мөн тэнд.

[240] *Төрийн мэдээлэл* эмхэтгэл (2004), №20

[241] Сайн дурын даатгалын хэлбэр, https://www.legalinfo.mn/annex/details/8551?lawid=13526 (Сүүлд үзсэн: 2020.08.06)

[242] *Төрийн мэдээлэл* эмхэтгэл (2020), №17

[243] *Төрийн мэдээлэл* эмхэтгэл (2020), №15, Тус хуульд цар тахлын улмаас үйл ажиллагаа нь доголдож, орлого нь буурч байгаа боловч ажлын байрыг хадгалж, хуульд заасан хугацаанд нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан ирүүлсэн хуулийн этгээдийг тодорхой хугацаанд нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэхээр хуульчилсан.

- Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль[244]
- Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хууль[245] болон бусад холбогдох УИХ-ын 5 тогтоол, Засгийн газрын 22 тогтоол гарчээ.

Цар тахалтай холбоотой эдийн засгийн арга хэмжээнүүдийг шат дараатайгаар хэрэгжүүлж, дээр дурдсан хууль тогтоомжийг батлан хэрэгжүүлж байгаа хэдий ч одоогоор КтХ-д холбогдох зохицуулалт, өөрчлөлт хийгээгүй байна.

Иргэний хуульд "гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал"-ын талаар зохицуулсан байдаг ч КтХ-д энэ талаарх зохицуулалт байдаггүй. Дурдсан хууль, авсан арга хэмжээнээс гадна цар тахлын нөхцөл байдалтай холбогдуулан компанийн эрх зүйн харилцаанд хийх шаардлагатай өөрчлөлтийг дараах байдлаар тодорхойлж болох юм. Үүнд:

- Хурлын зохион байгуулалт: Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын хугацааг тахлын үеэр хойшлуулах, зарласан бол нөхцөл байдлаас үүдэн хойшлуулж болох, эсвэл бүх хувьцаа эзэмшигчдийг оролцох нөхцөл байдлыг бүрдүүлж чадсан тохиолдолд цахимаар хурлыг зохион байгуулах зохицуулалт. Ингэхдээ КтХ-ийн 73 дугаар зүйлийн 73.2-т "Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг эчнээ санал хураалтаар орлуулахыг хориглоно" гэж заасныг харгалзан цар тахлын үеэр ХЭХ-ыг тодорхой хугацаагаар (жишээ нь 2020.12.31-нийг хүртэл) хойшлуулах эсхүл цахим хурлыг зохион байгуулах арга замын аль тохиромжтойг хуульчлах нь зүйтэй.
- Ноогдол ашиг хуваарилах хугацааг хойшлуулах: КтХ-ийн 46 дугаар зүйлийн 46.5 дахь хэсэгт "Төлөөлөн удирдах зөвлөл нь санхүүгийн жил дуусанаас хойш 50 хоногийн дотор ногдол ашиг хуваарилах эсэх талаар хэлэлцэн шийдвэрлэсэн байна" гэж заасан бөгөөд ХЭХ хойшилсон тохиолдолд тус асуудлыг ч мөн нөхцөл байдалтай холбогдуулан тодорхой хугацаагаар хойшлуулах зохицуулалтыг хийж болох юм.

ХОЁР. ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ КОМПАНИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ТУЛГАМДСАН АСУУДАЛ

Компанийн хууль тогтоомжийн хөгжлийн хандлага нь өнөөгийн даяаршиж буй нийгэм эдийн засгийн нөхцөлтэй холбоотой компанийн хууль тогтоомжийг эдийн засаг, эрх зүйтэй холбон цаашдын нийгэмд үүсэж буй болох харилцаа болон компанийн засаглалын чанар, зарчмуудын үзэл баримтлалыг сайжруулан, зохицуулах хэм хэмжээг бүрдүүлэхэд оршиж байна. Мөн групп компаниудын харилцааг нарийвчлан судлах шаардлага нийгэмд үүсэж, толгой компани охин компанийн хоорондох үүсэх хариуцлагын хэм хэмжээний хязгаар, харилцаа, хариуцлага хүлээх этгээд зэргийг дахин судалж өөрчлөлт оруулах нь энэхүү даяаршиж буй зах зээлийн нийгэмд ирээдүйд бий болох маргаанаас[246] урьдчилан сэргийлэх боломжийг бүрдүүлнэ. 2019 оны сүүл үеэр үүссэн "Ковид-19" тахалтай холбогдуулан улс орон бүр иргэн, хуулийн этгээдийн ашиг сонирхолд аль болох сөрөг нөлөөг бий болгохгүйгээр даван туулах эрх зүйн болоод эдийн засгийн шийдлийг хайсаар байна үүний нэг нь Компанийн тухай хууль тогтоомжид өөрчлөлт оруулсан явдал юм.

Иймд эрх зүйн бүлийн хувьд манай улстай нэг эрх зүйн бүлд хамаардаг

[244] *Төрийн мэдээлэл* эмхэтгэл (2020), №15, Тус хуульд цар тахлын оношилгоо, эмчилгээнд хэрэглэх зорилгоор импортоор оруулж байгаа оношлуур, эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, ариутгал, халдваргүйжүүлэлтийн бодис, амны хаалтыг гаалийн албан татвараас чөлөөлөхөөр хуульчилсан.

[245] *Төрийн мэдээлэл* эмхэтгэл (2020), №15, дээр дурдсан эм, эмнэлгийн хэрэгслийг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөхөөр хуульчилсан.

[246] "Хууль дэдлэх ёс сэтгүүл" цуврал-76, "Групп компанийн хууль зүйн орчны харьцуулсан судалгаа" , 2020 он. 215 хуудас.

Оросын Холбооны Улс болон Бүгд найрамдах Хятад ард улсын компанийн эрх зүйн хэтийн төлөвийг судалснаар манай улсын компанийн эрх зүйн цаашдын хөгжилд хувь нэмэртэй байх болов уу хэмээн харьцуулсан авч үзлээ.

2.1. ОХУ-ын Компанийн эрх зүйн өнөөгийн байдал, тулгамдсан асуудал

Оросын Холбооны Улсын хувьд Компанийн эрх зүй гэх нэр томьёоны ойлголт анх 1922 оны Иргэний хуулийн 2 дугаар бүлэгт тусгалаа олж байсан. 1980 оны шинэчлэлтэй холбоотой 1991 оны иргэний эрх зүйд компанийн зохион байгуулалтын хэлбэрийн талаар анхны зохицуулалт бий болжээ.

1991-1994 оны хооронд Иргэний хуулийн 1 дүгээр хэсэгт корпорац байгуулах журам, үйл ажиллагааны үндэс, хэлбэр, түүнчлэн корпорац эзэмшигчийн (үүсгэн байгуулагч, оролцогч) үүрэг, статусыг зохицуулах хэм хэмжээний тогтолцоо үүссэн байна.

Корпорацын хууль тогтоомжийг боловсронгуй болгох дараагийн үе шат 1995-2013 оны хооронд үргэлжилж, тус хугацаанд зохион байгуулалтын болон эрх зүйн хэлбэрийг боловсронгуй болгож, бизнесийн түншлэл, Корпорацуудын үйл ажиллагааг зохицуулах арга хэлбэр, корпорацын хэм хэмжээг байнга өөрчилж, тодруулга хийсээр иржээ.

Тухайлбал 2005 онд корпорацын хууль тогтоомжийг боловсронгуй болгох объектив шаардлага байгааг хүлээн зөвшөөрч, ОХУ-ын Эдийн засгийн хөгжил, худалдааны яам “2008 он хүртэл корпорацын хууль тогтоомжийг боловсронгуй болгох үзэл баримтлал”-ыг боловсруулж, ОХУ-ын Засгийн газар 2006 оны 5 дугаар сарын 18-ний өдрийн №16 протоколын II хэсгийг баталж корпорацын хууль тогтоомжуудад өөрчлөлтийг оруулсан. 2012 оны 12-р сарын 30-ний өдөр ОХУ-ын Иргэний хуулийн 1, 2, 3, 4 дүгээр бүлэгт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай №302 Холбооны хуулийг баталсан бөгөөд гол нэмэлт, өөрчлөлтүүдийн нэг нь Иргэний хуулийн 2 дугаар зүйлд корпорацтай холбоотой харилцаа нь иргэний хуулийн салшгүй хэсэг болохыг нэмэлтээр оруулсан юм.[247]

Эрх зүйн зохицуулалт

Корпорацын харилцааны зохицуулалтыг анхлан тусгаж байгаа эрх зүйн актуудын нэг бол ОХУ-ын Үндсэн хууль бөгөөд тус хуулийн 1 дүгээр бүлгийн 8 дугаар зүйлд ОХУ-ын эдийн засгийн эв нэгдэл, бараа, үйлчилгээ, санхүүгийн эх үүсвэрийн чөлөөтэй хөдөлгөөн, өрсөлдөөнийг дэмжиж эдийн засгийн үйл ажиллагааны эрх чөлөөг баталгаажуулж өгсөн[248]. Энэ корпорацын харилцаа нь өөрөө Үндсэн хуулийн тогтолцооны үндэс буюу тухайн улсын оршин тогтнох нэг чухал холбоос болохыг харуулж байна.

Корпорацын харилцааг зохицуулж байгаа эрх зүйн эх сурвалжуудын дунд ОХУ-ын Иргэний хууль гол байр суурь эзэлдэг гэвч тус Иргэний хуульд хуулийн этгээдийн болон арилжааны байгууллагуудын эрх зүйн байдлын ерөнхий харилцааг зохицуулсан байдаг[249] тодруулбал, 1995 оны 12 дугаар сарын 26-ний өдрийн “Хувьцаат компанийн тухай” Холбооны хууль, 1998 оны 2 дугаар сарын 8-ний өдрийн “Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн тухай” Холбооны хуулиудаар нарийвчлан зохицуулж өгсөн байдаг.

2016 оны 7 дугаар сарын 3-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн “ОХУ-ын зарим хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” /цаашид №343 гэх/ Холбооны хуулиар “Хязгаарлагдмал хариуцлагатай компаниудын тухай” болон

[247] ОХУ-ын хуулийн нэгдсэн цахим хуудас, www.consultant.ru/document/cons_doc_LAW_5142/8d8cd335130f04a7036c1eb50fff606c93fc643a/ (сүүлд үзсэн: 2020.05.12).

[248] ОХУ-ын Үндсэн хууль, http://www.constitution.ru/10003000/10003000-3.htm. (сүүлд үзсэн: 2020.08.10).

[249] ОХУ-ын хуулийн нэгдсэн цахим хуудас, http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_5142/a59399f9b8098892b58b37b351e1d8957453219a/. (сүүлд үзсэн: 2020.08.10).

“Хувьцаат компаниудын тухай” холбооны хуулиудад ашиг сонирхлын зөрчилтэй этгээдтэй хийх хэлцэл болон их хэмжээний хэлцэлтэй холбоотой гүйлгээг хэрхэн байгуулах, гүйлгээ хийх, эсэргүүцэх журмыг өөрчлөх зорилгоор нэмэлт, өөрчлөлт оруулсан. Тухайлбал “Хувьцаат компанийн тухай” хуулийн 79 дүгээр зүйлийн 79.6-д ямар тохиолдолд их хэмжээний хэлцлийг хүчин төгөлдөр бус гэж тооцох мөн ямар этгээдүүд тус хэлцэлтэй холбоотой шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй талаар зохицуулж өгсөн байна.

Мөн Холбооны хуулийн «Гэмт хэргийн улмаас олсон орлогыг хууль ёсны болгох, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай» /цаашид №115 гэх/ оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр Хувьцаат компани болон Хязгаарлагдмал хувьцаат компаниас ашиг авдаг хувьцаа эзэмшигчдийн тухай мэдээллийг ил болгоогүй, жил бүр шинэчлээгүй, хадгалах үүргийг биелүүлээгүй тохиолдолд хуулийн этгээдэд захиргааны хариуцлагад татахаар зохицуулж өгсөн байдаг.

ОХУ-ын хувьд корпорацын хууль тогтоомжийн цаашдын чиг хандлагын хувьд корпорацын хяналтын механизмыг тэгш хуваарилж, өргөжүүлэх бодлоготой байгаа тухайлбал, корпорацын гэрээний зохицуулалттай холбоотой хэм хэмжээг хөгжүүлэх, янз бүрийн эрх бүхий хувьцааны ангиллыг бие болгож зохицуулах, хаалттай компанийн удирдлагын талаар диспозитив дүрмийг боловсруулахад чиглэгдэж байна. Корпорацын хурлын шийдвэрийг нотариат, бүртгэгчдээр баталгаажуулах, охин компанийн өрийг толгой корпорац болон охин корпорац тэгш хариуцах зэрэг шинэчлэлийн талаар “МФЦ”-ээс байгуулсан ажлын хэсгийн тайланд дурдсан байна.[250]

Сүүлийн жилүүдэд ОХУ-ын корпорацын хууль тогтоомжид тулгамдсан асуудлуудын нэг бол корпорацын засаглал болон үүнтэй холбоотой хөрөнгө дахин хувиарлах маргаан юм. Корпорацын засаглалын чанарыг сайжруулах нь хөрөнгийн тогтвортой өсөлтөд хувь нэмэр оруулж, эрсдэлийг бууруулж, бизнесийн тогтвортой байдлыг нэмэгдүүлэх ач холбогдолтой.

ОХУ-ын практикт хэрэгжиж байгаа корпорацын засаглалын талаар судлан үзэхэд корпорацын засаглалын менежментийн чиглэлээр зохицуулалт дутмаг, хувьцаат компаниудын корпорацын засаглалын нэгдсэн стандарт байхгүй байна. Үүнээс үүдэж хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалахад асуудал үүссээр байна, учир нь корпорацын засаглалтай холбоотой зүйл, заалтуудыг хэрхэн тайлбарлаж хэрэглэснээс шалтгаалан хүрэх үр дүн нь өөр байгаа юм.

Хувьцаа эзэмшигчийн нэгдсэн хуралдаанд оролцох, хөрөнгийг татан буулгах, өөрчлөн байгуулах, нэгтгэх явцад (ялангуяа нэг хувьцаанд шилжих тохиолдол) хувьцаа эзэмшигчдэд шилжүүлэх хөрөнгө, хувьцаа дээр маргаан нилээд үүсэж байгаа нь эрх зүйн зохицуулалт дутмаг байгааг харуулж байна. Одоогийн ОХУ-д хэрэгжиж буй корпорацын засаглалын хэлбэр нь удирдлагын үр ашиггүй загварыг бий болгож, компанийн хөрөнгө оруулалтын чадамжийг нэмэгдүүлэхэд бус харин нөхөрсөг бус байдлаас хамгаалахад чиглэсэн байна.[251]

Эдийн засаг болон, нийгмийн нөхцөл байдалтай холбоотой Ковид-19” тахалтай холбоотой эрх зүйн зохицуулалт, тулгамдсан асуудал

Эдийн засаг болон, нийгмийн нөхцөл байдалтай холбоотой 2020 оны 4 дүгээр сарын 7-ны өдөр нэмэлт, өөрчлөлт орж батлагдсан №115 Холбооны хууль нь корпорацын хууль тогтоомжуудад мөрдөгдөж буй зарим тавигдах шаардлага болон

[250] “МФЦ”-ээс байгуулсан ажлын хэсгийн тайлан. http://www.mfc-moscow.com/assets/files/misc/corp_law_next_steps.pdf (сүүлд үзсэн: 2018.01 сар).

[251] Гараджа, Ю. В. “ОХУ-ын компанийн тухай хууль тогтоомжийн цаашдын чиг хандлагад тулгарч буй асуудал”, Залуу эрдэмтэн. 2019. № 2 (240).х.х119-122. (сүүлд үзсэн: 2020.08.11). https://moluch.ru/archive/240/55502/

хэм хэмжээний хүчин төгөлдөр болох хугацааг өөрчилж хойшлуулсан. Тухайлбал:

- *Хувьцааг бүртгэх, сунгах болон хувьцаа гаргаагүй хувьцаат компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах*

2015 оны 6 дугаар сард батлагдсан "Төрийн болон хотын үйлчилгээг зохион байгуулах тухай" /цаашид №210 гэх/ Холбооны хуулиар 2014 оны 9 дүгээр сарын 1-ээс өмнө бүртгүүлсэн Корпорацын дүрэмд "олон нийтэд" гэсэн үг агуулсан Хувьцаат компаниуд зах зээлд хувьцаа гаргаагүй эсхүл худалдагдаагүй бол №210 холбооны хуульд заасны дагуу ОХУ-ын Төв банкинд өөрийн компанийн үнэт цаасыг бүртгүүлэх эсхүл компанийн дүрмээс олон нийтийн гэх нэршлийг хасах үүрэгтэй байна. Тус үүргийг биелүүлэх эцсийн хугацаа 2020 оны 6 дугаар сард дуусгавар болсон бөгөөд №115 Холбооны хуулиар цаг үеийн нөхцөл байдалтай холбогдуулан 2021 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр хүртэл сунгасан байна.

- *Аудитын хороо, шалгалт хариуцсан албан тушаалтныг томилох тухай хэрэгжилтийг хойшлуулах*

"Хувьцаат компанийн тухай" /цаашид № 208 гэх/ Холбооны хуулийн 64 дүгээр зүйлийн 3 дахь заалтын 2 дахь догол мөрөнд олон нийтийн компанид аудитын хороо байгуулахыг заасан байдаг. Энэхүү нэгжийг Төлөөлөн удирдах зөвлөлөөс байгуулах бөгөөд санхүүгийн болон эдийн засгийн үйл ажиллагаа, аудитын чанар, аудиторын бие даасан, хараат бус байдал болон ашиг сонирхлын зөрчил байгаа эсэхэд хяналт тавих үүрэгтэй нэгж. "ОХУ-ийн жижиг, дунд бизнесийг хөгжүүлэх тухай" /цаашид №209 гэх/ холбооны хуульд заасны дагуу 2020.07.01-ний өдрөөс эхлэн тус хороог байгуулах үүрэгтэй байсан боловч 2020 оны нөхцөл байдлыг харгалзан 2021 оны 1 дүгээр сарын 1-ний өдрийг хүртэл хойшлуулсан.

- *Хэрэв цэвэр хөрөнгө нь эргэлтийн хөрөнгийн хэмжээнээс бага бол 2020 оны эцэс гэхэд компанийг эргэлтэд оруулах эсвэл компанийг татан буулгах үүрэг бий болгосон хэм хэмжээг түдгэлзүүлэх*

Хувьцаат компани, Хязгаарлагдмал хувьцаат компанийн тухай хууль тогтоомжид хуулийн этгээдийн эргэлтийн хөрөнгө цэвэр хөрөнгийн хэмжээнээс бага, эсвэл жилийн эцэст цэвэр хөрөнгө нь дүрэмд заасан хэмжээнээс бага байвал компанийг бүхэлд нь татан буулгахаар зохицуулсан байдаг. 2020 оны нөхцөл байдалтай холбоотой «тахлын хямрал» ба дэгдэлтийн үеэр бизнес эрхлэгчдэд тавьсан тус шаардлагыг харгалзан үзэж 2020 он дуустал үйлчлэхгүй байхаар зохицуулсан.

- *2020 онд нэгдсэн хуралдааныг хийх хугацааг уртасгах*

Хууль тогтоомжийн дагуу Хязгаарлагдмал хувьцаат компанийн ээлжит хурал тайлант жил дуусанаас хойш хоёр сараас дөрвөн сарын хооронд, харин Хувьцаат компанийн ээлжит хурал тайлант жил дуусанаас хоёр сараас зургаан сарын хооронд зохион байгуулагддаг. Үүнийг дагуу компаниуд ээлжит хурлаа ихэвчлэн 3 сараас 5 сарын хооронд зохион байгуулдаг байсан. Харин энэ жилийн 4 дүгээр сарын 1-нээс ОХУ-д хөл хорио тогтоосонтой холбоотой, уулзалтыг биечлэн хийх боломжгүй болсон. Иймд төрөөс хурал цуглаан хийх хугацааг 9 дүгээр сарын 30-ний өдрийг хүртэл сунгасан байна. Энэ жилийн уулзалтуудыг цахимаар хийх боломжтой бөгөөд Хувьцаат компани, Хязгаарлагдмал хувьцаат компани нь санхүүгийн тайланг 2020 оны 9 дүгээр сарын 30-ний өдрийн дотор батлах үүрэгтэй.

- *Үнэт цаас гаргагчийн арилжаалагдсан хувьцааг худалдаж авах журмыг түр хугацаагаар өөрчлөх*

2020 оны 12 дугаар сарын 31-нийг хүртэл хууль тогтоогч №208 дугаар Холбооны хуулийн 72 дугаар зүйлийн 4-8 дахь заалтуудад урьдчилж гаргасан хувьцааг үнэт цаас гаргагч худалдаж авах, тус худалдаж авсан үнэт цаасаа өөрийн

Хувьцаат компанийн тухай хууль www.zsv.mn

болгох боломжтой нөхцөлүүдийг танилцуулсан байсан. №115 дугаар Холбооны хуулийн дагуу хуулийн этгээд нь эдгээр хувьцааг худалдаж авсан тухай ОХУ-ын Төв банканд мэдэгдэх үүрэгтэй. Үүний зэрэгцээ хувьцаат компани нь хувьцааг авах шийдвэрт заасан хугацаанд материаллаг баримт хэлбэрээр олон нийтэд ил болгохгүй байх эрхийг олж авсан.

- *Нэгдсэн тайлан илгээх хугацааг сунгах*

Санхүүгийн тайлангийн №208 дугаар Холбооны хуульд №115 дугаар Холбооны хуулиар хуулийн этгээдийн нэгтгэсэн тайлан гаргах хугацааг сунгахаар болсон. Хуучин "Санхүүгийн тайлангийн тухай хууль"-д жилийн эцсийн тайланг шинэ жил эхэлснээс хойш зуун хорин хоногийн дотор гаргаж өгөх, завсрын тайланг тайлант хугацаа дуусснаас хойш жаран хоногийн дотор ирүүлдэг байсан. Тус №115 дугаар Холбооны хуулиар жилийн эцсийн тайланг тайлант жил дуусснаас хойш зуун наян хоногийн дотор, завсрын тайланг зуун тавин хоногийн дараа ирүүлнэ гэж тогтоож өгсөн бөгөөд тус хугацаа 2020 оны 12 дугаар сарын 31-нийг хүртэл хүчинтэй байна.

Аудитын тайланг тайлагнах өдрүүдийг мөн түр хугацаагаар хойшлуулсан байна. Үнэт цаасны тухай хуульд заасны дагуу тухайн тайлант жил дуусснаас хойш 120 хоногийн дотор компани жилийн тайлан болон аудитын тайланг гаргах, харин завсрын тайлан болон завсрын аудитын тайланг тайлант хугацаа дуусснаас хойш 60 хоногийн дотор тайлагнах үүрэгтэй байсан хэдий ч 2020 онд эдгээр хэм хэмжээнүүдийг түр түдгэлзүүлж жилийн эцсийн тайланг 2020.07.28-аас өмнө, хагас жилийн тайланг 2020.12.28-наас өмнө тайлагнахаар хойшлуулсан байна.

Дээрхээс үзвэл цаг үеийн нөхцөл байдалтай холбоотой ОХУ-ын хувьд хурал хийх хугацаа, мэдээлэл ил болгох, тайлан ирүүлэхтэй холбоотой г.м хэм хэмжээнд өөрчлөлт оруулсан. Мөн дотоод аудитын дүрмийг хүчин төгөлдөр болох хугацааг түр хойшлуулж, цэвэр хөрөнгийн үнэ цэнэ нь эргэлтийн хөрөнгийн хэмжээнээс доогуур байгаа тохиолдолд компанийн хөрөнгийг багасгах эсвэл татан буулгахыг үүрэг болгосон хэм хэмжээний үр нөлөөг түр зогсоосон. Эдгээр өөрчлөлтүүд нь корпорацын эрх зүйн дэвшилтэт хөгжлөөс үүдэлтэй биш, харин цар тахлын аюулаас үүссэн түр зуурын шинжтэй зохицуулалтууд юм.

2.2. Бүгд Найрамдах Хятад Ард Улсын компанийн эрх зүйн өнөөгийн байдал, тулгамдсан асуудал

БНХАУ-ын анхны Компанийн хууль Чин гүрний үед буюу 1904 онд батлагдаж байсан бөгөөд тус хууль нь Англи, Японы компанийн хуулийг загвар болгож, хуулийн этгээдийн хэд хэдэн хэлбэрээс гадна хязгаарлагдмал хувьцаат компанийн загварыг анхалж хуульдаа томьёолж оруулж ирсэн байна. Тус хууль нь 7 жилийн турш үйлчилж байгаад Чин гүрний мөхөлтэй зэрэгцэн үгүй болсон тул 1914 онд Компанийн удирдамж шинээр батлагдсан байна.[252] Үүний дараагаар 1929, 1946 оны хуулиуд батлагдаж, 1946 оны хуульд анх удаа гадаадын аж ахуй нэгж гэсэн ойлголтыг оруулж ирснийг бататган Дэн Сяопины үеэс БНХАУ нь нээлттэй хаалганы бодлого баримталж 1979 онд гадаадын хамтарсан аж ахуй нэгжийн хуулийг баталж, 1980 онд Шенженд анхны чөлөөт худалдааны бүс байгуулж социалист хөрс дээр капиталист үр тарих оролдлого эхэлсэн байна.[253]

Эрх зүйн зохицуулалт болон тулгамдсан асуудал.

Одоогийн хүчин төгөлдөр үйлчилж буй Компанийн хууль нь 1993 оны 12 дугаар сарын 29-нд болсон Ардын Төлөөлөгчдийн Наймдугаар Их Хурлын Байнгын хорооны 5 дугаар хуралдаанаар батлагдаж 1994 онд хүчин төгөлдөр болсноос хойш 4 удаагийн нэмэлт, өөрчлөлтийг оруулж сүүлчийн өөрчлөлт 2018 онд орж өдгөө хүчин төгөлдөр үйлчилсэн хэвээр байна.

[252] Jiang Yu Wang "Overview of the company law regime in China", 2014, p.4.

[253] Aspects of Company law in China, lecture of Professor Wen Shuangge, Jilin University, 2018.

БНХАУ-ын Компанийн хууль нь нийт 13 бүлэг 218 зүйлтэй.[254] Компанийн тухай хуулиар компани байгуулах, үйл ажиллагаа эрхлэх, компанийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, компанийн оролцогчид (хувьцаа эзэмшигчид), зээлдүүлэгчидтэй холбоотойгоор нийгэм, эдийн засгийн дэг журмыг хамгаалах, социалист зах зээлийн эдийн засгийн хөгжлийг дэмжих харилцааг зохицуулсан. Компанийн тухай ойлголтыг хуулийн 3 дугаар зүйлд "Компани нь хуулийн дагуу байгуулагдсан бөгөөд ашиг олох зорилгоор хувьцаа эзэмшигчдийн хөрөнгө оруулалтаар байгуулагдсан аж ахуйн нэгжийн хуулийн этгээд юм. Компани нь өр төлбөрөө бүх эд хөрөнгийнхөө хэмжээгээр хариуцна." гэж заасан байна. Компани байгуулан үйл ажиллагаагаа явуулах гэж байгаа этгээдүүд компанийн хууль тогтоомж болон бусад хууль тогтоомж, дүрэм журам, нийтийн болон бизнесийн ёс зүй, шударга байдлыг баримтална, төр засаг, олон нийтийн хяналт дор нийгмийн хариуцлагаа ухамсарлан үйл ажиллагаа явуулах үүрэгтэй.[255] Компани нь ажилчдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах үүрэгтэй бөгөөд хуульд заасны дагуу ажилчидтай хөдөлмөрийн гэрээ байгуулах, нийгмийн даатгалд хамруулах, хөдөлмөр хамгааллын аюулгүй байдлыг хэрэгжүүлэх, үйлдвэрлэлийн аюулгүй байдлыг ханган үйл ажиллагаа явуулна.[256]

БНХАУ-ын Компанийн хуулийн 2 болон 4 дүгээр бүлэгт компанийг Хязгаарлагдмал хариуцлагатай компани, Нэг хүний Хязгаарлагдмал хариуцлагатай компани, Төрийн өмчит Хязгаарлагдмал хариуцлагатай компани, Хувьцаат хамтарсан компани гэж ангилдаг.

Хязгаарлагдмал хариуцлагатай компани нь өөрийн үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигчдээс тусдаа ашгийн төлөө хуулийн этгээд бөгөөд Хувьцаа эзэмшигчид компанийн өр, алдагдлын хариуцлагыг хүлээдэггүй. Компани үүсгэн байгуулах нийт гишүүний тоо 50-аас хэтрэхгүй байхаар хуульчлагдсан байна. Анхны хувьцаа эзэмшигчийн хурлыг хамгийн их хувьцаа эзэмшдэг хувьцаа эзэмшигч зарлаж, тус хурлыг хуульд заасны дагуу даргалж болно. Цөөхөн гишүүнтэй эсвэл жижиг үйл ажиллагаа эрхэлдэг хязгаарлагдмал хариуцлагатай компани нь төлөөлөн удирдах зөвлөлийг байгуулахгүй байж болох ба гүйцэтгэх захирал нь тухайн компанийн удирдлагын үйл ажиллагааг мөн явуулах үүрэгтэй бөгөөд гүйцэтгэх захирлын эрх хэмжээг компанийн дүрмээр зохицуулна. Хязгаарлагдмал хариуцлагатай компани нь хяналтын хороо байгуулах үүрэгтэй. Тухайн компанийн цар хүрээнээс шалтгаалж 1-3 хяналтын гишүүнтэй байх ёстой бөгөөд хяналтын гишүүний ажиллах нийт хугацаа 3 жил байна хэрвээ тус хугацаа дуусвал сунгаж болно гэж хуулиар зохицуулсан байна.

Нэг хүний Хязгаарлагдмал хариуцлагатай компанийг хувь хүн эсвэл хуулийн этгээд байгуулж болно. Тус компани нь жилийн эцэс гэхэд санхүүгийн тайлангаа бэлтгэж санхүүгийн тайланд аудит хийдэг байгууллагаар шалгуулах үүрэгтэй. Хэрэв нэг гишүүнтэй хязгаарлагдмал хариуцлагатай компанийн гишүүн тухайн компанийн эд хөрөнгийг хувийн өмчөөсөө тусгаарлаж чадаагүй тохиолдолд өөрийнхөө бүх хөрөнгөөрөө компанийн хариуцлагыг хүлээнэ.

Төрийн өмчит Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьд БНХАУ-ын Төрийн зөвлөл буюу орон нутгийн ард түмний засгийн газраас компанийн гишүүнд олгосон эрх хэмжээний хүрээнд үйл ажиллагаа нь явагддаг бөгөөд Төрийн өмчит компанийн дүрмийг төрийн өмчийн менежментийн байгууллага баталж, компанийн захирлуудын зөвлөл (хяналтын зөвлөл) боловсруулж, төрийн өмчийн менежментийн байгууллагад батлуулахаар өргөн барина. Төрийн өмчит компанийн

[254] БНХАУ-ын Компанийн тухай хууль, http://fdi.gov.cn/1800000121_39_4814_0_7.html (сүүлд үзсэн: 2013.12.28).

[255] БНХАУ-ын "Компанийн тухай хууль"-ийн 5 дугаар зүйл. (сүүлд үзсэн: 2020.08.11).

[256] БНХАУ-ын "Компанийн тухай хууль"-ийн 17 дугаар зүйл. (сүүлд үзсэн: 2020.08.11).

хяналтын хороо дор хаяж таван хүнээс бүрдэх ёстой бөгөөд хяналтын хорооны 1/3-ас доошгүй гишүүн нь хөдөлмөрийн хамтын ажиллагааны төлөөлөгч байх ёстой бөгөөд тохирох харьцааг компанийн дүрмээр тогтооно. Хяналтын хорооны гишүүдийг төрийн өмчийн удирдлагын байгууллага томилдог бөгөөд тус хороонд ажиллах хөдөлмөрийн хамтын ажиллагааны төлөөлөгчийг Хөдөлмөрийн хамтын ажиллагааны төлөөлөгчийн хурлаар сонгоно. Төрийн өмчийн менежментийн байгууллага хяналтын хорооны даргыг нь гишүүд дундаас нь томилдог.

Компанийн тухай хуулийн 19 дүгээр зүйлд компани коммунист намын төлөөлөл болохын тухай ойлголтыг зохицуулахдаа "Компани нь Хятадын коммунист намын байгууллага болохын тулд намын дүрэмтэй нийцүүлэн үйл ажиллагаагаа явуулж, намын үйл ажиллагаанд шаардагдах дэмжлэг үзүүлнэ." гэж заасан байдаг. Компанийн тухай хуулийн 5 дугаар зүйлд "... нийгмийн ёс зүй, бизнесийн ёс зүй, ..., нийгмийн болон нийтийн өмнө хүлээж, хариуцлагыг удирдлага болгон үйл ажиллагаа явуулна.", зарим хөрөнгийн биржүүд бүртгэлтэй компаниудаа нийгмийн хариуцлагын хүрээнд шаардлага тавьдаг, Жишээлбэл, Шенженийн хөрөнгийн биржийн бүртгэлтэй компани нийгмийн хариуцлагын хүрээнд "... компани нь үндэстний болон нийгмийн хөгжил, хүрээлэн орчин, нөөцийн ... талаар боломжит бүхий л арга хэмжээг авч ажиллана." гэж заасан нь компанийн нийгэмд хүлээх үүрэг, хариуцлагыг хуульчилж өгсөн байна. Мөн хуульд ажилчдын нийгэм хамгаалал, ажилчдын өөрөө удирдах байгууллага, ажилчдын дуу хоолойг эрх бүхий албан тушаалтнуудад хүргэх тогтолцоог сайтар бүрдүүлэн хуульчилж өгсөн. Жишээлбэл, ажилчдын төлөөллийг заавал төлөөлөн удирдах зөвлөл болон хяналтын зөвлөлд оруулах шаардлага тавьсан[257] байна.

2018 оны 10 дугаар сарын 26-ны өдөр Ардын Төлөөлөгчдийн Наймдугаар Их Хурлын Байнгын хорооны зургаа дахь хуралдаанаар "БНХАУ-ын Компанийн тухай хууль"-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай шийдвэрийг гаргасан бөгөөд компанийн анхны хувьцааг эргүүлэн худалдаж авах тогтолцоог улам боловсронгуй болгох зорилгоор хуулийн 142 дугаар зүйлд "компанийн ажилчдад хувьцааг урамшуулж олгох", "ажилчдын хувьцааны өмчлөлийн төлөвлөгөө гаргах эсвэл хувьцааны урамшуулалд ашиглах", "хувьцаат компанийн хувиргаж болгох хувьцааг ашиглах" зэрэгт өөрчлөлт оруулсан.[258]

"Ковид-19" тахалтай холбоотой үүссэн эрх зүйн өөрчлөлтүүд.

БНХАУ нь "Ковид-19"-тэй холбоотой нэмэгдсэн өртгийн албан татварын хэмжээг бууруулж, чөлөөлж, хөнгөлсөн арга хэмжээнүүдийг авч байна. Өөрөөр хэлбэл, жижиг дунд үйлдвэрийн татвар төлөгчид татвар ноогдуулах борлуулалтын орлогоос 1%-ийг бууруулан татвар ногдуулж нэмэгдсэн өртөгийг албан татвар төлөх боломжийг бий болгосон байна.[259] Тухайлбал, хүнд үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүд 2020 онд тахал өвчин дэлгэрсэнтэй холбоотой үйл ажиллагаанд учирсан алдагдлыг нөхөн төлөх хугацааг 5 жилээс 8 жил хүртэл сунгасан бөгөөд нийтийн тээврийн үйлчилгээ[260], амьжиргааны үйлчилгээ, оршин суугчдад шаардлагатай материалын шуурхай хүргэлт явуулж байгаа аж ахуй

[257] БНХАУ-ын "Компанийн тухай хууль"-ийн 44-51 дүгээр зүйл.

[258] China Collective Economy цахим хуудас. http://www.ce2293.com/qkglxt/showlm.asp?id=9289&fbclid=IwAR2G6Mrg9o_da1GRGYmtk8EK4EYiHiXtBhUKtFtsclAKlL_6CW0LbWbPPtM, (сүүлд үзсэн огноо 2019.01.02).

[259] "Tax measures in response to COVID-19" Based on information received from countries as of 23/03/2020 04 PM GMT", 2020, p.31.

[260] Нийтийн тээврийн үйлчилгээнд гатлага онгоц, автобусны зорчигч тээвэр, метро, хотын хөнгөн төмөр зам, такси, холын зорчигч тээвэр, автобусны үйлчилгээ, амьдралын үйлчилгээнд соёл, спортын үйлчилгээ, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ, аялал жуулчлал, зугаа цэнгэлийн үйлчилгээ, нийтийн хоол, байрны үйлчилгээ, оршин суугчдын өдөр тутмын үйлчилгээ орно.

нэгжүүдийг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлсөн.[261]

“Ковид-19”-ээс урьдчилан сэргийлэх, хамгаалах зорилгоор үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгжийг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх, буцаан авах, суутган тооцох зэрэг хөнгөлөлтийг үзүүлж байна. Тухайлбал, урьдчилан сэргийлэх, хамгаалах үйлдвэрлэл эрхэлдэг аж ахуйн нэгжүүд үйлдвэрлэлийн хүчин чадлыг өргөжүүлэх зорилгоор халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, хянах үндсэн баталгааны материал үйлдвэрлэдэг аж ахуйн нэгжүүд шинээр худалдаж авсан хэрэгслийг одоогийн өртөгт оруулж, аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас суутган тооцох.[262] Тахлын эсрэг хамгаалах гол материалыг тээвэрлэж буй аж ахуй нэгжийг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх бөгөөд энэхүү нэмэгдсэн өртгийн албан татвараас хөнгөлөлт эдлүүлэх эцсийн хугацааг тархалтын нөхцөл байдлаас шалтгаалан тухай бүрт нь зарлахаар зохицуулсан байна.

Мөн “Ковид-19”-тэй холбоотой урьдчилан сэргийлэх, хамгаалах зорилгоор хандивлаж буй импортын барааг татвараас чөлөөлөх бодлого хэрэгжиж байна. Халдвараас урьдчилан сэргийлэх, хяналтын ажлыг цаашид дэмжих зорилгоор 2020 оны 1 дүүгрсарын 1-ээс 3 дугаар сарын 31-ний хооронд импортын бараанд татварын илүү таатай бодлого хэрэгжүүлж эхэлсэн.[263]

2020 оны 2 дугаар сараас эхлэн бүх муж, хотуудад үйл ажиллагаагаа явуулж буй жижиг дунд үйлдвэр эрхлэгчдэд нийгмийн даатгалын хураамж төлөх хугацааг 5 сар хүртэл хугацаагаар чөлөөлөх бусад томоохон байгууллагуудын нийгмийн даатгалын хураамжийн хэмжээг 2 дахин бууруулах эсвэл гурван сар хүртэл хугацаагаар чөлөөлөх.[264]

2.3. Бүгд Найрамдах Сингапур Улсын компанийн эрх зүйн өнөөгийн байдал, тулгамдсан асуудал

Бүгд Найрамдах Сингапур Улсад Компанийн тухай хуулийн анхны хэлэлцүүлэг 1966 оны 12 дугаар сарын 5-ний өдөр болж, 1967 оны 12 дугаар сарын 29-ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн. Үүнээс хойш нийт таван удаа шинэчлэгдсэн бөгөөд хамгийн сүүлд 2014 онд нэмэлт, өөрчлөлт орж 2015 оноос эхлэн хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн.

Эрх зүйн зохицуулалт болон тулгамдсан асуудал.

БНСУ-ын Компанийн хууль нь нийт 12 бүлэг 411 зүйлтэй.[265] Компанийн тухай хууль нь компанийн бүртгэл, удирдлага, албан тушаалтнуудын эрх мэдлийн хуваарилалт, хувьцааны зохицуулалт, өр төлбөр болон нягтлан бодох бүртгэл, аудит, компанийн зохион байгуулалтын үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтын болон гадаадын компаниудын зохицуулалтын тухай ойлголтыг багтаасан болно. Аливаа хувь хүн дангаараа болон бусад этгээдтэй хамтран хуульд заасны дагуу бүртгүүлэн компани байгуулах эрхтэй бөгөөд дор хаяж нэг гишүүнтэй байх ёстой байдаг. Сингапурын компанийн тухай хуульд зааснаар компани байгуулж байгаа этгээд

[261] БНХАУ-ын хайлтын систем http://www.zlketang.com/news/kjsc/policy_detail/3314.html?fbclid=IwAR08kV5eLvVSfH9Cc2OUWK9uRlVRPLNQERybwm61v7IZpABoXyXz0kZ4bF8 (сүүлд үзсэн: 2020.08.10).

[262] Эпидемийн аюулаас урьдчилан сэргийлэх, хянах үндсэн баталгаат материал үйлдвэрлэх аж ахуйн нэгжийн нэрсийн жагсаалтыг аймаг, түүнээс дээшхи хөгжлийн болон шинэчлэлийн газар, үйлдвэр, мэдээллийн газар тогтооно.

[263] Импортын барааг татвараас чөлөөлөх хугацааны арга хэмжээ нь халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, хянах зорилгоор хандивласан импортын материалыг татвараас чөлөөлөх импортын материалын хэмжээ, татваргүй татварын субъектүүдийн хамрах хүрээ, хүлээн авагчийн цар хүрээ гэх мэт заалтуудыг оруулсан болно.

[264] “Tax measures in response to COVID-19” Based on information received from countries as of 23/03/2020 04 PM GMT”, 2020, p.31.

[265] Бүгд Найрамдах Сингапур Улсын эрх зүйн мэдээллийн цахим хуудас. https://sso.agc.gov.sg/Act/CoA1967?ProvIds=P1I-#pr1- (сүүлд үзсэн огноо 2020.08.06).

хувийн болон олон нийтийн компани байгуулж болох ба олон нийтийн компани нь хязгаарлагдмал хувьцаат компани, баталгаагаар хязгаарлагдмал компани болон хязгааргүй (хувьцаат) компани[266] гэж ангилж, харин хувийн компани байгуулж байгаа тохиолдолд нийт гишүүний тоо 50-с хэтрэлгүй, хувьцаа шилжүүлэх эрхэд хязгаарлалт хийж, мөн үүнийгээ компанийн дүрэмдээ заавал тусгасан байх ёстой байдаг.[267]

Хувьцаа эзэмшигчтэй Олон нийтийн компани нь хувийн компани болон өөрчлөгдөх боломжтой бөгөөд үүний тулд хувийн компани болох шийдвэр, хувьцаа эзэмшигчийн нэрс, эзэмшдэг хувьцаа, компанийн үндсэн хуулиа хувийн компанийн үндсэн хуульд нийцүүлэн өөрчилсөн байх мөн хувьцаа эзэмшигчтэй холбоотой бусад мэдээлэл байх шаардлагтай үүнтэй мөн адилаар хувийн компани нь олон нийтийн компани болон өөрчлөгдөж болно.[268]

Мөн хувьцаа эзэмшигчтэй олон нийтийн компани нь үүсгэн байгуулагдсанаас хойш 1-3 сарын дотор хувьцаа эзэмшигчдийн хурлыг явуулах үүрэгтэй. Тайлант жил дуусанаас хойш олон нийтийн компани 4 сар, бусад компани 6 сарын дотор ээлжит хурал хийх шаардлагыг хуулиар тавьсан байна.

Мөн бүртгэгдсэн компани бүр Аудитын хороог ажиллуулах үүрэгтэй бөгөөд аудитын хороонд хамгийн багадаа гурван гишүүн ажиллах ёстой, гүйцэтгэх захирал болон төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, тэдний гэр бүлийн гишүүн болон ашиг сонирхлын зөрчил үүсэж болох этгээд байж болохгүй аудитын гишүүнээр ажиллаж болохгүй.

Компанийн тухай хуульд 2014 онд орсон нэмэлт, өөрчлөлт компаниудын үйл ажиллагааны зохицуулалтын ачааллыг бууруулж, бизнес эрхлэх явцыг хялбаршуулах, төрөл бүрийн хөрөнгө босгох аргыг ашиглаж бизнес эрхлэх уян хатан нөхцөлийг нэмэгдүүлэх, компанийн засаглалыг сайжруулж, ил тод байдлыг хангахад чиглэгдсэн байна. Тухайлбал, компаниуд өөрийн компанийн хувьцааг эргүүлэн худалдаж авахад санхүүгийн тусламж үзүүлэх хоригийг цуцалсан. Энэхүү өөрчлөлт нь бизнес эрхлэхэд илүү уян хатан байдлыг хангасан төдийгүй зээлсэн хөрөнгийн босгох гүйлгээг хялбаршуулсан. Өөрийн эзэмшлийн хувьцааг худалдаж авахад санхүүгийн туслалцаа үзүүлэх нь тухайн компанийн ашиг сонирхолд ноцтой хохирол учруулахгүй, эсвэл компанийн зээлдүүлэгч төлөх чадвартай тохиолдолд л хоригийг цуцалсан байдаг.

Компанийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр жижиг бизнесүүдээ дэмжихийн тулд компанийн жилийн нийт орлого нь 10 сая Сингапур доллар эсвэл нийт хөрөнгө нь 10 сая хүртэл Сингапур доллар мөн нийт ажилчдын тоо 50-с хэтрэхгүй тохиолдолд аудит хийхээс чөлөөлсөн.

Компанийн хувьцаа эзэмшигчид хэрэв үүсгэн байгуулах баримт бичиг дээрээ цахим хэлбэрийн харилцааны талаар тусгасан тохиолдолд хувьцаа эзэмшигчид хурлаа цахим хэлбэрээр явуулж болох хууль зүйн эх үүсвэрийг бий болгосон. Өөрөөр хэлбэл хувьцаа эзэмшигчдэд баримт бичиг, мэдэгдлийг цахим хэлбэрээр илгээх боломжтой болсон бөгөөд харилцаа холбооны цахим хэрэгслийг өргөн ашиглах нь тухайн компанийн үйл ажиллагааг илүү уян хатан болгож, мэдээллийг боловсруулах цагийг хэмнэх боломжийг олгосон.

2015 оны хоёрдугаар улирлаас эхлэн мөрдөгдөж эхэлсэн нэмэлт, өөрчлөлтөд харьяаллын нутаг дэвсгэрт байгаа аж ахуйн нэгжийг бүртгэхэд зөвхөн нэг баримт бичиг шаардагдах болсон. Компани бүртгүүлэхэд бүртгэлийн хоёр журмаас аль нэг

[266] БНСУ-ын “Компанийн тухай” хуулийн 17 дугаар зүйл. (сүүлд үзсэн огноо 2020.08.11). ““public company” means a company other than a private company”

[267] БНСУ-ын “Компанийн тухай” хуулийн 18 дугаар зүйл. (сүүлд үзсэн огноо 2020.08.11).

[268] БНСУ-ын “Компанийн тухай” хуулийн 31 дугаар зүйл. (сүүлд үзсэн огноо 2020.08.11).

хувилбарыг сонгон компанийн зөвхөн компанийн Үндсэн хуулийн хамт (компанийн дүрэм) бүртгүүлэх боломжийг бий болгосон болсон. Сингапурт бүртгэлтэй гадаадын компанийн тайлан орон нутгийн компаниудын санхүүгийн тайлангийн шаардлагад нийцүүлэн санхүүгийн тайлангаа гаргаж өгөх ёстой. Хэрэв стандартыг зөрчвөл гадаадын компани, түүний захирал эсвэл итгэмжлэгдсэн төлөөлөгч (төлөөлөгч) 50 мянган хүртэл сингапур долларaар торгуулах зохицуулалт зэргийг нэмсэн байна.

“Ковид-19”тахалтай холбоотой үүссэн эрх зүйн өөрчлөлтүүд.

“Ковид-19” тахалтай холбоотой Сингапур улс нь 2020 оны 14 дүгээр хуулиар батлагдсан “Ковид-19-тэй холбоотой түр арга хэмжээний тухай” хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу Хууль зүйн яамны сайдын гаргасан “Компани, Бизнесийн Траст, Нэгтгэсэн Траст, Үнэт цаасны хувьцаа эзэмшигчдийн хурлыг явуулах арга хэлбэрүүд”[269]-ийн тухай тушаалаар компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлыг зохицуулсан байна.

Тухайлбал, Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлыг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн цахим аргаар явуулах, тухайн компанийн хурлын товыг товлосон өдрөөс хойш нэг сарын дотор Сингапурын бирж дээр болон компанийн вебсайтад (хэрэв байгаа бол) нийтлэх, мөн хурлын үеэр хэлэлцэх асуудлын талаар хурал даргалагчид шуудан болон цахим шуудангаар хуралд оролцогчид хурал болохоос өмнө шаардлагатай бол явуулах, Компанийн хуралд оролцож буй гишүүн хурлын процессыг цахим хэлбэрээр сонсох боломжтой бөгөөд компани нь аудио болон визуал хэлбэрээр хурлын үйл ажиллагааг явуулж аудио болон визуал хэлбэрээр нэвтрэх боломжоор хангана гэж, хурлын талаарх мэдэгдлийг цахим хэлбэрээр хүргүүлж байгаа тохиолдолд хурлыг явуулах арга хэлбэр, уулзалтыг зохион байгуулж байгаа байршил, хурлын даргыг хэрхэн яаж сонгох, хурлын даргад хуралтай холбоотой мэдээллийг хэрхэн хүргүүлэх, бусад хуралтай холбоотой баримт бичгийн хамт хуралд оролцож байгаа гишүүнд хүргүүлэх тухай зохицуулжээ.

ДҮГНЭЛТ, САНАЛ

Аливаа эрх зүйн харилцаа тухайн улс болон дэлхий дахины чиг хандлага, нийгэм, улс төр, эдийн засгийн байдлаас хамаарч хувьсан өөрчлөгдөж, шинэчлэгдэн сайжрах шаардлагатай байдаг бөгөөд энэхүү судалгаа мөн тийм шаардлагаас үүдэлтэй. Тодруулбал, 2019 онд КОВИД-19 хэмээх цар тахал гарснаар дэлхий нийтийн эрүүл мэнд, нийгэм, эдийн засагт хүчтэй нөлөө үзүүлсэн билээ. Ялангуяа, нийгмийн хөгжлийг тодорхойлогч аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд мэдэгдэхүйц өөрчлөлт гарсан бөгөөд үүнтэй холбоотойгоор эрх зүйн орчныг шинэчлэх зүй ёсны шаардлага бий болсон гэж болох юм. Мөн үүнээс гадна өнөөг хүртэл үйлчилж ирсэн Компанийн тухай хуулийн тодорхой бус зарим зохицуулалтыг дүгнэх, нэмэлт, өөрчлөлт оруулах хэрэгцээ бий.

Монгол Улсын компанийн эрх зүйн харилцаа 1990 оноос хойш үе шаттайгаар тасралтгүй хөгжих арга замыг эрэлхийлж, нийт 4 удаа Компанийн тухай хуулийг шинэчилжээ. Ингэхдээ тухай бүрд шаардлагатай нэмэлт, өөрчлөлтийг хийж, шинэлэг зохицуулалтуудыг хуульчилсан байна.

Судалгаанд Компанийн тухай хуулийг бүхэлд нь бус тодорхой зохицуулалтыг сонгож, холбогдох асуудлыг гаргаж ирэхийг зорьсон билээ. Тухайлбал, Компанийн тухай хуулийг бүрдүүлдэг “суурь” зохицуулалт болох “хувьцаа эзэмшигчдийн хурал”, “хувьцаа эзэмшигч”, “төлөөлөн удирдах зөвлөл” зэргээс тулгамдаж буй асуудлыг тодорхойлж, нэмэлт, өөрчлөлт оруулах шийдлийг эрэлхийллээ. Түүнчлэн, КОВИД-19 цар тахлын нөхцөл байдалтай холбоотой компанийн эрх зүйн өөрчлөлт,

[269] Бүгд Найрамдах Сингапур Улсын эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем. https://sso.agc.gov.sg/Act/COVID19TMA2020#pr27- (сүүлд үзсэн огноо 2020.08.06).

шинэчлэлтийг тодорхойлохын тулд гадаадын 3 улсын туршлагыг хураангуй байдлаар харьцуулан судлав. Судалгааны тус хэсэгт эрх зүйн бүл, хил хязгаарын байршлыг харгалзан үзэж, ОХУ, БНХАУ, БНСУ-ыг сонгосон юм.

Судалгааны үр дүнд гарсан дүгнэлтэд үндэслэн дараах саналыг гаргаж байна. Үүнд:

- “Давуу эрхийн хувьцаа”-ны зохицуулалтыг нарийвчилж, нийт хувьцаанд ноогдох давуу эрхийн хувьцааны дээд хэмжээг тогтоох замаар хязгаарлалт хийх;
- Төрийн өмчит компанийн хувьцаа эзэмшигчийн хувьд эдлэх эрх болон төрийн байгууллагын хувьд эдлэх эрхийг нарийвчлан тодорхойлох;
- Жижиг хувьцаа эзэмшигчийн эрхийг хамгаалах зохицуулалтыг тодорхой болгох, хяналтын багц хувьцаа болон ХК-г ХХК болгон өөрчлөн байгуулах асуудалд жижиг хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрхэх талаар зохицуулах;
- Компанийг төлөөлөх эрх бүхий этгээдийн асуудлыг тодорхой болгох, гүйцэтгэх удирдлагаас бусад захирал, менежер зэрэг албан тушаалтны хэлцэл хийх, гэрээ байгуулах үед төлөөлөх эрхийн асуудлыг нарийвчлан зохицуулах;
- Хувьцаа эзэмшигчдийн хурал бүрэн эрхийнхээ хүрээнээс хальсан шийдвэр гаргах тохиолдолд хүлээлгэх хариуцлагын асуудлыг тодорхой зохицуулах;
- Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны тайлан гэж тусдаа байх учиртай тул хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал дээр зардал, цалин, урамшууллаас гадна өөрсдийн үйл ажиллагааны тайланг давхар танилцуулдаг болохыг хуульчлах;
- Ажилтанд хувьцаа эзэмшүүлж, ажилтан хувьцаа эзэмшигчийн төлөөллийг ТУЗ-д байлгах талаар хуульчлах эсэхийг хэлэлцүүлэг явуулах;
- КОВИД-19 цар тахлын нөхцөл байдлын улмаас үйл ажиллагаа нь доголдож, орлого буурсан аж ахуйн нэгжүүдийн байдлыг харгалзан үзэж, гагцхүү эм, эмнэлэгийн хэрэгсэл бус өөр бусад импортын бараанд татвар хөнгөлөлт үзүүлэх;
- КОВИД-19 цар тахалтай холбоотойгоор ХЭХ болон ТУЗ-ийн хурлыг цахимаар явуулах талаар хуульчлах боломжтой эсэх, эс бол хурлын огноог хуулиар хойшлуулж болох талаар нэмэлт, өөрчлөлт оруулах;
- КОВИД-19 цар тахал, цаашид өөр давагдашгүй хүчин зүйл гарсан тохиолдолд санхүүгийн жилийн тайлан илгээх хугацаа, өр төлбөр, алданги төлөх хугацаа зэргийг хойшлуулах талаар зохицуулах;
- Компанийг татан буулгах, хариуцлага хүлээх хугацааг цаг үеийн нөхцөл байдлаас хамааран хойшлуулах, хариу тайлбар өгөх хугацааг сунгаж болох эсэх талаар зохицуулах;
- КОВИД-19 цар тахлын нөхцөл байдалтай холбоотой цахим шилжилтийг төрийн болон төрийн бус байгууллагууд хийж байгаатай холбогдуулан аюулгүй байдлын талаар авах хэмжээг нэмэгдүүлэн уялдаа холбоог хангах;
- Дээр дурдсан өөрчлөлттэй холбогдуулан Компанийн тухай хуулиас гадна Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль зэрэгт холбогдох өөрчлөлтийг оруулах, хууль хоорондын уялдаа холбоог хангах, хүчингүй болсон хуулийн эшлэлийг өөрчлөн, найруулах.

Хуулийн үнэгүй хураалцаа www.mnlegal.mn

НОМ ЗҮЙ

Хууль

- Монгол Улсын Үндсэн хууль, *Төрийн мэдээлэл* эмхэтгэл (1992), №1;
- Иргэний хууль, *Төрийн мэдээлэл* эмхэтгэл (2002), №7;
- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, *Төрийн мэдээлэл* эмхэтгэл (2010), №20;
- Компанийн тухай хууль, *Төрийн мэдээлэл* эмхэтгэл (2011), №42;
- Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, *Төрийн мэдээлэл* эмхэтгэл (2013), №24;
- Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, *Төрийн мэдээлэл* эмхэтгэл (2018), №30;
- ОХУ-ын Үндсэн хууль, 1993 он;
- ОХУ-ын Хувьцаат компанийн тухай хууль, 1995 он;
- ОХУ-ын Хязгаарлагдмал хариуцлагтай компанийн тухай хууль, 1998 он;
- БНХАУ-ын Компанийн тухай хууль, 1993 он;
- БНСУ-ын Компанийн тухай хууль, 1966 он.

Судалгааны тайлан эмхэтгэл

- Ханнс Зайделийн сан, Эрх зүйн боловсрол академи, Арилжаа (худалдаа)-ны хуулийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах, УБ:2019 он;

Ном, сурах бичиг, гарын авлага, сэтгүүл

- Aspects of Company law in China, lecture of Professor Wen Shuangge, Jilin University, 2018;
- Aspects of Company law in China, lecture of Professor Wen Shuangge, Jilin University, 2018;
- Jiang Yu Wang “Overview of the company law regime in China”, 2014.
- Д.Байлыхүү, Компанийн төлөөлөн удирдах зөвлөл, УБ: Адмон принт, 2016 он;
- Д.Байлыхүү, *Хувьцаа болон хувьцаа эзэмшигчийн эрх, түүний хэрэгжүүлэлт*, УБ: Адмон принт, 2017 он;
- Д.Байлыхүү, Хувьцаа эзэмшигчдийн хурал, УБ: Адмон принт, 2016 он.
- Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2002 он, №7;
- Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2010 он, №30;
- Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2013 он, № 24;
- Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2018 он, №20;
- Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2018 он, №42;
- Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2020 он, №15;
- Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2020 он, №17;
- Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2020 он, №76;
- Хууль дээдлэх ёс сэтгүүл, ХЗҮХ, 2020 он, №76;
- Хууль зүйн үндэсний төв, Үнэт цаас, хөрөнгийн зах зээл бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ, эдийн засгийн өсөлт, *илтгэлийн эмхэтгэл*, УБ: ХЗҮТ, 2006 он;

Хуулийн үндэсний хүрээлэн www.nlrc.gov.mn

Цахим эх сурвалж

- China Collective Economy цахим хуудас,
  - http://www.ce2293.com/qkglxt/showl.sp?id=9289&fbclid=IwAR2G6Mrg9o_da1GRGYmtk8EK4EYiHiXtBhUKtFtsclAKlL_6CW0LbWbPPtM, (сүүлд үзсэн огноо 2019.01.02);
- БНХАУ-ын хайлтын систем- http://www.zlketang.com/news/kjsc/policydetail/3314.html?fbclid=IwAR08kV5eLvVSfH9Cc2OUWK9uRIVRPLNQERybwm61v7lZpABoXyXz0kZ4bF8 (сүүлд үзсэн: 2020.08.10);
- Бүгд Найрамдах Сингапур Улсын эрх зүйн мэдээллийн цахим хуудас, https://sso.agc.gov.sg/Act/CoA1967?ProvIds=P1I-#pr1- (сүүлд үзсэн огноо 2020.08.06);
- ОХУ-ын хуулийн нэгдсэн цахим хуудас,
  - www.consultant.ru/document/cons_doc_LAW_5142/8d8cd335130f04a7036c1eb50fff606c93fc643a/, (сүүлд үзсэн огноо 2020.08.10);
- Бүгд Найрамдах Сингапур Улсын эрх зүйн мэдээллийн цахим хуудас, https://sso.agc.gov.sg/Act/CoA1967?ProvIds=P1I-#pr1- (сүүлд үзсэн огноо 2020.08.06).
- Сайн дурын даатгалын хэлбэр, https://www.legalinfo.mn/annex/details/8551?lawid=13526, (сүүлд үзсэн огноо 2020.08.06).
- Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр, №649, 2018.04.04, http://new.shuukh.mn/irgenanhan/74995/view (УБ, 2018).
- “МФЦ”-ээс байгуулсан ажлын хэсгийн тайлан. http://www.mfc-moscow.com/assets/files/misc/corp_law_next_steps.pdf (сүүлд үзсэн огноо 2020.08.06).
- G20/OECD, Principles of Corporate Governance (Paris: OECD Publishing, 2015), p.26. http://dx.doi.org/10.1787/9789264236882-en;
- СЗХ-ны 2018 оны 12 сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолын хавсралт “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”, https://www.legalinfo.mn/annex/details/8870?lawid=13845;
- Гараджа, Ю. В. “ОХУ-ын компанийн тухай хууль тогтоомжийн цаашдын чиг хандлагад тулгарч буй асуудал”, Залуу эрдэмтэн. 20196 https://moluch.ru/archive/240/55502/;
- “Tax measures in response to COVID-19” Based on information received from countries as of 23/03/2020 04 PM GMT”, 2020. https://www.pwc.com/gx/en/assets/tax/covid-19-master-document-tax-measures.pdf

Хуулбарлах, нийтлэхийг хориглоно www.mlcgovin

ХАВСРАЛТ 1

КОМПАНИЙН ТУХАЙ ХУУЛЬТАЙ ХОЛБОГДОХ ХУУЛИЙН ЖАГСААЛТ

№	Хууль	Батлагдсан огноо	Холбогдох заалт	тайлбар
1.	Авлигын эсрэг хууль	2006.7.6	**4 дүгээр зүйл.Хуулийн үйлчлэлд хамаарах этгээд** 4.1.Доор дурдсан этгээд энэ хуулийн үйлчлэлд хамаарна: 4.1.3.төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах болон компанийн эрх бүхий албан тушаалтан;	Төрийн өмчит компанийн удирдах болон компанийн эрх бүхий албан тушаалтаны үйл ажиллагаанд хяналт оролцоог ханган авлигын эсрэг үйл ажиллагааг хэрэгжүүлдэг байна.
2.	Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай	2001.4.12	9 дүгээр зүйл.Ажлын байрны төлбөр, түүний хэмжээ 9.5.Гадаадын дипломат төлөөлөгчийн болон консулын газар, олон улсын байгууллагын суурин төлөөлөгчийн газар ажиллаж байгаа гадаадын иргэд, түүнчлэн боловсрол, шинжлэх ухаан, инновацийн салбар, гарааны компанид гэрээгээр ажиллаж байгаа гадаадын мэргэжилтэн, ажилтнууд Засгийн газар хоорондын гэрээнд заасан тохиолдолд уг гэрээгээр ажиллаж байгаа гадаадын мэргэжилтэн, ажилтнуудад, чөлөөт бүсэд үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгжид ажиллаж байгаа гадаадын мэргэжилтэн, ажилтанд энэ зүйлд заасан төлбөр хамаарахгүй.	
3.	Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай	2020.1.30	**ЗУРГАДУГААР БҮЛЭГ** **ТӨЛӨӨЛӨГЧИД НЭР ДЭВШҮҮЛЭХ, НЭР ДЭВШИГЧИЙГ БҮРТГЭХ** **28 дугаар зүйл.Нэр дэвшүүлэх нийтлэг журам** 28.3.Нэр дэвшигч нь хуульд заасан нийтлэг шаардлагаас гадна дараах шаардлагыг хангасан байна: 28.3.1.банк, бусад хуулийн этгээд, иргэнд шүүх болон арбитрын шийдвэрээр тогтоогдсон төлбөл зохих зээл, барьцаа болон батлан даалтын өр төлбөргүй байх; 28.3.2.татварын хугацаа хэтэрсэн өр төлбөргүй байх, аль нэг компанийн 51 ба түүнээс дээш хувийн хувьцаа эзэмшдэг бол тухайн компани нь албан татварын хугацаа хэтэрсэн өргүй байх.	

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХУРЭЭЛЭН
www.parliament.mn

4.	Аудитын тухай /Шинэчилсэн найруулга/	2015.6.19	**10 дугаар зүйл.Санхүүгийн тайланд заавал аудит хийлгэх** 10.1.Дараах аж ахуйн нэгж, байгууллага санхүүгийн тайландаа заавал аудит хийлгэнэ: 10.1.1.Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.1-д заасан стандартыг мөрдөх аж ахуйн нэгж, байгууллага; 10.1.2.нэгтгэсэн санхүүгийн тайлан гаргадаг аж ахуйн нэгж, байгууллага; 10.1.3.өөрчлөн байгуулагдаж байгаа болон татан буугдаж байгаа, эсхүл бүх хөрөнгөө дуудлага худалдаагаар худалдах гэж байгаа аж ахуйн нэгж, байгууллага; 10.1.4.гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, байгууллага; 10.1.5.Иргэний хуулийн 36.2-т заасан сан; 10.1.6.хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд санхүүгийн тайландаа заавал аудит хийлгэхээр заасан бусад аж ахуйн нэгж, байгууллага. 10.2.Энэ хуулийн 10.1-д заасан аж ахуйн нэгж, байгууллага санхүүгийн тайлангийн аудитыг дараах хугацаанд хийлгэсэн байна: 10.2.1.хувьцаат компани нь тайлангийн жилийн эцсийн санхүүгийн тайланг хэлэлцэх хувьцаа эзэмшигчдийн хурлаас хоёр ба түүнээс доошгүй долоо хоногийн өмнө;	
5.	Ашигт малтмалын тухай (Шинэчилсэн найруулга)	2006.7.8	ДОЛДУГААР БҮЛЭГ Тусгай зөвшөөрлийг шилжүүлэх, барьцаалах 49 дүгээр зүйл. Тусгай зөвшөөрлийг шилжүүлэх 49.1.Хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Иргэний хууль, Компанийн тухай, Нөхөрлөлийн тухай хуульд заасны дагуу нэгдэх, нийлэх хэлбэрээр өөрчлөн байгуулагдсан тохиолдолд шинээр бий болсон эрх хүлээн авагчид, түүнчлэн хараат, охин компани нь толгой компанидаа тусгай зөвшөөрлийг шилжүүлж болно.	Энэхүү хууль батлагдах явцад нэгдэх, нийлэх хэлбэрээр өөрчлөн байгуулагдсан тохиолдолд шинээр бий болсон эрх хүлээн авагчид, түүнчлэн хараат, охин компани нь толгой компанидаа тусгай зөвшөөрлөө шилжүүлэх талаар тусгайлан зааж өгсөн нь хараат болон охин компанийн хувьцааг авах, шилжүүлэх эрхийг нээлттэй болгосон нь бусад улсын нэртэй толгой компанитай нэгдэн нийлэх хэлбэрээр өөрчлөгдсөн тохиолдолд тухайн гадны толгой комапанид эрх шилжүүлэх зөвшөөрлийг хуулиар олгосон зохицуулалт болжээ.
6.	Ашигт малтмалын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай	2006.7.8	**2 дугаар зүйл.** 2006 оны 7 дугаар сарын 8 -ны өдөр батлагдсан Ашигт малтмалын тухай хуулийг дагаж мөрдөхөөс өмнө тухайн үед мөрдөгдөж байсан хууль тогтоомжийн дагуу олгогдсон тусгай зөвшөөрөл /лиценз/-ийг эзэмшигч иргэн түүнийг үргэлжлүүлэн эзэмшихийг хүсвэл хууль тогтоомжийн дагуу компани, нөхөрлөл байгуулан шинэ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 6 сарын хугацаанд тусгай зөвшөөрлийг шинэчлэн бүртгүүлэх, эсхүл шинэ хуулийн дагуу тусгай зөвшөөрөл эзэмших эрх бүхий этгээдэд шилжүүлж болно.	

ХУУЛЬ ЗҮЙН ЯАМНЫ ХҮРЭЭЛЭН www.legal.mn

7.	Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай	2002.12.12	5.1. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийг Компанийн тухай хуульд заасны дагуу үүсгэн байгуулна.	Бүхэлдээ хамаарна. Хуулийн төгсгөлд Компанийн тухай -"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1999 оны 34 дүгээрт нийтлэгдсэн тухай заасныг засах
8.	Банкны салбарын тогтвортой байдлыг хангах тухай	2018.6.22	12.11.Банкны гүйцэтгэх удирдлагыг Компанийн тухай хууль болон Банкны тухай хуульд заасны дагуу банкны төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр томилж, чөлөөлнө.	Бүхэлдээ хамаарна.
9.	Банкны тухай (Шинэчилсэн найруулга)	2010.1.28	3.1.1."банк" гэж хувьцаа эзэмшигчдийн оруулсан мөнгөн хөрөнгөөс бүрдсэн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй, хувьцаа эзэмшигч нь эзэмшиж байгаа хувьцааны хэмжээгээр хариуцлага хүлээдэг, бусдын мөнгөн хөрөнгийг хуримтлуулан хадгалж, өөрийн нэрийн өмнөөс зээл олгох, төлбөр тооцоо хийх зэрэг санхүүгийн зуучлалын үйл ажиллагааг Монголбанкны тусгай зөвшөөрөлтэйгээр эрхэлдэг, ашгийн төлөө хуулийн этгээдийг; 31.2.Хувьцаат компанийн хэлбэрээр байгуулагдсан банкны төлөөлөн удирдах зөвлөл ес ба түүнээс дээш, хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хэлбэрээр байгуулагдсан банкны төлөөлөн удирдах зөвлөл тав ба түүнээс дээш гишүүнтэй байна. 29.2.Банкны хувьцаа эзэмшигчдийн хурал дараахь асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ: 29.2.10.банкны хянан шалгагч /хянан шалгах зөвлөл/-ийн асуудлыг Компанийн тухай хуулийн 92 дугаар зүйлийн дагуу зохицуулах.	Бүхэлдээ хамаарна. Компанийн тухай хуулийн 92 дугаар зүйлийг ишлэл авсан нь 2011 оны хуультай нийцэхгүй байна.
10.	Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай	2018.1.18	1 дүгээр зүйл.Банкны хараат болон охин компанид банкнаас оруулсан хувь хөрөнгө буюу хувьцаа эзэмших эрх 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөр дуусгавар болно.	бүхэлдээ
11.	БНМАУ-ын өмч хувьчлах тухай хууль	1991.5.22	17 дугаар зүйл. Их хувьчлалыг хэрэгжүүлэх арга Их хувьчлалыг БНМАУ-ын иргэд эрхийн бичгээ оролцуулан үйлдвэрийн газрын хувьцааг худалдан авч хувьцаат компани байгуулах замаар хэрэгжүүлнэ.	бүхэлдээ
12.	Валютын зохицуулалтын тухай	1994.5.12	1. Эрх бүхий банк, бирж, брокерийн компаниас эрэлт нийлүүлэлтийн үндсэн дээр хийж байгаа валютын худалдаа арилжааны үйл ажиллагааг Монгол Улсын валютын зах гэнэ.	бүхэлдээ

Хуулийн хүрээлэн
law.mn

13.	Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай	2001.10.18	1 дүгээр зүйл. БНМАУ-ын иргэний паспортыг Монгол Улсын иргэний үнэмлэхээр солих үйлчилгээнд хэрэглэх зорилгоор Англи Улсын “Де Ла Ру” компаниас оруулж ирсэн болон ирэх дор дурдсан тоо, хэмжээ бүхий иргэний үнэмлэх хэвлэх материал, хэвлэлийн тоног төхөөрөмж, түүний сэлбэг хэрэгслийг 2002 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд гаалийн албан татвараас чөлөөлсүгэй:	2002 онд иргэний үнэмлэхийг шинэчлэх зорилгоор тоног төхөөрөмж, бусад дагалдах хэрэгслийг оруулж байжээ.
14.	Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай /Шинэчилсэн найруулга/	2010.7.8	15 дугаар зүйл.Визийн ангилал 15.1.Тухайн гадаадын иргэний хилээр нэвтрэх зорилгыг үндэслэн дараахь ангиллын виз олгоно: 15.1.6.“S” ангиллын визийг суралцах, мэргэжил дээшлүүлэх болон дадлага, эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх, эрдэм шинжилгээний байгууллага болон инновацийн салбарын гарааны компанид эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг хөдөлмөрийн гэрээгээр хийх зорилгоор ирэх гадаадын иргэнд;	
15.	Газрын тосны бүтээгдэхүүний тухай	2005.7.1	4 дүгээр зүйл.Хуулийн нэр томъёо 4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно: 4.1.5.“компанийн нөөц” гэж газрын тосны бүтээгдэхүүний бөөний худалдаа, үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн хангамж, худалдааны хэвийн үйл ажиллагааг тасралтгүй явуулахад шаардагдах хэмжээний тухайн этгээдийн эзэмшлийн агуулах, саванд хадгалагдаж байгаа газрын тосны бүтээгдэхүүнийг; 5 дугаар зүйл.Газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаа, тээвэрлэлт, хадгалалтын талаархи Засгийн газар болон газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх 5.1.Газрын тосны бүтээгдэхүүний талаар Засгийн газар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 5.1.3.газрын тосны бүтээгдэхүүний бөөний худалдаа, үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч компанийн нөөцийн хэмжээ, нөөц бүрдүүлэх журмыг батлах; **13 дугаар зүйл.Газрын тосны бүтээгдэхүүний нөөц** 13.1.Газрын тосны бүтээгдэхүүний нөөц нь улсын болон компанийн нөөцөөс бүрдэнэ. 13.2.Улсын нөөцийг Засгийн газраас баталсан журмын дагуу бүрдүүлнэ. 13.3.Газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл, бөөний худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Засгийн газраас тогтоосон журмын дагуу компанийн нөөцийг бүрдүүлнэ.	

ХУУЛЬ ЗҮЙН ЯАМНЫ ХЭРЭГЛЭЭНД ЗОРИУЛСАН ХУВИЛБАР

16.	Газрын тосны тухай /Шинэчилсэн найруулга/	2014.7.1	**4 дүгээр зүйл.Хуулийн нэр томьёоны тодорхойлолт** 4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно: 4.1.11.“гэрээлэгч” гэж Монгол Улсын нутаг дэвсгэрт газрын тос, уламжлалт бус газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа эрхлэх гэрээ байгуулсан компанийг; 4.1.12.“оператор компани” гэж гэрээлэгчийн газрын тос, уламжлалт бус газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа эрхлэх Монгол Улсад бүртгэлтэй, татвар төлөгч компанийг; 4.1.13.“туслан гүйцэтгэгч” гэж газрын тостой холбогдсон үйл ажиллагааны тодорхой хэсгийг гүйцэтгэхээр гэрээлэгчтэй, эсхүл оператор компанитай гэрээ байгуулсан, Монгол Улсад бүртгэлтэй, татвар төлөгч хуулийн этгээдийг; 11.4.Оператор компани нь Компанийн тухай хуульд заасан эрх, үүргээс гадна энэ хуулийн 11.2.1-11.2.8, 11.2.12-11.2.20-д заасан үүргийг хүлээнэ. 11.5.Туслан гүйцэтгэгч нь Компанийн тухай хуульд заасан эрх, үүргээс гадна энэ хуулийн 11.2.1, 11.2.7, 11.2.10-11.2.12, 11.2.15-д заасан үүргийг хүлээнэ. **41 дүгээр зүйл.Даатгал** 41.1.Гэрээлэгч болон туслан гүйцэтгэгч нь газрын тостой холбогдсон үйл ажиллагаа, эд хөрөнгө, ашиг сонирхлоо Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу Монгол Улсын даатгалын эрх бүхий компаниар даатгуулж болно. 41.2.Монгол Улсын даатгалын эрх бүхий компани нь энэ хуулийн 41.1-д заасан даатгалыг хийхээс татгалзсан тохиолдолд гадаад улсын даатгалын хуулийн этгээдээр даатгуулж болно.	
17.	Даатгалын тухай (Шинэчилсэн найруулга)	2004.4.30	4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно: 4.1.2.“даатгагч” гэж энэ хуулийн дагуу даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан компанийг; 4.1.11.“эрх бүхий албан тушаалтан” гэж Компанийн тухай хуулийн 81.1-д заасан этгээдийг.	бүхэлдээ хамаарна
18.	Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай	2004.4.30	23.2.Даатгалын компанид Компанийн тухай хуулийн 45 дугаар зүйл хамаарахгүй.	1999 оны Компанийн тухай хуулийн 45 дугаар зүйлд төлбөрийн талаар дурдсан нь 2011 оны хуульд 45 дугаар зүйл.Үнэт цаас эзэмшигчдийн бүртгэлтэй холбоотой зохицуулалт орсон нь өөр хоорондоо нийцэхгүй байна.

Хуулийн мэдээллийн хүрээлэн www.legal.mn

19.	Дампуурлын тухай	1997.11.20	**1 дүгээр зүйл.Хуулийн зорилт** 1.1.Энэ хуулийн зорилт нь дампуурлын хэрэг үүсгэх, хянан шийдвэрлэх, төлбөрийн чадваргүй аж ахуйн нэгжийг дахин хөрөнгөжүүлэх, татан буулгахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино. 3.1.2.”хариуцагч” гэж тусгай зориулалтын компани, орон сууцны санхүүжилтийн компаниас бусад төлбөрийн чадваргүй болсон нөхөрлөл, хоршоо, компани, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, хуулийн этгээдийн эрх бүхий төрийн бус байгууллагыг; 11.3.Дор дурдсан этгээд, түүний гэр бүлийн гишүүнийг хэрэг гүйцэтгэгчээр томилохыг хориглоно: 11.3.2.хувьцаат компаниас бусад хариуцагч хуулийн этгээдийн гишүүн;	
20.	Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай	2011.7.9	12.4.Дээд боловсролын сургалтын байгууллага санхүүгийн хувьд бие даасан байдлаа хадгалах талаар дараахь үйл ажиллагаа эрхэлнэ: 12.4.1.судалгаа, шинжилгээ, зөвлөгөө өгөх үйл ажиллагааны үр дүн, бүтээгдэхүүнийг зах зээлд худалдан борлуулах зорилгоор гарааны компани байгуулж ажиллуулах;	
21.	Дээд боловсролын тухай	2002.5.3	5 дугаар зүйл. Дээд боловсролын сургалтын байгууллагын зохион байгуулалтын бүтэц 5.2.Их сургууль харьяалалдаа дээд сургууль, коллеж, технологийн коллеж, эрдэм шинжилгээний байгууллага, гарааны компани, ахлах сургуультай байж болно. */Энэ хэсгийг 2016 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/* 5.6.Дээд боловсролын сургалтын байгууллага нь хамтарсан болон дагнасан сургалт, эрдэм шинжилгээ, инновацийн үйл ажиллагаа явуулах зориулалт бүхий үйлдвэрлэл, үйлчилгээний түшиц байгууллага, гарааны компани, лаборатори, эмнэлэг, дадлагын бааз, туслах аж ахуйтай байж болно. 11.7.Ашгийн төлөө дээд боловсролын сургалтын байгууллагын удирдлагыг Компанийн тухай хуулиар зохицуулна. **14 дүгээр зүйл.Багшийн эрх, үүрэг** 14.1.Багш Боловсролын тухай хуулийн 44.1-д зааснаас гадна дараахь эрхтэй: 14.1.4.дангаараа болон их сургууль, дээд сургууль, эрдэмтдийн баг, хуулийн этгээдтэй хамтран ажиллах болон гарааны компани байгуулах. */Энэ заалтыг 2016 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар нэмсэн/* магистрант, докторын шатлалд суралцагчийг докторант гэнэ. 16 дугаар зүйл.Суралцагчийн эрх, үүрэг 16.1.Суралцагч Боловсролын тухай хуулийн 45.1-д зааснаас гадна дараахь эрхтэй: 16.1.8.их сургууль, дээд сургуулийн дэргэд байгуулагдсан гарааны компанид хичээлийн бус цагаар ажиллах, өөрөө гарааны компани байгуулах. */Энэ заалтыг 2016 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар нэмсэн/*	

22.	Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай /Шинэчилсэн найруулга/	2019.6.6	**3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ** 3.1.Энэ хууль Монгол Улсын нутаг дэвсгэрт байнга байрлан үйл ажиллагаа эрхэлдэг улсын бүртгэлд бүртгүүлсэн ашиг олох зорилго бүхий дотоодын жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгжид үйлчилнэ. 3.2.Төрийн бус байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, түүний оролцоотой компани, улсын төсөвт үйлдвэрийн газар, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой газар, гадаад улсын хуулийн этгээд энэ хуулийн зохицуулалтад хамаарахгүй. **ХОЁРДУГААР БҮЛЭГ** **ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭР, ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧ** **5 дугаар зүйл.Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч** 5.5.Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч нь компани, хоршоо, нөхөрлөлийн хэлбэрээр үйл ажиллагаа явуулна.	бүхэлдээ хамаарнаv
23.	Залуучуудын хөгжлийг дэмжих тухай	2017.5.18	**11 дүгээр зүйл.Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих** 11.1.Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дараахь чиглэлээр дэмжинэ: 11.1.3.гадаад улсын тэргүүн туршлага, өндөр технологи, шинэ санааг үндэсний технологи болгон нутагшуулах, гарааны компани эрхлэхэд нь дэмжлэг үзүүлэх; **20 дугаар зүйл.Залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг** 20.5.Залуучуудын хөгжлийн төв нь дараахь чиг үүрэгтэй: 20.5.7.залуучуудын гарааны компани эрхлэхийг дэмжих чиглэлээр орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн байгууллагатай хамтран ажиллах.	
24.	Зөрчлийн тухай /шинэчилсэн найруулга/	2017.5.11	**АРВАН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ** **ҮНЭТ ЦААС, БАНК, САНХҮҮ, ГААЛЬ, ТАТВАР, МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТ, ДААТГАЛЫН ЖУРМЫН ЭСРЭГ ЗӨРЧИЛ** 10.11 дүгээр зүйл.Компанийн тухай хууль зөрчих 11.10 дугаар зүйл.Үнэт цаасны зах зээлийн тухай хууль зөрчих	
25.	Зөрчлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай	2017.5.18	Компанийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай,…	

ХЭВЛЭЛИЙН ЭРХТЭЙ ХУРЭЭЛЭН
www.parliament.mn

26.	Зээлийн мэдээллийн тухай	2011.10.20	**ХОЁРДУГААР БҮЛЭГ** **ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН САН, ТҮҮНИЙГ БҮРДҮҮЛЭХ, АШИГЛАХ** **6 дугаар зүйл.Зээлийн мэдээлэл** 6.2.6.толгой, хараат, охин компани болон тэдгээрийн Банкны тухай хуулийн 3.1.2-т заасан холбогдох этгээд, Компанийн тухай хуулийн 99.1-д заасан нэгдмэл сонирхолтой этгээдийн нэр, улсын бүртгэлийн болон регистрийн дугаар, оршин байгаа газрын хаяг, утасны дугаар, цахим шуудангийн хаяг; 11 дүгээр зүйл.Зээлийн лавлагаа өгөх 11.8.Зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдээс Компанийн тухай хуулийн 84.1-д заасан өөрийн эрх бүхий албан тушаалтан, хувьцаа эзэмшигчийн талаарх зээлийн лавлагаа гаргаж өгөх журмыг Монголбанк тогтооно. **ЗУРГАДУГААР БҮЛЭГ** **МОНГОЛБАНКНЫ ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН САН** **28 дугаар зүйл.Монголбанкны зээлийн мэдээллийн сантай мэдээлэл солилцох** 28.2.Банк, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж, зээлийн хоршоо, санхүүгийн түрээс /лизинг/-ийн компани, төрийн байгууллага нь иргэн, хуулийн этгээдээс зөвшөөрөл авсан эсэхээс үл хамааран Монголбанкны мэдээллийн санд зээлийн мэдээллийг тогтмол өгнө.	
27.	Инновацийн тухай	2012.5.22	**3 дугаар зүйл.Хуулийн нэр томьёоны тодорхойлолт** 3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно: 3.1.8.“гарааны компани” гэж инновацийн бүтээгдэхүүн шинээр үйлдвэрлэх зорилгоор үүсгэн байгуулагдсан компанийг; */Энэ заалтыг 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./* 3.1.9.“технологийн туршилт, зүгшрүүлэлт” гэж лабораторийн түвшинд боловсруулсан технологи, бүтээгдэхүүний загварыг үйлдвэрлэлийн нөхцөлд турших, боловсронгуй болгох, технологийн баримтжуулалт хийх үйл ажиллагааг; 3.1.10.“роялти” гэж оюуны өмчийг лицензийн гэрээгээр ашиглан олсон ашгаас лицензэд түрээслүүлэгчид ногдох хувь хэмжээг; 3.1.11.“хөрөнгө оруулалтын компани” гэж инновацийн үйл ажиллагааг санхүүжүүлэхэд чиглэгдсэн, энэ хуульд заасан үйл ажиллагаа эрхлэх зорилгоор Иргэний хуульд[8] заасны дагуу байгуулагдсан хуулийн этгээдийг; /Энэ заалтад 2013 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/ 3.1.12.“менежментийн гэрээ” гэж энэ хуулиар тогтоосон шаардлагад нийцүүлэн хөрөнгө оруулалтын компанийн активыг удирдах талаар уг хөрөнгө оруулалтын компанийн удирдлага менежментийн компанитай байгуулсан гэрээг; /Энэ заалтад 2013 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/ 3.1.13.“менежментийн компани” гэж хөрөнгө оруулалтын компанитай байгуулсан энэ хуулийн 3.1.12-т заасан гэрээний үндсэн дээр уг хөрөнгө оруулалтын компанийн активын удирдлагыг хэрэгжүүлж байгаа тусгай зөвшөөрөл бүхий компанийг; /Энэ заалтад 2013 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/ 3.1.18.“зөвлөх компани” гэж эрдэм шинжилгээний байгууллага, түүний дэргэд байгуулагдсан гарааны компанийн инновацийн бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлж эдийн засгийн эргэлтэд оруулахад дэмжлэг үзүүлэх бусад этгээдэд гарааны компанийн өөрийн эзэмшлийн хувийг борлуулах зорилгоор байгуулагдсан компанийг. */Энэ заалтыг 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн хуулиар нэмсэн./*	

28.	Иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг төрөөс нэг удаа төлөх тухай	2020.1.10	**5 дугаар зүйл.Тэтгэвэр барьцаалсан зээлийг төлөх арга хэмжээ, түүний санхүүжилтийн эх үүсвэр** 5.1.Төрийн өмчит "Эрдэнэс Монгол" ХХК өөрийн охин компанийн эзэмшлийн Салхитын мөнгө, алтны ордыг эдийн засгийн эргэлтэд оруулсан орлогоос төрд ногдох өгөөжийг барьцаалан үнэт цаас гаргах замаар иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн тодорхой хэсгийг төлнө. 5.2.Төрийн өмчит "Эрдэнэс Монгол" ХХК иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн үүргийг үнэт цаас гаргаж төлөх гэрээг холбогдох банк тус бүртэй байгуулна. 5.3.Монгол Улсын Хөгжлийн банк энэ хуулийн 5.1-д заасан үнэт цаасанд хууль тогтоомжид нийцүүлэн бие даан баталгаа гаргах бөгөөд уг баталгаанд зориулж төрийн өмчийг барьцаалахад Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт хамаарахгүй. 5.4.Монголбанк энэ хуулийн 5.1-д заасан үнэт цаасыг Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 2, 4 дэх заалтад заасан хэрэгслийг ашиглан худалдан авна. 5.5.Тэтгэврийн зээлийг төлөхтэй холбоотойгоор энэ хуулийн 5.1-д заасан төрийн өмчит компани зээл авах болон үнэт цаас гаргахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 16 дахь хэсэгт заасан зөвшөөрлийг авахгүй. 5.6.Энэ хуулийн 5.4-т заасны дагуу үнэт цаас эзэмшсэнээс Монголбанкны өөрийн хөрөнгө буурсан тохиолдолд Засгийн газар үнэт цаас гаргаж, Монголбанканд эзэмшүүлэх замаар нөхнө. 5.7.Энэ хуулийн 5.4-т заасны дагуу Монголбанк үнэт цаас худалдан авахад Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4, 7 дахь заалт хамаарахгүй.	
29.	Иргэний хууль	2002.1.10	33 дугаар зүйл. Хуулийн этгээдийн төрөл 33.1.Ашгийн төлөө хуулийн этгээдийг нөхөрлөл, компанийн хэлбэрээр байгуулна. 33.2.Ашгийн төлөө бус хуулийн этгээдийг холбоо, сан, хоршооны хэлбэрээр байгуулна. Хэвлэх 34 дүгээр зүйл. **Компани** 34.1.Хувьцаа эзэмшигчийн оруулсан хөрөнгө нь тодорхой тооны хувьцаанд хуваагддаг, өөрийн тусгайлсан хөрөнгөтэй, ашгийн төлөө үндсэн зорилготой хуулийн этгээдийг компани гэнэ. /Энэ хэсэгт 2011 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/ 34.2.Компанийн эрх зүйн байдлыг хуулиар тогтооно.	

ХУУЛЬ ЗҮЙН ХҮРЭЭЛЭН
www.legal.mn

30.	Ирээдүйн өв сангийн тухай	2016.2.5	4 дүгээр зүйл. Хуулийн нэр томьёоны тодорхойлолт 4.1.13.“хөрөнгө оруулалтын менежментийн компани” гэж Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4.1.33-т заасан этгээдийг; **8 дугаар зүйл. Сангийн эх үүсвэрийг төвлөрүүлэх** 8.4.Улсын төсөв, Сан, Корпораци, кастодиан, хөрөнгө оруулалтын менежментийн компани хооронд Сангийн хөрөнгө шилжүүлэх журам, дансны зааврыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. 25 дугаар зүйл. Корпорацийн гүйцэтгэх удирдлага 25.19.Гүйцэтгэх удирдлага удирдах зөвлөлийн зөвшөөрөлтэйгээр Сангийн хөрөнгийн зарим хэсгийг гэрээний үндсэн дээр хөндлөнгийн хөрөнгө оруулалтын менежментийн компаниар гүйцэтгүүлж болно. 25.20.Хөндлөнгийн хөрөнгө оруулалтын менежментийн компани, кастодианы байгууллага болон Корпорацийн хооронд байгуулах гэрээг удирдах зөвлөлөөс зөвшөөрөл авсны үндсэн дээр гүйцэтгэх удирдлага байгуулна. Хэвлэх 26 дугаар зүйл. Хойшлуулшгүй арга хэмжээ 26.1.Хөрөнгө оруулалтын менежментийн компани, эсхүл кастодиантай холбогдуулан доор дурдсан нөхцөл бий болсон, түүнчлэн дараахь бусад нөхцөл үүссэн тохиолдолд гүйцэтгэх удирдлага санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, удирдах зөвлөлд нэн даруй мэдэгдэнэ: **ЗУРГАДУГААР БҮЛЭГ** **ТАЙЛАГНАЛ, ИЛ ТОД БАЙДАЛ, ХЯНАЛТ** **27 дугаар зүйл. Нягтлан бодох бүртгэл** 27.1.Корпораци өөрийн хөрөнгө болон Сангийн хөрөнгийн нягтлан бодох бүртгэлийг тус тусад нь бүртгэнэ. 27.2.Корпорацийн хөндлөнгийн хөрөнгө оруулалтын менежментийн компаниар гэрээгээр гүйцэтгүүлж байгаа хөрөнгийн нягтлан бодох бүртгэлийг менежментийн компани тус бүрээр бүртгэнэ. 29.2.3.Сангийн хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд оролцох Хөрөнгө оруулалтын менежментийн компани, кастодианы байгууллага болон бусад оролцогчийн нэр;	

31.	Малын индексжүүлсэн даатгалын тухай хууль	2014.6.13	**4 дүгээр зүйл.Хуулийн нэр томьёо** 4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно: 4.1.1.“малын индексжүүлсэн даатгалын үйл ажиллагаа” гэж даатгуулагчид учирсан бодит хохирлоор бус, даатгалын хамрах хугацаанд сумын хэмжээнд гарсан том малын хорогдлын хувь босго үзүүлэлтээс давсан тохиолдолд босго үзүүлэлтээс давсан хувь болон даатгалын үнэлгээнээс тооцож, даатгуулагчид нөхөн төлбөр олгох даатгалын үйл ажиллагаа буюу Даатгалын тухай хуулийн 4.3-т заасан үйл ажиллагааг; 4.1.9.“малын давхар даатгалын компани /цаашид “давхар даатгалын компани” гэх/ гэж энэ хуулийн 18.1-д заасан давхар даатгалын үйл ажиллагаа эрхлэн явуулах, тусгайлсан чиг үүрэг бүхий хуулийн этгээдийг; 4.1.14.“малын давхар даатгалын гэрээ” /цаашид “давхар даатгалын гэрээ” гэх/ гэж даатгагч даатгуулагчийн өмнө хүлээсэн үүргээ давхар даатгалын компанид хэсэгчлэн шилжүүлэхээр харилцан тохиролцсон хэлцлийг; 4.1.15.“олон улсын давхар даатгалын гэрээ” гэж давхар даатгалын компани даатгагчийн өмнө хүлээсэн үүргээ багцлан гадаад улсын давхар даатгалын компанид бүрэн, эсхүл хэсэгчлэн шилжүүлэхээр харилцан тохиролцсон хэлцлийг. **11 дүгээр зүйл.Даатгалын эрсдэлийн хуваарилалт** 11.1.Даатгалын эрсдэлийг доор дурдсан этгээд дараах байдлаар хариуцна: 11.1.3.энэ хуулийн 11.1.1, 11.1.2-т заасаас бусад эрсдэлийг давхар даатгалын компани энэ хуулийн 27.1-д заасан сангийн хөрөнгөөр. **ГУРАВДУГААР БҮЛЭГ** **МАЛЫН ИНДЕКСЖҮҮЛСЭН ДААТГАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА** **13 дугаар зүйл.Малын индексжүүлсэн даатгалын үйл ажиллагаа эрхлэх** 13.1.Даатгалын компани /цаашид “даатгагч” гэх/ дараах шаардлагыг хангасан тохиолдолд малын индексжүүлсэн даатгалын үйл ажиллагаанд оролцоно: 13.1.1.Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлд малын индексжүүлсэн даатгалын төрлийг зөвшөөрсөн байх; 13.1.2.энэ хуулийн 18.1-д заасан компанитай давхар даатгалын гэрээ байгуулсан байх. **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ** **ДАВХАР ДААТГАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА** **18 дугаар зүйл.Давхар даатгалын компанийн эрх зүйн байдал**	

32.	Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай	2019.12.20	**1 дүгээр зүйл.Хуулийн зорилт** 1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийг зохион байгуулж явуулах үндсэн зарчим, журмыг тодорхойлж, түүнтэй холбогдсон харилцааг зохицуулах, Монгол Улсын иргэний сонгох, сонгогдох эрхийг хангахад оршино. **РГАДУГААР БҮЛЭГ** **УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНД НЭР ДЭВШҮҮЛЭХ, НЭР ДЭВШИГЧИЙГ БҮРТГЭХ** **29 дүгээр зүйл.Нэр дэвшүүлэх нийтлэг журам** 29.3.Нэр дэвшигч хуульд заасан нийтлэг шаардлагаас гадна дараах шаардлагыг хангасан байна: 29.3.1.банк, бусад хуулийн этгээд, иргэнд шүүх болон арбитрын шийдвэрээр тогтоогдсон төлбөл зохих зээл, барьцаа болон батлан даалтын өр төлбөргүй байх; 29.3.2.татварын хугацаа хэтэрсэн өр төлбөргүй байх, аль нэг компанийн 51, түүнээс дээш хувийн хувьцаа эзэмшдэг бол тухайн компани нь албан татварын хугацаа хэтэрсэн өргүй байх.	
33.	Монгол Улсын Их Хурлын тухай */шинэчилсэн найруулга/*	2020.5.7	**43 дугаар зүйл.Гишүүнд хориглох үйл ажиллагаа** 43.1.Гишүүнд дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно: 43.1.6.бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй нь холбогдуулан олгосон санхүүгийн эх үүсвэр, холбоо, мэдээлэл, тээврийн хэрэгсэл, төрийн өмчийн бусад эд зүйлийг ашиг хонжоо олох зорилгоор, эсхүл сонгуулийн компанит ажилд ашиглах;	
34.	Монгол Улсын хөгжлийн банкны тухай */шинэчилсэн найруулга/*	2017.2.10	**5 дугаар зүйл. Хөгжлийн банкны эрх зүйн байдал** 5.1.Хөгжлийн банк нь үндэсний эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах тэргүүлэх салбаруудад хэрэгжих төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх, импортыг орлох, экспортын орлогыг нэмэгдүүлэх үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх зорилготой, энэ хуулийн 8.1-д заасан үйл ажиллагааг эрхлэх чиг үүрэг бүхий ашгийн төлөө хуулийн этгээд байна. 5.2.Хөгжлийн банкийг байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэрийг Засгийн газар гаргана. **6 дугаар зүйл. Хөгжлийн банкны өөрийн хөрөнгө** 6.1.Хөгжлийн банкны хувь нийлүүлсэн хөрөнгө нь хувьцаа эзэмшигчийн оруулсан хөрөнгөөс бүрдэх бөгөөд түүний хэмжээг хувьцаа эзэмшигч тогтооно. 6.2.Хөгжлийн банк нь тухайн жилийн цэвэр ашгаас хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлж, үлдэх хэсгээр алдагдлыг нөхөх зорилго бүхий нөөц сан байгуулна. 6.3.Хөгжлийн банкны алдагдлыг нөөц сангийн хөрөнгөөр нөхөх боломжгүй тохиолдолд нэмэлт хөрөнгө олгох эсэхийг хувьцаа эзэмшигч шийдвэрлэнэ. 6.4.Энэ хуулийн 6.2-т заасан санг бүрдүүлэх, түүнийг удирдах журмыг төлөөлөн удирдах зөвлөл батална. **7 дугаар зүйл. Хөгжлийн банкны баримтлах зарчим** 7.1.Хөгжлийн банк нь үйл ажиллагаандаа компанийн сайн засаглалын дараахь зарчмыг баримтална: 7.1.1.ашигтай ажиллах; 7.1.2.үйл ажиллагаагаа тогтвортой явуулах; ... **19 дүгээр зүйл. Төлөөлөн удирдах зөвлөл** 19.1.Хөгжлийн банкны төлөөлөн удирдах зөвлөл есөн гишүүнтэй байх бөгөөд тэдгээрийн дөрөв нь хараат бус гишүүн байна. 19.2.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг хувьцаа эзэмшигчид нээлттэй сонгон шалгаруулалтаар сонгон гурван жилийн хугацаагаар томилж, Компанийн тухай хуульд заасан үндэслэлээр чөлөөлнө. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг нэг удаа улируулан томилж болно.	**Хөгжлийн банк нь ашгийн төлөө хуулийн этгээд байх бөгөөд** Хөгжлийн банкны хувь нийлүүлсэн хөрөнгө нь хувьцаа эзэмшигчийн оруулсан хөрөнгөөс бүрдэх бөгөөд түүний хэмжээг хувьцаа эзэмшигч тогтоох, цэвэр ашгаас хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлж, үлдэх хэсгээр алдагдлыг нөхөх зорилго бүхий нөөц сан байгуулах, алдагдлыг нөөц сангийн хөрөнгөөр нөхөх боломжгүй тохиолдолд нэмэлт хөрөнгө олгох эсэхийг хувьцаа эзэмшигч шийдвэрлэнэ.

35.	Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай /Шинэчилсэн найруулга/	2013.5.31	ХОЁРДУГААР БҮЛЭГ УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА 4 дүгээр зүйл.Мэдээлэх үүрэгтэй этгээд 4.1.Дараах этгээд энэ хуулийн 7 дугаар зүйлд заасан гүйлгээний талаар энэ хуулийн 16.1-д заасан Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх үүрэгтэй: 4.1.1.банк; 4.1.2.банк бус санхүүгийн байгууллага; 4.1.3.даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогч; 4.1.4.хөрөнгө оруулалтын сан, хөрөнгө оруулалтын менежментийн компани; */Энэ заалтад 2018 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./* 4.1.9.г.компанийг үүсгэн байгуулах, түүний үйл ажиллагааг явуулах, удирдахад зориулан хөрөнгө татах, бүрдүүлэхийг зохион байгуулах; хориглоно. 14 дүгээр зүйл.Мэдээлэх үүрэгтэй этгээдийн дотоод хяналт */Энэ зүйлийг 2018 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./* 14.3.Дотоод хяналтын хөтөлбөрийг энэ хуулийн 4.1-д заасан этгээдийн харьяалагддаг санхүүгийн нэгдэл, тэдгээрийн бүх салбар нэгж, охин компани нь нэгэн адил хэрэгжүүлнэ.	
36.	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай	2012.1.19	3 дугаар зүйл.Хуулийн нэр томьёоны тодорхойлолт 3.1.7.“ашгийн төлөө үйл ажиллагаа” гэж компани, нөхөрлөл, хувиараа эрхлэх аж ахуй зэрэг аж ахуй, худалдаа, зээл, санхүүгийн бүх төрлийн байгууллагын үйл ажиллагааг; **20 дугаар зүйл.Аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхтэй холбогдсон хориглолт** 20.2.Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Үндсэн хуулийн цэцийн гишүүн, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын дээд шүүхийн шүүгч, Улсын ерөнхий прокурор, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга, аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн дарга, яамны Төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн дарга, төрийн өмчит компани, олон улсын байгууллагын дарга, захирлын албан тушаал эрхэлж байсан болон эрхэлж байгаа хүн, эсхүл түүнтэй хамаарал бүхий этгээд нээлттэй тендер шалгаруулалтаар шийдвэрлэснээс бусад тохиолдолд төрийн болон орон нутгийн хэрэгцээнд бараа, ажил, үйлчилгээ худалдан авагч, төрийн санхүүгийн нөөц бүрдүүлэгч, төрөөс баталгаа гаргасан зээл хүртэгч аж ахуйн нэгжийн хувь, хөрөнгө эзэмшигч, хамтрагч, эсхүл эдгээрийг гүйцэтгэж байгаа хувиараа аж ахуй эрхлэгч байж болохгүй. */Энэ хэсгийг 2013 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан, энэ хэсэгт 2015 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*	

37.	Нөхөрлөл, компанийн тухай болон хоршооны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай	2002.7.4	1 дүгээр зүйл. Нөхөрлөл, компанийн тухай болон хоршооны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай. 2 дугаар зүйл. Энэ хуулийг 2002 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр батлагдсан Иргэний хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.	дагаж мөрдөх журмын тухай хуулийг хүчингүй болсон тухай
38.	Нөхөрлөлийн тухай /Энэ хуулийн нэрээс “компани” гэсэн үгийг 1999 оны 7 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар хассан/	1995.5.11	Энэ хуулийн нэрээс «компани» гэсэн үгийг 1999 оны 7 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар хассан.	
39.	Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай /Шинэчилсэн найруулга/	2015.7.9	**ЗУРГААДУГААР БҮЛЭГ** **АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ** **13 дугаар зүйл.Албан татвараас чөлөөлөх** 13.1.14.банк, банк бус санхүүгийн байгууллага болон бусад хуулийн этгээдээс банк, тусгай зориулалтын компани, орон сууцны санхүүжилтийн компанид хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах зориулалтаар шилжүүлсэн зээл, санхүүгийн түрээсийн гэрээнээс үүсэх аливаа шаардах эрх; **НАЙМДУГААР БҮЛЭГ** **АЛБАН ТАТВАРЫГ ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛЭХ, ТАЙЛАГНАХ** **16 дугаар зүйл.Албан татвар ногдуулах, төсөвт төвлөрүүлэх, тайлагнах** 16.1.Албан татвар суутган төлөгч нь борлуулсан бараа, ажил, үйлчилгээнд ногдох албан татварыг доор дурдсан журмаар дараа сарын 10-ны өдрийн дотор төрийн сангийн нэгдсэн дансанд шилжүүлж, баталсан маягтын дагуу тайлангаа харьяалах татварын албанд тушаана: 16.2.4.компанийн нөөц бүрдүүлэх зорилгоор импортоор оруулж байгаа автобензин, дизелийн түлшинд ногдох нэмэгдсэн өртгийн албан татварыг компанийн нөөц бүрдүүлэх аж ахуйн нэгжийн нэр, автобензин, дизелийн түлшний заавал байлгах нөөцийн тоо хэмжээ, сэлгээ хийх хугацааг тогтоосон Засгийн газрын шийдвэрийг үндэслэн компанийн нөөцийг сэлгэх зорилгоор борлуулж эхэлсэн өдөр ногдуулна; 16.2.5.газрын тосны бүтээгдэхүүний бөөний худалдаа, үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч компанийн импортоор оруулж байгаа компанийн нөөц бүрдүүлэхээс бусад Монгол Улсын 30 хоногийн хэрэглээтэй тэнцэх хэмжээний автобензин, дизелийн түлшинд ногдох нэмэгдсэн өртгийн албан татварыг 30 хоногоор хойшлуулан ногдуулна.	тусгай зориулалтын компани гэж ямар компанийг хэлэх тухай ойлгомжгүй байна.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХЭЛТЭС www.legalinfo.mn

40.	Нягтлан бодох бүртгэлийн тухай /Шинэчилсэн найруулга/	2015.6.19	**3 дугаар зүйл.Хуулийн нэр томьёоны тодорхойлолт** 3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно: 3.1.11.“нэгтгэсэн санхүүгийн тайлан” гэж Компанийн тухай хуулийн 6.4-т заасан санхүүгийн тайланг; 3.1.12.“гүйцэтгэх удирдлага” гэж дараах этгээдийг ойлгоно: 3.1.12.а.Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлд заасан этгээдийг; 3.1.12.б.компаниас бусад хуулийн этгээдийн хувьд тухайн хуулийн этгээдийн дүрэмд гүйцэтгэх удирдлага гэж заасан этгээдийг. **ХОЁРДУГААР БҮЛЭГ** **НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН СТАНДАРТ, ЗАРЧИМ** **4 дүгээр зүйл.Нягтлан бодох бүртгэлийн стандарт** 4.2.Энэ хуулийн 4.1.1-д заасан стандартыг мөрдөх аж ахуйн нэгж, байгууллагын ангилал, шалгуур үзүүлэлтийг хуульд нийцүүлэн санхүү, бүртгэлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтоож, нийтэд мэдээлнэ. Энэ ангилалд доор дурдсан аж ахуйн нэгж, байгууллагыг заавал хамруулна: 4.2.1.гадаад, дотоодын хөрөнгийн биржид бүртгүүлсэн бүх төрлийн хувьцаат компани; 4.2.2.гадаад, дотоодын хөрөнгийн биржид бүртгүүлэхээр хүсэлт гаргасан компани; 4.2.3.Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.2, 15.3, 15.4, 15.10.5, 15.10.6 болон 15.10.13-т заасан чиглэлээр тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллага; 4.2.7.арилжааны банкны болон тусгай зориулалтын компани, хөрөнгө оруулалтын сангийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага. 8 дугаар зүйл.Санхүүгийн тайлан 8.3.Нэг буюу түүнээс дээш охин компанитай аж ахуйн нэгж, байгууллага энэ хуулийн 3.1.11-д заасан нэгтгэсэн санхүүгийн тайлан гаргана. Охин компани нь охин компанитай, тэдгээр нь охин компанитай гэх мэтээр үргэлжилсэн холбоо хамааралтай байгаа тохиолдолд хамгийн дээд шатны толгой компани нь нэгтгэсэн санхүүгийн тайлан гаргана. Дээд шатны толгой компани нь гадаад улсад бүртгэлтэй бол Монгол Улсад бүртгэлтэй охин компаниудын дотроос дээд шатны толгой компани нь завсрын нэгтгэсэн санхүүгийн тайлан гаргана. **10 дугаар зүйл.Санхүүгийн тайлангийн жил, санхүүгийн тайлан гаргах хугацаа** 10.4.Нэгтгэсэн санхүүгийн тайлан гаргах үүрэг хүлээсэн аж ахуйн нэгж, байгууллага нь жилийн санхүүгийн тайланг дараа оны 03 дугаар сарын 01-ний өдрийн дотор толгой компанийн харилцдаг харилцагч санхүүгийн байгууллагад цахим хэлбэрээр хүргүүлнэ.	

41.	Онцгой албан татварын тухай (Шинэчилсэн найруулга)	2006.6.29	8 дугаар зүйл. Онцгой албан татварыг ногдуулах, төсөвт төлөх 8.10.Компанийн нөөц бүрдүүлэх зорилгоор импортлож байгаа автобензин, дизелийн түлшинд ногдох онцгой албан татварыг компанийн нөөц бүрдүүлэх аж ахуйн нэгжийн нэр, автобензин, дизелийн түлшний заавал байлгах нөөцийн тоо хэмжээ, сэлгээ хийх хугацааг тогтоосон Засгийн газрын шийдвэрийг үндэслэн компанийн нөөцийг сэлгэх зорилгоор борлуулж эхэлсэн өдөр ногдуулна. */Энэ хэсгийг 2007 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар нэмсэн/* 8.11.Газрын тосны бүтээгдэхүүний бөөний худалдаа, үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч компанийн импортлож байгаа компанийн нөөц бүрдүүлэхээс бусад Монгол Улсын 30 хоногийн хэрэглээтэй тэнцэх хэмжээний автобензин, дизелийн түлшинд ногдох онцгой албан татварыг 30 хоногоор хойшлуулан ногдуулна. */Энэ хэсгийг 2007 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар нэмсэн/*	
42.	Өмгөөллийн тухай	2019.10.18	**19 дүгээр зүйл.Өмгөөллийн хуулийн этгээд** 19.1.Өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд /цаашид “өмгөөллийн хуулийн этгээд” гэх/ нь хязгаарлагдмал хариуцлагатай компани, эсхүл хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөлийн хэлбэртэй байна.	
43.	Өргөн нэвтрүүлгийн тухай	2019.12.12	4 дүгээр зүйл.Хуулийн нэр томьёоны тодорхойлолт 4.1.18.“ашгийн төлөө үйл ажиллагаа” гэж компани, нөхөрлөл, хувиараа эрхлэх аж ахуй, худалдаа, зээл, санхүүгийн бүх төрлийн байгууллагын үйл ажиллагааг; **15 дугаар зүйл.Тусгай зөвшөөрөл шилжүүлэхийг хориглох** 15.1.Тусгай зөвшөөрлийг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 5.3-т зааснаас гадна өөрийн компанийн нэгдлээс бусдад өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах зэргээр шилжүүлэхийг хориглоно. **19 дүгээр зүйл.Эзэмшлийн ил тод байдлыг хангах** 19.2.1.тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн гаргасан хувьцааных нь тав ба түүнээс дээш хувийг эзэмшигчийн овог, эцэг /эх/-ийн нэр, нэр, компанийн эрх бүхий албан тушаалтны жагсаалт; 19.3.Гаргасан хувьцааных нь тав ба түүнээс дээш хувийг эзэмшдэг хувьцаа эзэмшигч болон компанийн эрх бүхий албан тушаалтан өөрчлөгдсөн тохиолдолд өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгч нь энэ тухай 30 хоногийн дотор Зохицуулах хороонд бичгээр мэдэгдэнэ.	
44.	Өрсөлдөөний тухай (Шинэчилсэн найруулга)	2010.6.10	**8 дугаар зүйл. Давамгай байдалтай хуулийн этгээд нэгдэх, нийлэх замаар өөрчлөн байгуулагдах, бусад компанийн хувьцааг худалдан авах** 8.1.Давамгай байдалтай хуулийн этгээд бусад этгээдтэй нэгдэх, нийлэх замаар өөрчлөн байгуулагдах, эсхүл ижил төрлийн бараа бүтээгдэхүүн борлуулдаг өрсөлдөгч компанийн энгийн хувьцааны 20-оос дээш, давуу эрхийн хувьцааны 15-аас дээш хувийг худалдан авах, эсхүл харилцан хамаарал бүхий этгээдтэй нэгдэх, нийлэх тохиолдолд Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газарт өргөдөл гаргана.	

45.	Протокол соёрхон батлах тухай Хууль хүчингүй болсонд тооцох тухай	2019.6.12	1 дүгээр зүйл.2015 оны 10 дугаар сарын 22-ны өдөр баталсан Монгол-Оросын “Эрдэнэт үйлдвэр” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн үйл ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын 2003 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын протоколыг соёрхон батлах тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.	
46.	Протокол соёрхон батлах тухай Хууль хүчингүй болсонд тооцох тухай	2019.6.12	1 дүгээр зүйл.2015 оны 10 дугаар сарын 22-ны өдөр баталсан Монгол-Оросын “Монголросцветмет” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн үйл ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын 2007 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын протокол соёрхон батлах тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.	
47.	Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай	2005.11.17	ТАВДУГААР БҮЛЭГ САНХҮҮГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ 22 дугаар зүйл.Тусгай зөвшөөрөл олгох 22.1.Энэ хуулийн 3.1-д заасан санхүүгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг Хороо олгоно. 22.2. Бүтцэд нь банк ордог компанийн аливаа хэлбэрийн нэгдлийн бусад оролцогчид тусгай зөвшөөрөл олгох эсэхийг шийдвэрлэхдээ Монголбанкны саналыг авна. */Энэ хэсэгт 2018 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./* 22.3.Хороо энэ хуулийн 22.2-т заасны дагуу тусгай зөвшөөрөл олгосон бол хяналтыг Монголбанктай хамтран хэрэгжүүлнэ. 22.4.Хороо тусгай зөвшөөрөл авахаар хүсэлт гаргасан компанийн толгой компанийн дүрэм, санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг шаардан авч, хянан үзэж болно. **27 дугаар зүйл.Хорооны мэдээлэл шаардах эрх** 27.1.Хороо буюу Хорооноос эрх олгосон этгээд тусгай зөвшөөрөл эзэмшигчээс тодорхой төрлийн буюу тусгайлан заасан мэдээлэл, санхүүгийн болон бусад баримт бичиг гаргаж өгөхийг бичгээр шаардаж болно. 27.2.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь компанийн аливаа хэлбэрийн нэгдлийн гишүүн бол Хороо тухайн нэгдэлд багтах аль ч этгээдийн, эсхүл уг нэгдлийн санхүүгийн тайланг шаардаж болно. 27.3.Тусгай зөвшөөрөл эзэмшигч энэ хуулийн 27.1, 27.2-т заасны дагуу Хорооны шаардсан мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж өгнө.	

Хуулийн хүрээлэн www.legal.mn

48.	Сонгуулийн тухай хууль	2015.12.25	**39 дүгээр зүйл.Сонгууль зохион байгуулах үйл ажиллагаанд туслах** 39.1.Сонгуулийн орон нутгийн байгууллагын ажиллах байр болон санал авах байрыг төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд үнэ төлбөргүй гаргаж өгнө. 39.2.Сонгуулийн орон нутгийн байгууллагыг ажиллах байр, тээвэр, холбоо болон бусад шаардлагатай хэрэгслээр үнэ төлбөргүй хангах асуудлыг тухайн шатны Засаг дарга хариуцна. 39.3.Шаардлагатай гэж үзвэл сонгуулийн төв байгууллага нь төрийн болон орон нутгийн өмчит, 51 ба түүнээс дээш хувийн төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компанийн өмчлөлд байгаа тээврийн хэрэгсэл, бусад техник хэрэгслийг сонгуулийн үйл ажиллагаанд үнэ төлбөргүй дайчлан гаргуулах эрхтэй ба эрх бүхий этгээд сонгуулийн төв байгууллагын шийдвэрийг биелүүлэх үүрэгтэй. **139 дүгээр зүйл.Ерөнхийлөгчид нэр дэвшүүлэх нийтлэг журам** 139.3.Нэр дэвшигч нь хуульд заасан нийтлэг шаардлагаас гадна дараах шаардлагыг хангасан байна: 139.3.3.нэр дэвшигч компанийн 51 ба түүнээс дээш хувьцааг эзэмшдэг бол тухайн компани нь албан татварын хугацаа хэтэрсэн өр төлбөргүй байх;	
49.	Татан буугдсан “Ардын эрх”, “Засгийн газрын мэдээ” сонины өмчийг хувьчлах тухай	1999.1.22	1 дүгээр зүйл.Татан буугдсан “Ардын эрх”, “Засгийн газрын мэдээ” сонины тус бүрийн өмчлөлд байсан хөрөнгийн үндсэн дээр шинээр хувьцаат компаниуд үүсгэн байгуулж тэдгээрийн хувьцааг худалдах замаар хувьчилж, тус бүрийн хувьцааны дөчин хувийг “Ардын эрх”, “Засгийн газрын мэдээ” сонинд ажиллаж байсан ажиллагсдад нь давуу эрхээр буюу хувьцааны доод үнээр, үлдэж байгаа хувьцааг хязгаартай буюу сонин, хэвлэл эрхлэн гаргадаг хуулийн этгээд, иргэдэд дуудлага худалдаагаар худалдах замаар хувьчилсугай.	
	Татварын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/		34.12.Хөрөнгийн бирж дараах мэдээллийг тухай бүр гаргаж, татварын албанд хүргүүлнэ: 34.12.1.хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчийн тархалтын тухай мэдээлэл; 34.12.2.хувьцаат компанийн хувьцааны борлуулалтын талаарх мэдээлэл. 34.14.Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв дараах мэдээллийг тухай бүр гаргаж, татварын албанд хүргүүлнэ: 34.14.1.үнэт цаасны бүртгэл, өөрчлөлтийн болон төлбөр тооцооны мэдээлэл; 34.14.2.төвлөрсөн хадгаламжийн дансны өөрчлөлтийн мэдээлэл; 34.14.3.хувьцаат компаниудын ногдол ашгийн олголтын мэдээлэл.	Бүхэлдээ хамаарна
50.	Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай	2012.12.27	**ГУРАВДУГААР БҮЛЭГ** **ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭД, ТҮҮНД ТАВИХ ШААРДЛАГА, ҮЙЛ АЖИЛЛАГАА,ЭРХ, ҮҮРЭГ** **9 дүгээр зүйл.Татварын итгэмжлэгдсэн хуулийн этгээд** 9.1.Татварын итгэмжлэгдсэн хуулийн этгээд нь хязгаарлагдмал хариуцлагатай компани, нөхөрлөлийн хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулна.	

51.	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай	1996.5.27	**5 дугаар зүйл. Төрийн өөрийн өмч** 1.Төрийн өөрийн өмчид энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт зааснаас бусад төр эзэмшиж, ашиглаж, захиран зарцуулж болох дараахь эд хөрөнгө хамаарна: 2.Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг аж ахуйн зориулалтаар нь Нөхөрлөл, компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу үндсэн ба эргэлтийн хөрөнгө гэж хуваана. 14 дүгээр зүйл. Төрийн байгууллага, албан газрын эд хөрөнгийн эрх 4/ төрийн өмчит эрдэм шинжилгээний байгууллага, их, дээд сургууль дэргэдээ бие даасан гарааны компани байгуулахаас бусад тохиолдолд үндсэн хөрөнгөд хамаарах эд хөрөнгө олж авах, захиалах, данснаас хасаж шилжүүлэх, устгах саналаа төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тавьж, энэ хуулиар тогтоосон журмын дагуу зөвшөөрөл авах. /Энэ заалтад 2012 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/ /Энэ заалтад 2015 оны 11 дүгээр сарын 26-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/ /Энэ заалтад 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/ **21 дүгээр зүйл. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, түүний эд хөрөнгийн эрх, онцлог** 2. Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөлөгчийг дараах байдлаар томилно. /Энэ хэсэгт 2011 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/ 2/төрийн өмчийн оролцооны хувь хэмжээтэй хувь тэнцүүлэн тухайн этгээдийн төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд төрийг төлөөлөх гишүүний нэрийг төрийн эзэмшлийн хувьцааг эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлж байгаа этгээд тухайн компанийн нэр дэвшүүлэх хороонд санал болгох бөгөөд нэр дэвшүүлэх хороо тэрхүү нэр дэвшигдэж байгаа этгээд нь хуульд заасны дагуу төрийг төлөөлөх этгээд мөн бол төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр томилуулахаар хувьцаа эзэмшигчдийн хуралд шууд оруулах үүрэгтэй; /Энэ заалтыг 2014 оны 6 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/ 21[1] дүгээр зүйл.Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааны төлөвлөлт, тайлагналт 7.Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай болон Компанийн тухай хуульд заасан журмын дагуу жилийн эцсийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан гаргана. 55 дугаар зүйл. Хувьцаа, ногдол хувь гарган хувьчлах 1. Төрийн өмчит үйлдвэрийн газрыг компаний хэлбэрт оруулан хувьцаа, ногдол хувийг нь худалдах замаар хувьчилж болно. Энэ тухай шийдвэрийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага гаргана. /Энэ хэсэгт 2015 оны 11 дүгээр сарын 26-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/ /Энэ хэсэгт 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/	Нөхөрлөл, компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу, Нөхөрлөл, компанийн тухай хуулийн 35 дугаар зүйл, Нөхөрлөл, компанийн тухай хуулийн 91 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу гэж хүчингүй хуулийн заалт ишлэсэн байгаа нь алдаатай байна.

			Эдийн засаг нийгмийн хэрэгцээ шаардлагын үүднээс төр зарим хувьцааг нийтэд санал болгохгүй, өөрийн өмчлөлдөө авч үлдэн төрийн өмчийн оролцоотой этгээд үүсгэж болно. 2. Төрийн өмчит үйлдвэрийг энэ зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар өөрчлөн зохион байгуулах ажлыг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага эрхэлж, Нөхөрлөл, компанийн тухай хуулийн 35 дугаар зүйлд заасан үүсгэн байгуулагчийг төлөөлсөн үүргийг гүйцэтгэнэ. /Энэ хэсэгт 2015 оны 11 дүгээр сарын 26-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/ /Энэ хэсэгт 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/ 3.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь хувь нийлүүлэгчдийн зохион байгуулах хурлыг хувьцаа, ногдол хувь нь зохих журмын дагуу борлогдож дуусанаас хойш 3 сарын дотор зохион байгуулж өөрийн хариуцаж байсан эрх, үүргийг шинээр байгуулагдсан хуулийн этгээдийн удирдлагад шилжүүлнэ. /Энэ хэсэгт 2015 оны 11 дүгээр сарын 26-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/ /Энэ хэсэгт 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/ Хэвлэх 56 дугаар зүйл. Төрийн өмчлөлийн хувьцаа, ногдол хувийг хувьчлах, бусад этгээдийн өмчлөлд шилжүүлэх 1. Энэ хуулийн 55 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар компани болон өөрчлөгдсөн төрийн өмчит үйлдвэрийн газрын болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрд ногдох хувьцаа, ногдол хувийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын шийдвэрээр чөлөөтэй, эсхүл багцалсан хэлбэрт оруулан энэ зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар биржээр болон энэ хуулийн 38-45, 46-54, 58 дугаар зүйлд заасны дагуу биржийн гадуур арилжиж худалдана. /Энэ хэсэгт 2015 оны 11 дүгээр сарын 26-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/ /Энэ хэсэгт 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/ 2. Хувьцааг биржээр худалдахад дор дурдсан дараалал, журмыг баримтална: 1/ хувьцааг биржээр арилжаалахад төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хувьчлагдах үйлдвэрийн газрын хөрөнгийг үнэлэн, гаргах хувьцааны хэлбэр, тоо хэмжээ, худалдах анхны үнэ, багцлах бол түүний хэмжээ зэргийг тогтоон Хөрөнгийн биржээр дамжуулан нийтэд арилжих тухай шийдвэрийг гаргана. Мөн хувь нийлүүлсэн байгууллага дахь төрийн өмчлөлийн хувьцааг энэ хэлбэрээр арилжиж болно; /Энэ заалтад 2015 оны 11 дүгээр сарын 26-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/ /Энэ заалтад 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/ 2/ хувьцааг биржээр арилжих үйл ажиллагааг Үнэт цаасны тухай хуульд заасан журмын дагуу явуулна. 3. Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрийн өмчлөлийн ногдол хувийг худалдахад Нөхөрлөл, компанийн тухай хуулийн 91 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу тухайн хуулийн этгээдийн бусад өмчлөгчдийн / гишүүдийн/ саналыг авна. 4. Үндэсний аюулгүй байдал, стратегийн ач холбогдолтой төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрд ногдох хувьцааг худалдах талаар Засгийн газар тусгайлан журам тогтоож болно	

52.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай	2005.12.1	**46 дугаар зүйл.Захиалагчийн эрх, үүрэг** 46.1.Захиалагч бараа, ажил, үйлчилгээг худалдан авах талаар дараахь эрх, үүрэгтэй байна: 46.1.9.гүйцэтгэгч компанийн товч танилцуулга, харилцах утас, гүйцэтгэж байгаа ажил, үйлчилгээний гэрээний үнийн дүн, санхүүжилтийн хуваарь, ажил эхлэх, дуусах хугацаа болон авто зам, инженерийн шугам сүлжээний хувьд дайран өнгөрөх маршрут зэргийг багтаасан мэдээллийн самбарыг төв, суурин бүрийн олон нийтэд үзэгдэхүйц газар уг ажил, үйлчилгээний баталгаат хугацааны туршид заавал байрлуулахыг шаардах. */Энэ заалтыг 2011 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар нэмсэн/*	
53.	Төсвийн тогтвортой байдлын тухай	2010.6.24	***17 дугаар зүйл.Санхүүгийн хуримтлал, түүний хөрөнгө оруулалт*** *17.3.Төсвийн тогтворжуулалтын сангийн хөрөнгө удирдлагын бодлого, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа дараахь шаардлагыг хангасан байна:* *17.3.1.энэ хуулийн 17.4-т зааснаас бусад тохиолдолд зээл авахгүй байх;* *17.3.2.зөвхөн олон улсын санхүүгийн зах зээлд гаргасан, гадаад улсын нутаг дэвсгэрт арилжаалагдаж байгаа, Монгол Улсад бүртгэлтэй, эсхүл Монгол Улсын хуулийн этгээдтэй нэгдэл бүхий компанийн нэгдлийн оролцогчоос бусад этгээдийн гаргасан санхүүгийн хэрэгсэлд байршуулах;*	
54.	Улсын тэмдэгтийн хураамжийн тухай /Шинэчилсэн найруулга/	2010.11.25	**18 дугаар зүйл.Банкнаас бусад санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгоход хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ** 18.3.Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана: 18.3.20.компанийн үнэт цаасыг нийтэд санал болгон худалдах зөвшөөрөл олгоход 40 000-100 000 төгрөг;	
55.	Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай	2014.1.9	**4 дүгээр зүйл.Хуулийн нэр томьёоны тодорхойлолт** 4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно: 4.1.13.“хуулийн этгээд” гэж Иргэний хуулийн 33.1-д заасан компани, нөхөрлөлийг.	
56.	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай	2000.11.17	**4 дүгээр зүйл. Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар төлөгч** 4.1. Монгол Улсын нутаг дэвсгэрт үл хөдлөх эд хөрөнгө өмчилж байгаа дараахь этгээд үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар төлөгч байна: 4.1.1. өмчийн бүх төрөлд хамаарагдах компани, хоршоо, нөхөрлөл, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, байгууллага, тэдгээрийн төлөөлөгчийн газар; 4.1.3. төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд;	
57.	Үндэсний төлбөрийн системийн тухай	2017.5.31	**ТАВДУГААР БҮЛЭГ** **СИСТЕМИЙН ДҮРЭМ** **23 дугаар зүйл.Системийн дүрмийг тогтоох** 23.1.Оператор нь системийн зохистой засаглал, удирдлага, үйл ажиллагааны дүрэмтэй байна. Дүрэмд дараахь зүйлийг тусгана: 23.1.3.оролцогч, операторын эрх, үүрэг, системийн үйл ажиллагааны эрсдэл, компанийн зохистой засаглал, системд оролцох болон учирч болзошгүй нөхцөл байдлын үед авах арга хэмжээний зохицуулалт.	

58.	Үнэт цаасны зах зээлийн тухай /Шинэчилсэн найруулга/	2013.5.24	**1 дүгээр зүйл.Хуулийн зорилт** 1.1.Энэ хуулийн зорилт нь үнэт цаасны зах зээлд оролцогчдын үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих, хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.	Бүхэлдээ хамаарна.
59.	Үрийн тариалангийн даатгалын тухай	1999.7.2	**1 дүгээр зүйл.Хуулийн зорилт** 1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын нутаг дэвсгэр дээр үрийн тариаланг албан журмаар даатгуулахтай холбогдсон даатгалын компани болон иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино. 8 дугаар зүйл.Даатгалын нөхөн төлбөр 8.6.Энэ хуулийн 5.1-д заасан эрсдэл тухайн даатгалын компанид даатгагдсан нийт талбайн 70-аас дээш хувьд тохиолдсоны улмаас даатгагч нь нөхөн төлбөрийг бүрэн нөхөн төлж чадахгүй болсон нь тогтоогдсон нөхцөлд нөхөн төлбөрийн зөрүүг Засгийн газар хариуцна.	
60.	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай /Шинэчилсэн найруулга/	2020.5.7	8 дугаар зүйл.Хөгжлийн бодлого, төлөвлөлтөд оролцогч 8.1.Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтөд доор дурдсан оролцогч оролцоно: 8.1.14.хувийн хэвшил. 8.2.Энэ хуулийн 8.1-д зааснаас бусад төрийн захиргааны байгууллага, шинжлэх ухааны төв байгууллага, төрийн өмчит хувьцаат компани, сан, Хөгжлийн банк, төрийн гүйцэтгэх байгууллагын чиг үүргийг эрхлэн гүйцэтгэгчид, мэргэжлийн холбоод, иргэний нийгмийн байгууллагууд болон хувийн хэвшлийн хуулийн этгээд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хөгжлийн бодлого, төлөвлөлтийн үйл ажиллагаанд оролцоно.	
61.	Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай	2011.6.2	**3 дугаар зүйл.Хуулийн нэр томьёоны тодорхойлолт** 3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно: 3.1.1.“хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн бирж” /цаашид “бирж” гэх/ гэж хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн арилжааг тогтсон журмын дагуу зориулалтын байранд, эсхүл цахим сүлжээгээр болон энэ хуулийн 7 дугаар зүйлд заасан биржийн арилжааны төрөл, хэлбэрээр зохион байгуулдаг компанийг; **9 дүгээр зүйл.Биржийн ажилтанд хориглох зүйл** 9.1.Биржийн ажилтанд дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно: 9.1.2.биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн компани байгуулах;	
62.	Хөрөнгийн үнэлгээний тухай	2010.1.21	**15 дугаар зүйл.Хөрөнгийн үнэлгээ хийж болохгүй нөхцөл** 15.1.Дараахь этгээдийн хөрөнгийн үнэлгээ хийлгэх хүсэлтийг үнэлгээчин хүлээн авахаас татгалзана: 15.1.1.өөрийн ажилладаг хуулийн этгээд болон сүүлийн хоёр жилийн дотор хамтран ажиллаж байсан иргэн, хуулийн этгээдийн; 15.1.2.сүүлийн нэг жилийн дотор өөрөө эд хөрөнгийн талаар /компанийн нийт гаргасан хувьцааны 5-аас дээш хувийг эзэмшдэг, эсхүл зээл, төлбөр болон хөрөнгө оруулалтын талаар харилцаатай/ холбоотой байсан буюу холбоотой байгаа иргэн, хуулийн этгээдийн;	

63.	Хөрөнгө оруулалтын сангийн тухай	2013.10.3	**4 дүгээр зүйл.Хуулийн нэр томьёоны тодорхойлолт** 4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно: 4.1.1.“хөрөнгө оруулалтын сан” гэж Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4.1.32-т заасныг; 4.1.11.“хөрөнгө оруулалтын менежментийн компани” гэж Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4.1.33-т заасан этгээдийг; 4.1.12.“кастодиан” гэж хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгийг тухайн сангийн хөрөнгө оруулалтын менежментийн компанийн хөрөнгөөс тусгаарлан хадгалж, төлбөр, тооцоог гүйцэтгэн хөрөнгийн бүртгэлийг хөтлөх, хөрөнгө оруулалтын сангийн гишүүдэд холбогдох мэдээллийг өгөх зэрэг үйлчилгээг хууль болон хөрөнгө хадгалах гэрээний хүрээнд үзүүлэх кастодианы үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай хуулийн этгээдийг;	Бүхэлдээ хамаарна
64.	Хөрөнгө оруулалтын тухай	2013.10.3	3 дугаар зүйл.Хуулийн нэр томьёоны тодорхойлолт 3.1.12.“нэгдмэл сонирхолтой этгээд” гэж Компанийн тухай хуулийн[3] 99.1-д заасан этгээдийг. **5 дугаар зүйл.Хөрөнгө оруулалтын хэлбэр** 5.1.Хөрөнгө оруулалтыг Монгол Улсад дараах хэлбэрээр хэрэгжүүлнэ: 5.1.3.компанийг нэгтгэх, нийлүүлэх замаар хөрөнгө оруулалт хийх;	
65.	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай	2010.4.23	**11 дүгээр зүйл. Баталгаат үнэт цаас гаргагч** 11.1.Баталгаат үнэт цаасыг тусгай зориулалтын компани гаргана. **12 дугаар зүйл. Тусгай зориулалтын компани байгуулах** 12.1.Тусгай зориулалтын компани нь Компанийн тухай хууль болон Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд заасан журмын дагуу байгуулагдсан, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан тусгай зөвшөөрлийг авсан хязгаарлагдмал хариуцлагатай компани байна. 12.2.Тусгай зориулалтын компани нь хөрөнгийн багцыг өөрийн санхүүгийн тайлан, тэнцэлд шилжүүлэн авах замаар баталгаат үнэт цаасыг хөрөнгө оруулагч эзэмших эрхтэйг баталгаажуулах чиг үүргийг хэрэгжүүлнэ. 12.3.Тусгай зориулалтын компанийг баталгаат үнэт цаас гаргах бүрт байгуулна. 12.4.Тусгай зориулалтын компанийг банк, банк бус санхүүгийн байгууллага, орон сууцны санхүүжилтийн компани болон Хорооноос зөвшөөрсөн санхүүгийн бусад байгууллага байгуулж болно.	

Хуулийн мэдээлэл www.legal.mn Нэвтэрхий хуулийн сан

66.	Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай /Шинэчилсэн найруулга/	2018.6.21	**ХОЁРДУГААР БҮЛЭГ** **УЛСЫН БҮРТГЭЛИЙН БАЙГУУЛЛАГА, ТҮҮНИЙ ЧИГ ҮҮРЭГ** **7 дугаар зүйл.Улсын бүртгэлд бүртгүүлэх хуулийн этгээд** 7.1.Улсын бүртгэлийн байгууллага дараах хуулийн этгээд, түүний салбар, төлөөлөгчийн газрыг бүртгэнэ: 7.1.1.нөхөрлөл; 7.1.2.компани; 7.1.3.холбоо /төрийн бус байгууллага/; 7.1.4.сан; 7.1.5.хоршоо; 7.1.6.шашны байгууллага; 7.1.7.нийтийн эрх зүйн хуулийн этгээд; 7.1.8.төрийн байгууллага, албан газар; 7.1.9.улсын төсөвт үйлдвэрийн газар; 7.1.10.аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар. 7.2.Улсын бүртгэлийн байгууллага гадаадын хуулийн этгээд /компани, нөхөрлөл/-ийн төлөөлөгчийн газрыг бүртгэх бөгөөд холбогдох журмыг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. **10 дугаар зүйл.Хуулийн этгээдийн хувийн хэргийн агуулга** 10.1.Хуулийн этгээдийн хувийн хэрэг дараах мэдээллийг агуулна: 10.1.9.компанийн хувьд үүсгэн байгуулах баримт бичигт заасан хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ;	
67.	Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай	2018.6.21	1 дүгээр зүйл.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг дагаж мөрдөхөөс өмнө соёл, боловсрол, сургалт, эрдэм шинжилгээ, эрүүл мэнд, хэвлэл мэдээллийн байгууллагаар бүртгүүлсэн хуулийн этгээдийг тус байгууллагын хүсэлтийг үндэслэн Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 7.1.2-т заасан компани, эсхүл 7.1.3-т заасан холбоо /төрийн бус байгууллага/-ны, 7.1.4-т заасан сан хэлбэрээр бүртгэх ажлыг улсын бүртгэлийн байгууллага хариуцан зохион байгуулна.	
68.	Хэлэлцээр соёрхон батлах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай	2019.6.12	1 дүгээр зүйл.2009 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр баталсан Монгол Оросын “Монголросцветмет” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн үйл ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хооронд байгуулсан хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.	
69.	Цахим гарын үсгийн тухай	2011.12.15	**ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ** **ГЭРЧИЛГЭЭ ОЛГОХ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ** **18 дугаар зүйл.Гэрчилгээ олгох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл** 18.2.Гэрчилгээ олгох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл /цаашид “тусгай зөвшөөрөл” гэх/-ийг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдан үйл ажиллагаа явуулж байгаа компанид олгож болно.	

ХУУЛЬ ЗҮЙН ЯАМНЫ ХУУЛЬЧДЫН ЗӨВЛӨЛ

70.	Цөмийн энергийн тухай	2009.7.16	**5 дугаар зүйл.Цацраг идэвхт ашигт малтмалын өмчлөл болон цацраг идэвхт ашигт малтмал ашиглах үйл ажиллагаанд оролцох төрийн оролцоо** 5.1.Монгол Улсын газрын хэвлийд оршиж байгаа цацраг идэвхт ашигт малтмал төрийн өмч мөн. 5.2.Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийж нөөцийг нь тогтоосон цацраг идэвхт ашигт малтмалын ордыг бусадтай хамтран ашиглах тохиолдолд түүнтэй хамтран байгуулах компанийн хувьцааны 51-ээс доошгүй хувийг төр үнэ төлбөргүй, шууд эзэмшинэ. 5.3.Улсын төсвийн хөрөнгийн оролцоогүйгээр хайгуул хийж нөөцийг нь тогтоон улсын нэгдсэн бүртгэлд бүртгэсэн орд газарт цацраг идэвхт ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч компанийн хувьцааны 34-өөс доошгүй хувийг төр үнэ төлбөргүй, шууд эзэмшинэ. **7 дугаар зүйл.Засгийн газрын онцгой бүрэн эрх** 7.1.Энэ хуулийн 15.1.2, 15.2.1, 15.2.2-т заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хувь нийлүүлэгчдийн хурал, төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага болон хувьцаа эзэмшигч нь дараах асуудлаар шийдвэр гаргахаас өмнө Цөмийн энергийн комиссоос зөвшөөрөл авна: */Энэ хэсэгт 2015 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/* 7.1.1.тухайн компанийн хувьцааны 5-аас дээш хувийг худалдах, бэлэглэх, барьцаалах болон өөр бусад хэлбэрээр бусдын өмчлөл, эзэмшил, ашиглалтад шилжүүлэх; 7.1.2.тухайн компанийн хувьд хувьцаа авах эрхийн бичиг буюу хувьцаанд хөрвөх үнэт цаас шинээр гаргах, эсхүл урьд гаргасан нийт хувьцааны 5 хувиас дээш хэмжээний хувьцаа нэмж гаргах; 7.1.3.тухайн компанийг нийлэх, нэгдэх, хуваах, тусгаарлах замаар өөрчлөн байгуулах.	
71.	Шилэн дансны тухай	2014.7.1	**3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ** 3.1.Доор дурдсан байгууллага, түүний эд хөрөнгө захиран зарцуулах эрх бүхий албан тушаалтан энэ хуулийн үйлчлэлд хамаарна: 3.1.1.төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд; 3.1.2.төрийн өмчит үйлдвэрийн газар; 3.1.3.хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг нь төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компани; 6 дугаар зүйл.Шилэн дансны мэдээлэл 6.8.Энэ хуулийн 3.1.3-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ: 6.8.3.төр болон орон нутаг тавь буюу түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа компанийн гаргасан их хэмжээний хэлцэлд тооцогдохуйц баталгаа, батлан даалт.	

Хэвлэлийн хуулийн дагуу

72.	Эрүүгийн хууль /Шинэчилсэн найруулга/	2015.12.3	**9.7 дугаар зүйл.Хуулийн этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлага гарцаагүй байх** 1.Энэ хуулийн тусгай ангид заасны дагуу эрүүгийн хариуцлага хүлээлгэх хуулийн этгээд өөрчлөн байгуулагдсан бол доор дурдсан хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ: 1.1.бусад хуулийн этгээдтэй нийлүүлэн нэг хуулийн этгээд үүсгэсэн бол шинээр бий болсон хуулийн этгээдэд; 1.2.бусад хуулийн этгээдэд нэгтгэсэн бол нэгтгэж авсан хуулийн этгээдэд; 1.3.хуваах, тусгаарлах замаар өөр хуулийн этгээд үүсгэн байгуулсан бол тухайн гэмт хэрэгт холбогдох эд хөрөнгө, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус эрх, үүрэг, үйл ажиллагааг шилжүүлэн авсан хувь хэмжээгээр нь зохих хуулийн этгээдэд; 1.4.хуулийн этгээд нь зохион байгуулалтын төрөл, хэлбэр, үндсэн зорилгоо өөрчлөх замаар өөрчлөгдсөн бол тухайн өөрчлөгдөн зохион байгуулагдсан хуулийн этгээдэд; 1.5.компани нь толгой компани, түүний үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигчийн ашиг сонирхлын үүднээс гэмт хэрэг үйлдсэн бол толгой компанид.	

Хуулийн мэдээлэлийн нэгдсэн сан www.nli.gov.mn

ХАВСРАЛТ 2

КОМПАНИЙН ТУХАЙ ХУУЛЬТАЙ ХОЛБОГДОН ГАРГАСАН ХУУЛЬ ЗҮЙН СУДАЛГААНЫ БҮТЭЭГДЭХҮҮН

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн хууль зүйн судалгааны төвөөс хийсэн судалгааны ажил

№	Он/ Судалгааны тайлангийн эмхэтгэл	Нэр	Хуудасны тоо
1	2016-2017 он	Аж ахуйн нэгжийн дампуурал ба дахин хөрөнгөжүүлэх ажиллагаа	398- 431
2	2016-2017 он	Гадаадын зарим орны хуулийн этгээдийн төрөл	761-782
3	2012-2013 он	Компани худалдан авах, өөрчлөн байгуулах үндсэн аргууд, Гадаад орны туршлага	541-573
4	2018 он	Компанийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ	231-248
5	2016- 2017 он	**Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга хуулийн төсөлд хийсэн зардлын тооцоо**	208-254
6	2016- 2017 он	Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн төслийн үр нөлөөг үнэлэр үнэлгээ	170-207

- Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн номын санд байрлаж буй бүтээлүүд

		Сэтгүүл	
№	он	Нэр	Дансны дугаар
1	2019	Хууль дээдлэх ёс цуврал 74	340 Х-758
2	2017	Эрх зүй цуврал 37	403,4599-1-3
3	2016	Эрх зүй цуврал 33	327,4403-1-2
4	2016	Эрх зүй цуврал 36	370,4512-1-1
5	2019	Эрх зүй цуврал 45	523,4837-1-2
6	2013	Эрх зүй цуврал 25	306,4407-1-1
7	2014	Эрх зүй цуврал 25	313,4406-1-3
8	2014	Эрх зүй цуврал 29	319,4401-1-3
9	2013	Эрх зүй цуврал 24	54,3848-1-9
10	2019	Хууль дээдлэх ёс цуврал 72	506,4806-1-2
11	2012	Стратеги судлал цуврал 57	162,4105-1-2
12	2016	Стратеги судлал цуврал 73	281,4356-1-2
13	2016	Стратеги судлал цуврал 74	339,4356-1-3
		Ном	
14	2011	Үнэт цаасны эрх зүйн үндэс (Оюутан, суралцагсад зориулсан гарын авлага)	8381,3418-1-1
15		Компанийг шинэчлэхүй, Мэдээллийн шинэ эрин ажил төрөл, байгууллага, компаниа хэрхэн шинэчлэх вэ?	4490,1013-1-1
16	2017	Компанийн эрх зүйн үндсэн ойлголт	10184,4504-1-3
17	2006	Үнэт цаас, хөрөнгийн зах зээл бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ эдийн засгийн өсөлт	4716,1396-1-1
18	2017	Компанийн засаглал, Зарим чухал хэлцлүүд	10088,4423-1-3
19	2017	Компанийн засаглал, Хувьцаа болон эзэмшигчийн эрх, түүний хэрэгжүүлэлт	10084,4424-1-4
20	2016	Компанийн төлөөлөн удирдах зөвлөл	10076,4425-1-1
21	2016	Хувьцаа эзэмшигчдийн хурал	10072,4421-1-3
22	2013	Бизнес эрхлэлтийн орчин дахь авлигын нөхцөл байдал	9435,3990-1-3
23	2017	Хувийн эрх зүй: онол-арга зүй, эдийн засгийн анализ, харьцуулсан асуудал (Эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэлийн эмхэтгэл)	10180,4502-1-2
24	2008	Юридические лица	1014,356-1-1

хуулийн үндэсний хүрээлэн www.nli.gov.mn

25	2010	Зависимость независимых юридических лиц	875,3107-1-1
26	2009	Предпринимательское право	896,3138-1-1

№	Он, сар	Гарчиг	Цахим хаяг/ эх сурвалж
1	2013	Жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг шүүхээр нэхэмжлэн хамгаалах эрх зүйн зохицуулалт, тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам, гадаад орны харьцуулсан судалгаа	//legaldata.mn/buteel/pdf?id=291
2	2016	Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын эрх зүйн зохицуулалт	http://legaldata.mn/buteel/pdf?id=292
3	2019	Монгол улсын компанийн тухай хууль дахь хувьцаа эзэмшигч компанийг төлөөлөн шүүхэд нэхэмжлэл гаргах нь: харьцуулсан судалгаа	http://legaldata.mn/buteel/pdf?id=699
4	2012	Хувьцаа эзэмшигч компанийн эрх ашгийг хамгаалан нэхэмжлэл гаргах боломж ТУЗ болон гүйцэтгэх удирдлагыг хамгаалах эрх зүйг боломж	Хууль дээдлэх ёс цуврал- 36
5	2012	Компанийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, шинэлэг зохицуулалт	Хууль дээдлэх ёс цуврал- 37
6	2012	Форексийн бизнес түүний эрх зүйн зохицуулалт, тулгамдсан асуудал	Хууль дээдлэх ёс цуврал- 38
7	2017	Компанийн эрх зүйн сонирхолын зөрчилтэй хэлцлийн зохицуулалт	Хууль дээдлэх ёс цуврал- 61
8	2017	Компанийн гүйцэтгэх удирдлагын эрх зүйн асуудал	Хууль дээдлэх ёс цуврал- 63
9	2019	Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнд нэр дэвшигчид тавигдах шалгуур, хэрэгжилт	Хууль дээдлэх ёс цуврал- 72
10	2019	Компанийн хууль зүйн зохицуулалтын онолын асуудал	Хууль дээдлэх ёс цуврал- 74
11	2020	Групп компанийн хууль зүйн орчны харьцуулсан судалгаа	Хууль дээдлэх ёс цуврал- 76
12	2013	УИХ-ын гишүүн С.Бямбацогт болон нэр бүхий гишүүдийн санаачилсан Компанийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг өнөөдөр УИХ-ын дарга З.Энхболдод барилаа	https://vip76.mn/content/19320
13	2017	“Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга” хуулийн төсөлд хийсэн зардлын тооцоо	http://nli.gov.mn/?cat=32
14	2017	**Компани худалдан авах, өөрчлөн байгуулах үндсэн аргууд: гадаад орнуудын туршлага**	http://nli.gov.mn/?cat=32
15	2019	Монгол Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр, З.Нарантуяа, Ж.Бат-Эрдэнэ, М.Оюунчимэг, Я.Содбаатар, Л.Мөнхбаатар нарын гишүүд өнөөдөр (2019.07.02) Актив удирдлагын компанийн тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын дарга Г.Занданшатарт өргөн барилаа.	https://news.mn/r/2161815/
16	2019	“Монгол Улсын компанийн эрх зүйд тулгамдаж буй асуудал: Хувьцаа эзэмшил буюу өмчлөлийн төлөв байдал. Нээлттэй хувьцаат компанийн жишээн дээр”	https://www.mglbar.mn/news/3340
17		**Компанийн засаглалын үндэсний портал сайт**	http://governance.mn/file/71

- МУИС номын сан

Цахим магистрын ажил			
№	он	нэр	Дансны дугаар
1	2013	Хязгаарлагдмал Хариуцлагатай Компанийн хувьцаа эзэмшигчдийн гэрээ, түүний эрх зүйн зохицуулалт	304250
2	2013	Олон нийтийн өмчлөлийн компанийн эрх зүйн зохицуулалт. Харьцуулсан судалгаа	304605
3	2016	Гадаадын хөрөнгө оруулалттай компаний эрх зүйн байдал	305779
4	2016	Компанийн нэгдэл, эрх зүйн зохицуулалт Харьцуулсан судалгаа	305897
5	2017	Хувьцаа эзэмшигчийн эрхийн хэрэгжилтэнд тулгамдаж буй зарим асуудал (Хувьцаат компанийн жишээн дээр)	305912

Хуулийн мэдээлэл хүргэлтийн www.nli.gov.mn

6	2014	Төлөөлөн удирдах зөвлөлийн эрх зүйн байдал, олон улсын ба үндэсний эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгаа	304881
Ном			
1	2015	Судалгааны эмхэтгэл. Боть XIX.	9315283
2	2012	Компанийн засаглал, компанийн эрх зүйн тулгамдсан асуудал	5051553
3		Орчин үеийн эрх зүйн тулгамдсан асуудлууд: Эрдэм шинжилгээний хурлын илтгэлийн эмхэтгэл	9315138
4	2017	Хувийн эрх зүй. Эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэлийн эмхэтгэл	9320090
5	2020	Өмчийн харилцааны хөгжил, эрх зүйн зохицуулалтын зарим асуудал.	9321611

- СЭЗИС номын сан

№	Он	Нэр	Дансны дугаар
1	2017	Компанийн эрх зүйн үндсэн ойлголт	346.066’023 / О-603
2	2018	Компаний хувьцаа эзэмшигчийн эрхийн зарим асуудал	340’0 715 / С-363
3	2018	Компанийн эрх зүйн зохицуулалтын зарим асуудал	340’0 715 / Э-661
4		Компанийн гүйцэтгэх дээд удирдлага буюу CEO	650.1’092 / Б-559
5	2017	Гадаадын хөрөнгө оруулалттай компанийн засаглал ба түүнийг сайжруулах арга зам	658.4’071 5 / А-751
6	2015	Бизнесийн эрх зүй	340’077 / О-634

- Үндэсний номын сан

№	Он	Нэр	Дансны дугаар
1	2016	Гадаадын хөрөнгө оруулалттай компанийн эрх зүйн байдал	305779
2	2018	Компанийн нийгмийн хариуцлага ба үндсэн үзүүлэлтүүдийн хамаарлын судалгаа	14197
3	2017	Компаийн эрх зүй дэх сонтрхолын зөрчилтэй хэлцэлийн зохицуулалт, харьцуулсан судалгаа	305902
4	2017	Хувьцаа эзэмшигчийн эрхийн хэрэгжилтэнд тулгамдаж буй зарим асуудал	305912
5	2014	Төлөөлөн удирдах зөвлөлийн эрх зүйн байдал, олон улсын ба үндэсний эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгаа	304881

- Бэлэн ном, сэтгүүл

№	Он	Нэр
1	2003	Компанийн эрх зүй /Гарын авлага/
2	2003	Компанийн эрх зүйн асуудал
3	2010	Гадаадын хөрөнгө оруулалт эрх зүйн асуудал
4	2010	Толгой ба охин компанийн хариуцлагын асуудал хязгаарлагдмал хариуцлагыг нэвтлэх нь /Сургалтын гарын авлага/
5	2011	МУИС-ийн “Эрх зүй” сэтгүүл цуврал 1/2011(20
6	2018	“Өмгөөлөгч” сэтгүүл цуврал 23 /82/
7	2020	“Өмгөөлөгч” сэтгүүл цуврал 31 /90/

хуулийн үндэсний хүрээлэн www.ulg.gov.mn

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХУРЭЭЛЭН
www.nli.gov.mn